UNIYERSITY OF INTERNAL AFFAIRS
SCHOOL FOR COURT DECISION EXECTION SERYICE

COURT DECISION EXECUTION STUDY

THEORETICAL AND METHODOLOGICAL QUARTERLY JOURNAL

2024
№01

Ulaanbaatar

Дугаарыг эрхлэн гаргаж эмхэтгэсэн: **дэд хурандаа Я.Батгэрэл**
ахмад Б.Замбага
хошууч Э.Цэрэнханд
дэслэгч Б.Дэнсмаа

Сургалт судалгааны 403 анги- Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхим

Эх бэлтгэсэн: Б.Тулга
Хэвлэл, редакцын хэлтсийн
эх бэлтгэгч-дизайнер, дэд ахлагч

Хэвлэлийн хуудас: 22,4
Хэвлэлийн тоо: 10

ISBN: 978-99978-770-2-4

“ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ” сэтгүүл

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Цагдаагийн академийн өргөн чөлөө,
Хилчний гудамж,
Дотоод хэргийн их сургууль
И-мэйл: setguul.cd@gmail.com
Веб: uia.gov.mn

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ	JOURNAL EDITOR BOARD
Сэтгүүлийн эрхлэгч **Дамдинцэрэн Д.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн захирал, доктор, бригадын генерал	**Editor of the journal** **Damdintseren D.** Director, School For Court Decision Execution Serүice, Ph.D, Brigadier general
Нарийн бичгийн дарга **Галбадрах Б.** Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, хошууч	**Editor of the journal** **Galbadrakh B.** Head of Social work and psychology department, Ph.D, Major
Гишүүд **Алтангэрэл Б.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын хүрээлэнгийн эрхлэгч эрхлэгч, доктор, дэд профессор, хурандаа	**Members** **Altangerel B.** Head of Court Decision Execution Study Center, Ph.D, associated Professor, Colonel
Очгэрэл Ц. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын профессорын судалгааны багийн тэргүүлэх профессорын орлогч, доктор, дэд профессор, хурандаа	**Ochgerel Ts.** Deputy professor of Professor research team ofCourt Decision Execution, Ph.D, associated Professor, Colonel
Баттулга Г. Харуул хамгаалалт, гүйцэтгэх ажлын тэнхимийн эрхлэгч хурандаа	**Battulga G.** Head of Security and Executiүe Work Department, Colonel
Батгэрэл Я. Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн эрхлэгч, дэд хурандаа	**Batgerel Ya.** Head of Ciүil Court Decision Execution Department, Lieutenant colonel
Батбаяр Э. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор, хурандаа	**Batbayar E.** Head of Non custodial Punishment Execution Department, Ph.D, associated Professor, Colonel
Мягмарсүрэн Д. Ахлагчийн мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төвийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тэнхимийн эрхлэгч, доктор, дэд хурандаа	**Myamarsuren D.** Head of Department of the Court Decision Execution Serүice of the Sergeant Profession, Training and Production Center, Ph.D, Lieutenant colonel

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ

Онол-арга зүйн сэтгүүл

ДУГААРЫН ТОВЧООН

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

Иргэн, захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

Я.Батгэрэл
Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудаас гаргасан гомдлыг шалган шийдвэрлэхэд анхаарах асуудал 9-15

Б.Базарсад
Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны хэрэгжилт, тулгамдсан асуудал 16-25

А.Жандаг
Төлбөр төлөгчийг эрэн сурвалжлах ажиллагааны удирдлага зохион байгуулалт, сайжруулах арга зам 26-34

М.Золбоо
Үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдааны эрх зүйн зохицуулалт, анхаарах асуудал 35-46

Д.Оюу
Албадан дуудлага худалдааны эд хөрөнгийн үнэлгээ тогтоох ажиллагаанд хийсэн шинжилгээ 47-58

О.Уртнасан
Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хууль зүйн хариуцлага 59-71

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа, албадлагын арга хэмжээ

Э.Батбаяр
Ялын төрөл 72-76

С.Эрдэнэболор, О.Хишигмөнх
Зан үйлд нөлөөлөх албадан сургалт: сургалтын хөтөлбөрийг сайжруулах хэрэгцээ, шаардлага 77-87

А.Баасанцэрэн
Олон улсад болон монгол улсын эрүүгийн эрх зүй дэх ял тэнсэх институцийн түүхэн хөгжилт 88-95

Э.Өнөболд
Согтуурах, мансуурах донтой хүнийг албадан эмчлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт 96-104

Д.Энх-Амар
Хорих ангиас суллагдсан хүмүүсийн хөдөлмөр эрхлэлт ба эрүүл мэндийн даатгал 105-117

Ч.Нансалмаа
Нийтэд тустай ажил хийх ялын хэрэгжилтийн өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ 118-124

Хорих ял эдлүүлэх ажиллагаа

П.Жамбажамц
Хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаарх гадаадын зарим орны туршлага, эрх зүйн зохицуулалт 125-135

Поликарпов Б.А
К вопросу о преодолении противодействия головному преследованию в учреждениях уголовно-ясполнительной системы 136-142

С.Цэрэндолгор
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа ба хиймэл оюун ухаанд суурилсан хяналтын телекамер 143-148

С.Эрдэнэбат
Эмэгтэй хоригдлыг хүүхдийнх нь хамт байлгах зохицуулалтын онцлог 149-158

Ш.Дэчинбал
Хоригдлыг сайшааж урамшуулж ирсэн уламжлал 159-164

Ж.Болдбаяр
Цагдан хорих байрны алба хаагчдын сахилгын зөрчилд шинжилгээ 165-180

Г.Мөнхбаяр
Хорих байгууллагын биечилсэн харуул хамгаалалтын олон улсын жишээ 181-185

Ц.Батзориг
Хар тамхи, мансууруулах бодистой холбогдох хэрэг үйлдсэн хоригдлуудтай ажиллахад анхаарах асуудал 186-194

Б.Анун
Эмэгтэй хоригдлын эрх, хорих ял эдлүүлэх нөхцөл, түүнд хийсэн шинжилгээ 195-206

Нийгмийн ажил, сэтгэл зүй

О.Баяржаргал
Хоригдолд үзүүлэх сэтгэл зүйн үйлчилгээ 207-212

Г.Батжаргал
Согтуурах, мансуурах донтох өвчтэй хүнд өгөх сэтгэл зүйн зөвлөгөөнд анхаарах асуудал 213-220

Ц.Ганзориг
Суллагдах хугацаа дөхсөн хоригдолд үзүүлэх нийгэмшүүлэх ажлын ач холбогдол 221-230

Хилийн эрх зүй

Ч.Чулуунхүү
Улсын хилийн нутаг дэвсгэрийн аюулгүй байдал 231-236

Шинжлэн магадлах ухаан

Ц.Нандинцэцэг
Өсвөр насны хүүхдүүдийн амиа хорлох эрсдэл түүнд нөлөөлөх хүчин зүйлс 237-242

Боловсрол судлал	
Я.Ариунболд Команд штабын сургуулийн онол, арга зүй	243-259
О.Эрдэнэсайхан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үнэт зүйл, хөгжлийн чиг хандлага	250-258
Э.Цэрэнханд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн англи хэлний боловсролын нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага	259-273
Б.Дэнсмаа Сургалтын үйл ажиллагааны сэтгэл зүй	274-284
Я.Ариунболд Цэргийн алба хаагчийн мэргэжлийн боловсрол, сэтгэл зүйн асуудал	285-292
Судлаач сонсогч, оюутан, суралцагч	
Д.Лхагвадорж, М.Маралмаа Цэргийн нийтлэг дүрмийн хэрэгжилтэд нөлөөлж буй хүчин зүйлд хийсэн дүн шинжилгээ	293-300
Х.Отгонбат Телехяналтын системийн өнөөгийн чиг хандлага	301-312
Б.Насанжаргал Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны түүхэн эх сурвалж	313-324
А.Мягмарнаран Хүний эрхийг хангах, хамгаалах төрийн үүрэг	325-333
ДУУРСАХ НЭР БУЛАН	
Доктор (Ph.D), профессор, бэлтгэл хурандаа Б.Алтангэрэл багшийн “Дурсамж яриа”	334-337
ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ	
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага ахлагч бүрэлдэхүүний дунд “ахлагчийн алба-өнөө ба ирээдүй” сэдэвт эрдэм шинжилгээний хурал зохион байгууллаа	338
Ерөнхий боловсролын сургуулийн сурагчидтай уулзалт зохион байгууллаа	339
Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын эмэгтэй ахлагч нарын анхдугаар чуулга уулзалт боллоо	340
Эрэгтэй багш, албан хаагчдын дунд “дартс-2024” тэмцээнийг зохион байгууллаа	341
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тэнхимийн “Харуул хамгаалалтын албаны ажилтан" мэргэжлийн дамжааны төгсөлт боллоо	342
“English language in my career and future” сэдэвт багш нарын англи хэлний илтгэлийн уралдаан зохион байгууллаа	343

“Алдрын дуулалтай бидний сургууль” караоке дууны тэмцээн боллоо	344
Үе үеийн төгсөгчдийн дунд дартсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгууллаа	345
Дотоод хэргийн их сургуулийн үе үеийн төгсөгчдийн волейболын тэмцээний аваргууд тодорлоо	346
Дотоод хэргийн их сургуулийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн үе үеийн бага дарга, төгсөгчдийн төлөөлөл оролцсон уулзалт зохион байгууллаа	347
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2024 оны аварга шалгаруулах “спортын зургаан төрөлт тэмцээн” 7 бүсэд боллоо	348
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын “Спортын 6 төрөлт тэмцээн” 7 бүсэд боллоо	349
“Ахлагч танд баярлалаа” урлагийн үзлэгийн бүсийн шалгаруулалт эхэллээ	350
Алба хаагчийг мэргэшүүлэх сургалтын нээлтийн үйл ажиллагаа эхлүүллээ	351
МЭДЭЭЛЭЛ	
Парламентын мэтгэлцээний дүрэм	351-358

---o0o---

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



Эрхэм хүндэт уншигч танд энэ өдрийн мэнд хүргэе.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулиас улирал тутамд эрхлэн гаргадаг “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл, судлал” онол, арга зүйн сэтгүүлийн 2024 оны 1 дүгээр улирлын дугаарыг тус сургуулийн Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхим эрхлэн гаргаж уншигч та бүхэнд хүргэж байгаадаа таатай байна.

Манай сэтгүүл нь 2012 онд анхны дугаараа нийтийн хүртээл болгосноос хойш 46 дахь дугаарыг хэвлэн нийтлүүлж байна. Ингэхдээ шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын судалгааны голлох эх сурвалж болон шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын салбарын үе үеийн эрдэмтэн профессорууд болон судлаачдын судалгаа, эрдэм шинжилгээ өгүүлэл, хорих ял эдлүүлэх ажиллагаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ зэргийг хэвлэн нийтэлдэг манай салбарын шинжлэх ухаан практикт өөрийн өнгө аяс бүхий хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүл болон хөгжиж ирсэн билээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл сэтгүүлийн I улирлын дугаарын онцлог шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн судлагдахууны хүрээгээр хязгаарлахгүйгээр эрх зүйн ерөнхий онолын агуулгыг илэрхийлсэн, иргэний эрх зүй, эрүүгийн эрх зүй, хилийн эрх зүй, шинжлэн магадлахуй, боловсрол судлал, сэтгэл судлал, удирдахуйн ухааны онол, практикийн тулгамдсан асуудлыг хөндөн судалсан багш, судлаагчдын судалгааны ажлыг нийтийн хүртээл болгож байгаагаараа онцлог юм.

Тус сэтгүүлийг орчин үеийн технологийн хөгжил, дэвшилд нийцүүлэн цахим хэлбэрт шилжүүлэн олны хүртээл болгон ажиллаж байна.

Уншигч, судлаач та бүхэн Монгол улс болон олон улсын түвшинд дүйцэхүйц шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын сэтгүүлийг буй болгох үйлсэд бидэнтэй хамтран ажиллаж, хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна.

Уншигч Таны эрдэм шинжилгээ, судалгааны ажилд тань өндөр амжилт хүсье.

Хүндэтгэсэн:

ИРГЭНИЙ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН ТЭНХИМИЙН
ПРОФЕССОР, ДЭД ХУРАНДАА Я.БАТГЭРЭЛ

ИРГЭНИЙ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ТАЛУУДААС ГАРГАСАН ГОМДЛЫГ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ

THE CONCERNING PROBLEM OF REVIEW AND RESOLVE COMPLAINTS LODGED BY PARTIES TO CIVIL DECISION ENFORCEMENT PROCESS



Я.Батгэрэл
Дотоод хэргийн их сургуулийн
Сургалт, судалгааны 403 дугаар анги-
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн профессор,
хууль зүйн магистр, дэд хурандаа

Товч утга: Монгол Улсын нэрийн өмнөөс гарсан хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг иргэн, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд хэрэв сайн дураар биелүүлээгүй бол тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн байгууллага болох Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадан гүйцэтгэх эрх зүйн зохицуулалттай билээ. Хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа нь аливаа хэрэг хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны үргэлжлэл бөгөөд төгсгөлийн шат юм[1].

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зорилго нь шүүхээс гарсан шийдвэрийг албадан биелүүлж, бусдын хуулиар хамгаалагдсан эрх ашгийг бодит байдлаар сэргээхэд оршдог. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага чиг үүргийнхээ хүрээнд иргэний хэргийн, захиргааны хэргийн, зөрчлийн хэргийн, эрүүгийн хэргийн талаарх шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулж байна.

Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 15 дугаар бүлэгт заасан үндэслэл журмын дагуу явагдах бөгөөд тухайн ажиллагаанд прокурор хяналт тавьж байдаг.

[1] Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох-чадавхийг бэхжүүлэх” төсөл. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гарын авлага. Уб., 2016. 51 дэх тал.

Монгол Улсын Үндсэн хуульд Прокурорын байгууллагын чиг үүргийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэрэгжүүлдэг олон талт ажиллагаанаас зөвхөн ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавихаар зохицуулж өгсөн байна.

Энэхүү илтгэлээр практикт идэвхтэй хэрэгжиж байгаа зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тавих прокурорын байгууллагын хяналт Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг эрх зүйн зүйн зохицуулалтын хүрээнд судалж, тодорхойлон гаргахыг зорилоо.

Уг илтгэлийг удиртгал, үндсэн хэсэг, дүгнэлт, санал, эх сурвалжийн жагсаалт гэсэн бүтэцтэйгээр бичсэн болно.

Түлхүүр үгс: Прокурорын байгууллага, шийдвэр гүйцэтгэгч, зөрчил үйлдсэн этгээд, аргачилсан заавар.

Key word: Prosecutor's office, enforcement officer, offender, methodical instruction.

ҮНДСЭН ХЭСЭГ

Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш Б.Чимид "Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл" бүтээлдээ "Цаг төрийн байдал, түүний жам ёсны хөгжлийг гүн ухаарч ирээдүйгээ зөв баримжаалж ажиллах нь хэнд ч болов өгөөжтэй. Тэр дундаа ийм хандлага төрийн мэргэшсэн албан хаагчдын сор нь байвал зохих шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөн байцаагч гээд шүүх эрх мэдлийн хүрээнийхэнд илүүтэй чухал. Тийн мэдвэл зохих чухал асуудлын нэг нь шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлал, түүний дагуу хийж буй төрийн байгууллын хийгээд эрх зүйн тогтолцооны шинэтгэл мөн"[2] хэмээгээд "өгүүлэн буй шинэтгэлийн гол зорилго нь нэгэнтээгүүр Монгол төр, хууль зүйн амьдралд байсан наашгай бүхнийг өвлөх, нөгөөтээгүүр гажигтай бүхнийг арилгаж, бүх эд эрхтнийг нь байвал зохих байран дээрээ урган хөгжиж, эв дүйтэй, үр нөлөөтэй ажилладаг болгоход оршиж байгаа билээ. Түүнийг прокурорын байгууллагын шинэтгэл тойрч гараагүй, гарах ч аргагүй"[3] гэж тэмдэглэн үлдээжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн далдугаар зүйлд "Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино"[4] гэж заасан нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн уг сурвалж нь Үндсэн хууль болохыг баталгаажуулсан хэрэг юм.

[2] Чимид,Б. Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл. Уб., 2017. 315 дахь тал
[3] Мөн тэнд
[4] Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. Уб., 1992. №1

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин зургадугаар зүйлд “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно[5]”, “Монгол Улсын прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно[6]” гэж тус тус заасан бөгөөд Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 9-ний өдөр шинэчлэн баталсан “Прокурорын тухай[7]” хуулийг батлан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Прокурорын тухай хууль нь Үндсэн хуульчилсан хууль бөгөөд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд прокурорын байгууллагын оролцоог зохицуулсан хууль юм.

1. ЗӨРЧЛИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА.

Зөрчлийн хэргийн талаарх шийдвэрийг шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтан өөрөө холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэх боловч шийдвэр гүйцэтгэгчийн эрхийг эдлэхгүй бөгөөд хэрэв шүүх гаргасан бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гүйцэтгэнэ.

Шийтгүүлсэн этгээд зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй, оргон зайлсан тохиолдолд шийтгэл оногдуулсан албан тушаалтан шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр шүүхэд хандах ба шүүхээс гүйцэтгэх хуудас олгосон тохиолдолд 7 хоногийн дотор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлснээр шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэл бий болно.

Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэл нь шүүхээс гүйцэтгэх хуудас олгосон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр байна. Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дараах шийдвэрийг үндэслэн явуулна.

1. Торгох шийтгэл оногдуулсан шүүгчийн шийтгэх хуудас;
2. Зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого, зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, тээврийн хэрэгсэл, уналгыг хураах, эсхүл түүний үнийг гаргуулан хураан авах тухай шийдвэр;
3. Хохирол, нөхөн төлбөр гаргуулах тухай шийдвэр;
4. Албадан эмчилгээ, албадан сургалтад хамруулах тухай шүүхийн шийдвэр;
5. Баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэр;
6. Гадаадын иргэнийг саатуулах тухай шүүхийн шийдвэр;

[5] Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. Уб., 1992. №1
[6] Чимид.Б. Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл бүтээлдээ Прокурорын статусыг ердийн биш “Үндсэн хуульчилсан хууль”-иар тодорхойлон зохицуулна гэсэн утгатай болно хэмээн тайлбарласан.
[7] Прокурорын тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. Уб., 2017. №24

7. Шүүхээс гүйцэтгэх хуудас олгосон бусад байгууллага, албан тушаалтны зөрчлийн хэргийн талаарх шийдвэр.

Ахлах шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг нээж, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх тухай тогтоол гарган зохих тойргийн шийдвэр гүйцэтгэгчид хуваарилна. Зөрчлийн хэргийн шийдвэрүүд хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 3 жилийн хугацаа өнгөрсөн бол зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэхгүй бөгөөд шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан этгээд оргон зайлсан хугацааг тухайн хугацаанд оруулан тооцохгүй. Харин шийдвэрийг буцаасан бол тухайн өдрөөс эхлэн хугацааг тоолно.

Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тойргийн харьяаллыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу тогтоодог бөгөөд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр төлөгчөөс төлбөрийг бүрэн барагдуулж дуусгавар болгох шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дарааллыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар нарийвчлан тогтоож өгсөн бол зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай ижил дарааллаар явуулна гэж зааснаас өөр зохицуулалт байхгүй байна.

Иймээс шийдвэр гүйцэтгэгч нь зөрчлийн хэргийн шийдвэр гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахдаа иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах дарааллын дагуу нэгэн адил явуулдаг.

Шийтгүүлсэн этгээд зөрчлийн хэргийн талаархи хуулийн хүчин төгөлдөр шийдвэрийг хууль болон шийтгэл, албадлагын арга хэмжээ оногдуулсан шийдвэрт өөрөөр заагаагүй тохиолдолд даруй биелүүлэх үүрэгтэй.

2. ПРОКУРОРЫН ХЯНАЛТ.

Нийтээр дагаж биелүүлэх журам тогтоосон хуулийн хэм хэмжээ зөрчсөн гэх үйлдэл, явдал нь эрх зүй зөрчсөн хэрэг болдог. Түүнийг зөрчигдсөн харилцааны шинж, үйлдсэн этгээдийн гэм буруугийн цар хэмжээгээр гэмт хэрэг, бусад зөрчил гэж ялгадаг[8]. Захиргааны зөрчил нь нийгмийн аюул, гэм буруугийн хэр хэмжээгээр их бол гэмт хэрэгт тооцогдох, мөн гэмт хэрэг гэсэн нь хор аюулаар ялимгүй бол захиргааны зөрчилд тооцогдох учир шалтгаан бий. Иймийн учир зохих албан тушаалтан их, бага энэ хоёр зөрчлийг бүртгэх, зохих нотолгоог бэхжүүлэх, зөрчлийн тухай хэрэг үүсгэх ажиллагаандаа хуулийг хэрхэн биелүүлж байгааг хянадаг[9].

Эрүүгийн болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж, хууль буруу хэрэглэвэл хүний эрх зөрчигдөх нөхцөл үүсдэг. Жишээлбэл эрүүгийн хэргийн болон

[8] Чимид.Б. Үндсэн хуулийн мэдлэг. Уб., 2008. 338 дахь тал
[9] Мөн тэнд

зөрчлийн хэргийн журмаар хүнийг цагдан хорих, баривчлахад тухайн хүнд халдаж байгаагаараа хүний эрхийн асуудал болдог.

Гавьяат хуульч Б.Чимид багш өөрийн бүтээлдээ прокурорын байгууллагын талаар "Ютай ч прокурорын хяналтад хамрагддаг байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хууль гажуудуулсан алдаа, зөрчил олонтоо тохиолдоно. Түүнээс улбаалан хүний эрх, эрх чөлөө, хуулийн этгээд, улмаар нийтийн хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж, хөсөрддөг нь үзтэл илт билээ. Үүнээс шалтгаалан шүүх эрх мэдлийг зөв шударгаар хэрэгжүүлэхэд чиглүүлэн хэрэгжүүлж буй прокурорын хяналт нь шүүх эрх мэдлийн хүрээнд хуулийг нэг мөр хэрэгжүүлж, хүний эрх, эрх чөлөөг хангахад нэн ач тустай юм"[10] хэмээн өгүүлсэн байдаг. Иймд прокурорын хяналт нэн чухал билээ.

Прокурор хяналтын үйл ажиллагаандаа хуулийг нэг мөр хэрэглэх, хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх, хараат бус, бие даасан байх, ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлан ажилладаг.

Прокурорын тухай хуулийн 22 дугаар зүйл[11]-д зааснаар прокурор ял эдлүүлэх ажиллагаанд дараах байдлаар хяналт тавина. Үүнд:

1. Хорих, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, тэнсэх, албадлагын арга хэмжээ биелүүлэх ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа эсэх;
2. Ял эдлүүлэх ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг зөв хэрэглэсэн эсэх;
3. Ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн эсэх;
4. Баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх ажиллагаа хуулиар тогтоосон нөхцөл, журамд нийцэж байгаа эсэх.

Ерөнхий прокурорын тушаалаар "Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих прокурорын хяналтын аргачилсан заавар[12]"-ыг баталсан бөгөөд тус зааврын зорилгыг "Энэхүү аргачилсан зааврын зорилго нь ял эдлүүлэх болон зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулийн заалтыг нэг мөр хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдсөн эрхийг сэргээх, эрүүдэн шүүх явдлыг гаргуулахгүй байхад прокурорын хяналтыг чиглүүлэх, прокурорын шийдвэр, үйл ажиллагаа хуульд нийцсэн байх, хяналт хариуцсан прокурорт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэхэд оршино" хэмээн тодорхойлоод "Энэ зааврыг хорих, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, тэнсэх, албадлагын арга хэмжээ, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон цагдан хорих, баривчлах, саатуулах шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд прокурорын

[10] Чимид.Б. Үндсэн хуулийн мэдлэг. Уб., 2008. 339 дэх тал
[11] Прокурорын тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. Уб., 2017. №24
[12] Монгол Улсын Ерөнхий прокурорын 2021 оны 5 сарн 27-ны өдрийн А/71 тушаалаар баталсан Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих прокурорын хяналтын аргачилсан заавар.

хяналтыг хэрэгжүүлэхэд дагаж мөрдөнө[13]” гэж зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тавих прокурорын хяналтыг тодорхой тусгаж өгсөн байна.

Улмаар уг зааврын зургадугаар бүлгийг зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тавих хяналт гэж нэрлээд энэ төрлийн ажиллагаанд хэрэгжүүлэх прокурорын хяналтыг нэг бүрчлэн тусган зааж өгсөн. Тухайлбал зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэн эхлүүлэхээс дуусгах хүртэлх бүхий л хугацаанд прокурор хяналт тавин ажиллахаар, мөн зааврын дөрөвдүгээр бүлэгт ял эдлүүлэх, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах харьяалал нь тухайн хоригдол, ялтан, тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээд, шийтгүүлсэн этгээдийн оршин суугаа газар, нутаг дэвсгэрийн эсхүл тусгайлсан чиг үүргийн дагуу хуульд зааснаар хэрэгжинэ[14] гэж тус тус заасан байна.

Мөн прокурор нь ял эдлүүлэх болон зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд Прокурорын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан хяналтыг мөн хуулийн 24 дүгээр зүйлд заасан арга, хэлбэрээр хэрэгжүүлнэ гэж зааварт тусгасан бөгөөд Прокурорын тухай хуулийн 22 дугаар зүйлд зааснаар прокурор ял эдлүүлэх ажиллагаанд дараах хяналт тавина. Үүнд:

1. Хорих, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, тэнсэх, албадлагын арга хэмжээ биелүүлэх ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа эсэх;
2. Ял эдлүүлэх ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг зөв хэрэглэсэн эсэх;
3. Ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн эсэх;
4. Баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх ажиллагаа хуулиар тогтоосон нөхцөл, журамд нийцэж байгаа эсэх.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Дээрх эрх зүйн зохицуулалтын хүрээнд судлан үзэхэд Монгол Улсын Ерөнхий прокурорын тушаалаар баталсан “Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих прокурорын хяналтын аргачилсан заавар”-т Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэрэгжүүлэн ажиллаж байгаа зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тавих хяналт нь Монгол Улсын Үндсэн хууль, Прокурорын тухай хуульд нийцээгүй байна гэж дүгнэж байна.

Тухайлбал Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлд прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно, Прокурорын тухай хуулийн 22 дугаар зүйлд ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих гэж зааж өгсөн байгаагаас тодорхой харагдана.

Мөн хуулийн дөрөвдүгээр зүйлд прокурор үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан хуулийг баримталж, орон нутаг, салбар, байгууллагын онцлогийг үл харгалзан хуулийг нэг мөр хэрэглэх явдлыг

[13] Монгол Улсын Ерөнхий прокурорын 2021 оны 5 сарын 27-ны өдрийн А/71 тушаалаар баталсан Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих прокурорын хяналтын аргачилсан заавар.
[14] Мөн тэнд

хангана[15]” гэж заасан бөгөөд ерөнхий прокурорын баталсан дээрх зааварт зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавихаар зохицуулсан нь Үндсэн хууль болон Үндсэн хуульчилсан хуулийг зөрчиж байна гэж судлаачийн хувьд үзлээ.

Орчин үеийн шаардлага хангасан Үндсэн хуульт төрийг тодорхойлдог хэм хэмжээний тогтолцоонд Үндсэн хууль нь төрийн дээд хүчин чадал бүхий хэм хэмжээ мөн тул хууль, эрх зүйн бусад акт, дүрэм журмууд түүнд нийцсэн байх ёстой.

Иймд Монгол Улсад мөрдөгдөж байгаа Үндсэн хуульчилсан хууль, ердийн хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, дүрэм, заавар Үндсэн хуульд бүрэн нийцэж байхын тухайд “Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих прокурорын хяналтын аргачилсан заавар”-ыг Үндсэн хуульд нийцүүлэх, эсхүл Үндсэн хуульдаа Прокурорын байгууллагын хамаарах үйл ажиллагаанд зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тавих хяналтыг нэмж тусгах саналтай байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Прокурорын тухай хууль, 2017.
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017.
4. Зөрчлийн тухай хууль, 2017.
5. Монгол Улсын Ерөнхий прокурорын 2021 оны 5 сарын 27-ны өдрийн А/71 тушаалаар баталсан Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих прокурорын хяналтын аргачилсан заавар.

Ном, бүтээл

1. Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал (Илтгэл, өгүүлэл, ярилцлага, дурсамж), 2002.
2. Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл, 2017.
3. Б.Чимид. Үндсэн хуулийн мэдлэг, 2008.
4. Д.Гангабаатар, Үндсэн хуулийн эрх зүй Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал, 2017
5. Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, 2000.

---o0o---

[15] Прокурорын тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. Уб., 2017. №24

ХҮҮХДИЙН ТЭТГЭЛЭГ ГАРГУУЛАХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ТУЛГАМДСАН АСУУДАЛ

AND ISSUES OF DECISION ENFORCEMENT OF THE MAINTENANCE ALLOWENCE FOR CHILDREN



Б.Базарсад
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Банкны төлбөр барагдуулах газрын дэд дарга, Дотоод хэргийн их сургуулийн магистрант, хошууч

Товч утга: Хүүхдийн тэтгэлэг гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт, тулгамдаж буй асуудлыг судалж, шийдвэрлэх арга замыг тодорхойлохыг зорилоо.

Abstract: We aim to study the legal regulations, implementation, and problems of the execution of child support decisions, and determine ways to solve them.

Түлхүүр үг: Шийдвэр гүйцэтгэгч, тэтгэлэг төлөгч, тэтгэлэг авагч, хүүхэд, амьжиргааны түвшин, тэтгэлгийн хэмжээ.

Key word: Executor, the payer grant, grantee, child, standard of living, amount of grant

ҮНДСЭН ХЭСЭГ:

Гэр бүлийн эрх зүйн хамрах асуудлын хүрээнд тэжээн тэтгэх, тэр дундаа хүүхдийг тэтгэхтэй холбогдсон харилцаа онцгой байр суурийг эзэлдэг. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.11-д “Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн эрх ашиг сонирхлыг төр хамгаална[16] гэж заажээ. 18 насанд хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэх бөгөөд хүүхдийн бие бялдар, оюун ухаан гүйцэд төлөвшөөгүйн улмаас түүнийг төрөхийн өмнө болон төрсний дараа онцгой халамж, хамгаалалт шаардлагатайн зэрэгцээ тэдний гэр бүлийн дотор аз жаргалтай, хайр халамжтай, бие биеэ ойлгодог, нөхцөлд өсөж бойжвол өв тэгш хүмүүжиж хөгжиж чадна. Тийм ч учраас эцэг, эх асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн амьдрах эрүүл орчныг

[16] Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. -Уб., 1992 он. №01

бүрдүүлэх, бие бялдрын хувьд эрүүл чийрэг өсгөн хүмүүжүүлэх, хөгжүүлэх нэн шаардлагатай хоол хүнс орон байр, хувцас бусад зүйлээр хангах зэргээр хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд хамгаалдаг.

ХҮҮХДИЙН ТЭТГЭЛГИЙГ ГАРГУУЛАХ АЖИЛЛАГАА:

Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааг Гэр бүлийн тухай хууль[17], Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль[18]-ийг үндэслэн явуулж байна. Хүүхдийг тэжээн тэтгэх үүрэг нь хүүхдийг эрүүл орчинд өсөж хүмүүжихэд шаардлагатай хэрэгцээт наад захын зүйлсийг хангахад чиглэгддэг.

Хүүхдийн тэтгэлэг гэж хуульд заасан хэмжээ, хугацаагаар мөнгөн болон эд хөрөнгөөр гаргуулж, тэжээн тэтгүүлэгч хүүхдийн хэрэгцээнд зарцуулах хөрөнгийг хэлнэ. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаа нь хэдийгээр иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нэгэн адил явагдах боловч гэр бүлийн хүрээнд явагддаг өвөрмөц ажиллагаа юм.

Гэр бүлийн тухай хуульд зааснаар эцэг, эх нь насанд хүрээгүй болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй. Энэхүү үүргээ эцэг, эх нь харилцан тохиролцож гэрээ байгуулан шийдвэрлэж болохоор хуульд заасан ба хэрэв тэтгэлгийн хэмжээг харилцан тохиролцоогүй, тохиролцоонд хүрч чадаагүй, гэрээ байгуулаагүй тохиолдолд тэтгэлгийн хэмжээг хүүхдийн насны байдлыг харгалзан шүүх тогтоодог.

Хүүхдийн тэтгэлгийг мөнгийг тухайн тэжээн тэтгүүлэгч хүүхдийн оршин суугаа нутаг дэвсгэрт тогтоосон амьжиргааны доод түвшингийн тодорхой хувь хэмжээгээр тооцон төлбөр төлөгчөөс гаргуулан тэтгэлэг авагчид олгоно. Тэтгэлэг авагч хүүхэд гадаад улсад суугаа бол иргэний бүртгэлд бүртгэгдсэн болон сүүлд оршин сууж байсан бүс нутагт тогтоосон амьжиргааны доод түвшингийн тодорхой хувь хэмжээгээр тооцон олгодог.

Шүүх хүүхдийн насыг харгалзан сард төлүүлэх тэтгэлгийг хэмжээг 11 хүртэлх насны хүүхдэд тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшингийн 50 хувиар, 11-16 нас /суралцаж байгаа бол 18 нас/-тай болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдэд амьжиргааны доод түвшингийн 100 хувиар тооцон тогтоодог.

Монгол Улсын “Хүн амын амьжиргааны доод түвшнийг тодорхойлох тухай”[19] хуулийн 3 дугаар зүйлд зааснаар хүн амын амьжиргааны доод түвшин гэж “хэрэглээний доод хэмжээ”-г мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг хэлэх бөгөөд, “хэрэглээний доод хэмжээ[20]” гэж хүний нэн тэргүүний зайлшгүй хэрэгцээг хангах

[17] Гэр бүлийн тухай хууль. Уб., 1999. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №30
[18] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 1999. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №24
[19] Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл №2.Уб., 1998.
[20] Мөн тэнд

хүнсний болон хүнсний бус хэрэглээний сагсаар тодорхойлсон бараа, үйлчилгээний шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоосон тоо, хэмжээг ойлгоно хэмээн заасан.

Хүн амын амьжиргааны доод түвшнийг жил бүр тодорхойлдог. Ингэхдээ тухайн жилийн бараа, бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтөөс хамаарч жилд 1-ээс доошгүй удаа шинэчлэн тодорхойлох бөгөөд дэлхийн улс орнуудад өргөн хэрэглэгддэг хэрэглээний сагс, хэрэглээний үнийн индексийг үндэслэн тооцдог аргыг өөрийн орны онцлог нөхцөлтэй уялдуулан хэрэглэнэ.

Мөн хүн амын амьжиргааны доод түвшнийг бүсийн ялгавартайгаар бүсчилсэн хөгжлийн баримт бичигт тусгагдсан бүсээр тодорхойлдог. Үүнд:

1. Баруун бүс: Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд
2. Хангайн бүс: Архангай, Баянхонгор, Булган, Өвөрхангай, Хөвсгөл, Орхон
3. Төвийн бүс: Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул
4. Зүүн бүс: Дорнод, Сүхбаатар, Хэнтий
5. Улаанбаатар: Улаанбаатар хот хамрагдана.

Хүүхдийн тэтгэлгийг Гэр бүлийн тухай хуульд зааснаар сар, улирал, жилээр болон 1 удаа бөөнд нь мөнгөн хэлбэрээр болон эд хөрөнгөөр олгож болно. Тэтгэлгийг эд хөрөнгөөр олгохоор талууд харилцан тохиролцсон бол эд хөрөнгийг орон нутгийн зах зээлийн тухайн үеийн ханшаар үнэлнэ.

Хүүхдийн тэтгэлэг төлөгчийн дийлэнх хувь нь иргэн, тэр дундаа эцэг нь байх бөгөөд цөөхөн тохиолдолд хуулийн этгээд тэтгэлэг төлөгч байдаг. Энэ нь хуулийн этгээдийн буруутай үйлдлээс шалтгаалан гэнэтийн осол, аваарт хүүхдийн эцэг, эх нь өртөж нас барсан тохиолдолд тухайн хүүхэд болон гэр бүлийг тэжээн тэтгэх үүргийг тухайн хуулийн этгээд биелүүлж, хүүхдийн тэтгэлэг төлөх тохиолдол гардаг.

Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаа нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бусад ажиллагаанаас дараах онцлогоор ялгагдана. Үүнд:

- Хүүхдийн тэтгэлэг нь сар бүр тодорхой мөнгөн дүнгээр давтамжтайгаар төлөгдөж байдаг;
- Хүүхдийн тэтгэлэг нь хүүхдийн насны байдлаас хамааран өөр өөрөөр тогтоогддог бөгөөд 11 нас хүрсэн бол төлөх хэмжээ 1 дахин нэмэгдэж байдаг;
- Хүүхдийн тэтгэлгийг хэмжээ жил бүр 1 удаа, зарим жилд 2 удаа амьжиргааны доод түвшнийг хэмжээнээс хамааран өөрчлөгдөж байдаг;
- Хүүхдийн тэтгэлэг гаргуулах шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны явцад тэтгэлэг төлөгч хэд хэдэн төлбөр төлөх үүрэг хүлээсэн бол хүүхдийн тэтгэлгийг дараалал харгалзахгүй тэргүүн ээлжид олгоно;

➢ Хүүхдийн тэтгэлэг гаргуулах шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа нь хүүхдийг 18 нас хүртэлх хугацааны тэтгэлгийг бүрэн төлж дуусах хүртэл үргэлжилнэ. Тэтгэлэг авагч хүүхэд 18 нас хүрсэн ч тэтгэлгээ бүрэн аваагүй бол тэтгэлэг гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа тэтгэлгийг бүрэн гаргуулах хүртэл үргэлжлэн явагдах ёстой.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүүхэд шилжүүлэх эсхүл тодорхой үүрэг гүйцэтгүүлэх шүүхийн шийдвэр харьцангуй бага ирдэг боловч биелүүлэхэд ихээхэн хүндрэл учруулдаг. Шүүхийн шийдвэрт хүүхдийг хууль бус асран хамгаалагчаас (эцэг, эх, эмээ, өвөө) шилжүүлэн шүүхийн шийдвэрт заасан хууль ёсны асран хамгаалагчид (эх, эцэг) хүлээлгэн өгөхөөр шийдвэрлэсэн бол хүүхэд шилжүүлэх үүргийг хангуулах хугацааг төлбөр төлөгч, бусад этгээдэд тогтоож, хүүхдийг асран хамгаалагчид хүлээлгэн өгч, холбогдох үйл явцыг баталгаажуулна.

Шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахдаа хүүхдийн оршин суух газрын өрхийн эмнэлэгтэй хамтран хүүхдийн биед эрүүл мэндийн үзлэг хийлгэж, ил шарх, сорви, бэртэл, гэмтэл байгаа эсэхийг нягтлан шалгаж, хүүхэд хүлээлцсэн тэмдэглэлд тусгаж, оролцогчоос гаргасан санал, хүсэлтийг шийдвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Шүүхээс гэр бүл цуцалсан шийдвэрийг гаргахдаа хүүхдийг эцэг, эх болон хамаарал бүхий этгээдтэй нийтээр амрах болон баяр ёслолын өдрүүд түүнчлэн бусад хугацаанд (хүссэн үед) уулзуулахыг даалгах, долоо хоногт нэгээс доошгүй хоног хамт байлгахыг даалгах зэрэг олон төрлийн шийдвэрийг гаргадаг. Гэтэл энэ төрлийн шийдвэрийг гүйцэтгэхэд заавал шийдвэр гүйцэтгэгч биечлэн уулзуулах шаардлагатай болдог.

Энэ тохиолдолд талуудыг тодорхой үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан гэрээ байгуулах замаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах бөгөөд үүрэг хүлээсэн этгээд шүүхээс даалгасан тодорхой үүргийг биелүүлээгүй бол түүний үйлдэл, эс үйлдэхүйд зөрчлийн хариуцлага тооцуулах үндэслэл болдог.

Шүүхийн шийдвэрт заасан асран хамгаалагчид хүүхдийг шилжүүлэх явцад тухайн хүүхэд очихоос татгалзсан, уг үндэслэлээр сэтгэл зүйн цочролд орсон бол шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түр зогсооно.

Шийдвэр гүйцэтгэгч шүүхийн шийдвэрээр тогтоосон тэтгэлгийг төлөгдөөгүй хэсгийг хугацаа харгалзахгүйгээр тэтгэлэг төлөгчөөс нөхөн гаргуулах ба тэтгүүлэгч хүүхэд 18 насанд хүрч, уг үндэслэлээр иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгосон бол төлөгдөөгүй хугацааны тэтгэлгийг нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг шүүхэд тэтгэлэг авагч эсхүл тэтгүүлэгч хүүхэд гаргаж болно.

Шийдвэр гүйцэтгэгч хүүхдийн тэтгэлэг төлөлтийн тооцоог бодож төлөөгүй хугацааг тооцон энэ хугацаан дахь тэтгэлгийн хэмжээ тооцож гарган тэтгэлэг төлөгч, тэтгэлэг авагч нарт танилцуулан гарын үсэг зуруулан баталгаажуулна.

Тэтгэлэг авагч хүүхэд 18 нас хүрээгүй бол шийдвэр гүйцэтгэгч өөрөө дээрх төлөгдөөгүй тэтгэлгийг нөхөн гаргуулах ажиллагааг явуулах бөгөөд тэтгэлэг авагч хүүхэд 18 насанд хүрсэн бол төлөгдөөгүй тэтгэлгийн талаарх тодорхойлолтыг гарган тэтгэлэг авагчид өгнө. Тэтгэлэг авагч шийдвэр гүйцэтгэгчийн гаргаж өгсөн тодорхойлолтыг нотлох баримт болгон, хүүхдийн тэтгэлгийг алдангийн хамт нөхөн төлүүлэх шийдвэрийг гаргуулахаар шүүхэд хандаж болно.

Тэжээн тэтгүүлэгч хүүхэд бусдад үрчлэгдсэн бол тэжээн тэтгэх үүрэг дуусгавар болох ч үрчлэлтийн харилцаа үүсэхээс өмнөх төлөгдөөгүй хугацааны тэтгэлгээс тэтгэлэг төлөгчөөс чөлөөлөх үндэслэл болохгүй бөгөөд тэтгэлэг төлөгчөөс тухайн тэтгэлгийн мөнгийг нөхөж гаргуулна.

Тэтгэлэг төлөгч хуулийн этгээдээс хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааг төлбөр төлөгч-хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны журмаар гүйцэтгэнэ.

Шүүхийн шийдвэрийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй, хөдөлмөр эрхлэх чадвартай бөгөөд хөдөлмөр эрхлээгүй үндэслэлээр тогтоосон тэтгэлгийг төлөхөөс зориуд зайлсхийсэн, эсхүл шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд зориуд саад учруулсан хүн, хуулийн этгээд, төлбөр төлөгчид хууль заасан хариуцлага хүлээлгэнэ[21].

Нийслэлийн хэмжээнд 2023 онд хүүхдийн тэтгэлэг гаргуулах 6116 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг явуулж байна. Үүний цаана багаар бодоход 7 мянган хүүхдийн эрх зөрчигдөж буй юм. Тэтгэлэг авагч хүүхдийг насны байдлаар ангилбал:

Улсын хэмжээнд 2023 оны байдлаар 15128 гэр бүл шинээр батлуулсан бол 4102 гэр бүл буюу 27,1% нь гэр бүлээ цуцлуулсан байна[22]. Тэгвэл нийт шүүхээр гэр бүл цуцлуулсан хүүхдийн тэтгэлэг тогтоолгосон хэрэг маргааны 45% буюу 1878 гүйцэтгэх баримт бичиг Шийдвэр гүйцэтгэх байгууллагад иржээ[23].

Үүний 47,8 хувь буюу 898 гүйцэтгэх баримт бичиг нийслэлийн хэмжээнд хүүхдийн тэтгэлэг гаргуулах чиг үүрэг бүхий дагнасан нэгж болох Банкны төлбөр барагдуулах газарт шинээр ирсэн байна. Тус газар 2023 онд хүүхдийн тэтгэлгийн 5968 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулж 484 гүйцэтгэх баримт бичгийг биелүүлж 8,1%-ийг хааж дуусгавар болгож 5484 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй ажиллаж байна[24].

[21] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №24. Уб., 2017
[22] Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 оны 10 сарын тайлан мэдээ.
[23] ШШГЕГ-ын Шийдвэр гүйцэтгэх албаны 2023 оны 10 сарын мэдээ.
[24] Банкны төлбөр барагдуулах газрын 2023 оны 10 сарын мэдээ.



Зураг №1 Гэр бүл цуцлалтын байдал



	Үлдэгдэл	Хэсэгчилэн гүйцэтгэсэн	Төлбөр авхаастатгалзсан	Талууд эвлэрсэн	Бүрэн төлж дуусгасан	Гүйцэтгэвэл зохих	Хасагдсан	Нэмэгдсэн	Урдоны үлдэгдэл
2021 он	4710	2805	146	250	257	5363	59	766	4656
2022 он	5123	3063	145	214	252	5734	537	1561	4710
2023 он	6947	3194	122	164	272	5556	63	1055	5124

Зураг № 2 Хүүхдийн тэтгэлэг төлөлтийн судалгаа

Д/д	Төлбөр төлөгдөхгүй байгаа шалтгаан	Гүйцэтгэх баримт бичгийн тоо
1	Төлбөрийн чадваргүй	383
2	Оршин суух хаяг тодорхойгүй	445
3	Эрэн сурвалжилж байгаа	100
4	Хорих ангид ял эдэлж буй	29
5	Бусад	2125
Нийт		3082

Судалгаанаас харахад үлдэгдэл гүйцэтгэх баримт бичгийн 55 хувь нь хүүхдийн тэтгэлэг огт төлөхгүй, шүүхийн хүчин төлдөр шийдвэрийг биелүүлэхгүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тайлан мэдээнээс нийслэлийн хэмжээнд хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааг хэрхэн хэрэгжүүлж байгааг сүүлийн 3 жилийн байдлаар харьцуулан судалгаа хийлээ[25].

Судалгаанаас шинээр ирсэн гүйцэтгэх баримт бичиг төдийлөн өсөөгүй байхад үлдэгдэл гүйцэтгэх баримт бичгийн тоо өссөн үзүүлэлттэй байна. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж тэтгэлгийн бүрэн болон хэсэгчлэн гүйцэтгэсэн тоо үзүүлэлт өмнөх оны мөн үеэс өсөөгүй байгаа нь хариуцсан нэгжийн ажил тааруу байгаа харуулж байна гэж судлаачийн хувьд үзлээ.

Бүс нутаг	Хамрагдах аймаг	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Баруун бүс	Баян-Өлгий	197,000	203,400	212,600	238,800	274,400	447,100
	Говь-Алтай						
	Завхан						
	Увс						
	Ховд						
Хангайн бүс	Архангай	194,300	206,000	213,800	240,400	282,500	447,300
	Баянхонгор						
	Булган						
	Өвөрхангай						
	Хөвсгөл						
	Орхон						
Төвийн бүс	Говьсүмбэр	187,100	198,300	207,400	239,200	272,300	446,700
	Дорноговь						
	Дундговь						
	Өмнөговь						
	Сэлэнгэ						
	Төв						
	Дархан-Уул						
Зүүн бүс	Дорнод	187,600	201,700	210,300	236,400	271,800	446,400
	Сүхбаатар						
	Хэнтий						
Улаанбаатар		217,900	230,000	238,700	277,800	313,400	454,200

Зураг № 3 Амьжиргааны баталгаажих түвшингийн өсөлт, бууралт

Шүүхээс гэр бүл цуцлуулж байгаа тохиолдолд тэтгэлгийн хэмжээг Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр тогтоодог. Амьжиргааны доод түвшингийн хэмжээ жил бүр хүн амын суурь хэрэгцээг хангах хэрэглээний түшингээр нь бүс нутгаар нь

[25] ШШГЕГ-ын Шийдвэр гүйцэтгэх албаны 2023 оны 10 сарын мэдээ.

ангилан тогтоодог. Энэ нь тэтгүүлэгч хүүхдийн суурь хэрэгцээг хангах урьдач нөхцөлд болдог ч хөдөлмөр эрхэлдэггүй, хөрөнгө орлогогүй тэтгэлэг төлөгчдийн хувьд хүндээр туслах нь байдаг. Эдгээр тэтгэлэг төлөгчдийг ажлын байраар хангаж, цалин орлогоос нь тодорхой хувийн суутгал хийх замаар тэтгэлэг төлүүлэх асуудлыг Төрөөс зохион байгуулах шаардлагатай байна.

Амьжиргааны доод түвшингийн хэмжээ нь[26] жилд дунджаар 9,7 хувиар өсөж байгаа нь төлбөрийн хэмжээ тэр хэрээр нэмэгдэж байгаа юм. Тухайлбал, Улаанбаатарт 2019-2020 онд 5,6%, 2020-2021 онд 3,9%, 2021-2022 онд 16,4%, 2022-2023 онд 12,8%, 2023-2024 онд 31% дунджаар 13,9% өссөн байна.

ДҮГНЭЛТ

Шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх ажиллагааны буюу хүүхдийн тэтгэлгийн төлбөр барагдуулалтын бодит биелэлтийн мэдээллээс харахад гүйцэтгэх баримт бичгийн биелэлт 10-15 хувьтай, биелүүлбэл зохих мөнгөн дүнгийн биелэлт 40-45 хувьтай байгаа нь хүүхдийн тэжээн тэтгүүлэх эрхийн хэрэгжилт төдийлөн хангалтгүй байгаа нь харагдаж байна. Энэ нь нэг талаас шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хангалттай хийгдэхгүй байна гэж судлаачийн хувьд үзэж байна.

Нөгөө талаасаа бодит биелэлт хангалтгүй байгаа нь нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай шууд холбоотой гэж үзлээ. Учир нь дэлхий нийтийг хамарсан коронавируст халдварын үед буюу 2021 онд шүүхээс ирсэн гүйцэтгэх баримт бичгийн тоо 898 байгаа бол халдварт өвчний тархалт буурсан, иргэд хэвийн амьдралдаа эргэн орсон 2022 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар гүйцэтгүүлэхээр ирсэн шүүхийн шийдвэр, гүйцэтгэх хуудасны тоо 1561 буюу өмнөх оны мөн үеэс 57,5 хувиар өссөн нь статистик мэдээллээс харагдаж байна.

Хүүхдийн тэтгэлэг төлөгдөхгүй байгаа шалтгаан, нөхцөлийн тайлбарласан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий албан ёсны мэдээллээс харахад төлбөрийн чадваргүй, оршин суугаа хаяг тодорхойгүй, хорих ял эдэлж байгаа, эрэн сурвалжлагдаж байгаа, бусад гэсэн агуулгаар тайлбарласан. Үүний бусад гэдэг ангилалд 2023 оны 10 дугаар сарын байдлаар гаргасан бодит биелэлтийн мэдээнд 2053 гүйцэтгэх баримт бичгийг буюу нийт гүйцэтгэх баримт бичгийн 37 хувийг шалтгаан тодорхойгүй гэж дүгнэжээ.

Энэ нь судлаачийн хувьд харахад шалтгаан нь үндэслэлгүй, мэдээний тоон үзүүлэлтийг тааруулсан тоо гэж үзэж байна. Эсхүл иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэх эрх зүйн үндэслэлд заасан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл байхгүй байгаагаас шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад талуудаас гаргасан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүчингүйд

[26] Хүн амын амьжиргааны доод түвшнийг Монгол Улсын Үндэсний статистикийн хороо жил бүр тогтоодог.

тооцох санал, гомдол зэргээс шалтгаалан шийдвэр гүйцэтгэх ажиллагаа түдгэлзсэн үндэслэлээр төлбөр төлөлт хийгээгүй баримт бичиг байх боломжтой гэж харж байна.

Мөн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад нэг гүйцэтгэх баримт бичгээр эсхүл хэд хэдэн гүйцэтгэх баримт бичгээр хэд хэдэн хүүхдийн тэтгэлэг төлж байгаа нөхцөлд сард гаргуулах төлбөр нь тэтгэлэг төлөгчийн цалин, хөлсний 50 хувиас хэтрүүлэхгүй байхаар зохицуулсан хуулийн зохицуулалтаас шалтгаалан хуримтлал үүсдэг. Энэ нь тэтгэлэг төлөгдөөгүй шалтгаан болдог учир мэдээний үзүүлэлтэд энэ агуулгаар төлөгдөөгүй шалтгааныг задлан оруулах нь дээд шатны байгууллага, албан тушаалтан, иргэдийг үнэн зөв, бодит мэдээллээр хангах үндэслэл болно гэж харж байна.

САНАЛ

Дээрх санал дүгнэлтдээ тулгуурлан дараах саналыг гаргаж байна.

1. Эрх зүйн зохицуулалтын хүрээнд

Гэрийн бүлийн тухай хуульд тэтгүүлэгч 18 насанд хүрснээр тэжээн тэтгэх үүрэг дуусгавар болдог боловч өмнөх хуримтлагдсан тэтгэлгээ авах эрх нь дуусахгүй болохыг анхаарах шийдвэр гүйцэтгэгч ажиллагааг дээрх үндэслэлээр дуусгаж болохгүй, мэдээнд оруулахгүй байхаа талаар анхаар ч ажиллах.

2. Үндэсний статистикийн хорооны зөвшөөрлөөр Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар баталдаг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны мэдээний загвар, аргачлал, журам, зааврыг шинэчлэн боловсруулах чиглэлээр

- Хүүхдийн тэтгэлгийн мэдээ боловсруулахад гүйцэтгэх баримт бичгийн хуримтлал болон тэтгэлгийн тооцоо бодох аргачлалыг шинэчлэл оруулах
- Хүүхдийн тэтгэлгийн төлбөр барагдуулалтын мэдээний одоогийн загварыг Үндэсний статистикийн хорооны даргын зөвшөөрснөөр, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 02-р сарын 13-ны өдрийн А/24 тоот тушаалаар баталсан байдаг. Энэхүү загварын үндсэн үзүүлэлтийн хасагдсан төлөв дээр түдгэлзүүлсэн үндэслэлийг нэмэх, тайлант хугацааны үлдэгдэл хэсгийн бусад гэсэн үзүүлэлтийг хасах эсхүл шалтгаан, нөхцөлийг дэлгэрэнгүй оруулах саналтай байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Үндсэн хууль. Уб 1992 он.
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уб. 2017 он.
3. Гэр бүлийн тухай хууль, Уб. 1999 он.
4. А.Лхагва “Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй” Уб. 2012 он

5. Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. Уб. 1966 он
6. С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. Уб., 2007 он

СУДАЛГАА СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ

1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын статистик мэдээ.
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын статистик мэдээ.
3. Банкны төлбөр барагдуулах албаны статистик мэдээ.

---o0o---

ТӨЛБӨР ТӨЛӨГЧИЙГ ЭРЭН СУРВАЛЖЛАХ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

METHODS OF ORGANIZING AND IMPROVING THE MANAGEMENT OF DEBTOR SEARCH ACTIVITIES



А.Жандаг
Дотоод хэргийн их сургуулийн
Удирдлагын академийн 8013 дугаар дамжааны
сурагч, хошуучийн

Товч утга: Шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийж эрэн сурвалжлагдаж буй төлбөр төлөгчийг олж тогтоох үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалтын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, цаашид сайжруулах арга замын тодорхойлоход оршино.

Abstract: The management of the operation to find the wanted debtor who avoids the execution of the court decision is to analyze the current state of the organization and determine the ways of further improvement.

Түлхүүр үгс: Эрэн хайх, сурвалжлах, төлбөр төлөгч, зайлсхийх, зохион байгуулалт

Key words: Search, reporting, debtor, avoidance, organization

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг шүүхийн шийдвэрт заасан бодит байдлаар сэргээх, шүүх болон бусад эрх олгогдсон байгууллагаас гаргасан шийдвэрийг заавал гүйцэтгэх, хилсээр нэг ч хүнийг шийтгэхгүй байх зорилгын хүрээнд шүүх эрх мэдлийн гүйцэтгэлийг хэрэгжүүлэгч эрх зүйн тулгуур үндсийг тодорхойлсон бие даасан салбар юм.

Өмнө хүчин төгөлдөр үйлчилж байсан хуулиудтай харьцуулбал шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль нь олон зарчмын шинжтэй өөрчлөлт, шинэчлэлийг эхлүүлсэн боловч зарим зохицуулбал зохих эрх зүйн харилцааг зохицуулж чадаагүй болно. Үүний нэг жишээ нь: Эрүү, Иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх явцад зайлсхийж эрэн сурвалжлагдаж буй этгээдийг олж тогтооход үүссэн эрх зүйн харилцаа юм.

Шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийж, эрэн сурвалжлагдаж буй этгээдийг олж тогтоох ажиллагааны талаар судалсан зүйл дутмаг байгаа нь сэдвийг судалгах хэрэгцээ, шаардлага байгааг илтгэж байна.

НЭГ. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНААС ЗАЙЛСХИЙСЭН ЭТГЭЭДИЙГ ЭРЭН СУРВАЛЖЛАХ АЖИЛЛАГАА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Эрэн сурвалжлах ажиллагаа: Хэн нэгэн этгээд болон түүний эд хөрөнгийн хуульд заасан үндэслэл журмын дагуу тогтоохоор тодорхой газар, нутагт явуулах ажиллагаа[27].

Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллага, албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шийдвэр байна[28]. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд:

- ✓ иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа
- ✓ захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа
- ✓ зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа
- ✓ эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

хамаардаг[29].

Дээр дурдсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас иргэний хэргийн талаарх шийдвэр гүйцэтгэх ажиллагааг онцлон авч үзье.

Иргэний хэрэг үүсгэхдээ шүүх эдийн ба эдийн бус баялагтай холбоотой эрх нь зөрчигдсөн тухай эрх зүйн харилцаанд оролцогч этгээдээс гаргасан нэхэмжлэл, бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалж шүүхэд мэдүүлэх эрх нь хуулиар олгогдсон этгээдээс гаргасан нэхэмжлэл, онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлүүлэхээр хуульд заасан асуудлаар сонирхогч этгээдээс гаргасан хүсэлт, Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд зааснаас бусад байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа болон тэдгээрийн гаргасан захиргааны актын талаар гаргасан гомдол, хуульд заасан бусад үндэслэлээр үүсгэнэ.[30] Иймхүү иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэж, явуулахдаа иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг баталгаажуулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг.

---

[27] Нарангэрэл, С. Гүйцэтгэх ажлын эрэн сурвалжлалт. Уб., 2003. 14 дэх тал

[28] Шүүхийн шийвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл №24.5 дугаар зүйл.

[29] Шүүхийн шийвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл №24.6 дугаар зүйл.

[30] Төрийн мэдээлэл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. –Уб., 2002. №8.

Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээ гэж гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг албадан гүйцэтгэх, эсхүл төлбөр төлөгчийг гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг тогтоосон хугацаанд бүрэн гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн шийдвэр гүйцэтгэгчийн хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлэх арга х эмжээг ойлгоно[31].

Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээнүүдээс онцлон анхаарах ёстой үйл ажиллагаа нь төлбөр төлөгч түүний эд хөрөнгийг эрэн сурвалжлах юм.

Төлбөр төлөгчийн оршин суугаа /байгаа/ хаяг тогтоох, тэдгээрийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа байршил тодорхойгүй хөрөнгө илрүүлэх иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эрэн сурвалжлах ажиллагаанд хамааруулан ойлгоно[32].

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч, түүний хөрөнгийг дараах эрх бүхий албан тушаалтан эрэн сурвалжилна.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн эрэн сурвалжлах чиг үүрэг бүхий нэгж, албан хаагч;
- Гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж буй тойргийн шийдвэр гүйцэтгэгч;
- Шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг үндэслэн цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан

Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгч, түүний хөрөнгийг олж тогтоох бүхий л ажиллагааг явуулсан боловч тодорхой үр дүн гараагүй бол тэдгээрийг эрэн сурвалжилж, олж тогтоох үүргийг энэ хуулийн 257.7-д заасан нэгжид даалгана[33].

Эрэн сурвалжлах ажиллагаа явуулах эрх олгогдсон албан тушаалтан нь төлбөр төлөгч, түүний хөрөнгөтэй холбогдуулан Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасан тодорхой ажиллагаа гүйцэтгэх эрх эдлэхгүй ба гүйцэтгэх баримт бичигт заагдсан төлбөр төлөгчийг олж тогтоох, хөрөнгийн байршлын мэдээлэл шалгах, хөрөнгө олж илрүүлэх албадлагын арга хэмжээгээр эрэн сурвалжлах ажиллагааны хамрах хүрээ тодорхойлогдож байна.

Эрэн сурвалжлах ажиллагаа явуулах чиг үүрэг бүхий шийдвэр гүйцэтгэгч, ажилтан байхгүй нэгжид тухайн тойргийн шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгч, түүний хөрөнгийг эрэн сурвалжлах ажиллагааг гүйцэтгэнэ. Төлбөр төлөгч, түүний хөрөнгийг эрэн сурвалжлах ажиллагааны хамрах хүрээг тухайн нутаг дэвсгэр

[31] Шүүхийн шийвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл №24.44 дүгээр зүйл

[32]Өнөрцэцэг, Ч., Дамдинцэрэн, Д., Дашдаваа, Б. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараалал, эрх зүйн зохицуулалт. Уб., 2022.120 дахь тал.

[33] Шүүхийн шийвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл №24.57 дугаар зүйл.

эсхүл тодорхой нутаг дэвсгэрт эсхүл улсын хэмжээнд зохион байгуулах ба эрэн сурвалжлах ажиллагаа тодорхой нутаг дэвсгэрт үр дүнд хүрээгүй тохиолдолд улсын хэмжээнд эрэн сурвалжлах ажлыг гүйцэтгэнэ.

Төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг эрэн сурвалжлах тухай шийдвэр нь тэдгээрийг улсын хэмжээнд болон Монгол Улсын олон улсын гэрээний дагуу гадаад улсын нутаг дэвсгэрт эрэн сурвалжлах үндэслэл болно[34]. Эрэн сурвалжлах шийдвэрийг гүйцэтгэх баримт бичигт ажиллагаа явуулж буй тойргийн шийдвэр гүйцэтгэгч эсхүл эрэн сурвалжлах ажиллагаа явуулах дагнасан чиг үүрэг бүхий шийдвэр гүйцэтгэгч тухайн нутаг дэвсгэрийн ахлах шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрлийг үндэслэн үйлдэнэ.

Гадаад улсад байгаа төлбөр төлөгч, түүний хөрөнгөтэй холбоотой хангалттай мэдээлэл байгаа бол олон улсын гэрээний заалтыг үндэслэн эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулсан улсад эрх бүхий байгууллагаар дамжуулан даалгавар хүргүүлэх хүсэлт гаргана. Хүсэлтэд гүйцэтгэх баримт бичгийн баталгаат орчуулга, эрэн сурвалжлах ажиллагаа явуулах шийдвэр, уг шийдвэрт хамаарах холбогдох баримт бичиг, мэдээлэл хүргүүлэх гадаад улсын хамаарах албан ёсны орчуулгын баримтыг хавсаргана[35].

Эрэн сурвалжлах чиг үүрэг бүхий шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийн гүйцэтгэлийг баталгаажуулах талаар энэ хуульд заасан шийдвэр гүйцэтгэгчийн эрхээс гадна дараах эрх эдэлнэ:

- Төлбөр төлөгч, түүний хөрөнгийг эрэн сурвалжилж байгаа тухай олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлах;
- Эрэн сурвалжлагдаж байгаа төлбөр төлөгч, түүний хөрөнгийн талаарх иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд ач холбогдол бүхий мэдээллийг төлбөртэй авах;
- Эрэн сурвалжлагдаж байгаа төлбөр төлөгч, түүний хөрөнгө мөн гэх, эсхүл төлбөр төлөгчийн эд хөрөнгийг нуун далдалсан, төлбөр төлөгчийг шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийхэд нь туслалцаа үзүүлсэн гэх үндэслэл бүхий сэжиг байгаа тохиолдолд хүн, хуулийн этгээдийн баримт бичгийг шалгах, тайлбар авах, тодорхойлолт гаргуулах, тэдгээрийн бие, эд зүйл болон орон байрнаас бусад байр, барилга байгууламж, агуулах сав, эзэмшил газарт үзлэг хийх[36].

Төлбөр төлөгч, түүний хөрөнгийг эрэн сурвалжлах ажиллагааны явцад шаардлагатай тохиолдолд тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага,

[34] Шүүхийн шийвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл №24.57 дугаар зүйл.
[35] Өнөрцэцэг, Ч., Дамдинцэрэн, Д., Дашдаваа, Б. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараалал, эрх зүйн зохицуулалт. Уб., 2022.121 дэх тал.
[36] Шүүхийн шийвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл №24.57 дугаар зүйл.

түүний харьяа нэгжид хандан шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд туслалцаа, дэмжлэг үзүүлэх хүсэлт гаргаж, хамтран ажиллана[37]. Хүсэлтийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн даргаар уламжлуулна. Эрэн сурвалжлах ажиллагааны явцад төрийн мэдээлэл солилцооны системд нэвтрэх эрхийг ашиглан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй "Эрэн сурвалжлах сан буюу ASAP", "Гэмт хэрэг, зөрчлийн сан", "Эрүүлжүүлэгдсэн этгээдийн сан", "Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн сан"-аас мэдээлэл авна.

Эрэн сурвалжлах ажиллагаанд ач холбогдол бүхий мэдээллийг эрх бүхий албан тушаалтан, шийдвэр гүйцэтгэгч төлбөртэй хүлээн авч болно. Хүлээн авах мэдээлэл нь бодитой, үндэслэл бүхий, тогтоогдсон байна. Төлбөр төлөгч, түүний хөрөнгийн талаарх мэдээллийг төлбөртэй авах шаардлага үүссэн даруйд төлбөр авагчид холбогдох зардал шийдвэрлэхийг урьдчилан мэдэгдэнэ.. Төлбөр авагчаас зардал шийдвэрлэхээс татгалзсан тохиолдолд мэдээлэл тодруулах боломжгүй нөхцөл байдал, үүсэх үр дагавар болон шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас гүйцэтгэх баримт бичгийг түүнд буцаах үндэслэл, холбогдох хуулийн зүйл, заалтыг[38] танилцуулна.

Төлбөр төлөгч, түүний хөрөнгийг эрэн сурвалжлах ажиллагааны явцад дараах үндэслэл үүссэн бол эрэн сурвалжлах ажиллагаа зогсооно.

1.Төлбөр төлөгч, түүний хөрөнгийг олж тогтоосон;

2.Эрэн сурвалжлагдаж буй төлбөр төлөгч нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсон, нас барсан гэж зарлагдсан шийдвэр гарсан;

3.Эрэн сурвалжлах ажиллагаа явуулахыг зогсоох хүсэлтийг төлбөр авагч гаргасан;

4.Эрэн сурвалжлах тухай шийдвэрийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүчингүйд тооцсон;

5.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон, төлбөр авагчид гүйцэтгэх баримт бичгийг буцаасан, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн, гүйцэтгэх баримт бичиг хүчингүйд тооцсон эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр гарсан бол эрэн сурвалжлах ажиллагааг зогсооно.

Дээрх үндэслэл илэрсэн даруйд эрх бүхий албан тушаалтан нь тойргийн шийдвэр гүйцэтгэгчид эрэн сурвалжлах ажиллагаа зогсоосныг мэдэгдэж, эрэн

[37] ШШГЕГ., ЦЕГ-ын даргын хамтарсан 2017 оны А/269, А/242 дугаар тушаалаар батлагдсан "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаагийн байгууллагын хамтран ажиллах журам, уг журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай мөн даргын хамтран баталсан 2019 оны А/123, А/159 дүгээр тушаалаар батлагдсан "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон цагдаагийн байгууллага хооронд солилцох мэдээллийн жагсаалт"

[38] Шүүхийн шийвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл №24.31 дүгээр зүйл.

сурвалжлах ажиллагааны хувийн хэргийг хаана. Шийдвэр гүйцэтгэгч нь эрэн сурвалжлах ажиллагааны хувийн хэргээс иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд ач холбогдол бүхий л баримт бичгийг хуулбарлан авч, шийдвэр гүйцэтгэлийн хувийн хэрэгт хавсаргана[39].

ХОЁР. ТӨЛБӨР ТӨЛӨГЧИЙГ ЭРЭН СУРВАЛЖЛАХ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн А/117 дугаар тушаалаар Эрэн сурвалжлах хэлтсийн дарга-1, ахлах мэргэжилтэн-1, туслах ажилтан-5 алба хаагчийн бүтэц, орон тоотойгоор батлагдаж, нийт 7 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр эрэн сурвалжлах ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын сүүлийн 6 жилд эрэн сурвалжлагдсан төлбөр төлөгчийг мөн оны өнөө үетэй харьцуулж үзвэл:



Дээрх судалгаанаас үзэхэд 2017 оноос 4 дахин, 2018 оноос 3 дахин, 2019 оноос 3 дахин, 2020 оноос 67,4%, 2021 оноос 4 дахин, 2022 оноос 1 дахин тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Эрэн сурвалжлах ажилтны ажлын ачаалал нь нэмэгдэж нэг эрэн сурвалжлахын ажилтанд дунджаар 334 төлбөр төлөгчийг олж тогтоох нөхцөл байдал үүсэж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн нормативаас 2 дахин илүү ачаалалтай ажиллаж байгаа болно.

Монгол Улсын Их Хурлаас 2002 онд батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар төлбөр төлөгч этгээдийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж байсан ба 2017 оны 6 дугаар сарын 9-ний өдөр баталж, мөн оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж

[39] Өнөрцэцэг, Ч., Дамдинцэрэн, Д., Дашдаваа, Б. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараалал, эрх зүйн зохицуулалт. Уб., 2022.127 дахь тал.

байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /шинэчилсэн найруулга/ хуулиар уг асуудлаар хориглосон зохицуулалт тусгагдсан.

Ийнхүү хууль хэрэгжиж эхэлснээс хойш 239,5 тэрбум төгрөгийн төлбөртэй 1569 Монгол улсын иргэн, 20.5 тэрбум төгрөгийн төлбөртэй 42 гадаад улсын төлбөр төлөгчид хилийн хориг тавьсан байсныг цуцлах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдсан.

2018 онд 211.4 тэрбум төгрөгийн төлбөртэй 719 төлбөр төлөгчдийг хилийн лавлагааг эрх бүхий байгууллагаас авахад 194.6 тэрбум төгрөгийн төлбөртэй 630 төлбөр төлөгч хилээр гарсан, 2019 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар 22.3 тэрбум төгрөгийн төлбөртэй 174 төлбөр төлөгчийн Монгол Улсын хилээр орж, гарч шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан бол 2023 оны 12 дугаар сарын байдлаар 927 төлбөр төлөгч гадаад улсад ажиллаж, амьдарч байгаагаас шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах боломжгүй байдал үүсээд байна.

Энэ нь шүүхийн шийдвэрийг биелүүлэх үйл ажиллагаанд хүндрэл үүсгэж, төлбөр төлөгчийн төлбөр төлөхөөс зайлсхийх боломжийг бий болгож байх тул Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3-т заасан арга хэмжээг авах нэн шаардлагатай болохыг харуулж байна.

Шүүхийн аливаа шийдвэр, тогтоолыг түргэн шуурхай гүйцэтгэх, төлбөр авагчийн эрх ашиг, сонирхлыг хамгаалах, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтэд чухал байдлаар нөлөөлөхөд эрэн сурвалжлах ажиллагааг үр дүнтэй болгох шаардлага үүсэж байна

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2023 оны А/58 дугаар тушаалаар Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагааг эрчимжүүлэх, бодит биелэлтийг нэмэгдүүлэх, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх зорилгоор харьяа газар, хэлтсээс 25 албан хаагчийг татан ажиллуулсан байна.

Зохист ажлын хүрээнд 1088 төлбөр төлөгчийн хаягийг олж, тогтоосон бөгөөд 346.1 сая төгрөгийн 109 гүйцэтгэх баримт бичигт төлбөрийг төлүүлж, холбогдох шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгосон.

Мөн эрэн сурвалжлах ажиллагааны үр дүнд 31 төлбөр төлөгчид Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага тооцуулах санал шийдвэрлүүлж, 18 төлбөр төлөгчийн төлбөр төлөхөөс зайлсхийсэн үйлдлийг шалгуулахаар Эрүүгийн хуулийн 21.7 дугаар зүйлд заасны дагуу эрх бүхий байгууллагад хандсан байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын нэрийн өмнөөс гаргасан хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг иргэн, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд иргэнд учирсан эд хөрөнгийн болон эдийн бус хохирлыг бүрэн нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх нь гэмт этгээдийг олж илрүүлэн шийтгэхээс дутуугүй ач холбогдолтой.

Өнөөгийн нөхцөл байдалд онцлон авч үзэх шаардлагатай иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны баталгаажуулах арга хэмжээний нэг нь төлбөр төлөгч түүний эд хөрөнгийг эрэн сурвалжлах ажиллагаа юм. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтэд чухал байдлаар нөлөөлөх эрэн сурвалжлах ажиллагааг илүү үр дүнтэй болгох, ажиллагааг илүү боловсронгуй болгох аргачлал, журмыг шинэчлэх, тодотгол хийх шаардлагатай болсныг тулгамдаж буй асуудлууд илтгэж байна.

Шүүхийн аливаа шийдвэр, тогтоолыг түргэн шуурхай гүйцэтгэх, төлбөр авагчийн эрх ашиг, сонирхлыг хамгаалах, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлтэд чухал байдлаар нөлөөлөхөд эрэн сурвалжлах ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх шаардлагатай гэж дүгнэж байна

САНАЛ

1.Хууль Зүй Дотоод Хэргийн Сайдын 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/218 дугаар тушаалаар батлагдсан “Эрэн сурвалжлах ажиллагаа явуулах заавар, аргачлал”-т нэмэлт өөрчлөлт оруулах. Үүнд: Шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийсэн төлбөр төлөгчийг Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах Асап санд зарлах, зогсоох асуудал болон бусад;

2. Гадаад улсад байгаа төлбөр төлөгчийг олж тогтоох, олон улсын эрх бүхий байгууллагаар дамжуулан Эрэн сурвалжлах ажиллагааг зохион байгуулах, хамтын ажиллагааг эрчимжүүлэх, холбогдох арга хэмжээг авах

3.Эрэн сурвалжлагдаж байгаа төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийн талаарх мэдээллийг төлбөртэй авах журмыг олон нийтэд буюу цахим хэлбэрээр тогтмол мэдээлэх

4.Эрэн сурвалжлахын алба хаагч нарыг мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах, чиг үүргийн байгууллагатай хамтран ажиллах.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль УБ 2017 он
2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай УБ хот 2002 он
3. Ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч нар зориулсан гарын авлага УБ хот 2020 он
4. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл- 3 дахь хэвлэл УБ хот 2020 он
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, цагдаагийн ерөнхий газрын даргын хамтарсан тушаал УБ хот 2017 он

6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, цагдаагийн ерөнхий газрын даргын “Жагсаалт батлах, тушаал, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хамтарсан тушаал УБ хот 2019 он
7. ХЗДХС-ын “Эрэн сурвалжлах ажиллагаа явуулах заавар, аргачлал” нэгдүгээр хавсралт “Эрэн сурвалжлагдаж байгаа төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийн талаарх мэдээллийг төлбөртэй авах журам” УБ хот 2017 он
8. Иргэн, захиргаа, зөрчлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа УБ хот 2019 он
1. https://mongoltoli.mn/
2. https://mojha.gov.mn/

---o0o---

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАДАН ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, АНХААРАХ АСУУДАЛ



М.Золбоо
НШШГГ-ийн Сонгинохайрхан дүүргийн хэлтсийн дарга бөгөөд ахлах шийдвэр гүйцэтгэгч, ахмад

Товч агуулга: Иргэн, хуулийн этгээдийн шүүхээр баталгаажуулсан эрхийг хангах, хамгаалах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгчөөс хураан авсан үл хөдлөх эд хөрөнгийг албадан худалдан борлуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн талаар судалж, практикт тулгамдаж буй асуудлыг тодруулахыг зорилоо.

Abstract: The aim is to study the legal regulation and implementation of the forced purchase and sale of immovable property confiscated from the payer during the execution of the decision to ensure and protect the rights of citizens and legal entities confirmed by the court, and to clarify the problems in practice.

Түлхүүр үг: Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, Хөрөнгө албадан борлуулах ажиллагаа, Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд.

Key words: Enforcement proceedings, Forced sale of property, Aspects of enforcement proceedings.

УДИРТГАЛ

Иргэн, захиргааны шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг боловсронгуй болгох, албадан гүйцэтгэх ажиллагааны явцад тулгамдаж буй онол, практикийн тодорхой асуудлыг шийдвэрлэх арга зам, шийдлийг эрэлхийлэн тодорхойлох, эрх зүйн шинэтгэлийг өргөжүүлэхэд тухайн салбарт ажиллаж, чиг үүргийг гүйцэтгэж буй ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчдийн санал чухал үр нөлөө үзүүлэх юм.

2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль батлагдан гарснаас хойш нийгэм, эдийн засгийн хөгжлийг дагасан шинэ харилцаа үүсэж, хуулийн хэрэгжилттэй холбоотой зарим хүндрэлийг хуульд өөрчлөлт оруулж, шийдвэрлэх шаардлагатай болж Улсын их хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж,

2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хуульд заасны дагуу нэг мөр хэрэгжүүлэхэд анхаарч ажилласан.

Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 4.4.1-т “Иргэн, захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сайжруулах, хууль эрх зүйн зохион байгуулалтын цогц арга хэмжээг авах” зорилтод арга хэмжээ тусгагдсан. Уг арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд иргэний болон захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн орчныг боловсронгуй болгохтой холбогдуулан хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагаа энэ цаг хугацаанд явагдаж байгаа билээ.

Шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах ажиллагааг гүйцэтгэхэд төлбөр төлөгчийн хөрөнгийг худалдан борлуулах ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд энэхүү ажиллагаа нь процессын шинжтэй, шат дараалсан үйл ажиллагаа юм. Иргэдийн болон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудын эрх зүйн боловсрол өсч байгаа төдийгүй эдийн засгийн нөхцөл байдлын улмаас эдийн болон эдийн бус баялагтай холбоотой гомдол, маргаан гарах тохиолдол нэмэгдэж, улмаар шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хохирол, төлбөр шаардах явдал түгээмэл болоод байна.

Иймд төлбөр гаргуулах зорилгоор төлбөр төлөгч болон гуравдагч этгээдийн өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийг албадан дуудлага худалдаагаар худалдан борлуулах ажиллагаанд тулгамдаж байгаа асуудал, үүсэж буй хүндрэл, түүнийг шийдвэрлэх арга замыг эрэлхийлж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохыг зорилоо.

1. ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАДАН ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ОЙЛГОЛТ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдааны ойлголтын өмнө үл хөдлөх эд хөрөнгийн тухай ойлголт, хөрөнгө албадан худалдан борлуулах гэсэн ойлголтыг үг зүйн болон хууль зүйн талаас авч үзэх нь зүйтэй.

Үг зүйн талаас нь Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн судлаачдын туурвисан “Монгол хэлний их тайлбар толь”-д “үл хөдлөх хөрөнгө” гэдэг үгийг эдлэн газар, барилга сууц зэрэг[40] хөрөнгө гэсэн агуулгыг илэрхийлнэ гэжээ.

Иргэний хуулийн 84.3-т “Газар, түүнээс салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл болох эд юмс үл хөдлөх эд хөрөнгөд хамаарах”-аар заасан бол Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 3.1.1-д “үл хөдлөх эд хөрөнгийн эрх[41]” гэж газар, түүнээс салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл

[40]Монгол хэлний их тайлбар толь
[41]Иргэний хууль 2002 он

болох эд хөрөнгийн өмчлөх эрх болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийг ойлгоно" гэж заажээ.

Хууль зүйн утгаараа үл хөдлөх хөрөнгө гэдэг нь эд хөрөнгө гэсэн материаллаг шинжтэй байгалийн баялаг болох газар биет байдлаараа, газраас салгаж болохгүй түүн дээр болон доор байгаа нэмэлт зүйлсийн хамт харж, мэдэрч болох хүний хөдөлмөрийн үр дүнд бий болсон барилга, байгууламж байдлаар байх бөгөөд ихэнх тохиолдолд эдгээрийн нэгдэл хэлбэрээр оршиж байдаг.

Амрыг эрье. Илтгэлийг нь хүлээн авлаа. Албаны хувцастай цээж зургаа ирүүлээрэй.

Мэдээж туйлын утгаараа салгаж үл болох зүйл гэж үгүй бөгөөд бүхий л эд юмсыг газраас салган авах боломжтой юм. Гэвч нөгөө талаасаа газраас салгаж үл болох гэдэг тодотгол тэдгээр эд юмсыг газраас салгаснаар эдийн засгийн зориулалтаа бүрэн алдах буюу дахин газарт байршуулахад ихээхэн хэмжээний хөрөнгө шаардах гэсэн агуулгыг илэрхийлж байгаа юм[42].

"Монгол хэлний их тайлбар тольд дуудлага худалдаа гэдэг үгийг "Хөтлөгчийн удирдлагаар олны өмнө зарагдаж байгаа бараанд хамгийн өндөр үнэ хэлсэн хүн нь худалдаж авдаг үнэ хаялцуулах худалдаа[43]"-г илэрхийлнэ гэж томьёолжээ.

Мөн уг тайлбар тольд "худалдах" гэдэг үг нь дагаараа болон "зарах худалдах" гэдэг хоршоо үгээр "ямар нэг зүйлийг бусдад худалдан борлуулах" гэсэн утгыг, харин "албадан зарах" гэдэг нь "хүчээр зарах[44]" гэсэн утгыг илэрхийлнэ гэжээ.

Мөн Иргэний хуулийн 197 дугаар зүйлийн 197.6-д "Үнэ хаялцуулах ажиллагааг дуудлага худалдаа буюу уралдааны хэлбэрээр явуулах[45]"-аар заасан.

Хөрөнгө албадан худалдан борлуулах ажиллагаа гэдэг нь ***хуулийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөрийн шаардлагыг биелүүлэх зорилгоор хураан авсан хөрөнгийг Монгол Улсын Иргэний хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу үнэлгээ тогтоох, худалдан борлуулах, төлбөрт тооцон шилжүүлэх тодорхой үе шат бүхий албадлагын журмаар хэрэгждэг цогц ажиллагаа*** гэж тодорхойлж болно.

Шүүхийн шийдвэрт заасан төлбөрийн шаардлагыг биелүүлэх зорилгоор хураан авсан хөрөнгө гэдэгт гүйцэтгэх баримт бичигт төлбөрийн шаардлага

[42]Хууль зүйн үндэсний төв. Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг. УБ., 2003 он
[43]Монгол хэлний их тайлбар толь
[44]Монгол хэлний их тайлбар толь
[45]Иргэний хууль 2002 он

хангуулахаар нэрлэн заасан хөрөнгө, мөн төлбөрийн шаардлага хангуулах зорилгоор шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хураан авсан төлбөр төлөгчийн өмчлөл, эзэмшлийн болон дундын өмчлөлийн хөрөнгө, бусад этгээдийн хөрөнгийг ойлгоно.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2016 оны 6 дугаар сарын 09-ний өдөр шинээр батлагдан, 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд шинээр батлагдсан хуульд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нэг томоохон төрөл болох хөрөнгө албадан худалдан борлуулах ажиллагаатай холбоотой өмнөх хуулиар зохицуулагдаагүй байсан харилцаануудыг зохицуулахыг оролдсон шинэ зохицуулалтууд нэмэгдсэнээрээ онцлогтой болсон.

Шүүхийн шийдвэрийн үндсэн дээр иргэн, хуулийн этгээдээс хураан авсан үл хөдлөх хөрөнгө, хөдлөх хөрөнгө, үнэт цаас, эдийн бус хөрөнгө, түүх, соёлын өвд хамаарах үнэт зүйл, тусгай зөвшөөрөл болон шаардах эрхээс төлбөр гаргуулах ажиллагааг бүхэлд нь “Хөрөнгө албадан худалдан борлуулах ажиллагаа” гэж томьёолон, уг хуулийн 5 дугаар бүлгээр зохицуулжээ.

Улмаар хөрөнгийн төрлөөс хамаарч албадан худалдан борлуулах ажиллагаа явуулах хэлбэрийг тодорхой болгосон. Тухайлбал, хөдлөх хөрөнгийг үнэ хаялцуулах дуудлага худалдаагаар, үл хөдлөх эд хөрөнгө төдийгүй үнэт цаас, эдийн бус хөрөнгө, түүх, соёлын өвд хамаарах үнэт зүйл, тусгай зөвшөөрөл, шаардах эрхийг албадан дуудлага худалдаагаар худалдан борлуулахаар ялгамжтай байхаар хуульчилсан.

Шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах ажиллагааг гүйцэтгэхэд хөрөнгө худалдан борлуулах ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд энэхүү ажиллагаа нь процессын шинжтэй, шат дараалсан үйл ажиллагаа юм. Хөрөнгө худалдан борлуулах ажиллагааг гүйцэтгэхээс өмнө дор дурдсан хуульд заасан дараалсан ажиллагааг хянах шаардлагатай.

Үүнд:

- Худалдан борлуулах хөрөнгө эрхийн зөрчилгүй байгаа эсэх. /тухайлбал гуравдагч этгээдийн эрх хөндөгдөж байгаа эсэх/
- Битүүмжлэх, хураах ажиллагаа хуульд заасны дагуу явагдсан эсэх
- Талууд болон өмчлөгчөөс үнийн санал авсан, үнэ тохиролцуулах ажиллагаа явагдсан эсэх/Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн 177.1 дэх хэсэг/
- Битүүмжилж, хурааснаас хойш 1 сарын дотор үнэлгээ тогтоосон эсэх
- Хөрөнгийн үнэлгээний тайланг хуульд заасан хугацаанд талууд болон өмчлөгчид танилцуулж, мэдэгдсэн эсэх

- Үнэлгээтэй холбоотой гомдол гарсан, гомдлыг эцэслэн шийдвэрлэсэн эсэх
- Төлбөр төлөгчид бие даан худалдан борлуулах хугацаа олгосон эсэх, талуудаас хөрөнгийг төлбөрт тооцох тухай санал гаргасан эсэх
- Төлбөр авагчаас дуудлага худалдааг хойшлуулах тухай хүсэлт ирүүлсэн эсэхийг хянаж үзсэний үндсэн дээр хөрөнгө худалдан борлуулах ажиллагааг зохион байгуулна.

2. ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН АЛБАДАН ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсын Иргэний хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар үл хөдлөх хөрөнгийн албадан дуудлага худалдааг 2 үе шаттай зохион байгуулахаар хуульчилсан. Албадан дуудлага худалдааг Иргэний хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, эсхүл шийдвэр гүйцэтгэх алба зохион байгуулж байгаа бөгөөд улсын хэмжээнд үл хөдлөх хөрөнгийн албадан худалдан дуудлага худалдааны 90 орчим хувь нь Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хэмжээнд зохион байгуулагддаг тул 2021 онд зохион байгуулсан үл хөдлөх хөрөнгийн албадан дуудлага худалдааны талаарх судалгаанд дүн шинжилгээ хийж албадан дуудлага худалдааны өнөөгийн байдал, хүрч байгаа үр дүнг тодорхойлохыг зорилоо.

Тус газраас жил бүр нэгтгэн гаргадаг статистик мэдээгээр 2021 онд нийслэлийн хэмжээнд шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу 550 үл хөдлөх хөрөнгийг анхны албадан дуудлага худалдаагаар, 319 үл хөдлөх хөрөнгийг 2 дахь албадан дуудлага худалдаагаар худалдан борлуулахаар тус тус нийтэд зарласан [46]байна.

Үүнээс анхны албадан дуудлага худалдаанд оруулахаар нийтэд зарлагдсан 164 үл хөдлөх хөрөнгө буюу 29.8 хувь, 2 дахь албадан дуудлага худалдаанд оруулахаар нийтэд зарлагдсан 57 үл хөдлөх хөрөнгө буюу 17.8 хувьд нь холбогдох шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шүүхээс түдгэлзүүлжээ.

Төлбөр авагчийн хүсэлтийг үндэслэн анхны албадан дуудлага худалдаанд оруулахаар нийтэд зарлагдсан хөрөнгийн 6 хувь буюу 33 үл хөдлөх хөрөнгө, 2 дахь албадан дуудлага худалдаанд оруулахаар нийтэд зарлагдсан хөрөнгийн 12.8 хувь буюу 41 үл хөдлөх хөрөнгийг албадан худалдан борлуулах ажиллагааг хойшлуулсан байна.

Мөн албадан дуудлага худалдаа болохын өмнө төлбөр төлөгч төлбөрөө бүрэн төлсөн үндэслэлээр анхны албадан дуудлага худалдаагаар худалдан

[46]Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны АДХ-ны жилийн эцсийн мэдээ

борлуулахаар нийтэд зарлагдсан хөрөнгийн 4.5 хувь буюу 25 үл хөдлөх хөрөнгө, 2 дахь албадан дуудлага худалдаанд оруулахаар нийтэд зарлагдсан хөрөнгийн 4.3 хувь буюу 14 үл хөдлөх хөрөнгө чөлөөлөгдсөн байна.

Анхны албадан дуудлага худалдаагаар худалдан борлуулахаар нийтэд зарласан үл хөдлөх хөрөнгийн 10 хувь буюу 55 үл хөдлөх хөрөнгийг, 2 дахь албадан дуудлага худалдаагаар худалдан борлуулахаар нийтэд зарлагдсан үл хөдлөх хөрөнгийн 32.6 хувь буюу 104 үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулж, нийт дуудлага худалдааны 18.2 хувь нь л үр дүнтэй болжээ.

Харин 2022 онд нийслэлийн хэмжээнд шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу 546 үл хөдлөх хөрөнгийг анхны албадан дуудлага худалдаагаар, 335 үл хөдлөх хөрөнгийг 2 дахь албадан дуудлага худалдаагаар худалдан борлуулахаар тус тус нийтэд зарласан[47] бөгөөд анхны албадан дуудлага худалдаанд 64 буюу 11.7 хувь, 2 дахь албадан дуудлага худалдаанд 142 буюу 42.3 хувь нь худалдан борлогдсон нь нийт зарласан хөрөнгийн 23.3 хувь нь үр дүнтэй болсон байна.

Дээрх судалгаа, мэдээнээс дүгнэхэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль шинээр батлагдсанаас хойш буюу 2021, 2022 онуудад албадан дуудлага худалдаагаар худалдан борлуулахаар нийтэд зарласан үл хөдлөх хөрөнгийн тоо буурсан боловч дуудлага худалдаагаар худалдан борлуулсан үл хөдлөх хөрөнгийн тоо жил дараалан мэдэгдэхүйц өсөж, албадан дуудлага худалдааны үр дүнд шинэ хуулийн зохицуулалт эергээр нөлөөлж байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

Жишээлбэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 63.4-т хөрөнгийг албадан худалдан борлуулах шийдвэрийн талаар болон хөрөнгийн үнэлгээний талаар шүүхэд гомдол гаргаж шийдвэрлүүлсэн тохиолдолд шүүхэд дахин гомдол гаргах эрхгүй байхаар[48], мөн хуулийн 55.3-т хөрөнгийн үнэлгээний мэдэгдэл, шинжээчийн гаргасан үнэлгээний тайланг 3 хоногийн дотор талуудад мэдэгдэх[49], мөн хуулийн 55.7-д талууд хөрөнгийн үнэлгээний талаарх гомдлоо үнэлгээг мэдэгдсэнээс хойш 7 хоногийн дотор шүүхэд гаргаж болохоор хуульчилснаар ямар ч тохиолдолд талууд үнэлгээний талаар албадан дуудлага худалдаа зарлагдахаас өмнө шүүхэд гомдол гаргах болж, энэ нь 3 шатны шүүхээр жил дамнан хянагдсанаар дуудлага худалдаанд оруулахаар нийтэд зарлагдсан үл хөдлөх хөрөнгийн тоо тодорхой хэмжээгээр буурахад нөлөөлсөн гэж үзэж байна.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай 2017 оны хуулийн 62 дугаар зүйлд хөрөнгийн үнэлгээ тогтоогдсоны дараа төлбөр төлөгч өөрийн хөрөнгөө 1 сарын дотор бие бие даан худалдан борлуулж болохоор хуульчилсан нь дуудлага

[47]Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны АДХ-ны жилийн эцсийн мэдээ
[48] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он
[49] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он

худалдаанд оруулахаар нийтэд зарлагдсан үл хөдлөх хөрөнгийн тоо тодорхой хэмжээгээр буурахад бас нөлөөлсөн байх боломжтой.

Хэдийгээр 2021, 2022 онд албадан дуудлага худалдаанд оруулахаар нийтэд зарлагдсан үл хөдлөх хөрөнгийн тоо тодорхой хэмжээгээр буурсан байх боловч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 63.4-т албадан дуудлага худалдааны явцад нэг асуудлаар шүүхэд олон дахин гомдол гаргах эрхийг хязгаарласан зохицуулалтыг хуульчилсан[50] нь албадан дуудлага худалдаагаар худалдан борлуулсан үл хөдлөх хөрөнгийн тоо жил дараалан өсөж, дуудлага худалдаа үр дүнтэй болоход нөлөөлсөн байна.

3. АЛБАДАН ДУУДЛАГА ХУДАЛДААНД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төгсгөлийн шат гэж зарим судлаачид дүгнэсэн байдаг хэдий боловч шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь төрийн албадлагаар шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангуулахад чиглэгдсэн эрх зүйн онцлог зохицуулалт шаардагдсан бие даасан харилцаа юм.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шинэчлэл нь холбогдох хууль тогтоомжид тусгалаа олж, боловсронгуй болон хөгжсөөр ирснийг 1994, 1996, 2002, 2017 оны хуулиас тодорхой харж болно.

Төлбөр төлөгч болон гуравдагч этгээдээс шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, удаашруулах, өөрт ашигтай байдал үүсгэх зорилгоор хөрөнгийн үнэлгээг эс зөвшөөрөх болон бусад үндэслэлээр ажиллагааг хүчингүй болгуулах тухай гомдлыг шүүхэд гаргах тохиолдол их байна.

Шийдвэр гүйцэтгэгч Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн 177.1-д заасны дагуу үүрэг гүйцэтгэгч, үүрэг гүйцэтгүүлэгч, өмчлөгч нараас үнийн санал авах, хөрөнгийн үнэлгээг талууд харилцан тохиролцож тогтоох ажиллагааг гүйцэтгэдэг боловч төлбөр төлөгч болон гуравдагч этгээдээс хөрөнгийн үнэлгээнд холбогдуулан шүүхэд гомдол гаргах зорилгоор үнийн саналаа ирүүлдэггүйгээс хуульд заасны дагуу хөндлөнгийн шинжээч томилох ажиллагааг явуулж байна.

Хуульд хөрөнгийн үнэлгээ тогтоох, худалдан борлуулах хугацааны зохицуулалт тусгагдсанаар үнэлгээг хугацааг хэтрүүлж тогтоох тохиолдол цөөнгүй гарч, ахлах шийдвэр гүйцэтгэгчээс ажиллагааг хүчингүйд тооцож, шийдвэр гүйцэтгэгч ажиллагааг зөвтгөн явуулах тохиолдол цөөнгүй гарч байгаа нь бодит байдал юм.

Хугацаа хэтрүүлж байгаа тохиолдлыг судлахад дараах шалтгаан нөхцөл байна. Үүнд

[50] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он..,

- Шинжээч ШШГТХ-ийн 55.1-д заасан хугацаанд хөрөнгийн үнэлгээг тогтоогоогүй /Жишээлбэл: Шинжээч томилох тухай тогтоолд заасан үл хөдлөх хөрөнгөнд нэвтэрч чадахгүй хүндрэл үүсэх, тухайн обьект эзэнгүй, хөрөнгийн хаягт байгаа этгээд ажиллагаанд саад учруулах зорилгоор зайлсхийх явдал/
- Шийдвэр гүйцэтгэгчийн хариуцсан тойргийн гүйцэтгэх баримт бичигт тавих хяналт муу, түүний эс үйлдэхүйгээс үүдэлтэй
- Тухайн тойрогт шийдвэр гүйцэтгэгч томилогдоогүй байх хугацаанд ажиллагаа зогссон
- Талуудаас шүүхэд гаргасан гомдлыг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд
- Цөөн тохиолдолд төлбөр авагчийн эс үйлдэхүй

Хөрөнгийг бие даан худалдан борлуулах ажиллагааны талаар

Шинэчлэн батлагдаж, дагаж мөрдөж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хөрөнгийн үнэлгээний талаар талуудаас гомдол гаргаагүй тохиолдолд төлбөр төлөгч хөрөнгийн үнэлгээний мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор өөрийн хөрөнгийг мөн хуулийн 55.3-т заасан шийдвэрт зааснаас багагүй үнээр бие даан худалдан борлуулах[51] санал гаргах эрхтэй зохицуулалтыг оруулсан нь нэг талаас хөрөнгийн үнэлгээнд гомдол гаргах явдлыг хязгаарласан, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шуурхай явуулахад ач холбогдолтой заалт болсон.

Хуулийн энэ зохицуулалтыг хэрэглэх явцад төлбөр төлөгчид хөрөнгөө бие даан худалдан борлуулах хуульд заасан хугацаа олгосон боловч төлбөр төлөгч хөрөнгийг хугацаандаа худалдан борлуулсан тохиолдол маш цөөн, түүгээр ч зогсохгүй худалдан борлуулах хугацаа дуусмагц хөрөнгийн үнэлгээтэй холбоотой гомдлыг шүүхэд гаргаж, шүүх тухайн нэхэмжлэлийг хүлээн авч, шийдвэрлэх тохиолдол гарсаар байгаа нь хуулийн зохицуулалтыг шүүх зөрчиж, шийдвэр гүйцэтгэх байгууллагатай харилцан уялдаагүй байгаагийн нэг илрэл гэж үзэж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасан зохицуулалтад талуудын харилцан тохиролцож тогтоосон үнэлгээгээр хөрөнгийг бие даан худалдан борлуулах хугацааг төлбөр төлөгчид олгох боломжгүй тухай шууд ойлгогдож байгаа бөгөөд практикт “талуудын харилцан тогтоосон үнэлгээгээр хөрөнгийг хөрөнгийг бие даан худалдан борлуулах хугацаа олгох” тухай хүсэлтийг төлбөр төлөгчөөс ирүүлж байгаа тохиолдол багагүй байна.

Худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөр авагчид санал болгох ажиллагааны талаар

[51]Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он

Анхны болон 2 дахь албадан дуудлага худалдаагаар худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөр авагчид санал болгох ажиллагаа нь хөрөнгө албадан худалдан борлуулах ажиллагааны төгсгөлийн шат бөгөөд энэхүү ажиллагаатай хуулийн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох, хуулиар зохицуулаагүй зарим харилцааг зохицуулсан зохицуулалтыг хуульд оруулах шаардлага практик ажиллагааны явцад гарсаар байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73.3-т "Дуудлага худалдаагаар худалдан борлогдоогүй үл хөдлөх хөрөнгийг энэ хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу тогтоосон үнээр төлбөр авагчид санал болгох"-оор, мөн хуулийн 73.5-д "Барьцаалагч-төлбөр авагчийн барьцаанд байгаа, эсхүл дундын өмчлөлийн худалдан борлогдоогүй төлбөр төлөгчид ногдох хөрөнгийг энэ хуулийн 55.3-т заасны дагуу тогтоосон үнэлгээгээр тооцож төлбөр авагчид шилжүүлэх[52]"-ээр хуульчилсан.

Дээрх 2 заалтын алинд нь ч талуудын харилцан тохиролцсон үнэлгээ гэсэн ойлголт байхгүй дуудлага худалдаагаар худалдан борлогдоогүй хөрөнгийг талуудын харилцан тохиролцож тогтоосон үнээр төлбөр авагчид санал болгож болох эсэх талаар хуульд зохицуулаагүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31.4-д Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн 31.1.1, ~~31.1.2~~-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй.

/Энэ хэсгийн "31.1.2" гэснийг Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02 дугаар тогтоолоор хүчингүй болгосон./

Иймд төлбөр авагч хөрөнгө авахаас татгалзсан, эсхүл хуульд заасан хугацаанд /10 хоногийн дотор саналыг хүлээн авах эсэх тухайгаа шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэнэ./ хариу ирүүлээгүй бол худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр төлөгчид, гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаана. Буцаасан гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагч дахин гүйцэтгүүлэхээр хандах эрхтэй бөгөөд дахин хүлээн авсан тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эхнээс нь дахин гүйцэтгэх тухай ойлголт бий болж байна.

Мөн 2017 онд шинээр батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойших хугацаанд нийт 6 зүйлд өөрчлөлт орсноос Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтээр 27.1.5 дахь заалт хүчингүй болж, 31.4, 73.3 дахь зүйлүүдэд өөрчлөлт орсон байна.

Улс орны нийгэм эдийн засгийн байдал, тухайн цаг үеийн хэрэгцээ шаардлагатай уялдан, тухай бүр хуульд нэмэлт өөрчлөлт орох замаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааг улам бүр боловсронгуй болгох алхмууд хийгдэж байгаа боловч практик ажиллагааны явцад гарч байгаа өнөөгийн эрх зүйн зохицуулалтын

[52]Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он

хүрээнд шийдвэрлэх боломжгүй асуудлууд, практикт гарч байгаа хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх зүй ёсны шаардлага байсаар байна.

Тэр дундаа хөрөнгө албадан худалдан борлуулах ажиллагаа, дуудлага худалдааны явцын зарим процессыг тодорхой хуульчлах, санал болгох ажиллагааны явцад гарч байгаа зарим хүндрэлийг хэрхэн шийдвэрлэх зэрэг асуудал практикт тулгарсаар байгаа бөгөөд хөрөнгө албадан худалдан борлуулах ажиллагаанд тулгарч байгаа хүндрэл бэрхшээлийг хуулиар хэрхэн зохицуулбал оновчтой байх талаар өөрийн санал, дүгнэлтийг бичлээ.

ДҮГНЭЛТ

2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль батлагдан гарснаас хойш нийгэм, эдийн засгийн хөгжлийг дагасан шинэ харилцаа үүсэж, хуулийн хэрэгжилттэй холбоотой зарим хүндрэлийг хуульд өөрчлөлт оруулж, шийдвэрлэх шаардлагатай болж Улсын их хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хуульд заасны гүйцэтгэх ажиллагааг нэг мөр хэрэгжүүлэхэд та бид анхаарч ажилласан.

Иргэдийн болон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудын эрх зүйн боловсрол өсөж байгаа болон эдийн засгийн нөхцөл байдлын улмаас эдийн болон эдийн бус баялагтай холбоотой гомдол, маргаан гарах тохиолдол нэмэгдэж, улмаар шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хохирол, төлбөр шаардах явдал түгээмэл болоод байна.

Үл хөдлөх хөрөнгийн албадан дуудлага худалдаатай холбоотой одоогийн зохицуулалт нь хөрөнгийн үнийг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд болон хамтран өмчлөгчид харилцан тохиролцох байдлаар тогтоох зохицуулалт нь практикт хууль зүйн утгаараа хэрэгжих боломжгүй болж, хийсвэр байдлаар үнэ тогтоогддог цаг хугацаа, механик ажиллагаа шаардсан ач холбогдол багатай ажиллагаа болсон байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73.3-т “Дуудлага худалдаагаар худалдан борлогдоогүй үл хөдлөх хөрөнгийг энэ хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу тогтоосон үнээр төлбөр авагчид санал болгох”-оор, мөн хуулийн 73.5-д “Барьцаалагч-төлбөр авагчийн барьцаанд байгаа, эсхүл дундын өмчлөлийн худалдан борлогдоогүй төлбөр төлөгчид ногдох хөрөнгийг энэ хуулийн 55.3-т заасны дагуу тогтоосон үнэлгээгээр тооцож төлбөр авагчид шилжүүлэх”-ээр хуульчилсан.

Өнөөгийн хуулийн зохицуулалтаар худалдан борлогдоогүй хөрөнгийн дуудлага худалдааны доод үнийг Иргэний хуулийн 177.1-д заасны дагуу талууд

харилцан тохиролцож тогтоосон тохиолдолд уг үнээр төлбөр авагчид санал болгох боломжгүй болж байна.

Дээрх хуулийн зохицуулалтыг нэг талаас нь харахад талуудын харилцан тохиролцож тогтоосон үнэ бол тухайн хөрөнгийн зах зээлийн бодит үнийг тодорхойлж чадахгүй гэж үзэн талуудын харилцан тохиролцож тогтоосон үнээр төлбөр авагчид хөрөнгө санал болгох ажиллагааг хуульчлаагүй орхисон гэж ойлгож болохоор байна.

Иймд төлбөр гаргуулах зорилгоор төлбөр төлөгч болон гуравдагч этгээдийн хөрөнгийг худалдан борлуулах ажиллагаанд тулгамдаж байгаа асуудлыг тавьж, үр дүнтэй шийдвэрлэх талаарх өөрийн саналыг дэвшүүлж байна.

САНАЛ

1. Хөрөнгийн үнэлгээг хүндэтгэн үзэх үндэслэлтэй шалтгаанаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55.1-д заасан хугацааг хэтрүүлсэн тохиолдолд ахлах шийдвэр гүйцэтгэгчээс үнэлгээ тогтоох боломжит хугацааг сунгах эрхтэй байх зохицуулалтыг хуульд нэмэлт өөрчлөлт оруулах,

2. Хөрөнгийн үнэлгээг талууд, өмчлөгч нар харилцан тохиролцож тогтоосон тохиолдолд бие даан худалдан борлуулах хугацааг олгох тухай заалтыг тусгайлан нэмж оруулах, /Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 62 дугаар зүйлд/,

3. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны аль ч шатанд талууд эвлэрэх, харилцан тохиролцох эрхтэй тул хөрөнгө санал болгох ажиллагааны явцад хөрөнгийн үнийг талууд харилцан тохиролцон шийдвэрлэж, санал гаргасан тохиолдолд тохиролцсон үнээр хөрөнгийг санал болгох ажиллагааг зохион байгуулах тухай зохицуулалтыг хуульд нэмж тусгах,

4. Үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шүүхийн шийдвэр, гүйцэтгэх хуудсанд тусгаагүй боловч барьцаат зээлийн гэрээтэй тохиолдолд хөрөнгийг шууд худалдан борлуулах ажиллагааг гүйцэтгэх зохицуулалтыг хуульд тусгах,

5. Хөрөнгө худалдан борлогдсон тохиолдолд төлбөр төлөгч төлбөрийн дийлэнх буюу тодорхой хувийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 71.13-т заасан хугацаанд барагдуулсан, үлдэгдэл төлбөрийг ямар хугацаанд барагдуулахаа илэрхийлсэн төлбөр төлөгчийн хүсэлт нь үндэслэл бүхий гэж үзсэн тохиолдолд худалдан борлогдсон хөрөнгийн өмчлөх эрхийг ялагчид шилжүүлэх тухай эрхлэн хөтлөгчийн шийдвэр танилцуулах хугацааг сунгах, хойшлуулах боломжтой зохицуулалтыг хуульд тусгах,

6. Хөрөнгийн үнэлгээг тогтоосон хугацаанд ирүүлээгүй тохиолдолд /шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан үндэслэлээр/ шинжээч томилж хөрөнгийн үнэлгээг тогтоох тухай зохицуулалтыг хуульд тусгайлан нэмж тусгах.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
2. Иргэний хууль 2002 он
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2002 он, 2017 он
4. Монгол хэлний их тайлбар толь
5. Шийдвэр гүйцэтгэх албаны Иргэний, захиргааны, зөрчлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа 2019 он
6. ШГА-ны ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч нарт зориулсан гарын авлага 2020 он
7. ШГА-ны Иргэн, захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн шинэтгэл /илтгэлийн эмхэтгэл/ 2021 он
8. ШГА-ны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараалал, эрх зүйн зохицуулалт 2022 он
9. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын албадан дуудлага худалдааны мэдээ 2021он, 2022 он
10. www.Legalinfo.mn
11. www.shuukh.mn

---o0o---

АЛБАДАН ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЭД ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ТОГТООХ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

STUDY ON THE ASSET APPRAISAL PROCEDURE IN A FORCED AUCTION



Д.Оюу
Дотоод хэргийн Их сургуулийн
Удирдлагын академийн 8013 дугаар дамжааны суралцагч, ахмад

Товч утга: Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны удааширч буй шалтгаан, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг үнэлэх үнэлгээтэй холбоотой тулгамдаж буй асуудлыг одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зохицуулалтын хүрээнд мөн гадаадын зарим улс орны эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалж, үнэлэлт дүгнэлт хийх хэрэгцээ шаардлагыг судалж, түүнийг боловсронгуй болгох санал дүгнэлт боловсруулна.

Abstract: By conducting a study on the reasons causing delay during the civil court decision-executing process as well as the problematic matters related to immovable and movable property appraisals during the court decision-implementing procedures within the scope of current law on the enforcement of court decisions, Also, to prepare the proposal on the improvement of current law by conducting comparisons with foreign legal frameworks as well as investigating the needs for concluding them into the improvement proposal.

Түлхүүр үгс: албадлага, дуудлага худалдаа, эд хөрөнгө, үнэлгээ

Key words: enforcement, auction, property, appraisal

ОРШИЛ

Монгол улсад социалист систем задран унаж, ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжсэн үеэс эхлэн чөлөөт зах зээлийн эдийн засаг хөгжиж эхэлсэн. Энэхүү хөгжлийг дагаад иргэд, аж ахуйн нэгжийн хооронд эдийн болон эдийн бус хөрөнгийн харилцаа хөгжин тэлсэн. Өнөөгийн нийгмийн хурдацтай хөгжлийг дагаж хүмүүсийн хэрэгцээ шаардлага нэмэгдсэнтэй холбоотойгоор иргэд, хуулийн этгээдүүдийн хооронд эд хөрөнгийн талаарх гомдол, маргаан нэмэгдэхийн хэрээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааны ачаалал ихэсч байна. Шүүхийн шийдвэр

гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтийг хангуулахад үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулах шаардлага тулгардаг. Албадан дуудлага худалдаа зохион байгуулахтай холбоотойгоор эд хөрөнгийн үнэлгээ тогтоох зайлшгүй шаардлага тулгардаг. Энэхүү эд хөрөнгө үнэлэх ажиллагааны явцад төлбөр төлөгч, төлбөр авагч нарын хоорондын саналын зөрүүтэй байдал, үнэлгээчин, шинжээчийн тогтоосон үнэлгээнд гомдол гаргах тохиолдол ихээхэн гардаг. Иймээс эд хөрөнгийн үнэлгээний талаарх асуудлыг улам боловсронгуй болгох шаардлага тулгарч байна.

НЭГ. ОНОЛЫН АСУУДАЛ

Албадан дуудлага худалдаа: Манай улсад Иргэний хуулийн 175-181 дүгээр зүйлүүд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд албадан дуудлага худалдаа болон бусдын удирдлагад шилжүүлэх замаар ипотекийн эрхийг хэрэгжүүлж, үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангах асуудлыг зохицуулсан байна.

Албадах гэдгийг үг зүйн үүднээс авч үзвэл “хүчлэн тулгах, захиран тушаахаар, албаар хийлгэх, шахаж шаардах” гэсэн утгатай байна.[53] Албадан дуудлага худалдааны гол зорилго нь албадан дуудлага худалдааны ажиллагаанаас аль болох их орлого олох бөгөөд тэр хэмжээгээр төлбөр төлөгч үүргээсээ чөлөөлөгдөнө.

Эд хөрөнгө: Иргэний хуулийн 84 дүгээр зүйлд зааснаар эд хөрөнгө гэдэг нь аливаа этгээдийн эзэмшилд байгаа эд юмсыг хэлнэ.

Үл хөдлөх хөрөнгө гэдэг нь газар, газраас салгаж үл болох хүний бүтээсэн зүйлсийг хэлнэ. Үл хөдлөх хөрөнгө гэдэг нэгэнт бүрэн судлагдсан зүйл. Дэлхий нийтэд үл хөдлөх хөрөнгөнд юуг хамааруулахыг улс орон бүхэн хуулиар тогтоож байна. Үл хөдлөх хөрөнгөд орохгүй эд зүйлсийг хөдлөх хөрөнгө гэж ойлговол зохино. Үнэлгээний Олон Улсын Стандартанд *"газар болон түүний салшгүй хэсэг болох* мод, эрдэс баялаг, түүн дээр хүмүүсийн бий болгосон барилга ба сайжруулалт, шугам сүлжээ, хоолой, цахилгаан утас, цахилгаан шат зэрэг барилгад хөдөлгөөнгүй бэхлэгдсэн байгууламж зэрэг газрын дээрх болон доорх зүйлсийг *хамруулна” гэж заасан.*

Манай улсад “Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа газар, түүнээс салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл болох барилга байгууламж, хөлөг онгоц[54] зэргийг үл хөдлөх хөрөнгө”-нд хамруулна гэж заасан. Үүнээс үзвэл ҮОУС-нд[55] заасан мод, эрдэс баялаг, шугам сүлжээ хоолой цахилгаан утас, цахилгаан шугам сүлжээ, цахилгаан шат төмөр замын дээд анги зэрэг нь хэдийгээр хуулиар заасан зурвас газар дээр баригдсан боловч хуулж ааваад өөр газар барих

[53] Баярсайхан, Б. Монгол хэлний тайлбар толь. -Уб., 2011. 30 дахь тал

[54] Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль. //Төрийн мэдээлэл сэтгүүл. Дугаар 25 -Уб., 2003

[55] Үнэлгээний Олон Улсын Стандарт гэж ойлгох

боломжтой. Энэ үл хөдлөх эд хөрөнгөнд орох уу гэх мэт олон асуудал бас эргэлзээтэй.

Аливаа эд хөрөнгийг тодорхой шаардлага, шалтгааны улмаас үнэ цэнэ, эдийн засгийн ач холбогдол, өөрийн өртөг зэргийг тооцож тодорхойлох цогц үйл ажиллагааг хөрөнгийн үнэлгээ гэнэ.[56] Хөрөнгийн үнэлгээний зорилго, зориулалт нь дараах байдлаас үүдэн гардаг.

- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын зориулалтаар,
- ХХОАТатварын хөнгөлөлт эдлэх зориулалтаар,
- Худалдах/худалдан авах зориулалтаар,
- Байгууллага санхүүгийн тайландаа тусгах зориулалтаар,
- Компанийн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний зориулалтаар,
- Компани татан буугдахад хөрөнгө хуваах зориулалтаар,
- Хөрөнгө оруулалт татах зориулалтаар,
- Хөрөнгийн шинэчилсэн үнэлгээ тогтоох,
- Зах зээлийн үнийг үндэслэлтэй тогтоох,
- Хөрөнгийн баталгаа гаргах зориулалтаар,
- Зээл авах зориулалтаар,
- Улсын орлого болгох зориулалтаар
- Хөрөнгийн даатгалын үнэлгээ тогтоох гэх мэт.

Үнэлгээ: Хөрөнгийн үнэлгээний тухай хуулиар хөрөнгийн үнэлгээ хийх, түүний зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тодорхойлж, хяналт тавих, энэ чиглэлээр төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэний эрх, үүрэг, үйл ажиллагаа болон үнэлгээний мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино гэж хуульчилсан байдаг.

Үнэлгээний талаар дэлгэрүүлж үзвэл үнэлгээний арга хандлагад ашиглагддаг анхдагч ухагдахуун нь үнэ цэнэ (value, expense), үнэ (price, value), өртөг (cost, value) гэсэн ойлголтууд юм. Тиймээс үнэ, өртөг болон үнэ цэнийн талаарх ойлголтыг шинжлэн ялгааг тодорхойлох хэрэгтэй.[57]

Өртөг: Үнэ цэнэ болон өртгийн онолын гол төлөөгчид Карл Хайнрих Маркс[58] юм. Түүний Капитал зохиолд өртгийг хэрэглээний буюу ашиглалтын өртөг, арилжааны өртөг, абсолют нэмүү өртөг, харьцангуй нэмүү өртөг зэргээр ялгаатай тайлбарласан байна. Эдгээр нэр томъёоллоос хэрэглээний өртөг гэдэг нь

[56] Гантулга, Г. Үл хөдлөх хөрөнгийн харилцаа. -УБ., 2011. 139 дэх тал

[57] Барсболд, Б. Өртөг, үнэ, үнэ цэнийн тухай ойлголт.// Хөрөнгийн үнэлгээ сэтгүүл. Дугаар 02/002. – Уб., 2015. 3 дахь тал

[58] Карл Хайнрих Маркс XIX зууны үеийн Германы философич, улс төр судлаач, эдийн засагч, түүхч, сэтгүүлч, эрдэмтэн. 1848 онд “Коммунист намын тунхаг бичиг” бүтээлээ Фридрих Энгельстэй хамтран бүтээсэн. Мөн 1867-1894 оны хооронд Капитал 1, 2, 3 цуврал зохиолуудаа бичсэн.

ямар нэг таваарыг бий болгосноос үүсэх ашигт байдлыг арилжааны өртөг гэнэ. болно.[59]

Үнэ: Эдийн засгийн сургаалийн түүхэнд тухайлбал МЭӨ 427-347 онд Платон, МЭӨ 384-322 онд Аристотель нар тухайн үеийн Грекийн эдийн засаг, улс төрийн талаар тайлбарлахдаа нийгмийг гүн ухаантан, цэрэг, доод давхрагынхан хэмээн ангилж тэдгээрийн хооронд товар солилцооны харилцааг дамжин нийгмийн үйлдвэрлэлийн хүрээнд товараас товар, товараас мөнгө, мөнгөнөөс товар, гэсэн арилжаа солилцооны хөгжлийн түвшинг тодорхойлж өгчээ.

Үнэ цэнэ: Value гэдэг үгийн гарал нь Франц хэлний valuta, Латин хэлний valere буюу үнэ цэнэ, хүч гэсэн үгнээс гаралтай. Value гэдэг үг нь нэг үг зүйн хувьд нягтлан бодох бүртгэлийн нэр томьёонд үнэ цэнэ, эдийн засгийн нэр томьёонд өртөг, худалдан авах чадвар, математикийн нэр томьёонд утга, үнэт чанар, техникийн нэр томъёонд хэмжээ, өнгөний хослол, санхүүгийн нэр томъёонд валют, худалдаа арилжааны нэр томъёонд векселийн дүн, чансаа, үнэлгээ, уран зурагт харилцан уялдаа гэсэн 6 төрлийн санааг илтгэдэг байна.[60]

Санхүүгийн зах зээл нэг талаас хөрөнгө босгох, бизнесээ өргөжүүлэх ашиг сонирхол бүхий компани, хувь хүмүүсийн, нөгөө талаас өөрт байгаа мөнгөн хуримтлалыг зах зээлд гаргаж хөрөнгөө өсгөх, эргэлтэд оруулах баталгаатай, ашигтай бизнест хөрөнгө оруулах хүсэл эрмэлзэлтэй компани, хувь хүмүүсийн хүрээнд явагддаг үйл ажиллагаа юм.

Эд хөрөнгийн үнэлгээний төрлийг тухай ойлголтыг:

1. Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ
2. Хөдлөх хөрөнгийн үнэлгээ
3. Биет бус хөрөнгийн үнэлгээ /үнэт цаас, вексель гэх мэт/
4. Оюуны үнэт зүйлийн үнэлгээ
5. Түүх, соёлын дурсгалт зүйлийн үнэлгээ гэж ангилж болох юм.

Үнэлгээний олон улсын стандартын “Үнэлгээний тулгуур ухагдахуун, зарчим”-д үл хөдлөх хөрөнгө, үл хөдлөх өмчийн ойлголтыг дараах байдлаар тодорхойлжээ. *Үл хөдлөх хөрөнгө гэдэг нь газар биет байдлаараа, газраас салгаж үл болох хүний бүтээсэн эд зүйлсийг хэлнэ.Энэ нь газар, түүн дээр болон доор байгаа нэмэлт зүйлсийн хамт харж, мэдэрч болох бодит биет зүйлс юм.* Эдийн засгийн агуулгаараа эзэндээ орлого оруулдаг өмчийг хөрөнгө гэнэ.

Олон улсын практикт үнэлгээг хийдэг, хянадаг, бүртгэдэг алба тус тусдаа байдаг бөгөөд энэ нь аливаа нэгэн нөлөөллөөс хараат бус байх нөхцөлийг бүрдүүлдэг. Хөрөнгө үнэлдэг алба болон үнэлгээчид нь тодорхой хариуцлага

[59] Олон улсын Үнэлгээний стандарт. -Уб., 2011. 6 дахь тал
[60] Барсболд, Б. Өртөг, үнэ, үнэ цэнийн тухай ойлголт. // Хөрөнгийн үнэлгээ сэтгүүл. Дугаар 02/002. -Уб., 2015. 4 дэх тал.

хүлээдэг ба энэ хариуцлага нь олон улсын түвшинд улс орны эдийн засгийн байдалд нөлөө үзүүлэх ач холбогдлоороо өндөр байдаг. Хөрөнгийн үнэлгээ хийх алба, үнэлгээчид нь зохих нэр хүндтэй, олон улсын түвшинд үнэлгээ хийх чадвартай, хөрөнгө үнэлэх зохих шалгуурыг хангаж эрх авсан, бусдын нөлөөнд автдаггүй, өндөр ёс суртахуун, ажлын зохих дадлагатай байх нь зүйтэй бөгөөд энэ нь үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг бодитой зөв тогтооход чухал нөлөөтэй юм.[61] Үнэлгээ хийх үндэслэл нь үнэлгээчин болон үйлчлүүлэгч харилцан тохиролцсон болон хуульд заасан тохиолдол эрх бүхий этгээдийн шийдвэр гарсан тохиолдлуудад үнэлгээ хийх үндэслэл бүрддэг.

ХОЁР. ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, САЙЖРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хамгийн ихээр үнэлэгддэг эд хөрөнгө бол үл хөдлөх эд хөрөнгө юм. Энэхүү хуулиар тусгайлан эрх олгогдсон албадлагын арга хэмжээний дагуу төлбөр төлөгчийн эдийн баялагтай холбоотой эрхэд халддаг гүйцэтгэлийн ажиллагааны дээд хэлбэр нь үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгөөс албадан төлбөр гаргуулах үйл ажиллагаа хамаардаг. Ийм ч учраас үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдаатай холбоотой шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа ихээхэн маргаан, гомдлыг дагуулдаг.

2023 онд Улсын хэмжээнд нийт 52956 гүйцэтгэх хуудасны 3.0 их наяд төгрөгийн мөнгөн дүнтэй гүйцэтгэх баримт бичгийг гүйцэтгэвэл зохихоос 30835 гүйцэтгэх хуудасны 646.6 тэрбум төгрөг буюу 58.2 хувийг биелүүлсэн байна.[62]

Аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албад өөрсдийн албанд Үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдааг зохион байгуулан явуулдаг. Үл хөдлөх эд хөрөнгийн дуудлага худалдааг зохицуулсан иргэний болон шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулийн зарим зүйл заалтыг шүүхийн практикт зөв хэрэглэх тухай зөвлөмжид “Шүүхэд шийдвэрлэгдэж буй иргэний эрх зүйн маргаантай хэрэгт үүргийн харилцааны талууд үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ байгуулж, энэхүү гэрээ нь хуульд заагдсан бүхий л шаардлагыг хангасан, хүчин төгөлдөр гэрээ бол нэхэмжлэлийн шаардлагыг барьцааны эд хөрөнгөнөөс гаргуулах тухай заалтыг шүүхийн шийдвэрт заавал тусгаж байхыг шүүхүүдэд зөвлөжээ. Ингэхдээ Иргэний хуулийн 174 дүгээр зүйлд заасан шаардлагыг үүрэг гүйцэтгүүлэгч үүрэг гүйцэтгэгчид тавьсан боловч үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй, үүрэг гүйцэтгүүлэгч шүүхэд ипотекийн зүйл болох хөдлөх эд хөрөнгийн албадан худалдаж, шаардлагаа хангуулах хүсэлт гаргасан байхаар Иргэний хуулийн 175 дугаар зүйлийн 175.1-д заасныг анхаарах нь зүйтэй гэжээ.

Улсын Дээд Шүүхийн зөвлөмжид үл хөдлөх эд хөрөнгийг үүргийн шаардлагыг хангуулахаар барьцаалсан тохиолдолд тухайн үл хөдлөх эд хөрөнгөөс

[61] Тунгалаг, Н. "Хөрөнгийн үнэлгээний арга, хандлага". -УБ., 2010. 52 дахь тал.
[62] ШШГЕГ-н 2023 оны жилийн эцсийн статистик мэдээ

шаардлага хангах үндсэн гурван хэлбэрийг хуульд тусгасныг анхаарч тухайн тохиолдол бүр тохируулан зөв хэрэглэж байхыг зөвлөжээ.[63] Ингэхдээ:

а) Үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдаанд оруулах тухай шүүхийн шийдвэрт тусгахдаа ипотекийн зүйлийг албадан дуудлага худалдаанд оруулах тухай үүрэг гүйцэтгүүлэгчийн хүсэлт байхыг шаардсан,

б) Талуудын тохиролцсон өөр хэлбэрийн худалдаа хийхээр шүүхийн шийдвэрт тусгахдаа үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч, үүрэг гүйцэтгүүлэгч харилцан тохирч, шүүхэд хамтран хүсэлт гаргасан байхыг шаардсан,

в) Үл хөдлөх эд хөрөнгийг бусдын удирдлагад шилжүүлэх тухай шүүхийн шийдвэрт тусгахдаа үүрэг гүйцэтгүүлэгч хүсэлт гаргасан байхыг тус тус шаардсан байна.

Үүрэг гүйцэтгэгч (зээлдэгч) гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй нөхцөлд үүрэг гүйцэтгүүлэгч (зээлдүүлэгч) нь Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.1-д зааснаар үл хөдлөх эд хөрөнгийг худалдахыг шаардах, мөн шаардлага гаргасан боловч үүрэг гүйцэтгэгч *(барьцаалуулагч)* үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгчийн *(барьцаалагч)* хүсэлтийг үндэслэн ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийг шүүхийн шийдвэрийн дагуу албадан худалдан борлуулж үүргийг хангуулдаг.

Хөрөнгийн албадан дуудлага худалдааг шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, эсхүл шийдвэр гүйцэтгэх алба зохион байгуулдаг. Төлбөр төлөгчийн үл хөдлөх эд хөрөнгө, үнэт цаас, эдийн бус хөрөнгө, түүх, соёлын өвд хамаарах үнэт зүйл, тусгай зөвшөөрлийг зөвхөн хөрөнгийн албадан дуудлага худалдаагаар худалдан борлуулах ба уг дуудлага худалдааг Иргэний хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулах ёстой.

Шүүхийн шийдвэр, захирамжийн дагуу үл хөдлөх эд хөрөнгийг албадан борлуулах тохиолдолд дуудлага худалдааны үнийг талууд *(үүрэг гүйцэтгэгч, үүрэг гүйцэтгүүлэгч, гуравдагч этгээд)* харилцан тохиролцох, хэрэв тохиролцохгүй бол үнэлгээчний тогтоосон зах зээлийн үнийн 70 хувиар тооцон дуудлага худалдаанд оруулдаг. Анхны дуудлага худалдаагаар санал болгосон үнэд хүрэх санал гараагүй буюу дуудлага худалдаанд хэн ч оролцоогүй бол хоёр дахь дуудлага худалдааг явуулдаг. Хоёр дахь дуудлага худалдааны доод үнийг талууд харилцан тохиролцох, хэрэв тохиролцохгүй бол үнэлгээчний тогтоосон зах зээлийн үнийн 50 хувиар тооцон дуудлага худалдаанд оруулдаг.

Албадан дуудлага худалдааг хөдөө орон нутагт харъяа газар нэгжүүд, нийслэлийн хэмжээнд хөрөнгийн албадан дуудлага худалдааг Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар *(цаашид "НШШГГ" гэх)* эрхлэн зохион байгуулдаг. Дуудлага худалдаагаар худалдах үл хөдлөх эд хөрөнгийн санал болгох үнийг ***нэгдүгээрт*** талууд харилцан тохиролцож тогтоох, ***хоёрдугаарт*** тохиролцож

[63] http://www.legalinfo.mn/law/?cat=32&l_name=%D0%97

чадаагүй тохиолдолд дээр дурдсанаар үнэлгээчний тогтоосон зах зээлийн үнийн тодорхой хувиар тогтоодог. Ипотекийн зүйл буюу үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг тогтоохдоо үнэлгээний зүйлийн шинж байдал, онцлог, зориулалтыг харгалзан хөрөнгийн үнэлгээний өртгийн, жишиг үнийн болон орлогын аргуудыг хослуулан олон улсын болон хөрөнгийн үнэлгээний үндэсний стандартад нийцүүлж үнэлэх ёстой. Гэтэл үнэлгээчний тогтоосон үнэлгээ илтэд өмчлөгч (үүрэг гүйцэтгэгч)-ийн эрх зүйн байдлыг дордуулсан *(өмчлөлийн зүйлийг үнэгүйдүүлсэн),* зах зээлийн үнэд үндэслээгүй, эсхүл хэт өндөр үнэлэгдсэн тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.7-д зааснаар талууд *(төлбөр төлөгч, төлбөр авагч, гуравдагч этгээд)* эд хөрөнгийн үнэлгээний талаар эрх бүхий байгууллагад гомдол гаргах эрхтэй.

Мөн Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс гаргадаг Монгол Улсын шүүхийн тайлан *(2023 оны хагас жил)*-г харвал сум, сумдын, дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 2023 оны эхний хагас жилд нийт 59197 маргааныг хянан шийдвэрлэсэн. Үүнийг задлан харуулбал,

- Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд 7026 хэрэг хянан шийдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 7.3 хувиар буурсан байна.
- Иргэний хэргийн анхан шатны шүүхүүд 32050 хэрэг маргаан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 8.3 хувиар өссөн.
- Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 1336 хэрэг шийдвэрлэсэн нь өмнөх оноос 30.6 хувиар өссөн дүнтэй байна[64]

Хөрөнгийн албадан дуудлага худалдааны явцад төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээд, төлбөр авагч, гуравдагч этгээдийн зүгээс анхны болон хоёр дахь дуудлага худалдааны үнэ зах зээлийн бодит үнийг тогтоож чадаагүй, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хуулиар тогтоосон журам зөрчсөн зэрэг үндэслэлээр хөрөнгийн үнэлгээ, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг бүхэлд нь хүчингүй болгуулах мөн шинжээчийн үнэлгээг дахин хийлгэх гомдол, нэхэмжлэл гаргах явдал ихсэх болсон.

Тухайлбал 2019 онд 284, 2020 онд 354, 2021 онд 344, 2022 онд 277, 2023 онд 283 шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой хэрэг маргаанаар Шийдвэр гүйцэтгэх байгууллага хариуцагчаар татагдан оролцсон байна[65]. Өөрөөр хэлбэл, сүүлийн жилүүдэд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа, үнэлгээг хүчингүй болгуулах нэхэмжлэл эрс нэмэгдсэн байна. Энэ нь хөрөнгө албадан худалдан борлуулах ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмаар явагддаггүй, дуудлага худалдааны санал болгосон үнийг зах зээлийн үнээс хэт доогуур тогтоож байгаатай холбоотой юм.

[64] Монгол Улсын шүүхийн тайлан 2023 оны эхний хагас жил, Шүүхийн Ерөнхий зөвлөл,
[65] https://shuukh.mn/cases/1/1?item_id=27

Дүгнэвэл, иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа, тэр дундаа хөрөнгө албадан худалдан борлуулах ажиллагааны үед төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээд, гуравдагч этгээдийн зүгээс шүүхэд хандах явдал нэмэгдсэн байна. Энэ нь шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагддаггүй, уг ажиллагааны явцад талуудад хуулиар олгогдсон эрхийг эдлүүлээгүй, дуудлага худалдааны санал болгох үнэ өмчлөгчийн өмчийг үнэгүйдүүлж байгаатай холбоотой байна. Мөн 2017 онд шинэчлэн найруулагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.7-д зааснаар талууд *(төлбөр төлөгч, төлбөр авагч, гуравдагч этгээд)* эд хөрөнгийн үнэлгээний талаар гомдол гаргаж нэгэнт шийдвэрлүүлсэн тохиолдолд тухайн асуудал *(хөрөнгийн албадан худалдан борлуулах шийдвэрийн талаар болон хөрөнгийн үнэлгээний талаар)*-аар хөрөнгө албадан худалдан борлуулах ажиллагааны явцад шүүхэд дахин гомдол гаргах эрхийг хязгаарласан байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхийг хязгаарласан төдийгүй улмаар өмчлөгчийн эрх зөрчигдөхөд хүргэж болохоор байна.

Жишээ нь, талуудын гаргасан гомдлыг шүүх хүлээн авч, ханган шийдвэрлэсэн тохиодолд дуудлага худалдааны үнийг үнэлгээчин дахин тогтооно. Амьдрал баялаг учраас үнэлгээчний дахин тогтоосон үнэлгээ талуудын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хөндөөгүй, үнэлгээг бодитоор тогтоосон гэж үзэх боломжгүй. Тухайлбал, шүүхээс үнэлгээчний тогтоосон 80.000.000 /наян сая/ төгрөгний үнэлгээ нь зах зээлийн бодит үнийн дүнд үндэслэгдээгүй тул дахин үнэлэхийг даалгасан гэж үзье. Гэтэл үнэлэгээчин дахин үнэлгээ тогтоохдоо урьд тогтоосон үнээс онцын ялгаагүй 80.000.001 /наян сая нэг/ төгрөгөөр үнэлэх, эсвэл үнэлгээчин субъектив ашиг сонирхлоор хэт зөрүүтэй үнэлэхийг үгүйсгэх боломжгүй юм.

Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ болон албадан дуудлага худалдааг хүчингүй болгосон шийдвэрээс харахад:

-Тухайн эд хөрөнгийн бусад өмчлөгч нараас үнийн санал аваагүй болон шүүхийн шийдвэрээр худалдагдах эд хөрөнгөнөөс хасахаар шийдвэрлэсэн үл хөдлөх эд хөрөнгийг албадан дуудлага худалдаанд оруулсан,

-Албадан дуудлага худалдааны талаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудад өгсөн мэдэгдэл, албадан дуудлага худалдаанд оруулах тогтоол, нийтэд мэдээлсэн үнэ нь хоорондоо зөрүүтэй бичигдсэн байх,

-Төлбөр авагч, төлбөр төлөгч нараас үнийн санал авсан талаар, үнийн санал өгөөгүй, эсхүл тохиролцоонд хүрээгүй гэдгийг баримтаар нотолж чадаагүйн улмаас,

-Төлбөр төлөгч болон төлбөр авагч нараас үнийн санал авахдаа хугацааны хувьд зөрүүтэй авснаар зах зээлийн бодит ханшийг тогтооход нөлөөлсөн,

-Анхны албадан дуудлага худалдаанд гомдол гаргаж амжаагүй байхад 2 дахь албадан дуудлага худалдааг явуулсан,

-Албадан дуудлага худалдаа явагдсан талаар мэдэгдээгүй, мэдэгдсэн ч танилцсан талаарх гарын үсэг, нотолгоо байхгүй, эсхүл гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэх бололцоог хангаагүй,

-Шинжээч томилж үнэлгээ тогтоосон талаар төлбөр төлөгч, төлбөр авагч, бие даасан шаардлага гаргах эрхтэй гуравдагч этгээдэд цаг тухайд нь мэдэгдээгүй,

-Албадан дуудлага худалдаа явуулахдаа урьд шүүхээр хүчингүй болгосон дуудлага худалдааны үнээр дахин оруулсан зэрэг зөрчлийн улмаас үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдааг хүчингүй болгож шийдвэрлэжээ.

Шүүхээр хянан хэлэлцэгдэж хүчингүй болсон **Албадан дуудлага худалдааны 83,8 хувь нь** Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн 177.1, 177.4 дэх заалтуудыг тус тус зөрчсөний улмаас шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хүчингүй буюу хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь судалгаанаас харагддаг.

Дуудлага худалдааны анхны үнийг тогтоохдоо талуудыг байлцуулаагүй, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаанаар нэгэн зэрэг ирж чаддаггүйн улмаас хуульд заасан ".....харилцан тохиролцож тогтоох...." гэсэн заалт хэрэгжихгүй байна. Анхны албадан дуудлага худалдаагаар худалдан борлогдоогүй үл хөдлөх эд хөрөнгийг 2 дахь албадан дуудлага худалдаанд оруулах анхны үнийг **"...шаардлагыг хангахад хүрэлцэхүйц..."** хэмжээгээр тогтооно гэж заасан нь ямар нөхцөлийг үндэслээд хэдэн хувиар бууруулахыг тодорхойлон тусгаагүй байснаас шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хүчингүй болж байсан.

Харин Иргэний хуульд 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр "177.1. Дуудлага худалдаагаар худалдах үл хөдлөх эд хөрөнгийн санал болгох доод үнийг дуудлага худалдаа явуулахаас өмнө үүрэг гүйцэтгэгч, үүрэг гүйцэтгүүлэгч, өмчлөгч харилцан тохиролцож тогтоосон үнийн, хэрэв тохиролцоогүй бол үнэлгээчний тогтоосон зах зээлийн үнийн 70 хувиар тооцон тогтооно. Үнэлгээчнийг дуудлага худалдаа явуулах эрх бүхий этгээд томилно." гэх,

"177.4. Хоёр дахь дуудлага худалдааны доод үнийг харилцан тохиролцож тогтоосон, эсхүл үнэлгээчний тогтоосон зах зээлийн үнийн 50 хувиар тооцон тогтооно."[66] гэсэн заалт орсноос хойш үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдаатай холбоотой гомдол маргааныг шүүхийн шатанд шийдвэрлэхэд нэхэмжлэгчдийн гомдлын зарим хэсгийг болон бүхлээр нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэж байна.

[66] Иргэний хууль. //Төрийн мэдээлэл сэтгүүл. Дугаар 7. -Уб., 2002.

Төлбөр төлөгчийн хувьд талууд харилцан тохиролцож чадвал анхны болон хоёр дахь үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдаагаар худалдан борлогдох үл хөдлөх эд хөрөнгийг зах зээлийн үнээс доогуур худалдахгүй байх боломж байгаа боловч бодит байдалд талууд харилцан тохиролцож чаддаггүй. Учир нь төлбөр авагч төлбөрөө хурдан шуурхай гаргуулах юм. Харин төлбөр төлөгч өөрийн өмчлөлийн эд хөрөнгөө зах зээлийн үнээр, өндөр үнэтэй худалдан борлуулах хүсэлттэй холбоотой болно.

Үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдааны үнэлгээг шууд хуульд 70, 50 хувь гэж тогтоосноор төлбөр төлөгчийн эрх ашгийг хамгаалсан байгаа боловч нөгөө талаар энэ нь хангалттай хэмжээнд үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдааны үнэлгээний доод үнэлгээний хувийг тогтоосон гэж миний бодлоор үзэхгүй байна.

Энэ нь шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны хувьд давуу тал хэдий ч төлбөр төлөгчдийн хувьд эд хөрөнгийг нь үнэгүйдүүлж байгаа тэгш эрхийг хангах зарчмыг алдагдуулж байгаа хэрэг юм. Үнэлгээний Олон улсын 2011 стандартын, 54-т албадан борлуулах гэдэг ойлголтод маркетингийн талаар хамааруулж үзсэн байдаг. Үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдаа нь нэг талаар төлбөр авагчийн төлбөрийг барагдуулахад удаашралтай, нөгөө талаар худалдан борлогддоггүй байдалд дараах хүчин зүйл нөлөөлж буй бөгөөд үүнд албадан дуудлага худалдаанд Үнэлгээний Олон улсын стандартад заасан маркетингийн талаар юу ч хийдэггүй учраас зарим хүндрэл бэрхшээл үүсэж байж болох юм. Хэрвээ эдгээр орчин нөхцөлийг бүрдүүлж өгвөл төлбөр авагчийн төлбөр хурдан шуурхай барагдах, төлбөр төлөгч шүүхэд үнэлгээтэй холбоотой, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар гомдлоор дахин дахин хандахгүй байх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулах байдал багасах боломжтой байна.

Гадаадын зарим улс орны иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийг судалж үзэхэд: /Холбооны бүгд найрамдах Герман улс, Бүгд Найрамдах Казакстан улс/

Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд шийдвэр гүйцэтгэгч гол, чухал үүрэг гүйцэтгэдэг учраас тэднийг бусдаас хараат байж, гүйцэтгэлийн ажиллагааг түргэн, шуурхай, нээлттэй явуулахад мөрдөх хууль тогтоомж, дүрэм, заавар гэх мэт эрхийн актууд нь хэрэглэхэд ойлгомжтой, хоёрдмол санаа агуулаагүй, гүйцэтгэх арга хэмжээг нарийн зохицуулсан байх нь чухал гэж үзэж байна. Шийдвэр гүйцэтгэгч төрийн нэрийн өмнөөс бусдын өмч хөрөнгөнд хэний ч зөвшөөрөлгүй халдах тусгайлсан эрхийг эдэлдэг учраас тэдэнд мэдлэг, мэргэжил.мэргэшил, ёс суртахууны хувьд өндөр шаардлага тавигдах тийм эрх зүйн орчин бий болгох. Шийдвэр гүйцэтгэгчийг мэргэжлийн удирдлагаар хангах үүргийг шүүх гүйцэтгэж байхаар бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа нь өөрөө өмчийн болон олон талын харилцаатай холбогдсон нарийн харилцаа байдаг учраас түүнд тулгарсан бэрхшээлтэй

асуудлууд өмнө нь урган гарч байдаг. 1990 он гарснаас хойш нийгэм эдийн засгийн байдал бүхэлдээ өөрчлөгдөн өмчийн олон хэлбэрийн харилцаа үүсэн, тэр дундаа банк санхүүгийн хуулийн этгээдүүдийн аж ахуй үйл ажиллагаа улам өргөжиж байна. Мөн тухайн Улсын иргэний эрх хууль ёсны ашиг сонирхол зэргийг харгалзан үзэж, өршөөл буюу итгэл үзүүлж тухайн үүргийн гүйцэтгэлийг албадан дуудлага худалдаа явуулахгүйгээр шийдвэрлэбудэг байна. Мөн өмчлөгчийн эрх ашгийг хөндөж албадан дуудлага худалдааг эдийн засгийн зарлага, бусздаас хараат бус байх зарчмуудыг баримталж Шүүхийн шийдвэрийг явуулдаг байна.

ДҮГНЭЛТ

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, албадан дуудлага худалдаанд үл хөдлөх эд хөрөнгийг үнэлэх асуудлыг боловсронгуй болгосноор хууль зүйн хувьд төлбөр авагч иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээж эдлүүлж төр иргэнийхээ өмнө үндсэн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж төлбөр төлөгч иргэн, байгууллагын хувьд өмч хөрөнгөө бодитойгоор үнэлүүлэх буюу зөвхөн өр төлбөрийг барагдуулах зорилгоор хөрөнгийг үнэгүйдүүлэх байдлаас ангид байх боломжийг болгоно. Мөн монгол улсын хууль зүйн шинжлэх ухааны хувьд эрх зүйн нэгэн хийдлийг үгүй хийж байгаа юм. Эдийн засгийн хувьд төлбөр авагч эдийн засгийн байдлыг сэргээн дээрдүүлж энэ хэмжээгээрээ эдийн засгийн эргэлтэд орох хөрөнгө нэмэгдэж мөн хөрөнгийг бодитойгоор үнэлүүлж төлбөрийг барагдуулснаар далд эдийн засгийг үгүй хийхэд нэмэр болно. Иймд төлбөр авагчийг эдийн засаг болон санхүүгийн нөхцөл байдлаар хохироож буй дээрх үйлдлийг таслан зогсоох эрх зүйн орчиныг боловсронгуй болгох хэрэгтэй. Мөн иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хөрөнгө дуудлага худалдаанд оруулах үнэлгээг тогтоох тухай Монгол улсын одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Иргэний хуулийн 177 дугаар зүйл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан зохицуулалтын хүрээнд иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хугацаа албадан дуудлага худалдаанд үл хөдлөх эд хөрөнгө үнэлэх талаар харилцааг зохицуулсан хэм хэмжээ нь нэг талаас тодорхойгүй зарим шаардлагатай зохицуулалт хуульчлагдаагүй байдлаас төлбөр төлөгч болон төлбөр авагчийн ашиг сонирхол нь хөндөгдөж байна.

САНАЛ

Иймээс цаашид эд хөрөнгийн үнэлгээтэй холбоотой шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр дараах саналыг дэвшүүлж байна.

1. АНУ-ын Калифорний мужийн Иргэний процессын хуулийн 10330-р зүйлд “дуудлага худалдаагаар тухайн үл хөдлөх эд хөрөнгийг зээлээр худалдан авч байгаа тохиолдолд худалдан авагч үнийн дүнгийн 25 хувийг бэлнээр төлсөн байх шаардлагатай гэж зээлийн үйлчилгээг оруулж өгсөн байна.” Зээлийн үйлчилгээг худалдан авагчдад санал болгосноор төлбөр авагчийн төлбөр хурдан барагдах нөхцөл бүрдэж байна гэж үзэж байгаа тул үл хөдлөх эд хөрөнгийн албадан

дуудлага худалдааны ажиллагаанд худалдан авагчид зээлээр худалдах хууль эрх зүйн орчиныг бий болгох,

2. Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн 177.1 “Дуудлага худалдаагаар худалдах үл хөдлөх эд хөрөнгийн санал болгох доод үнийг дуудлага худалдаа явуулахаас өмнө үүрэг гүйцэтгэгч, үүрэг гүйцэтгүүлэгч, өмчлөгч харилцан тохиролцож тогтоосон үнийн, хэрэв тохиролцоогүй бол үнэлгээчний тогтоосон зах зээлийн үнийн 70 хувиар тооцон тогтооно.” гэснийг 90 гэж өөрчлөх,

3. Мөн хуулийн 177 дугаар зүйлийн 177.4. “Хоёр дахь дуудлага худалдааны доод үнийг харилцан тохиролцож тогтоосон, эсхүл үнэлгээчний тогтоосон зах зээлийн үнийн 50 хувиар тооцон тогтооно.” гэснийг 70 хувь болгох саналтай байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Ном сурах бичиг, гарын авлагаас

1. Баярсайхан, Б. Монгол хэлний тайлбар толь. -Уб., 2011. 30 дахь тал
2. Гантулга, Г. Үл хөдлөх хөрөнгийн харилцаа. -Уб., 2011. 139 дэх тал
3. Карл Хайнрих Маркс XIX зууны үеийн Германы философич, улс төр судлаач, эдийн засагч, түүхч, сэтгүүлч, эрдэмтэн. 1848 онд “Коммунист намын тунхаг бичиг” бүтээлээ Фридрих Энгельстэй хамтран бүтээсэн. Мөн 1867-1894 оны хооронд Капитал 1, 2, 3 цуврал зохиолуудаа бичсэн.
4. Тунгалаг, Н. "Хөрөнгийн үнэлгээний арга, хандлага". -УБ., 2010. 52 дахь тал.
5. //www.legalinfo.mn/law/?cat=32&l_name=%D0%97 2024.03.10
6. //shuukh.mn/cases/1/1?item_id=27 2024.03.10
7. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль. //Төрийн мэдээлэл. Дугаар №25. -Уб., 2003.
8. Барсболд, Б. Өртөг, үнэ, үнэ цэнийн тухай ойлголт. //Хөрөнгийн үнэлгээ сэтгүүл. Дугаар 02/002. – Уб., 2015. 3 дахь тал
9. Иргэний хууль. //Төрийн мэдээлэл сэтгүүл. Дугаар №7. -Уб., 2002
10. Барсболд, Б. Өртөг, үнэ, үнэ цэнийн тухай ойлголт.// Хөрөнгийн үнэлгээ сэтгүүл. Дугаар 02/002. -Уб., 2015. 4 дэх тал.
11. ШШГЕГ-н 2023 оны жилийн эцсийн статистик мэдээ
12. Монгол Улсын шүүхийн тайлан 2023 оны эхний хагас жил, Шүүхийн Ерөнхий зөвлөл,
13. Олон улсын Үнэлгээний стандарт. -Уб., 2011. 6 дахь тал

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ ЗҮЙН ХАРИУЦЛАГА



О.Уртнасан
Дотоод хэргийн Их сургуулийн
Удирдлагын академийн 7051 дугаар дамжааны
магистрант, ахмад

Товч агуулга: Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа, шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага, тэдгээрийн эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн талаар онолын болон практик үр дүнг судахыг зорьсон.

Abstract: It was intended to study the theoretical and practical results of the execution of the court decision in administrative cases, the responsibility imposed on the person who does not comply with the court decision, and their legal regulation and implementation.

Түлхүүр үг: Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага, захиргааны байгууллага.

Key words: Court decisions in administrative cases, decision enforcement proceedings, liability for non-compliance with court decisions, administrative bodies.

УДИРТГАЛ:

Монгол улсын Үндсэн хуулийн 47 дугаар зүйлд “Монгол улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ[67]” гэж заасан бөгөөд шүүхийг Эрүү, Иргэний, Захиргааны гэх төрлөөр нь дагнан байгуулж болно гэж заасан байна. Монгол улсын нутаг дэвсгэрт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага шүүхийн шийдвэрийг гүйцэтгэж байгаа бөгөөд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хуульд иргэний, захиргааны, зөрчлийн, эрүүгийн[68] гэж ангилж дээрх төрлөөр нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх биелүүлэх нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үндсэн чиг үүрэг бөгөөд захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн салшгүй нэгэн хэсэг юм.

[67] Монгол улсын үндсэн хууль, 1992 он.
[68] Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, зургаа дугаар зүйл, Төрийн мэдээллийн эмхэтгэл, №24, 2017 он.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь иргэн, байгууллага хоорондын харилцааг, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь зөрчлийн тухай хуулиар зөрчил шийтгэгдсэн этгээдэд холбогдон гарсан шүүхийн шийдвэрийг биелүүлдэг бол Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь захиргааны байгууллага, албан тушаалтанд тодорхой үүрэг хүлээлгэж, шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлдгээрээ онцлогтой.

Зарим тохиолдолд захиргааны албан тушаалтан өөрчлөгдөх, шүүхийн шийдвэрийг өөрийн хариуцсан асуудал биш гэж тайлбарлах, шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байх үйлдэл гаргаж шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүндрэл учруулж байна.

Сүүлийн таван жилийн байдлаар захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтийг хувийг авч үзэхэд 2016 онд 62,6 хувь, 2017 онд 65,3 хувь, 2018 онд 61,6 хувь, 2019 онд 55,9 хувь[69], 2020 онд -50,7 хувийн бодит биелэлттэй байгаа бөгөөд 2017 оноос 2018 оны хооронд 2,7 хувиар өссөн бөгөөд 2018 оноос 2021 оныг хүртэлх хугацаанд 5,7-5,9 хувь дунджаар буурсан үзүүлэлттэй байгаа нь улсын хэмжээнд захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтийг нэмэгдүүлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгасан Захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой хуулийн зүйл, заалтыг шинэчлэн найруулах, захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай үүсээд байна.

Дээрх тоон судалгааг харахад улсын хэмжээнд нийт биелүүлбэл зохих гүйцэтгэх баримт бичгийн 50 хувийг биелүүлж байгаа нь одоогоор хэрэгжиж байгаа хуулийн зохицуулалт хангалтгүй, нийт захиргааны хэргээр шүүхийн шийдвэр гаргасан иргэд, аж ахуй нэгжийн 50 хувь нь хэргээ шийдвэрлэж чадахгүй хугацаа алдан хохир ч байгаа нь дээрх тоон судалгаанаас ажиглагдаж байна.

Захиргааны шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байх нь иргэн хүн, төр, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад итгэх итгэлгүй болж, хуулийг дагаж мөрдөхгүй байх, өөрийн Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдэлж чадахгүй байх, шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчим алдагдаж байгаа юм.

Иймд Захиргааны хэргийн талаарх Шүүхийн шийдвэрийг нэн даруй биелүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахын тулд Захиргааны хэргийн талаар Шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэдэг байх шаардлага тулгар ч байна.

Захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны ойлголт:

Захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үргэлжлэл бөгөөд захиргааны хэргийн шүүхээс гарсан шийдвэр биелэх төгсгөлийн шат юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх

[69] Б.Алтангэрэл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэл тайлан. 2020 он.

ажиллагааны зорилго нь шүүхээс гарсан шийдвэрийг албадан биелүүлж, бусдын хуулиар хамгаалагдсан эрх ашгийг бодит байдлаар сэргээхэд оршдог. [70]

Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелүүлэхгүй байгаа этгээдэд хүлээлгэж байгаа хариуцлагын хэлбэр арав гаруй байхад захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг биелүүлэхгүй байгаа этгээдэд хүлээлгэж буй хариуцлагын хэлбэр нь хоёр л төрөлтэй байгаа нь Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд хүндрэл учруулаад зогсохгүй дээрх хоёр хуулийн хариуцлага хүлээлгэх хэлбэр нь Шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд нөлөөллийн хувьд шууд шийдвэр биелүүлэхэд нөлөөлж чадахгүй байна.

Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуульд Шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа этгээдэд хүлээлгэх хууль зүйн хариуцлагыг хүлээлгэхээр заасан бөгөөд зөрчлийн хуульд тусгагдсан байдлаар Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа этгээдэд зөрчлийн хэрэг үүсгэж хариуцлага хүлээлгэх боломжтой боловч практик дээр захиргааны ажилтанд зөрчлийн хуулиар торгууль оногдуулсан тохиолдол байхгүй байна.

Харин эрүүгийн хуульд заасан зүйл заалтаар Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа этгээдэд хариуцлага хүлээлгэх арга ажиллагааг тодорхой заагаагүй бөгөөд зөвхөн дүр эсгэн биелүүлсэн гэх хэсгээр хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэхээр байгаа боловч яг энэ тохиолдлоор эрүүгийн хэрэг үүсгэн хариуцлага хүлээлгэсэн тохиолдол одоогоор байхгүй байгаа нь харамсалтай байна. Эрүүгийн хуулийн 21.7-д заасан бусад зүйл заалт нь иргэнээс төлбөр гаргуулах ажиллагаатай холбоотойгоор эрүүгийн хэрэг үүсгэн хариуцлага хүлээлгэх шаардлагатай байна.

Зөрчлийн тухай хуульд хүүхдийн тэтгэлгээ төлөөгүй этгээдэд 7-30 хоногийн баривчлах ял шийтгэл оногдуулж байхад Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа этгээдэд одоогоор мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид Шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд бодитойгоор нөлөөлөхүйц хариуцлага хүлээлгэх хуулийн зүйл заалт байхгүй байна.

Захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа тулгамдаж буй асуудал :

Шийдвэр гүйцэтгэх газрын хэмжээнд захиргааны шийдвэр гүйцэтгэхтэй холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтийг судлан үзвэл[71]

[70] А.Дугарма “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онол, практикийн асуудал” илтгэл.
[71] Шийдвэр гүйцэтгэлийн тайлан 2020 он, Улаанбаат хот, 109 тал



Захиргааны хэргийн шүүхээс гаргасан шийдвэрийг хариуцагч сайн дураар биелүүлэхгүй, иргэнийг хохироосон үйлдэл үргэлжлэх тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн[72] 185-д зааснаар иргэн шүүхэд хандан "албадан биелүүлэх захирамж, гүйцэтгэх хуудас олгуулах"-аар хүсэлт гаргах эрхтэй байдаг. Үүний үндсэн дээр иргэд шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх хүсэлт гаргасны дагуу Монгол улсын хэмжээнд 2011 онд 67 гүйцэтгэх баримт бичиг, 2012 онд 71 гүйцэтгэх баримт бичиг 71 гүйцэтгэх баримт бичиг, 2013 онд 81 гүйцэтгэх баримт бичиг, 2014 онд 180 гүйцэтгэх баримт бичиг, 2015 онд 375 гүйцэтгэх баримт бичиг, 2016 онд 353 гүйцэтгэх баримт бичиг, 2017 онд 395 гүйцэтгэх баримт бичиг, 2018 онд 691 гүйцэтгэх баримт бичиг, 2019 онд 531 гүйцэтгэх баримт бичиг, 2020 онд 467 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллаа явагдаж байгаа бөгөөд 2018 оноос хойш гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт 5-6 хувиар буурсаар байгаа нь захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн шинэтгэлийг хийх зайлшгүй шаардлагатай байна.

Нийт шийдвэр гүйцэтгэгч нараас шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд тулгамдаж буй асуудлын талаар санал асуухад:

1. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн эрх зүйн орчин дутмаг байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлана гэсэн бөгөөд дээрхийн дагуу арга хэмжээ авахад шийдвэр гүйцэтгэгчийг заналхийлдэг, дарамталдаг асуудал гарч байна.

[72] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

Тухайлбал ажилд эгүүлэн томилох тухай шийдвэрийг гүйцэтгэхэд тухайн ажил албан тушаалд өөр хүн томилогдсон, орон тоо байхгүй байх, эсвэл ажилд нь эгүүлэн аваад 3 хоногийн дараа ажлаас чөлөөлдөг зэрэг зөрчлүүд байсаар байна.

2. Шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцдог эрх зүйн орчин дутмаг байна. Ажилгүй байсан хугацааны цалин хөлс олгох шийдвэр гүйцэтгэх ажиллагааг биелүүлэхэд төрийн байгууллагын дансыг битүүмжилж болохгүй байна. Дараа жилийн төсөвт тухайн хүний төлбөрийг барагдуулах мөнгийг суулгаж байна. Гэвч зарим нэг шалтгааны улмаас дээрх мөнгийг хариуцагч байгууллагын жилийн төсөвт тусгаж өгөхгүй 2-3 жил болж байгаа асуудал хүртэл байна.
3. Шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцооноос шалтгаалаад шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газар нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн нэг бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавина. Гэтэл хууль зүйн яам, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргатай холбоотой шүүхийн шийдвэрийг хэрхэн биелүүлэх, энэ ажиллагааг гүйцэтгэхдээ дэрх эрх мэдэл бүхий байгууллагаас хараат бус байж чадах эсэх, хэрэв чадах бол эрх мэдэл бүхий талтай хэрхэн харилцах талаар нарийн тогтоосон журам байхгүй байна.
4. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь хэт тунхгийн шинжтэй байна. Захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг тодорхой явуулах дараалал түүний хэрхэн хурдан биелүүлэх талаар тодорхойлсон хуулийн зохицуулалт дутмаг энэ байдлыг арилгах талаар тодорхойлсон дагаж мөрдөх журамгүй байна.
5. Шүүхийн шийдвэрийг биелүүлэх тухайд иргэдийн эрх зүйн ухамсар дутмаг, бодит нөхцөл байдалд биелүүлэхгүй байж болдог гэсэн ойлголтыг тухайн захиргааны албан тушаалтанд ойлгуулаад зогсохгүй, нөгөө талаас шүүхэд үл итгэх сөрөг үр дагаврыг эрх нь зөрчигдсөн иргэн, хуулийн этгээд, нийгмийн сэтгэл зүйд төрүүлж, шүүхийн шийдвэрийг биелэгдэхгүй байх нөхцөлд хүргэж байна.
6. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр нь хэрэгжүүлэхэд төвөгтэй хэт ерөнхий ойлголт төрүүлэхүйц гардаг. Үүнээс шалтгаалаад захиргааны албан тушаалтан буруу ойлгож хэрэглэх, эсэргүүцдэг.
7. Захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогчдыг төлбөр авагч, төлбөр төлөгч гэж нэрлэх нь учир дутагдалтай. Учир нь захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэл төлбөр гаргуулахаас өөр буюу ямар нэгэн үйлдэл гүйцэтгүүлэх, эрхтэй болохыг тогтоож, зөрчигдсөн эрхийг сэргээх байдаг.

Шийдвэр гүйцэтгэх байгууллага нь шүүхийн шийдвэрийг биелүүлэхээр шүүх, цагдаагийн байгууллага, прокурор, Хууль зүйн сайд, Ерөнхийлөгчид хүртэл хандаж захиргааны шүүхийн шийдвэрийг биелүүлэхээр олон арван албан бичгийг /мэдэгдэл/ явуулж ажиллаж байгаа бөгөөд зарим тохиолдолд үр дүн багатай байна.

Шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа захиргааны албан тушаалтанд арга хэмжээ авхуулахаар дүүргийн шүүхэд хандахад "зөрчил гаргасан хүнээ авчир" гэдэг шаардлагыг тавьдгаас шийдвэр гүйцэтгэгч нар захиргааны арга хэмжээ авхуулж чаддаггүй байна[73].

Харин шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа хэд хэдэн албан тушаалтанд эрүүгийн хариуцлага ногдуулахаар шийдвэр гүйцэтгэгчээс дүүргийн Цагдаагийн хэлтэст хандсан боловч эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан байна. Үүний шалтгаан нь эрүүгийн хэрэг үүсгэн шалгагдаж байх явцад шүүхийн шийдвэрийг биелүүлдэг, биелүүлсэн гэж өөрсдөө үзэн гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж хаажээ.

Шүүхийн шийдвэр биелэхгүй байгаа шалтгаан, түүнчлэн шийдвэрийг биелүүлэх явцад учирч буй хүндрэл бэрхшээлийг тогтоох зорилгоор Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн шийдвэр гүйцэтгэгч нартай ярилцаж, шийдвэр гүйцэтгэлийн материалтай нэг бүрчлэн танилцаж, тодруулахад дараах хүндрэл бэрхшээл гардаг байна. Үүнд:

1. Захиргааны байгууллага, албан тушаалтан нь шийдвэр гүйцэтгэгчийн шаардлагыг тоодоггүй, үл хэрэгсдэг. Захиргааны байгууллагын албан тушаалтнаас дарамт шахалт ирдэг.
2. Шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцооноос шалтгаалдаг. Өөрөөр хэлбэл шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, шийдвэр гүйцэтгэгч нь шийдвэр биелүүлэгч төрийн захиргааны байгууллага, албан тушаалтнаас хараат байдаг учир шүүхийн шийдвэрийг биелүүлэх талаар шаардлага тавьсан ч биелүүлдэггүй. НШГА нь Хууль зүй дотоод, хэргийн сайдын харьяа агентлагийн алба, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг байдаг учир дээд шатны байгууллагын албан тушаалтныг шийдвэр биелүүл гэж шаардахад хүндрэлтэй.
3. Захиргааны шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх хуулийн зохицуулалт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд байхгүйгээс шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг хэрхэн явуулах талаар шийдвэр гүйцэтгэгч нар нэгдсэн ойлголтгүй, иргэний шүүхээс шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг дутуу хийсэн гэж шийдвэр гүйцэтгэгчийг буруутгадаг. Мөн захиргааны байгууллага, албан тушаалтан захиргааны шүүхийн шийдвэрийг буруу ойлгож, хэрэгжүүлдэг.

[73] Д.Оросоо "Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тулгамдсан асуудал" Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны 10 жилийн ойн эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл

4. УИХ-аас "Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг шинээр олгохыг хориглох тухай хууль”-иар Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэн баталж, дагаж мөрдөх хүртэл хайгуулын тусгай зөвшөөрлийг шинээр олгохгүй, бусдад шилжүүлэхийг хориглосон байна. Энэ үндэслэлээр ашигт малтмалтай холбоотой шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хийгдэхгүй байна.
5. Шүүхийн шийдвэр ойлгомжгүй, хэрэгжих боломжгүй байдлаар гардаг.
6. Захиргааны байгууллага, албан тушаалтан шүүхийн шийдвэрийг биелүүлсэн дүр үзүүлдэг, биелүүлэхийг хүсдэггүй. Тухайлбал төрийн албан хаагчийг ажилд эгүүлэн томилсон шийдвэр гаргасны дараа албан тушаалыг бууруулсан тушаал гаргадаг. Тухайн албан тушаалд өөр хүнийг томилсон бөгөөд орон тоо байхгүй гэдэг.
7. Захиргааны байгууллага, албан тушаалтан шийдвэр гаргахдаа захиргааны эрх зүйгээр мэргэшсэн хуульчдаас зөвлөгөө авалгүй шийдвэр гаргаснаар шийдвэр нь биелэгдэх боломжгүй болдог байна.
8. Захиргааны байгууллага, албан тушаалтныг шүүхэд төлөөлж оролцсон мэргэжилтэн, эсвэл нэхэмжлэгчийг Авлигатай тэмцэх газарт шалгаж байгаа гэсэн шалтгаанаар шүүхийн шийдвэр биелүүлдэггүй.

Зарим иргэд 2005 онд гарсан захиргааны шүүхийн шийдвэрийг 2013 онд албадан гүйцэтгүүлэхээр хүсэлт гаргаж байгаа бол 2007 онд ирсэн шийдвэр гүйцэтгэх хуудас өнөөдрийг хүртэл гүйцэт биелэгдээгүй тохиолдол байна.

Харин иргэнд учруулсан мөнгөн хохирлыг тухайлбал ажилгүй байсан хугацааны цалинг Хууль зүйн сайдын төсвийн багцаас төрийн байгууллага, албан тушаалтны учруулсан хохирол гэж үзэн төлбөр авагч нарт олгож байгаа нь иргэдэд чирэгдэл үүсэхгүйгээр энэ төрлийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хийгдэх сайн талтай боловч улсын төсөвт байнгын санхүүжилт байдаггүйгээс заавал ирэх жилийх нь төсвийг хүлээдэг байна.

Урьд нь төрийн албан хаагчийг халсан албан тушаалтан нь ажилгүй байсан хугацааны цалин олгох зөвшөөрлийг Төрийн санд олгодог байснаас дээрх төрлийн шийдвэр гүйцэтгэлийн хэрэгжилт хангалтгүй байдаг.

Гэхдээ захиргааны байгууллагын албан тушаалтан шүүхийн шийдвэрийн дагуу төрийн албан хаагчийг ажилд нь томилохгүй байгаагаас ажилгүй байсан хугацааны цалинд их хэмжээний төлбөрийг өгдөг байна. Тухайлбал нэгэн төрийн албан хаагч 2010 оны 10-р сараас хойш ажилгүй байсан хугацааны цалинд 17 сая төгрөгийг төрөөс гаргуулсан бөгөөд одоо үлдсэн 22 сая төгрөгийг төсвөөс гаргуулахаар иргэний шүүхийн шийдвэр гарчээ. Өөрөөр хэлбэл нэг албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас болж, төрөөс 39 сая төгрөгийг

гаргуулахаар шийдвэрлээд байна. Иймд цаашид Иргэний хуулийн [74] 498 дугаар зүйлийн 498.5-д зааснаар төр өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай албан тушаалтнаас гаргуулан авах хуулийн заалтыг хэрэгжүүлэх цаг болжээ.

Түүнчлэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал, урамшууллыг иргэнээс гаргуулж хохиролгүй, шийдвэрийг биелүүлэхгүй байгаа албан тушаалтан, байгууллагаас гаргуулж байвал зүйтэй юм.

Захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахад тулгамдаж буй асуудлууд

- Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа шүүхийн шийдвэрт шууд заадаггүй, шийдвэрийг гүйцэтгэх арга журам, хүлээлгэх хариуцлагыг тодорхой тусгахгүй, шүүхээс ойлгомжгүй шүүхийн шийдвэр гаргаж байна.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын харьяанд байгаагаас төрийн эрх бүхий байгууллагад мэдэгдэл хүргүүлэхэд заавал дээд шатны байгууллагад уламжлуулан хүргэдэг.
- Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлахаас өөр хуулийн хариуцлага тооцох нарийвчилсан зохицуулалт байхгүй. /Олон нийтийн байгууллага болох аймгийн иргэдийн төлөөлөгчийн хурал, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал зэрэг олон нийтийн байгууллагыг нийтэд мэдээлэхэд хүндрэлтэй/
- Төсөвт байгууллагаас төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хүндрэлтэй байна. /Заавал дараа жилийн улсын төсвийг тусгуулдаг/
- Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагаа сул байна.

Дээрх тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэж хууль болон журмаар шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэж байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг биелүүлэхэд хамгийн хүндрэлтэй байгаа асуудал нь Шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа этгээдэд ямар нэгэн байдлаар хариуцлага хүлээлгэдэг, тухайн хариуцлага нь Шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд нөлөөлөхүйц бодитой байх шаардлагатай байна. Одоогоор мөрдөгдөж байгаа хуульд тусгагдсан олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарах ажиллагааг нь төдийлөн үр дүн муутай, харин шүүхийн шийдвэр гүйцэтгэгч байгаа төрийн албан хаагчийн амь нас эрүүл мэндэд хохирол учруулж болохуйц эрсдэлтэй нөхцөл байдлыг хүргэж байгаа ба шийдвэр гүйцэтгэгч нартай уулзаж ярилцах буруутай албан тушаалтныг нийтэд мэдээлсний дараа тухай этгээд заналхийлэх, утсаар сүрдүүлэх зэрэг асуудлууд үүсэж байсан ба энэ тухай Цагдаагийн байгууллагад хандахад эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл

[74] Монгол улсын иргэний хууль, , Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн баримт бичгийн эхэтгэл УБ., 2020

болохгүй байна гэж хүсэлтийг буцаадаг, зөрчлийн тухай хуулиар болохоор хариуцлага хүлээлгэх торгуулийн хэмжээ хэт бага байгаа үүргээс шалтгаалан шийдвэр гүйцэтгэгчийг эрсдэлд оруулж байна.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа этгээдэд хууль зүйн хариуцлагыг бодитой болгож хариуцлага хүлээлгэх.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хууль зүйн хариуцлагыг боловсронгуй болгох арга зам

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь Монгол улсын хэмжээнд хамгийн олон захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх баримт бичиг бүхий байгууллага, бүтэц чиг үүргийн хувьд Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн шийдвэр гүйцэтгэгч нарт захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэлийн баримт бичгийг хуваарилан шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж байгаа бөгөөд дээрх дүүргүүдийн шийдвэр гүйцэтгэгч нараас анкетын аргаар судалгаа авсан бөгөөд судалгаанд Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 14, Өмнөговь аймаг дахь Шүүхийн газрын 4 шийдвэр гүйцэтгэгч нараас нийт 18 шийдвэр гүйцэтгэгч нараас захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох асуудлаар судалгаа авахад:

Үүнд:

1. Захиргааны хэргийн гүйцэтгэх баримт бичиг, хуулийн шаардлага хангалтгүй ирдэг эсэх талаарх доорхоос сонгоно уу. гэсэн асуултад

- Гүйцэтгэх хуудас, захирамж зөрүүтэй ирдэг -9
- Хариуцагчийн нэр регистрийн дугаар зөрдөг-10,
- Шүүгчийн тамга, гарын үсэг зурагдсан гэсэн асуултад нэг хүн хариулаагүй байна.
- Үг үсгийн алдаатай -12 шийдвэр гүйцэтгэгч ирүүлдэг гэж хариулсан байна.

2. Захиргааны хэргийн шийдвэрийг биелүүлэхэд тулгамдаж буй асуудал гэсэн асуултад

- Захиргааны албан тушаалтан үл тоох, уулзахгүй байх-8 гэж хариулсан.
- Хуулийн хариуцлага байдаггүйгээс эсэргүүцдэг-14 гэж хариулсан
- Төсөвт байгууллагаас төлбөр гаргуулахад хүндрэлтэй-12 хариулсан
- Зарлан мэдэгдэл өгсөн боловч заасан хугацаанд ирдэггүй-12
- ШШГБ-н бүтцээс хамаараад шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд хүндрэлтэй- 8 хариулсан байна
- Төрийн эрх бүхий байгууллагад дээд шатны байгууллагаар дамжуулан мэдэгдэхэд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удааширдаг-18 хариулсан

3. Захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хууль зүйн хариуцлага аль болохыг сонгоно уу

- Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдийг баривчлах огт хариулаагүй
- Торгох, сахилгын хариуцлага тооцох арга хэмжээ авах-18 хуулийн хариуцлага мөн гэж хариулсан.

- Эрүүгийн хэрэг үүсгэх, гэмт хэрэгт тооцох- огт хариулаагүй.

1. Цаашид захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хууль зүйн хариуцлагыг сайжруулснаар ямар давуу талтай гэж бодож байна.

- Шүүхийн харьяанд байлгах-1 хариулсан
- Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдийг торгох арга хэмжээ оногдуулах огт хариулаагүй
- Шүүхийн шийдвэр биелүүлээгүй захиргааны албан тушаалтанд сахилгын арга хэмжээ оногдуулах-17 хүн хариултыг дугуйлсан.

5. Одоогоор мөрдөгдөж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээд хүлээлгэх хууль зүйн хариуцлага хангалттай байна уу?

-Хангалттай-2 хүн хариулсан

-Б. Хангалтгүй-16 хүн хариулсан

6. Хангалтгүй бол яагаад ?

7. Захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шүүхийн харьяанд шилжүүлэх гэж нийт судалгаанд оролцогчдын 66,6 хувь хариулсан .

8. Шүүхээс торгодог эсвэл сахилгын арга хэмжээ авах гэж 12 хувь нь хариулсан

9. Захиргаан шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд торгох арга хэмжээ гэж 11.1 хувь нь хариулсан

10. Эсвэл шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хариуцлага тооцдог болохыг маш тодорхой хугацаатай оногдуулдаг болох гэж 22,2 хувь нь хариулсан.

Дээрх судалгаанаас харахад шүүхээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ирүүлж буй гүйцэтгэх баримт бичиг нь тодорхой хэмжээний алдаатай ирдэг, мөн зарим тохиолдолд үг үсгийн алдаатай байдаг харагдаж байна.

Мөн Өмнөговь аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулж дуусгавар болсон гүйцэтгэх баримт бичгийн төлбөр авагчтай байсан хоёр иргэнтэй уулзаж ярилцлагын аргаар судалгаа авсан бөгөөд тухай төлбөр авагч иргэд нь тус газарт 2 дээш удаа өргөдөл гомдол гаргасан байсан учраас дээрх иргэд ярилцлагын аргаар судалгаа авлаа.

Ярилцлагын явцад гарсан санал, дүгнэлт

1. Шүүхийн шийдвэр хэт удаашралтай, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч ажлаа хийхгүй байсан. Гүйцэтгэх баримт бичигт бодитой ажил харагдахгүй байсан.
2. Хуульд заасан хариуцлагын тооцох механизм байдаггүй, хариуцлага тооцуулахаар дээд шатны албан тушаалтанд хандсан боловч хэтэрхий удаашралтай байсан.
3. Шүүхийн шийдвэр биелэгдэхгүй удааширсны улмаас гэр бүлээ тэжээн тэтгэхэд хүндрэлтэй байсан.

   /Дээрх судалгаан хамрагдсан иргэд хоёулаа өрх толгойлсон эмэгтэйчүүд байсан/

4. Шүүхийн шийдвэр биелүүлэхгүй байгаа этгээд, шийдвэр гүйцэтгэгч аль алинд нь шүүхийн шийдвэр биелүүлэхгүй байгаагийн улмаас хариуцлага хүлээлгэх боломжгүй төрийн хуулийг хийдүүлсэн.

Дээрх судалгаанаас дүгнэлт хийхэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд, эсвэл захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой өөрчлөлт оруулж, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа этгээдэд тодорхой хариуцлага хүлээлгэдэг, хариуцлага хүлээлгэх ажиллагаа нь түргэн шуурхай байхгүй бол тухайн этгээдийг өөхшүүлэх, хууль хэрэгжихгүй байх, төлбөр авагч иргэн, түүний гэр бүл хохирох эрсдэл үүсээд байна.

Нэгдүгээрт: Өнөөгийн байдлаас харахад шүүхийн шийдвэрт материаллаг хуулийн тодорхой зүйл, заалтыг хэрэглэсэн нь тодорхой харагдах боловч, яагаад энэ тохиолдолд хуулийн энэ зүйл, заалтыг хэрэглэсэн, хэрхэн зүйлчилсэн нь тодорхой харагдахгүй байгаа нь Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн шинжлэх ухааны байдал учир дутагдалтай байгааг харуулж байна. Иймээс шүүхийн шийдвэрийг цаашид гаргахдаа хуулийг тайлбарлах, хууль хэрэглээний асуудал, шүүхийн шийдвэрийн хууль зүйн үндэслэл, үр нөлөө, ач холбогдлын шинжлэх ухааны шинж чанарыг хөгжүүлж, тухайн шийдвэрийн үр нөлөөг талуудад сайтар танилцуулах хэрэгтэй.

Хоёрдугаарт: Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаа нь бусад шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаатай харьцуулахад арга журмын хувьд өөрийн өвөрмөц онцлог зүй тогтолтой.

Гуравдугаарт: Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шууд заасан, шийдвэрийг гүйцэтгэх арга журам, хүлээлгэх хариуцлагыг тодорхой тусгасан байх шаардлагатай. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн /энэ хуулийн 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдөр баталсан/ 107.5. Тогтоох хэсэгт "... Шийдвэр гүйцэтгэх арга, журам, хугацаа, шийдвэрийг давж заалдах журам, хугацаа заана..." гэжээ. Иймхүү заасан нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн хэрэгжилт нь түүний биелүүлэх арга, журмаас шууд хамааралтай байхаар байна. Хэдийгээр хуульд "Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх арга, журмыг гаргасан шийдвэртээ тодорхойлно." гэж заасан ч бодит байдал дээр энэ нь төдийлөн тодорхой бус байна. Жишээ нь захиргааны акт гаргахыг даалгах тухай, мөн захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох шаардлагыг хангасан шүүхийн шийдвэрт түүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаар арга журам агуулгыг тодорхой заахгүй, биелүүлээгүй тохиолдолд хэрхэн шийдвэрлэх, хэнд хандах зэрэг асуудлыг нарийвчлан заахгүй, хуульд тодорхойгүй байна.

Дөрөвдүгээрт: Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэх гэм буруутай нийтийн захиргааны байгууллага, албан тушаалтан ХБНГУ, Франц зэрэг орны хувьд шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхдээ

торгуулийн өндөр дүнгээр торгодог байх. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг тодорхой зааж тусгах, хариуцлага ийм нөхцөлд торгох талаар маш тодорхой тусгах.

Тавдугаарт: Энэхүү судалгааны ажлын өмнөх бүлгүүдэд дурдсан тоо баримт, тохиолдол зэргээс үзэхэд захиргааны хэргийн шүүхийн шийдвэрээс төрийн албатай холбоотой, ажлаас үндэслэлгүй халсан, ажилд эгүүлэн томилох, цалин олговор нөхөн гаргуулах зэрэг шийдвэрийн хэрэгжилт төдийлөн хангалттай бус байна.

Зургаадугаарт: Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг үр дүнтэй биелүүлэхэд байгууллага хоорондын хамтын ажиллагаа дутагдаж байна. Тухайлбал Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, захиргаан хэргийн шүүх, Цагдаагийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа дутмаг байна. ШШГТХуульд Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах хуулийн зохицуулалт байгаа юм. Гэтэл бодит байдал дээр захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахад төдийлөн хэрэгжихгүй байна. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа албадан гүйцэтгэх асуудал хугацааны хувьд удаашралтай, чирэгдэл ихтэй хэрэгжиж байна. Нөгөөтээгүүр шүүгч гаргасан захирамждаа шийдвэр гүйцэтгэх арга, журмаа заадаг хэдий ч түүнд оногдуулах хариуцлага байдаггүй улмаас шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд хүндрэл учирч байна. Үүнээс үзвэл захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа биелүүлэх эрх зүйн орчныг шинэчлэх хуулийн дагуу буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэдэг байх хэрэгтэй.

Долоодугаарт: Ажилгүй байсан хугацааны цалин хөлс, захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд холбогдолтой төлбөр гаргуулахад төрийн сангаас төлүүлж байгаа бөгөөд буруу шийдвэр тушаал гаргасан этгээд ямар нэгэн хариуцлага хүлээхгүй гарах Төрийг хохироох асуудал гарч байна.

Өнөөдрийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага өөрөө дангаараа захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүрэн хариуцан хэрэгжүүлж чадахгүй болох нь өмнө судалгаагаар тодорхой харагдаж байгаа бөгөөд Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлдэг дагнасан шийдвэр гүйцэтгэх албыг бий болгох эсвэл Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Хот, аймаг, сумын захиргааны шүүх нь хэрэгжүүлдэг болох шаардлагатай гэж дүгнэж байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж, эрх зүйн бусад акт

1. Монгол улсын үндсэн хууль 1992 он
2. Үндсэн хуулийн цэций тухай хууль 1993 он
3. захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2002 он
4. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2016 он

5. Захиргааны ерөнхий хууль 2016 он
6. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2002 он
7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2018 он
8. ХБНГУ-ын захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /орчуулга/
9. Латви улсын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /орчуулга/
10. "Шүүхийн шийдвэрийн тухай" Улсын дээд шүүхийн 2006 оны 4 дүгээр сарын 24-ны Дугаар 21 тоот тогтоол
11. "Шүүхийн шийдвэрийг боловсронгуй болгох аргачлалын тухай" Улсын дээд шүүхийн 2006 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн зөвлөмж
12. Захиргааны хэргийн шүүх /эмхэтгэл/УБ., 2003 он
13. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн цуврал №1 УБ., 2005 он
14. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн цуврал №2 УБ., 2005 он
15. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, төрийн мэдээллийн эмхэтгэл, №9
16. Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль .....
17. Улсын дээд шүүхийн 2003 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар тогтоол
18. Улсын дээд шүүхийн 2004 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 17 дугаар тогтоол
19. Улсын дээд шүүхийн 2010 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 17 дугаар тогтоол

Ном сурах бичиг

1. Д.Ганзориг "Захиргааны эрх зүйн тайлбар толь". УБ хот., 2002.
2. С.Жанцан "Захиргааны эрх зүй /ерөнхий анги/ УБ хот., 2004
3. П.Одгэрэл, "Захиргааны эрх зүй /ерөнхий анги/ УБ., 2004
4. А.Лхагваа "Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй" УБ., 2004
5. Б.Чимид. /ред/ Захиргааны хэргийн шүүх, УБ., 2004.
6. Б.Чимид. "Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл" /Хоёр дугаар дэвтэр/ УБ., 2004.
7. Монгол улсын үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлт. Эмхэтгэсэн, Д.Батаа, УБ., 1998

ЯЛЫН ТӨРӨЛ

TYPE OF PUNISHMENT



Э.Батбаяр
Дотоод хэргийн их сургуулийн
Сугалт, судалгааны 403 дугаар анги-
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн профессор,
хууль зүйн ухааны доктор /Ph.D/, дэд профессор, хурандаа

Хураангуй: Энэхүү өгүүлэлдээ Монгол Улсын Эрүүгийн хуулиудад заасан ялын төрөл, түүний ойлголт, зорилгын талаар товч дурдсан болно.

Түлхүүр үг: Ялын төрөл, үндсэн ял, сонгох ял, нэмэгдэл ял, цаазаар авах ял, цаазаар авах ял, хорих ял, торгох ял, нийтэд тустай ажил хийлгэх ял, зорчих эрхийг хязгаарлах ял, эрх хасах ял.

Аливаа шүүх “гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, гэмт хэргийн шинж, ял оногдуулахад харгалзах хүндрүүлэх болон хөнгөрүүлэх бүхий л нөхцөл байдлыг бүрэн тогтоосны үндсэн дээр гэм буруутай этгээдэд хуульд заасан, тохирсон ялыг сонгон оногдуулах” учиртай.[75] Иймд ялын төрөл онцгой нөлөө үзүүлнэ.

Ялын төрөл нь ялын үндсэн агуулга, мөн чанарыг илэрхийлэх гадаад талын нэгэн чухал элемент юм. Энэ нь “эрүүгийн эрх зүйд ялын агуулгыг гадаад хэлбэр талаас нь а/ ялын төрөл, б/ ялын хэлбэр, в/ ялын хэмжээ, г/ ялын дэглэм, д/ ялын /систем/ тогтолцоо гэсэн ойлголтын хүрээнд авч үздэг”-тэй холбоотой[76].

Ялын төрөл гэдэг бол ялын нэр, тоо, тодорхой агуулгыг илэрхийлсэн ойлголт юм. Тиймд ялын төрөл нь ялыг ердийн нэг байдлаар эрэмбэлэн зааж гаргасан жагсаалт биш шинжлэх ухааны үндэслэлтэй байдлаар хэд хэдэн ангиллыг өөр өөр бүтцийн хэлбэрээр тодорхойлон нэгтгэж Эрүүгийн хуульд томьёолон тусгаж буй хууль зүйн нарийн техник, логик шаардсан эрүүгийн эрх зүйн институци мөн.

[75] ХЗДХЯ. Монгол Улсын хууль. Эрүүгийн хууль. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/. Сургагч багш нарт зориулсан гарын авлага. УБ., 2017., 42 дахь тал.
[76] **Б.Ганболд.** Эрүүгийн эрх зүйд нэвтрэхүй. УБ., 2012., 598 дахь тал.

Эрүүгийн эрх зүйд ялын төрлүүд нь өөрийн үндсэн агуулга, мөн чанар, хуульд заасан үндэслэл, журам, хэрэгжилт, хугацаа, хэлбэр, арга, зорилго, үр нөлөө гэх олон талт байдлаараа өөр хоорондоо ялгаатайн зэрэгцээ биесээ нөхцөлдүүлсэн, уян хатан бөгөөд бүхэллэг, харилцан хамаарлыг үүсгэдэг онцлогтой.

Шигтгээ. Өмнөх хуулиудад ялын төрлийг хүндээс нь хөнгөн рүү нь байрлуулж байсан. Гэтэл 1993 онд Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр хөнгөнөөс хүнд рүү нь дэс дараалалд оруулсан юм. Энэ бол санамсаргүй байдалтай, эсхүл техникийн чанартай асуудал биш Монгол Улсын ялын тогтолцоо, ялын бодлогод зарчмын шинжтэй өөрчлөлт орсныг харуулна. Тухайлбал: 1987 оны шинэчлэн найруулсан хуультай харьцуулахад дан ганц хорих ялтай байсан санкц багасаж, сонгох буюу хорихоос өөр төрлийн ялтай санкц эрс нэмэгдсэн. Эрүүгийн хуульд заасан ялын төрлийн жагсаалтыг дур зоргоороо өөрчлөх, үзэмжээрээ хэрэглэх эрх шүүхэд ч байхгүй[77].

Ялын төрөл нь Эрүүгийн хууль тогтоомж дахь ялын тогтолцоог бүрдүүлж, уг хуулийн тусгай ангид заасан санкцийн үндэслэл болдог бөгөөд ялын хүнд, хөнгөн байдлыг тодорхойлж ял оногдуулах, ялын цээрлэлийг хэмнэлттэй зөв ашиглах, үр нөлөөг дээшлүүлэхэд онолын төдийгүй практикийн чухал ач холбогдолтой нэгэн гол ухагдахуун юм.

Тухайлбал, 2002 оны Эрүүгийн хуульд “торгох, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, эд хөрөнгө хураах, албадан ажил хийлгэх, баривчлах, хорих, цаазаар авах” гэсэн ялын 7 төрөл байсан бол 2015 оны Эрүүгийн хуулиар “цаазаар авах, баривчлах” ялыг халж, эд хөрөнгө хураах ялыг эрүүгийн хариуцлагын ялын бус арга хэмжээний төрөл болгон өөрчилж, зорчих эрхийг хязгаарлах шинэ ялын төрлийг бий болгожээ.

Дэлхий дахинаа улс орнуудын Эрүүгийн хууль тогтоомж судлалын хүрээнд ялын тогтолцоо нь бүхэлдээ торгох, хорих л гэсэн үндсэн 2 ялын төрөлд хуваагдаж буй хандлага түгээмэл байна. Энэ нь үндсэн ялаас илүүтэй нэмэгдэл ялуудыг олноор тогтоож, эрүүгийн ялын бус бусад арга хэмжээг түлхүү хэрэглэх, хорихоос өөр төрлийн ялын тогтолцоог бүрдүүлэхтэй холбоотой нь ажиглагдана.

Зарим үндэстний хэл, соёл, түүхэн уламжлал, шашин зэргээс үүдэж тухайлбал, Мусульманы эрүүгийн эрх зүйд цусан өшөө авах, бие махбодын хатуу шийтгэл ял болж хэрэгжих /нүдийг нүдээр, амийг амиар солих гэх мэт/ явдал ч байна. Энэ нь тухайн улс орны онцлог, нийгэм, улс төр, эдийн засаг, ялын бодлогоос хамаарч янз бүр байх, онцгой төрлийн зарим ялыг хэрэглэх тохиолдлууд ч байгаа юм.

[77] **С.Нарангэрэл.** Дурдсан бүтээл. УБ., 1996., 281 дэх тал.

Тухайлбал: Проф. **Г.Совд** судлан тэмдэглэснээр, Англи улсад хорих, тэнсэн хойшлуулах, торгох, даалтад өгөх, тусгай хязгаарлалт тогтоох, хөлсгүйгээр албадан хөдөлмөрлүүлэх гэсэн ялын төрлүүдтэй, АНУ-д муж бүр өөрийн Эрүүгийн хуулиар тогтоосон үндсэн ба нэмэгдэл ялтай, **жишээ нь**: Калифорон муж улсын Эрүүгийн хуулийн 645-р зүйлд 10 нас хүрээгүй эмэгтэйн бэлгийн харилцааг доромжилсон хэрэг үйлдсэн этгээдэд хөнгөлөх нэмэгдэл ял оногдуулна. Энэ ялыг шоронгийн нөхцөлд бус тусгай эмнэлэгт, мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх ёстой. 50 жилийн зэрэг урт хугацааны болон бүх насаар нь хорих, бага насны хүүхдийг цаазалж болох хуулийн заалт ч АНУ-д байдаг байна[78].

Олон Улсын ял оногдуулах зарчимд тодорхой санкцийг хуульчлан, оногдуулах явдлаас аль болох зайлсхийн, алтернатив нөхцөлийг тодорхой боломжит шийдлээр зохицуулах, хүнд биш хэргийн хувьд хянан харгалзах, торгох ялыг өргөн хэрэглэх, баривчлах болон хорих ялын доод хугацааг багаар тооцох, торгуулийг сүүлийн 6 сар хүртэлх сарын дундаж орлогоор тооцох, мөнгөн дүнгээр илэрхийлэх, хорихоос өөр төрлийн ялыг өргөжүүлэн, ял солих процедурыг оновчтой хэрэглэх практик түгээмэл хэрэглэгдэж байна[79].

НҮБ болон харьцуулсан эрүүгийн эрх зүй судлалын Олон Улсын хүрээлэнгийн дэмжлэгтэй **В.Коннор**, **С.Раушь** нар редакторлаж Олон Улсын шинжээч, судлаач, эрдэмтдийн оролцоотой 2007 онд гарсан Дэлхий дахины Эрүүгийн Загвар хуульд ялын бодлогын хувьд аль нэг системийн онцлогийг тусгаагүй, харин дундын буюу жишгийн зарчим, хандлага түлхүү тусгагдсан ба,

- ялын **үндсэн төрөл**д бүх насаар нь хорих, хугацаатай хорих, торгох;
- **сонгох ял**д шүүхийн тогтоол гүйцэтгэхийг хойшлуулах, нийгмийн үйлчилгээнд хамруулах, гэрийн хяналтад байлгах;
- **нэмэлт ял**д торгууль, нөхөн төлбөр, эрх хасах, хянан харгалзах, үйл ажиллагаа албан тушаал эрхлэхийг хориглох, иргэний харьяаллаас хасах г.м /38-р зүйл/ гэсэн 3 ангиллаар авч үзжээ[80].

Монгол Улсын хувьд ялын төрлийг Эрүүгийн хууль тогтоомжийн хүрээнд 2002 оноос хойш зарчмын шинэ өөрчлөлт, хандлагаар авч үзэхийг оролдсон хэд хэдэн хувилбарт Эрүүгийн хуулийн төсөл боловсрогдож, өргөн мэдүүлэгдэж байсан юм.

[78] Франц улсад гутаах ялд уг нутгаас зайлуулах, иргэний зарим эрхийг хасах, цагдаагийн ялд 2 сар хүртэл хорих зэргийг ойлгодог. **Г.Совд.** Эрүүгийн эрх зүйн оршил. Прокурорын ном. УБ., 2002., 292-294 дэх тал.

[79] Үз. **Б.Алтангэрэл.** "Эрүүгийн ялын гүйцэтгэлийн үр нөлөөнд хийсэн дүн шинжилгээ" судалгааны ажлын тайлан. УБ., 2018.

[80] **Д.Баярсайхан**. Дурдсан өгүүлэл. Шударга ёс. УБ., 2010., №4., 67 дахь тал.

Тухайлбал, **2009** оны **Монгол Улсын Эрүүгийн** /төрөлжсөн/ **хуулийн** төсөлд, 43-р зүйл. Ялын ухагдахуун ба зорилго[81]. **Ял** нь шүүхийн шийтгэх тогтоолоор ногдуулах төрийн албадлагын арга хэмжээ болно. Ялыг гэмт хэрэг үйлдэж, гэм буруутайд тооцогдсон этгээдэд хэрэглэх ба энэхүү төрөлжсөн хуулиар тухайн этгээдийн эрх ба эрх чөлөөг хасах буюу хязгаарлана. Ялыг нийгмийн шударга ёсыг сэргээн тогтоох, түүнчлэн ялтныг засан хүмүүжүүлэх ба шинэ гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэнэ. 44-р зүйл. Ялын төрөл, үүнд:

- торгууль;
- тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах;
- тусгай, цэргийн буюу хүндэт цол, зэрэг дэв ба төрийн шагналыг хасах;
- албадан ажил хийлгэх;
- засан хүмүүжүүлэх ажил хийлгэх;
- цэргийн алба хаахыг хязгаарлах;
- эрх чөлөөг хязгаарлах;
- цэргийн сахилгажуулах ангид явуулах;
- тодорхой хугацаагаар хорих;
- бүх насаар нь хорих;
- цаазаар авах гэсэн 11 төрөлтэй байхаар тусгасан байна[82]. Харин 2013 оны **Гэмт хэргийн тухай** хуулийн төсөлд, **5.6 дугаар зүйлд** "торгох; нийтэд тустай ажил хийлгэх; эрх чөлөө хязгаарлах; хорих; эрх хасах, хязгаарлах, хөрөнгө, орлогыг хураах" гэсэн ялын 6 бие даасан төрөл байхаар төслийг боловсруулж байв[83].

Энэ боловсруулалтын явцад **2014** онд дээрх Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд ялын төрлийг 5 байхаар тусгаж, "хөрөнгө, орлогыг хураах"-ыг ял бус, албадлагын арга хэмжээ байхаар өөрчилсөн байдаг /энэ хуулийн төсөл 2014.04.30-нд УИХ-д өргөн баригдаж байсан/[84].

Түүнчлэн 2015 онд **Эрүүгийн хуулийн** төслийг дахин боловсруулж, **5.2 дугаар зүйлд** "торгох; нийтэд тустай ажил хийлгэх; **гэрийн хорионд байлгах**; хорих; эрх хасах" гэсэн ялын 5 бие даасан төрөл байхаар төслийг боловсруулжээ[85].

Дээрх төслүүдийг боловсруулах үед манай улсад 2002 оны Эрүүгийн хууль үйлчилж байсан бөгөөд тус хуулийн 46 дугаар зүйлд "торгох, тодорхой албан

---

[81] Уг хуулийн төслийг УИХ-ын гишүүн **Ш.Сайхансамбуу** санаачлан, академич **С.Нарангэрэл** боловсруулсан гэдэг. Үз. **ХЗҮХ.** Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь. УБ., 2016., 15 дахь тал.

[82] МУ-ын Эрүүгийн /төрөлжсөн/ хууль /төсөл/. УБ., 2009., 13 дахь тал.

[83] ХЗЯ. Гэмт хэргийн тухай хуулийн төсөл. УБ., 2013., 38 дахь тал.

[84] Хууль зүйн яам /**сайд** Х.Тэмүүжин/. Гэмт хэргийн тухай хуулийн төсөл /зөрчлийн тухай хуулийн төсөл/. УБ., 2014., 33, 42 дахь тал.

[85] ХЗЯ /**сайд** Д.Дорлигжав/. Эрүүгийн хуулийн төсөл. УБ., 2015., 22 дахь тал.

тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, эд хөрөнгө хураах, албадан ажил хийлгэх, баривчлах, хорих, цаазаар авах" гэсэн хөнгөнөөс нь хүнд рүү нь жагсаан заасан ялын 7 төрөлтэй байсан юм [86].

Анхлан 2015 онд батлагдаж,[87] 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Монгол Улсын одоогийн дагаж мөрдөж байгаа Эрүүгийн хуулийн дагуу авч үзвэл: **5.2 дугаар зүйл. Ялын төрөл.** 1. Гэмт хэрэг үйлдсэн хүнд доор дурдсан ял оногдуулна:

1.1. торгох ял;

1.2. нийтэд тустай ажил хийлгэх ял;

1.3. зорчих эрхийг хязгаарлах ял;

1.4. хорих ял;

1.5. эрх хасах ял. Торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих ялыг үндсэн, эрх хасах ялыг нэмэгдэл ялаар хэрэглэнэ. Энэ хуулийн тусгай ангид гэмт хэрэгт оногдуулах үндсэн ялын төрөл, хэмжээг заана[88].

Бид ялын төрлийн талаар болон ял оногдуулах ойлголтын хувьд "гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хэт хөнгөн, эсхүл хэтэрхий хүнд ял оногдуулах нь ял үр дүнтэй хэрэгсэл байхад сөрөг нөлөөтэй. Оногдуулсан хорих ял хэтэрхий хүнд байвал ялтан шударга бус байдалд эгдүүцэх, гомдох байдалтай болно. Харин ял хэт хөнгөн байвал ялтанд цээрлүүлэх нөлөөлөл үзүүлэхгүй, дахин давтан гэмт хэрэг үйлдэх санаархлыг улам лавшруулна" гэж үзэж ирсэн юм[89].

Өдгөө цагт хүнд, хөнгөн ялын төрөл, хэлбэрийн тухайд бус "гэмт хэргийн шинж чанар нь нийгмээс нуугдмал, бугшсан, далд эдийн засаг нүүрлэсэн, улс төрийн нөлөө бүхий шүүх, эрх зүйн тогтолцоотой, хууль биш хүн засагладаг нь илэрхий болсон" үед хүний эрх, шударга ба тэгш байдал, хууль ёсны зарчим нь хэзээ мөдгүй нуран унаж, хар нүхний хонгил руу очиход ял нь хазаар болж тогтоон барих чадамжтай байх нь чухал байна.

Шигтгээ. Ялын олон төрөл байснаар нийгэмд гарч буй гэмт хэрэг буурна гэж шууд ойлгож болохгүй. Харин ч хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн, дарангуйллын байдал нийгэмд хүчтэй болдог хэмээн зарим эрдэмтэд үздэг[90].

---

[86] Энэ хууль 2002 оны Төрийн мэдээлэл эмхтгэлийн 5 дугаарт нийтлэгдсэн.

[87] Үз. 2015.12.03. Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл., 2016.02.19., №07/916/.

[88] Үз. Төрийн мэдээлэл., 2016.09.06., №33/942/., 1814 дэх тал. Монгол Улсын хууль /**сайд** С.Бямбацогт/. "Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай". 2016.08.30.

[89] **С.Жанцан.** Дурдсан бүтээл. Боть-II., УБ., 2014., 11., 146 дахь тал.

[90] **Б.Батбаяр.** Ял шийтгэлийн өнөө үеийн чиглэлийн зарим хандлага. Монголын төр, эрх зүй /сэтгүүл/. УБ., 1999., №1., 49 дэх тал.

ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ АЛБАДАН СУРГАЛТ: СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ САЙЖРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

FORCED LEARNING TO INFLUENCE BEHAVIOR: NEEDS AND REQUIREMENTS TO IMPROVE THE CURRICULUM



О.Хишигмөнх
Отгонтэнгэр их сургуулийн
Хууль зүйн сургуулийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн багш,
хуульч, докторант



С.Эрдэнэболор
Отгонтэнгэр их сургуулийн
Хууль зүйн сургуулийн захирал, доктор

Товч утга: Албадан сургалт нь хууль зүйн хариуцлагын нэг төрөл болохын зэрэгцээ сургалт болох талаасаа хөтөлбөрийн дагуу явагдана. Монгол Улсад практикт албадан сургалт нь давамгайлж байна. Ялангуяа албадан сургалтын төрлүүдээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд чиглэсэн албадан сургалтын эрх зүйн орчин зохих түвшинд бүрдсэн хэдий ч сургалтын үр нөлөө хангалтгүй байгааг холбогдох байгууллагуудын хийсэн судалгаанаас харж болохоор байна. Иймд зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийг сайжруулах, үр нөлөөг нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага байна. Албадан сургалт нь гэмт хэрэг, зөрчил гарсны дараа зан үйлийг засах, өөрчлөх оролдлого хийж байгаа нь урьдчилан сэргийлэх талаасаа учир дутагдалтай байна. Зан үйлд нөлөөлөх сургалтыг гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд явуулж буй талаас Нээлттэй нийгэм

форум[91], Хүчирхийллийн эсрэг үндэсний төв[92], судалгаа хийж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага[93] зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөг тус тус судалсан байна. Энэ нь баривчлах шийтгэл хүлээсэн этгээдийн ихэнх хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчил эзэлж байгаатай холбоотой. Энэ удаагийн цуврал[94] өгүүллээрээ зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөртэй холбогдох асуудлыг хөндөн авч үзнэ.

Abstract: Compulsory education, as one of the types of legal responsibility, is carried out in accordance with the program in terms of training. Compulsory education is dominated by practice in Mongolia. In particular, studies conducted by the relevant authorities have shown that, although the legal framework for compulsory education is adequate for those who have committed domestic violence, the effectiveness of education is not sufficient. Thus, there is a need and a need to increase the impact of the mandatory training program on behavior. Mandatory training attempts to correct or change behavior after a crime or offense are flawed from the point of view of prevention. At the Open Societies Forum, the National Anti-Violence Center, and the Court conducted a study on the effects of forced behavior education on perpetrators of domestic violence. This means that a significant part of the persons subject to arrest are violations of the law on domestic violence. In this series of articles, we look at the issue of compulsory educational programs that influence behavior.

Түлхүүр үгс: Зөрчил, Гэмт хэрэг, Хариуцлага, Албадлага, Үр дүн, Зан үйл засах, Зан үйлийг өөрчлөх

Keywords: Conflict, crime, responsibility, coercion, results, behavior correction, Change behavior

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын тухай ойлголт, эрх зүйн зохицуулалт

“Зан үйлд нөлөөлөх”, “зан үйлээ засах” гэх хоёр ойлголтуудыг тодруулбал: “Зан” (англи-character, орос-характер) сэтгэлийн төлөвийн

[91] Нээлттэй нийгэм форумын дэмжлэгтэй 2020 онд Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн Дархан-Уул аймгийн салбар Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилт” сэдвээр мониторингийн тайлан хийсэн.

[92] Хүчирхийллийн эсрэг Үндэсний төвөөс 2019 онд “Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилт” мониторингийн тайланг гаргасан, энэхүү тайланг бичсэн багийн гишүүнээр бид ажилласан.

[93] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Захиргаа удирдлагын газрын захиалгаар Дотоод хэргийн Их сургуулийн эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төв 2020 онд “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөнд хийсэн шинжилгээ” судалгааны тайланг бичсэн.

[94] Сэдэвтэй холбоотой, харилцан хамааралтай өгүүлэл, илтгэлүүдийг цувралаар Хууль дээдлэх ёс, Хүний эрх, Гэмт явдалтай тэмцэх асуудал, Отгонтэнгэр зэрэг эрдэм шинжилгээ, судалгааны сэтгүүлүүдэд хэвлүүлсэн болно.

харьцангуй тогтвортой, төрмөл шинж, хүн амьтны аашлах төлөв байдал[95]-ыг илэрхийлдэг бол “Зан үйл” (англи-behavior, орос-поведение) сэтгэлийн шинжийн хэлбэр, амьд амьтны гадаад орчин ба өөр хоорондоо харилцан үйлчлэлцэх явцад илрэх харш үйлдэл буюу үйл, үйлдлийн багц[96] юм. Орчин үед өндөр хөгжсөн, хөгжиж буй орнууд зан үйлд нөлөөлөх ухааныг төрийн бодлогод хэрэглэж хүний зан үйлд нөлөөлөх замаар ухамсар, үйлдэлд өөрчлөлт хийх судалгаа, туршлагыг амжилттай явуулж байна. Зан үйл хувирч болдог, зан үйл нь ухаан бодолд нөлөөлдөг. Оюун ухааныг өөрчилж чадвал бие махбодыг удирдан өөрчилж болдог, оюун бодол өөрчлөгдөхгүй бол зан үйл өөрчлөгдөхгүй, зан үйл өөрчлөгдөхгүй бол үйлдэл өөрчлөгдөхгүй бөгөөд харилцан уялдаатай. Хүний бодол үйлдлээ өөрчилдөг бөгөөд орон зай, цаг хугацаа, гүйцэтгүүлж буй ажилбар, өгч буй сургалтын агуулга оролцогчид эерэг болон сөрөг нөлөө үзүүлж болохыг сэтгэл зүйч судлаачид тогтоосон[97] нь ялангуяа насанд хүрэгчдийн хувьд өөрчлөгдөх боломж бараг байхгүй гэх хэвшмэл ойлголтыг өөрчилсөн төдийгүй бүхий л шатанд зан үйлд нөлөөлөх ухааныг хэрэглэх боломжтой байна. Албадан сургалтыг баривчлах байранд эсхүл хорих газар тусгаарлан зохион байгуулж байгаа нь сургалтаар дамжуулж оролцогчдод нөлөөлөх боломжийг нэмэгдүүлэх юм. Учир нь сургалтын орчин, нөхцөл оролцогчийн сэтгэл зүй, бие махбодод нөлөө үзүүлдгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон сэтгэл зүйч, судлаачид нотолдог. Өнгөрсөн хугацаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас албадан сургалтын танхим хэрэглэгдэхүүн, боловсон хүчинд анхаарч буй төдийгүй төрийн бус байгууллагуудтай хамтран бясалгалын сургалтыг хорих ял эдэлж буй ялтнуудыг сайн дураар нь хамруулан зохион байгуулж үр дүнг нь дүгнэхэд хамрагдсан ялтнууд сэтгэл ханамжтай, өөртөө эерэг зан үйл төлөвшсөн, хэвшүүлэн үйлдлээ хянах чадвартай болсон[98] гэж дүгнэсэн байна. Энэ нь сургалтын явцад эерэг хандлага төлөвших, зан үйл өөрчлөгдөх боломжтой гэдгийг илтгэж буй юм. Иймд сургалтыг үр дүнтэй болгохын тулд сургалтын хөтөлбөрөөс эхлэн сайжруулж хэрэгжилтэд анхаарах нь хөтөлбөрийг үр дүнтэй болгох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, давтан үйлдэхгүй байхад нөлөөлөх юм. Хөтөлбөрийн үр дүн нь хуулийн зорилго биелэх, гэмт хэрэг,

[95] С.Нарангэрэл “Эрхзүйн эх тайлбар толь” УБ 2011 он 3 дахь хэвлэл, х.203, Мөн Я”Цэвэл “Монгол хэлний тайлбар толь” УБ.,2013 х.265 зан нь хүн амьтны аашлах байдал төлөв гэж тайлбарласан.

[96] С.Нарангэрэл “Эрх зүйн эх тайлбар толь” УБ 2011 он 3 дахь хэвлэл х.203

[97] Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Зан үйлд нөлөөлөх ухааныг төрийн бодлогод ашиглах нь” сэдэвт Сингапур Үндэсний Их Сургуулийн Төрийн бодлогын сургуулийн профессор Доктор Рубинг Ньг хийсэн сургалтын хэсгээс хэсэгчилэн авав.” https://www.youtube.com/watch?v=7tM7DFaOr7s

[98] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага 2016 оноос эхлэн харьяа 421, 439, 433 дүгээр хорих ангиудад уг сургалтыг зохион байгуулсан.

зөрчлийн хохирогчийг дахин хохирохоос хамгаалсан байх[99] шаардлагыг хангахад чухал нөлөөтэй.

Албадан сургалт нь үүрэг хүлээлгэх албадлагын нэг төрөл болохын зэрэгцээ сургалт болохынхоо хувьд хөтөлбөрийн дагуу явагдана. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 04 сарын 04-ны өдрийн А/73-р тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан хөтөлбөрийн дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын харьяа нэгжүүд хариуцан зохион байгуулах[100]аар заасан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/103 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Зан үйлд нөлөөлөх сургалт зохион байгуулах журам, сургалтын төлөвлөгөө”-ний дагуу хорих ангийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нараар сургалт явуулж байна. Албадан сургалт явуулах талаар Зөрчлийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Эрүүгийн хууль, Хүүхэд хамгаллын тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиудад тус тус заасан.

Зөрчлийн хуулийн тусгай ангид өөрөөр заагаагүй бол шүүх баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэн хүнд албадан сургалтад хамруулах албадлагын арга хэмжээг хэрэглэж болно. Албадан сургалт нь арваас тавин цагийн хугацаатай байна[101]. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд баривчлах байр нь баривчлагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулна[102]. Баривчлах байрны дотоод журамд зааснаар баривчлах төв байр нь сургалтын танхимтай байх бөгөөд шүүхийн шийтгэвэрт заасан хугацаагаар албадан сургалтад хамруулна, сургалт нь баривчлагдсан хүний зан үйлд нөлөөлөх, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх бөгөөд хөтөлбөрийн дагуу явагдана, сургалтыг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болохоор хуульчилсан.

Зан үйлд нөлөөлөх сургалт нь сэтгэл зүй, эрх зүйн болон бясалгалын гэсэн төрөлтэй[103] байна. Сэтгэл зүйн сургалт:

- Архинд донтолт болон түүний хор уршгийн талаарх,
- Хүчирхийлэл үйлдэх зан үйлийг хэрхэн зохицуулах
- Уур бухимдлыг хэрхэн зохицуулах, стрессийг даван туулах

[99] Нэгдсэн Үндэстэний байгууллагын жишиг хуульд хариуцлагын оновчтой тогтолцоо нь зөрчил дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх, зөрчил үйлдэгчид буруутай зан үйлээ засах боломж олгох, хариуцлага гарцаагүй байх, хохирогчийг дахин халдлагад өртөхөөс хамгаалах зохицуулалтыг агуулсан байхыг зөвлөдөг.

[100] Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын “хөтөлбөр батлах тухай” 2017.04.04 А/73 тушаалын нэгдүгээр хавсралт “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр” 4.1

[101] Зөрчлийн тухай хууль (2017) 4.5 дугаар зүйлийн 4.5.1,2,3,4

[102] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2017) 147 дугаар зүйлийн 147.5

[103] Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын “хөтөлбөр батлах тухай” 2017.04.04 А/73 тушаалын нэгдүгээр хавсралт “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр” 8.1

- Харилцах ур чадвараа дээшлүүлэх
- Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх
- Өөрийн үнэлэмжийг дээшлүүлэх
- Хүчирхийллээс үүдэх хүүхдийн сэтгэл зүйн асуудал сөрөг үр дагавар
- Гэр бүлийн сэтгэл зүйг төлөвшүүлэх чиглэлээр байна.

Эрх зүйн сургалтыг Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор явуулах бол бясалгалын сургалтыг эрх бүхий байгууллагын даргын тушаалаар баталсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулж явуулна гэж заасан. Тухайн оролцогчийн зан үйлийн өөрчлөлтөд тохирсон сэтгэл зүйн сургалтыг эрх зүйн сургалттай хослуулан явуулна. Оролцогчийн хувийн байдал, үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн шинжийг харгалзан тэдний сэтгэл зүйн онцлогт тохирсон хэд хэдэн сургалтыг хослуулан явуулна. Сургалтыг хослуулан явуулахдаа хамтран ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлж болох зохицуулалтай.

Эрүүгийн хуульд үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээнд зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах[104] гэж заасан. Зан үйлээ засах сургалт гэдэг нь сургалтын оролцогч төвтэй, зан зүйлд нөлөөлөх гэдэг нь сургалтыг хэрэгжүүлэгч байгууллага буюу багш төвтэй сургалт байхаар харагдаж байна. Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж байгаа өсвөр насны хүнд ерөнхий, мэргэжлийн боловсрол, хөдөлмөрлөх, амьдрах ухааны дадал олгох сургалт зохион байгуулна. Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг гэм бурууг нь ухамсарлуулах, хохирлыг нөхөн төлүүлэх, хөдөлмөрлөх, амьдрах зөв арга барилд сургах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авах үүргийг хүлээлгэнэ[105] гэж эрүүгийн хуульд заасан.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг шүүхийн шийдвэрээр ял ногдуулахаас өмнө, ял ногдуулсан хоригдох хугацаандаа хамрагдах гэж ангилж үзэж болохоор байна. Зөрчлийн тухай хуульд албадан сургалттай холбоотой харилцааг хуулиар зохицуулна[106] гэж заасан хэдий ч эрүүгийн болон зөрчлийн тухай хуулиар албадан сургалт явуулна гэж заагаагүй үйлдлүүд дээр албадан сургалт явуулахаар зарим хуульд тусгасан байна. Тухайлбал Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд гэр бүлийн харилцаанд хүйсийн шинжээр шууд ялгаварлан гадуурхсан этгээдийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу зохион байгуулдаг зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулж

[104] Эрүүгийн хууль (2015) 7 дугаар зүйлийн 7.3.2.2
[105] Эрүүгийн хууль (2015) 8 дугаар зүйлийн 8.7.2
[106] Зөрчлийн тухай хууль (2017) 4дүгээр зүйлийн 4.5.4

болно[107] гэж заасан. Гэтэл зөрчлийн тухай хуульд шүүхийн шийдвэрийн дагуу хариуцлага хүлээлгэнэ гэжээ. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зөрчлийн бүрэлдэхүүнд жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн заалттай нийцэхгүй байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18.2.6-т шүүхийн шийдвэрээр албадан сургалтыг Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага нь хүүхэд хамгааллын чиглэлээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран зохион байгуулна[108] гэж заасан байна. Энэхүү сургалтын хөтөлбөрийг батлах байгууллага төсөв санхүүг шийдэх, хэрэгжүүлэх, хяналт тавих зэрэг асуудал нь тодорхойгүй байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан сургалтын хөтөлбөрийн агуулгаар явуулж болох эсэх, сургалтаар хүлээгдэх үр дүн нь ижил эсэхийг тодорхой болгох шаардлагатай байна.

Зөрчлийн тухай хуулиар олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, танхайрах, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, жагсаал цуглаан зохион байгуулах журам зөрчих, гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих, хүүхдийн эрхийг зөрчих, бэлгийн дарамт учруулах, генетик нөөцийн тухай хууль зөрчих[109], хулгайлах, хөрөнгө завших, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчлүүдэд 7-30 хоног баривчлах шийтгэл хүлээлгэхээр тус тус заасан байна. Зөрчил үйлдсэн үйлдсэн хүнийг хуульд заасан хугацаагаар тусгай зориулалтын байранд саатуулахыг баривчлах шийтгэл гэнэ. Баривчлах шийтгэлийг шүүгч ногдуулах зохицуулалтай. Энэ нь Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах, хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй[110] гэсэн суурь зохицуулалтаас улбаатай төдийгүй хуулиар хориглосон үйлдэлд хариуцлага хүлээлгэх нь гарцаагүй байх зарчимтай салшгүй холбоотой юм.

Албадан сургалтын хөтөлбөр тулгамдсан зарим асуудал

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрт Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэр бүлийн тухай хууль болон сэтгэл зүй, зан үйлийн өөрчлөлтийн хосолмол онолын загваруудыг тус тус удирдлага болгоно гэж заасан. Зан үйл нөлөөлөх сургалт хуульд заасан зөвхөн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлөөр хязгаарлагдахгүй, танхайрах, олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, хүүхдийн тэтгэлгээ төлөхгүй байх, хулгайлах, хөрөнгө

[107] Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011) 26 дугаар зүйлийн 26.3
[108] Хүүхэд хамгааллын тухай хууль (2016) 18дугаар зүйлийн 18.2.6
[109] Зөрчлийн тухай хууль (2017) 7.18 дугаар зүйлийн 7.18.1.2 энэ заалтыг 2021.12.30ны өдөр нэмсэн
[110] Монгол Улсын Үндсэн хууль (1992)19 дүгээр зүйлийн 19.1,3

завших, хүйсийн шинжтэй ялгаварлан гадуурхах гэх мэт үйлдэлд явуулахаар байгаа нь сургалтад удирдлага болгохоор заасан нь тус хуулиуд бүх сургалтын төрөл дээр үндэслэл, удирдлага болох эсэхийг эргэн харах нь зүйтэй. Хөтөлбөрийг баталсан тушаалын хуулийн үндэслэл нь зөвхөн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг үндэслээгүй байх бөгөөд бусад төрлийн зөрчил, гэмт хэрэгт хамаарах эсэхийг хөтөлбөрийн үндэслэл хязгаарлаж байна. Мөн ерөнхий байдлаар сэтгэл зүй, зан үйлийн өөрчлөлтийн хосолмол онолын загваруудыг удирдлага болгохоор заасан нь сайшаалтай хэдий ч ямар зан үйлд нөлөөлөх онолуудыг хэрэглэх нь талаар тодорхой дурдаагүй ерөнхий байна.

Хөтөлбөрийн 2 дугаар зүйлийн 2.1-т Захиргааны журмаар баривчлах шийтгэл хүлээсэн этгээдэд албадан сургалт явуулах, эрхийг хязгаарлах орчинд сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэсэн сургалтыг зохион байгуулж, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх нь нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцэх болно гэж заажээ. Энэхүү хөтөлбөр нь зөрчил үйлдэж баривчлах шийтгэл хүлээсэн этгээдээс гадна гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хүртэл албадан сургалтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хорих ангид нь зохион байгуулж байгаа. Иймд нийтлэг үндэслэлийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлохдоо гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулах гэж өөрчлөх нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд нийцэхээр байна.

Сургалтын алсын хараг хөтөлбөрт зөвхөн гэр бүлийн хүчирхийллийн үйлдэлтэй холбон тодорхойлж дэмжлэг үзүүлэхээр заасан нь бусад үйлдлүүдийг орхигдуулсан байна. Албадан сургалтад хамрагдуулахаар заасан үйлдэл бүр зан үйлийн өөр өөр шинжийг өөртөө агуулж байгаа нь албадан сургалт үйлдсэн этгээдийн зан үйлийг засах, өөрчлөхөд нөлөөгөө үзүүлэхгүй байх эрсдэлийг бий болгож байна. Тухайлбал хөрөнгө завших, хулгайлах зөрчил гаргасан хүн шунахай төрлийн зан үйлтэй, мансуурдаг, бэлгийн дарамт учруулдаг, олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явдаг, хүйсийн шинжээр ялгаварлан гадуурхсан хүн үйлдлийн шинжээсээ хамаарч өөр өөр төрлийн нийгэмд сөрөг зан үйлтэй. Тиймээс хөтөлбөр нь өөр өөр байх, үйлдэлдээ хандсан сэдлийн ялгаатай байдлыг нь харгалзан үзэх шаардлагатай гэдгийг харуулж байна.

Хөтөлбөрт сургалтад хамрагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх замаар гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх нь алсын хараа байхаар заасан. Сургалтад хамрагдсан хүмүүс давтан гэмт хэрэг, зөрчил гаргахгүй байх, тухайн төрлийн гэмт хэрэг, зөрчил буурах, үйлдлээ дахин давтахгүй байснаар сургалтын үр дүн тодорхойлогдоно. Албадан сургалтад хамрагдсан хүмүүсийн сургалтад өгсөн үнэлгээ, ар гэрийнхний сургалтад суугаад өөрчлөгдсөн байдлыг үнэлсэн байдал, тухайн зөрчлийг дахин үйлдсэн тоон статистикаас сургалтын агуулга, үр нөлөөг сайжруулах хэрэгцээтэй гэж үзсэн[111] нь одоогийн хөтөлбөр, агуулга

[111] https://forum.mn/uploads/site/1126/res_mat/2020/OSF_monitoring_21.pdf Cartes Mongolia, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгуллагын захиалгаар хийсэн “Зан үйлд

тохиромжтой, үр дүндээ хүрч байгаа эсэхийг нягтлан сайжруулах шаардлагатай гэдгийг илтгэж байна.

Сургалтын хэлбэр нь ганцаарчилсан, бүлгийн, хосолсон байхаар зохицуулсан байна. Хэлбэр тус бүрд хөтөлбөр байх эсэх нь тодорхойгүй, хэлбэр бүрд тусгайлсан хөтөлбөр байхгүй байгаа нь ямар тохиолдолд ганцаарчилсан сургалт байх, бүлгээр байх сургалтын зааг ялгаа байхгүй байна. Зөвхөн нэг л сургалтын төрөл дээр өөр сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж байна[112]. Иймд сургалт хөтөлбөрийн дагуу төлөвлөгөөтэй байх, төлөвлөгөөг нэг ижил загвараар хийх шаардлагатай байна.

Зан үйлд нөлөөлөх сургалт нь сэтгэл зүйн сургалт нь архинд донтолт болон хор уршгийн талаар, хүчирхийлэл үйлдэх зан үйлийг хэрхэн зохицуулах, уур бухимдлыг хэрхэн зохицуулах, стрессийг даван туулах, харилцах ур чадвараа дээшлүүлэх, бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх, өөрийн үнэлэмжийг дээшлүүлэх, хүчирхийллээс үүдэх хүүхдийн сэтгэл зүйн асуудал сөрөг үр дагавар, гэр бүлийн сэтгэл зүйг төлөвшүүлэх гэсэн төрөлтэй байхаар заасан. Эдгээр төрөл бүр дээр байхын зэрэгцээ, хүчирхийлэлд өртсөн субъектийн онцлог ялгааг харгалзан үзэх анхаарах хэрэгтэй. Тухайлбал хүүхдийн эсрэг, ахмад настны эсрэг, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн бол тухайн хохирогчийг ойлгох, хүлээн зөвшөөрөх, онцлог ялгааг таниулах, ойлгуулах нь чухал ач холбогдолтой.

Сургалтын үргэлжлэх хугацааг сэтгэл зүйн сургалт 16-41 цаг байх, эрх зүйн сургалт 2-5 цаг байхаар, бясалгалын сургалт нь 2-5 цаг байхаар нийт цаг 23-56 байхаар тусгасан байна[113]. Энэ нь шинээр батлагдан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Зөрчлийн тухай хуулийн 4.5.3-т заасан албадан сургалт нь арван цагаас тавин цагийн хугацаатай байна гэсэнтэй зөрчилдөж байна. Тушаалаар баталсан хөтөлбөрийн цаг хуулиар тогтоосон цагаас илүү байх нь цаашлаад хүний эрхийг хөндөх, төсөвт хүндрэл үүсэх эрсдэлийг үүсгэх, үр дүнд нөлөөлөх тул хуульд нийцүүлэн дээд хугацааг 50 цаг байхаар нэг мөр зохицуулах шаардлага байна. Судалгааны үр дүнгээс шүүхээс тогтоосон цагийг баривчлах хугацаанд бүрэн хамрагдахгүй хугацаа нь дуусах, сургалтын дундаас орох, сургалтын төлөвлөгөө, хуваарьт байхгүй сэдвүүдээр орох, хэргийн төрлөөс нь хамааруулж тус тусад оруулах боломжгүй нэг дор бөөн оруулж сургалт хийдэг[114] зэрэг асуудлууд байна. Мөн шүүхийн шийдвэрээр зөрчил гаргагчийн 70 хувь нь 7 хоног баривчлагдах

нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөнд хийсэн шинжилгээ судалгааны тайлан" 2020 х.69, 70

[112] Хүчирхийллийн эсрэг Үндэсний төв "Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилт мониторинг 2019 х.27,28

[113] Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 04 сарын 04-ны өдрийн А/73-р тушаалын 2 хавсралтаар "Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам" 9 дүгээр зүйл 9.2

[114] Хүчирхийллийн эсрэг Үндэсний төв "Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилт мониторинг 2019 х.27-31

шийтгэлтэй байдаг тул уг хугацаанд сургалтын хөтөлбөрт заасан цагаар бүрэн сургалтыг хийх боломжгүй, 7 хоногт 2 удаа сургалт хийхэд 2-4 цаг, 30 хоног баривчлах шийтгэлтэй хүн 16 цагийн сургалтад хамрагдах боломжтой[115] нь сургалтаас үр дүн хүлээхэд хүндрэлтэйг харуулж буй хэрэг юм. Үүнээс үзэхэд албадан сургалтыг баривчлах шийтгэлийг эдэлж байх хугацаанд хэрэгжүүлэх, биелүүлэх боломж бүрдэхгүй байна.

Хөтөлбөрт санхүүжилтийг улсын төсөв, төрийн болон төрийн бус байгууллагын, байгууллагын дотоод орлогоос бүрдэх боломжтой байхаар тусгасан. Одоогоор хөтөлбөрийг санхүүжилт нь ихэнх нь төрөөс болон олон улсын байгууллага, төрийн бус байгууллагын санхүүжилтээр явагдаж ирсэн, санхүүжилтээс шалтгаалж сургалтын орчин, нөхцөл, хэрэглэгдэхүүн, багшид олгох цалин хөлсний асуудал шийдвэрлэгддэг нь сургалтын үр дүнд нөлөөлөх хүчин зүйлийн нэг болдог.

Судалгаагаар санхүүжилт хангалтгүй, тогтмол бус, хүрэлцдэггүй[116] гэдгийг сургалтыг хийж буй байгууллага, албан тушаалтнууд илэрхийлсэн. Тиймээс албадан сургалтыг ганцаарчлан болон бүлгээр явуулах сургалтын байр, тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн, орчин нөхцөлийг бүрдүүлэх, сургалтыг заах багш нарыг бэлтгэх, цалин хөлсийг шийдвэрлэхэд шаардлагатай санхүүжилтийг төсвөөс шийдвэрлэх нь чухал байна. Гадаадын зарим улсад онцгой албан татварын орлогыг архидан согтуурах, хүчирхийлэл, мансуурах, донтох төрлийн эмгэгтэй тэмцэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд зарцуулдаг нь нийгмийн суурь асуудлыг шийдвэрлэхэд тодорхой хэмжээгээр нөлөөлдөг ач холбогдолтой байна.

Сургалтын хүрэх үр дүнг эхэнд, төгсгөлд үнэлэн зан үйл өөрчлөгдөх бодолгүй байх, бодож эргэцүүлэх, бэлтгэл, үйлдэл хийх, хэвших гэсэн 5 үе шатаар тооцон үйлдэлдээ дүгнэлт хийдэг, өөрийн буруутай үйлдлийг ухамсарласан, уур бухимдлаа хянах, асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх арга замд суралцсан, өөрийгөө үнэлдэг, хянадаг, нийгэмд биеэ зөв авч явах арга замд суралцсан, зан үйлд нөлөөлөх сургалтад бүрэн хамрагдаж гэр бүлийн хүчирхийллээс ангид байх ухамсар суусан байхаар үр дүнг тодорхойлсон.

Судалгаагаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд явуулдаг албадан сургалтын хувьд л гэхэд үнэлгээг 80 хувь нь хийдэггүй, 20 нь заримдаа хийдэг,

[115] Зан үйлд нөлөөлөх сургалтын хэрэгжилт мониторинг 2020 х.4

[116] Хүчирхийллийн эсрэг Үндэсний төв “Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилт мониторинг 2019 х.34, Зан үйлд нөлөөлөх сургалтын хэрэгжилт мониторинг 2020 х.3 баривчлах байрны орчин нөхцөл хүнд, сургалт явуулах боломжгүй, сургалт нэр төдий явагддаг, санхүүгийн асуудал шийдэгдээгүй тул төрийн бус байгууллагад тулгуурлан явагддаг.

шалтгаан нь үнэлгээний арга зүй, аргачлал мэдэхгүй[117] гэж хариулсан сургалтыг орж буй багш үнэлгээ хийдэггүй, үнэлгээ хийх боломж хомс, зан харилцаанд гарч буй өөрчлөлт, хүнтэй харилцаж байгаа байдлаас нь өөрчлөгдөж байгаа эсэхийг хардаг байна. Энэ нь хөтөлбөрт тусгагдсан үр дүнг тодорхойлох үнэлгээг хийх аргачлал боловсруулах, сургалтын төрөл бүр дээр ялгаатай үнэлэх, үр дүндээ хүрсэн эсэхийг оролцогч талуудад ойлгомжтой, тодорхой хянадаг болох шаардлагатайг харуулж байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд зохих хуулиудыг шинэчлэн зөрчил, гэмт хэрэг үйлдэгчийн баривчлагдсан болон хорих хугацаанд нь зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулах, давтан зөрчил, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх улмаар асуудлаа шийдвэрлэхэд шаардлагатай хууль зүй, сэтгэл зүй, харилцааны мэдлэг, чадвар олгох замаар хандлагад өөрчлөлт оруулах хүмүүжлийн шинжтэй механизмыг хэрэглэх боломжтой болсон нь сайшаалтай байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас явуулж буй зан үйлд нөлөөлөх сургалт нь орчин, нөхцөл, хангамжийн хувьд боломжийн зориуд бэлтгэгдсэн байр, багш, төлөвлөгөөгөөр явуулж байгаа бол цагдаагийн байгууллагаас явуулж буй баривчлах байран дахь сургалтын хувьд хүндрэлтэй, сургалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай байр, боловсон хүчин, хэрэглэгдэхүүн дутмаг байна.

Албадан сургалтыг орчин цагийн хэрэгцээ, шаардлага гэмт хэрэг, зөрчлийн төрөл, хохирогчийн онцлогт тохируулах нь зүй ёсны бөгөөд үр дүнд нөлөөтэй гэдгийг онцлон тэмдэглэж байна. Сургалтын агуулгаар юу өгөхөд бус юу үлдэхэд анхаарч суралцагч төвтэй үр дүнд суурилсан байхад сургалтын хөтөлбөр чиглэгдэж суралцагч тухайн хөтөлбөрийг эцэст юу хийж чаддаг, юу үлдсэн болохыг тодорхойлоход сургалтын гол зорилго чиглэгдэх шаардлагатай байна.

Хөтөлбөрийн хүрээнд агуулга нь хорих ял болон зөрчил үйлдэж баривчлах шийтгэл хүлээсэн этгээдийг нийтлэг байдлаар хамруулж гэмт хэрэг зөрчлийн төрлөөс үл хамаарч гэмт хэрэгтэн, зөрчил гаргагч нэг ижил агуулгаар байх эсэх нь тодорхойгүй байгааг нэг мөр тодорхой болгох хэрэгтэй.

Албадан сургалтын хувьд гэмт хэрэг, зөрчил гаргасан этгээдэд сургалт явагдаж буй тул дахин тухайн төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгын агуулгад чиглэх ёстой. Сургалтын зорилгоос сургалтын үр дүн тодорхойлогдох бөгөөд зорилго нь тодорхой зорилтод этгээд рүү чиглэсэн үр дүн нь тодорхой байхаар зохицуулагдах, сургалтад хамрагдах зорилтот бүлэг болон сургалтын чиглэл зорилгыг хуульд тодорхой заасан бөгөөд үүнтэй нийцүүлэн

[117] Хүчирхийллийн эсрэг Үндэсний төв “Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилт мониторинг 2019 х.31

хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох шаардлага байна. **Иймд** албадан сургалт тус бүр дээр тухайлсан журам гаргаж сургалтын хөтөлбөр боловсруулах нь үр дүнтэй юм.

Хөтөлбөрт сургалтын хугацааг 23-56 цаг байна гэж заасан хүчингүй болсон Захиргааны хариуцлагын хуультай нийцүүлж гарсан хугацаа ба шинээр батлагдан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Зөрчлийн тухай хуулийн **4.5 дугаар зүйлийн албадан** сургалт гэсэн зүйлийн 4.5.3-т албадан сургалт арван цагаас тавин цагийн хугацаатай байна гэсэнтэй зөрчилдөж байгааг зөрчлийн хуульд нийцүүлэн дээд хугацааг 50 цаг байхаар өөрчлөх нь зүйтэй юм.

Сургалтын хөтөлбөр бусад уялдаа холбоотой олон хүчин зүйлээс хамаарч үр дүнгээ өгөх, хэрэгжилт нь хангагдах юм. Зан үйлийг засах, өөрчлөх агуулга бүхий сургалт нь бусад сургалтаас ялгаатай сургалтын хөтөлбөр, сургалтын орчин, хэрэглэгдэхүүн шаарддаг төдийгүй сургалтын зорилго, зорилтод хүрэх үр дүнгийн асуудал, зайлшгүй тавигдах учиртай. Албадан сургалтыг цагдаагийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага өөрийн нөхцөл, боломждоо тулгуурлан зохион байгуулан явуулж байна. Энэхүү сургалтыг зохион байгуулж байгаа практикаас харахад сургалтын хөтөлбөрийн агуулга, сургалтын танхим, багшлах нөөц, чадавх, сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтыг үнэлэх арга, аргачлал дутмагаас шалтгаалж хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Учир нь сургалтыг зохион байгуулахад хэрэгцээтэй мэдлэг, мэдээлэл, орчин, нөхцөл хүний нөөц, чадавх, материаллаг бааз нь тухайн сургалтын үр дүнд шууд нөлөөлдөг тул гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийн зан үйлд нөлөөлөх, зан үйлээ өөрчлөх, асуудлыг шийдвэрлэх хандлага төлөвшихгүй байна. Албадан сургалт нь бусад сургалтаас эрс ялгаатай сургалтын орчин, нөхцөл, хэрэглэгдэхүүн шаарддаг сургалтын нэг төрөл юм. Иймд албадан сургалтыг үр дүнтэй зохион байгуулахад материаллаг бааз, боловсон хүчин, тохиромжтой сургалтын орчин нөхцөл, хэрэглэгдэхүүн дутах асуудлууд практик үүсэж байгаа нь цаашид зайлшгүй санхүүжилтийг бүрэн шийдвэрлэх, шаардлагатай байна. Ингэснээр сургалтын хөтөлбөрийн үр нөлөө нэмэгдэх, давтан гэмт хэрэг, зөрчлийг үйлдэхгүй байхад нөлөөлөх юм.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2016
2. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль 2011
3. Зөрчлийн хууль 2017
4. Монгол Улсын Үндсэн хууль 1992
5. Хүүхэд хамгаллын тухай хууль 2016
6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017
7. Эрүүгийн хууль 2015
8. С.Нарангэрэл Эрх зүйн толь бичиг гуравдахь хэвлэл 2011
9. С.Нямсүрэн “Эрх зүйн ерөнхий онол” 2017
10. Ханс Кельзин Хэм хэмжээний тухай онол 2013

11. Я”Цэвэл “Монгол хэлний тайлбар толь”
12. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын “хөтөлбөр батлах тухай” 2017.04.04 А/73 тушаал
13. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/103 дугаар тушаалаар баталсан “Зан үйлд нөлөөлөх сургалт зохион байгуулах журам”
14. Нээлттэй нийгэм форум “Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн Дархан Уул аймгийн салбар Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилт” сэдэвт мониторингийн тайлан 2020
15. Хүчирхийллийн эсрэг Үндэсний төв “Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилт мониторинг 2019
16. Cartes Mongolia, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын захиалгаар хийсэн “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөнд хийсэн шинжилгээ судалгааны тайлан” 2020
17. https://www.youtube.com/watch?v=7tM7DFaOr7s
18. https://forum.mn/uploads/site/1126/res_mat/2020/OSF_monitoring_21.pdf

ОЛОН УЛСАД БОЛОН МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ ДЭХ ЯЛ ТЭНСЭХ ИНСТИТУЦИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛТ



А.Баасанцэрэн
Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн хурандаа

Товч утга: Ял тэнсэх нь олон улсын болон Монгол улсын (хууль зүйн) эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд хэрхэн институци болж үүсэж хөгжсөн нөхцөл байдал, шалтгаан, нийгмийн захиалга, эрдэм судлаачдын дүгнэлт судалгаа, өнөөгийн нөхцөл байдал,

Түлхүүл үг: Ял тэнсэх, институци, хянан харгалзах, хязгаарлалт тогтоох үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах.

1. ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Өнөөдөр дэлхийн ихэнх улс орны эрүүгийн эрх зүйн ялын бодлогод хорих ялаас аль болох татгалзах, бусад төрлийн ялыг түлхүү хэрэглэх болсон байна.

Европын холбооны орнуудад сүүлийн үед анх удаа санамсар болгоомжгүй гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэргийн улмаас хохирсон хохирол бүрэн нөхөн төлсөн, үйлдсэн гэмт хэрэгтэй гэмшсэн зэрэг шалтгаанаар хорих ялыг тэнсэх нь нийт хорих ялын 80 гаруй хувийг эзэлж байна. Манай улс сүүлийн жилүүдэд хорих ялыг биеэр эдлүүлэх явдал жил ирэх тутам багасаж байна, үүний нэг жишээ бол 2010 онд шүүхээс хорих ял оногдуулсан 7292 ялтны 2444 буюу (33,6%), 2011 онд 8210 ялтны 3084 буюу (37,5%), 2012 онд 8324 ялтны 3217 буюу (38,6%), 2013 онд 8065 ялтны 3342 буюу (41,4%) ялтанд оногдуулсан хорих ялыг тэнсэж хянан харгалзсан байна. Монгол улсын дээд шүүхийн статистик мэдээгээр 2010 – 2014 онд шүүхээр 40069 ял шийтгэгдсэнээс 15483 хүн буюу (38,6%), үүнээс 3 хүртэл хүүхэдтэй 492 (3,2%), насанд хүрээгүй хүүхэд 1744 (11,3%), үйлдсэн бол хорих ялын тэнссэн хүнээс давтан гэмт хэрэг үйлдсэн148 хүн байгаа нь (0,95%)[118] эзэлж байгаа нь хорих ялын тэнсэж байгаа нь үр дүнтэй байна гэж үзэх боломжтой юм

Монгол улсад 2016 онд 6566 хүн ял шийтгэгдсэнээс 2866 буюу (43,6%), 2017 онд 9019 – 2795 буюу (31%), 2018 онд, 2019 онд 13011 – 2167 буюу (16,6%)[119] шүүхээс хорих ялыг тэнссэн байна. Үүнээс үзэхэд сүүлийн жилүүдэд шүүхээс хорих ялын тэнсэх нь багассан мэт боловч шүүхээр шийдвэрлэгдэж байгаа гэмт хэрэг тоо өссөн, түүнд оногдуулж байгаа ялын төрөлд өөрчлөлт орсон, ялын бодлого өөрчлөгдсөн нь шинээр батлагдсан 2017 оны эрүүгийн хуулийн агуулгатай холбоотой гэж үзэх боломжтой байна.

[118]МУ-ын Дээд шүүхийн статистик мэдээ 2010-2014 он.
[119] Монгол улс дахь гэмт хэргийн цагаан ном 2016-2019 он.

Түүхэн хөгжилт:

Ял тэнсэх институц нь 19 зууны 40-өөд оны үед Английн шүүгч Бирмингама Метью Хилл нь үзэхдээ анх удаа гэмт хэрэг үйлдсэн өвчтэй ялтнуудад өвчнөө эмчлүүлэх боломж олгох үүднээс биеэр эдлэх хорих ялаас чөлөөлөх, хорих ялыг торгох ялаар солих саналыг анх тавьж байсан, 1879-өөс 1887 оны хооронд английн шүүхийн практикт хэрэглэж ирсэн байна.[120]

19 зууны 60-аад оноос Англиас салбарлан АНУ-д анх Массачузетсом мужийн шүүх хэрэглэсэн байна. 1899 он гэхэд Америкийн ихэнхи мужууд Миннесота, Иллинойс, Род-Айленд, Верменте, Нью-Джерси, Нью-Йорке мужуудад хэрэглэж ирсэн байна. 1911 оны эцэс гэхэд 41 мужуудад тархан хэрэглэж байсан бол 1920 он гэхэд Хойд-Америк, Англии, Шотланд, Канаде, Австралии, Шинэ Зеланд, Өмнөд-америкийн орнуудад ял тэнсэх институцийг өргөн хэрэглэх болсон байна.[121]

19 зууны 60-аад оноос Англиас АНУ-д салбарласан бол Европт Белги, Франц, Германаар дамжин Оросод орж ирсэн байна. 1894 онд Оросын эрдэмтэн А.А. Пионтковский анх “ял тэнсэж хянан харгалзах тогтолцоо” гэсэн анхны нийтлэл гаргаснаас хойш 1900 онд ял тэнсэх асуудлыг Оросын хууль цаазын бичигт урьдчилсан байдлаар нэмэлт оруулан хэрэглэж болохыг Төрийн зөвлөлөөс баталж өгсөн байна.

Оросын эрдэмтэн Н.И.Фалеева 1904 онд бичихдээ энэ Бидний цаг үед манай эрүүгийн тогтолцооны гажуудлыг засах туршилтын бүтээгдэхүүн бол ял тэнсэх явдал юм. Хэрэв хууль сахиулах арга хэрэгсэл нь төгс бус байвал түүнийг зайлшгүй засаж сайжруулах шаардлагатай байдаг. Энэ дүгнэлтээс ял тэнсэх нь ялыг бие даасан төрөл болсноор орчин үеийн хорих ялын дутагдалтай талыг арилгах явдал юм.[122]

1907 оны 1 дүгээр сарын 21 нд хуулийн төсөл боловсруулах тусгай комисс байгуулсан байна, Энэ комисс нь 1-рт Ял тэнсэх институцийг хуулийн төсөл боловсруулах, 2-рт Шүүхийн шинэчлэлийг асуудал зэргийг боловсруулж 1909 оны 10 дугаар сараас 11-р сарын хооронд Бүх Оросын Төрийн Думаар батлуулсан байна.

Оросод 19 зууны сүүлч 20 зууны эхэн үеэс шинжлэх ухааны түвшинд судалж ирсэн байна. Тухайн үед ял тэнсэх институцийг тусгайлан судалж байсан судлаачид бол А.А. Пионтковский, Н.И.Фалеева, Н.С.Таганцев, И.П. Люблинский нар бол Оросын эрүүгийн эрх зүй тэр тусмаа ял тэнсэх институтийг судалсан томоохон төлөөлөгчид юм.

Манай оронд 1921 онд ардын хувьсгал ялж улмаар 1924 онд Бүгд найрамдах засаглалыг тунхаглаж анхдугаар үндсэн хууль батлагдсанаас хойш хууль эрх зүйн томоохон өөрчлөлт шинэчлэлт хийгдсэний нэг илрэл бол 1926 онд анхны шүүх цаазын бичгийг гаргасан байна. Энэ хуулийн 8 дугаар зүйлд Шүүх гэмт этгээдэд оногдуулсан ялаа биечлэн эдлүүлэхийг түдгэлзэн тэнсэж гурваас таван жил хүртэл хугацаагаар хянан харгалзах бөгөөд уг хянан харгалзсан

---

120 *П.И.Люблинский*. Журнал< Право и жизнь> Условное осуждение. г Москва 1924 г .С.5

121 *П.И.Люблинский*.Дурьдсан зохиол. Москва.,1924., 6 талд.

122 *Н.И. Фалеева* Условное осуждение (новая область его применения) г Москва 1904 г С.43.

хугацаанд шийтгүүлсэн этгээд түрүүчийн үйлдсэн хэргийн нэг төрлийн гэмт хэрэг үйлдээгүй бол ялыг эдлүүлэхгүй тухай заасан байдаг. Гэвч энэ хуульд чухам ямар ялыг тэнсэж болохыг тодорхойлоогүйн гадна хянан харгалзах хугацаанд түрүүчийн үйлдсэн хэргээс өөр төрлийн хэрэг үйлдсэн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх асуудлыг тодруулан заагаагүй нь дутагдалтай байсан байна.[123]

1929 оны БНМАУ-ын Шүүх цаазын бичиг-т Оноосон ялыг түдгэлзүүлэх нь шүүх таслах газраас тогтоосон нэг жилээс таван жил хүртэлх тэнсэх хугацааны дотор ялт хүмүүн дахин нэг төрлийн буюу өөр хүнд гэмт явдал эс үйлдвээс оноосон ялыг үл эдлүүлмой. Хэрэв гэмт хэрэг үйлдсэн хүмүүн зан авир нь ард олны дунд аюултай бол тэнсэж болохгүй гэж хуульчилсан байна.[124] Энэ хуулийг өмнөх хуультай харьцуулбал шинэлэг зүйлүүд олон тусгагдсан. Тухайлбал Гэм буруутай этгээдийн ялыг тэнсэх хугацааг 1-5 жилийн хугацаатай байхаар хуульчилсан нь одоо хүртэл мөрдөгдөж ирсэн. Түүнчлэн 12-р зүйлийн тайлбарт хэрэг үйлдсэн этгээдийн зан авир нь ард олны дунд аюултай бол ялыг тэнсэхгүй гэж хуульчилсан байна, үүнийг дан ганц субьектив шинжээр нь буюу субъектийн зан төлөвөөр тогтоож байсан нь учир дутагдалтай байсан. Уг хуульд ял тэнсэгдсэн этгээд хянан харгалзах хугацааны дотор дахин гэмт хэрэг үйлдэхэд түрүүчийн тогтоолоор шийтгүүлсэн ялыг ямар журмаар эдлүүлэх асуудал тодорхойлоогүй юм. Дээрх хуулиудад ял тэнсэх институци нь ялын бие даасан нэг төрөл болж хэрэглэгдэж байсан байна.

1934 оны шүүх цаазын бичиг энэ хуулийн 6-р бүлгийн 38-д шийтгэсэн ялыг гүйцэтгэхийг түдгэлзэн, ялыг тэнсэх, хугацааны өмнө тэнсэж суллах гэж заасан байна. Шүүн таслах газар уг хэргийг хянаж үзээд олон нийтэд аюултай эсэхийг үзэж заавал хорих буюу хорихгүй албадан ажил хийлгэх зэрэг ялыг тэнсэх эрхтэй болно. Шүүн таслах газраас тогтоосон хянан харгалзах хугацаа нь 1 жилээс 5 жил хүртэл байна. Энэ хууль нь өмнөх хуулиудаас хэд хэдэн өөрчлөлт орсон байна.

Үүнд: 1.Тэнсэх явдлыг хорих, албадан ажил хийлгэх хоёр үндсэн ялын аль нэгэнд хэрэглэж байх.

2.Ял тэнсэх тохиолдолд тэнсэж байгаа үндсэн ял дээр хөрөнгө хураах буюу торгох нэмэгдэл ял оногдуулсан бол тогтоолд зааснаар гүйцэтгэж байх.

3.Ял тэнсэх үндэслэлийг хэргийн нийгмийн хор аюулын байдлаар тогтоосон.

Ял тэнсэх асуудлыг эрүүгийн ял шийтгэлийн нэг хэлбэр болгон заадаг байсныг хассан байна.

1940 оны 6 сард хуралдсан Улсын 8 их хурал шинэ үндсэн хуулийг батлан гаргасантай холбоотойгоор Монгол улсад дагаж мөрдөх хууль дүрмүүд шинэчлэн боловсруулах ажил явагдаж үүний үр дүнд 1942 оны 1 сарын 17 нд Улсын бага хурлаар анх удаа Эрүүгийн хууль нэртэйгээр батлагдан гарсан.энэ хуулинд ял тэнсэх явдлыг бүтэн бүлэг болгон хуульчилсан. Энэ хуулийн 6 бүлэгт Тэнсэн шийтгэх ба хугацаа дуусахын өмнө суллаж тэнсэх тухай гэж бие даасан бүлэг

[123] *С.Жанцан*. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол. УБ., 2014, 307 талд.

[124] *Д. Адъяабазар*. Монгол улсын 1921 оноос хойшхи эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ ., 1998, 39 талд.

болгон хуульчилсан. 50 зүйлд Шүүх таслах газар бол уг хэргийн байдал, олон нийтэд хэр аюултай болохыг хянан үзэж заавал хорих буюу хорихгүйгээр засан хүмүүжүүлэх хөдөлмөр хийлгэх ял оногдуулах эсвэл ялыг тэнсэхээр тогтоох эрхтэй болно[125].

Шүүх таслах газраас тэнсэн харгалзахаар зааж тогтоосон хугацаа нь нэг жилээс доошгүй 5 жилээс дээшгүй байна. Тайлбар: Хорих буюу засан хүмүүжүүлэх хөдөлмөр хийлгэх явдал дээр мөнгө буюу эд хөрөнгөөс хураах нэмэгдэл ял шийтгэсэн байвал таслан шийтгэх тогтоолд заасан ялыг эдлүүлэх буюу тэнсэхийг үл ялгаварлан шууд гүйцэтгэвэл зохино.[126]

1960-аад он бол монгол оронд социализм байгуулах суурийг тавьж байсан цаг үе юм. БНМАУ-ын АИХ-ын 2 чуулганаар баталсан шинэ эрүүгийн хуулийг 1961 оны 4 сарын 1-ээс мөрдөж эхэлсэн.Энэ хуулийн 4 бүлгийн 83 зүйлд Ял шийтгэх ба ялаас чөлөөлөх тухай ,ял тэнсэх.

1. Хэргийн учир шалтгаан ба хэрэгтний хувийн байдлыг харгалзан хорих буюу засан хүмүүжүүлэх ажил хийлгэхээр шийтгэсэн ялыг биечлэн эдлүүлэх шаардлагагүй гэж шүүх үзвэл тухайн шалтгааныг тодорхойлон тэнсэхээр тогтоож хуульд заасан хугацаагаар хянан харгалзана.
2. Хянан харгалзах хугацааг 1-ээс 5 жил хүртэл тогтооно.
3. Тэнсэгдсэн этгээдээс хянан харгалзах хугацааны дотор шинэ гэмт хэрэг үйлдвэл энэ хуулийн 31.6-д заасныг баримтална.
4. Тэнсэгдсэн этгээдэд торгууль, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгийг хураахаар шүүхээс оногдуулсан бусад нэмэгдэл ялыг хэрэглэж болохгүй.
5. Олон нийтийн байгууллага буюу хамт ажиллаж байсан ажилчин, албан хаагчид, нэгдлийн гишүүдийн хамт олноос тэнсэхийг хүссэн өргөдөл хүсэлтийг үндэслэж хэргийн учир шалтгаан ба хэрэгтний хувийн байдлыг харгалзан түүнийг засан хүмүүжүүлэхийг дээрх байгууллагууд буюу хамт олонд хариуцуулах журмаар тэнсэж болно[127] гэжээ.

Уг хуулиар олон нийтийн байгууллага, хамт олон нь уг этгээдийг тэнсэхийг хүссэн хүсэлтийг шүүхэд гаргавал тэдэнд хариуцуулах журмыг шинээр оруулж өгсөн нь тухайн үеийн нийгмийн хөгжил, ард иргэдийн эрхийн ухамсар дээшилснийг харуулсан чухал заалт болсон байна.

1986 онд БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 40 зүйлд ял тэнсэх асуудлыг дор дурдсанаар өөрчлөн найруулсан юм. Хэрэв хэргийн нөхцөл байдал, гэм буруутай этгээдийн хувийн байдлыг харгалзан түүнд оногдуулсан хорих буюу засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг биечлэн эдлүүлэх шаардлагагүй гэсэн дүгнэлтэд шүүх хүрвэл энэ шалтгааныг таслан шийдвэрлэх тогтоолд заавал зааж уг ялыг тэнсэж 1-ээс 5 жил хүртэл хугацаагаар хянан харгалзахаар тогтоож болно.

---

[125] *Даваасамбуу. Б, Совд Г, Ахметшин Х. М, Владимиров В. А, Загородников Н. И, Криволапов Г. Г, Наумов А.В, Худяков Е. А,* Уголовное право МНР общая часть Москва 1983 г, стр 48.

[126] *Д.Адъяабазар.* Дурьдсан зохиол. УБ., 1998,77 талд.

[127] Мөн тэнд.

Тэнсэгдсэн ялтанд Цагдан сэргийлэх байгууллага, насанд хүрээгүй этгээдэд ЦСБ болон орон нутгийн АДХГЗ-ны дэргэдэх насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисс хяналт тавина.

1995 оны12 сарын 11-ний "Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх тухай" хуулийн 4 бүлгийн 21-р зүйлд тэнсэгдсэн ялтныг хараа хяналтдаа байлгаж, ялтны хөдөлмөр эрхлэлт,засрал хүмүүжлийн байдлыг хариуцах үүргийг сум, дүүргийн засаг дарга нарт хариуцуулах, тэнсэгдсэн ялтныг хянан харгалзах талаар Цагдаагийн байгууллага ямар үүрэг хүлээхийг болон мөн 22-р зүйлд ял тэнссэнийг хүчингүй болгож ялыг биечлэн эдлүүлэх үндэслэл журмыг хуульчилсан[128] байна.

2002 оны эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйл.Тэнсэх 61.1.Хүндэвтэр гэмт хэрэгт анх удаа хорих ял шийтгүүлсэн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан тохиолдолд түүнд оногдуулсан ялыг биечлэн эдлүүлэх шаардлагагүй гэж шүүх үзвэл уг ялыг тэнсэж, нэгээс таван жилийн хугацаагаар хянан харгалзахаар тогтоож болно. Тэнсэгдсэн ялтан шүүхээс тогтоосон хянан харгалзах хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдээгүй, засарч хүмүүжсэнээ харуулсан бол шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхгүй.

61.2.Энэ хуулийн 61.1-д заасан журмыг ялтай байгаа этгээдэд хэрэглэхгүй.

61.3.Тэнсэгдсэн ялтан хянан харгалзах хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд энэ хуулийн 58 дугаар зүйлд заасан журмыг баримтлан ял оногдуулна.

61.4.Тэнсэгдсэн ялтанд цагдаагийн байгууллага хяналт тавина.

61.5.Тэнсэгдсэн ялтан хянан харгалзах хугацаанд захиргааны шийтгэл хүлээсэн бол цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн хорих ялыг биечлэн эдлүүлэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ.[129]

Монгол улсын 2002 оны эргүүгийн хуулийн 78-р зүйл ялтай байдал нь 7,-р зүйлийн 78.2.1.тэнсэж хянан харгалзсан, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдээгүй[130] бол ял шийтгэлгүйд тооцохоор заасан нь хуульд заасан хянан харгалзах хугацаанд дахин гэмт хэрэг үйлдээгүй бол гэсэн нь энэ хугацаанд зөрчил үйлдсэн тохиолдол заагаагүй байгаа нь учир дутагдалтай байна.

Монгол улсын 2015 он, 2017 оны шинэчлэн найруулсан эрүүгийн хуулийн 7-р зүйлийн 7.1 дүгээр зүйл. Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэхээр заахдаа

1.Хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хүн гэм бурууг хүлээн зөвшөөрч гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлж хор уршгийг арилгасан, эсхүл гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан

[128] Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ., 2011. 665-666 дах тал.
[129] Эрүүгийн хэрэг. эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. УБ., 2013. 27-28 дахь тал.
[130] МУ-ын Эрүүгийн хууль 2002 он

тухайн зүйл, хэсэг, заалтад заасан хорих ялыг оногдуулахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар тэнсэж болно.

2.Энэ хуулийн тусгай ангид заасан хоёр, түүнээс дээш гэмт хэргийг санаатай үйлдсэн, эсхүл хорих ялын дээд хэмжээг таван жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн, эсхүл зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүн гэмт хэрэг үйлдсэн бол энэ зүйлийн 1 дэх хэсэг хамаарахгүй.

3.Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан энэ хуулийн 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хэд хэдэн үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоож болно.

4.Тэнссэн хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, хязгаарлалтыг зөрчсөн бол шүүх тэнссэн шийдвэрийг хүчингүй болгож ял оногдуулна.

5.Тэнссэн хугацаанд энэ хуулийн тусгай ангид заасан санаатай гэмт хэрэг үйлдсэн бол шүүх тэнссэн шийдвэрийг хүчингүй болгож, энэ хуулийн 6.8, 6.9 дүгээр зүйлд заасан журмаар ял оногдуулна.

6.Тэнссэн хугацаанд болгоомжгүй гэмт хэрэг үйлдсэн бол тухайн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлсэн байдлыг харгалзан уг албадлагын арга хэмжээг хүчингүй болгох эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

7.Тэнссэн хугацаанд гэмт хэргийн хохирлыг бүрэн төлж шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлж эрхийн хязгаарлалтыг зөрчөөгүй ба цаашид үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэх шаардлагагүй гэж үзвэл прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан хугацааг дуусахаас өмнө ялаас чөлөөлж болно.

8.Тэнсэх хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ял оногдуулахгүй.

9.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо төлөхөө илэрхийлж тэнсэгдсэн хүн хохирлоо нөхөн төлөх хугацааг шүүх тогтооно[131].

ЭРДЭМТЭН СУДЛААЧДЫН ДҮГНЭЛТ:

Ял тэнсэх талаар доктор Б.Содовсүрэн : Шүүх ял ноогдуулахдаа Эрүүгийн хуулийн зохих зүйл ангийг баримтлан хорих, засан хүмүүжүүлэх хөдөлмөр хийлгэхээр шийтгэсэн ялыг тодорхой хугацааны дотор биечлэн эдлүүлэхээс түдгэлзүүлэхийг тэнсэх гэнэ[132].

Профессор Г Совд “Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулсан ялыг тэнсэж, тусгай хугацаагаар хянан харгалзаж хүмүүжүүлэх явдал эрүүгийн эрх зүйн зарчмын нэг бодит илрэл. Тэнсэх бол ял шийтгэлийн хүмүүжүүлэх зорилгыг оногдуулсан ялыг биечлэн эдлүүлэлгүй хэрэгжүүлж байгаа арга

[131] МУ-ын эрүүгийн хууль 2017 он
[132] БНМАУ-ын эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. УБ., 1969. 134 дэх тал.

хэрэгсэл[133] гэж энэ институцийн хууль зүйн учир холбогдлыг өндрөөр үнэлсэн юм. Хуульч Т.Дэндэв “Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулсан хорих засан хүмүүжүүлэх хөдөлмөр хийлгэх ялыг түдгэлзэж, хянан харгалзах талаар гаргасан шүүхийн шийдвэр бол шүүгдэгчид итгэл хүлээлгэж, энэрэнгүй хандаж байгаа явдал[134] гэж тэмдэглэсэн байна.

Ял тэнсэх институцийг тусгайлан судалсан доктор С.Батхүлэг тодорхойлохдоо “Ял тэнсэх нь анх удаа хүндэвтэр, болгоомжгүйгээр хүнд гэмт хэрэг үйлдсэн тохиолдлын шинжтэй гэмт хэрэгтнүүдэд хорих ял оногдуулаад түүнийг биечлэн эдлүүлэхгүйгээр хянан харгалзаж байгаа эрүүгийн ялын бус арга хэмжээ юм. Энэ нь орчин үед эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг өргөн хэрэглэх төрийн эрүүгийн бодлогын бодит биелэл юм”[135] гэж тайлбарласан байна.

ДҮГНЭЛТ

Монгол улсын 2002 оны эргүүгийн хуулийн 78-р зүйл ялтай байдал нь 7,-р зүйлийн 78.2.1.тэнсэж хянан харгалзсан, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдээгүй бол ял шийтгэлгүйд тооцохоор заасан нь хуульд заасан хянан харгалзах хугацаанд дахин гэмт хэрэг үйлдээгүй бол гэсэн нь энэ хугацаанд зөрчил үйлдсэн тохиолдол заагаагүй байгаа нь учир дутагдалтай байна.

Ял тэнссэн хүнд хянан харгалзах хугацаанд үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах, талаар 2002 оны хуульд Цагдаагийн байгууллагын хяналтад байлгаж дээрх арга хэмжээг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмаар зохицуулагдаж байсан бол, 2017 оны эрүүгийн хуулийн 7-р зүйлийн 7.3 дугаар зүйлд нэг бүрчлэн тусгаж өгсөн нь өмнөх хуулиудаас дэвшилтэй болсон боловч ялтай байдлыг хассан явдал нь учир дутагдалтай гэж үзэж байна.

Ял тэнсэх гэдэг нь шүүхээс хорих ялыг биечлэн эдлүүлэх шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд ялаас чөлөөлөх бус ялыг түдгэлзүүлж байгаа нэг хэлбэр юм. Гэвч хууль зүйн үр дагавар уг ял тэнссэн этгээд ялтай байдлын хувьд тодорхой хугацаанд ял эдэлж байсан хэлбэрээр илэрнэ.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. БНМАУ-ын эрүүгийн хууль 1986 он
2. МУ-ын Эрүүгийн хууль 2002 он
3. МУ-ын эрүүгийн хууль 2017 он
4. МУ-ын Дээд шүүхийн статистик мэдээ 2010-2014 он.
5. Монгол улс дахь гэмт хэргийн цагаан ном 2016-2019 он.
6. Г.Совд. БНМАУ-ын Эрүүгийн эрх зүй , Курс. УБ, 1973 он.
7. Т.Дэндэв. БНМАУ-ын Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн ялын асуудал. УБ, 1975 он
8. С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол. УБ., 2014 г

[133] *Г.Совд*. БНМАУ-ын Эрүүгийн эрх зүй , Курс. УБ, 1973. 405 талд.

[134] *Т.Дэндэв*. БНМАУ-ын Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн ялын асуудал. УБ, 1975.123 талд.

[135] *С. Батхүлэг*. Уголовно-правовая и криминологическая характеристика условного осуждения в Монголии. Г Краснодар. 2005. 13 дах тал.

9. Д.Адъяабазар. Монгол улсын 1921 оноос хойших эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ ., 1998 он.

10. П.И.Люблинский. Журнал< Право и жизнь> Условное осуждение. г Москва 1924 г

11. Н.И.Фалеева Условное осуждение (новая область его применения) г Москва 1904 г

12. С.Батхүлэг. Диссертация Уголовно-правовая и криминологическая характеристика условного осуждения в Монголии. Г Краснодар. 2005 г.

13. Эрүүгийн хэрэг. эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. УБ., 2013 он.

14. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ., 2011 он.

15. Даваасамбуу. Б, Совд Г, Ахметшин Х. М, Владимиров В. А, Загородников Н. И, Криволапов Г. Г, Наумов А.В, Худяков Е. А, Уголовное право МНР общая часть Москва 1983 г

СОГТУУРАХ, МАНСУУРАХ ДОНТОЙ ХҮНИЙГ АЛБАДАН ЭМЧЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

LAW REGULATION TO INVOLUNTARY TREATMENT FOR DRUGAND INTOXICATED ADDICTION



Э.Өнөболд
Дотоод хэргийн их сургуулийн
Сургалт, судалгааны 403 дугаар анги-
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Аюулгүй байдлын тэнхимийн ахлах багш, хошууч,
хууль зүйн магистр

Товч утга: Албадан эмчлэх ажиллагааны ойлголт, мөн чанарыг тодорхойлсны үндсэн дээр манай улсад согтуурах, мансуурах донтой хүнийг албадан эмчилж байгаа эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал, эмчлүүлэгчийн эрх зүйн байдлыг тодорхойлж санал дэвшүүлнэ.

Abstract: On the basis of defining the concept and nature of forced treatment, we will determine the legal regulations, problems, and the legal status of treatment providers in our country for the forced treatment of people addicted to alcohol and drugs.

Түлхүүр үгс: Хүний эрх, эрхийн хязгаарлалт, сэтгэцийн эрүүл мэнд, аюулгүй байдал, орчин нөхцөл, албадлага.

Key words: Human rights, limitations of rights, mental health, safety, environment and coercion.

УДИРТГАЛ

Нийгмийн оршин тогтнолын гол үндэс нь тухайн нийгмийн эд эс болсон хүнээс хамаардаг. Хүн буюу иргэний ухамсар төлөвшлийн байдал, хандлага, ёс зүй нь тухайн нийгмийн хөгжлийг тодорхойлох төдийгүй эрх зүйн шинжлэх ухааны үзэл баримтлалыг тодорхойлдог зүй тогтолтой.

Нийгмийн эрүүл мэндийн асуудлыг дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүмүүсийн төрж, өсөж хөгжих, ажиллах, амьдрах, нас ахих нөхцөл, өдөр тутмын амьдралын нөхцөлийг бүрдүүлдэг өргөн хүрээний тогтолцоо гэж үзэж байна.

Энэхүү тогтолцоонд эдийн засгийн бодлого, хөгжлийн хөтөлбөр, нийгмийн хэм хэмжээ, бодлого, улс төрийн тогтолцоо зэргийг хамааруулж байна. Хүн амын янз бүрийн бүлэг давхаргуудын хувьд нийгмийн хэм хэмжээ, бодлого,

улс төрийн нөлөөлөл нь өөр өөр байж болох бөгөөд эрүүл мэндийн үр дүнгийн ялгааг үүсгэж байна.

Ялгаатай бүлгүүдийн өөр өөр эрүүл мэндийн байдал нь баялгийн тэгш бус хуваарилалт, нийгмийн шударга бус байдал, тэгш бус хүртээмж зэргийг бий болгох ба эдгээр нь нийгмийн хөгжил, ухамсар төлөвшилд сөргөөр нөлөөлдөг.

Антропологийн судалгаагаар согтуурсан, мансуурсан үед хүмүүсийн зан байдал нь согтууруулах ундаа, мансууруулах бодисын шинж чанараас илүүтэй нийгмийн соёлын байдлаар илүү тодорхойлогддог болохыг харуулж байна[136]. Энэ нь нийгмийн хөгжил, нийгмийн хандлага, төлөвшлийг бүрдүүлэхэд сөргөөр нөлөөлөх нь харагдаж байна.

Дээрх сөрөг нөлөөллийг засах, үүсэж болох аливаа сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэхийн тулд эрх зүйн зарим төрлийн албадлага хэрэглэх шаардлага бий болдог.

Харин хүн амын эрүүл мэндийг хамгаалах асуудлыг хууль, эрх зүйн хүрээнд тусгайлан авч үзэж, зохицуулалт хийгээд, үйл ажиллагааны механизмыг боловсронгуй болгох хэрэгцээ нэн чухал юм.

Эдгээр нь согтуурах, мансуурах дон буюу сэтгэл зүйн эмгэгийг заавал эмчлэх зайлшгүй урган гарах нь тодорхой тул түүнийг хэрхэн хэрэгжүүлэх, хүний эрхийн хязгаарлалтыг хэрхэн зохимжтой түвшинд хэрэглэх вэ гэдэг үндсэн асуудал болоод байгаа юм.

Манай улсын хувьд “мансуурах, согтуурах” асуудал нийгэмд томоохон тулгамдсан асуудал болоод байна. Уг асуудлын хүрээнд тодорхой этгээдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх ажиллагааг албажуулан, нийгмийн гишүүдэд тэгш хүртээмжтэй хүргэх шаардлага үүсдэг. Эмнэлгийн тусламж үйлчилгээ нь нэг талаас өвчтөн нөгөө талаас эмнэлгийн байгууллагын нэгдмэл хүслийг илэрхийлэх ажиллагаа хэдий ч мансуурах, согтуурах хүсэл тээж буй этгээдэд тусламж үйлчилгээ үзүүлэх нь төдийлөн нэгдмэл хүсэл эрмэлзлэлээр тодорхойлогдож чаддаггүй.

Тэгвэл албадан буюу хүсэл сонирхлын эсрэг хэдий ч нийгмийн гишүүдийн ашиг сонирхлын үүднээс тэдгээр хүмүүст эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх асуудал эрх зүйн хувьд ихээхэн зохицуулалт, үзэл баримтлал шаардлагатай.

Иймд албадан эмчлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт хийгээд түүний хоорондын уялдаа холбоог нарийвчлан судлах шаардлагатай.

ҮНДСЭН ХЭСЭГ

Албадан эмчилгээ гэдэг нь эмчлүүлж буй хүнийзөвшөөрөлгүйгээр эмчилгээ хийлгэхийг хэлэх бөгөөд албадан эмчлэхийг дэлхийн улс орнууд

[136] https://pubmed.ncbi.nlm.nih.gov/national library of medicine

шүүхийн шийдвэрээр хэрэглэхийг зөвшөөрдөг ба эмч нарын шууд хяналтад явагддаг онцлогтой[137].

Албадан эмчлэх ажиллагаа нь эмчлүүлэгчийн бус хууль ёсны төлөөлөгчийн хүсэлтэд үндэслэх хандлага олон улсад түгээмэл байдаг ба гол шалгуур нь өвчтөн өөртөө буюу бусдад аюултай эсхүл аюул учруулж болзошгүй байх үндсэн шаардлагыг тавьдаг бөгөөд энэ нь албадан эмчлэх буюу хүний зөвшөөрөлгүйгээр эмчилгээ хийх ажиллагааг зөвтгөх шалтгаан болдог байна.

Хүний эрхийг хязгаарлах, халдашгүй байдлыг нь зөрчих ажиллагаанд түүнийг хүлээн зөвшөөрөх хангалттай үндэслэл байхыг шаардах бөгөөд "хуульд заасан бөгөөд үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун буюу бусдын эрх, эрх чөлөө болон энэхүү пактаар хүлээн зөвшөөрсөн бусад эрхийг хамгаалахад шаардлагатай хязгаарлалтаас бусдаар дээр дурдсан эрхийг хязгаарлаж болохгүй"[138] гэж олон улсын хэм хэмжээнд заасан. Энэ нь хүний эрхийг хязгаарлах нь зөвхөн нийгмийн хэв журам, олон нийтийн ашиг сонирхолыг хангах зорилгодоо хүрэхдээ гагцхүү тэр ашиг сонирхлыг л хэрэгжүүлэх бөгөөд өөр бусад хүний эрхийг хязгаарлахыг хориглосон томоохон үзэл баримтлал, зарчмыг өөртөө агуулжээ.

Мөн "Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ гагцхүү бусдын эрх, эрх чөлөөг зохих ёсоор хүлээн зөвшөөрч хүндлэх , мөн ардчилсан нийгмийн ёс суртахууны шударга шаардлага, нийгмийн хэв журам, ерөнхий сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосноос өөр хязгаарлалтад өртөгдөх ёсгүй"[139] гэж заасан. Эдгээр нь албадан эмчлэх ажиллагааны хувьд эмчлүүлэгчийн эрхийг зөвхөн нийгмийн хэв журам, бусад этгээдийн аюулгүй байдлыг хангах хүрээнд л хязгаарлах мөн чанарыг илэрхийлж байна.

Түүнчлэн хүний эрхийн аливаа хязгаарлалт нь ямар нэг байдлаар ялгаварлан гадуурхах зорилгыг агуулах ёсгүй байх талаар дурдсан байдаг.

Эдгээр нь зөвхөн эмчлүүлэгчийн өвчин эмгэг нь албадан эмчлэх ажиллагааны гол объект болох ёстой болохыг илтгэж байна.

Иймд албадан эмчлэхдээ өвчтөнүүд дараах шаардлагыг тавихыг зөвлөж байна.

А. Өвчин эсхүл, сэтгэцийн эмгэгтэй байх;

Б. Өөртөө болон бусдад аюултай;

[137] Davidson G, Brophy L, Campbell J, Farrell SJ, Gooding P, O'Brien AM (1 January 2016). "An international comparison of legal frameworks for supported and substitute decision-making in mental health services". International Journal of Law and Psychiatry. 44: 30–40.
[138] http://legalinfo.mn/Иргэний ба Улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. 1966
[139] http://legalinfo.mn/Хүний эрхийн түгээмэд тунхаглал. 1948

В. Хамгийн бага хязгаарлалттай байрлуулах;

Г. Эмчилгээний талаар бие даан шийдвэр гаргах чадвар дутмаг байх гэсэн шаардлагуудыг дурджээ[140].

Дээрх шаардлага, хязгаарлалтууд нь албадан эмчлэх ажиллагааны мөн чанарыг илэрхийлэх бөгөөд албадан эмчлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын суурь нөхцөлийг тодорхойлж байна.

Өөрөөр хэлбэл албадан эмчлэх ажиллагаанд сэтгэцийн эмгэг, эсхүл сэтгэл зүйн хувьд тогтворгүй хүмүүс оролцдог шинж, нөгөө талаас тухайн оролцогч нь өвчин, эмгэгээс шалтгаалан өөртөө болон бусдад аюул учруулж болзошгүй, мөн өөрөө бие даан шийдвэр гаргах хангалттай чадваргүй байхыг тодорхойлж байгаа бөгөөд тийм хүмүүсийн эрхийг хязгаарлан эмчилгээ хийхдээ хүний эрхийг хамгийн багаар хязгаарлах зарчим баримтлахыг тодорхойлсон. Иймээс уг ажиллагаа нь эрх зүйн нарийн бөгөөд хоорондоо уялдаа холбоо бүхий зохицуулалтыг шаардах нь харагдаж байна.

Монгол Улсын хувьд “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө.”[141] гэж тунхаглан хуульчилсан бөгөөд дээрх зарчмуудын агуулгыг хангаж байна. Иймд хүний эрхийг хязгаарлан албадан эмчлэх ажиллагаа нь эрх зүйн зохицуулалтын хувьд хүний эрхийг ямагт эрхэмлэсэн байх шаардлагатайг тодотгож байна.

Манай улсын хувьд албадан эмчлэх ажиллагааг Эрүүгийн хуульд заасан албадан эмчлэх албадлагын арга хэмжээ, Зөрчлийн тухай хуульд зааснаар албадан эмчлэх, мөн захиргааны журмаар албадан эмчлэх гэсэн төрлөөр явуулж байна.

Эдгээрээс согтуурах, мансуурах донтой хүмүүсийг захиргааны журмаар албадан эмчлэх ажиллагааг нарийвчлан авч үзэж, эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийе.

Согтуурах, мансуурах донтой хүнийг албадан эмчлэх ажиллагааны үндэслэлийг дээрх зарчмуудад хэрхэн нийцэж байгааг авч үзэх хэрэгтэй.

1. Согтуурсан, мансуурсны улмаас өөртөө болон бусдад аюул учруулах эрсдэлтэй байдалд орсон хүн согтуурах, мансуурах донтой болох нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон

[140] https://www.sciencedirect.com/ involuntary treatment
[141] Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 1992. №01

боловч сайн дурарааа эмчлүүлэхээс татгалзсан тохиолдолд шүүхийн шийдвэрээр албадан эмчилгээнд хамруулна[142].

Энэ нь захиргааны журмаар буюу удирдлагын эрх хэмжээний хүрээнд аливаа зөрчил гэмт хэрэг үйлдсэнээс үл хамааран тухайн хүний нийтэд аюултай болон донтох эмгэгтэй байдлыг харгалзан албадан эмчлэх агуулгыг илэрхийлж байна.

2. Зөрчил үйлдсэн хүн донтох сэтгэцийн эмгэгтэй болох нь эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон бол шүүх түүнийг албадан эмчилгээнд хамруулахаар шийдвэрлэж болно[143].

Энэ нь зөрчил үйлдсэн хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх бөгөөд эмчилгээ дууссаны дараа шүүх тухайн хүнд шийтгэл оногдуулах эсэхийг шийдвэрлэдэг.

3. Бусдын эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй халдварт өвчтэй, согтуурах, мансуурах донтох эмгэгтэй хоригдлыг албадан эмчлэнэ[144].

Согтуурах, мансуурах донтой байгаа нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээс татгалзах үндэслэл болохгүй бөгөөд хорих ялыг оногдуулах бөгөөд хорих байгууллага хоригдлыг тусгаарлан албадан эмчлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Согтуурах мансуурах донтой хүнийг албадан эмчлэхэд дээрх үндэслэлүүдийн аль тохиолдолд тухайн хүнийг бусад хүмүүсээс тусгаарлах арга хэмжээг авах ба тусгайлан харуул хамгаалалтын хяналт тавьдаг.

Үүнээс үзвэл согтуурах, мансуурах донтой хүний манай улсын хувьд “Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар”, “Хорих анги”-д олон нийтээс тусгаарлан албадан эмчилж байна. уг хоёр байгууллагыг судалгааны дараагийн хэсгүүдэд хялбар болгох зорилгоор “Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар”-т албадан эмчлэх ажиллагааг АЭ-1, “Хорих анги”-д албадан эмчлэх ажиллагааг АЭ-2 гэж томьёолоё.

“АЭ-1”-ийн хувьд албадан эмчлэх хугацааг 3 сараас 6 сар хүртэл, давтан эмчлүүлэх тохиолдолд 6 сараас 2 жил хүртэл хугацаатай байхаар тодорхойлсон.

Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын судалгаанд сүүлийн 3 жилийн байдлаар албадан эмчлэгдэж байгаа хүмүүсийн тоонд дүн шинжилгээ хийх замаар “АЭ-1” хэлбэрээр албадан эмчлэх

[142] Согтуурах, мансуурах донтой хүний захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 2018. №46
[143] Зөрчлийн тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2018. №24
[144] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. Уб., 2017. №26

болон эмчилгээний үр дүн хийгээд тус ажиллагаанд хүний эрхийн хязгаарлалтыг хэрхэн хэрэгжүүлж байгааг дүгнэж болох юм.

График 1. Захиргааны журмаар албадан эмчлүүлэгсдийн судалгаа[145]



Эдгээр хүмүүсийн тооноос согтуурах, мансуурах донтой гэж тогтоогдон албадан эмчлэгдэж байгаа хүмүүсийн тоо харьцангуй их бөгөөд давтан эмчлүүлж байгаа хүмүүсийн тоо нийт эмчлүүлэгчдийн 30 орчим хувийг эзэлж байгааг харуулж байна.

Харин “АЭ-2”-ын хувьд согтуурах, мансуурах донтой байх нь ял оногдуулахад саад болох хүчин зүйл болохгүй тул хорих байгууллага өөрөө эмчлэх үүргийг заажээ.

“АЭ-1”-ын хувьд тодорхой зөрчил үйлдээгүй буюу зөрчил гаргаж болзошгүй байдлаар тодорхойлогддог. Тэгвэл зөрчил гаргасан этгээдийг шийтгэх шаардлага нь хуульзүйн хувьд зайлшгүй зүйл бөгөөд албадан эмчлэх ажиллагаа нь тухайн шийтгэлийн нэг хэсэг байж болох юм. Харин зөрчил гаргаагүй этгээдийг зөрчил гаргаж болзошгүй үндэслэлээр шийтгэх нь хууль зүйн хувьд хүлээн зөвшөөрч болохгүй ойлголт юм.

Гэтэл өнөөгийн байдлаар согтуурах, мансуурах донтой этгээдийг албадан эмчлэх төв улсад ганц бөгөөд согтуурах, мансуурах донтой этгээдийг “Согтуурсан, мансуурсны улмаас өөртөө болон бусдад аюул учруулах эрсдэлтэй байдалд орсон хүн согтуурах, мансуурах донтой болох нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон боловч сайн дураараа эмчлүүлэхээс татгалзсан тохиолдолд шүүхийн шийдвэрээр албадан эмчилгээнд хамруулна” , “Зөрчил үйлдсэн хүн донтох сэтгэцийн эмгэгтэй болох нь эмнэлгийн

[145] Согтуурах, мансуурах донтой өвчтөнийг албадан эмчлэх, албадан хөдөлмөрлүүлэх газар. 2023 оны 10 сарын мэдээ. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба.

дүгнэлтээр тогтоогдсон бол шүүх түүнийг албадан эмчилгээнд хамруулахаар шийдвэрлэж болно” гэсэн үндэслэлээр албадан эмчилж байгаа нь ямар онцлог бүхий, этгээдийг хэрхэн хорих вэ гэсэн мөн чанартай агуулгын хувьд зөрчилдөж байна.

Энэ бол эрх зүйн тогтолцоо, хоорондын холбоо хамаарлын хувьд томоохон зөрчил төдийгүй цаашид албадан эмчлүүлэгчийн эрх зүйн байдлыг оновчтой байдлаар тодорхойлоход саад учруулахад хүргэх юм.

Энэ нь дан ганц согтуурах, мансуурах донтой үндэслэлээр албадан эмчлэгдэж байгаа этгээдийн ахуй нөхцөл болон дэглэмийн агуулгыг илэрхийлэхгүй ач холбогдолтой юм.

Албадан эмчлэх ажиллагааны хувьд бас нэгэн анхаарах шаардлагатай асуудал бол хэрэг хариуцах чадварыг согтуурах, мансуурах донтой этгээдийг албадан эмчлэх ажиллагаанаас тусгаарлан авч үзэх ёстой бөгөөд эрх зүйн ач холбогдлын хувьд адилтан авч үзэх эрсдэлийг үүсгээд байна.

Мөн албадан эмчилгээ үзүүлэх байгууллага, эмчлүүлэгчийн орчин нөхцөлийн тухай асуудлыг тухайн харилцааг зохицуулсан хууль, журам болон дотоод журмаар нарийвчлан зохицуулдаггүй байдал нь эмчлүүлэх орчны хувьд хүний эрхийн зөрчлийг бий болгож байна.

Холбогдох хуульд албадан эмчилгээ хийхдээ хүний эрх, эрх чөлөөнд хүндэтгэлтэй хандана гэж заасан бөгөөд харилцааны хэм хэмжээг нарийвчлан тодорхойлоогүй байдал тэгш бус нөхцөл байдлыг бий болгож байна.

Мөн эмчлүүлэгчийг тодорхой эмчилгээ хийлгэхээс татгалзсан тохиолдолд шууд албадлагын арга хэмжээ авахаар хуульд заасан бөгөөд тодорхой урьтач нөхцөлийг заагаагүй байгаа нь ихээхэн анхаарал татаж байна.

ДҮГНЭЛТ

1. Нийгмийн нийтлэг ашиг сонирхолыг хангах үүднээс нийгмийн хэв журмыг алдагдуулах, эрсдэл учруулах хангалттай үндэслэл байгаа тохиолдолд тэдгээр хүмүүсийг албадан эмчилж, эрхийн хязгаарлалт тогтоох боломжийг олон улсын эрх зүйн хэм хэмжээ, хийгээд дотоодын хууль тогтоомжоор олгосон байна.

Гэхдээ энэхүү хүний эрхийн хязгаарлалт нь зөвхөн албадан эмчлэх ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдсон байхаас бус өөртөө цээрлүүлэх, залхаах, тарчлаах шинжийг агуулж болохгүй.

2. Албадан эмчлэх ажиллагаа нь хүний эрхэд хязгаарлалт тогтоодог арга хэмжээ тул албадан эмчлэхэд шаардлагатай суурь нөхцөлүүдийг заавал шалгуур болгон авч үзэх хэрэгтэй бөгөөд тэрхүү шалгууруудаар албадан эмчлэх ажиллагааны нөхцөл журам, эрхийн хязгаарлалтын хэмжээ тодорхойлогдох ёстой.

3. Манай улсын хувьд согтуурах, мансуурах донтой хүмүүсийг албадан эмчлэх ажиллагаанд гурван үндсэн эх сурвалжийн хүрээнд цагдаагийн байгууллагын санаачлагаар, зөрчил гаргасан этгээдийг шүүхээс, мөн хорих ял эдэлж байгаа согтуурах, мансуурах донтой этгээдийг албадан эмчлэх үндэслэлүүдийг тодорхойлсон бөгөөд эдгээр хүмүүсийн эмчлэгдэх болсон нөхцөл байдлаас үл хамааран нэг орчинд, нэг нөхцөл, нэг арга журмын хүрээнд эмчилгээ үзүүлдэг байгаа нь эмчилгээний чанар өгөөжийн хувьд хүртээмжтэй байж болох хэдий ч эрхийн хязгаарлалт хүлээж байгаа этгээдийн хувьд зүй ёсны бус нөхцөл байдлыг бий болгож байна.

Сайн дурын биш хууль тогтоомжийн хүрээнд албадлага хэрэглэж байгаа тул албадлагын арга хэмжээг хэрэглэх үндэслэл, журам нь хувь хүний онцлог, субъектив болон объектив нөхцөлд тохирсон байх шаардлагатай болохыг харуулж байна.

САНАЛ

Илтгэлийн хүрээнд албадан эмчлэх ажиллагааны үеийн хүний эрхийг хангах, эрхийн хязгаарлалтыг оновчтой тодорхойлох, албадан эмчлүүлэгсдийн эрх зүйн байдлыг ялгамжтай тогтоох хүрээнд дараах саналуудыг дэвшүүлж байна.

1. Албадан эмчлэх ажиллагаа нь нийтийн эрх зүйн харилцааны нэг салбар болохын хувьд албадан эмчүүлэгчдийн эрүүл мэндийн байдал, эмчилгээний үр дүн, харилцааны хэм хэмжээ, хүний эрх хамгаалах хүрээнд хяналт тавих, шаардлага хүргэх байгууллага, албан тушаалтны үүргийг нэмэгдүүлэх.

2. Согтуурах, мансуурах донтой хүмүүсийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуульд согтуурах, мансуурах донтой хүмүүсийн эрх зүйн байдлыг тодорхой тусгах шаардлагатай. Үүнд:

- Албадан эмчлэх үндэслэлийг нарийвчлан дэлгэрүүлж тусгах. Ингэснээр албадан эмчлэх ажиллагааг зайлшгүй шаардлагаар хэрэглэж ба албадан эмчлэхдээ хүний эрхийн хязгаарлалтын хэмжээг багасгах боломж бүрдэнэ.

- Албадан эмчлэх ажиллагааны эмчилгээний дэглэмийг өвчтөний өвчний шинж байдал болон албадан эмчлэгдсэн үндэслэлийг харгалзан ялгамжтай тогтоох.

- Албадан эмчлэх ажиллагаа нь зөвхөн эмчлүүлэгчийн донтох эмгэгтэй холбоотойгоор тусгаарлаж, албадах эмчлэх шаардлагад хүргэсэн тул бусад нийгмийн харилцаанд оролцох боломж нөхцөлөөр хангах хүрээнд эмчлүүлэгчийн эрх болон эмнэлгээс үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх.

3. Албадан эмчлэх ажиллагааны үед харуул хамгаалалтын алба хаагчаас эмчлүүлэгчид тавих шаардлагыг нарийвчлах үүнтэй холбоотойгоор эмчлүүлэгчийн үүргийг дэлгэрүүлэх.

4. Эмчлүүлэгчид харуул хамгаалалтын алба хаагчаас албадлага хэрэглэх үндэслэл, шаардлагыг нарийвчлан тодорхойлж, албадлага хэрэглэх үеийн урьдач нөхцөлүүдийг тодорхойлох.

5. Албадан эмчлэх байгууллагад эмчлэгдэж байгаа хүмүүсийн иргэний эрхийг хангах хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон Согтуурах, мансуурах донтой хүний захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуулиудын уялдаа нийцлийг сайжруулах зэрэг саналуудыг дэвшүүлж байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 1992 №01
2. Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2016 №07
3. Зөрчлийн тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2017 №24
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. Уб., 2017. №26
5. Согтуурах, мансуурах донтой хүний захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2018. №46
6. Согтуурах, мансуурах донтой өвчтөнийг албадан эмчлэх, албадан хөдөлмөрлүүлэх газар. 2023 оны 10 сарын мэдээ. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба.
7. http://legalinfo.mn/Иргэний ба Улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. 1966
8. http://legalinfo.mn/Хүний эрхийн түгээмэд тунхаглал. 1948
9. https://www.sciencedirect.com/
10. https://pubmed.ncbi.nlm.nih.gov/
11. Davidson G, Brophy L, Campbell J, Farrell SJ, Gooding P, O'Brien AM (1 January 2016). "An international comparison of legal frameworks for supported and substitute decision-making in mental health services". International Journal of Law and Psychiatry

ХОРИХ АНГИАС СУЛЛАГДСАН ХҮМҮҮСИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ

EMPLOYMENT AND HEALTH INSURANCE FOR PEOPLE RELEASED FROM PRISON



Д.Энх-Амар
ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн ахмад

Хураангуй: Дэлхийн улс орнуудад хорихоос суллагдсан этгээдэд хяналт тавихдаа тусламж, дэмжлэг үзүүлэх, нийгэмд эргэн нэгтгэх нийгэмшүүлэх талаас нь анхааран ажилладаг хэдий ч Монгол Улсын хувьд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгын хүрээнд буюу Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн[146] 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 29.1.11 дэх заалтад зааснаар ял шийтгүүлсэн этгээдэд хяналт тавих үүргийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах болон төрийн хяналт шалгалтын байгууллагад оногдуулж хэрэгжүүлж байгаа нь хангалтгүй байгаа юм. Үүний улмаас хорихоос суллагдсан этгээд нийгэмд шилжин орох үед материаллаг байдлын хомсдол, сэтгэл зүйн болон нийгмийн дэмжлэг, төрийн зүгээс авч хэрэгжүүлэх нийгэмшүүлэх үйл ажиллагаа дутагдаж байгаа бөгөөд суллагдсан этгээдүүд дахин гэмт хэрэг үйлдэх цаашлаад хөдөлмөр эрхлэх боломжгүй болсноор Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрх[147] нь зөрчигддөг байна.

Түлхүүр үгс: Хорих ангиас суллагдсан хүмүүс, хорих ангиас суллагдсан этгээдэд тавих хяналт, нийгэмшүүлэлт, хорих ангиас суллагдсан хүмүүсийн хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэндийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл.

Abstract: In countries around the world, when monitoring persons released from prison, they pay attention to providing help and support, reintegrating them into society, but in the case of Mongolia, within the scope of the goal of crime prevention, i.e. Article 29, Section 1, Clause 29.1.11 of the Law on Crime Prevention According to the law, it is not enough that law enforcement and state inspection organizations are assigned the responsibility of monitoring convicted persons in order to prevent crimes and violations.

[146] Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль
[147] МУ-н Үндсэн хууль 16.6

As a result, when a person released from prison transitions into society, there is a lack of material conditions, psychological and social support, and a lack of socialization activities carried out by the government. the right to assistance is violated.

Keywords: persons released from prison, supervision and socialization of persons released from prison, employment of persons released from prison, health insurance, and health insurance premiums.

Хорих ял эдэлж байсан хүмүүсийн нийгэмшилтийн тухай:

Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заанаар “Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино”[148] хэмээн хуульчилсан байдаг. Өөрөөр хэлбэл эрүүгийн хариуцлага буюу ял нь дан ганц яллагдагчийн гэм бурууд тохирсон хэмжээгээр шийтгэж, цээрлүүлэхээс гадна тухайн хүнийг нийгэмшүүлэх, эрүүгийн хариуцлагаа зохих ёсоор хүлээсний түүнийг буцаад нийгмийн нэг хэсэг болоход нь чиглүүлэх, туслах мөн зорилготой.

Хорих ял эдэлж байсан этгээдийг нийгэмд эргэн нэгтгэх буюу нийгэмшилт хэмээх ойлголтыг олон эрдэмтэн, судлаачид өөр өөрөөр тодорхойлсон байдаг. Тухайлбал: нийгэмшилтийг социологийн хандлагаар нь Э.Дюркгейм “хүүхэд, залуусын хөгжилд нийгмийн бүтэц чухал ач холбогдолтой гэж тэмдэглээд хүмүүжил нь хүүхдийг нийгэмд амьдрах чухал нөхцөлийг бэлтгэх нийгмийн гол хэрэгсэл бөгөөд энэ хэрэгслийн тусламжтайгаар хүн амиа бодсон байдлаа гэтлэн давж, социаль мөн чанарыг олно. Энэхүү социаль мөн чанарын ачаар ёс суртахуунтай социаль амьдралаар амьдрах чадвартай болно” гэж үзэж тэрээр бие хүний хөгжилд нийгмийн нөлөөллийн ач холбогдлыг тэмдэглэж, хүмүүжил-нийгэмшилтийг холбож үзсэн байдаг.

Харин Т.Холтын үзсэнээр “нийгэмшилт нь бодгаль тухайн соёлын голлох стандартад нийцүүлэн биеэ авч явж сурах үйл явц”, Ч.Кули, Дж,Мид нар “нийгэмшилт нь процесс бөгөөд нийгэм бодгаль хоёр салгаж болохгүй нэг цул юмны 2 тал. Чухамхүү соёл л хүүхдийг нийгэмдээ яаж бодож, мэдэрч үйлдэхийн гол хүчин зүйл болдог” гэж үзжээ. Мөн Стенфордын их сургуулийн профессор А.Бандура “бие хүний хөгжилд ажигдах ба загварчлах гэсэн ойлголтыг авч үзэн бага насны хүүхдийн телевизээр үзэж буй зүйлд анхаарлаа хандуулах нь чухал”, Ф.Гиддингс “нийгэмшил нь хүний социаль мөн чанар хөгжих үйл явц. АНУ-д нүүж ирэгсдийн хэл, шүтлэг, зуршилд эхний үед гарах ялгаа нь эрс багасах буюу устаж үгүй болон Америкт байнга оршин суугчдын хэв шинжид автан шингэх үзэгдэл нь нийгэмших үйл явц” гэж үзжээ.[149]

[148] Эрүүгийн хууль 2015 он
[149] Хорих байгууллага дах нийгмийн ажил. 2015 он

Эдгээрээс дүгнэвэл нийгэмшилт нь хүнд нийгмийн шинж чанарууд төлөвших үйл явц бөгөөд нийгмийн орчноос социаль дадал, зуршил олж авах явц юм. Үүний мөн чанар нь хамтын амьдралын дүрэм, журмыг ойлгох болон соёлын мөн чанарыг өөртөө шингээх үйл явц. Өөрөөр нийгэмшил нь хүн, орчиндоо зохицож, харьцаж, орчноо бүрдүүлэх, хүмүүстэй хамтран ажиллах, амьдрах чадвартай болж хөгжих үйл явц юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар[150] Монгол Улсын иргэн ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй хэмээн заасан байдаг бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээсэн хүн бүхэнд ч уг эрх нээлттэй байна. Хорих ангид ял эдэлж буй хоригдлын уг эрхүүдийг хангахын тулд хорих байгууллагад хоригдлыг нийгэмшүүлэх ажил зохион байгуулахаар хуульчилсан байдаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн[151] 218 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын хүрээнд хоригдол хорих ангид ял эдлэх бүхий л хугацаа хамарсан, хоригдолд нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ.”, 2 дах хэсэгт “Хорих анги нь нийгэмшүүлэх ажлын мэргэшсэн нэгжтэй байх бөгөөд хоригдлыг хорих ангид хүлээн авмагц нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, түүнд үндэслэн нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө боловсруулна.” 219 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “Хоригдлыг эрх зүй мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон хүсэл, сонирхолд нь үндэслэн эерэг зан үйлд төлөвшүүлэх бусад хэлбэрээр нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулна.” хэмээн тус тус хоригдлыг хоригдох хугацаандаа, “хорих анги дах нийгэмшүүлэх” ажиллагаа явуулах талаар хуульчилсан байна. Үүнээс гадна Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын даргын 2018 оны 07 дугаар сарын 03-ний өдрийн А/129 тоот тушаалаар батлагдсан “Нийгмийн ажлын аргачилсан загвар”[152]-т зааснаар “Суллагдахын өмнө нийгэмшүүлэх ажил” буюу ялын хугацаа дуусаж, хорих ялаас хугацаанаас өмнө суллах хоригдлыг нийгмийн амьдралд гарахад нь бэлтгэх зорилгоор 3 сарын өмнө сургалтад хамруулах үйл ажиллагаа явагддаг бөгөөд үүнд:

- Нийгмийн амьдралын болон цаг үеийн мэдээллийг гарын авлага, тусгайлан бэлтгэсэн нэвтрүүлэг зэрэг бусад хэлбэрээр танилцуулах

[150] Монгол Улсын Үндсэн хууль
[151] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
[152] Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын даргын 2018 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/129 тоот тушаал

- Мэргэжлийн болон бусад сургалтад хамрагдсан бичиг баримтыг бүрдүүлэх
- Хоригдлын гэр бүлд чиглэсэн зөвлөгөө өгөх
- Суллагдсаны дараа хүлээн авах орчингүй хоригдлыг халамжийн үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагад, хөдөлмөр эрхлэх хүсэлтэй хоригдлыг хөдөлмөрийн бирж, хөдөлмөр эрхлэх газарт холбон зуучлах зэрэг үйл ажиллагаа хамаардаг байна.

Хууль сахиулах байгууллагаас гэмт хэрэг үйлдээд хорих ял эдэлсэн этгээдийг нийгэмд эргэн нэгтгэх үйл явцад туслах буюу нийгэмшүүлэх болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гэсэн үндсэн зорилгын хүрээнд хорихоос суллагдсан этгээдэд хяналт тавьж болохоор эрх зүйн зохицуулалт хийгдсэн буюу хорих ялаас хугацаанаас нь өмнө суллахдаа эдлээгүй үлдсэн ялын хугацаатай тэнцүү хяналтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хэрэгжүүлэх ба тэрхүү хяналтын хугацаа дууссаны дараагаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн байгууллага хяналт тогтоож болдог. Харин хорих ялын хугацаа нь дуусаж суллагдсан этгээдийн тухайд Эрүүгийн хуульд заасан тодорхой гэмт хэрэг үйлдэж, хоёроос дээш жилийн хугацаагаар хорих ял эдэлсэн бол суллагдсаны дараагаар цагдаагийн байгууллага 1-3 жилд хяналт тогтоохоор заасан [153].

Монгол Улсад 2018 онд нийт 12,088 хүн, 2019 онд нийт 13,011 хүн, 2020 онд нийт 13,392 хүн, 2021 онд нийт 11,263 хүн, 2022 онд нийт 14,392 хүн шүүхээр ял шийтгүүлсэн бөгөөд эдгээрээс 2018 онд 3,245 хүн, 2019 онд 3520 хүн, 2020 онд 3,679 хүн, 2021 онд 2,509 хүн, 2022 онд 2,918 хүн тус тус хорих ялаар шийтгүүлсэн байна.



2023 оны байдлаар Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх байгууллага 7,010 хүнд хорих ял эдлүүлж байгаа бөгөөд нийт хоригдлын 4,155 буюу 92,9% нь эрэгтэй,

[153] Хорихоос суллагдсан этгээдэд хяналт тавих нь. Судалгааны тойм. Нээлттэй нийгэм форум 2021 оны 04 сар

2,822 буюу 6,3% нь эмэгтэй, 33 буюу 0,7% нь насанд хүрээгүй этгээдүүд байна. Мөн эдгээрээс 44,2% нь анх удаа хорих ял эдэлж байгаа бол 55,8% нь удаа дараа хорих ял эдэлж байна. [154]

Мөн 2023 оны 4 дүгээр сарын байдлаар хорих ангиас суллагдсан 699 иргэн[155] харьяа нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын хяналтад байсан.

Хорих ял эдэлж байсан хүний хөдөлмөр эрхлэлт:

Дээр дурдсанчлан Монгол Улсад хэрэгжиж буй хорих ангиас суллагдсан хүмүүст тавих хяналт нь зөвхөн гэмт хэрэг дахин үйлдэхээс нь урьдчилсан сэргийлэх зорилгоор, хариуцсан хэсгийн цагдаа нь ярилцлага хийх замаар хэрэгждэг бөгөөд ялтны хөдөлмөр эрхлэлттэй нь холбоотой асуудалд давхар хяналт тавихгүй байгаа байдал, цаашлаад зөвхөн ял эдэлж байх хугацаанд нь тухай иргэний нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс төлөх, эрүүл мэндийн туслалцаа, үйлчилгээнд хамруулах эрх зүйн зохицуулалт, боломжоор хангаж байгаа нь учир дутагдалтай байна. Жишээлбэл: Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.5 дах хэсэгт ял эдэлж байгаа ялтны эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс сар бүр төлөхөөр заасан байдаг. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хорих ял эдэлж буй хоригдлыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбогдсон арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр заасан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд хорих ангиас суллагдсан иргэнийг “ажил олоход хүндрэлтэй иргэн”[156] хэмээн тодорхойлсон бөгөөд тус хуульд тэдгээрт чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн сургалтын төсөл хэрэгжүүлж болохоор заасан. Үүнээс гадна тус хуульд ажил олоход хүндрэлтэй иргэн зээл авах, түүнийг ажилд авсан ажил олгогчид санхүүгийн байдлаар дэмжлэг үзүүлэхээр заасан байх бөгөөд энэ нь тухайн иргэнийг ажил хөдөлмөр эрхлэх явцад нь буюу ажилд орсны дараах үе шатанд дэмжлэг үзүүлэхээр заасан харин ажил олох, зуучлахад чиглэсэн зохицуулалт дутмаг байгаа юм. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд хорих ангиас суллагдсан этгээдүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийн талаарх асуудлыг нэлээдгүй хэлэлцэж зарим төрийн бус байгууллагууд тэдгээрт чиглэсэн, ажилд зуучлах үйл ажиллагааг эрхэлж эхэлсэн бөгөөд 2022 онд 400 гаруй хорих ангиас суллагдсан хүмүүс ажилд зуучлагдсан[157] байна.

[154] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар https://uzesgelen.cd.gov.mn/wp/?page_id=206
[155] Unuudur.mn https://www.unuudur.mn/a/255310
[156] Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль 3.1.7
[157] https://mongoltv.mn/post/126089

Хэдий хорих ангиас суллагдсан хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалтын төсөл, нийгмийн халамжаас онцгой тэтгэмж олгох болон төрийн бус байгууллагууд үйл ажиллагаа явуулсан ч ажиллах хүчнээс ангид хүмүүсийн ангилалд хорих ангиас суллагдсан хүмүүс тодорхой хувиар байсаар байгаа бөгөөд зөвхөн Улаанбаатар хотын хүрээнд 2022 онд 40-44 насны 52 хүн ажиллах хүчнээс гадна байх ба 2022 оны байдлаар улсын хэмжээнд идэвхтэй ажлын байр хайдаг 40-44 насны 55 хүн засан хүмүүжүүлэх газраас суллагдсан гэх шалтгааны улмаас ажилгүй гэсэн судалгаа гарчээ. Гэсэн хэдий ч ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн хувьд аль нэг байгууллагын үндсэн орон тоонд биш байх тохиолдол их учир хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур орлоготой байдаг тул /томоохон зах, худалдааны төвүүдээр тэрэг түрэх, ачаа зөөж, буулгах гэх мэт/ эдгээр хүмүүс сайн дурааараа эрүүл мэндийн даатгалд даатгуулах нөхцөл үүсдэг. Гэсэн хэдий ч хөдөлмөр эрхлэх боломж бага байдаг тул шимтгэл төлөх нь хүндрэлтэй байсаар байна.

Шалтгаан	Аймаг	Аймгийн код	Насны бүлэг	2018	2019	2020	2021	2022
Засан хүмүүжүүлэх газраас суллагдсан	Дүн	15-19	0		0	0	0	
		Total	20-24	0		19	0	0
		Total	25-29	0		57	0	0
		Total	30-34	0		11	51	0
		Total	35-39	0		193	0	0
		Total	40-44	0		0	0	52
		Total	45-49	0		0	0	0
		Total	50-54	0		0	0	0
		Total	55-59	0		0	0	0
		Total	60-64	0		0	0	0



Үүнээс гадна Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “ejob.gov.mn”[158] буюу ажил хайгчийн ажлын туршлага, ур чадвар, чадамж, байршлыг харгалзан хүний оролцоогүйгээр системээс автоматаар ажил санал болгох, ажил хайгч, ажлын байрны нийцлийг тодорхойлох цахим системээс боловсролын түвшнийг харгалзахгүй 60 ажлын байрнаас 20 нэр төрлийн ажлын байрыг сонгон авч үзэхэд аль ч төрөлд нь ажил олоход хүндрэлтэй иргэн буюу хорих ангиас суллагдсан иргэний ажиллуулах нөхцөлтэй ажлын байр байсангүй. Харин бүрэн дунд боловсролын зэрэг шаардсан нийт 60 ажлын байрны саналаас 20 нь ажил олоход хүндрэлтэй иргэдийг авах боломжтой байсан бөгөөд эдгээрээс 17-н ажлын байрнаас нэг нь буюу кассчины ажлын байранд хорихоос суллагдсан хүнийг авахаар, дээд боловсрол шаардсан ажлын байрны 6 нь хүндрэлтэй иргэдийг ажилд авах боломжтой бөгөөд нэг нь буюу менежерийн ажлын байранд тус тус ажилд авах боломжтойгоор ажлын байр зарлагдсан байна.

№	Боловсролын түвшин харгалзахгүй ажлын байр	Бүрэн дунд боловсролын түвшин шаардах ажлын байр	Дээд боловсролын түвшин шаардах ажлын байр
1.	Жолооч	Гагнуурчин	Бичиг хэргийн ажилтан
2.	Үйлчлэгч	Үйлчлэгч	Бариа заслын сувилагч
3.	Туслах ажилтан	Үйлдвэрийн туслах ажилтан	Нягтлан бодогч
4.	Түүхийн эд бэлтгэгч	Машин засварчин, механикч	Менежер
5.	Оёдолчин	Автомашины будагчин	Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн
6.	Тогооч	Цаг уурч	Борлуулалтын байцаагч
7.	Галч	Кузов засварчин	
8.	Ажлын байрны жижүүр	Оёдолчин	
9.	Сантехникийн слесарь	Хүргэлтийн жолооч	
10.	Үйлдвэрийн туслах	Худалдааны зөвлөх	
11.	Угаагч	Хувцас чиплэгч	
12.	Бэлтгэгч	Хамгаалалтын ажилтан	
13.	Үйлчлэгч, цэвэрлэгч	Ресепшин	
14.	Барилгын туслах	Туслах ажилтан	
15.	Бармен	Кассчин	
16.	Оператор	Барилгын ажилтан	
17.	Гал тогооны үйлчлэгч	Барилгын засал чимэглэл	

Цахим хэлбэрээр тавигдсан ажлын байрны зарыг ийнхүү судлан үзвэл ажил эрхлэхэд хүндрэлтэй иргэн буюу хорих ангиас суллагдсан этгээдийн ажил хөдөлмөр эрхлэх боломж нь хязгаарлагдмал байгаа нь харагдаж байна. Хэдий судалгаагаар 55 хүн буюу цөөнх хүн засан хүмүүжүүлэх газраас суллагдсан тул

[158] https://ejob.gov.mn/jobs/19021

ажилгүй гэж хэлж байгаа ч зарлагддаг ажлын байрнууд нь хорих ангиас суллагдсан хүнийг тэр бүр хүлээж авах тохиолдол бага байна.

Дээр дурдсанчлан хорих ангиас суллагдсан хүмүүс ихэвчлэн томоохон худалдааны төвүүдэд ачаа ачих, тэрэг түрэх, барилгын хүнд нөхцөлд ажиллах зэрэг хөдөлмөрийн эрсдэлтэй, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөл хангаагүй ажил хөдөлмөр эрхэлдэг нь өдгөө нууц биш болсон билээ. Тэдгээр хүмүүст олдож буй энэ төрлийн тогтмол бус өдрөөр хийдэг ажлыг эрхэлж буй хүмүүс нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалд даатгуулалгүй ажиллах, цаашлаад татвар төлөхгүйгээр цалингаа бүтнээр авах сонирхол ихтэй байдаг. Үүнээс үүдээд тухайн хүн хөдөлмөрийн эрсдэлтэй байдлын улмаас бэртэж гэмтэх, өвчлөх тохиолдолд эрүүл мэндийн даатгалын шимтгэл тасралтгүй төлөөгүйн улмаас төрөөс санхүүжүүлэх үйлчилгээ, тусламжийг авч чадалгүй, эмнэлгийн бус аргаар эмчлэх зэрэг үйлдлүүд ажиглагдсаар байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай:

Эрүүл мэндийн даатгал нь XIX зууны II хагаст Англи, Герман зэрэг улсуудад бүрэн утгаараа хийгдэж эхэлжээ. 1883 онд анх Герман улсад эрүүл мэндийн заавал даатгалын хууль батлагдсанаар гарч ирсэн байна.[159]

Эрүүл мэндийн даатгал гэдэг нь даатгалын нэг хэлбэр бөгөөд төр, иргэн, хуулийн этгээдээс хуульд заасан журмын дагуу эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлж, эрүүл мэндийн даатгалын санг урьдчилан бүрдүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг хэлдэг.[160] Эрүүл мэндийн даатгал нь тодорхой хувиар тогтоосон хэмжээгээр шимтгэл төлж, төлсөн шимтгэлийн хэмжээнээс үл хамааран эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш эрхтэйгээр авах эв санааны нэгдлийн зарчимд тулгуурласан даатгалын төрөл юм.[161]

Монгол улсад шинжлэх ухааны эмнэлэгт тулгуурласан эрүүл мэндийн албаны үүсэл, хөгжил, түүхэн замналыг:

- 1921-1940 оны үе буюу БНМАУ-д орчин цагийн анагаах ухаанд суурилсан эрүүл мэндийн албыг бүрдүүлж эхэлсэн үе,
- 1941-1990 оны үе буюу Социалист эрүүлийг хамгаалах номлолоор замнасан үе,

[159] Монгол улс дах эрүүл мэндийн даатгалын тогтолцоог сайжруулах арга зам Г.Ариунзаяа УБ хот 2022, 21-р тал
[160] Эрүүл мэндийн даатгалын тухай хууль 2015 он
[161] Монгол улс дах эрүүл мэндийн даатгалын тогтолцоог сайжруулах арга зам Г.Ариунзаяа УБ хот 2022, 15-р тал

- 1991 оноос одоог хүртэлх үе буюу Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үеийн эрүүл мэндийн албаны хөгжил гэсэн гурван томхон үе болгон авч үзэж болох юм.[162]

Монгол улсын эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн эрүүл мэндийн, эмнэлгийн тусламж, үйлчилгээний, эм хангамжийн, анагаах ухааны боловсрол, эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа хариуцсан төрийн, хувийн хэвшлийн, холимог өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бүрдэнэ.[163]

Эмнэлгийн тусламж, үйлчилгээ[164] гэж өвчин эмгэг, гэмтэл бэртэл, хүний биеийн үйл ажиллагааны алдагдлыг орчин үеийн болон уламжлалт анагаах ухаанд тулгуурлан оношлох, эмчлэх, сувилах, хөнгөвчлөх, сэргээн засах цогц үйл ажиллагааг хэлнэ. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсанаар учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээ хуваалцах бөгөөд төрийн болон төсвийн хөрөнгөөр хувийн эмнэлгийн байгууллагаас тодорхой төрлийн эмнэлгийн тусламж үйлчилгээг авах боломжийг бий болгодог. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд зааснаар хэвтэн эмчлүүлэх, өдрийн эмчилгээ, үйлчилгээ авах, асаргаа, сувилал, сэргээн засах төв зэрэг эрүүл мэндийн байгууллагад үзүүлэх, тусламж үйлчилгээ авах, тодорхой төрийн эмийн хөнгөлөлт эдлэх, сэргээн засан эмчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ авах гэсэд 11 төрлийн эрүүл мэндийн үйлчилгээг төрийн зүгээс санхүүжүүлэн иргэд авах боломжтой.

Эдгээрээс хэвтэн эмчлүүлэх үйлчилгээний хувьд 2019 онд улсын хэмжээнд 25,661 эмнэлгийн ор ашиглалт, 2020 онд 27,083 эмнэлгийн ор ашиглалт, 2021 онд 27,080 эмнэлгийн ор ашиглалт, 2022 онд 29,629 эмнэлгийн ор ашиглалт бүртгэгдсэн байна.

Амбулаторийн үйлчилгээний хувьд 2019 онд аймгийн нэгдсэн эмнэлэгт 1.8 сая хүн, дүүргийн нэгдсэн эмнэлэгт 2.7 сая хүн, 2020 онд аймгийн нэгдсэн эмнэлэгт 1.9 хүн, дүүргийн нэгдсэн эмнэлэгт 2 сая хүн, 2021 онд аймгийн нэгдсэн эмнэлэгт 1.5 сая хүн, дүүргийн нэгдсэн эмнэлэгт 1.7 сая хүн, 2022 онд аймгийн нэгдсэн эмнэлэгт 2.3 сая хүн, дүүргийн нэгдсэн эмнэлэгт 2.8 сая хүн тус үйлчилгээг авсан байна. [165] Үүнээс харвал иргэд эрүүл мэндийн даатгалаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нь ихсэх төлөвтэй байна.

---

[162] Монгол улс дах эрүүл мэндийн даатгалын тогтолцоог сайжруулах арга зам Г.Ариунзаяа УБ хот 2022, 18-р тал

[163] Эрүүл мэндийн хөгжлийн тов “Эрүүл мэндийн үзүүлэлт, 2020” http://hdc.gov.mn/media/files/2020_WKG0S7t.pdf

[164] Эрүүл мэндийн тухай хууль

[165] Эрүүл мэндийн хөгжлийн төв “Эрүүл мэндийн үзүүлэлт, 2019, 2020, 2021, 2022” http://hdc.gov.mn/media/uploads/2020-08/2019-eruul_mendin_uzuulelt_MU_mail.indd_2020_____7___21final.pdf http://hdc.gov.mn/media/files/2020_WKG0S7t.pdf http://hdc.gov.mn/media/uploads/2022-05/ERUUL_MENDIIN_UZUULELT_2021.pdf http://hdc.gov.mn/media/files/2022.pdf

Эрүүл мэндийн даатгалын шимтгэл:

Эрүүл мэндийн даатгалын шимтгэл гэж эрүүл мэндийн даатгалд даатгуулах зорилгоор иргэн болон түүний нэрийн өмнөөс төр, хуулийн этгээд эрүүл мэндийн даатгалын санд хуульд заасан хувь хэмжээгээр төлөх төлбөрийг[166] хэлдэг. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг жил бүр харилцан адилгүй тогтоодог буюу шимтгэлийн хувь хэмжээг Үндэсний Зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4-с доошгүй хувиар жил бүр, мөн тодорхой төрлийн даатгуулагчийн[167] сард төлөх шимтгэлийн хэмжээг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1-эс доошгүй хувиар жил бүр, тодорхой төрлийн даатгуулагчдаас бусад даатгуулагчийн сард төлөх шимтгэлийн хувь хэмжээг нэг сарын хөдөлмөрийн доод хэмжээний 2-с доошгүй хувиар жил бүр[168] шинэчлэн тогтоодог бөгөөд 2023 оны хувьд Засгийн газар эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг ажилтан сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4 хувь, үүнээс ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь төлөхөөр, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч, 0-18 насны хүүхэд болон бусад даатгуулагчийн шимтгэлийн хэмжээ нь 5500 төгрөг, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, хүүхдээ 2 (ихэр бол 3) нас хүртэл нь өсгөж байгаа эх, эцэг, хугацаат цэргийн албан хаагч, ял эдэлж байгаа ялтны эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг 11000 төгрөг[169] байхаар тогтоосон байна.

Он	Ажилтан	Ажил олгогч	Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч, 0-18 насны хүүхэд болон бусад даатгуулагч	Гадаадын иргэн, харьяалалтгүй хүн, тэтгэвэрээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, хүүхдээ 2 (ихэр бол 3) нас хүртэл нь өсгөж байгаа эх, эцэг, хугацаат цэргийн албан хаагч, ял эдэлж байгаа ялтан
Хувь хэмжээ /мөнгөн дүн/				
2023	2%	2%	5500₮	11000₮

[166] Эрүүл мэндийн даатгалын тухай хууль 2015 он
[167] Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн
6.1.2-хувиараа хөдөлмөр эрхлэгч
6.1.3-малчин
6.1.5-0-18 насны хүүхэд
6.1.19-их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч
6.1.12- 6.1.1-6.1.11-д зааснаас бусад иргэн
[168] Эрүүл мэндийн даатгалын тухай хууль 2015 он
[169] Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Дугаар 500 тогтоол

2022	2%	2%	4200₮	8400₮
2020	2%	2%	4200₮	8400₮
2019	2%	2%	3200₮	6400₮
2018	2%	2%	2400₮	4800₮

Эдгээрээс харвал эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээ нь нэмэгдсэн байх бөгөөд энэ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой буюу 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 240,000 төгрөг, 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 320,000 төгрөг, 2020 оны 01 дүгээр сарын 01-нээс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 420,000 төгрөг, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш 550,000 төгрөг[170] байхаар тогтоогдсонтой холбоотойгоор нийгмийн даатгалын шимтгэл нэмэгдсэн байна.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэний улмаас эрүүл мэндийн даатгалын шимтгэл нэмэгдсэнээр тогтвортой хөдөлмөр эрхлэгч хүмүүсээс бусад хувиараа хөдөлмөр эрхлэгч нарт болон бусад байдлаар орлого олдог иргэдэд эрүүл мэндийн даатгалыг төлөхөд хүндрэл үүсэж, даатгуулагчийн тоо буурах хандлага харагдаж байна.



Эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дах хэсэгт зааснаар “Монгол Улсын иргэн эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээ хуваалцах зорилгоор эрүүл мэндийн албан журмын даатгалд заавал даатгуулна” гэж заасан байдаг бөгөөд өөрөөр эрүүл мэндийн даатгал төлөх нь 19 нас хүрсэн өдрөөс эхлэн иргэний үүрэг болдог. Эрүүл мэндийн даатгалын шимтгэл тогтмол төлснөөр өвдөөгүй ч ирээдүйд учирч болох эрсдэлээс сэргийлэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хэрэгцээт үедээ санхүүгийн эрсдэлд оролгүйгээр авах боломж гардаг.[171] Төрийн зүгээс санхүүжүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүгийн эрсдэлд орохгүйгээр авахын тулд тавигдаад буй гол шаардлага нь “эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг тогтмол, тасралгүй төлсөн

[170] https://ikon.mn/n/1rds, https://montsame.mn/mn/read/310657, https://mlsp.gov.mn/content/detail/2072
[171] https://news.mn/r/2617695/

байх” явдал юм. Гэсэн хэдий ч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өөрчлөгдөхийн хэрээр хүний хэрэгцээт бараа, үйлчилгээний үнэ, цаашлаад нийгмийн даатгал-эрүүл мэндийн даатгалын шимтгэл даган өсөж байгаа энэ үед хувиараа ажил эрхлэгч болон ажил олоход хүндрэлтэй иргэд тэр тусмаа хорих ангиас суллагдсан иргэдийн хувьд эрүүл мэндийн даатгалыг тасралгүй төлөх нь тэр бүр боломжтой бус тул эмнэлгийн тусламж, үйлчилгээ авч чаддаггүй байна.

ДҮГНЭЛТ

Эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дах хэсэгт зааснаар хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш, хүртээмжтэй үзүүлэх хэмээн хуульчилсан байдаг ч нийгмийн цөөнх буюу хорих ангиас суллагдсан хүмүүс дахин нийгэмшихэд хүндрэлтэй байдлын улмаас эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлж чадахгүй байдал үүсдэг бөгөөд үүнээс үүдэн тэдгээр хүмүүст эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хүрч чаддаггүй байна. Учир нь Монгол Улсын хорих ангиас суллагдсан иргэдэд тавьдаг хяналтын хувьд дан ганц дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлдэг, тэдгээрийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг авч үздэггүй учир дутагдалтай. Мөн зөвхөн хорих ял эдэлж байх хугацаанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээгээр хангах зохицуулалттай байдаг.

Хорих ангиас суллагдсан хүмүүсийг ажилд зуучлах зэрэг нийгэмшүүлэх ажлыг төрийн бус байгууллагууд хийдэг ч энэ нь зөвхөн ял эдэлж байх хугацаанд л хэрэгждэг, төрийн зүгээс хэдий онцгой тэтгэмж олгохоор заасан ч иргэдийн хууль эрх зүйн мэдлэг хангалтгүйгээс хамрагдаж чаддаггүй болон нийтэд зарлагддаг ажлын байрны тодорхойлолтод хорих ангиас суллагдсан хүнийг хүлээн зөвшөөрсөн байдал тун ховор байдаг байна.

Хэдий ял эдэлж буй хүнийг хорих ангид байх хугацаанд нь эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг улсаас төлдөг хэдий ч манай улсын өнөөгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нөхцөлд эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг тасралтгүй төлсөн тохиолдолд л төр зарим төрлийн эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрийг хариуцан үйлчлэхээр зохицуулалтай байгаа нь хөдөлмөр эрхлэх боломж хомс эдгээр хүмүүст хүндрэл учруулсаар байгаа бөгөөд цаашлаад гэр оронгүй болох боломжийг мөн бүрдүүлээд байгаа тул дараах саналыг гаргаж байна:

1. Хорих ангиас суллагдаж буй хүмүүст тавих хяналтыг дан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор бус тухайн хүний хөдөлмөр эрхлэх боломжийг хангаж өгөх зорилгоор мөн хэрэгжүүлэх.
2. Хорих ангиас суллагдаж буй хүмүүст хамрагдаж болох үйл ажиллагаа, тэтгэмжийн талаар эрх зүйн мэдлэг олгох
3. Эрүүл мэндийн даатгалаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахад тасралтгүй шимтгэл төлсөн байх шаардлагыг өөрчлөн тухайн шимтгэл төлсөн оны туршид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үнэгүй авах боломжийг бүрдүүлэх

4. Ажил олгогчдын зүгээс боловсролын зэрэг харгалзахгүй ажлын мэргэжлийн төрөлд хорих ангиас суллагдсан хүмүүсийг хамруулах тухай анхаарах

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Эрүүл мэндийн тухай хууль
3. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
4. Эрүүгийн хууль
5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль
6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
7. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
8. Хорих байгууллага дах нийгмийн ажил. 2015 он
9. Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын даргын 2018 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/129 тоот тушаал
10. Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Дугаар 500 тогтоол
11. Хорихоос суллагдсан этгээдэд хяналт тавих нь. Судалгааны тойм. Нээлттэй нийгэм форум 2021 оны 04 сар
12. Монгол улс дах эрүүл мэндийн даатгалын тогтолцоог сайжруулах арга зам Г.Ариунзаяа УБ хот 2022
13. Үндэсний Статистикийн хороо Шүүхээр ял шийтгүүлсэн хүн https://www.1212.mn/mn/statistic/statcate/573071/table-view/DT_NSO_2300_037V21
14. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар https://uzesgelen.cd.gov.mn/wp/?page_id=206
15. Unuudur.mn https://www.unuudur.mn/a/255310
16. https://mongoltv.mn/post/126089
17. Үндэсний Статистикийн хороо https://1212.mn/mn/statistic/statcate/573055/table-view/DT_NSO_0400_036V1
18. https://ejob.gov.mn/jobs/19021
19. Эрүүл мэндийн хөгжлийн төв “Эрүүл мэндийн үзүүлэлт, 2019, 2020, 2021, 2022”
20. http://hdc.gov.mn/media/uploads/2020-08/2019 eruul_mendin_uzuulelt_MU_mail.indd_2020_____7___21final.pdf
21. http://hdc.gov.mn/media/files/2020_WKG0S7t.pdf
22. http://hdc.gov.mn/media/uploads/202205/ERUUL_MENDIIN_UZUULELT_2021.pdf http://hdc.gov.mn/media/files/2022.pdf
23. https://ikon.mn/n/1rds,https://montsame.mn/mn/read/310657, https://mlsp.gov.mn/content/detail/2072
24. Үндэсний Статистикийн Хороо эрүүл мэндийн даатгалд даатгуулагчид https://www.1212.mn/mn/statistic/statcate/48171317/table-view/DT_NSO_2100_033V2
25. https://news.mn/r/2617695/

НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙХ ЯЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

RESULT ANALYSIS OF COMMUNITY BASED SENTENCE ENFORCEMENT



Ч.Нансалмаа
ДХИС-ийн Удирдлагын академийн 8013 дугаар дамжааны суралцагч, ахлах дэслэгч

Товч утга: Монгол улсын Эрүүгийн тухай хуульд заасан нийтэд тустай ажил хийх ялын хэрэгжилтийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага зургаан жилийн хугацаанд хэрхэн хэрэгжиж ирсэн болон ялын хэрэгжилтийг бүрэн биелүүлэхэд онол, практик хэрхэн уялдахгүй хүндрэл тулгарч байгаад дүгнэлт хийж, цаашид эрүүгийн хуулийн ялын биелэлтийг бүрэн хангах, ялын хэрэгжилт үр дүнтэй байх эрх зүйн орчин нөхцөлийн бүрдүүлэх боломжийг эрэлхийлэх юм.

Abstract: The judicial body will evaluate the difficulties of theory and practice in fully implementing the applications of the judiciary over a period of six years, and will seek the possibility of creating a judicial environment where juvenile law enforcement is fully implemented and effective.

Түлхүүр үгс: Ял, ялын төрөл, хуулийн цоорхой ба хийдэл, хариуцлага

Key words: sentence, legal loopholes and abstracts, accountability.

ОРШИЛ:

Монгол улсын төрт ёсны түүхэн уламжлалын үе бүрд хууль бус үйлдэл, эс үйлдэхүйг үйлдсэн хэн бүрд хариуцлага тооцож, шийтгэдэг тогтолцоо байсаар ирсэн. Их засаг хуулиас өнөөгийн мөрдөгдөж байгаа эрүүгийн хуульд заасан хориглосон үйлдэл, эс үйлдэхгүйг үйлдсэн хэн бүрд хуульд заасан ял оногдуулж байгаа нь нөгөөтээгүүр шударга ёсны зарчимд нийцэхүйц бодлого юм. Эрүүгийн хуулийн шинэчлэн найруулсан 2002 оны эрүүгийн хуульд шинэ нэршлээр тусгагдсан “Нийтэд тустай ажил хийх ял” нь гагцхүү гэмт хэрэгтнийг цээрлүүлэхээс гадна нийгэмд үр ашигтай үр дүн өгөхүйц ялын санкц байснаараа ач холбогдолтой. Гагцхүү уг ялыг хэрэгжүүлэх процесс ажиллагаанд тулгарч байгаа зарим асуудлыг энэ илтгэлд тусгахыг зорилоо. Нийтэд тустай ажил хийх ялыг хэрэгжүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд засаж сайжруулах асуудлыг хөндсөнөөр цаашид энэ ялын хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэх, илүү үр

ашигтай нөхцөлийг бүрдүүлснээр нийгэмд ач тустай гэж үзлээ. “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 7 дугаар зорилтын 7.4.8-д “Ял шийтгэгдсэн хүнийг нийгэмшүүлэх, суллагдахад бэлтгэх, нийгмээс тусгаарлахгүйгээр ялын бодлогыг хангах зорилгоор “Цахим хяналтын төв”-ийг байгуулж, пробацийн тогтолцоог хөгжүүлнэ” (2050, 2020) хэмээн тусгасан нь хорихоос өөр төрлийн ял нийтэд тустай ажил хийх ялын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, цаашид засан сайжруулах, хувь хүний эрх ашгийг хохироохгүйгээр ял эдлүүлэх, нийгэмд эерэг үр дагаврыг бий болгох нөхцөлийг бүрдүүлэх нөхцөл боломжийг эрэлхийлэх үндэслэл болж байна.

НЭГ: МОНГОЛ УЛСЫН ЯЛЫН БОДЛОГО, ЯЛЫН ТӨРӨЛ

1.1 Ялын түүхэн өөрчлөлт, түүний бодлогын чиг хандлага

Эртний нийгэмд ял шийтгэл нь гэм буруутай хүнд “Нүдийг нүдээр амийг амиар” гэх Талионы зарчим эртний Вавилон болон бусад хуулиудад тусгагдан хэрэгждэг байв. (А.Алтанзул, 2007). Дундад зууны үед бие мах бодиор бус эд зүйлээр орлох зүйлээр ял шийтгэлийг оногдуулдаг байсан нь “Төсөөллийн зарчим”-ын үзэл баримтлал байсан байна. Энэ үед гэм буруутай үйлдэлд тарчлаах бус хохирлыг нөхөн төлүүлэх зарчмыг илүүд үздэг. Тухайн үед торгох эрх зүйн хэм хэмжээнд ял болон тусгагдсан гэж үздэг. Германы нэрт сэтгэгч Гегель гэмт хэргийн ялын мөн чанарыг харьцуулан судалсан бүтээлдээ “Хэрэв тухайн нийгмийн байдал тогтворгүй байвал ял шийтгэлийн тусламжтайгаар нийгмийг айлгах жишиг тогтдог, харин нийгэмд итгэх итгэл хүчтэй байх байдал нь ял шийтгэлийг зөөлрүүлдэг учиртай” (Г.Г.Ф.Гегель) гэсэн үзэл баримтлалыг тусгасан байна.

Түүхэн уламжлалаар нэр томьёоны хувьд:

Киргизийн эрх зүйд “нийтийн ажилд татан оролцуулах”, “нийгэмд үнэ хөлсгүй үйлчлэх”, Гүржийн хуульд “нийгэмд ашигтай хөдөлмөр эрхлэх”, Молдавд “нийтийн тусын тулд үнэ хөлсгүй ажиллах”, Латвийн хуульд “албадан хөдөлмөр хийх”, Францад “нийтийн ашиг сонирхлын төлөө ажил хийх”, Спанид “нийгмийн тусын тулд ажиллах”, ОХУ, Голланд, Украинд “нийгмийн хөдөлмөр буюу заавал хийх ажил хийх” ял гэж нэрлэгдэн иржээ. Эдгээрээс үзвэл гадаадын зарим улс орнуудад нийтэд тустай ажил хийх ялын мөн чанар гол утга агуулга нь тухайн нийгэмдээ үр ашигтай, үнэ хөлсгүй ажил хийлгэх, энэ ажил хөдөлмөрийн үр дүн нь нийгмийг сайн сайханд чиглэсэн байхаас гадна заавал хийж гүйцэтгэх үүрэг бүхий байсан байна. Монгол улсын ялын бодлого Хамаг монголын хаадын зарим ноёд 1189 онд Тэмүүжинийг хаанаар өргөмжилснөөр анхны төрт улсын зохион байгуулалтад шилжиж, монголчуудын зан заншлын буюу хэв хууль бий болж эрх зүйт тогтолцоо үүссэн гэж үздэг. Чингис хаан 1206 онд Их засаг хуулийг батлан гаргаж, уг хуульд эхэс дээдэс, энгийн ард иргэд хуулийн өмнө эрх тэгш хариуцлага хүлээдэг байхаар заасан. Тухайн үеийн нийгэмд монголчуудын дунд хулгай хийх, бусдыг дээрэмдэх, ядуусыг тэтгэхгүй байх, ар иргэд хаад ноёдоо хүндэтгэхгүй байх зэрэг аливаа харилцаа бүрийг хуульчлан тусгаж өгсөн байдаг. Монголын үе

үеийн эрх зүйн баримт бичгүүдэд биеийн хүчний хүнд хүчир ажил хийлгэх, түлээ түүлгэх, ус дамнуулах зэрэг ажил хийлгэж ял эдлүүлдэг байсан тухай тэмдэглэн үлдээсэн байдаг бөгөөд 1975 оноос эрх зүйн орчин үеийн чиг хандлага бий болж албадан ажил хийлгэх гэх нэршлээр эрх зүйн баримт бичигт тусгагдсан түүхийн эх сурвалж байна.

Эрүүгийн хууль 2002 онд батлагдаж, 12 бүлэг, 31 хэсэг 305 зүйлтэй Эрүүгийн хуулийн 46 дугаар зүйлд Ялын төрөлд:

- Торгох
- тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах;
- эд хөрөнгө хураах
- албадан ажил хийлгэх
- баривчлах
- хорих
- цаазаар авах ял багтсан.
- Үүний дараагаар 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр 30 бүлэгтэй Эрүүгийн хууль батлагдаж, 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн хуулийн 5.2 дугаар зүйлд ялын төрлийг
- Торгох ял
- Нийтэд тустай ажил хийх ял
- Зорчих эрх хязгаарлах ял
- Хорих ял
- Эрх хасах ял хэмээн хуульд тусгасан одоогийн нэршлийн эрх зүйн үндэс болон хэрэгжиж байна.

ХОЁР: НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙХ ЯЛЫН БИЕЛЭЛТИЙГ ХАНГАХ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.1 Нийтэд тустай ажил хийх ялын биелэлтийг хангах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

Нийтэд тустай ажил хийх ял шийтгүүлсэн ялтанд зохион байгуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 162, 163, 164, 165, 166 дугаар зүйлүүдэд заасны дагуу зохион байгуулахаар хуульчилсан.



Хүснэгт 1. Нийт ял шийтгүүлсэн хүний дотор нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн хүний тоон мэдээ

Тоон мэдээнээс дүгнэвэл нийтэд тустай ажил хийх ял шийтгүүлсэн ялтны тоо 2021 онд 19.1 хувь, 2022 онд 25.9 хувиар тус тус жил бүр өссөн дүнтэй байна (https://www.ncs.cd.gov.mn/, 2024).

Иймээс хорихоос өөр төрлийн ялын энэ төрлийг хэрхэн үр ашигтай зохион байгуулах талаар нухацтай тунгаан бодвол олон талын үр өгөөжийг бий болгож, нийгэмд, тухайн ялтанд ч ашигтай, хүний эрхийг хохироохгүй байх боломжийг бүрдүүлж болох юм.

2.2 Нийтэд тустай ажил хийх ялын биелэлтийг хангах шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ

Монгол улсын эрүүгийн хуульд заасан ялын нэгэн төрөл болох нийтэд тустай ажил хийх ялын хэрэгжилтийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 162, 163,164,165,166 дугаар зүйлд заасны дагуу хууль журмын дагуу хэрэгжүүлж байгаагаас тухайлан авч үзвэл:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 163 дугаар зүйлийн 163.1-д шүүхийн шийдвэрт тусгайлан заагаагүй тохиолдолд нийтэд тустай ажлыг нутгийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагаас баталсан жагсаалтад заасан байгууллагад гүйцэтгэнэ (мэдээлэл, 2017) гэж заасан бөгөөд уг жагсаалтад зөвхөн төрийн байгууллагад ял эдлүүлэхээр заасан байгаа. Энэ нь нийгэмд зөвхөн нэг чигийг харсан сонголтгүй сонголт буюу тухайн ял эдэлж байгаа ялтны болон нийгмийн бусад ялангуяа гарааны бизнес эрхэлж байгаа иргэд хувийн хэвшлийн байгууллагын эрх ашигт тус дэм болох боломжгүй нөхцөлийг бий болгож байна. Уг ялын мөн чанар нийтийн сайн сайхны төлөөг анхаарах нь зүйтэй.

2.Мөн хуулийн 163 дугаар зүйлийн 163.6-д шийдвэр гүйцэтгэгч нь ялтныг шүүхийн шийдвэр, ажил хийлгүүлэх тухай мэдэгдлийн хамт ажил хийлгэхээр тогтоосон байгууллагад биечлэн хүлээлгэж өгнө гэж заасан. Мэдээлэл технологийн хөгжил, төрийн байгууллагын үйл ажиллагаанд цахим технологи нэвтэрч байгаатай холбоотой алслагдсан сум, орон нутагт ял эдлэх ялтны хувийн зан байдлыг харгалзан ялтан хүлээлцэх ажиллагаанд технологийн дэвшилтийг нэвтрүүлэх нь зүйтэй. Энэ нь цаашлаад шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал хэмнэх, хамтран ажиллаж байгууллага хоорондын хамтын ажиллагаанд эерэг үр нөлөөтэй юм.

3. Ялтны хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөө авах эрхийг зөвхөн гэр бүлийн гишүүн хүндээр өвчилсөн, нас барсан, гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон бол долоо хүртэлх хоногийн чөлөөг тухайн ял эдэлж байгаа газар хэлтсийн даргын шийдвэрээр олгоно гэж заасан нь учир дутагдалтай байна. Энэ нь тухайн хүний өөрийн эрүүл мэндэд гэнэтийн өвчин эмгэг тусах, зайлшгүй бусад шалтгаан тохиолдох үед чөлөөний асуудал шийдэгдэхгүй, ялтны эрх зүйн байдлыг ноцтой зөрчсөн гэж үзэж болохоор. Тухайлбал эрүүл мэндийн байдал шалтгаант өвчин, өвчлөл үүссэн, ахуй амьдралд хууль зааснаас бусад шалтгаан үүссэн тохиолдол

үүссэн үед чөлөө олгох ажиллагаа хуулиас гадуур үлдсэн байж болох юм. Нөгөөтээгүүр ялтан тухайн ял эдэлж байгаа нутаг дэвсгэрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга чөлөө субъект байх нь зөв эсэх нь бас хугацаа алдах, төрийн үйлчилгээ түргэн шуурхай байх зарчимд зохимжтой эсэх гээд бодох асуудал юм.

4.Шийдвэр гүйцэтгэгч долоо хоног тутам биечлэн шалгана гэдэг нь хуулийн тусгалаар ойлгоход долоо хоног тутам гэсэн үг. Энэ нь давтамжтайгаар шалгах гэж ойлголт. Долоо хоног тутам шалгах нь ялтан ажил олгогч байгууллагын хууль зөрчих боломжийг бүрдүүлэх нөхцөл юм.

5.Ялтны ял солих үндэслэлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 165 дугаар зүйлийн 165.1-д ял эдлүүлэх нийт хугацаанд ажлаа дур мэдэн орхисон, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлаа тасалсан гэх шалтгаан нь хуулийн нэг мөр ойлголт бус юм. Өмнө нь дурдсанаар хуульд заасан чөлөө олгох нөхцөлөөс бусад шалтгаан үүсэж чөлөө хүссэн ялтанд хуулийн зохицуулалт танилцуулан ажлаа хийх шаардлага хууль ёсны дагуу тавихад ажилдаа ирээгүй ялтанд хүндэтгэн үзэх шалтгаангүй ажил тасалсан гэх шалтгаанаар зөрчлийн акт үйлдэх, цаашлаад ял солих санал хүргүүлэх нь хэт хатуу зарчим юм.

6. Нийтэд тустай ажил хийх ял шийтгүүлсэн ялтан ял эдэлж байх хугацаандаа болон шүүхийн шийдвэр гарснаас хойш ял эдлүүлэх ажиллагаанаас санаатай зайлсхийсэн тохиолдолд эрэн сурвалжлах ажиллагааг зохион байгуулж, ялтныг олж тогтоон ял солих шүүх хурал хүртэлх хугацаанд ялтан гадуур сул чөлөөтэй явж байдаг бөгөөд дахин ял эдлүүлэх ажиллагаанаас оргон зайлах эрсдэл өндөр. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны хяналтаас санаатай оргон зайлсан ялтныг хорих ял солих шүүх хурал болох хүртэлх хугацаанд саатуулах эрх зүйн зохицуулалт байхгүй.

ДҮГНЭЛТ

Эрт үеэс хэрэгжиж ирсэн эрүүгийн ялын бодлого хүний үйлдсэн бусдад хор уршигтай үйлдэлд нь тохирсон хариуцлага хүлээлгэдэг байсан. Хууль зөрчсөн үйлдэл хийсэн хүн бүр албан тушаал, хаад ноёд, энгийн ард иргэд хэн ч байсан хариуцлага хүлээдэг тогтолцоо хуучин хуулиудад оршин тогтнож байсан. Түүхэн цаг үеүд бүрд энэ ялын хэрэгжилтийн гол зорилго, мөн чанар нийгэмд эерэг үр нөлөөг бий болгох зорилгыг агуулж байсан нь илт байна. Одоогийн мөрдөгдөж байгаа хуулийн зорилго ч нэгэн адил нийгмийн сайн сайханд чиглэсэн, цаашлаад олон улсын чиг хандлагыг баримтлах, түүнийг өөрийн хууль тогтоомж, эрх зүйн орчинд нутагшуулахад чиглэсэн байна. Эдгээрээс дүгнэж дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

-Нийтэд тустай ажил хийх ялын хэрэгжилтийг хангах зорилгоор зөвхөн төрийн байгууллагад ажиллуулах нь учир дутагдалтай. Нийгмийн сайн сайхны төлөө гэх гол үзэл баримтлалыг алдахгүй ялын хэрэгжилтийг хангахын тулд гарааны бизнес эрхлэгч аж ахуйн нэгж, хувь хүнтэй гэрээ байгуулан ялтан

ажиллуулах нь нийгмийн эдийн засгийн болон төрийн жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих бодлогын хүрээнд ихээхэн үр ашигтай юм. Энэ нь цаашлаад тухайн ялтанд ажил хөдөлмөр эрхэлж санхүүгийн эх үүсвэртэй болох, хамт олны эерэг хандлага нөлөөлж, хүмүүжил, хандлага, үзэл бодолд эергээр нөлөөлөх үр дүнг бий болгох магадлал өндөр юм. Төрийн байгууллагад цаг гүйцээж хамаг хар бор ажил хийх бус хөдөлмөрийн чиг баримжаа олох, мэдлэг боловсролоо дээшлүүлэх, өөрийн амьдрал, ажил хөдөлмөрийн ач тусыг харах өнцөгт нөлөөллийн үйл ажиллагааг бий болгох нь ялтны хувийн байдалд гол нөлөөлөл юм. Цаашлаад ажил олгогч байгууллага ажилтан хоёрыг холбох холбоос болох ч үр дүн үүсэж болох юм.

-Алслагдсан суманд ял эдлэх ялтныг заавал биечлэн хүлээлгэн өгч байгаа нь одоогийн технологийн дэвшлийг нэвтрүүлсэн төрийн үйл ажиллагаанд нийцэхгүй байна. Иймд ялтны хувийн байдалд дүн шинжилгээ хийж, зарим тохиолдолд цахим технологи ашиглаж ялтан хүлээлцэх ажиллагааг зохион байгуулах нь ажиллагааны зардал, алба хаагчийн ажлын ачааллыг хөнгөвчилсөн зохицуулалт болно.

-Нийтэд тустай ажил хийх ял шийтгүүлсэн ялтан шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 164 дүгээр зүйлийн 164.4-д зааснаар бусад шалтгаанаар тодорхой цаг, хоногоор чөлөө авах зайлшгүй нөхцөл бий болсон тохиолдолд чөлөө олгох асуудал шийдвэр гүйцэтгэх ажиллагааны практикт хуулиас гадуур зохицуулагдаж байгаа. Энэ нь хяналт тавьж байгаа байгууллага болон ялтанд аль алинд нь эрсдэл бүхий үйл ажиллагаа юм Нийтэд тустай ажил хийх ял шийтгүүлсэн ялтанд чөлөө олгох хуулийн зохицуулалтыг эргэн сайтар тунгааж, “бусад шалтгаан” нөхцөлийн талаар хуульд тусгаж, гурав хүртэлх хоногийн чөлөөг хяналт тавьж байгаа шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн ахлах шийдвэр гүйцэтгэгч олгох эрх зүйн зохицуулалтыг хуульд шингээж өгснөөр ялтны эрхийг хүндэтгэн үзэж ял эдлүүлэх ажиллагаа хүнлэг энэрэнгүй байх зарчимд нийцэж, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа түргэн шуурхай хуулийн дагуу хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

-Шийдвэр гүйцэтгэгч нийтэд тустай ажил хийх ял шийтгүүлсэн ялтныг долоо хоног тутам биечлэн шалгана гэх заалтын утга агуулгын хувьд өөрчлөх нь зөв. Долоо хоног тутам гэдэг тогтсон давтамжит хугацаа гэж ойлгогдож байна. Иймд ажлын долоо хоногт нэгээс доошгүй удаа гэж утга агуулгын хувьд өөрчлөх нь зүйтэй. Давтамжтай шалгах нь ялтныг ял завшуулах боломжийг бүрдүүлэх боломжтой юм.

-Ял эдлүүлэх ажиллагаанаас санаатай зайлсхийсэн ялтныг шүүх хорих ял солих саналыг шийдвэрлэх шүүх хурал болох хүртэлх хугацаанд саатуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх.

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 165 дугаар зүйлийн 165.1-д заасан ял солих үндэслэлд “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлаа тасалсан” гэх ойлголт нэгдсэн нэг ойлголт бус байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 164 дүгээр зүйлийн 164.4-д заасан зөвхөн гэр бүлийн гишүүн хүндээр

өвчилсөн, нас барсан, гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон гэж заасан гэж болно. Монгол улсын эрүүгийн хуульд заасан гэм буруутай үйлдэл хийж, шүүхээс ял шийтгүүлсэн ялтан хэдий ч уг хүний амьдрал ахуйг харгалзан үзэх нь зайлшгүй хүний жам ёсны эрхийг хангах нэгэн хэлбэр юм. Хариуцлага хүлээлгэнэ, хорих ял солино гэж айлган сүрдүүлэх бус нийгэмд нь нийгэмшүүлэн, харилцаа хандлага нь эерэг нөлөөллийг үзүүлэх нь хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны гол амин мөн чанар. Тиймээс хүндэтгэн үзэх шалтгаангүй гэдэг ойлголтын эсрэг талын ойлголтыг ял эдлэх хугацаанд чөлөө олгох нөхцөл журмыг боловсронгуй болгосноор хангах юм. Эрүүгийн хуульд зааснаар хамгийн бага цаг буюу 240 цагийн ял эдлэхэд тухайн ялтан 30 хоног буюу ажлын тав хоногт найман цагаар тооцвол зургаан долоо хоног буюу сар гаруй хугацаанд ял эдэлнэ. Ажил хөдөлмөр эрхэлдэг ялтны хувьд ажлаас халагдах, ахуй амьдралд санхүүгийн сөрөг нөлөө үзүүлэх гэх мэт нэг ялын хэрэгжилтийг хангахын тулд давхар хохирол хүлээх боломжтой. Иймд ажил хөдөлмөр эрхэлдэг байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан цалин хөлсгүй ажиллуулж, ажлаас халагдахгүй байх боломжийг бүрдүүлэх нь монгол улсад нутагшуулахаар судалж байгаа Пробацийн тогтолцооны үзэл санаанд нийцсэн чиг хандлага юм. Энэ нь цаашлаад Алсын хараа- 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан үйл ажиллагаа болох юм.

Аливаа асуудлыг жижиг хэмжээний гэж хойш тавин үл ойшоолгүй, зарчмын асуудлыг шийдвэрлэж байх нь цаашдаа томоохон үйл хэргийн үндэс, суурь болж болох юм. Монгол улсад хорихоос өөр төрлийн ял хэрэгжиж эхэлсэн хугацаанаас одоог хүртэлх хугацааны туршлагыг онол, практиктай хослуулан дүн шинжилгээ хийн цаашид хэрхэн зөв замаар зөв хөгжүүлж, нийгэмд үр дүнтэй тусгаж, нутагшуулах цаашдын үйл хэрэгт нэн чухал юм.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Төрийн мэдээлэл, Т. (2017). Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.
2. Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого
3. А.Алтанзул. (2007). Албадлагын арга хэмжээ, ял. Улаанбаатар.
4. Г.Г.Ф.Гегель. (n.d.). Фильсофия прова.
5. https://www.ncs.cd.gov.mn/. (2024). Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба.

ХОРИГДЛЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

EXPERIENCE AND LEGAL REGULATION OF SOME FOREIGN COUNTRIES REGARDING PRISONER LABOR



П.Жамбажамц
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 441 дүгээр нээлттэй хорих ангийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан, хошууч

Товч агуулга: Хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг улс орны бүтээн байгуулалтад түлхүү чиглүүлэн, хоригдолд хөдөлмөрийн дадлага, мэргэжил олгох замаар нийгмийн харилцаанд бие даан оролцох чадвартай болгон төлөвшүүлэх, суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэхийг бууруулах зорилготой зохион байгуулдаг.

Хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар улс орон бүр харилцан адилгүй арга хэмжээ авч үздэг болох нь тэдгээрийн эрх зүйн зохицуулалтаас харагдана. Зарим улсад албадан хөдөлмөрийг хуулиараа зөвшөөрдөг бол зарим улс тэдний хөдөлмөрийг хөдөлмөрийн эрх чөлөөний зарчимд нийцэх ёстой гэж үздэг байна.

Abstract: Prisoner employment is organized with the aim of developing the ability to independently participate in social relations by providing labor practices and professions, focusing more on the development of the country, and reducing recidivism after release.

Each country takes different measures regarding the employment of prisoners, as can be seen from their legal regulations. Some countries allow forced labor by law, while others consider that their labor must conform to the principle of freedom of labor.

Түлхүүр үг: Хоригдол, хөдөлмөр, эрх зүйн зохицуулалт, цалин

Key word: Prisoners, labor, legal regulation, wages

ҮНДСЭН ХЭСЭГ

Хорих ял эдлүүлэх чиглэлээр НҮБ-аас гаргасан зарим эрх зүйн баримт бичгийн агуулгыг тусгайлан авч үзэх нь НҮБ-ын гишүүн орны ял эдлүүлэх бодлого, хэрэгжилтийг дэлхийн жишигт ойртуулах ач холбогдолтой юм. Хорих ял эдлүүлэхэд чиглүүлэн НҮБ-аас гаргасан эрх зүйн баримт бичигт:

Хэрэгтэн, ялтантай харьцах наад захын жишиг дүрэм /1955/

Хоригдолтой харьцах үндсэн зарчим /1990/

Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах дүрэм /1990/-үүд хамаарагддаг байна.

Мөн хорих ял эдлүүлэх байгууллагын ажилтнуудаас хоригдолтой харьцах үндсэн зарчмыг НҮБ-ын Ерөнхий ассамблейн чуулганы 1990 оны 45/111 дүгээр тогтоолоор батлан гаргажээ. Энэ үндсэн зарчимд бүх хоригдлыг заяасан нэрээр нь дуудаж, эрдэнэт хүнийх нь хувьд хүндэтгэн харьцаж байх, тэднийг яс үндэс, арьс өнгө, нас, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад итгэл үнэмшил, нийгмийн гарал, эд хөрөнгийн байдлаар ялгаварлан гадуурхахгүй байх, түүнчлэн орон нутгийн нөхцөл байдал шаардагдаж байвал тухайн хэсэг бүлэг хоригдлуудын шашны итгэл үнэмшил, соёлын зан заншлыг хүндэтгэх зэрэг зарчим хамаарагддаг байна.

НҮБ-аас батлан гаргасан дээрх зарчимд хамаарагдах нэг чухал зүйл бол хорих ял эдэлж байгаа хүмүүс олон нийтийн болон нийгмийн байгууллагуудын оролцоо тусламжтайгаар хохирогчийн ашиг сонирхлыг хохироохгүйгээр аль болох зохистой байдлаар нийгмийн амьдралд эргэн орох таатай нөхцөлийг бий болгох тухай заасан явдал юм.

НҮБ-аас батлан гаргасан ногоо нэг эрх зүйн баримт бичиг бол хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах дүрэм юм. Энэ дүрмийн зорилго нь аливаа хэлбэрээр хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах хүний эрх, үндсэн эрх чөлөөний дагуу бүх төрлийн хорих ялын тааламжгүй үр дагаврыг багасгаж, нийгмийн амьдралд татан оролцуулах зорилгоор НҮБ-аас баталсан наад захын хэм хэмжээнүүдийг тогтооход оршдог байна.

Америкийн нэгдсэн улс /ану/

АНУ-д бүхэлдээ болон муж улсуудад хорих ял эдлүүлэх ажлыг хэрэгжүүлэхэд олон янзын дүр зураг байна. Эрүүгийн ба засан хүмүүжүүлэх байгууллагуудын хууль тогтоомжууд нь АНУ-ын хуулийн системийн онцлогийг тусгасан байна. Хорихоос бусад төрлийн шийтгэлийн шийдвэр гүйцэтгэлийг эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх төрлийн актуудаар зохицуулдаг бол хорихтой холбоотой шийтгэлийг пенитенциар нормоор зохицуулна. Хорих ялыг засан хүмүүжүүлэх байгууллагуудад эдлүүлэх бөгөөд системд нь холбооны шоронгууд болон орон нутгийн хорих ангиуд багтана. Холбооны пенитенциар систем нь аюулгүйн төвшнөөр ангилсан 4 төрлийн байгууллагаас бүрдэнэ. Минимал аюулгүй, дунд зэргийн аюултай, максимал аюултай, онцгой аюултай гэж ангилна.

Минимал аюултай хорих анги нь нээлттэй хэлбэрийн байгууллага бөгөөд зэвсэгт хамгаалалт байхгүй ба хоригдлууд нь хорих ангиас гадуур ажиллах

боломжтой байна. Харин дунд зэргийн аюултай хорих анги нь хаалттай хэлбэрийн байгууллага бөгөөд зэвсэгт хамгаалалттай байна. Хоригдлуудыг хорих ангиас гадуур ажил хийлгэхээр гаргаж болно. Максимал аюултай болон онцгой аюултай хорих ангиудад хүнд гэмт хэрэгтнүүдийг хорих ба хоригдлыг хатуу дэглэмээр хорино. Хоригдол нь хорих ангиас гарч болохгүй, хөдөлмөр эрхлүүлэхийг зөвшөөрдөггүй байна. Орон нутгийн хорих анги нь нийгмийн хэв журам зөрчсөн, жижиг хэмжээний хулгай хийсэн зэрэг хамгийн аюул багатай хэрэгтнүүдэд зориулагдсан ба маш олон төрөл байх тул ангилах боломжгүй байдаг.

АНУ-д хоригдлын хөдөлмөр эрхлэх асуудлыг 1973 оны 11755 (1987 онд 12608 дугаар хуулийн дэд актаар нэмэлт оруулсан), 1994 оны 12943 дугаар хуулийн дэд актуудаар зохицуулсан байдаг. Эдгээр хуулийн дэд актаар ажил олгогч дараах этгээдүүдтэй хөдөлмөрийн гэрээ байгуулахыг хориглоогүй байна. Үүнд:

1. Хугацаанаас өмнө суллагдсан болон туршилтын хугацаанд байгаа этгээд
2. Өршөөгдсөн болон хугацаат ялаа эдлээд гарсан этгээд
3. Холбооны шоронд ял эдэлж буй хоригдол
4. Холбооны биш оронд ял эдлэгч зэрэг хүмүүс цалин хөлстэй хөдөлмөр эрхлэхийг зөвшөөрнө.

АНУ-д UNICOR нэрээр нийтэд танигдсан байгууллага нь 1934 онд холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан төрийн өмчит корпорац бөгөөд Холбооны шоронгийн товчооны хоригдлуудын хөдөлмөрийг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлдэг. Уг корпорацын гол зорилго нь хоригдлуудад ажил олгох, зах зээлийн үнээр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бие даан ажиллах юм. Уг байгууллага нь хоригдлыг хөдөлмөр хийлгэхээр албадаж болохгүй бөгөөд хөдөлмөр эрхлэх эсэх нь зөвхөн сайн дурын үндсэн дээр байна. UNICOR нь эдийн засгийн хувьд бүрэн бие даасан байгууллага бөгөөд улсаас ямар нэг санхүүжилт авдаггүй.[172]

Оросын холбооны улс /оху/

Хоригдлыг хөдөлмөр эрхлүүлэх асуудлыг ОХУ-ын эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль, Хөдөлмөрийн хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгэм хамгааллын тухай хуулиар тус тус зохицуулагддаг байна. ОХУ-ын Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулийн 14 дүгээр бүлэгт Хорих ял эдэлж буй хоригдлыг хөдөлмөрт хамруулах талаарх дараах зохицуулалтуудыг заасан байна.

103 дугаар зүйл. Хоригдлыг хөдөлмөр эрхлүүлэх

[172] “Хоригдлын хөдөлмөр зохион байгуулалтын талаарх түүх-онолын үзэл баримтлал” О.Серикбол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны эрх зүйн шинэтгэл ЭШХ-2021 он

1. Бүх хоригдлууд хоригдож байх хугацаандаа хорих газрын захиргаанаас тодорхойлсон ажлын байранд хөдөлмөр эрхлэх үүрэгтэй. Хорих ангийн захиргаа нь хоригдлын нас, хүйс, хөдөлмөр эрхлэх чадвар, эрүүл мэндийн байдал, ажлын байрнаас хамаарч тэднийг хөдөлмөр эрхлүүлэх үүрэгтэй.
2. 60-аас дээш настай эрэгтэй, 55-аас дээш настай эмэгтэй мөн хөгжлийн бэрхшээлийн 1,2 дугаар групптэй хоригдлыг өөрсдийнх нь хүсэлтээр холбогдох хууль тогтоомжийн дагуу хөдөлмөр эрхлүүлнэ.
3. Насанд хүрээгүй хоригдлыг мөн ОХУ-ын хөдөлмөрийн хуульд заасны дагуу хөдөлмөр эрхлүүлнэ.
4. Хоригдлыг хуульд заасны дагуу хорих газрын нутаг дэвсгэр дээр хөдөлмөрлүүлнэ.
5. Хоригдлыг ажиллахыг хориглох ажлын жагсаалтыг засан хүмүүжүүлэх байгууллагын дотоод журмаар тогтооно.
6. Хоригдлуудын хөдөлмөрлөх цаг нь хорих байгууллагын үндсэн зорилт болох засан хүмүүжүүлэх үйл ажиллагаатай давхцаж болохгүй.
7. Ажлаас татгалзах, эсвэл ажлыг зогсоовол тогтоосон журмыг санаатай зөрчсөн гэж үзэж шийтгэлийн арга хэмжээ, хариуцлага хүлээлгэнэ.

104 дүгээр зүйл. Хоригдлын хөдөлмөрийн нөхцөл

1. Хоригдлыг ажиллах хугацаанд хөдөлмөр хамгааллын, техникийн аюулгүй байдал болон ариун цэвэрт холбогдох дүрмийг ОХУ-ын хөдөлмөрийн тухай хууль тогтоомжид нийцүүлэн тогтооно. Ажлын эхлэх болон дуусах цаг нь ээлжийн графикаар тодорхойлогдоно.
2. Хоригдлын гүйцэтгэж байгаа ажлууд нь ажлын цагийг уртасгасан хэлбэрт ордог. (Өдөр болгон тогтмол цагаар ажилладаггүй, нэг өнжөөд 24 цаг ч юм уу ажилладаг гэсэн утгатай)
3. Хоригдол цалинтай ажил хийлгэхэд цаг нь нийт ажлын цагаар тооцогдоно.
4. Ажил хийдэг хоригдлууд жил бүр төлбөртэй амралт авна.
5. Ажил хийдэг хоригдлууд жил бүр төлбөртэй амралт авна. Хүмүүжүүлэх колонид хорих ял эдэлж буй хоригдол ажлын 18 өдөр, засан хүмүүжүүлэх байгууллагад хоригдож буй хоригдол 12 ажлын өдрийн төлбөртэй амралт авах эрхтэй байдаг байна.[173]

Холбооны бүгд найрамдах герман улс /ХБНГУ/

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь ажиллах хүсэл эрмэлзэл бүхий хоригдол бүрд эдийн засгийн үр ашигтай хөдөлмөр эрхлэх нөхцөл бололцоог хангасан зохион байгуулалтын арга хэмжээг авах үүрэгтэй.

Хоригдлуудыг өөрийн цехэд ажиллуулах: хорих байгууллагын өөрийн хангамж болох хувцас, хэрэглээний зүйл, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх цех. Мөн угаалга, цэвэрлэгээ болон засварын ажилд ажиллана. Шүүхийн шийдвэр

[173] УИХ-ын Тамгын газар Судалгааны төв 2011 он

гүйцэтгэх тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу хоригдол иймэрхүү туслах ажлыг 3 сар хүртэлх хугацаагаар хийх үүрэгтэй, өөрийн зөвшөөрснөөс 3 сараас дээш хугацаагаар хийж болно. Хоригдлуудад цалин хөлс олгодог.

Хоригдлыг өөрийн үйлдвэрт ажиллуулах: Өөрийн үйлдвэр гэж хорих газрын захиргаанаас байгуулан удирддаг, хорих газрын хашаан дотор байрладаг гар үйлдвэрлэл, аж үйлдвэрийг хэлдэг. Өөрийн үйлдвэрүүдийн тоног төхөөрөмжүүд ихэнхдээ хуучирсан байдгаас бүтээмж нь хязгаарлагдмал, ажиллах хүч нь байнга солигдож байдаг, мэргэжлийн биш хүн ажлын байранд ажилладаг, хязгаарлагдмал ачаалалтай байдаг.

Хоригдлыг хувийн үйлдвэрт ажиллуулах: Хоригдлууд харгалзагчийн хяналт дор хувийн үйлдвэрүүдэд ажилладаг. Энд хоригдол ажиллуулж байгаа компанийн эзэн эдийн засгийн эрсдэлээ үүрдэг. Харин тухайн үйлдвэрт ажиллах зөвшөөрөл авсан хоригдол ажлын журмыг мөрдөх үүрэгтэй.

Хоригдлыг чөлөөт хөдөлмөрийн харилцаанд ажиллуулах: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хоригдол хорих байгууллагаас гадуур хөдөлмөр эрхлэх боловч нийгмийн даатгалын харилцаанд ордоггүй. Ажил олгогч хоригдлын цалинг бүтнээр нь хорих ангид шилжүүлнэ, харин хорих анги нь хоригдолд оногдох хөлсийг олгодог.

Хөдөлмөрийн эмчилгээний арга хэмжээ: Эдийн засгийн үр ашигтай хөдөлмөр эрхлэх чадамжгүй, мэргэжил болон дунд боловсрол эзэмшээгүй зэрэг хоригдлуудад эмчилгээ засан хүмүүжүүлэх хөшүүрэг чухал байдаг. Хөдөлмөрийн эмчилгээний арга хэмжээнүүд болох хоригдлыг дэгийн дагуу өдрийг өнгөрүүлэхэд дасгах, тодорхой амжилтын амтыг мэдрүүлэх, гараар ажиллахыг зааж сургах, ухамсарлуулах ач холбогдолтой. Тухайлбал хөдөлмөрийн эмчилгээгээр бэлэг дурсгалын зүйлс үйлдвэрлэх гэх мэт.

Герман улсын нордрайн-вествален мужийн хорих ангийн онцлог.

Хоригдлуудыг ажлын байраар хангахад мужийн зүгээс анхаарч, хорих ангийн бүсэд үйлдвэрлэлийн талбай бэлтгэн өгдөг. Ингэснээр компаниуд хорих ангид үйлдвэрлэл явуулах боломжтой болдог ба хоригдлуудын 60 хувийг энэ замаар ажлын байраар хангаж чаддаг байна. Мөн хорих анги нь өөрөө гаднаас компаниудыг татаж ажиллуулахад санаа тавьж ажиллах ёстой. Хорих анги нь өөрөө компани гэж ойлгож болно. Тухайлбал мужаан, хэвлэлийн газар гэх мэт үйлдвэрлэлийг явуулдаг. Хорих байгууллагын үйлдвэрлэлд зориулсан “Website” нээсэн бөгөөд үүгээр хорих ангид үйлдвэрлэсэн бүх төрлийн барааг захиалан авах боломжтой. Мөн иргэдэд зориулж үзэсгэлэн худалдаа зохион байгуулдаг. Герман улсын бүх хорих байгууллагууд нь Засгийн газраас хамааралгүй тухайн оршин байгаа мужийн Хууль зүйн яаманд харьяалагддаг. Хууль зүйн яам нь хорих мэргэжил эзэмшсэн ангид хоригдлуудыг ажлын байраар хангах тал дээр анхаарч ажилладаг байна.

Жишээ нь мужийн Засгийн газрын агентлаг, хорих байгууллагуудын бүх тавилгыг хорих ангидаа үйлдвэрлэх, Хууль зүйн яамны болон хорих ангийн бүх авто машиныг хорих ангийн машин засварын газар засуулах зэргээр журам тогтоон хэрэгжүүлж ажилладаг байна.

Ремшайдын нээлттэй хорих ангийн дотоод журамд:

Нээлттэй хорих ангийн хоригдол ажил хийх үүрэгтэй. Ажил ихэнхдээ хорих ангиас гадна байгаа үйлдвэрүүдэд явагдана. Хэрэв хоригдол ажил хийхээс татгалзсан нөхцөлд, эсвэл ажлын үр бүтээмж хангалтгүй бол сахилга батын арга хэмжээ авна. Энэ нь улмаар Нээлттэй хорих ангид таарах хүн биш гэсэн эргэлзээнд хүрч эрхийг нь хасахад хүргэнэ.

Хоригдол хорих ангийн албан хаагч, үйлдвэрийн мастерт захирагдах ёстой. Ямар ч тохиолдолд аюул ослоос хамгаалах дүрэм, журмыг анхаарах ёстой. Аюул тохиолдсон үед үзлэгийн осол эмч ажилтанд болон ажлын захиргаанд нэн даруй мэдэгдэх ёстой. Та ажилдаа шууд ирж, буцаж очих ёстой. Замаараа өөр газар уруу явах, ажлын байраа зөвшөөрөлгүйгээр орхисон тохиолдолд сахилга батын арга хэмжээ авна. Энэ нь улмаар Нээлттэй хорих ангид байх хугацааг богино болгож байна гэсэн үг. Ажлын газарт таны гэр бүлийн гишүүд болон найз нөхөд эргэж очихыг хориглоно.[174]

Бүгд найрамдах солонгос улс /БНСУ/

БНСУ-д хоригдлын эрх зүйн байдлын хуулийн 4 дүгээр бүлэгт хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар зохицуулсан байдаг. Хорих ангийн дарга хоригдолд хийх ажлыг оноохдоо нас, ялын хугацаа, эрүүл мэндийн байдал, ур чадвар, зан ааш, сонирхол, ажил байдлын намтар, ирээдүйн амьжиргаа, болон хоригдлын нөхцөл байдлыг харгалзан үздэг. Хоригдол өөрт ногдох ажил үүргийг гүйцэтгэх үүрэгтэй. Хорих ангийн захиргаа хоригдлыг гаднын үйлдвэрт, эсвэл хорих байгууламжийн дотор зохион байгуулж гаднын үйлдвэрийн ажлыг хийж болно. Гаднын үйлдвэрийг сонгон авах стандартад холбогдох шаардлагатай зүйлийг хууль зүйн яам шийдвэрлэнэ.

Хоригдол нь амралтын өдөр, бүтэн сайн өдөр болон олон нийтийн амралтын өдөр ажиллахгүй. Мөн гэмтэл бэртэл, өвчин, ажлаа хийхэд саад болохуйц нөхцөл байдал үүсвэл түүнийг арилгах хүртэл ажлаас чөлөөлж болно. Хоригдлын хийсэн ажлын хөлс нь улсад орно. Хорих газрын дарга хоригдолд ажлын шагнал урамшууллыг суллагдахын өмнө бүгдийг нь болон зарим хэсгийг авч болно. Хэрэв хоригдол нь ажлын байр болон мэргэжлийн сургалтын явцад болон түүний улмаас нас барвал хоригдол хөдөлмөрийн шагнал урамшууллаар авсан мөнгийг өв залгамжлагчид өгнө.[175]

[174] Герман улсын хорих ял эдлүүлэх ажиллагаа Улаанбаатар 2014 он
[175] УИХ-ын Тамгын газар Судалгааны төв 2011 он

Япон улс

Японд хоригдлыг хүмүүжүүлэх үндсэн хэрэгсэл нь биеийн хүчний хөдөлмөр гэж үздэг. Хоригдлын хөдөлмөрийг зохион байгуулах эрх зүйн үндэс нь хөдөлмөрийн хууль тогтоомж бөгөөд “Шоронгийн тухай хуулийн хэрэгжүүлэх үндсэн зарчим”, “Албадлагын журам” гэх мэт журмаар зохицуулагдана. Хоригдлууд нь дараах 2 төрөлд ажиллана.

1. Аж үйлдвэрийн салбар, эл эдлүүлэх байгууллага хоорондын хамтарсан холбооны гэрээний дагуу гутал, цүнхний гэх мэт үйлдвэрт 25 орчим хувь нь ажилладаг.
2. Улсын гэрээтэй хувийн компанид худалдааны бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрт 75 орчим хувь нь ажилладаг. Хоригдлууд өдөрт 8, 7 хоногт 40 цаг ажилладаг. Өглөө өдөр 15 минутын амралттай бөгөөд өдрийн хоол 40 минут байна.

Хоригдлын хөдөлмөр эрхлэлтээс олсон орлого үндэсний санд ордог. Цалингүй ажиллана гэсэн үг. Гэхдээ ажлын төрлөөс хамаарч бага зэргийн тэтгэмж хуримтлагдана. Энэ мөнгийг суллагдахад нь өгөх ба зарим хэсгийг өөрсдийнх нь хэрэгцээнд зарцуулдаг. Мөн хоригдлыг аваар осолд орох, бэртэж гэмтэх, амь насаа алдсан тохиолдолд засгийн газраас нөхөн төлбөр олгодог байна. Хоригдлууд нь маш хатуу чанга дэглэмтэй ажилладаг. Ажил хийж байхдаа хоорондоо ярих, нүдээрээ харьцахыг хориглоно. Мөн 5 зарчим баримталж ажиллана. Үүнд: Шударга, зарчимтай, найрсаг, тусархаг, талархалтай байх ёстой.[176]

БНХАУ-ын засаг захиргааны онцгой бүс Хонг-конг

2013 оны байдлаар нийт ял эдлэгсэд 100 хувь хөдөлмөр эрхэлж, олон нийтийн салбарын бараа, үйлчилгээ, аж үйлдвэрийн ажилд оролцож байна. Жишээ нь албан тасалгааны тавилга, төрийн алба хаагчдын дүрэмт хувцас, ажилчдын хувцас, гутал, эмнэлгийн зотон даавуун шүүлтүүртэй маск, дэд бүтцийн төслүүдэд хэрэглэгдэх замын тэмдэг, төмөр хашлага, хучилт, бордуур үйлдвэрлэх, шилэн сав, хог хаягдал боловсруулах үйлдвэрт ажиллахын зэрэгцээ эмнэлэг, цагдаа, гал түймэртэй тэмцэх байгууллагын угаалгын үйлчилгээг үзүүлж байна. Түүнчлэн хэвлэх үйлдвэртэй бөгөөд Засгийн газрын албан бланк, дугтуй үйлдвэрлэж олон нийтийн номын сан, орон нутгийн их, дээд сургуулийн ном, товхимол, сурах бичиг зэргийг хэвлэх, ламинатаар хавтаслах зэрэг бүх төрлийн хэвлэлийн үйл ажиллагаа явуулдаг. Хөдөлмөрт хамрагдсан ялтнуудын хийсэн хөдөлмөрийн тоо, чанарт тохирсон хөдөлмөрийн хөлс олгодог ба мэргэжлийн ур чадвараас шалтгаалан долоо хоногт 40-70 НК/долларын цалин авдаг байна.

Хонг-Конгын Засгийн газраас хорих байгууллагын үйлдвэрлэлийн чиглэлд онцгой анхаарч дэмжлэг үзүүлдэг ба төрийн байгууллагын бусад

[176] УИХ-ын Тамгын газар Судалгааны төв 2011 он

байгууллагаар гүйцэтгүүлж болох бүхий л ажил үйлчилгээг хорих байгууллагаар дамжуулан үзүүлж эдийн засгийн хувьд дэмждэг нь харагдаж байлаа.

Ялтнуудад мэргэжлийн сургалт явуулах нь засан хүмүүжүүлэх үйл ажиллагааны нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь бөгөөд олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, мэргэжлийн үнэмлэх олгох /certificate/ төрөлжсөн ба зах зээлийн мэргэжлийн сургалтын хөтөлбөрт насанд хүрсэн болон насанд хүрээгүй бүх ялтнуудыг хамруулдаг байна.

Өсвөр насны эрэгтэй, эмэгтэй ялтнууд нь хагас өдөр нь боловсролын сургалт, хагас өдөр нь мэргэжлийн сургалтад заавал хамрагддаг. Сургалт нь онол, практик дадлага хосолсон байдлаар явагддаг нь өндөр ач холбогдолтой байна.

Зах зээл өндөр хөгжсөн орны хувьд худалдаа, наймаа эрхлэх чиглэлээр сургалт явуулдаг нь онцлог байлаа. Ял эдлээд суллагдсан иргэдийн хувьд аль нэг байгууллагад ажиллахаас гадна хувийн бизнес эрхлэх буюу дэлгүүр, лангуу ажиллуулах, дэлгүүрийн кассын машин дээр ажиллах зэрэг сургалтууд явагддаг байна. Насанд хүрсэн ялтнуудын хувьд сайн дурын үндсэн дээр хагас өдрийн болон бүтэн өдрийн мэргэжлийн сургалтад хамрагддаг бөгөөд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг хорих ангийн үйлдвэрлэлд ажиллаж буй ялтнууд нь ур чадвартай мэргэжлийн ажилтан болон хөгжсөн байдаг ба шаардлагатай тохиолдолд тэднийг мэргэжлийн байгууллагын шалгалтад хамруулах замаар ур чадварт нь тохирсон үнэмлэх, сертификат авахад нь тусалдаг байна.[177]

Финлянд улс

Финлянд улсын хорих байгууллага нь онцгой, жирийн, нээлттэй гэсэн гурван төрлийн дэглэмд хуваагддаг. Онцгой дэглэмийн хоригдлыг нийгмээс болон бусдаас чанд тусгаарласан нарийн хяналтад байлгадаг. Жирийн дэглэмийнхэн хоорондоо уулзаж болох ба хянагчийн харгалзаатайгаар гадуур явж болно. Нээлттэй хорих байгууллагад оргох зугтахаас сэргийлсэн хашаа, тор байхгүй, хоригдол өрөөнийхөө түлхүүрийг өөрөө эзэмшиж дотор чөлөөтэй явах, мөн энгийн хувцас өмсдөг.

Скандинавын бусад улсын нэгэн адил Финляндад хоригдол ажиллах юм уу суралцах ёстой бөгөөд зардлыг төр хариуцдаг. Ажил, сургууль амралтын өдрүүдэд амардаг. Мэргэжил эзэмших сургалтад суралцах хүсэлтэй хүмүүсийн дэглэмээс шалтгаалан гадагш гарч суралцах буюу дэглэм таарахгүй бол гаднаас багш ирүүлж сургалт явуулдаг байна. Дэглэмээс хамаарч гадагш гарч ажиллаж, суралцдаг байдал нь нийгэмшүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг байна.

Их Британи улс

[177] БНХАУ-ын засаг захиргааны онцгой бүс хонг-конгын хорих байгууллагын үйл ажиллагаатай танилцсан тэмдэглэл Ч.Мөнх-Эрдэнэ 2014 он

Их Британийн хорих байгууллага нь Дотоод хэргийн яамны харьяанд байх бөгөөд дараах хэлбэртэй байдаг. Үүнд:

- 3-аас дээш жилийн ялтай хоригдлын нэгдсэн хорих анги,
- Хэд хэдэн засаг захиргааны нутаг дэвсгэрийг хамарсан, 12 сараас ял эдлэх анхны хэрэгтэй хоригдлын орон нутгийн хорих анги,
- 21-ээс дээш насны засрах найдлага бүхий гэмт хэрэг давтан үйлдсэн хоригдлын хорих анги,
- Тухайн засаг захиргааны нутаг дахь анх удаа гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн хорих анги.

Мөн 21 хүртэлх насны хүмүүст зориулсан хорих анги болон хорихын сургууль байдаг. Үүнээс гадна насанд хүрээгүйчүүдийг богино хугацаагаар засан хүмүүжүүлэх төвүүд байдаг.

Европын хорих байгууллагын дүрмийг удиртгал болгон Их Британийн хорих байгууллага дараах хөтөлбөрийг хэрэгжүүлдэг Үүнд:

1. Хорих байгууллага бүр нийгэм боловсролын төлөвлөгөөтэй байх бөгөөд ялтан бүр авьяас чадвар, хэрэгцээ шаардлагаа хангах бололцоотой байх,

2. Боловсрол нь засан хүмүүжүүлэх үйл явцын салшгүй хэсэг, хөдөлмөрлөхийн чөлөөт цагаа өнгөрүүлэх үндсэн зүйлийн нэг байх.

3. Залуучууд, гадаадын иргэд, үндэстний цөөнхөд боловсрол олгоход анхаарах,

4. Онцлох бэрхшээлтэй ялтнуудад тусгайлан хөтөлбөр зохиох,

5. Хорихын боловсролын хөтөлбөр нь улс орны боловсролын тогтолцоотой адил түвшинд байж суллагдсаны дараа шууд үргэлжлүүлэн суралцахад саадгүй байх,

6. Хоригдол мөн хорихоос гадуур суралцах эрхтэй.

Дурдсан орнуудад хоригдол хөдөлмөр эрхлэлтийг явуулахдаа энэ талаар бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөгөө, журам, заавар гаргахдаа юуны өмнө хорих ангид хөдөлмөр эрхлэх сургалт, дадлагын асуудлыг шийдвэрлэсний дараагаар хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар тусгажээ.

Швейцари улс

Швейцарын хорих байгууллагын нийгмийн үйл ажиллагаа нь хөдөлмөр, ерөнхий боловсрол, мэргэжлийн сургалт, биеийн тамир, соёл оюуны гэсэн хэлбэрээр илрэлээ олдог бөгөөд ажил хийх нь хоригдлын заавал гүйцэтгэх үүрэг, бусдад нь сайн дурын үндсэн дээр хамрагддаг. Хуулийн дагуу сайшаалын хөшүүрэг байдаг бөгөөд тухайлбал ерөнхий боловсролын болон мэргэжил эзэмших сургалтад хамрагдах хүсэлтэй хүмүүсийг үдээс хойш ажлаас чөлөөлж суралцуулдаг бөгөөд амжилттай төгссөн нөхцөлд хугацаанаас нь өмнө суллах нэгэн хөшүүрэг болдог байна.[178]

[178] С.А.Лузгин, М.И.Кузнецов, В.Н.Казанцев. Мөн бүтээл. УБ., 2009 он

ДҮГНЭЛТ, САНАЛ

Хорих ял эдлүүлэх тодорхой хугацаанд олон нийтээс зөвхөн тусгаарлах бус хөдөлмөрлүүлэх нь улс орон болгонд ялгаатай тал байдаг ч зарим талаараа нийтлэг зохион байгуулагдаж байна. Тухайлбал: Америкийн Нэгдсэн Улсын Холбооны пенитенциар систем нь хамгаалалтын зэрэглэл болон аюулгүйн бага, дунд, дээд түвшинтэй байдаг. Бага түвшин-нээлттэй хэлбэрийн байгууллага бөгөөд зэвсэгт хамгаалалт байхгүй. Хоригдлууд нь гадуур ажиллах боломжтой. Дунд тувшин-хаалттай хорих байгууллага бөгөөд зэвсэгт хамгаалалт, хамгаалалтын байгууламжтай. Хоригдлуудаа зохих хамгаалалтын дор гадуур ажиллуулж болно. Дээд түвшин-онц аюултай гэмт хэрэгтнүүдийг хорих ба хоригдлуудаа гадуур ажиллуулдаггүй. Хоригдлуудыг хөдөлмөрлүүлэх асуудлыг дэд актуудаар зохицуулж байсан бөгөөд мэргэжил боловсролын чадвар олгох, суллагдан гарч нийгэмд амьдрахад туслах, тохирсон хөлс олгох, хөдөлмөр болон сургалтад сайн дураар хамруулах, хөдөлмөрийн таатай нөхцөлөөр хангагдах, хорих байгууллага үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай зөвшилцөн хамтран ажилладаг.

Оросын холбооны улсын эрүүгийн ялын гүйцэтгэлийн тухай хуульд зааснаар хоригдол бүр хорих ял эдлүүлэх байгууллагын захиргаанаас тодорхойлсон газарт хөдөлмөрлөх үүрэгтэй. Ингэхдээ тус улсын хөдөлмөрийн тухай хууль тогтоомжид заасан ажлын цаг, дүрэм, эрүүл ахуй, аюулгүй байдал гэх мэт шаардлагад нийцсэн байх ёстой.

Холбооны бүгд найрамдах Герман улсын хувьд хоригдлуудыг нийгэмшүүлэх зорилгыг нэгдүгээрт тавьж, хөдөлмөр эрхлэхийг үүрэг болгосон байдаг.

Бүгд найрамдах Солонгос улсын ял эдлүүлэх болон хоригдлын эрх зүйн байдлын тухай хуульд хөдөлмөр эрхлэлт нь тэдний эрх чөлөөт амьдралд эргэж ороход нь туслах зорилгоор ажлын дадал, мэргэжлийн ур чадвар олгох, хөдөлмөрт хандах сонирхлыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байна. Ингэхдээ нас, ялын хугацаа, эрүүл мэндийн байдал, ур чадвар, зан төлөв хүсэл сонирхол, мэргэжлийн чадвар зэргийг харгалзан үздэг байна.

Япон улсад засрал хүмүүжил олгох, нийгэмшүүлэх үндсэн хэрэгсэл нь хөдөлмөр гэж үздэг. Цалин хөлстэй ажлын байрын хувьд орлогыг үндэсний санд төвлөрүүлж, суллагдах үед нь тодорхой хувийг суутгаж олгодог байна. Хууль зүйн асуудал эрхэлсэн яамаар дамжуулж гаднын үйлдвэр эрхлэгчидтэй гэрээ байгуулан ажилладаг байна. Тэгэхээр улс орон бүрд тухайн улсын хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлж, хоригдлын хувийн болон бусад олон талын онцлогийг харгалзан зохион байгуулж байгааг ажиглаж болно. Хөдөлмөрийн ач холбогдол “хүний нийгмийн материал, соёлын үнэт зүйлс хөдөлмөрийн үр дүнд бий болдог тул хөдөлмөргүйгээр амьдрал байна гэж төсөөлөн бодохын аргагүй юм" гэсэн эшлэлээс тодорхой ойлгогдоно. Цаашилбал, хүн бүрийн сэтгэл зүйн үндсэн

онцлогтой холбоотойгоор аливаа үзэгдэл, үйл ажиллагаанд хариу үйлдэл үзүүлэх, зохицох чадавх ялгаатай байдаг. Нас, хүйс, ялын хугацаа, дэглэм, эрүүл мэндээс дутахааргүй чухал энэхүү онцлогийг харгалзан хөдөлмөрт хуваарилбал ажлын бүтээмж дээшлэх, зөв зан үйл төлөвших процессыг хялбаршуулах боломжтой.

Өнөө үед хорих байгууллагын аж ахуй, үйлдвэрлэлийн онцлог, нөхцөл байдлаас хамааралаад хоригдол тус бүрийн мэргэжил, ур чадварын онцлогт тохирсон ажлыг хийлгэх боломж нь хязгаарлагдмал хэдий ч хувь хүний ажлын ур чадвар, сонирхол, сэтгэл зүйн онцлогийг харгалзан хөдөлмөрлүүлэх нь хорих ангийн үйлдвэрлэл, гэрээгээр ажил гүйцэтгүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгцээг хангаад зогсохгүй хөдөлмөр эрхэлж буй хоригдлын нийгэмшилд чухал ач холбогдолтой юм.

Үүнээс үзвэл хорих ял эдэлж буй хүмүүсийг хөдөлмөрлүүлэх үйл ажиллагаа өвөрмөц онцлогтой бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан дэглэм, зэрэглэлийн онцлогт тохируулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаатай холбоотой хууль тогтоомжуудад нийцүүлэх, хүний эрхийг хангаж, албадан хөдөлмөр эрхлүүлэхгүй байх, эрүүгийн хариуцлагын зорилго болох хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд цалинтай хөдөлмөр эрхлүүлэх, хүч хөдөлмөрөө үр ашигтай, зөв зохион байгуулах, ажил хэрэгч хандлагатай болж, бэлэнчлэн хялбар, хууль бус аргаар амьдрах сэтгэлгээг даван туулах төлөвшлийг хүнд бий болгодог байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Лхагва А, Ганхүү М. Хорих ял эдлэгсдийг хүмүүжүүлэх-нийгэмшүүлэх ажлын зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. УБ., 2015 он.
2. Герман улсын хорих ял эдлүүлэх ажиллагаа Улаанбаатар 2014 он
3. С.А.Лузгин, М.И.Кузнецов, В.Н.Казанцев. Мөн бүтээл. УБ., 2009 он
4. УИХ-ын Тамгын газар Судалгааны төв УБ., 2011 он
5. “Хоригдлын хөдөлмөр зохион байгуулалтын талаарх түүх-онолын үзэл баримтлал” О.Серикбол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны эрх зүйн шинэтгэл эрдэм шинжилгээний хурал УБ., 2021 он
6. БНХАУ-ын засаг захиргааны онцгой бүс хонг-конгын хорих байгууллагын үйл ажиллагаатай танилцсан хувийн тэмдэглэл Ч.Мөнх-Эрдэнэ УБ.,2014 он
7. https://www.legalinfo.mn/law/details/11634
8. https://www.legalinfo.mn/law/details/12701
9. https://www.legalinfo.mn/law/details/89

К ВОПРОСУ О ПРЕОДОЛЕНИИ ПРОТИВОДЕЙСТВИЯ УГОЛОВНОМУ ПРЕСЛЕДОВАНИЮ В УЧРЕЖДЕНИЯХ УГОЛОВНО-ИСПОЛНИТЕЛЬНОЙ СИСТЕМЫ

ЭРҮҮГИЙН ЯЛ ЭДЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА ДАХЬ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ



Поликарпов Б.А., хууль зүйн доктор,
Дорж Банзаровын нэрэмжит Буриадын Улсын их сургуулийн Эрүүгийн эрх зүйн, эрүүгийн процессын эрх зүй, криминалистикийн тэнхимийн дэд процессор,

В статье освещаются вопросы преодоления противодействия уголовному преследованию в учреждениях уголовно-исполнительной системы. Автор указывает, что противодействие в учреждениях уголовно-исполнительной системы, следует определять как противодействие именно уголовному преследованию, так как акты противодействия встречаются на всех стадиях уголовного судопроизводства, вплоть до исполнения приговора. Обращается внимание, что криминальная субкультура оказывает значительное влияние на подозреваемых, обвиняемых и осужденных. Поддерживаемая организованными преступными формированиями, под руководством, так называемых лидеров и авторитетов, она идеологически детерминирует противодействие уголовному преследованию. В результате субъекты противодействия непрерывно обретают криминальный опыт и совершенствуют навыки в ходе общения с представителями преступной среды. В то же время наиболее эффективной системой преодоления противодействия уголовному преследованию в учреждениях уголовно-исполнительной системы, является совокупность уголовно-процессуальных, уголовно-правовых, уголовно-исполнительных, оперативно-розыскных, криминалистических, организационных мер по выявлению и устранению препятствий, созданных указанными лицами.

Ключевые слова: противодействие уголовному преследованию, учреждения уголовно-исполнительной системы, следственный изолятор, криминальная субкультура.

Polikarpov B.A., Ph.D. legal Sciences

Associate Professor of the Department of Criminal Law, Procedure and Criminalistics of the Dorzhi Banzarov Buryat State University,

Russia, Ulan-Ude, e-mail: *polikarpovb@mail.ru*

ON OVERCOMING RESISTANCE TO CRIMINAL PROSECUTION IN PENAL INSTITUTIONS

PROSECUTION IN THE PENAL SYSTEM INSTITUTIONS

The article highlights the issues of overcoming resistance to criminal prosecution in the institutions of the penal and correctional system. The author points out that counteraction in the institutions of the penal system should be defined as counteraction to criminal prosecution, since acts of counteraction are encountered at all stages of criminal proceedings, up to the execution of the sentence. Attention is drawn to the fact that criminal subculture has a significant impact on suspects, accused and convicted persons. Supported by organized criminal formations, under the guidance of so-called leaders and authorities, it ideologically determines the resistance to criminal prosecution. As a result, the subjects of resistance continuously acquire criminal experience and improve their skills in the course of communication with representatives of the criminal environment. At the same time, the most effective system of overcoming resistance to criminal prosecution in the institutions of the penal system, is a set of criminal procedural, criminal law, penal enforcement, operational and investigative, criminalistic, organizational measures to identify and eliminate the obstacles created by the specified persons.

Key words: counteraction to criminal prosecution, institutions of the criminal-executive system, pre-trial detention center, criminal subculture.

С начала 90-х годов и по настоящее время в криминалистической и уголовно-процессуальной литературе активно освещаются проблемы противодействия как уголовному преследованию, предварительному расследованию, так и правоохранительным органам в целом.

Рост количества совершенных преступлений, изменение качественных показателей организованной преступности предопределило повышенный интерес к проблеме противодействия. Хочется отметить, что расследование преступлений всегда испытывало противодействие со стороны подозреваемых и обвиняемых, их родственников, знакомых, обусловленное «инстинктом самосохранения», но, несмотря на это, теория о преодолении противодействия начала формироваться относительно недавно. Развитие такого института для криминалистики как прикладной науки имеет большое практическое значение, так как фактически вся деятельность органов расследования заключается в преодолении противодействия как такового[1, с.14].

Как правило, после совершения преступления виновный в своем стремлении избежать наказания осуществляет различные действия (бездействие), направленные на уклонение от уголовной ответственности. В ряде случаев такая деятельность носит незаконный характер, в других, наоборот, реализуется

предусмотренными законом способами в целях защиты прав и законных интересов подозреваемых и обвиняемых в совершении преступлений. Однако в любом случае противодействие уголовному преследованию создает либо препятствия для реализации прокурором, следователем, дознавателем, оперативными сотрудниками органов дознания своих должностных полномочий по решению стоящих перед ними задач, либо дает возможность принять меры по защите прав граждан.

Особенно важным направлением в развитии рассматриваемой частной криминалистической теории является изучение вопросов преодоления противодействия уголовному преследованию в учреждениях уголовно-исполнительной системы. Незаконное противодействие в местах лишения свободы во многом затрудняет борьбу с преступностью в связи тем, что значительная часть подозреваемых и обвиняемых, содержащихся под стражей, преследуется за совершение тяжких и особо тяжких преступлений. Кроме того, лица, впервые привлекаемые к уголовной ответственности, подвергаются воздействию сокамерников и других лиц. В результате субъекты противодействия непрерывно обретают криминальный опыт и совершенствуют навыки в ходе общения с представителями преступной среды. Криминальная субкультура оказывает значительное влияние на подозреваемых, обвиняемых и осужденных. Поддерживаемая организованными преступными формированиями, под руководством, так называемых лидеров и авторитетов, она идеологически детерминирует противодействие уголовному преследованию.

Незаконное противодействие уголовному преследованию в местах лишения свободы во многом затрудняет борьбу с преступностью, что обусловлено, как минимум, следующими факторами:

1. Значительная часть подозреваемых и обвиняемых, которым избрана мера пресечения в виде заключения под стражу, преследуется за совершение тяжких и особо тяжких преступлений. Удельный вес противоправных деяний, осуществленных лицами, имеющими криминальный опыт, составляет около половины всех расследованных преступлений. Вполне естественно, что данные лица часто продумывают способы оказания противодействия уголовному преследованию еще до совершения преступления. 2. Лица, впервые привлекаемые к уголовной ответственности, находясь в учреждениях уголовно-исполнительной системы, подвергаются воздействию вышеуказанных лиц и впоследствии также реализовывают акты противодействия. В результате они накапливают криминальный опыт и непрерывно совершенствуют навыки в ходе общения с представителями преступной среды.

Данная теория находится в стадии становления из-за отсутствия единого мнения ученых по многим вопросам преодоления противодействия, даже в самом названии института. Так, в юридической литературе большинство ученых

придерживаются мнения, что противодействие оказывается на стадии предварительного расследования. Один из первых разработчиков криминалистического учения о противодействии В.Н. Карагодин определил его как умышленные действия (или система действий), направленные на воспрепятствование установлению объективной истины по уголовному делу, достижению других целей предварительного расследования[2, с.35]. Р. С. Белкин полагает, что противодействие расследованию есть умышленная деятельность с целью воспрепятствования решению задач расследования и, в конечном счете, установлению истины по уголовному делу[3, с.129]. Как пишет А.Ю. Головин: "Противодействие расследованию - это умышленная деятельность преступников и связанных с ними лиц, препятствующая работе правоохранительных органов по раскрытию и расследованию конкретных преступлений"[4, с.158]. Э.У. Бабаева использует понятие «противодействие уголовному преследованию»[5, с.99].

Уголовное преследование, согласно пункту 55 статьи 5 УПК РФ, - процессуальная деятельность, осуществляемая стороной обвинения в целях изобличения подозреваемого, обвиняемого в совершении преступления. Данная деятельность намного шире, чем предварительное расследование, и охватывает все этапы уголовного судопроизводства. Мы придерживаемся мнения, что противодействие со стороны лиц, содержащихся в следственных изоляторах, следует определять как противодействие именно уголовному преследованию, так как акты противодействия встречаются на всех стадиях уголовного судопроизводства, вплоть до исполнения приговора (например, побег из места заключения тоже будет являться актом противодействия).

Единичные акты противодействия чаще всего свойственны лицам, не обладающим юридическими знаниями, криминальным опытом, необходимых для осуществления системы (комплекса) действий по оказанию противодействия уголовному преследованию. В некоторых случаях субъекты противодействия, совершая единичные акты противодействия, преследуют иные цели, не связанные с воспрепятствованием уголовному преследованию по конкретному уголовному делу, например, противопоставление криминальной субкультуры правоохранительной функции государства. Данное обстоятельство ярко выражено в учреждениях уголовно-исполнительной системы, в т.ч. в СИЗО. Так, отказ от сотрудничества, дачи показаний являются положениями, обязательными к исполнению с позиции криминальной субкультуры. Кроме того, единичные акты противодействия в СИЗО могут совершаться в целях получения тех или иных преимуществ при содержании под стражей.

Систему согласованных действий (бездействия) нельзя рассматривать как деятельность заинтересованных лиц [6, с. 7]. Любому виду деятельности присущи такие черты, как предметность, планомерность, системность, упорядоченность, целесообразность [7, с. 18]. Понятие деятельности неразрывно связано с сознанием

и социальными отношениями. Так, основным принципом теории деятельности является единство сознания и деятельности [8, с. 15]. Поэтому нельзя некоторые акты противодействия, реализуемые конкретным субъектом, назвать деятельностью. Тем не менее, если рассматривать противодействие уголовному преследованию применительно к организованной преступности или противодействию правоохранительным органам, то оно, бесспорно, будет являться деятельностью.

Дискуссионные вопросы возникают по другим категориям теории преодоления, например, по формам, видам, способам противодействия, средствам и методам преодоления и пр. И это закономерно, так как при формировании любой теории происходит аккумулирование описательных данных и материалов, полученных опытным путем, с последующим построением теоретических основ разрабатываемой теории. Рассматривая через призму структуры научного познания, можно сказать, что в настоящее время наблюдается процесс прохождения основных структурных компонентов теоретического уровня познания: проблема, гипотеза, теория, закон[9, с.113].

Многие ученые рассматривают внутренние и внешние формы противодействия (Т.В. Аверьянова, Р.С. Белкин)[10, с.118]. Под внутренним противодействием понимается умышленная деятельность преступников и иных лиц тем или иным образом связанной с преступлением. Под внешним противодействием понимается деятельность других лиц, в том числе коррумпированных сотрудников правоохранительных органов, не связанных с расследуемым уголовным делом. Субъектам преодоления противодействия необходимо помнить, что мотивом противодействия уголовному преследованию в учреждениях уголовно-исполнительной системы не всегда является лишь уклонение от уголовной ответственности. Существует ряд типовых мотивов противодействующих лиц, среди которых распространенными являются стремление к изменению меры пресечения в виде заключения под стражу на более мягкую; субъективная уверенность подозреваемого (обвиняемого) в своей невиновности; незаконная и/или аморальная, по мнению субъекта противодействия, деятельность отдельных сотрудников правоохранительных органов; стремление добиться тех или иных преимуществ при содержании в СИЗО и т. д.

Рассматривая противодействие со стороны лиц, содержащихся в следственных изоляторах, можно сказать еще и об особенностях взаимосвязи данных форм, т.к. противодействие без участия сторонних субъектов затруднительно из-за специфики изоляции. Большую роль в оказании противодействия играет влияние криминальной субкультуры спецконтингента (подозреваемые, обвиняемые и осужденные, содержащиеся в следственном изоляторе). Например, дача показаний о виновности соучастника отрицательно скажется на статусе лица в криминальной среде, взаимопомощь и взаимовыручка спецконтингента, также имеет немаловажное значение. Хочется отметить, что воздействие с оказанием давления на других участников уголовного судопроизводства, находится в прямой зависимости от

неформального статуса лица, содержащегося в следственном изоляторе, количества отбытых сроков и опыта общения с криминальной средой. Противодействие этих лиц может носить как криминальный (например, побег, угрозы, применение насилия в отношении следователя, дознавателя, оперуполномоченного, вмешательство в целях воспрепятствования расследованию уголовного дела), так и некриминальный характер, например, отказ участвовать в процессуальных действиях под предлогом болезней (невозможности выйти из камеры), формальное соблюдение правил внутреннего распорядка (завтрак, обед, ужин, прогулка), различные провокационные действия: объявление голодовки, акты членовредительства с целью оказания влияния на сотрудников правоохранительных органов.

Обстановка противодействия уголовному преследованию в учреждениях уголовно-исполнительной системы обусловливается следующими типовыми данными: а) состояние правопорядка, организация режима и надзора; б) условия места оказания противодействия уголовному преследованию; в) временные факторы, способствующие реализации актов противодействия уголовному преследованию; г) поведенческо-психологические особенности субъекта противодействия (образование, уровень интеллекта и правосознания, род занятий, изобретательность, воображение, воля, родственные и иные связи, статус лидера и авторитета в преступной среде).

Средства преодоления противодействия уголовному преследованию имеют различную структуру, которая определяется объективными и субъективными обстоятельствами. Осуществление уголовного преследования в условиях строгого, неукоснительного соблюдения законности и недопустимости нарушения прав и законных интересов участников уголовного судопроизводства является одним из самых надежных и эффективных средств преодоления противодействия уголовному преследованию. Кроме того, должностным лицам правоохранительных органов необходимо, не допуская обмана и иных незаконных, неэтичных методов, прилагать все усилия к убеждению стороны защиты в том, что сторона обвинения действительно располагает надлежащими доказательствами, позволяющими изобличить виновного в совершении преступления, тем самым предупреждая различные акты противодействия с их стороны.

Применение правовых средств (уголовных, административных, дисциплинарных) существенным образом влияет не только на принятие решений о продлении или изменении меры пресечения в виде заключения под стражу, но и на некоторые условия содержания в СИЗО, дальнейшего отбывания наказания в исправительном учреждении (в случае признания виновным и осуждения к реальному лишению свободы), замену не отбытой части наказания более мягким его видом, условно-досрочное освобождение и т. п.

Соответственно, наиболее эффективной системой преодоления противодействия уголовному преследованию в учреждениях уголовно-

исполнительной системы, является совокупность уголовно-процессуальных, уголовно-правовых, уголовно-исполнительных, оперативно-розыскных, криминалистических, организационных мер по выявлению и устранению препятствий, созданных указанными лицами.

Таким образом, преодоление противодействия уголовному преследованию в учреждениях уголовно-исполнительной системы можно определить как систему действий уполномоченных субъектов по прогнозированию, предупреждению, распознаванию, пресечению и нейтрализации противодействия уголовному преследованию по соответствующему уголовному делу (группе взаимосвязанных дел).

БИБЛИОГРАФИЯ

1. Абраменкова В.С. Противодействие при расследовании: понятие, формы и способы // Вопросы криминалистики и судебных экспертиз. 2005. С.59-63.
2. Карагодин В.Н. Основы криминалистического учения о преодолении противодействия расследованию: Дис. ... д-ра юрид. наук. Свердловск, 1992. 388 с.
3. Белкин Р. С. Противодействие расследованию и пути его преодоления криминалистическими и оперативно-розыскными средствами и методами // Криминалистическое обеспечение деятельности криминальной милиции органов предварительного расследования: учеб. пособие / под ред. Т. В. Аверьяновой, Р. С. Белкина. М., 1997.
4. Головин А.Ю. Теория и практика классификационных исследований в криминалистической науке. Тула, 2000. 228 с.
5. Бабаева Э.М. Современные проблемы криминалистической теории преодоления противодействия уголовному преследованию. М.: Русинжкомплект, 2002.
6. Белкин Р. С. Криминалистика: учебник. М.: Норма, 2000. С. 724; Баев М. О. Противодействие как реализация принципа состязательности в уголовно-процессуальном исследовании преступлений // Воронежские криминалистические чтения. 2005. № 6. С. 7.
7. Демин М. В. Природа деятельности. М., 1984. С. 18.
8. Рубинштейн С. Л. Основы общей психологии. СПб.: Питер, 2000. С. 15/
9. Философия науки: учебное пособие / отв. ред. Т. П. Матяш. – Ростов на Дону: Изд-во «Феникс», 2006. 272 с.
10. Белкин Р.С. Противодействие расследованию и пути его преодоления криминалистическими и оперативно-розыскными средствами и методами // Криминалистическое обеспечение деятельности криминальной милиции

органов предварительного расследования: учеб. пособие / под ред. Т.В. Аверьяновой, Р.С. Белкина. М., 1997.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА БА ХИЙМЭЛ ОЮУН УХААНД СУУРИЛСАН ХЯНАЛТЫН ТЕЛЕКАМЕР

ENFORCEMENT OF COURT DECISIONS AND INFRINGEMENT INTELLIGENT SURVEILLANCE CAMERAS



С.Цэрэндолгор
Дотоод хэргийн их сургуулийн
Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн
багш, ахмад

Хураангуй: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага өдөр тутмын үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ дуу, дүрсний бичлэгийг ашиглах эрх зүйн болон практик хэрэглээ их байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх тохиолдолд иргэдтэй хүндэтгэлтэй харьцах, өөрийн шаардлагыг үндэслэлтэй, ойлгомжтой хэлбэрээр илэрхийлэх үүрэгтэй. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах үед иргэдийн зүгээс алба хаагчийг үндэслэлгүйгээр гүтгэж, нэр төрд нь халдах тохиолдол түгээмэл байдаг. Үүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хиймэл оюун ухаанд суурилсан компьютерын харааны технологийн CCTV буюу хяналтын телекамерийг шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд ашиглах, төлбөр авагч, төлбөр төлөгчийн дундаас гарч болзошгүй бодитой эрсдэлээс урьдчилан сэргийлэх телекамерийн системийг нэвтрүүлэх, түүнд дүн шинжилгээ хийх талаар санал, зөвлөмж, дүгнэлтийг дэвшүүлсэн.

Abstract: There are many legal and practical uses of audio and video recordings in the day-to-day operations of judicial decision-making bodies. In case of enforcement of the court decision, the court decision enforcement agency and employee are obliged to treat citizens with respect and express their demands in a reasonable and understandable manner. During the execution of the decision, it is common for citizens to slander the official without reason and attack his dignity. In order to prevent this, proposals, recommendations and conclusions were put forward on the use of artificial intelligence-based computer vision technology CCTV or surveillance television cameras in decision-making operations, the introduction of a television camera system to prevent real risks that may arise between payers and payers, and its analysis.

Түлхүүр үг: CCTV, тандалт, компьютерын хараа, дүн шинжилгээ хийх

Key words: CCTV, surveillance, computer vision and analysis

Удиртгал: Энэхүү судалгаа нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын аюулгүй байдлыг хангахад ашиглагдаж буй хяналтын системийн цаашдын чиг хандлагыг тодорхойлох зорилготой.

Хүн төрөлхтний түүхэнд хамгийн анхны механик камерын системийг Оросын физикч Леон Теремин нь Климент Ворошиловын удирдлага доор 1927 оны 6-р сард Москвагийн Кремлийн хашаанд суурилуулсан түүхтэй.[179] Үүнээс 15 жилийн дараа Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Siemens AG компани пуужин хөөргөхийг ажиглах зорилгоор 1942 онд камерын системийг ашиглаж эхэлсэн байдаг. Ийнхүү 1970 он гэхэд аналог камерыг орчны аюулгүй байдал, замын түгжрэл, албан байгууллагуудын хамгаалалт, гаднын халдлага зэргийг хянах зорилгоор ашиглаж эхэлсэн[180] түүхтэй байна.

Орчин үед дэлхийн улс орнууд шинжлэх ухаан, технологийн тэргүүний ололт, амжилтыг практикт эрчимтэй нэвтрүүлж байгаа бөгөөд үүний нэг жишээ нь хиймэл оюун ухаанд суурилсан, компьютерын харааны технологи ашиглан, дүрс бичлэгт зайнаас тандалт хийн, дүн шинжилгээг хүний оролцоогүйгээр гаргаж, сэтгэцийн өвчтэй иргэдийн зүй бус үйлдэл, гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох боломжийг олгож байна.

Тэгвэл хиймэл оюуны болон компьютерын тусламжтайгаар хүн шиг шийдвэр гаргахаар оролдож байна . Өөрөөр хэлбэл, орчин үеийн техник технологийн шинэчлэлтэй уялдан олон хэмжээст, параметрийн бус аргын хэрэглээ нэмэгдсэнээр зайнаас тандан судлалын салбарт томоохон ахиц дэвшил гарч дараагийн шинэ чиглэл болох дүрс бичлэг боловсруулах хиймэл оюун ухааны технологиуд тэр дундаа хяналтын телекамераар хүний хөдөлгөөн, зан байдал, биеийн дулааны өөрчлөлт, цусны даралт, царайны хувиралд тандалт хийж, дүн шинжилгээ явуулан, өөрчлөлтийг харьцуулалтын аргаар гаргаж байгаа нь олон салбарт давуу талыг бий болгосон.

Шийдвэр гүйцэтгэгчийн өдөр тутмын үйл ажиллагааг CCTV-д хянаж, төлбөр авагч, төлбөр төлөгчтэй холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үйл явцыг хиймэл оюун ухаанд суурилсан, компьютерын харааны технологийн тусламжтай хяналтын телекамераар тандалт хийж, дүн шинжилгээг гаргаснаар тухайн алба хаагчийн ажлын ачаалал, аюулгүй байдал, үүрэг гүйцэтгэлтийг үндэслэлтэйгээр гарган, удирдлагын зүгээс стратегийн түвшний шийдвэрийг оновчтой гаргах боломжтой.

Хонконгийн Сай Кунг дахь Пик Ук хорих ангийн мэргэжилтэн “Wildfaces Technology” компанийн хиймэл оюун ухаанаар дүрс бичлэгт шинжилгээ хийдэг системийг давуу тал нь хоригдлын сэжигтэй зан үйл, амиа хорлох болон хүчирхийллийг илрүүлэх зорилгоор бүтээсэн төдийгүй өдөр шөнийн ямар ч цагт

[179] https://en.wikipedia.org/wiki/Closed-circuit_television#History
[180] https://mogulservice.mn/post/69502

өгөгдлийг оруулсан хоригдлын хуулиар хориглосон үйл хөдлөлийг 1 м/секундийн алдагдалтайгаар хянаж хорих ангийн аюулгүй байдлыг ханган гарч болзошгүй зөрчлийн 100 хувь бууруулсан талаар судалгааг танилцуулсан[181].

Зураг 1.

Хиймэл оюун ухаанд суурилсан хяналтын телекамерын ажиллагааны ерөнхий зураг



Дэлхийн улс орнууд хиймэл оюун ухаанд суурилсан дүрс бичлэгт дүн шинжилгээ хийдэг ухаалаг технологийг хорих байгууллага тэр дундаа харуул хамгаалалтад 2019 оноос түгээмэл ашиглан, телекамерийн системийн чиг хандлагыг өдөр ирэх тусам өөрчлөн, илүү боловсронгуй болгох ажлын эрчимтэйгээр хөгжүүлсээр ирсэн.

Тухайлбал Бүгд Найрамдах Энэтхэг Улсын DeepSight AILabs[182] нь шууд бичлэгээс объектуудыг илрүүлэх хиймэл оюун ухаан (AI) болон компьютерын харааны (CV) технологид суурилсан дүрс бичлэгт шинжилгээ хийдэг телекамерийн системийг үйлдвэрлэн Дели (Delhi) хотын хорих байгууллагуудын харуул хамгаалалтад ашиглахаар ажиллаж эхэлсэн нь бусад орнуудаас илүү үсрэнгүй явж байгааг харуулж байна.

Энэхүү технологийн бусад хиймэл оюун ухаанд суурилсан технологиос дэвшилтэд ялгаа нь телекамерт илэрсэн объект, хүн, зэвсэглэсэн этгээд, хар тамхи хэрэглэсэн иргэн, сэжигтэй үйлдэл гаргаж буй этгээдийн хөдөлгөөнийг маш богино хугацаанд илрүүлэх, тандалт хийх, задлан шинжилгээг нарийвчлан хийж, зөрчлийг илрүүлэн, гэмт явдал гарахаас урьтан шуурхай сэрэмжлүүлэг дохиог хяналтын төвд илгээснээр хорих ангийн аюулгүй байдал эрсдэлээс урьдчилан

[181] https://www.scmp.com/tech/start-ups/article/3021192/hong-kong-start-wildfaces-uses-ai-spot-potential-suicide-attempts

[182] https://deepsightlabs.com/ Энэтхэг, Их Британи, АНУ, Өмнөд Африкт үйл ажиллагаа явуулдаг хиймэл оюун ухаан, компьютерийн харааны технологийн компани

сэргийлэх, болзошгүй гэмт хэргийн үйл явцыг таслан зогсоох зориулалттай дэвшилтэд технологийн систем юм.

Монгол Улсад олон жилийн өмнөөс хэрэглэж заншсан бидний хэлдгээр энгийн телекамер буюу (CCTV) нь хүчин чадлын хувьд дүрс дамжуулах, зарим тохиолдолд дуу дамжуулах боломжтой байдаг нь үсрэнгүй хөгжиж буй цаг үеийн шаардлагыг хангахгүй байна гэж үзсэн. 2023 оны байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 1 цагдан хорих төв, 28 цагдан хорих байр нийт 29 шийдвэр гүйцэтгэх алба, салбар нэгжүүд телекамерийн системд холбогдсон боловч хяналтыг хүн буюу алба хаагч хянаж байна.

Аналог болон тоон технологийн CCTV ашигладаг байгууллагын хяналтын төвд 24 цагийн турш оператор буюу хүн ажиллаж хяналт тавин, зөрчил гарахаас сэргийлэн ажилладаг. Гэсэн хэдий боловч анагаахын шинжлэх ухаанд хүн минутад 17-20 удаа нүдээ анивчдаг, анхаарал төвлөрлийн хугацаа 10-52 минут үргэлжилдэг биологийн амьтан гэж үздэг тул телекамерийн хөдөлгөөнийг нэг бүрчлэн харж чадахгүй[183] гэсэн үг юм.

Өөрөөр хэлбэл хоногийн 24 цагийн үүрэг гүйцэтгэж буй теле-хяналтын ажилтан буюу хүн 1 цагт 1200 удаа, 10 цагт 12000 удаа 24 цагт 28800 удаа буюу дунджаар 6-8 цагийн хугацаатайгаар биологийн рефлексийн дагуу нүдээ анивчиж хяналтыг сулруулдаг гэж ойлгож болно.

Тэгвэл шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, аюултай гэмт хэрэг үйлдэх магадлалтай иргэн, хатуугаар хэлэхэд гэмт хэрэгтэн бие хүмүүстэй төлбөр барагдуулах чиглэлээр ажиллагаа явуулахад зөрчилдөөн үүсэх магадлал өндөр байдаг тул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, телекамерийн тусламжтайгаар тандалт хийснээр алба хаагчийн аюулгүй байдал хангагдах, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хэвийн явагдах зэрэг олон давуу талтай.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дугаар заалтад “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн, эсхүл хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан хүн, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан байдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангахад хиймэл оюун ухаанд суурилсан CCTV ашиглах, цаашлаад шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хяналтын системийг дараагийн түвшинд хүргэснээр аюулгүй байдал хангагдах давуу талтай.

Бүгд Найрамдах Энэтхэг Улсын DeepSight AILabs технологийн компанийн хиймэл оюун ухаан (AI) бүхий технологи нь хүний оюун ухаан шаарддаг даалгаврууды гүйцэтгэх боломжтой компьютерын харааны (CV) технологийг

[183] http://mlctraining.mn/b/2362 2021/08/31

Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад нэвтрүүлснээр гэмт хэрэгтэн хоригдол бие хүний зүгээс байнга өдүүлж байдаг гэмт үйлдлийг илрүүлэн таних, тэдний нүүр царай, зан төлөвт тандалт, дүн шинжилгээ хийх, хөдөлгөөн, байршил, чиглэлийг тасралтгүй буюу нүд цавчилгүйгээр 24 цагийн турш хянах, гэмт хэрэг, зөрчил гаргаж болзошгүй хоригдлуудыг шуурхай илрүүлэн, гэмт хэрэгтний зураг, бичлэгийг хяналтын төвийн компьютерт илгээн, анхааруулах дохио өгснөөр алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх системийн бүрдүүлэх боломж бүрдэх юм.

Зураг 1. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын DeepSight AILabs AI, CV дүрс бичлэгт шинжилгээ хийх технологи



Монгол Улс нь 2023 оноос нүүр царай танин бүртгэх телекамерийн системийг иргэдийн аюулгүй байдал, замын хөдөлгөөнд ашиглаж эхэлсэн харин Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага 2023 оны 3 дугаар сард 2 хорих ангид нүүр царай танин бүртгэх телекамерийг туршилтаар суурилуулаад байгаа боловч бидний судалгааны үр дүнд санал болгож буй хиймэл оюун ухаанд суурилсан (AI) технологи нь хүний нүүр царай танихаас гадна сэтгэл хөдлөлийн ерөнхий шинж, эрсдэлд үйлдэл, зүрхний цохилт, зэвсэг агуулж буй байдал, мансууруулах эм бэлдмэл, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг ялгаж салган боловсруулалт хийдгээрээ давуу талтай технологи юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад сүүлийн 10 жилд 446 гэмт хэрэг үйлдэгдсэн[184] байгаад дүгнэлт хийн, үйлдэгдэж байгаа гэмт хэргийн нотлох баримт болох хяналтын телекамерийн бичлэгт шинжээчийн дүгнэлт гаргуулах, урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр зохион байгуулах, боловсруулах шаардлага урган гарч байна.

[184] Шинжлэн магадлахуй сэтгүүл

Хяналтын телекамерын дүрс бичлэгт дүн шинжилгээ хийх нь шүүх шинжилгээний ажилтны гүйцэтгэх ажил мэт боловч, энэхүү хиймэл оюун ухаанд суурилсан хяналтын телекамерыг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр хүний оролцоогүйгээр телекамерын хөдөлгөөнд дүн шинжилгээг өгөгдсөн датанд үндэслэн, нарийвчилсан дүн шинжилгээг гаргаж, хууль сахиулах байгууллагын аюулгүй байдлыг найдвартай хангах боломжтой юм.

ДҮГНЭЛТ

Бидний судалснаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулахад нэн тэргүүнд алба хаагчийн аюулгүй байдал орох тул байгууллагын зүгээс шийдвэр гүйцэтгэгч нарын албан өрөөнд хиймэл оюун ухаанд суурилсан CCTV суурилуулах шаардлагатай.

Учир нь төлбөр төлөгч, төлбөр авагч нарын сэжигтэй үйлдэл, хөдөлгөөнийг маш богино хугацаанд илрүүлэн, тандалт хийж, задлан шинжилгээг нарийвчлан, зөрчлийг илрүүлснээр гэмт хэрэг үйлдэж болзошгүй, сэтгэцийн өөрчлөлтэй, хар тамхины хамааралтай иргэнийг илрүүлэн, шийдвэр гүйцэтгэгч нарт сэрэмжлүүлэг хүргүүлснээр ажиллагааг аюулгүй зохион байгуулах юм.

Цаашид шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь AI суурилсан CCTV-г үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр сэтгэцийн өөрчлөлттэй төлбөр төлөгч болон төлбөр авагч нарын датанд дүн шинжилгээ хийж, урьдчилан тодорхойлсноор, шийдвэр гүйцэтгэгч нарт гэмт хэрэг үйлдэж болзошгүй иргэний талаар бодитой сэрэмжүүлэг өгч, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах боломжтой гэж дүгнэлээ.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. https://en.wikipedia.org/wiki/Closed-circuit_television#History
2. https://mogulservice.mn/post/69502
3. https://deepsightlabs.com/ Энэтхэг, Их Британи, АНУ, Өмнөд Африкт үйл ажиллагаа явуулдаг хиймэл оюун ухаан, компьютерийн харааны технологийн компани
4. http://mlctraining.mn/b/2362 2021/08/31
5. Шинжлэн магадлахуй сэтгүүл 2022 он
6. Sisodiya, N., Dube, N., & Thakkar, P. (2020). Next-generation artificial intelligence techniques for satellite data processing. In Artificial Intelligence Techniques for Satellite Image Analysis (pp. 235-254). Springer, Cham.
7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль., 2017 он
8. https://www.researchgate.net/publication/362860111_zajnaas_tandsan_drs_medeeg_bolovsruulah_hijmel_ouuny_arguud_ba_tedgeerijn_hereglee

ЭМЭГТЭЙ ХОРИГДЛЫГ ХҮҮХДИЙНХ НЬ ХАМТ БАЙЛГАХ ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГ

REGULATORY FEATURES TO KEEP FEMALE PRISONER WITH HER CHILD



С.Эрдэнэбат
Дотоод хэргийн их сургуулийн
Биеийн тамир, албаны бэлтгэлийн институтийн багш, хошууч

Товч агуулга: Хүний эрхийн түгээмэл тунхаглал /1948/-ын16 дугаар зүйлийн 3 дугаар хэсэгт гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж мөн бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй гэж заасан байдаг.

Эрүүгийн ял эдлүүлэхэд жендер буюу хүйсээр ялгах нь энэрэнгүй болон шударга ёсны зарчмын илрэл юм. Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэрэг үйлдэхэд шууд нөлөөлдөг эмэгтэйчүүдийн гэмт хэрэг нь улс орон болон олон нийтийн анхаарлын төвд байсаар ирсэн.

Илтгэлд насанд хүрсэн эмэгтэй хоригдлын хүүхдийг нь хамт байлгах эрх зүйн зохицуулалтад дүгнэлт хийсэн**.**

Түлхүүр үг: Эмэгтэй хоригдол, хүүхэд, эрхийн хязгаарлалт, хоригдлын эрх, үүрэг.

Abstract: Section 3 of Article 16 of the Universal Declaration of Human Rights /1948/ states that family is the basic unit of social norms and has the right to protect it from society and government. Gender, or gender, in juvenile sentencing is a reflection of the principle of clemency and justice. Women's crimes, which directly affect minors committing crimes, have long been a focus of national and public attention. The talks concluded a judicial settlement for an adult female prisoner to keep her child together.

Keywords: Female prisoners, children, rights restrictions, prisoner rights and duties.

Монгол Улсын Үндсэн хуульд Монголын ард түмэн бид хүний эрх, эрх чөлөөг дээдлэхийг эрхэм зорилго болгоно гэж заасан байдаг. Энэхүү ардчилсан зарчим нь хүний эрхийг хангах олон улсын үзэл баримтлалд нийцэж байгаа юм.

Монгол Улсад энэ цаг үед өрнөж буй эрх зүйн шинэтгэлийн тогтолцоонд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил онцгой байр суурийг эзэлж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, тэдгээрийг таслан зогсоох, хянан шийдвэрлэх, гэмт хэрэг, зөрчлийн улмаас учирсан хор хохирлыг нөхөн төлүүлэх, холбогдох этгээдийг өөрчлөн нийгэмшүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг дахин үйлдэх явдлыг гаргуулахгүй байхад чиглэсэн эрх зүй, эдийн засаг, хүмүүнлэг, нийгмийн цогц арга хэмжээ ба энэ тогтолцоонд гүйцэтгэх эрх зүйн үүрэг, ач холбогдолтой юм.

Монгол Улсын Эрүүгийн хууль шинэчлэн баталснаар гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд шүүхээс оногдуулж буй хамгийн хүнд ял нь хорих ял болсон бөгөөд ялын төрлөөс цаазаар авах ялыг хассан юм. Үүнтэй холбогдуулан судлаач Б.Замбагын саналтай нийлж болох бөгөөд эрх зүйн шинэтгэлийн хүрээнд батлагдсан Эрүүгийн хууль нь өмнөх хуулиас 40 орчим хувиар өөрчлөгдсөн бөгөөд ял шийтгэлийн бодлогын хувьд зөөлөрсөн[185].

Эрүүгийн хариуцлагын мөн чанар нь иргэний тодорхой эрхийг хязгаарлах явдал бөгөөд эрх нь хамгийн ихээр хязгаарлагддаг иргэд болох хорих ял эдлэгчдийн эрх, тэр дундаа эмэгтэй хоригдлын эрхийг хангах явдал нь тодорхой онцлогуудтай байдаг. Дээр дурдсанчлан Эрүүгийн хууль нь ял шийтгэлийн бодлогын хувьд зөөлөрсөн хэдий ч гэмт хэрэг үйлдсэн эмэгтэй хүний хувьд тодорхой хэмжээгээр хүндэрсэн бөгөөд хугацаагүй хорих ял буюу бүх насаар хорих ял оногдуулдаг болсон. Гэхдээ эрэгтэй хоригдлоос ялгамжтай, эрх зүйн байдлын хувьд давуу байдал нь бүх насаараа хорих ял эдэлж байгаа эмэгтэй хоригдол 90 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт эрхтэй байдаг бөгөөд тухайн ялыг эдэлж байгаа эрэгтэй хоригдол удаан хугацааны уулзалт хийх эрхгүй байдаг. Тухайн байдлыг Монгол Улсын Үндсэн хуулийн хүн бүр хуулийн өмнө эрх тэгш байна зөрчилдөж байна гэж үзсэн байдаг[186].

Мөн дахин ялгамжтай хандаж байгаа байдал нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 198, 199 дүгээр зүйлийн дагуу нээлттэй хаалттай хорих ангид ял эдэлж байгаа эрэгтэй хоригдол зөвхөн илгээмж авах эрхтэй байгаа бөгөөд тус хуулийн 202 дугаар зүйлийн дагуу нээлттэй хорих ангид ял эдэлж байгаа эмэгтэй хоригдол илгээмж явуулах , хүлээн авах эрхтэй байгаа юм.

Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдсэн хүний эрх чөлөөг тодорхой хугацаагаар, эсхүл бүх насаар нь хязгаарлаж нээлттэй эсхүл хаалттай хорих байгууллагад байлгахыг хорих ял гэнэ гэж заасан бөгөөд хорих ялын бусад ялаас ялгагдах онцлог нь хоригдлыг нийгмээс тусгаарлах явдал юм.

---

[185] *Б.Замбага.* Хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн ялтны эрх зүйн байдлыг тодотгох нь // Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа: хэрэгжилт, чиг хандлага. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. 2018. УБ., 49 дэх тал.

[186] *Б.Галбадрах, Б.Ануужин* Хоригдлын гэр бүлийн гишүүнтэй удаан хугацаагаар уулзах эрхийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудал // Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал. 2018. № 1. 26-27 дах тал.

Академич С.Нарангэрэл “Хорих ял бол МУ-ын Эрүүгийн хуульд заасан үндсэн бөгөөд хамгийн хатуу төрлийн ял мөн. Хорих ялын үндсэн агуулга нь ялтныг олон нийтээс тусгаарлаж харуул, хамгаалалт, хяналт бүхий хорих байгууллагад байлгахад оршино. Энэ ял нь гол төлөв онц хүнд, хүнд гэмт хэрэг үйлдэгсэд, онц аюултай гэмт хэрэгтэнд зориулагдсан ял юм” гэсэн байна[187].

Сүүлийн 5 жилийн хугацаанд манай улсад эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурь нэлээдгүй өөрчлөгдсөн. Эдгээр өөрчлөлтүүдэд эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах асуудал, хүүхдийн мөнгө олгох асуудал, жижиг сум, дүүрэгт эдийн засгийн бололцоогүй эмэгтэйчүүдийн тоо нэмэгдсэн явдлыг хамааруулж болох юм. Хорих ял эдэлж байгаа эмэгтэйчүүдийн дийлэнх хувийг хувийн хэвшлийн байгууллагад ажилладаг, хувираа хөдөлмөр эрхэлдэг, малчин эсхүл тодорхой эрхэлсэн ажилгүй, эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн эмэгтэйчүүд эзэлдэг байна.

Архидалт, мансууруулах бодистой тэмцэх ажил сул байгаагаас эмэгтэйчүүд согтуурсан, мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдэх явдал өссөөр байгаа нь ажиглагдаж байгаа бөгөөд үүнтэй зэрэгцэн хөрш оронд болон манай улсад эмэгтэйчүүд хууль бусаар мансууруулах бодис тээвэрлэх, худалдаж борлуулах, хэрэглэх гэмт хэрэг үйлдэх, тухайн гэмт хэргийг давтан үйлдэх нь ажиглагдаж байна.

Цагдаагийн ерөнхий газраас гаргадаг гэмт хэргийн судалгаанаас харахад 2015 онд нийт гэмт хэрэг үйлдэгчдийн 15.2% /3782/, 2016 онд – 15% /3592/, 2017 – 13.9% /2532/ нь эмэгтэйчүүд байна. Гэмт хэрэг үйлдсэн эмэгтэй хүнд хорих ялыг илүү өргөнөөр оногдуулж байгаа бөгөөд тухайн эмэгтэйчүүдэд засралын нөлөө үзүүлэх эрүүгийн хариуцлагын хэлбэр болоод байна.

Хоригдол тэр дундаа эмэгтэй хоригдол нь нийгэм тэр дундаа гэр бүлээсээ тусгаарлагдсанаар гэр бүлийн харилцаагаа тогтвортой авч явахад хүндрэл учирдаг нь тодорхой бөгөөд гэр бүлийн хэрэгцээний хамгийн гол түвшний хэрэгцээнд гэр бүлийн сайн сайхан, бат бэх байхад гол нөлөөтэй хэрэгцээ байдаг. Үүнтэй холбогдуулан профессор Н.Гантулга, хорих ял эдлэх үйл явцтай уялдан дийлэнх ялтны нийгмийн эерэг, бодит хэлхээ холбоо тасрах, тасалдах гэх мэт сөрөг өөрчлөлтүүд гардгийг онцолж байна[188].

Хорих ял шийтгүүлсэн хүний хувьд ял эдлэх хорих ангид хуваарилагдсанаар хорих байгууллагын нийгмийн ажлын субъект болж тодорхой хугацааны дараа нийгмийн хэвийн амьдралд нэгтгэгдэж байдаг. Хоригдлыг нийгэмшүүлэх гол хүчин зүйл нь хорих байгууллагаас гадуурх харилцаа буюу гэр бүлийн харилцаа бөгөөд хүүхдийнх нь хамт байлгах явдал юм.

---

[187] *С.Нарангэрэл.* Монгол Улсын эрүүгийн эрх зүй ерөнхий анги. 1999. УБ., 268 дахь тал.
[188] *Н.Гантулга.* Хүний эрх ба хорих ял. УБ, 2015. 136 тал.

Эмэгтэй хоригдлыг хүүхэдтэй нь хамт байлгах зохицуулалтыг хуульчилж ирсэн уламжлалыг судлахад **1931 оны Монгол Ард Улсын дотор аливаа хэрэгтэн ялтанг засан сайжруулах ажлын тухайн хуульд** эмэгтэй хоригдлыг хүүхэдтэй нь хамт байлгах зохицуулалт байгаагүй бөгөөд ял эдлүүлэх ажиллагааг зохицуулсан заалт байсан бөгөөд жирэмсэн болсоор 5 сар өнгөрсөн эмэгтэйчүүдийг тэдгээрийн зөвшөөрөлгүйгээр засан сайжруулах газраас гадагш ажилд томилж үл болохоос гадна төрүүлэхийн урьд, хожил 45 хоногийн дотор аливаа ажлаас бүр мөсөн чөлөөлнө гэж заасан байдаг.

1966 оны Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуульд жирэмсэн эмэгтэйчүүд буюу хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүд насанд хүрээгүй хүмүүсийн ахуй нөхцөлийг сайжруулж тэдэнд нэмэгдэл хоол олгоно гэсэн мөн гяндангийн хатуу дэглэмд жирэмсэн буюу хөхүүл хүүхэдтэй эмэгтэй хоригдлыг байлгаж болохгүй гэсэн зүйл заалт байсан байна.

1981 оны Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуульд хорих ял эдэлж байгаа жирэмсэн эмэгтэйчүүдийн ялыг БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 352 дугаар зүйлд зааснаар төрөхөөс өмнө 45 хоног хүүхэд төрүүлснээс хойш нэг жилийн хугацаагаар хойшлуулна гэсэн заалт байснаас гадна жирэмсэн буюу хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүдийг торгуулийн тусгаарласан байр ганцаарчилсан буюу хатуу тасалгаа (карцер) гяндангийн чанга дэглэмд шилжүүлж болохгүй гэсэн заалт байжээ.

1993 оны Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай хуульд насанд хүрээгүй болон эмэгтэй хоригдлыг ялыг жирийн чанга онцгой дэглэмтэй хорих ангид тус тусад нь ял эдлүүлнэ гэсэн ба эмэгтэй хоригдлын ядыг зөвхөн эмэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлнэ эмэгтэй хоригдлыг ердийн нийтийн байранд байлгана жирэмсэн болон насанд хүрээгүй эмэгтэй хоригдлыг тусад нь байлгана түүнчлэн сахилгын байранд насанд хүрээгүйчүүд болон эмэгтэйчүүдийг 15 хүртэл хоног онцгой тохиолдолд 30 хүртэл хоног байлгана мөн эмнэлгийн комиссын дүгнэлтийн харгалзан жирэмсэн болон өвчтэй хоригдлыг нөхцөлийг нь сайжруулсан байранд байлгаж хоолны илчлэгийн хэмжээг нэмэгдүүлнэ гэж заасан байна.

2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд эмэгтэй хоригдлыг зөвхөн эмэгтэйчүүдийн хорих ангид ял эдлүүлнэ жирэмсэн болон насанд хүрээгүй эмэгтэй ялтныг тусад нь байрлуулна гэснээс гадна ял эдэлж байх хугацаандаа амаржсан ялтныг 0-1 насны хүүхэдтэй нь хамт байлгаж болно гэж заасан нь тухайн үедээ эмэгтэй ялтантай хүүхдийг нь хамт байлгах шинэлэг зохицуулалт болсон байна.

2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хорих ял шийтгүүлсэн эмэгтэй хоригдлын ялыг эмэгтэйчүүдийн нээлттэй хаалттай хорих

ангид эдлүүлнэ ял эдэлж байх хугацаандаа хүүхэд төрүүлсэн хоригдлыг хүүхдийг нь хоёр нас хүртэл хамт байлгаж болно хүүхэд нь хоёр нас хүрсэн боловч эмэгтэй хоригдлын ял эдлэх үлдэгдэл хугацаа 1 жилээс илүүгүй тохиолдолд хорих ял эдлэх хугацааг дуусах хүртэл хүүхдийг үргэлжлүүлэн хамт байлгаж болно мөн хорих анги нь эхийн хамт байгаа хоёр хүртэлх насны хүүхдийг эрүүл өсөж бойжих аюулгүй орчинг бүрдүүлсэн тусгай байр нөхцөлөөр хангана гэж заасан бөгөөд энэрэнгүй ёсны зарчмын илрэл болсон байна.

Д.Уранчимэгийн тэмдгэлснээр 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд орсон өөрчлөлт нь олон улсын гэрээ конвенц НҮБ-ын Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэмд нийцсэн байна[189].

Хоригдлын эрх, тэр дундаа эмэгтэй хоригдлын эрхийг хангахад олон улсын баримт бичиг, олон улсын стандарт, зөвлөмжүүд чухал ач холбогдолтой билээ. Хорих ял эдлүүлэх ажиллагааны Үндсэн хууль гэж нэрлэгддэг **1955 оны Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүдэд** эрэгтэй эмэгтэй хүмүүсийг боломжийн хирээр тусдаа хорих газруудад байлгана хэрэв эрэгтэй эмэгтэй хүмүүс тэд нэг хорих газарт байгаа бол эмэгтэйчүүдийг тусдаа өрөө тасалгаанд байрлуулбал зохино эмэгтэйчүүдийн хорих газар нь жирэмсэн болон төрсөн эхчүүдийг асрах тусгай өрөөтэй байх ёстой боломжтой бол эмэгтэйчүүдийг шоронгийн бус өөрийн эмнэлэгт төрүүлэхэд анхаарвал зохино хэрэв хүүхэд шоронд төрсөн бол энэ тухай төрсний гэрчилгээнд тэмдэглэхгүй байх нь зүйтэй хоригдол эхчүүдэд хүүхдээ өөртэй нь байлгахыг зөвшөөрдөг бол эдгээр хүүхдийг эхээс тусдаа байх үед нь асрах мэргэжлийн ажиллагсадтай ясли байгуулах хэрэгтэй гэсэн байна.

2015 оны НҮБ-ын Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүдэд /Нельсон Манделлын дүрэм/ хорих газар нь жирэмсэн болон төрсөн эхчүүдийг асрах, сувилах тусгай өрөөтэй байх. Боломжтой бол эмэгтэйчүүдийг шоронгийн бус өөрийн эмнэлэгт төрүүлэхэд анхаарвал зохино хэрэв хүүхэд шоронд төрсөн бол энэ тухай төрсний гэрчилгээнд тэмдэглэхгүй байх нь зүйтэй гэж заасан байдаг. Эмэгтэй хоригдол хүүхэдтэйгээ хамт байх тохиолдолд хамгийн түрүүнд хүүхдийн хууль ёсны ашиг сонирхлыг харгалзаж үзэх нь зүйтэй. Хүүхдийг нь хамт байлгахыг зөвшөөрсөн тохиолдолд хүүхдийг нь асрах тусгай мэргэшсэн алба хаагчидтай байх; хүүхдийн мэргэшсэн эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, хүүхдийн хэвийн өсөж бойжиж байгаад хяналт тавих эмнэлгийн хэсэгтэй байх гэж заасан байна.

Эмэгтэй хүний онцлог нь хорих ял эдлүүлэх хугацаанд тодорхой хүндрэлүүдийг дагуулж байдаг. Суллагдсны дараа тэдний дийлэнх нь тулгарсан

[189] *Д.Уранчимэг.* Эмэгтэй хоригдлын криминологи шинж, тэдэнд үзүүлж буй нийгмийн ажлын үйлчилгээ, тулгамдсан асуудал // Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал. 2017. № 4. 47 дах тал.

хүндрэл, бэрхшээлийг бие даан шийдвэрлэж чаддагүй бөгөөд энгийн амьдралд эргэн нэгдэж чаддаггүй.

2018 оны 06 дугаар сарын 01-ний байдлаар ШШГЕГ-ын харьяа 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид нийт 143 хоригдол ял эдэлж байгаагаас нээлттэй хорих ангид 107 /73%/, хаалттай хорих ангид 39 /27%/ хоригдол ял эдэлж байна. Нээлттэй хорих ангид ял эдэлж байгаа хоригдлуудын 28%-ийг хүнийг алах гэмт хэрэг, 20%-ийг залилах, 10.2%-ийг хулгайлах гэмт хэрэг үйлдсэн, хаалттай хорих ангид ял эдэлж байгаа хоригдлуудын 76.9% ийг хүнийг алах гэмт хэрэг, 10.2%-ийг залилах гэмт хэрэг үйлдсэн хоригдлууд эзэлж байна.

“Яллагдсан эх” гэдэг нь их өргөн ойлголт юм. Энэ нь хорих байгууллагад өөрийн хүүхдийн хамт байгаа эсхүл хамаатан садных нь эсхүл асрамжийн газрын асран хамгаалалтад хүүхдүүд нь байгаа ял эдэлж байгаа этгээдийг хэлэх юм.

Судалгаанаас харахад 2018 оны 06 дугаар сарын 01-ний нээлттэй хорих ангид 3 нярай хүүхэдтэй, 3 жирэмсэн хоригдол, хаалттай хорих ангид 1 нярай хүүхэдтэй, 1 жирэмсэн хоригдол ял эдэлж байгаа бөгөөд эхийн хамт байгаа хоёр хүртэл насны хүүхдийг эрүүл өсөж бойжих, аюулгүй орчинг бүрдүүлсэн тусгай байр нөхцөлөөр ханган ажиллаж байна.

Хорих ял эдлэх нөхцөлд эмэгтэй нь хорих байгууллагын дотоод цагийн хуваарийн дагуу, эрх чөлөө, эд зүйлийн хувьд, хүүхдээ асрах боломж тодорхой хэмжээгээр хязгаарлагдсан байдаг. Үүнтэй холбогдуулан доктор /Ph.D./ Р.Оюунбадамын эмэгтэй хоригдол аль болохоор гэр бүл, төрөл садан, хүүхдээс нь хөндийрүүлэхгүй байхаар зохицуулалттай байх нь чухал. Хэдийгээр эх нь хоригдож байгаа ч хүүхдээ үзүүлэх эхийн хайр халамжийн залгамж холбоог таслахгүй байлгах үүргийг хорих ангийн захиргааны ажилтнууд хүлээх ёстой гэж үзсэнтэй санал нийлэх нь зөв юм[190].

Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 202.6 дугаар зүйлд ял эдэлж байх хугацаандаа хүүхэд төрүүлсэн хоригдлыг хүүхдийг хоёр нас хүртэл хамт байлгаж болно. 202.7 дугаар зүйлд хүүхэд нь хоёр нас хүрсэн боловч эмэгтэй хоригдлын ял эдлэх хугацаа 1 жилээс илүүгүй тохиолдолд тохиолдолд хорих ял эдлэх хугацааг дуусах хүртэл хүүхдийг үргэлжлүүлэн хамт байлгаж болно гэж заасан байдаг.

Судлаачдын дэвшүүлсэн санааг судлан үзэхэд:

- Хорих ял эдэлж байгаа эмэгтэй хоригдол хүүхэдтэйгээ хамт байх нь тухайн хоригдолд эерэг нөлөө үзүүлдэг. Хүүхэдтэйгээ тогтмол харьцах нь эмэгтэй хоригдлын зан байдлыг сайн тал уруу хөтөлдөг, илүү их тэвчээртэй

[190] *Р.Оюунбадам.* Эмэгтэй хоригдолд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээний онцлог. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал. 2017. № 4. 25 тал.

болгодог, эхийн сэтгэл нь амьдралын зөв хэвшлийг тогтоодог, дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлдэг;

- эмэгтэй хоригдол нь хүүхэдтэйгээ хамт байх нь тэдний дунд амьд харьцаа үүсэх боломжийг үүсгэдэг. Хүүхэдтэйгээ **зөв харьцах** нь хүүхдэд зөв хүн болж төлөвших, хөгжихөд ихээхэн нэмэртэй байдаг.

Гэвч эмэгтэй хоригдолтой хүүхдийг нь хамт байлгахад тодорхой асуудал тулгарч байгаа бөгөөд хүүхэд тухайн хоригдлыг нийгэмшүүлэх хэрэгсэл болж байна. Дээрх судалгаанаас харахад ял эдэлж байгаа дийлэнх хоригдлууд нь хүн алах, залилах гэмт хэрэг үйлдсэн, хүний амь, эд хөрөнгийг хайрлаж чадаагүй хүн хүүхдээ зөв үлгэр дууриал үзүүлж, **зөв харьцаж** чадах эсэх нь эргэлзээтэй байгаа юм.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас гаргасан судалгаанаас харахад хүүхэд хүн болж төлөвших хамгийн чухал, шийдвэрлэх нас нь 0-5 нас бөгөөд бие өсөх нь хурдан, махбод эдгэх нь амархан, эд эс идэвхтэй урган төлждөг нас бөгөөд түүнийг Хан Хөвүүн мэт асарч хүмүүжүүл гэсэн байна. Гэтэл энэ тухайн насан дээрээ хүүхэд гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн хамт хязгаарлагдмал орчинд өсөж бойжиж байгаа нь яахын аргагүй анхаарал татах зүйл юм.

Монголчуудын хүүхдээ хүмүүжүүлэх үндсэн арга нь дэг журмыг таниулах гэрийн сургаал бөгөөд түүнийг хэрэгжүүлэх хөтөч нь аав ээж, гэрийн ахмад хүмүүс байдаг бөгөөд хүүхдийн насны онцлогийг харгалзан аливааг заах, дагуулан сургах, ухааруулан өсгөдөг.

Нэг хүртэл насны хүүхдийн хөгжилд аав, ээжийн хайр энэрэл, анхаарал халамж хамгийн чухал үе байдаг. Энэ насны хүүхдүүд ямар нэгэн зүйл хэрэгтэй болбол хамгийн түрүүнд уйлдаг бөгөөд хүсэл, шаардлагыг нь ойлгох хэрэгтэй байдаг бөгөөд гэмт хэрэг үйлдсэн, эргэн тойронд байгаа төрсөн бусад эмэгтэйчүүд, сэтгэл санааны хувьд тогтворгүй эмэгтэй хоригдлуудын хувьд тэвчээртэй хандах, тайвнаар хүлээж авах нь мөн эргэлзээ дагуулж болох юм. Тухайн нас нь хүүхдүүд томчуудыг хийж байгаа үйлдлийг дуурайх гэж хичээдэг үе байдаг ба буруу үлгэр дурайл, буруу жест, үйл хөдлөл зааж өгөх нь сөрөг нөлөөтэй байж болох юм.

Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуулинд хүүхэд эрүүл өсч бойжих, аюулгүй орчинд амьдрах, аливаа хүчирхийллээс ангид байх эрхтэй. Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй. Хүүхдийг хүмүүжүүлэх нь хүүхдэд бие хүний сайн сайхан шинж байдал зөв үйл, ёс суртахууны үнэт чанарыг төлөвшүүлэх тасралтгүй үйл ажиллагаа байх бөгөөд хүүхдийг хүмүүжүүлэхэд эцэг эхээ хайрлах, бусдыг хүндэтгэх, туслах; эх орон, байгаль орчноо хайрлан хамгаалах гэх мэт чиглэлүүдийг баримтална гэж заасан байдаг.

Гэтэл хүүхэд хүн болж төлөвших хамгийн чухал, шийдвэрлэх насан дээрээ таатай орчин нөхцөлөөр бүрэн хангагдаагүй, бусад гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын хажууд өсөж бойжиж байгаа нь тэднийг зөв хүн болж төлөвшихөд асуудал дагуулж байна. Мөн Монгол Улсын хэмжээнд гэмт хэрэг үйлдсэн эмэгтэйчүүдийг ял эдлүүлэх ганц л хорих анги байдгаас ар гэр нь хөдөө орон нутагт байдаг хоригдлуудын хүүхдүүдэд нэн хэрэгцээтэй зүйлийг дамжуулахад хүндрэлтэй байдаг. Мэдээж тухайн хүүхдэд эхийн хараа хяналт чухал ч хажууд нь байгаа хүмүүс ихээр нөлөө үзүүлдэг юм.

Гадаадын орнуудын туршлага, олон улсын нийтлэг жишгээс үзвэл Австралийн Сидней хотын төвд орших Эмэгтэйчүүдийн нэгэн хориход эх ба хүүхэд гэдэг хөтөлбөр хэрэгжүүлдэг. Тэрхүү хөтөлбөрийг Засгийн газраас баталж өгдөг бөгөөд хориход эхчүүд 4 хүртэлх насны хүүхэдтэйгээ хамт ялаа эдэлдэг. Хөтөлбөрийн дагуу хоригдол эмэгтэйчүүдэд хүүхдээ яаж асрах вэ, хоол хүнсээ яаж бэлтгэх вэ, хүүхдээ яаж хүмүүжүүлэх гэх мэт сургалтууд явагддаг юм.

ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх тухай хуулийн дагуу эмэгтэй хоригдлыг хүүхдийг гурав нас хүртэл хамт байлгаж болдог ба хорих ангийн дэргэд хүүхдийг өсөж бойжиход таатай нөхцөлөөр хангагдсан тусгай хүүхдийн байр байдаг. Эмэгтэй хоригдлыг ажлын бус цагаар хүүхэдтэйгээ уулзахыг зөвшөөрдөг ба хамт амьдрахыг мөн зөвшөөрдөг байна. Мөн мэргэшсэн хүүхдийн эмч ажилладаг юм.

Доктор /Ph.D./ Р.Оюунбадам хорих ангид эхийн хамт байгаа хүүхдүүдийг олон улсад нийгмийн эмзэг бүлэгт хамааруулан үздэг бөгөөд ихэнх тохиолдолд тэд хоол хүнсний хүрэлцээ хомс, эрүүл мэндийн үйлчилгээ хүртээмжтэй авч чаддаггүйгээс гадна хорих ангид эхийн хамт байдгаас шалтгаалан хязгаарлагдмал орчинд өсөж бойждог байна гэж тэмдэглэсэн нь манай орны хувьд мөн адил байгаа юм[191].

Дээр дурьдснаас үндэслэн хүүхдийг хүмүүжүүлэх, зөв хүн болгохын тулд тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж, таатай орчныг бүрдүүлэх шаардлагатай бөгөөд НҮБ-ын Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэмд тусгагдсан зөвлөмжүүдийг өөрийн оронд нэвтрүүлэн хорих ангийн дэргэд мэргэшсэн алба хаагчидтай тусгай цэцэрлэг байгуулах, хүүхэд харах үйлчилгээг нэвтрүүлэх, хүүхдийн өсөж бойжиход хяналт тавих хүүхдийн мэргэшсэн алба хаагчдыг ажиллуулах нь зүйтэй юм.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуулинд хүүхэд эрүүл өсч бойжих, аюулгүй орчинд амьдрах, аливаа хүчирхийллээс ангид байх эрхтэй. Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд

[191] *Р.Оюунбадам.* Дурдсан зохиол. 37 дах тал.

хамгаалагдах эрхтэй. Хүүхдийг хүмүүжүүлэх нь хүүхдэд бие хүний сайн сайхан шинж байдал зөв үйл, ёс суртахууны үнэт чанарыг төлөвшүүлэх тасралтгүй үйл ажиллагаа байх бөгөөд хүүхдийг хүмүүжүүлэхэд эцэг эхээ хайрлах, бусдыг хүндэтгэх, туслах; эх орон, байгаль орчноо хайрлан хамгаалах гэх мэт чиглэлүүдийг баримтална гэж заасан байдаг.

Гэтэл хүүхэд хүн болж төлөвших хамгийн чухал, шийдвэрлэх насан дээрээ таатай орчин нөхцөлөөр бүрэн хангагдаагүй, бусад гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын хажууд өсөж бойжиж байгаа нь тэднийг зөв хүн болж төлөвшихөд асуудал дагуулж байна. Мөн Монгол Улсын хэмжээнд гэмт хэрэг үйлдсэн эмэгтэйчүүдийг ял эдлүүлэх ганц л хорих анги байдгаас ар гэр нь хөдөө орон нутагт байдаг хоригдлуудын хүүхдүүдэд нэн хэрэгцээтэй зүйлийг дамжуулахад хүндрэлтэй байдаг. Мэдээж тухайн хүүхдэд эхийн хараа хяналт чухал ч хажууд нь байгаа хүмүүс ихээр нөлөө үзүүлдэг юм.

Гадаадын орнуудын туршлага, олон улсын нийтлэг жишгээс үзвэл Австралийн Сидней хотын төвд орших Эмэгтэйчүүдийн нэгэн хориход эх ба хүүхэд гэдэг хөтөлбөр хэрэгжүүлдэг. Тэрхүү хөтөлбөрийг Засгийн газраас баталж өгдөг бөгөөд хориход эхчүүд 4 хүртэлх насны хүүхэдтэйгээ хамт ялаа эдэлдэг. Хөтөлбөрийн дагуу хоригдол эмэгтэйчүүдэд хүүхдээ яаж асрах вэ, хоол хүнсээ яаж бэлтгэх вэ, хүүхдээ яаж хүмүүжүүлэх гэх мэт сургалтууд явагддаг юм.

ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх тухай хуулийн дагуу эмэгтэй хоригдлыг хүүхдийг гурав нас хүртэл хамт байлгаж болдог ба хорих ангийн дэргэд хүүхдийг өсөж бойжиход таатай нөхцөлөөр хангагдсан тусгай хүүхдийн байр байдаг. Эмэгтэй хоригдлыг ажлын бус цагаар хүүхэдтэйгээ уулзахыг зөвшөөрдөг ба хамт амьдрахыг мөн зөвшөөрдөг байна. Мөн мэргэшсэн хүүхдийн эмч ажилладаг юм.

Доктор /Ph.D./ Р.Оюунбадам хорих ангид эхийн хамт байгаа хүүхдүүдийг олон улсад нийгмийн эмзэг бүлэгт хамааруулан үздэг бөгөөд ихэнх тохиолдолд тэд хоол хүнсний хүрэлцээ хомс, эрүүл мэндийн үйлчилгээ хүртээмжтэй авч чаддаггүйгээс гадна хорих ангид эхийн хамт байдгаас шалтгаалан хязгаарлагдмал орчинд өсөж бойждог байна гэж тэмдэглэсэн нь манай орны хувьд мөн адил байгаа юм[192].

Дээр дурьдснаас үндэслэн санал гаргах нь:

1. Хоёр хүртэл насны хүүхэдтэйгээ байгаа эмэгтэй хоригдлын хүүхдэд хэрэглэх живх, витамин, нэмэлт хэрэгсэл зэргийн хангалтыг сайжруулах,

2. Хүүхдийг хүмүүжүүлэх, зөв хүн болгохын тулд тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж, таатай орчныг бүрдүүлэх

[192] *Р.Оюунбадам.* Дурдсан зохиол. 37 дах тал.

3. Зөв хүн болгохын тулд тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж, таатай орчныг бүрдүүлэх шаардлагатай бөгөөд НҮБ-ын Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэмд тусгагдсан зөвлөмжүүдийг өөрийн оронд нэвтрүүлэн хорих ангийн дэргэд мэргэшсэн алба хаагчидтай тусгай цэцэрлэг байгуулах,

4. Хүүхэд харах үйлчилгээг нэвтрүүлэх,

Хүүхдийн өсөж бойжиход хяналт тавих хүүхдийн мэргэшсэн алба хаагчдыг ажиллуулах нь зүйтэй юм.

ХОРИГДЛЫГ САЙШААЖ УРАМШУУЛЖ ИРСЭН УЛАМЖЛАЛ

A HISTORICAL ASPECT OF ENCOURAGEMENT OF PRISONERS



Ш.Дэчинбал

Дотоод хэргийн их сургуулийн Сургалт, судалгааны 403 дугаар анги- Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн магистрант, ахмад

Товч утга: Өгүүлэлд хоригдлыг урамшуулах эрх зүйн зохицуулалт, урамшуулж байсан түүхэн баримтын талаар судалсан.

Түлхүүр үгс: хоригдол, урамшуулах, хөдөлмөр.

Abstract: The article examines the legal regulation of incentivizing prisoners and the historical facts of incentivization.

Keywords: prisoner, incentive, labor.

Монгол Улсын хорих ял эдлүүлэх ажиллагааны түүхэн уламжлалд хоригдлыг хүмүүжүүлэх, хорих ангийн дэглэм журмыг биелүүлэх ажлын хүрээнд дан ганц албадлагын арга хэмжээ хэрэглэж ирсэнгүй, хоригдлын сэтгэл зүйд нөлөөлөх олон арга хэмжээг хэрэгжүүлж ирсний нэг нь хоригдлыг онц сонирхолтой олон хэлбэрээр шагнаж урамшуулж байсан явдал юм.

Хорих ял эдэлж байгаа хүмүүс нь хөдөлмөр, хүмүүжил, урлаг, спортын арга хэмжээнд тодорхой амжилт гаргасан, мэргэжлийн болон ерөнхий боловсролын сургалтад идэвх чармайлт гаргаж үр дүнтэй хамрагдсан, шинийг санаачилсныг нь зөв үнэлж урамшуулж байсан уламжлалын талаар эрдэмтэн судлаачдын бүтээлүүдэд тусгагдсан байдаг. Тухайлбал:

Төрөөс хорих ял эдлүүлэх байгууллагын эрхлэх үйлдвэрлэл чиглэл байршлыг зөв тогтоож хоригдлыг ажлаар хангахад зохих анхаарал тавьж ирсэн нь энэ чиглэлээр удаа дараа гаргасан баримт бичгийн агуулгаас тодорхой харагддаг байна. Эдгээрийн дотор түүхэнд томоохон байр суурь эзлэх шийдвэр бол 1929 оны 06 дугаар сарын 14-нд Засгийн газрын 9 дүгээр хурал, Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 55 дугаар хурлаар батлагдсан “Аливаа хэрэгтэн ялтнаар үйлдвэрлэл хийлгэх тухай дүрэм юм.[193]

[193] “Эрх зүй, албаны мэдээл” сэтгүүл, УБ., 1997 он, дугаар 1, 59 дэх тал.

Засан хүмүүжүүлэх байгууллагын түүхэнд хоригдлын хөдөлмөрийг зөв оновчтой зохион байгуулж улсаас өгсөн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 1960-1975 онуудад давуулан биелүүлсэн, мөн 6 дугаар таван жилийн /1976-1980/ төлөвлөгөөг хугацаанаас нь 22 хоногийн өмнө 100.4 хувааръ, 7 дугаар таван жилийн төлөвлөгөөг 107.5 хувааp биелүүлж ирсэн түүхтэй. Үйлдвэрлэлийн төлөвлөгөөг хугацаанд нь чанартай биелүүлж ирсэн нэг зүйл бол социалист уралдааныг офицер албан хаагчид, албадын дунд болон ялтнуудын дунд хөдөлмөрийн уралдаан зарлан 3, 5, 7, 14, 30 хоногийн хугацаанд дүгнэж ирсэн явдал байв.

Хоригдлын дунд зарласан хөдөлмөрийн уралдааныг эрчимжүүлэх гол хэлбэр бол тэдний хөдөлмөрийг үнэлэн ажлын хоногоор шагнах явдал байв. Зарим жишээг дурдвал:

- ЗСБНХУ байгуулагдсаны 60 жилийн ойг угтсан хөдөлмөрийн уралдаанд өндөр амжилт үзүүлсэн 2173 хоригдлыг Засан хүмүүжүүлэх байгууллагуудыг удирдах газрын даргын 1982 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 998 тоот тушаалаар 30-60 хоногоор шагнасны дотор 43 хоригдолд “Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагуудыг удирдах газрын тэргүүний хүмүүжигч” гэрчилгээ олгож хүн тус бүрийг ажлын 90 хоногоор шагнаж байжээ. Мөн газрын даргын 1986 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн а/239 тоот тушаалаар 3145 хоригдлыг ажлын 3-60 хоногоор шагнасан байдаг. Энэ мэтээр хоригдлыг ажлын хоногоор шагнагдах явдал нэлээд хавтгайрч Улсын Прокурорын газрын 1989 оны мэдэгдэлд шүүмжлэгдэж байсан удаатай.

Уралдааныг үе шаттай дүгнэх явцад шинэ бүтээл оновчтой санал гаргах ажил нэгэн зэрэг өрнөж олон сайхан зүйлүүдийг хоригдлуудаас санаачлан хийж урамшуулагдаж байсан байна. Тухайлбал:

1. Хоригдол Б-с Улсын барилгын гуалин ачих гар ажиллагааг хөнгөвчлөх гинжин кран хийх саналыг дэмжин хөрөнгө зарах.....краныг 7 дугаар сарын 01-нд ашиглалтад оруулах. /Засан хүмүүжүүлэх ерөнхий хэлтсийн даргын 1958 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 89 тоот тушаал/

2. Нэгдүгээр лагерийн нэгдүгээр колонид хоригдож байсан хоригдол Н.Г-ын санаачлан бүтээсэн 1.5-2.5 квт-ын хүчин чадалтай 4 ширхэг динам бүхий 5 төрлийн ажиллагаатай мужааны цахилгаанчлагдсан багажуудыг лагерийн үндсэн хөрөнгөд бүртгэн авч хоригдол Н.Г-ыг үлдсэн ялаас нь өршөөн суллахаар Улсын Их Хурлын Тэргүүлэгчдэд хүсэж тодорхойлох /мөн хэлтсийн даргын 1958 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 125 тоот тушаал/

3. Хоригдлын дунд зарласан “ШБОС -79” уралдаанд идэвхтэй оролцсон Б.Ш. нарын 14 хоригдлыг 30-60 хоногийн ажлын хоногоор шагнах. /Засан хүмүүжүүлэх байгууллагуудын удирдах газрын даргын 1980 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн 626 тоот тушаал/

4. Биндэр дахь Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонийн хоригдол А.А-ийн санаачилсан сантехникийн ялтанд хэрчлээс матаж гаргах төхөөрөмж, шахмал түлш бэлтгэх механизм нь НАХЯ-ны ШБОС-ын комиссын үнэмлэх авч ... үр дүнгээ өгч байгаа тул ажлын 50 хоногоор шагнах. /Засан хүмүүжүүлэх байгууллагуудын удирдах газрын даргын 1981 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 718 тоот тушаал/ зэрэг олон жишээ байдаг.

Хорих ял эдэлж байгаа хэнийг болов хүмүүжил, сургалт, спорт, урлагийн арга хэмжээнд хамруулан тэдэнд аятай нөлөө үзүүлэх, урамшуулах ажил 1930-аад оноос шинэ шатанд гарч 1931 оны хуульд хуульчилж өгсөн байдаг.

Монгол Ард Улсын дотор аливаа хэрэгтэн ялтанг засан сайжруулах ажлын тухай хуулийн 31 дүгээр зүйлд "Аливаа засан хүмүүжүүлэх газар хоригдогсдыг сурган гэгээрүүлэх, боловсруулах ажлыг гүйцэтгэвээс зохимуй" хэмээн заагаад энэ ажлын зорилтыг тодорхойлохдоо "хоригдогсдод нийтийн эрдэм ба аливаа ажил үйлдвэрийн ангид боловсруулах аргуудыг зааж сургахаас гадна тус улсын байгуулалтын үндсэн бодлого хийгээд харьяат ардын эрх, үүрэгтэй танилцуулж, суллагдан тавигдсаны хойно улсын ажил явуулах хэрэгт биеэр оролцоход дөхөм тустай болохыг хичээсэн хэрэг болно" гэжээ.[194]

1931 оны хуулийн 30 дугаар зүйлд зааснаар хоригдлыг цалинжуулах, ингэхдээ хөдөлмөрийн хөлсний 25 хувийг өөрт нь олгож урамшуулах заалт орж өгсөн. 1981, 1993 оны хуулиудад хоригдлын хөдөлмөрийн тоо, чанарт нь тохирсон үнэлгээгээр баримтлан цалинжуулж урамшуулж байхаар заажээ.

Хуулийн дээрх заалт, тодорхойлолт нь 1960-аад оны эхэн үе хүртэл хугацааны хүмүүжлийн ажлын гол удирдамж, чиглэл болж ирсэн байна.

Энэ ажлын хүрээнд хоригдлын хөдөлмөр, хүмүүжлийг үнэлэн шагнаж урамшуулах ажил зохиож үр дүнд хүрч байсан олон түүхэн баримт үлджээ. Тухайлбал.

1. Засан хүмүүжүүлэх ерөнхий хэлтсийн даргын 1958 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 126 тоот тушаалаар төв, хөдөөгийн лагерь, хорих ангиудаас шатар ба 100, 500, 1000 метрийн гүйлтэд түрүүлсэн хүмүүжих ажилчин Б, Ц, Б, С. нарыг 24-ийн срочик, үнэмлэхээр шагнаж байжээ.

2. Мөн хэлтсийн даргын 1959 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн "Хоригдлын сайн дурын уран сайхны үзлэг явуулсан дүнгийн тухай" 035 тоот тушаалд 1 дүгээр лагерийн хүмүүжигч Х, Г: нарын удирдсан уран сайхны бүлгэмийг нэгдүгээр байр эзлүүлж, баярын бичиг, 995 төгрөгийн үнэ бүхий хөгжмөөр шагнаж байжээ.

3. Мөн хэлтсийн даргын 1960 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн "хүмүүжих ажилчдаас гаргасан хөдөлмөрийн шинэ санаачилгыг дэмжих тухай"

[194] "Эрх зүй албаны мэдээл" сэтгүүл, УБ., 1997 он, дугаар 2, 30 дахь тал.

118 тоот тушаалд тодорхой үүрэг авч, хамтын хүчээр ажиллах “Хамтын нөхөрлөл ба хүмүүжил” /ХН ба Х/ бригад байгуулахыг дэмжиж бүрэлдэхүүнд нь Г. Ч. нарын 20 хүнийг баталсугай гэх мэтээр улиран өнгөрсөн он цагийн ажлын сонин хэлбэрүүд түүх болон үлдсэн байна. Энэ нь бригадын болзлыг эхлээд, дараа нь үүргийн биелэлтийг шалган тушаалаар баталдаг, дарга, гишүүдийг “Тэргүүний хүмүүжигч” тэмдэг, үнэ бүхий зүйлээр шагнадаг байжээ. ХН ба Х-ийн бригадын хэлбэр нь 1970-аад оны сүүл хүртэл засан хүмүүжүүлэх байгууллагын системд өрнөн ажиллаж хамт олноо хошуучилж байсан түүхтэй.

НАХЯ-ны орлогч сайдын 1980 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн 03 тоот тушаалаар Засан хүмүүжүүлэх байгууллагуудын удирдах газраас “Гэмт хэрэг, оргодолгүй, хөдөлмөр, хүмүүжлийн тэргүүний хамт олон” түүнчлэн Засан хүмүүжүүлэх байгууллагуудын удирдах газрын болон колонийн “Тэргүүний хүмүүжигч” гэрчилгээнүүдийг олгох болзол, дүгнэх журмыг баталсан байна. Энэ болзлыг биелүүлэх хөдөлгөөн бүх анги колониудад өрнөн олон тооны хамт олон, хоригдол зохих гэрчилгээг авч байжээ. Зөвхөн энэ төрлийн гэрчилгээ авсан хоригдлыг засрал хүмүүжлээ найдвартай олсон гэж үзэн хугацаанаас нь өмнө тэнсэн суллахаар шүүх магадланд оруулах тодорхойлолт гаргадаг журам тогтоон хэрэгжиж байв. Газрын даргын 1981 оны 367, 490 тоот тушаалаар 100 гаруй хоригдолд “Тэргүүний хүмүүжигч” гэрчилгээ олгож байжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэнд хөдөлмөрийн чадвартай хоригдол нэг бүрийг ажлын байраар хангаж, албан ёсоор хөдөлмөрлүүлэх, хөдөлмөрийн хөлсийг ялтан нэг бүрийн нэрийн дансанд төвлөрүүлж түүнээс өөрийн нь хэрэглэсэн хоол, хүнс, улирлын хувцасны үнэ, орон байр, гэрэл цахилгааны зардал зэрэг зайлшгүй хийгдэх суутгалаа хийсний дараа үлдсэнийг нь нэрийн дансанд нь хийж байв. Хөвсгөл аймгийн харьяат “Т” гэгч Авдрантын колониос суллагдахдаа хэдэн мянган төгрөг авч, ийм мөнгийг амьдралдаа анх удаа авлаа гэж баярлаж бүх төрөл төрөгсдөдөө бэлэг дурсгалын зүйл авч, өөрийгөө хувцаслаад, онгоцоор буцаж байсныг жишээ байдаг.

Ялтанд шагналын хоног олгох урамшуулал нь ялтны хүмүүжил, хөдөлмөрт хамгийн их үр нөлөө өгдөг урамшуулал бөгөөд энэ урамшууллыг авахыг тулд ялтны зүгээс их хүчин чармайлт гаргаж, хөдөлмөрлөдгийг манай ахмад буурлуудын дурдатгалд дурдсан байдаг. Тухайлбал:

Хорих ангийн мод бэлтгэлийн дарга байсан ахмад Дашдорж гуай хоригдолд ямагт ахын ёсоор, найз нөхдийн ёсоор ханддаг нэгэн байж. Тэдний хэсэг дээр өндөр бүтээлийн уралдаан зарласан болохоор шударга өрсөлдөөн ихтэй, өвөл цагийн богино өдрийн цаг бүр үнэтэй байж. Үдэш хоригдлууд хоолоо идчихээд амрахаар тус тусынхаа байранд орсны дараа хянагч Дамбий хоригдлын тоо авч байснаа гэнэт сандарч “ Нөгөө гозойн Жамц оргосон байна. Хөгшин чөтгөр хаашаа явчихдаг байна” гэж үгээ дээр дээрээс нь давхарлан Дашдоржид илтгэжээ. Дашдорж дарга бодолхийлснээ “Жамц гуай арай ч оргохгүй хүн дээ. Хэдүүлээ

эрлээ модны талбайгаас эхэлье” гээд сартай шөнө эрлийн группийнхэн ойн зах руу ороод чимээ чагнатал мод хөрөөдөх чимээ гарчээ. Тэр зүгт очтол өнөөх Жамц гуай ганцаараа мод хөрөөдөн зогсож байж. Та хаачдаг хүн бэ гэж асуухад “Хөгшин би хаачих вэ дээ? Өдөрт нь бусдын хэмжээнд хүрэхгүй болохоор шар хөдөллөө ч гэх юм уу даа, Оройдоо хэд гурван мод хөрөөдөж чадвал шагналын хэд хоног авч олон жилийн ялаасаа бага ч болов хасуулах болов уу гэж бодох юм”[195] гэжээ. Энэ нь хоригдол нэг хоногийн ч өмнө хорих ангиас суллагдах хүсэл их байдгийг харуулж байсан юм.

1950-аад онд Бороогийн алтны үйлдвэр буюу онцгой лагерийн улс төрийн орлогчоор ажиллаж байсан, хожмоо хошууч генерал Осорын Отгонжаргал гуайн дурсамжид “.....100-150 метр газрын гүнээс алт бүхий чулуун хүдрийг хоригдлууд шуудайгаар үүрч их хүнд нөхцөлд ажиллаж байсан нь одоо ч санаанаас гардаггүй юм. Норм төлөвлөгөөгөө сайн биелүүлж, биеэ харлахгүй ажилладаг хоригдлуудад талх, масло, сахар, дүнсэн тамхи нэмэгдэл болгон өгч шагнаж урамшуулдгаас гадна, ажлын хоног сайн өгдөг байсан учраас хоригдлууд олон жилийн ялаа хөдөлмөрийнхөө үр дүнгээр богино хугацаанд эдэлж дуусган хугацаанаасаа өмнө эрх чөлөөтэй иргэн болж суллагддаг байсныг санаж байна” гэж дурссан байдаг.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ахмад ажилтан, бэлтгэл хошууч И.Батмөнх дурдатгалдаа **“**1000 тонны мөсөн зоорийг барихад их хэцүү байдаг юм. Тэсгэм өвлийн хүйтэнд шөнийн 02 цагт голоос мөсийг хоригдлоос өөр хүн зөөхгүй шүү дээ. Одоо цагт мөнгөөр зодож хийлгэж болох юм. Резинэн цув өмсөж, хүйтэн төмөр хошуу бариад ус цацна гэдэг хэцүү. Хоригдлуудаар тэр бэрх ажлыг хийлгэх гол арга нь тэдэнд ажлын хоног өгч, сахилга баттай байвал хугацаанаас нь өмнө магадлангаар суллана. Ялаас түргэн салахын тул халшрахгүй хийнэ. Ажлын хоног сард 90 хоног тооцно гэхээр тэд сайн ажилладаг байсан, хоол ундыг нь сайн өгнө. Сайн ажилладаг хоригдлыг хонины чанасан толгойгоор шагнана. Түүнийг өвөртөө хийчхээд шөнө мөс зөөх зуураа мөлждөг байв. Энэ бол хоригдлын амьдрал байлаа”[196] гэж дурдсан байдаг нь албан хаагчдаас ялтны хөдөлмөр, хүмүүжилд гаргасан өчүүхэн амжилтыг шагнаж урамшуулж, сэтгэлд нь дэм өгөх нь ялтны цаашдын ял эдлэх чиг хандлагад сайн нөлөө үзүүлдгийн тод жишээ юм.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. “Эрх зүй, албаны мэдээл” сэтгүүл, УБ., 1997 он, дугаар 1.

[195] “Эрх зүй, албаны мэдээлэл” сэтгүүл. УБ., 1999 он, дугаар 4, 60 дахь тал, “Хорих 407 дугаар ангийн дарга хурандаа Р.Оюунбадамын илтгэл “

[196] “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ахмад ажилтан, бэлтгэл хошууч И.Батмөнхийн дурдатгал “ “Эрх зүй, албаны мэдээлэл” сэтгүүл. УБ., 2002 он, дугаар 1, 67 дахь тал,

2. “Эрх зүй албаны мэдээл” сэтгүүл, УБ., 1997 он, дугаар 2.

3. “Эрх зүй, албаны мэдээлэл” сэтгүүл. УБ., 1999 он, дугаар 4.

4. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ахмад ажилтан, бэлтгэл хошууч И.Батмөнхийн дурдатгал “ “Эрх зүй, албаны мэдээлэл” сэтгүүл. УБ., 2002 он, дугаар

ЦАГДАН ХОРИХ БАЙРНЫ АЛБА ХААГЧДЫН САХИЛГЫН ЗӨРЧИЛД ШИНЖИЛГЭЭ

DISCIPLINARY VIOLATIONS COMMITTED BY PRISON OFFICERS CURRENT ANALYSIS



Ж.Болдбаяр
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, ахлах дэслэгч

Хураангуй: Хүний эрх, эрх чөлөөнд хуульд зааснаар хязгаарлалт хийх үйл ажиллагаанд эрх хязгаарлагч буюу үүрэг хүлээгч нь өндөр хариуцлага, ёс зүй болон хууль, эрх зүйн мэдлэгтэй байхыг шаарддаг. Тиймдээ ч төрийн албан хаагч, хууль сахиулах байгууллагын алба хаагчийн сахилга, хариуцлагын тухай асуудлыг авч үзэн судлах нь “Rule of law”[197] хэмээх эрх зүйн тогтолцооны үндсэн зарчмыг хангаж буй хэрэг болно.

Abstract: In the activity of restricting human rights and freedoms according to the law, the person who restricts the rights or the obligee must have a high level of responsibility, ethics, and legal and legal knowledge. Therefore, considering and studying the issue of discipline and responsibility of civil servants and law enforcement officers will satisfy the basic principle of the legal system called "Rule of law".

Түлхүүр үг: Хүний эрх, хариуцлага, төрийн алба хаагч, эрх зүй, зөрчил, шийтгэл, цагдан хорих.

Key words: Human rights, responsibility, civil servants, law, violation, punishment, detention.

УДИРТГАЛ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэргийн талаар гарсан бүхий төрлийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх чиг үүрэг бүхий төрийн тусгай алба юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нь өдөр тутмын үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль[198], Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай

[197] Rule of law implies that every citizen is subject to the law. It stands in contrast to the idea that the ruler is above the law, for example by divine right.
[198] Төрийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2018. №01

хууль[199], Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын сахилга ёс зүйн дүрэм[200], Үйлчилгээний стандарт[201] зэрэг олон эрх зүйн актыг дагаж мөрдөх бөгөөд эдгээрт харшлах аливаа үйлдэл, эс үйлдэхүй нь сахилгын зөрчил хэмээх ойлголтыг бий болгодог байна. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга хариуцлагын асуудал багагүй хөндөгдөх болсон.

Иймд тэдгээрээс үүдэлтэй сахилгын зөрчлийн шалтгаан нөхцөлийг олж тогтоох, дүн шинжилгээ хийх асуудал ихээхэн чухал болоод байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч, тэр дундаа Цагдан хорих байрны алба хаагчдаас гаргаж буй сахилгын зөрчил, түүний хэлбэр, зөрчил гарахад нөлөөлж буй хүчин зүйлийг тогтоож, шалтгаан нөхцөлийг арилгах нь нэг талаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хангах ажиллагааны нэг бүрдэл болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчаас гаргах сахилгын зөрчил, түүнд хариуцлага хүлээлгэхтэй холбоотой эрх зүйн уламжлал, цагдан хорих байрны алба хаагчдаас үйлдэж буй сахилгын зөрчлийн өнөөгийн байдал, зөрчил гаргахад нөлөөлсөн хүчин зүйл, зөрчил гаргасан алба хаагчдад хүлээлгэж буй сахилгын шийтгэл болон сахилгын зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулснаар алба хаагчийн ажилдаа хандах хандлага, албан үүрэгтээ хандах итгэл үнэмшил нэмэгдэх, байгууллагын үйл ажиллагааны чанар нэмэгдэх ач холбогдолтой.

ҮНДСЭН ХЭСЭГ

Төр улс үүсэн, нийлмэл нийгэм бий болохтой зэрэгцэн эхэлсэн хүн төрөлхтний хөгжил, хувьсал одоог хүртэл тасралтгүй үргэлжилсээр байна. Эртний улсуудын төр, эрх зүй, нийгмийн түүхийн судалгаа шинжилгээг өнөөгийн нийгэмтэй харьцуулан үзэхэд асар их хувьсал, өөрчлөлт, дэвшлийг харж болох ч хүн төрөлхтөн хөгжин дэвшихийн хирээр нийгмийн харилцаанд сөрөг үр дагавар бүхий аливаа хүчин зүйлс ч мөн адил нэмэгдсээр байгаа юм.

Германы философич К.Маркус “Нийгэм бол хамтын үйл ажиллагааны явцад үүссэн хүмүүсийн хоорондын түүхэн харилцааны цогц юм” гэж тодорхойлсон байна. Тиймээс нийгмийн харилцаанд оролцогч хүмүүсийн ёс суртахуун, тэдгээрийн ухамсрын түвшин дэх тодорхой ойлголтуудыг судлахгүйгээр нийгэм, төр, эрх зүйн асуудал, цаашлаад хууль дээдлэх зарчим, хуульд захирагдах ёс, нийгмийн аюулгүй байдлын талаар ярих боломжгүй юм.

---

[199] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2017. №24

[200] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын сахилга, ёс зүйн дүрэм. Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал. УБ., 2018. А/183

[201] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйлчилгээний стандарт. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаал. УБ., 2013. А/81

Уламжлалт философийн онолоор бол нийгмийн харилцаа гэдгийг “хүмүүсээс нийгмийн үйл явцад, өөрөөр хэлбэл, нийгмийн амьдралыг зохион байгуулахад оролцох” үйл явцыг хамааруулдаг ойлголт юм. Тухайлбал сонгууль, төрийн үйлчилгээ, иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаа, үзэл бодол, байр суурия илэрхийлэх гэх мэт жишээг дурдаж болно.

Аливаа төр, улс оршин тогтнож ирсэн түүхэндээ өөрийн зорилго, чиг үүргийг тодорхойлж, түүнийгээ хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлж ирсэн нь төрийн алба бөгөөд төрийн алба нь торийг тодорхойлж ирсэн онол, арга зүй, үзэл хандлагыг дагаж мөн чанар, агуулгын хувьд хувьсаж ирсэн нь бий.

Орчин үед барууны орнуудад "Public service", "Civil service" хэмээн нэрлэгдэж буй ухагдахуун нь Монгол хэлэнд "Төрийн алба" гэдэг нэр томьёогоор хэрэглэгдэж төрд зүтгэх, ард түмэнд үйлчлэх гэсэн мөн чанарыг илэрхийлж байна.

Төр "хаан", "язгууртан"-ы үеэс л ямагт тусгай иммунитетийн эрх эдэлж, хариуцлагаас "мултарсаар" ирсэн хэдий ч нийгмийн хөгжлийн аясаар дэлхийн улс орнууд төрийн албаны үүрэг хариуцлагын асуудалд анхаарал хандуулж, төрийн буруутай үйл ажиллагаанд хариуцлага хүлээлгэхэд саад болж байсан засаглалын иммунитетийн ойлголт мэдэгдэхүйц багасаж бусдад хохирол учруулсан захиргааны актынхаа төлөө хариуцлага хүлээхийг хүлээн зөвшөөрснөөр төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэх зарчим нийтийн эрх зүйд аажмаар хөгжиж эхэлсэн байна.

Энэ үеэс төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэх асуудал нь хүн төрөлхтний нийгэм, улс төр, эрх зүйн хөгжлийн нөлөөгөөр харилцан адилгүй үзэл санаа, онолд үндэслэн хувьсаж иржээ.

Уламжлалт үзэл санаанд (XYII - XIX зуун) төрийн албаны хариуцлагын асуудал агентын онол (agency theory) -д үндэслэж байсан бөгөөд төр төрийн албан хаагчийн харилцааг агентын харилцаагаар төсөөлөн хамтын ажиллагааны үр дүнг хамгийн их байлгах талаар санал дэвшүүлэн энэ нь хариуцлага хүлээлгэх шалгуур болж байжээ. Аажимдаа төрийн албанд улс төрийн нөлөө ихсэж, хариуцлага хүлээх чадвар, шударга ёсыг төлөвшүүлэх асуудал нь улс төрчдийн ноёрхол дор орсноор улс төрийн албан тушаалтнууд болон мэргэшсэн төрийн албан хаагчдын үүрэг, хариуцлагын ялгаатай байдал багасаж төрийн мэргэшсэн алба хаагчдыг улс төрийн шалгууруар сонгон шалгаруулах, улмаар хариуцлагын тогтолцоог эвдэх, үл ойлгогдох байдал үүсгэхэд хүргэжээ.

Тийм болохоор төрийн албыг шинэчлэх, үйл ажиллагааны үр дүн, хариуцлагын механизмыг боловсронгуй болгохын тулд хувь хүмүүсийн сонголтын дээрх онцлогийг харгалзан харилцааг боловсронгуй болгож, эзэн (хууль тогтоогч)-ийн гаргасан бодлогыг агент (захиргаа) хамгийн үр дүнтэй хэрэгжүүлэх тийм зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим болон үр дүнг тодорхойлох аргыг олох ёстой болжээ.

Академич С.Нарангэрэл “Төр бүхэлдээ бүх ард түмнээс иш үндсээ авч байдаг бөгөөд ... үүнийг нь нийгэм болон төрөөс (бас зарчмын үүднээс болон үзэл санааны хувьд, хүн амын зүгээс ч) хүлээн зөвшөөрсөн байдаг. Нийгэм дэх хууль ёсны зарчим хатуу чанд, яв цав байдаг нь үүнээс үүдэлтэй юм.

“Үүрэг”, "Хариуцлага" тэргүүн байранд тавигдаж дараа нь хууль ёсны шинж товойн гарч ирж байгаа ийм байдлаар эрх зүйг ойлгох нь ... үндэслэгээтэй байдаг.[202] Эрх зүйн зорилт нь хэн хүн ... аливааг үйлдэх “эрхтэй”, “эрхгүй” болохыг тодорхойлох үндэслэлийг гаргаж ирдэг ба энэ зорилтыг хууль зүйн хатуу чанд үүрэг, түүнийг биелүүлээгүйн төлөө хүлээх хариуцлагыг тогтоох замаар багагүй хэмжээнд хэрэгжүүлдэг" хэмээн нотолсон байна.[203]

Сахилга гэдэг нь Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь” номдоо “ямар нэгэн хэсэг бүлгийн бүгдийн дагаж журамлавал зохих журам горим”[204] хэмээн тайлбарлажээ.

Судлаач Д.Цогт-Очир “Сахилга гэдэг нь амьдралын шаардлагаар нөхцөлдсөн хүмүүсийн үзэл бодол, үйл ажиллагааны нэгдэл, нийгмийн тогтоосон дэг журмыг сахихыг хэлнэ”[205] хэмээн тодорхойлсон байна.

Эрх зүйн эерэг хандлагаар авч үзвэл хууль зүйн хариуцлагыг үүргийн ухамсар, үүргийн мэдрэмж, хууль зүйн дагуу үйл ажиллагаа явуулах үүрэг болон тухайн үүргийн хэрэгжилт, түүнчлэн урамшууллын арга хэмжээг сонгон хэрэглэх нөхцөл гэж ойлгодог байна.

Харин сөрөг буюу негатив хандлагаар авч үзвэл хууль зүйн хариуцлага нь хэрэгжилт, төрийн албадлагын арга хэмжээ, ял (шийтгэл), эрх зүйн зөрчилд нийгмээс үзүүлэх хариу үйлдэл, эрх зүйн зөрчлөөс урган гарсан хууль зүйн үүрэг, албадлагын нөлөөллийн арга хэмжээг хүлээх чадвар, нийгэмд аюултай үзэгдэлд өгөх үнэлэмж болон түүнийг үйлдсэн этгээдийг буруутгах хэлбэр гэж ойлгодог байна.

Хууль зүйн доктор (Ph.D) Н.Мөнхзул “Төрийн тусгай алба хаагчид хүлээлгэх сахилгын хариуцлага” бүтээлдээ “Монголын төрт ёсны түүхэн хугацаанд “нийгэм” аливаа сөрөг үзэгдлээс ангид байж чадаагүй учраас төрд “хүч”-ийг ашиглах замаар хуулийн хүрээнд албадлага хэрэглэн нийгмийн сайн мууг дэнсэлж ирсэн түүхтэй. Нөгөө талаас хүчийг олсон төр засаглах эрхээ хэрэгжүүлэх явцдаа өөрийн эрх ямбаа хэтрүүлэх, дураар авирлах, хариуцлага алдаж ирсэн түүх цөөнгүй байна. Тиймээс төрийн эрх мэдэл, түүнийг хэрэгжүүлэгч алба хаагчдын хүч байх ёстой хэм хэмжээнээс хэтрэхээс сэргийлэх, төрийн эрх мэдлийг хязгаарлаж хууль зүйн тувшинд барьж байх үүднээс тэдэнд

[202] С.Нарангэрэл, Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо . УБ ., 2001. 6 дахь тал
[203] Мөн бүтээл. 7 дахь тал
[204] Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. Уб .1964.473 дахь тал
[205] Цогт-Очир Д. Хуульчийн ёс зүйн үндсэн асуудал. Уб.1999. 22 дахь тал

хууль зүйн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндсийг Монгол улсын үе үеийн эрх зүйн баримт бичгүүдэд тусгаж иржээ" хэмээн тэмдэглээд төрийн албан хаагчдад хариуцлага оногдуулж ирсэн эрх зүйн түүхийг үечлэн тодорхойлжээ. Энэ нь Монгол улсын төр, хууль цаазын түүхийг үечилж ирсэн нийтлэг үечлэлийн дагуу:

• Монголын эртний улсуудын хууль цааз дахь төрийн албан хаагчдад хариуцлага оногдуулж ирсэн уламжлал,

• Монголын дундад үеийн хууль цааз дахь төрийн албан хаагчдад хариуцлага оногдуулж ирсэн уламжлал,

• Шинэ үеийн хууль цааз дахь төрийн албан хаагчдад хариуцлага оногдуулж ирсэн уламжлал,

• Нэн шинэ үеийн хууль цааз дахь төрийн албан хаагчдад хариуцлага оногдуулж буй байдал[206]гэсэн үечлэлтэй байна.

Эндээс харвал төр улс үүсэхтэй зэрэгцэн төрийн албан хаагчдад сахилга, хариуцлагын асуудал яригдсаар байсан бөгөөд энэ тийм ч шинэ үзэгдэл биш болох нь тодорхой харагдаж байна.

Эрх хэмжээ буюу эрх зүйн чадамжтай байдлын хувьд сахилгын хариуцлага хэмээх ойлголт нь хууль зүйн үр дагавар болж өгдөг. Өөрөөр хэлбэл эрх зүйн онолын хүрээнд хууль зүйн хариуцлагыг эрх зүйн зөрчлийн шууд үр дагавар гэж үздэг судлаачид байдаг бол зарим судлаачид түүнийг эрх зүйн хариуцлага хэмээн үзэх тохиолдол байдаг.

Энэ үед төрийн алба буюу шаталсан зэрэг дэв бүхий түшмэл ёс бүрэлдэн тогтсон гэж үзсэн бөгөөд энэ нь эрдэм, мэдлэг хуримтлуулсан туршлагаараа бусдаас тодорсон албан тушаалтан төрөөс тогтоосон хэм хэмжээний дагуу засаг захиргааны хувьд удирдах, гүйцэтгэх, өвөрмөц эрх мэдлээ хэрэгжүүлэхийг улс төр, хууль зүйн тухай ойлголтыг илэрхийлж байгаа бөгөөд байнгын шинжтэй төрийн алба чухам энэ үед үүссэн байна.

Тухайн үеийн хууль цаазын уламжлалыг нэгтгэн авч үзэхэд төрийн эсрэг үймээн гаргах, төрөөс урван тэрслэх, төрийн хууль цаазыг зөрчих, төрд тэрслэх гэх мэт зан үйлүүдийг хаан болон түүний угсааны ноёд сайдуудад хамаатуулан хуульчилсан нь тухайн үеийн монголчуудын төрийг дээдлэх санааг хууль цаазын гол мөн чанар болгон авч үзсэнтэй холбоотой юм. Үүний ял шийтгэл нь чулуугаар цохих, цаазлах, цөлөх зэрэг хүнд шийтгэлүүд байсан нь бие махбодод чиглэсэн эрүүгийн шинжтэй хариуцлагын төрөл зонхилж байсныг харуулсан талаар доктор Н.Мөнхзул өөрийн бүтээлдээ дурдсан байна.

Монголын дундад үеийн эрх зүй дэх төрийн албан хаагчид хариуцлага оногдуулж ирсэн уламжлалыг XIII-XX зуунд хамааруулан үечилснээс онцлох нь:

[206] Н.Мөнхзул. Төрийн тусгай алба хаагчид хүлээлгэх сахилгын хариуцлага. УБ., 2019.

Цаг хугацааны хувьд 700 гаруй жилийг хамаарах энэ түүхэн үечлэлд төр ёсны харилцаа, эрх зүйн уламжлал шинэчлэлийн хамгийн ээдрээтэй үеүд хамардаг. Тухайн үеийн төр засгийн онцлог, нөхцөл байдлаас хамааран хууль эрх зүйн асар их өөрчлөлт орсон бөгөөд тэдгээр өөрчлөлт, шинэчлэлтээс ажиглавал төрийн албанд зүтгэж буй түшмэдийн сахилга хариуцлагад ихээхэн анхаарал хандуулж, мөн ял шийтгэл нь ч хүнд байсан талаар олон талаас нь тайлбарлаж болно.

Тухайлбал, Их засаг хуульд зөвхөн төрийн албан хаагч авлигын гэмт хэрэгт холбогдсон сахилга хариуцлагын асуудлаар олон төрлийн зохицуулалт байснаас дурдвал:

“Их засаг” хуульд хаан өргөмжлөх, их хуралдайг зарлан хуралдуулах, гадаад улс оронтой харилцах ёс, цэргийн болон иргэний үүрэг, алба татвар, эрүүгийн болон иргэний шинж чанартай олон асуудлыг хэрхэн зохицуулахыг хуульчлан заасан байдаг.

Түүхэн эх сурвалжуудаас үзвэл “... хэрвээ түмтийн жанжин алдаа эндэгдэл гаргалаа гэж бодвол, тэр жанжин хоёр нарны хооронд явж хүрэх хол газар байсан ч хаан түүн рүү ганц элч мордуулна. Тэр элч жанжинд хүрч очоод толгойг нь ав гэсэн бол аваад, алт эрдэнээр торго гэсэн бол торгоод буцаж ирнэ ...”[207] /Үүнийг мөн Монголын эрт эдүгээгийн хууль цаазын түүхийн сэдэв дэвтэрт Их засаг хуулийн цаазын чанартай сургаалд тэмдэглэн Нэгэн зүйл: Ноёд дотроос ямар нь боловч гэм халдаад, хаанаас хамаг доорд түшмэлийн албан хүнийг зарж гэсгээлгэхээр явуулбал даруй биеэ тэрхүү элчид өгч өмнө хэвтэж хаанаас тогтоосон амийг авах хэрэг боловч шууд гүйцэтгүүлтүгэй[208] гэж дурдсан байдаг./, “... түшмэл түшээ зарж хянан байцаалгах үес хэрэв цэргийн тоо дутах буюу оргодол хийгээд ядуу хүнийг ацаглан нэрийн цэсийг гүйцээсэн байх аваас заавал зэмлэж ял хэлэлцэх болмуй ...”[209], “... доод тушаалын дарга нар дур мэдэн бичиг шийтгэн олгож цэргийг халж солихыг цаазлах бөгөөд ...”[210], “... ажил үүргээ гүйцэтгэж чадахгүй байгаа буюу хааны зарлиг ёсоор ирээгүй ноёд жанждыг цаазаар авна...”[211] гэж хууль, цаазын хэм хэмжээ тогтоосон зарлиг бичгүүдийг нэрлэн дурдаж болно.

Эдгээр “Их засаг” хуульд тусгасан хэм хэмжээг эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийн түүхэн уламжлал гарцаагүй мөн гэж үзэх

[207] Ала-Ад-Дин Ата-Мелик Жувейни. Дэлхийг байлдан дагуулагчийн түүх. Орч. М.Д.Бадамням. УБ., 2006. 25 дахь тал
[208] Монголын эрт эдүгээгийн хууль цаазын түүхийн сэдэв дэвтэр. Монгол бичгээс хөрвүүлсэн Б.Баярсайхан. УБ. 2002. 14 дэх тал
[209] Ж.Амарсанаа нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл. Нэгдүгээр боть. УБ., 2010. 36 дахь тал
[210] Гуулин улсын судар. Тэргүүн боть. Пхеньян. 1957. 452-454 дэх тал
[211] Б.Чимид. Төр, нам эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудлууд. УБ., 2008. 140 дэх тал

нэг дэх шалтгаан нь уг хэм хэмжээнд тусгасан түшмэл гэж урьдын цагт албан хэргийн талаар таслан тогтоох явдалд оролцох эрх тушаал бүхий хүнийг, жанжин гэж бүх цэргийг ерөнхийлөн захирах дээд албан тушаалыг, ноёд[212] гэж хошуу, орон нутгийн дээд албан тушаалтан буюу захирагчийг хэлэх талаар Монгол хэлний их тайлбар толиос харж болох бөгөөд энэ нь одоогийн дагаж мөрдөж буй Эрүүгийн хуульд заасан нийтийн албан тушаалтан гэдэгтэй адил ойлголт юм.

Түүнчлэн "Монголын эрх зүйн философид Хубилай хааны төр, хууль цаазын үзэл баримтлал чухал байр эзэлдэг"[213] гэж үздэгээс харвал Арван цагаан буянт номын түүхийг энд мөн дурдах нь зүйтэй. "Цагаан түүх"[214] нь хэдийгээр эрүүгийн эрх зүйн шинж чанар агуулаагүй шашин, төрийн ёсыг тэгш явуулах тухай хууль цааз боловч "Улсыг засахын ёсны тулд шуудган хол бүхүйг өөр нөхөр аваад, засаг зарлигийг бэлгэтэйеэ онож явуулаад, заал заргын эсэх харваас, иргэн оргоныг аврахын дээд эрхлэгч тайш[215] хэмээюү",

"Хэн гэнэдэлгүй явбаас баатрын зэрэгт оруул

Алдалгүй төгсвөөс тухайлан[216] зэрэгт оруул

Хэн алагчлалгүй шүүвээс заргачийн зэрэгт оруул" зэрэг айлтгалуудаас харвал төрийн алба хаших ёс, дэг жаяг, цааз цээрийг тогтоосон хэм хэмжээ агуулагдаж байжээ.

Эдгээрээс харвал түүхэн энэ цаг үеэс эхлэн хууль, эрх зүйн харилцаан дахь төрийн албан хаагчид сахилгын хариуцлага оногдуулж буй зохицуулалт аяндаа боловсронгуй болох зарчмаар хөгжиж ирсэн гэж хэлж болохоор ажээ.

Шинэ үеийн эрх зүй дэх төрийн албан хаагчид хариуцлага оногдуулж ирсэн уламжлалыг 1921-1990 онд хамааруулан үечилснээс онцлох нь:

Монгол улсад 1921 оны Ардын хувьсгал ялж тухайн үед Монгол орон социализмд хүрэх чиг баримжааг сонгон түүний онол, үзэл баримтлалын дагуу түүнд тохирсон нийгэм, улс төр, эдийн засгийн зохих тогтолцоог бүрдүүлэхийн тулд өөртөө тохирсон эрх зүйн үндсийг бий болгох зайлшгүй шаардлага бий болсон.[217]

---

[212] Монгол улсын ерөнхийлөгчийн Тамгын газар. Монгол хэлний их тайлбар толь. УБ., https://mongoltoli.mn/dictionary/

[213] Д.Лүндээжанцан нар. Эрх зүйн философи. УБ., 1998. 191 дэх тал

[214] Ж.Амарсанаа нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл. Нэгдүгээр боть. УБ., 2010.44-68 дахь тал

[215] Тайш - Монгол улсын үеийн цэрэг захирах ноёны цол. Монголын түүхийн тайлбар толь. https://mongoltoli.mn/history/h/444

[216] Тухал – Хааны зарлигаар улсын сангийн эд ашгийг хуваах үйлийг эрхэлдэг ордны түшмэл.

[217] Н.Мөнхзул. Төрийн тусгай алба хаагчид хүлээлгэх сахилгын хариуцлага. УБ., 2019

Харин энэ цаг үед төрийн албан хаагчийн сахилгын хариуцлагатай холбоотой эрх зүйн хэм хэмжээг улам боловсронгуйгаар төрөлжүүлж эхэлсэн ба үүнийг “Төмөр замын ажилчин, алба хаагчдын сахилга батын дүрэм”, “БНМАУ-ын шүүгчдийн сахилга батын дүрэм” гэх зэргээр нэрлэн баталгаажуулсан сахилгын тусгай дүрмүүдийг дагаж мөрдөж байснаар нотолж болно.

Энэ цаг үеийн онцлог нь захирах, захирагдах журмаар сахилгын хариуцлага хүлээлгэх явдал байв. Энэ нь гол төлөв удирдах албан тушаалтанд хамааралтай бөгөөд ажлын газрын захиргаанаас биш, тухайн ажилтан шууд харьяалж захирах дээд байгууллагаас нь сахилгын шийтгэл оногдуулахыг хэлж байжээ.

Социализмын дундаас хойших жилүүдэд намын шийдвэр нь илт хүч нөлөөтэй байсан бөгөөд Намын төв хорооны дэргэдэх Намын хянан шалгах хороо нь намын гишүүд, орлогч гишүүдээс намын сахилгыг сахиж байгаа байдлыг шалгаж, намын дүрэм журмыг зөрчсөн гишүүд, түүнчлэн намын ёс суртахууныг зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх, намаас хөөгдсөн, намын шийтгэл үзүүлсэн шийдвэрт гомдсон гомдлыг хянан үздэг байсан.

Эдгээр нөлөөгөөр эрх бүхий албан тушаалтан хариуцлага хүлээлгэх эрх зүйн тогтолцоо бүрдэж эрүүгийн, иргэний, сахилгын, олон нийтийн, эд хөрөнгийн, хариуцлага зэргээр салбарлан хөгжсөн ба энэ нь төрийн алба хаагчийн сахилга хариуцлага нь нам, эвлэлийн гишүүний үүрэг, хариуцлагын тогтолцооноос ихээхэн хамааралтай байсан гэж хэлж болно.

Нэн шинэ үеийн хууль тогтоомжийн хүрээнд төрийн албан хаагчид хариуцлага оногдуулж буй байдлыг 1990 оноос өнөөг хүртэл хамааруулан үечилснээс онцлох нь:

Ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжиж хууль, эрх зүйн хувьд олон шинэ өөрчлөлтийг бүтээж, өдгөө ч эрх зүйн шинэтгэлийн олон өөрчлөлт шинэчлэл явагдаж байгаагийн хувьд түүхэн үечлэлийн энэ цаг үе ч мөн ололттой, дутагдалтай олон асуудлыг агуулж явдаг эгзэгтэй цаг үеийн нэг гарцаагүй мөн юм.

1990 оноос хойших Монгол улсын төрийн албаны шинэтгэлийн үйл явцыг доктор Д.Зүмбэрэллхам дараах 4 үе шатад хуваажээ. Үүнд:

1. Ардчилсан нийгмийн мөн чанарт нийцүүлж төрийн байгууллагын шинэ тогтолцоог бүрдүүлэх эхний үе шат (1990-1995 он),

2. Төрийн мэргэшсэн албыг бүрдүүлж, төлөвшүүлэх үе шат (1995-2002 он),

3. Засаглалын институтийн чадавх, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх үе шат (2002-2008 он),

4. Улс төрөөс ангид, мэдлэг чадварт суурилсан төрийн албыг бэхжүүлэх үе шат (2008 оноос хойш)[218] хамаарч байгаа юм.

Энэ хугацаанд Төрийн албаны тухай хуулийг 2 удаа шинээр баталсан бөгөөд уг хуулиудад төрийн жинхэнэ албан хаагчид оногдуулах сахилгын хариуцлагын асуудлыг хөндөн хуульчилж ирсэн. Харин 2017 онд батлагдсан Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгад 2021 онд орсон нэмэлт өөрчлөлтөөр тус хуулийн есдүгээр бүлэгт төрийн нийт алба хаагчийн нийтлэг үүрэг, эрх, хориглох зүйлийг тодорхойлох болсон. Үүгээр сахилга, хариуцлагын хувьд төрийн албан хаагч, төрийн жинхэнэ албан хаагч хэмээн ялгах боломжгүй болж байгаа юм.

Өөрөөр хэлбэл энэхүү өөрчлөлтөөр нийт төрийн алба хаагчид ижил түвшний үүрэг, эрх, хориглох зүйлийг бий болгож өгснөөр төрийн бүхий л албан хаагчдын үүрэг, хариуцлага ижил түвшний стандартад нийцэхээс өөр аргагүй болсныг дурдах нь зүйтэй.

Үндсэндээ нийгмийн харилцааны бүхий л цаг үед ёс зүй, ёс суртахууны агуулга нь гарцаагүй чухал байр суурийг эзэлж байсан бөгөөд чухам тэндээсээ салбар бүрд тархан хөгжиж энэхүү сахилга хариуцлагын асуудал нь эрх зүйн харилцааны бас нэгэн тулгуур зарчим болж өгснөөрөө сахилгын зөрчил хэмээх ойлголт нь хууль зүйн үр дагавар бүхий нэгэн цул ойлголт болжээ.

Өөрөөр хэлбэл энгийн иргэний ёс зүйн асуудал нь төрд алба хашиж буй албан тушаалтны ёс зүйн асуудлаас харьцангуй өөр ойлголт бөгөөд чухам тэндээс сахилга, хариуцлагын асуудал үүсдэг.

Төрийн албан хаагчийн сахилгын зөрчил, сахилга хариуцлагын тухай ойлголт нь төр улс үүсэхтэй зэрэгцэн бий болсон үндсэн элемент гэж хэлж болно. Түүхийн бүхий л цаг үед төрийн албан хаагч, түшмэл ноёдтой холбоотой эрх зүйн харилцааг зохицуулж ирсэн эрх зүйн үр дагавар бүхий олон хэм хэмжээг дурдаж болно.

Сахилгын зөрчил нь үндсэндээ эдгээр эрх зүйн хэм хэмжээнүүдийг зөрчих процесст үүсдэг харилцаа бөгөөд үүнийхээ төлөө тухайн албан хаагч тодорхой хариуцлагыг хүлээдэг.

Хариуцлага гэдэг нь тухайн субъект үйл ажиллагаагаа явуулсныхаа төлөө эцсийн үр дагаврыг өөртөө хүлээх онцгой чадвар, эрх зүйн зөрчилтэй тэмцэх үндсэн арга хэрэгслийн нэг нь хууль зүйн хариуцлага юм.

[218] Д.Зүмбэрэллхам. “Монгол улсын төрийн албаны шинэтгэл: Сорилт, боломж” үндэсний чуулганд тавьсан “Монгол Улсын төрийн албаны шинэтгэл” сэдэвт үндсэн илтгэл. 2011

Сахилгын хариуцлага хүлээлгэх үндэслэл нь ихэнх тохиолдолд сахилгын зөрчил гаргасан байх явдал бөгөөд зарим тохиолдолд Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил үйлдсэн алба хаагчид сахилгын хариуцлага хүлээлгэдэг.

Төрийн алба хаагчид хүлээлгэх сахилгын хариуцлага хүлээлгэх журам нь өөрийн онцлогтой бөгөөд түүнийг үндэслэн:

- Дотоод дүрэмд заасан журмаар
- Захирах захирагдах журмаар
- Сахилгын тусгай дүрэмд зааснаар арга хэмжээ авах гэж ангилдаг.

Харин Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааныхаа хүрээнд гэмт хэрэгт, шалгагдаж байгаа этгээдийг цагдан хорих, тэдний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлдэг. Уг ажиллагаанд холбогдох алба хаагчдын ажлын сахилга хариуцлага, сахилгын зөрчлийн тухай авч үзэх хэрэгтэй.

Цагдан хорих байрны алба хаагчид нь ажил үүргийн хувьд иргэдтэй хамгийн ойр байж, цагдан хоригдсон шийтгэх тогтоол нь хүчин төгөлдөр болоогүй сэжигтэнтэй тогтмол харьцдаг онцлог бүхий ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлдэг алба хаагч юм.

Цагдан хорих байрны алба хаагчдаас гаргаж буй сахилгын зөрчил, түүний шалтгаан нөхцөл, нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, түүнийг арилгах арга замыг эрэлхийлэх нь энэхүү судалгааны ажлын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж байна.

Энэхүү судалгааны ажилд Цагдан хорих байрны нийт 84 алба хаагч оролцож, анкет асуулгын аргаар судалгаа авч дүн шинжилгээ хийлээ.

Судалгаанд оролцогчдын насны байдлыг хүснэгтээр оруулан авч үзвэл:

Хүснэгт №1

Нас	Судалгаанд хамрагдсан алба хаагч	Хамрагдсан байдал
18-24	12	8.2 %
25-29	27	23.4%
30-34	24	34.2%
35-39	11	26.1%
40-44	8	6.5%
45-49	2	1.6%
50-айс дээш	0	0%
Нийт	84	100%

Судалгаанд оролцогчдын цагдан хорих байрны алба хаагчдын насны байдлын дийлэнх хувь буюу 23.4%-ийг 25-29, 34.2%-ийг 30-34, 26.1%-ийг 35-39 настай алба хаагчид эзэлж байгаагаас үзвэл судалгааны оролцогчдын 83.7% нь 25-39 насны алба хаагчид эзэлж байна.

Судалгаанд оролцогчдын насны байдлыг авч үзвэл:

Хүснэгт №2

Хүйс	Судалгаанд хамрагдсан алба хаагч	Хамрагдсан байдал
Эрэгтэй	62	88.2 %
Эмэгтэй	22	11.8%
Нийт	84	100%

Судалгаанд оролцогчдын 62 буюу 88.2% нь “эрэгтэй”, 22 буюу 11.8% нь “эмэгтэй” алба хаагчид эзэлж байна.

Судалгаанд оролцогчдын боловсролын байдлыг авч үзвэл:

Хүснэгт №3

Боловсрол	Судалгаанд хамрагдсан алба хаагч	Хамрагдсан байдал
Дээд	37	74.5 %
Тусгай дунд	15	8.2%
Бүрэн дунд	32	17.4%
Бүрэн бус дунд	-	-
Бага	-	-
Боловсролгүй	-	-
Нийт	84	100%

Дэлгэрэнгүй байдлаар авч үзвэл судалгаанд оролцогчдын 37 буюу 74.5% нь “дээд боловсролтой”, 15 буюу 8.2% нь “тусгай дунд”, 32 буюу 17.4% нь “бүрэн дунд” боловсролтой алба хаагчид хамрагджээ.

Цагдан хорих байрны албаны алба хаагчдын 2019-2023 он хүртэлх хугацааны сахилгын зөрчлийн дэлгэрэнгүй мэдээнээс харвал 2019 онд 54, 2020 онд 52, 2021 онд 44, 2022 онд 29, 2023 онд 76 алба хаагч сахилгын зөрчилд холбогдсон байгаа нь цаашид өсөх хандлагатай байгааг харуулж байна.

Алба хаагчдын гаргаж байгаа зөрчлийн хэлбэрээр авч үзвэл архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэж гаргасан зөрчил 2022 онд 12 байсан бол 2023 оны 18, Албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажил үүргээ хангалтгүй биелүүлсний улмаас сахилгын шийтгэл оногдуулсан тохиолдол сүүлийн жилд 15 нэгжээр өссөн зэрэг үзүүлэлтийг дурдаж болохоор байна.

Цагдан хорих байрны алба хаагчдын сахилга шийтгэлийн нэгтгэсэн тоон мэдээлэлд дурдсанаар 2019 онд нийт 54 алба хаагч сахилгын шийтгэл хүлээснээс ахлагч 33, 2020 онд нийт 52 алба хаагч сахилгын шийтгэл хүлээснээс ахлагч 28, 2021 онд нийт 44 алба хаагч сахилгын шийтгэл хүлээснээс ахлагч 18, 2022 онд нийт 29 алба хаагч сахилгын шийтгэл хүлээснээс ахлагч 12 байна.

Үүнээс үзвэл цагдан хорих байрны алба хаагчдын сахилгын зөрчлийг тогтмол өсөлттэй гэж хэлэх боломжгүй юм. Харин сахилгын зөрчлийн төрөл зүйлийг нарийвчлан тогтоож судалбал сахилгын зөрчлийг тодорхой хэмжээнд бууруулах, цаашид өсгөхгүй байх боломжтой харагдаж байна.

Энэхүү тоон мэдээллээс 2022, 2023 онуудад сахилгын шийтгэл оногдуулсан байдалд дэлгэрэнгүй задаргаа хийж харвал:

Нэгдүгээрт 2022 онд сахилгын шийтгэл оногдуулсан алба хаагчдын ажилласан жилийн онцлогоор 0-5 жил ажилласан алба хаагч 9, 5-15 жил ажилласан алба хаагч 18, 15 ба түүнээс дээш жил ажилласан алба хаагч 6 байна.

Харин 2023 онд сахилгын шийтгэл оногдуулсан алба хаагчдын ажилласан жилийн онцлогоор 0-5 жил ажилласан алба хаагч 18, 5-15 жил ажилласан алба хаагч 12, 15 ба түүнээс дээш жил ажилласан алба хаагч 5 байна.

Энэ тоон мэдээлэл нь үндсэндээ шинээр томилогдсон алба хаагчид гэхээсээ илүү дадлага туршлагатай алба хаагчид сахилгын зөрчилд холбогддог болохыг харуулж байна.

Хоёрдугаарт 2022 онд сахилгын шийтгэл оногдуулсан 29 тохиолдлын ажлын хариуцлага алдсан 13, архидан согтуурсан 8, Хүндэтгэн үзэх шалтгаангүй ажил тасалсан 4 , Хоригдогчтой зүй бус үг хэллэг хэлж харьцсан 1, Хоригдогчтой хувийн харилцаа тогтоосон 3,тохиолдол байх бөгөөд эдгээрийн 39-ийг нь хувь хүний буруутай үйл ажиллагаа гэж дүгнэжээ.

Харин 2023 оны сахилгын шийтгэл оногдуулсан 76 тохиолдлын ажлын хариуцлага алдсан 37, ахуйн хүрээнд архидан согтуурсан 12, цэргийн дүрэмт хувцас дүрмийн дагуу өмсөөгүй 5, үүрэг даалгавар үл биелүүлсэн 10, харуул хамгаалалтын хүч сулруулсан 12 тохиолдол, байх бөгөөд эдгээрийн 55-ийг нь хувь хүний буруутай үйл ажиллагаа гэж дүгнэжээ.

Сүүлийн 2 жилд Цагдан хорих байрны алба хаагчдад сахилгын шийтгэл хүлээлгэсний 10 тохиолдол нь өндөржүүлсэн бэлэн байдал болон албаны бэлэн байдал зарласан үед архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн гэх шалтгаантай байна.

Түүнээс гадна 5-15 жил ажиллаж байгаа алба хаагчид сахилгын зөрчилд холбогдох нь их байгаагаас харвал алба хаагчдын давтан сургалтыг зохион байгуулах хэрэгцээ шаардлага үүссэн, ажлын ачаалал ихсэж, нийгэм цаг үеийн онцлогоос хамаарах ажлын бүтээмж буурч байгаа зэрэг шалтгаанууд байж болно.

Алба хаагчдын гаргаж буй сахилгын зөрчлийн хувьд тодорхой үйлдэл, эс үйлдэхүйд оногдуулах шийтгэлийг нарийвчлан, нэг бүрчлэн зааж өгөөгүйгээс хэлбэр, агуулгын ялгаатай байдлыг үл харгалзан ижил шийтгэл оногдуулж байгаа оновчтой, зөв шийдэл эсэхэд эргэн дүгнэлт хийх шаардлагатай.

Түүнээс гадна удирдах албан тушаалтны сахилга, хариуцлагыг сайжруулах, мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж ажиллах туршлагыг бий болгохын тулд тухайн удирдах албан тушаалд томилохдоо удирдахуйн ухааны сургалт, хөтөлбөрт зайлшгүй хамрагдах нь зүйн хэрэг юм. Энэ эргээд нөгөө талаасаа удирдах албан тушаалтны үүрэг, хууль ёсны шаардлага биелүүлээгүйтэй холбоотой үүсдэг сахилгын зөрчил буурах боломжийг бүрдүүлж өгөх нь тодорхой юм.

Хамгийн чухал асуудал нь сахилга, ёс зүй зөрчигдөхөд нөлөөлдөг тухайн бие хүний зан чанарын онцлогууд гэж байдгийг анхаарч үзэх нь зүйтэй. Тухайлбал үзэн ядах, хайрлах сэтгэл, мөнгө, алдар хүнд, нэр төртэй байх хүсэл эрмэлзэл, атаархал, хардалт, сэрдэлт гэх зэрэг хувь хүний зан чанарууд нь ёс зүй зөрчихөд өөрийнх нь зүгээс хүргэдэг бөгөөд үүнийг ёс зүйн бус асуудал гэдэг.

Өөрөөр хэлбэл эдгээр нь ёс зүй зөрчих үйлдлийг хийлгэхэд цаанаас нь өдөөж байдаг хүчин зүйл болж өгдөг байна. Шийдвэр гаргагч бүрд аливаа нэг шийдвэр гаргахад хувь хүний зан чанар нь заавал нөлөөлж байдаг бөгөөд энэ зан чанараасаа давж ёс зүйн дагуу шийдвэр гаргах нь тухайн ажилтнаас ихээхэн шалтгаалдаг.

Ямар ч албан тушаалтан, албан хаагчид мэргэжил дээрээ алдахаас илүү ёс зүйн алдаа гаргах нь илүү байдаг. Ёс зүйн алдаа нь цаашлаад мэргэжлийн алдаанд хүргэдгийг санах нь зөв бөгөөд алба хаагчдаас гаргаж буй сахилгын зөрчилд энэ байдал давамгай харагдаж байна.

Алба хаагчдын гаргаж буй сахилгын зөрчлийн хувьд тодорхой үйлдэл, эс үйлдэхүйд оногдуулах шийтгэлийг нарийвчлан, нэг бүрчлэн зааж өгөөгүйгээс хэлбэр, агуулгын ялгаатай байдлыг үл харгалзан ижил шийтгэл оногдуулж байгаа оновчтой, зөв шийдэл эсэхэд эргэн дүгнэлт хийх шаардлагатай.

Түүнээс гадна удирдах албан тушаалтны сахилга, хариуцлагыг сайжруулах, мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж ажиллах туршлагыг бий болгохын тулд тухайн удирдах албан тушаалд томилохдоо удирдахуйн ухааны сургалт, хөтөлбөрт зайлшгүй хамрагдах нь зүйн хэрэг юм. Энэ эргээд нөгөө талаасаа удирдах албан тушаалтны үүрэг, хууль ёсны шаардлага биелүүлээгүйтэй холбоотой үүсдэг сахилгын зөрчил буурах боломжийг бүрдүүлж өгөх нь тодорхой юм.

Хамгийн чухал асуудал нь сахилга, ёс зүй зөрчигдөхөд нөлөөлдөг тухайн бие хүний зан чанарын онцлогууд гэж байдгийг анхаарч үзэх нь зүйтэй. Тухайлбал үзэн ядах, хайрлах сэтгэл, мөнгө, алдар хүнд, нэр төртэй байх хүсэл эрмэлзэл,

атаархал, хардалт, сэрдэлт гэх зэрэг хувь хүний зан чанарууд нь ёс зүй зөрчихөд өөрийнх нь зүгээс хүргэдэг бөгөөд үүнийг ёс зүйн бус асуудал гэдэг.

Өөрөөр хэлбэл эдгээр нь ёс зүй зөрчих үйлдлийг хийлгэхэд цаанаас нь өдөөж байдаг хүчин зүйл болж өгдөг байна. Шийдвэр гаргагч бүрд аливаа нэг шийдвэр гаргахад хувь хүний зан чанар нь заавал нөлөөлж байдаг бөгөөд энэ зан чанараасаа давж ёс зүйн дагуу шийдвэр гаргах нь тухайн ажилтнаас ихээхэн шалтгаалдаг.

Ямар ч албан тушаалтан, албан хаагчид мэргэжил дээрээ алдахаас илүү ёс зүйн алдаа гаргах нь илүү байдаг. Ёс зүйн алдаа нь цаашлаад мэргэжлийн алдаанд хүргэдгийг санах нь зөв бөгөөд алба хаагчдаас гаргаж буй сахилгын зөрчилд энэ байдал давамгай харагдаж байна.

Цагдан хорих байрны алба хаагчдын сахилгын зөрчлийн төлөв байдлыг тодорхойлох зорилгоор судалгаанд оролцогчдоос “ “Та цагдан хорих байранд ажиллаж байхдаа сахилга, ёс зүйн зөрчил гаргаж байсан уу?” гэсэн асуултыг судалгаанд оролцогчдын 23 буюу 15.4% нь “тийм”, 61 буюу 84.6% нь “үгүй” гэсэн хариултыг өгсөн байна.

Судалгаанд оролцсон алба хаагчдаас “Хэрэв та зөрчил гаргасан бол ямар шийтгэл хүлээсэн бэ?” гэсэн асуултад 10 буюу 67.7% нь “Сануулах”, 6 буюу 27.4% нь “Албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар хасах”, 5 буюу 4.8% нь “Цолны мөнгө хасах”, 2 буюу 3.2% нь “цол бууруулах шийтгэлийг тус тус хүлээсэн байна.

“Цагдан хорих байранд ажиллахад ямар зөрчил давамгайлан гардаг гэж та үздэг вэ?” асуултад судалгаанд оролцогчдын 12 буюу 5.8% нь “ажил таслах”, 39 буюу 22.8% нь “ажлаас хоцрох”, 7 буюу 1.8% нь “өгсөн үүрэг даалгавар биелүүлээгүй байх”, 6 буюу 11.7% нь “дүрэмт хувцасны зөрчил гаргах”, 20 буюу 25.7% нь “бусад” үйлдэлд хамаарах зөрчил гаргасан байна.

Цагдан хорих байрны алба хаагчдаас “сахилгын зөрчил гаргахад ямар хүчин зүйл нөлөөлж байна вэ” гэсэн асуултад /давхардсан хариулттай/ судалгаанд оролцогчдын 42 буюу 23.9% нь “үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт”, 71 буюу 40.3% нь “ажлын хүнд нөхцөл”, 67 буюу 38.1% нь “цалин хөлс бага”, 84 буюу 55.7% нь “ачаалал их учир стресс ордог”, 36 буюу 20.5% нь “удирдлагын арга барил”, 22 буюу 12.5%, 8 буюу 4.5% нь “Хамт олны уур амьсгал тааламжгүй байдал”, 52 буюу 29.5%, 7 буюу 4% нь “Найз нөхдийн нөлөөлөл” гэсэн хариултыг тус тус өгчээ.

Түүнчлэн судалгаанд оролцогчдын 9 буюу 5.4% нь нээлттэй байдлаар дараах хариултыг өгчээ. Үүнд: хувь хүний асуудал, мэдэхгүй, дарга нар алба хаагчдаа анхаардаггүй, 1 хүн 2 хүний ажил хийдэг, гэсэн хариултуудыг нээлттэй байдлаар өгсөн байна.

Судалгаанд оролцогчид “Цагдан хорих байрны алба хаагчдаас сахилгын зөрчил гаргахад хувь хүний суурь хүмүүжил нөлөөлдөг үү?” гэсэн асуултад 54 буюу 46.7% нь “тийм”, 20 буюу 42.1% нь “үгүй”, 10 буюу 11.2% нь “Зарим тохиолдолд” гэсэн асуултыг өгсөн байна.

Дээрх хариултаас үзвэл хувь хүний суурь хүмүүжил сахилгын зөрчил гаргахад ихээхэн нөлөө үзүүлдэг болох нь харагдаж байна.

ДҮГНЭЛТ

Эдгээрээс харвал түүхэн энэ цаг үеэс эхлэн хууль, эрх зүйн харилцаан дахь төрийн албан хаагчид сахилгын хариуцлага оногдуулж буй зохицуулалт аяндаа боловсронгуй болох зарчмаар хөгжиж ирсэн гэж хэлж болохоор ажээ.

Эрх бүхий албан тушаалтан хариуцлага хүлээлгэх эрх зүйн тогтолцоо бүрдэж эрүүгийн, иргэний, сахилгын, олон нийтийн, эд хөрөнгийн, хариуцлага зэргээр салбарлан хөгжсөн ба энэ нь төрийн алба хаагчийн сахилга хариуцлага нь нам, эвлэлийн гишүүний үүрэг, хариуцлагын тогтолцооноос ихээхэн хамааралтай байсан гэж хэлж болно.

Үндсэндээ нийгмийн харилцааны бүхий л цаг үед ёс зүй, ёс суртахууны агуулга нь гарцаагүй чухал байр суурийг эзэлж байсан бөгөөд чухам тэндээсээ салбар бүрд тархан хөгжиж энэхүү сахилга хариуцлагын асуудал нь эрх зүйн харилцааны бас нэгэн тулгуур зарчим болж өгснөөрөө сахилгын зөрчил хэмээх ойлголт нь хууль зүйн үр дагавар бүхий нэгэн цул ойлголт болсон байна.

Өөрөөр хэлбэл энгийн иргэний ёс зүйн асуудал нь төрд алба хашиж буй албан тушаалтны ёс зүйн асуудлаас харьцангуй өөр ойлголт бөгөөд чухам тэндээс сахилга, хариуцлагын асуудал үүсдэг.

Алба хаагчдын гаргаж буй сахилгын зөрчлийн хувьд тодорхой үйлдэл, эс үйлдэхүйд оногдуулах шийтгэлийг нарийвчлан, нэг бүрчлэн зааж өгөөгүйгээс хэлбэр, агуулгын ялгаатай байдлыг үл харгалзан ижил шийтгэл оногдуулж байгаа оновчтой биш байна.

Байгууллагын удирдах албан тушаалтны ажлын арга барил, менежментийн шинжлэх ухааны ерөнхий ойлголтуудыг баримтлах чадвар цагдан хорих байранд алба хаагчийн гаргаж байгаа сахилгын зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх арга, ажиллагааг хэрэгжүүлэхэд нөлөөлдөг байна. Энэ эргээд нөгөө талаасаа удирдах албан тушаалтны үүрэг, хууль ёсны шаардлага биелүүлээгүйтэй холбоотой үүсдэг сахилгын зөрчил буурах боломжийг бүрдүүлж өгөх нь тодорхой юм.

Хамгийн чухал асуудал нь сахилга, ёс зүй зөрчигдөхөд нөлөөлдөг тухайн бие хүний зан чанарын онцлогууд гэж байдаг нь харагдаж байна. Тухайлбал үзэн ядах, хайрлах сэтгэл, мөнгө, алдар хүнд, нэр төртэй байх хүсэл эрмэлзэл, атаархал, хардалт, сэрдэлт гэх зэрэг хувь хүний зан чанарууд нь сахилгын зөрчил үүсэхэд нөлөөлөх томоохон хүчин зүйлс болж байна.

САНАЛ

Өгүүллийн хүрээнд дараах саналуудыг дэвшүүлж байна.

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, тэр дундаа баривчлах цагдах хорих ажиллагааны онцлогт тохирсон алба хаагчийн үйл ажиллагаандаа баримтлах зан үйл, ёс зүйн үзэл баримтлалыг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн боловсруулах;

2. Цагдан хорих байрны алба хаагчийн сахилгын хариуцлага, түүнд хүлээлгэх шийтгэлтэй холбоотой харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээг боловсруулахдаа цагдан хорих үйл ажиллагааны онцлогт тохируулан албан хаагчид хүлээлгэх шийтгэх, хариуцлагын тогтолцоог сайжруулан бүрэлдүүлэх;

3. Цагдан хорих байгууллагын удирдах албан тушаалтны үйл ажиллагаа алба хаагчийн сахилга, хариуцлага, алба хаагчид хүлээлгэх сахилгын шийтгэлд шууд нөлөөлдөг тул алба хаагчийн удирдлагын үйл ажиллагаа, менежментийн бодлогыг сайжруулах үе шаттай арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх;

4. Алба хаагчаас гаргаж буй сахилгын зөрчилд тэдний зан харилцаа, ажлын байрны орчин нөхцөл, ажлын ачаалал, хүмүүжлийн төлөвшлийн байдалд нөлөөлдөг болох судалгаанаас харагдаж байгаа тул алба хаагчид үзүүлэх сургалт, давтан сургалтын үйл ажиллагаанд сэтгэл зүй, сэтгэл заслын хөтөлбөрүүдийг тусгах шаардлагатай байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Төрийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2018. №01
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2017. №24
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын сахилга, ёс зүйн дүрэм. Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал. УБ., 2018. А/183
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйлчилгээний стандарт. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаал. УБ., 2013. А/81
5. С.Нарангэрэл, Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. 2001.
6. Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. 1964.
7. Цогт-Очир Д. Хуульчийн ёс зүйн үндсэн асуудал. УБ.1999.
8. Алаадахын Жавайны. Дэлхийг байлдан дагуулагчийн түүх. Орч. М.Д.Бадамням. УБ., 2006.
9. Монголын эрт эдүгээгийн хууль цаазын түүхийн сэдэв дэвтэр. Монгол бичгээс хөрвүүлсэн Б.Баярсайхан. УБ. 2002.
10. Ж.Амарсанаа нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл. Нэгдүгээр боть. УБ., 2010.
11. Гуулин улсын судар. Тэргүүн боть. 1957.

12. Д.Лүндээжанцан нар. Эрх зүйн философи. УБ., 1998.
13. Н.Мөнхзул. Төрийн тусгай алба хаагчид хүлээлгэх сахилгын хариуцлага. УБ., 2019.
14. Б.Чимид. Төр, нам эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудлууд. УБ., 2008. 140 дэх тал
15. Д.Зүмбэрэллхам. “Монгол улсын төрийн албаны шинэтгэл: Сорилт, боломж” үндэсний чуулганд тавьсан “Монгол Улсын төрийн албаны шинэтгэл” сэдэвт үндсэн илтгэл. УБ., 2011.
16. Монгол улсын ерөнхийлөгчийн Тамгын газар. Монгол хэлний их тайлбар толь. УБ., https://mongoltoli.mn/dictionary/
17. Монгол улсын үеийн цэрэг захирах ноёны цол. Монголын түүхийн тайлбар толь. https://mongoltoli.mn/history/h/444
18. Rule of law implies that every citizen is subject to the law. It stands in contrast to the idea that the ruler is above the law, for example by divine right.

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН БИЕЧИЛСЭН ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ОЛОН УЛСЫН ЖИШЭЭ

INTERNATIONAL EXAMPLES OF PERSONAL GUARDS IN PRISON FACILITIES



Г.Мөнхбаяр
Дотоод хэргийн их сургуулийн Сургалт, судалгааны 403 дугаар анги- Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн магистрант, ахлах дэслэгч

Товч утга: Өгүүлэлд хорих байгууллагын биечилсэн харуул хамгаалалтыг гадаадын заримд оронд хэрхэн зохион байгуулж байгаа талаар судалсан.

Түлхүүр үгс: хоригдол, аюулгүй байдал, харуул хамгаалалт.

Abstract: The article examines how the physical security of prisons is organized in some foreign countries.

Keywords: prisoner, security, guard.

Харуул хамгаалалт гэсэн нэр томьёог хууль эрх зүйн тайлбар тольд ижил утга агуулгаар тодорхойлсон байдаг бөгөөд Академич С.Нарангэрэл "Эрх зүйн толь бичигт" Харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага гэрээний үндсэн дээр үйлчлүүлэгчийн эд хөрөнгө, объектыг хамгаалах үйл ажиллагаа Хяналт гэдэг нь (supervision) хууль дээдлэх талаарх төрийн янз бүрийн байгууллагын үйл ажиллагааны хэлбэр гэж тодорхойлсон бол И.Дамбажав. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичигт[219] “*хамгаалалт*-гэж хүний амь нас, эд хөрөнгө зэргийг сэргийлэх хамгаалах ажиллагаа”, “*харуул*-гэж холын барааг харахаар байгуулсан өндөрлөг тагт, цамхаг”, “*хяналт тавих*-гэж хянах үйлийн нэр, хянан магадлах ажиллагаа”, хянагч-гэж хянах үүрэг бүхий этгээд гэж тодорхойлжээ.

Дээрх тодорхойлолтоос харахад хорих байгууллагын харуул хамгаалалт гэсэн албан ёсны тогтсон тодорхойлолт байхгүй байна.

Хорих байгууллагын үйл ажиллагаа буюу хорих ял эдлүүлэх, баривчлах, цагдан хорих үйл ажиллагааг хөгжин өөрчлөгдөж буй шинжлэх ухааны чиг хандлага, түүний дотор хүн, нийгэм, төр, байгууллага, хүрээлэн буй орчны зэрэг

[219] Дамбажав.И. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг. -Уб., 2010 он. 568, 600, 866 дахь тал

бүхий л түвшний зүйлсийн хэвийн, аюулгүй оршин тогтнох үндсийг хамруулан судалдаг аюулгүй байдлын тухай онол, сургаалтай уялдуулан авч үзэж хөгжүүлэх шаардлага хэдийн бий болжээ.

Үүний гол илрэл нь хорих байгууллагын биечилсэн харуул хамгаалалт бөгөөд хорих байгууллагын албан хаагчдын тоо, нөөц хүч зэргээс шууд хамааралтай юм.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив”[220]-аар нээлттэй, хаалттай хорих ангиудад 20 хоригдол тутамд 1, хаалттай хорих ангийн тусгай нэгжид 5 хоригдол тутамд 1, нийслэл дэх цагдан хорих төвд 10 хоригдогч тутамд 1, орон нутаг дахь цагдан хорих байруудад 20-50 хоригдогчтой бол 2 хамгаалалтын ажилтан биечилсэн хяналт тавихаар тогтоосон.

Сүүлд 2017 онд шинэчлэгдэн батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 245 дугаар зүйлийн 245.2 дахь хэсэгт *“Хорих ангийн алба хаагч биечилсэн хамгаалалт, жижүүрийн үүргийг дөрвөн ээлжээр гүйцэтгэнэ”* гэж заасан мөн жишиг нормативд 20 хоригдол тутамд 1 харуул хамгаалалтын ажилтан хяналт тавьж ажиллах зохицуулалттай боловч одоогоор алба хаагчдын орон тоог жишиг норматив зааснаар нэмэгдүүлээгүй зарим хорих анги байгууллагууд харуул хамгаалалтыг гурван ээлжээр зохион байгуулан ажиллаж байна.

Монгол Улсад 2007-2010 онд нийт 31393 хүн ял шийтгүүлснээс 23193 хүнд хорих ял оногдуулсан[221] нь нийт ял шийтгүүлэгчдийн 60-аас дээш хувийг хорих ял шийтгүүлэгчид эзэлж байсан байна.

Хоригдлын тоо 5500 орчим байх хугацаанд 1 харуул хамгаалалтын ажилтны биечлэн хяналт тавих хоригдлын тоо дунджаар 70-80 байсан бөгөөд 2015, 2016 онуудад “Өршөөл үзүүлэх тухай хууль”, “Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль” хэрэгжсэнээр өршөөл, хуулийн тэгшитгэлд хамрагдан нийт 3495 хоригдол шууд суллагдаж, 2746 хоригдлын эдлэх ялаас дүйцүүлэн хассан тул нийт хоригдлын тоо буурч, ажлын ачаалал жишиг норматив ойртож байсан боловч хоригдлын тоо жилд дунджаар 400 хоригдлоор нэмэгдэж. Ажлын ачаалал буцаад нэмэгдэх хандлагатай байна[222].

Ийм дүр зураг гадаадын орнуудын хорих ял эдлүүлэх ажиллагаанд ч ажиглагдаж байгаа юм. Тухайлбал, Дэлхийн хэмжээнд 2021 оны байдлаар хорих байгууллагуудад 11 сая гаруй хоригдол ял эдэлж байгаагаас 740.000 гаруй нь эмэгтэй хоригдол байна. 118 улсад 100 хувиар, 11 улсад 250 хувиар хорих

[220]Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны А/247, А/167, 303 дугаар хамтарсан тушаал.

[221]Гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт. -Уб., 2013. 145 дахь тал.

[222] Батболд Ч. Хорих байгууллагын биечилсэн харуул хамгаалалтыг боловсронгуй болгох зарим асуудал // Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал. 2023. №02, 03, 17 дахь тал.

байгууллагын даац хэтэгсэн байна. Үүнээс гадна хорих байгууллагын алба хаагчдын дутагдал үүссэн байна. Тухайлбал, зарим орнуудад 1 алба хаагчид 1 хоригдол, зарим орнуудад 1 алба хаагчид 28 хоригдолд хяналт тавих чиг үүрэг оногдож байгаа нь өндөр ялгаатай байгааг харуулж байна. Энэ хоригдолд биечлэн хяналт тавих ажиллагаанд шууд нөлөө үзүүлдэг байна.

Цаашлаад бид өгүүлэлдээ гадаадын зарим оронд хорих байгууллагын хүний нөөцийн талаар судлан үзье.

Хүний нөөцийн хомсдол, хорих байгууллагын албан хаагчид ажлаас гаргах явдал их байгаа нь олон хорих ял эдлүүлэх тогтолцоонд томоохон тасалдал, нөхцөл байдал муудсан хэвээр байгааг Тайваны судалгааны институтээс эрхлэн гаргадаг Global Prison Trend судалгааны тайланд онцолсон байна[223].

Тухайн хүчин зүйлээс хамаарч хорих байгууллагын бусад албан хаагчид, цаашлаад хорих байгууллагын хэвийн үйл ажиллагаанд асуудал үүсгэх нь гарцаагүй. Жишээ нь, Шинэ Зеланд Улсад 2023 онд тус улсын зөвхөн нэг хорих анги бүрэн бүрэлдэхүүн, хүчин чадлараа ажиллаж, нийт хорих ангид 500 шахам сул орон тоотой, 350 гаруй ажилтан өвчтэй, чөлөө болон бусад шалтгааны улмаас ажиллах боломжгүй болсон гэж мэдээлсэн байна. Хүний нөөцийн хомсдолоос үүдэн хоригдлууд өдөрт 23 цаг өрөөндөө хоригдож, хугацаанаас нь өмнө суллагдах шүүх хурал удааширч, нийгэмшүүлэх үйл ажиллагаа доголдож, ар гэрийнхэнтэйгээ уулзах цаг ч багассан байна.

Словени Улсад 2022 онд хоригдол, хоригдогчийг шүүх хуралдаанд хуяглан хүргэх чиг үүрэг бүхий 456 албан хаагчийн орон тоо дутуу байсны улмаас шүүх хуралд хоригдол, хоригдогчийг биечлэн оруулахгүй болж цахимаар оролцуулдаг болжээ.

Австрали Улсад хоригдолд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх нэгж, албан хаагчид байхгүйгээс хоригдлуудыг бусад хорих ангиудад шилжүүлсэн тохиолдол ч байна.

Албан хаагчдын хомсдолын асуудлыг шийдвэрлэхийн тулд шинээр хүмүүсийг сонгон шалгаруулж, тогтвор суурьшилтай ажиллахгүй байгаа шалтгааныг арилгахын оронд богино хугацааны шийдлийг эрэлхийлдэг байв. Сүүлийн жилүүдэд Америкийн Нэгдсэн Улс болон Бельги Улсад дор хаяж хоёр мужид цэргийн албан хаагчдаар хорих байгууллагын сул орон тоог нөхөж байна. Хүний нөөцийн хомсдол үргэлжилсээр байгаа газар дэвшилтэт технологийг нэвтрүүлэхийг мөн эрмэлзэж байгаа юм байна. Жишээ нь Америкийн Нэгдсэн Улсын Невада мужид хийсэн туршилтаар ажилтнуудад үйл ажиллагааг бодитоор харуулах зорилгоор шууд видео дамжуулалт, дрон, дулаан мэдрэгч камер, гео орон зайн зураглал, байршил хянах төхөөрөмж зэрэг ажилтнуудыг орлох технологийг

[223] https://cdn.penalreform.org/wp-content/uploads/2023/06/GPT-2023.pdf

ашиглах, удирдлагын платформын хэсгүүдийг туршиж үзсэн байна. 900 ажилтан сул орон тоотой байсан Монтана мужийн хорих ангид үүнтэй төстэй туршилтыг хийхээр ажиллаж байна. Техник, технологи нь харуул хамгаалалтын чухал хэрэгсэл болдог хэдий ч аюулгүй байдлыг чиг үүрэг бүхий албан хаагчдыг орлох хэрэгсэл болгон ашиглах ёсгүй гэдгийг ажилтнуудын эрх ашгийг төлөөлдөг байгууллагууд онцолсон байна.

Хорих ангийн ажилтнуудын нөхцөл байдал тааруу байгаа нь ажилтнуудын эсэргүүцэл нэмэгдэхэд хүргэсээр байна. Тухайлбал, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсад 2022 онд хорих байгууллагын офицерууд хоёр долоо хоног гаруй хугацаанд ажил хаялт зарлаж, хорих байгууллагын ачаалал даамжирч, ажлын нөхцөл муу байгааг эсэргүүцэж, цалингаа нэмүүлэхийг шаардсан байна. Кот-д'Ивуар Улсын хорих байгууллагын албан хаагчид мөн ажлын нөхцлийн улмаас 2022 онд ажил хаялт зарлаж байжээ. Австрали Улсад насанд хүрээгүйчүүдийн хорих төвийн албан хаагчид эрүүл мэнд, аюулгүй байдлын хангах үйл ажиллагааг сайжруулахыг шаардсан байна. Испани Улсын Баски муж дахь Забалла шоронд саяхан шоронгийн захиргааг Баскийн засгийн газарт шилжүүлсний дараа ажилчдын хөдөлмөрийн нөхцөл байдал доройтсныг эсэргүүцэж, хөдөлмөрийн тэгш бус нөхцөл байдлын улмаас 2022 онд ажил хаялт зарласан.

Цалин нэмэх, ажлын байрны нөхцөлийг сайжруулах нь хорих байгууллагад сайн боловсон хүчнийг шинээр ажилд авах, тогтвор суурьшилтай ажиллуулахад чухал хүчин зүйл болдог хэдий ч эдгээр арга хэмжээг хорих байгууллагын тогтолцооны өөрчлөлттэй уялдуулан зохицуулах ёстой олон улсад хүлээн зөвшөөрч байна. Жишээ нь 2022 оны сүүлээр Кени улсын Ерөнхийлөгч цагдаа, хорих байгууллагын албан хаагчдын баталгаа, ажлын нөхцөлийг сайжруулах, бусад шинэчлэл хийх үндэсний ажлын хэсгийг байгуулсан. Үүнд хууль эрх зүй, бодлого, зохион байгуулалт, үйл ажиллагааны шинэчлэлийг авч үзэхээс гадна албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах арга хэмжээг авсан байна.

Хорих байгууллагын удирдах албан хаагчид шинээр албан хаагчдыг ажилд авах, тэдний сонирхолыг татах янз бүрийн арга замыг ч хайж байна. Тухайлбал, Бельги Улсад хорих байгууллагын хүний нөөцийн хомсдолыг шийдвэрлэхэд онцгойлон анхаарч байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд хэд хэдэн оронд телевизийн зар сурталчилгаагаар дамжуулан ажлын зар түгээр ажил зохион байгуулагдаж байна. Цэргийн албанаас чөлөөлөгдөж байгаа хүмүүсийг хорих байгууллагын офицероор сурган ажиллуулахыг ажлыг Англид идэвхтэй өрнүүлж байгаа юм. Мөн АНУ-ын Техас мужид хорих байгууллагад ажилд орохыг хүссэн хүмүүсийг хүлээн авах шинэ карьерын төв нээхээр төлөвлөж байгаа юм.

Дээрхээс дүгнэн үзэхэд хорих байгууллагын биечилсэн хамгаалалт нь албан хаагчдын тооноос шууд хамааралтай бөгөөд хүний нөөцийн хомсдол нь

хоригдолд зохих хяналт тавихад саад учруулж байгаа юм. Дэлхийн нэлээдгүй орнууд хорих байгууллагын албан хаагчдын хомсдолд орсон байгаа бөгөөд үүнийг шийдвэрлэхийн тулд техник, технологийг ашиглах, албан хаагчдыг орлуулах зэрэг арга хэмжээг авч байгаа юм. Гэсэн хэдий ч зөвхөн хүний хүчээр хийж болох ажлыг ямар ч техникээр оролцуулах боломжгүй нь мэдээжийн хэрэг юм.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Дамбажав.И. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг. -Уб., 2010 он. 568, 600, 866 дахь тал
2. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны А/247, А/167, 303 дугаар хамтарсан тушаал.
3. Гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт. -Уб., 2013. 145 дахь тал.
4. Батболд Ч. Хорих байгууллагын биечилсэн харуул хамгаалалтыг боловсронгуй болгох зарим асуудал // Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал. 2023. №02, 03, 17 дахь тал.
5. https://cdn.penalreform.org/wp-content/uploads/2023/06/GPT-2023.pdf

ХАР ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИСТОЙ ХОЛБОГДОХ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ХОРИГДЛУУДТАЙ АЖИЛЛАХАД АНХААРАХ АСУУДАЛ

INCIDENTS RELATED TO TOBACCO AND DRUGS
ISSUES TO CONSIDER WHEN WORKING WITH PRISONERS



Ц.Батзориг
Дотоод хэргийн их сургуулийн
Сургалт, судалгааны 403 дугаар анги-
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Аюулгүй байдлын тэнхимийн нууцын номын санч,
Хууль зүйн магистр, ахлах ахлагч

Товч агуулга: Монгол Улсад сүүлийн жилүүдэд мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн гаралт эрчимтэй нэмэгдэж аюулын харанга дэлдэж байна. Цаашдаа ч энэ төрлийн гэмт хэргийн гаралт өсөх төлөвтэй.

Хорих байгууллагад энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж хорих ял эдлэгчдийн тоо өссөөр байна. Одоогоор хорих ял эдлэгсдийн дотор мансууруулах бодист донтогч байхгүй боловч ирээдүйд ийм этгээд ял эдлэх нь тодорхой.

Иймд хар тамхинд донтогч, идэвхтэй хэрэглэгч хоригдлуудтай хэрхэн ажиллах тухай бэлтгэлийг нэн яаралтай хангах талаар санал дүгнэлт дэвшүүлсэн.

Summary: In recent years, the number of crimes related to the illegal circulation of narcotic drugs and psychoactive drugs has been increasing rapidly in Mongolia, and there is a danger. The incidence of this type of crime is expected to increase in the future.

The number of people sentenced to prison for this type of crime continues to grow. Currently, there are no drug addicts among those sentenced to prison, but it is certain that such persons will be sentenced in the future.

Therefore, suggestions were made on urgently providing training on how to work with prisoners who are drug addicts and active users.

Түлхүүр үг: Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, хар тамхи, хорих ял эдлүүлэх ажиллагаа, албадан эмчилгээ, сургалт, нийгэмшүүлэх ажил, сэтгэл заслын үйлчилгээ

Keywords: Narcotic drugs, psychoactive drugs, drugs, imprisonment, involuntary treatment, training, social work, psychotherapeutic services

УДИРТГАЛ

Сүүлийн жилүүдэд мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хууль бус эргэлт, түүнтэй холбоотой гэмт хэргийн гаралт эрчимтэй нэмэгдэж, энэ нь манай улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй байна.

Тухайлбал: 1986-2012 он хүртэл 26 жилийн хугацаанд дээрх төрлийн 67 гэмт хэрэгт 157 хүн ял шийтгүүлсэн байдаг. Гэтэл сүүлийн 5 жилд энэ төрлийн 894 гэмт хэрэг бүртгэгдэж олон тооны этгээдүүд шалгагджээ[224]. Монгол Улсын шүүн таслах ажиллагааны 2023 оны тайлан[225]-аас үзвэл 2021 онд 104 хэрэгт 238 хүн, 2022 онд 202 хэрэгт 215 хүн, 2023 онд 128 хэрэгт 144 хүн ял шийтгүүлсэн байна. /график-1/

Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн үйлдэгдсэн байдлыг сүүлийн 3 жилийн байдлаар авч үзвэл: 2021 онд мансуурсан 65, согтуугаар 5520, 2022 онд мансуурсан 92, согтуугаар 4012, 2023 онд мансуурсан 176, согтуугаар 3286 гэмт хэрэг тус тус үйлдэгдсэн тухай мэдээ байна. /график-2/.

Мөн дээрх төрлийн гэмт хэрэгт 2020 оны жилийн эцсийн байдлаар 18, 2021 онд 52, 2022 онд 32, 2023 онд 65 хүн хорих ял эдэлж байна[226]. /график-3/ Одоо ял эдэлж 91 хүний 67,3 хувь нь анх удаа, 32,7 хувь нь энэ төрлийн гэмт хэргийг давтан үйлдэгч байна. Үүнээс гадна тухайн гэмт хэрэгт шалгагдан цагдан хоригдож буй 84 хоригдогч өнөөдрийн байдлаар байна. Тэдний олонх буюу 94 хувь нь 19-40 насны буюу залуучууд байна. /график-4/

Гадаад улсад 2006 оноос 2015 оны хооронд манай улсын 126 иргэн хар тамхитай холбоотой гэмт хэрэгт холбогдсон бөгөөд үүнээс тээвэрлэсэн 13, хадгалсан 15, хилээр нэвтрүүлсэн 41, хэрэглэсэн 39, бусдад дамжуулсан 1 иргэн тус тус тухайн орны шүүхээс ял шийтгэгдсэн бол 2016 онд 18 иргэн энэ төрлийн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан байна.

Манай орны зарим нутаг дэвсгэрт ургадаг мансууруулах болон донтуулах үйлчилгээтэй бодис бүхий ургамал болох намуу, зэрлэг олс, зээргэнэ, лантанз зэрэг 9 овог, 11 төрөлд хамаарах 18 зүйл ургамал нь манай улсын 14 аймгийн 49 гаруй сумын нутаг дэвсгэрт 15,000 орчим га талбайд ургадаг гэсэн судалгаа байдаг[227].

Монгол Улсын Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн судалгаагаар[228] сүүлийн жилүүдэд мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх

[224] http://police.gov.mn/home ЦЕГ-ын цахим мэдээлэл
[225] Монгол Улсын 2023 оны шүүн таслах ажиллагааны тайлан. Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудас. www.judinstitude.mn
[226] ШШГЕГ-ын хорих ял эдлүүлэх албаны 2023 оны статистик мэдээ
[227] Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолын хавсралт
[228] Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2023 оны статистик мэдээ, СЭМҮТөв

эм бэлдмэл хэрэглэгч болон түүнд донтогчийн тоо өсөн нэмэгдэх хандлагатай байна.

ҮНДСЭН ХЭСЭГ

Дээрх төрлийн гэмт хэрэгт холбогдсон тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзвэл манай улсад мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хууль бус эргэлт, түүнтэй холбоотой гэмт хэргийн гаралт, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл /цаашид мансууруулах бодис гэх/ хэрэглэгчийн тоо цаашид тогтвортой өсөхөөр байна. Тэгвэл энэ төрлийн ял шийтгүүлсэн хоригдлуудтай харилцах асуудал нь хорих ял эдлүүлэх ажиллагааны үндсэн асуудлыг нэг болоод байгааг дурдах нь зүйтэй.

Энэ төрлийн гэмт хэргийн гаралт, хэрэглэгчийн тоо өсөх болсон шалтгааныг улс орны гадаад дотоод олон хүчин зүйлтэй холбон тайлбарлаж болно. Тухайлбал: Хөрш хоёр улс мансууруулах бодисын хууль бус эргэлт, хэрэглээгээр өндөрт тооцогддог, иргэдийн улс хооронд харилцан зорчих явдал, арилжаа худалдаа, мэдээлэл солилцоо улам бүр өссөн зэрэг даяаршлын болон иргэдийн ухамсар, нийгэм хүн ам зүйн олон хүчин зүйлийг дурдаж болно.

Сүүлийн жилүүдэд амфетамин, метамфетамины төрлийн болон мансууруулах ургамлын гаралтай бодисыг Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн, нэвтрүүлэхийг завдсан, зарж борлуулсан гэмт хэрэг, зөрчлийн тоо ихсэх болсон.[229]

Өнөөдрийн байдлаар мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг үйлдэж хорих ял эдэлж буй нийт хоригдлын 70 гаруй хувь нь мансууруулах бодисыг сонирхон хэрэглэгч байна. Нийт хорих ял эдлэгчдийн дунд хийсэн судалгаагаар мансууруулах бодис идэвхтэй хэрэглэгч буюу донтогч одоогоор байхгүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Согтуурах, мансуурах донтой өвчтөнийг албадан хөдөлмөр хийлгэх газарт захиргааны журмаар албадан эмчлүүлсэн мансуурах донтой этгээд одоогоор байхгүй. Гэвч мансууруулах бодист хэт хамаарал бүхий /донтогч/ хоригдол байхгүй гээд тайвширч болохгүй. Өөрөөр хэлбэл мансуурах бодист хэт хамаарал бүхий хоригдлуудтай хэрхэн ажиллах, тэднийг хэрхэн эмчилж нийгэмшүүлэх, хорих ангийн харуул хамгаалалтын үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах, хорих ангид мансууруулах бодис нэвтрэхээс яаж урьдчилан сэргийлэх, мансууруулах бодисыг таньж илрүүлэх, түүнд зориулсан техник хэрэгсэл ашиглах ур чадварыг алба хаагчдадаа эзэмшүүлэх, мансуурсан хоригдолтой хэрхэн ажиллах зэрэг тулгамдсан олон асуудалд одоогоос эхлэн бэлтгэх шаардлагатай байна.

[229] Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолын хавсралт

Түүнчлэн мансуурах донтой этгээдэд үзүүлэх сэтгэл зүйн болон эмнэлгийн тусгайлсан үйлчилгээний арга технологийг хорих байгууллагад нэвтрүүлж хүний нөөцийг чадавхжуулах, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дотоод гадаадын бусад байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлага тулгарч байна.

2017 онд Монгол Улсын засгийн газраас Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталсан нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, түүнээс үүдэх гэмт явдалтай хийх тэмцэлд чухал нөлөөтэй арга хэмжээ болсон. Уг хөтөлбөрийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд 1-р үе шатанд /2017-2019 он/ мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож, ажлын шинэ арга замыг тодорхойлох; мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийг иргэдэд тайлбарлан таниулах, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимтэй, үр дүнтэй зохион байгуулах бол 2-р шатанд /2019-2021 он/ мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэхэд шаардлагатай холбоо, харилцаа, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, хангах; мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын шалтгаант эмэгтэй болон мансуурсан хүнд сайн дурын болон албадан эмчилгээ, сэтгэл зүйн тусламж үзүүлэх, нийгэмшүүлэх үйлчилгээний төвийг байгуулах гэх мэт үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулсан эрх зүйн гол эх сурвалж болох Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 208 дугаар зүйлд "...мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг үйлдсэн хоригдлыг энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос тусад нь ял эдлүүлнэ гэж[230] заасан.

Гэвч хуулийн энэхүү зохицуулалтыг бүрэн хэрэгжүүлэх, өөрөөр хэлбэл энэ төрлийн гэмт хэрэгт хорих ял эдэлж буй хоригдлуудыг хоорондоо огт харьцахгүй байхаар тус тусдаа ял эдлүүлэх орчин нөхцөлийг хараахан бүрдүүлж чадаагүй байна. Харин хорих байгууллагын зүгээс мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт ял шийтгүүлж хорих ял эдэлж буй этгээдийн сөрөг нөлөөллөөс бусад хоригдлыг хамгаалахад ихээхэн анхаарч ирсэн.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээтэй холбоотой эрх зүйн хэм хэмжээ болон үндэсний хөтөлбөрт үндэслэн мансууруулах бодист хамаарал бүхий хоригдлуудын зан үйлд нөлөөлөхөд чиглэсэн "Сэтгэл хөдлөлөө хянах нь", "Гэр бүлийн харилцаа хандлага", "Зан төлөв, түүний онцлог", "Донтолт ба нойрны хямрал, "Уур бухимдлаа зохицуулах нь" зэрэг төрөл бүрийн сургалтуудыг төрийн болон төрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж ирсэн.

[230] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. 2017. №24

Түүнчлэн бясалгалын сургалтад энэ төрлийн гэмт хэрэгт ял шийтгүүлсэн хоригдлуудыг хамруулсан зохих үр дүнгээ өгдөг.

Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудыг албадан сургалтад хамруулах тухай Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан боловч уг сургалтын хөтөлбөр, агуулга, сургалтын гарын авлага, сургалт зохион байгуулах хүний нөөц, хөрөнгө мөнгөний асуудал одоогоор нэг мөр шийдвэрлэгдээгүй.

Нөгөө талаас мансуурах донтой этгээдтэй хэрхэн ажиллах, тэдгээрийг эмчлэх, сэтгэл заслын үйлчилгээнд хамруулах, хорт зуршлаас нь салгах чиглэлээр Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв болон гадаад дотоодын бусад байгууллагуудтай хамтран ажиллах асуудлыг ихээхэн чухалчилж хүний нөөцөө чадавхжуулахад анхааран ажиллаж байна.

Монгол Улсын эрүүгийн хуульд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зөвхөн сэтгэцийн хувьд хэрэг хариуцах чадваргүй эсхүл ял эдлэх боломжгүй болсон хүмүүст оногдуулахаар заасан. Харин мансуурах донтой этгээдийг хорих ял эдлэх явцад нь албадан эмчлэх асуудал эрх зүйн зохицуулалтын хувьд хийдэлтэй байна.

САНАЛ

Энэхүү илтгэл мэдээллийн хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Мансуурах донтой, хар тамхинд хамаарал бүхий хоригдолд үзүүлж буй эмчилгээ, сэтгэл засал, нийгэмшүүлэх ажлын ололт амжилт, туршлагаа хуваалцах, харилцан мэдээлэл солилцох;

2. Дээрх чиглэлээр хүний нөөцийг чадавхжуулах, сургаж дадлагажуулахад харилцан дэмжлэг үзүүлэх зэрэг болно;

3. Хар тамхи болон архинд донтсон хоригдлуудыг бусад хоригдолтой харьцах боломжийг хязгаарлаж тусад нь ял эдлүүлэх.гэмт хэрэгтнээс урьдчилан сэргийлэхэд хамгийн чухал нь тусад нь ял эдлүүлэх.

4. Манай хөрш хорон болох ОХУ-д хоригдлууд судсаар тарьдаг хар тамхи хэрэглэгдэх явдал ихэссэн. Үүнийг даган хорих ангиудад ДОХ, бусад халдварт өвчинтэй хоригдлуудын тоо эрс нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаа. Манай оронд ч гэсэн ийм байдал гарахыг үгүйсгэж болохгүй юм.

Үүнтэй холбогдуулан зарим эрдэмтэн, судлаачдын дэвшүүлсэн шинээр ирсэн мансуурах донтой хоригдлуудаас цусны шинжилгээг заавал авч байх ажлыг зохион байгуулах шаардлагатай юм.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017. №24

“Мансуурууллах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоол

Хорих ял эдлүүлэх алба. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын статистик мэдээ. УБ., 2023

СЭМҮТөв. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2023 оны статистик мэдээ

Монгол Улсын 2023 оны шүүн таслах ажиллагааны тайлан. Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудас. www.judinstitude.mn

http://police.gov.mn/home ЦЕГ-ын цахим мэдээлэл

ХАВСРАЛТ МЭДЭЭЛЭЛ

График-1



График-2

График 3





График 4



Хүснэгт 1

Мансууруулах болон сэтгэц идэвхт эм, бодис хэрэглэх донтой хэвтэн эмчлүүлсэн хүмүүс **(СЭМҮТ)**

Үзүүлэлт		2019		2020		2021		2022		2023	
		n	%	n	%	n	%	n	%	n	%
Хүйс	эрэгтэй	20	54.1	27	69.2	26	65.0	32	60.4	40	76.9
	эмэгтэй	17	45.9	12	30.8	14	35.0	21	39.6	12	23.1
Нас	10--19	5	13.5	3	7.7	7	17.5	15	27.3	14	26.9
	20-29	11	29.7	14	35.9	15	37.5	18	32.7	20	38.5
	30-39	4	10.8	11	28.2	7	17.5	9	16.4	11	21.2
	40-49	5	13.5	5	12.8	4	10.0	4	7.3	5	9.6
	50-59	6	16.2	6	15.4	2	5.0	3	5.6	2	3.8
	60+	6	16.2	0	0	5	12.5	6	10.9	0	0.0
Давтан хэвтэн эмчлүүлэгчийн тоо				3		3		3			0.0
Нийт		**37**	**100**	**39**	**100**	**40**	**100**	**55**	**100**	**52**	**100**

Хүснэгт 2

Мансууруулах болон сэтгэц идэвхт эм, бодис хэрэглэх донтой хэвтэн эмчлүүлсэн хүмүүс, оношоор **(СЭМҮТ)**

Он	Опиоидын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F11	Каннабиноидын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F12	Тайвшруулах, нойрны эмийн шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F13	Кокайны шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F14	Кофейн бүюу бусад сэдэгч хэрэглэснээс үүссэн сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F15	Хий үзэгдлийг үүсгэгч эм бодисын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F16	Дэгдэмхий уусгагч бодисын шалтгаант сэтгэцийн ба зан үйлийн эмгэгүүд F18	Олон төрлийн сэтгэц нөлөөт ба донтолт үүсгэх бодисыг хослуулан хэрэглэсний улмаас үүсэх сэтгэц болон зан үйлийн эмгэгүүд F19	Нийт
2019	5	7	16	0	1	2	0	6	37
2020	10	8	4	0	4	1	0	12	39
2021	10	6	7	0	5	1	4	7	40
2022	11	8	9	0	5	0	5	17	55
2023	12	9	4	0	1	0	7	19	52

Хүснэгт 3

Мансууруулах болон сэтгэцэд хүчтэй нөлөөлөх эм, бодисын шалтгаант магадалгааны тоо	2019	2020	2021	2022	2023
	133	90	174	239	261

Хүснэгт 4

Мансууруулах болон сэтгэц идэвхт эм, бодис, бүртгэгдсэн өвчлөл, **(улсын дүнгээр)**

Он	Опиоидын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F11	Каннабиноидын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F12	Тайвшруулах, нойрны эмийн шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F13	Кокайны шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F14	Кофейн бүюу бусад сэдэгч хэрэглэснээс үүссэн сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F15	Дэгдэмхий уусгагч бодисын шалтгаант сэтгэцийн ба зан үйлийн эмгэгүүд F18	Олон төрлийн сэтгэц нөлөөт ба донтолт үүсгэх бодисыг хослуулан хэрэглэсний улмаас үүсэх сэтгэц болон зан үйлийн эмгэгүүд F19	Нийт
2019	14	2	22	1	1	5	4	49
2020	19	3	9	0	3	5	5	44
2021	13	5	9	1	7	2	2	39
2022	10	14	9	0	5	21	3	62
2023	18	11	17	1	3	19	5	74

ЭМЭГТЭЙ ХОРИГДЛЫН ЭРХ, ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ НӨХЦӨЛ, ТҮҮНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

THE RIGHTS OF FEMALE PRISONERS, THE CONDITIONS OF IMPRISONMENT AND ANALYSIS OF HER



Б.Анун
Дотоод хэргийн их сургуулийн
Сургалт, судалгааны 403 дугаар анги-
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн магистрын хөтөлбөрийн 7011 дүгээр
дамжааны суралцагч, дэслэгч

Товч утга: Илтгэлээр хүний эрхийн суурь ойлголтыг тодорхойлж, ял эдлүүлэх ажиллагааны мөн чанарт тулгуурлан хорих ял эдлүүлэх ажиллагаа дахь хүний эрхийн ойлголтыг тайлбарлан, тэр дундаа хорих ял эдэлж буй эмэгтэйчүүдийн ялгаатай шинжийг хорих ял эдлүүлэх ажиллагаанд хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлэхийг зорьсон.

Abstract: The presentation aimed to determine the basic concept of human rights and explain the concept of human rights in the process of serving a prison sentence based on the nature of the process of serving a sentence, including how to effectively implement the different characteristics of women serving a prison sentence in the process of serving a prison sentence.

Түлхүүр үгс: Эмэгтэй хоригдол, Хорих ял эдлүүлэх дэглэм, Хоригдлын сэтгэл санааны онцлог Эмэгтэй хоригдлын бусад хоригдлоос ялгагдах онцлог

Key words: Female prisoner, Prison terms, Mental characteristics of the prisoner, Distinguishing characteristics of female prisoners from other prisoners

УДИРТГАЛ ХЭСЭГ:

Даяаршиж буй ардчилсан нийгэмд хүн төрөлхтний амьдрах орчин, эрх зүйн байдал, эдийн засгийн байдал, хүн амын тоо, гэмт хэргийн өсөлт гэх мэт олон нөхцөлөөс шалтгаалан хууль, журам баталж дагаж мөрдсөөр ирсэн. Монгол улс дахь хорих ял эдлүүлэх ажиллагаанд голчлон эрүүгийн хууль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэглэж ирсэн. Энэхүү эрх зүйн зохицуулалтууд нь эрүүгийн хариуцлагыг хангах бөгөөд тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг гэмт хэргийн нийгмийн шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна. Хорих ялыг залхаан цээрлүүлэх зорилготойгоор бус гэмт хэрэг

үйлдсэн хүнд биш гэм буруугаа ойлгох дахин гэмт хэрэг үйлдэхгүй байхад чиглэн хүний эрхийг дээдлэн хууль эрх зүйн зохицуулалт нэмэлт өөрчлөлт орж хүний эрхийг дээдлэх зарчмыг баримталсаар ирсэн. Хорих ялын асуудлыг судлаачид ихэнхдээ тухайн ялын үндэслэл, нөхцөлийг эрүүгийн хариуцлага талаас нь судалдаг хэдий ч эмэгтэй хоригдлын хорих ял эдлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох чиглэлээр харьцангуй бага судлагдсан байна.

Монгол улсын хэмжээнд Эмэгтэйчүүдийн хорих анги ганц байдаг нь Улаанбаатар хотод байрладаг. Хорих байгууллага бол хүний эрхийн талаарх асуудлын халуун цэг юм. Хорих ялаар шийтгүүлсэн хоригдол засран хүмүүжихэд сонгуульд оролцох эрх эдлэхгүй, улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих эрх нь хязгаарлагддаг ч амьд явах, эрүүл мэндээ хамгаалуулах, шударга шүүхээр шүүлгэх, хууль зүйн туслалцаа авах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, өргөдөл гомдлоо шийдвэрлүүлэх эрх нь хангагддаг байх хэрэгтэй.

ҮНДСЭН ХЭСЭГ

Хүний эрхийн ойлголт нь өнө удаан хугацаатай судлагдахуун бөгөөд олон судлаачдын анхаарлын төвд оршиж буй туйлын өргөн цар хүрээг хамарсан, бусад салбар шинжлэх ухаантай уялддаг бие даасан судлагдахуун билээ.

Хүний эрхийн тухай ойлголтыг хүний үүсэл хөгжил хийгээд төрийн үүсэл оршилтой холбон авч үзэх нь оновчтой. Италийн философич Чезериа Беккариа Нийтийн эрх ашгийн төлөө өргөл болгосон тэр л эрх чөлөөний хэсэг бүрээс төрийн дээд эрх мэдэл бүрэлдэж, засгийн эрх баригч тэрхүү сонирхлыг албан ёсоор хадгалагч эрхлэн мэдэгч болсон гэж үзжээ.

Уг судлагдахууныг өнгөрсөн цаг үеүдэд нийгмийн хүчин зүйлүүдээс хамааран харилцан адилгүйгээгээр тодорхойлж ирсэн. Тухайлбал:

Хүний эрхийн үзэл хандлагын талаар эртний буюу дээхэн үеийн судлаачдын үзэл баримтлалын нөлөө:

Руссо, Гроций, Локк, Монтескье нар хүний төрөлхөөс заяагдсан салшгүй эрхийн тухай номлолууд нь улмаар хүний эрхийн тухай билль, хүн ба иргэний эрхийн тунхаглал зэрэг алдарт баримт бичгүүд болон Англи, Франц, АНУ зэрэгт гарч дэлхийд түгэн дэлгэрчээ.[231]

Тэр дундаас Францын 1789 оны Хүний ба иргэний эрхийн тунхаглал АНУ-ын 1791 оны хүний эрхийн тухай Үндсэн хуулийн нэмэлтүүд хүний эрхэд хандах хандлагын нөлөөнд зүй ёсоор тооцогдсон.

Орчин үед хүний эрхийг хүн байх шинж, хүн төрлийг олж төрсний тулд зайлшгүй агуулах зүйл гэж үзэх болсон.

[231] Хүний эрх онол арга зүйн сэтгүүл., УБ., 2018 он

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын нэгдүгээр зүйлд хүн төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна гэж тусгажээ.[232] Энэ ч агуулгын хүрээнд байгалиас хүнд заяасан өгөгдөл, хүн хэмээх бодгальд зайлшгүй хүртэх боломжийг хэн нэгэн хууль тогтоогч, төр, нийгмийн байгуулал үгүйгсэн хязгаарлах нь тийм ч оновчтой бус гэж үзэх болсон.

Хүний эрх бусад хүний эрхээр хязгаарлагдаж, тэдэнтэй харилцан тэнцвэртэй орших шаардлагатай.

Гагцхүү хүний эрхийг ноцтой зөрчиж, нийгэмд аюул учруулахуйц этгээдийн эрх, эрх чөлөөг хязгаарлан бусдад учруулах хор уршгаас хамгаалах зорилгоор хүний эрхийг хязгаарлах агуулга илэрхийлэгдэнэ.

Үүнийг гэмт хэрэг хэмээн тайлбарлаж болох бөгөөд гэмт хэрэг, нийгмийн ноцтой зөрчил нь тухайн хүний эрхийг хязгаарлахад хүргэх гол хөшүүрэг байх учиртай. Гэсэн хэдий ч гэмт хэргийн улмаас хүний эрхийг хязгаарлах, ял шийтгэл оногдуулах нь хүртэл хүний эрхийг дээдэлсэн байх агуулгыг олон улсын хэм хэмжээнд тусгасаар байдаг.

Ял шийтгэл бол хүний нэр төр алдар хүндийг гутаан доромжлох, бие махбодыг тарчлаан зовоох хэрэгсэл биш юм.

Нөгөө талаас ял шийтгэл нь гэмт хэргийн эсрэг чиглэсэн хэрэг болохоос хүний эсрэг чиглэсэн хэрэгсэл биш. Гэмт хэрэг байгаа учраас ял шийтгэл оршиж байгаа харин хүн оршиж байгаа учраас ял шийтгэл байгаа гэдэг өнцгөөр авч үзэж хэрхэвч болохгүй.

Гэмт хэрэг гэдэг зүйл хүний толгойд, ухамсар, сэтгэхүйд л оршдог бөгөөд ял шийтгэлээр дамжуулан хүний ухамсар сэтгэхүйг засаж, сэргээн эмчлэхэд чиглэх ёстой.

Ялангуяа ял эдлүүлэх ажиллагаанд эдлэх эрх, хүлээх үүрэг буюу эрх зүйн байдал нь өвөрмөц шинжтэй. Монгол улсын эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага, ялын төрөл тодорхойлсон байдаг.

Эрүүгийн хуульд зааснаар торгох ял, нийтэд тустай ажил хийлгэх ял, зорчих эрхийг хязгаарлах ял, эрх хасах ял, хорих ял гэх мэт ялын төрөл байдаг. Үүнээс хорих ял хамгийн хүнд шийтгэлийн төрөл бөгөөд хүний эрх, эрх чөлөөг хязгаарлан олон нийтээс тусгаарлаж, харуул хамгаалалт, хяналт бүхий нөхцөлд хорих тусгай байгууллагад байлган хоригдлыг засаж хүмүүжүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэгддэг.

Энэхүү ял хэрэгжих явцад хоригдол нь жирийн иргэдийн эдэлдэг олон төрлийн эрх тухайлбал оршин суух газраа чөлөөтэй сонгох, зорчих, татвар төлөх гэх мэт иргэний журамт үүргээ биелүүлэх боломжгүй болдог онцлогтой.

[232] https://legalinfo.mn

Хорих ялын зорилго, агуулгын талаар Монгол улсын болон гадаад орны эрдэмтэн судлаачид онолын үзэл баримтлалуудыг тодорхойлон гаргасан байдаг.

Доктор Г.Совд Хорих ял нь манай эрүүгийн эрхээр тогтоосон ял шийтгэлүүдийн дотор нэлээд хүнд нь учраас түүнийг нийгмийн хор аюулаар их гэмт хэрэг үйлдсэн этгээдэд буюу хувийн чанарааараа нийгмээс тусгаарлагдах шаардлагатай этгээдэд оногдуулдаг ял[233]хэмээн тодорхойлсон байна.

ОХУ-ын судлаач профессор А.С Михлин үзэхдээ Хорих ялын зорилго нь тухайн ялтан этгээдийг залхаан цээрлүүлэхээсээ илүү гэмт зан төлөвийг нь засан төлөвшүүлэх бөгөөд нийгэмшүүлэхэд чиглэгддэг учраас зарим онцлог статус бүхий хоригдол болон хүүхэд эмэгтэйчүүдэд хорих ял шийтгүүлсэн хоригдлын хүүхэд, эмэгтэйчүүдэд тухайн ялыг эдлүүлэх дэглэмийн нөхцөл, эрхийн хязгаарлалтыг шинээр авч үзэх шаардлагатай байна гэж үзжээ.

Монгол Улсын үндсэн хуульд зааснаар Монгол улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна гэж хуульчилсан. Энэ зарчмын дагуу эрэгтэй, эмэгтэй, хүүхэд үл ялгаварлан хуулийн хариуцлага хүлээдэг. Гэсэн хэдий ч тэдний тэгш бус өгөгдөл, харилцан адилгүй шинжүүдийг харгалзан ял эдлүүлэх ажиллагааг уян хатан байдлаар хэрэгжүүлэх нь шударга ёсны зарчмын илрэл мөн.

Эрэгтэй эмэгтэй хүмүүст байгаль ертөнцөөс заяасан маш олон ил, далд өөрчлөгдөшгүй ялгаатай сэтгэлгээ, зан байдал, харилцааны арга барил өөр өөр байдаг. Тухайлбал:

- Эмэгтэй хүний биед дааврын өөрчлөлт их орж, шүлс ялгаруулалт бага байдагтай холбоотойгоор тэднийг шүд эрчүүдийнхээс хавьгүй эмзэг байдаг бөгөөд шүд цооролд өртөх магадлал их байдаг;
- Цусны даралт эрэгтэй хүнээс багатай;
- Эмэгтэйчүүд илүү анхаарал халамж шаарддаг.
- Эмэгтэй хүн маш бүтээлч бөгөөд олон ажлыг нэг дор амжуулах чадвартай байдаг.

Дээрх ялгаанаас үзэхэд эрэгтэй эмэгтэй хүмүүсийг хорих нөхцөл, хорих арга журам, үндэслэл шаардлагад тодорхой хэмжээгээр нарийвчилсан зохицуулалт шаардлагатай.

Мөн эмэгтэйчүүд гэмт хэрэг үйлдэхэд хүргэж буй шалтгаанууд нь эрэгтэй хүний гэмт хэрэг үйлдэх шалтгаан нөхцөлөөс харилцан адилгүй байгааг дурдах нь зүйтэй.

Ядуурал, ажилгүйдэл, архидалт, гэр бүлийн дарамт, хүчирхийлэл, амьдралын аргагүй гачигдалтай байдал гэх мэт бусдын нөлөөнөөс үйлддэг ба санаатай болон эрүүгийн хүнд гэмт хэрэг үйлдэх нь эрэгтэй хүнээс харьцангуй цөөн. Монгол улсад Эмэгтэйчүүдийн үйлдсэн хүн амины санаатай гэмт хэргийг судалж үзэхэд хохирогчийн буруутай ажиллагаа зохих хэмжээгээр нөлөөлсөн

[233] Совд.Г. БНМАУ-ын Эрүүгийн эрхийн курс. УБ., 1973 он 352-355 дах тал

нөхцөл байдал илрэн гардаг. Ялангуяа хохирогчийн зүгээс хүч хэрэглэсэн, дарамталсан, сэтгэл санааны хүнд байдалд оруулсан байдал ажиглагддаг[234] байна.

Монгол улсад хорих ял эдэлж буй 4169 хоригдол байгаагаас 253 эмэгтэй хоригдол юм.[235] 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 407 дугаар нээлттэй хорих ангид нийт 253 хоригдол байгаагаас залилангийн гэмт хэрэг үйлдсэн хоригдол 40 гаруй хувийг хар тамхитай холбоотой хэргээр 10 гаруй хувь хүний наймаа, бэлгийн мөлжлөгтэй холбоотой хэргээр 10 орчим хувийг эзэлж байна. Насны хувьд 26-40 насны эмэгтэйчүүд 60 гаруй хувь байгаа бөгөөд хамгийн ихдээ 10-15 жилийн хорих ял оноогдон хоригдож байгаа. Гэтэл хорих ял эдлүүлэх ажиллагаанд бага хувийг эзэлж буй эмэгтэй хоригдлын эрх зүйн байдал, хоригдох нөхцөл, хорих ял эдлүүлэх дэглэм зэрэглэлийн хуваарилалт, сэтгэл зүйн онцлогт тохирсон эрх зүйн зохицуулалтыг эрэгтэй хоригдолтой нэгдмэл зохицуулалтаар зохицуулж буй нь дутагдалтай.

Хорих ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Хорих ангийн дотоод журам голчлон ашиглагддаг.

Судлаачийнһ зүгээс эмэгтэй хоригдлын ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлын шалтгаан нөхцөлийг дараах байдлаар судлан үзлээ.

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар:

Хуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 198-202 дугаар зүйлд Хорих ял эдлүүлэх дэглэмийн талаар зохицуулсан.

Тухайлбал Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 198 дугаар зүйлийн 198.3 дахь хэсэгт “Нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол 30 хоногт 1 удаа удаан хугацааны уулзалт хийж болох бөгөөд түр хугацааны уулзалт хийх, захидал илгээх, илгээмж авах, утсаар ярих тоог хязгаарлахгүй” гэж заажээ.

Мөн 202.3 дугаар зүйл “Нээлттэй хорих ангид анх удаа гэмт хэрэг үйлдэж 5 жил хүртэл хугацаагаар ял шийтгүүлсэн эсхүл болгоомжгүй гэмт хэрэг үйлдэж 5 жил, түүнээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн эмэгтэй хоригдлыг ял эдлүүлнэ. Хоригдлын илгээмж авах тоог хязгаарлахгүй бөгөөд 7 хоногт нэг удаа түр 30 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж 7 хоногт нэг удаа илгээмж явуулж, утсаар ярьж болно” гэсэн зохицуулалт бий.

Гэтэл уг зохицуулалтад ижил төрлийн гэмт хэрэг үйлдсэн эмэгтэй, эрэгтэй хоригдлуудыг ямар шалгуурыг үндэслэн түр хугацааны уулзалтыг ялгамжтай тогтоож байгаа нь тодорхой бус байна. Үүнээс харахад эмэгтэй хоригдлын түр хугацааны уулзалт, илгээмж авах утсаар ярих боломжид хязгаарлалт тогтоосон нь

[234] Р. Оюунбадам Эмэгтэйчүүд ба хорих ял. УБ., 2021 он 23 дахь тал
[235] График 1-г харна уу. Нийт хоригдлын дотор эмэгтэй хоригдлын эзлэх хувийн жин

эмэгтэй хоригдлын эрх зүйн байдлыг эрэгтэй хоригдлынхоос дордуулсан зохицуулалт болжээ.

Герман улсад хорих ял эдлүүлэх ажиллагааг дэглэмийн төрлийн хувьд нээлттэй ба хаалттай гэсэн хоёр хэлбэрээр эдлүүлдэг байна.[236] Гэхдээ хаалттай нээлттэй дэглэм нь дотроо хэд хэдэн зэрэглэлд хуваагддагаараа онцлогтой. Нээлттэй дэглэмд хоригдож буй хоригдлууд нь эргэлт уулзалт чөлөөтэй бөгөөд тэднийг бие дааж амьдрах орчныг бүрдүүлж өгсөн байдаг.

Эмэгтэй хүнийг онцгойлон авч үзэх шаардлага нь түүний хүүхэд төрүүлэх эх хүн, гэр бүлийн түшиг тулгуур гэсэн шинжтэй холбоотой. Хүний эрхийн түгээмэл тунхаглалд Эх нялхас онцгой асрамж, туслалцаа авах хэрэгтэй[237] гэж ч тусгаж байгаа нь эмэгтэй хүн гэр бүлдээ ихээхэн ач холбогдол бүхий хамгийн гол амин чухал хэрэгтэй.

Ингэхээр эмэгтэй хүн хорих газарт хоригдсоноор үр хүүхэд ар гэрт нь тусах сөрөг нөлөө бүхий үр дүн маш их байдаг, Гараад очиход тосох үр хүүхэд, нөхөр нь хөндийрч цаашлаад салах холдох өндөр магадлал ихтэй учраас ахин гэмт хэрэг үйлдэх хүчин зүйл болохыг ч үгүйсгэхгүй. Тэгэхээр гэр бүлтэйгээ ойр дотно байж уулзалт харилцаа холбоог боломжит дээд хэмжээнд зохицуулах ёстой бөгөөд хорих ял эдэлж буй болохоос эх байх, эхнэр байх эрхээ хязгаарлуулаагүй юм.

2. Хорих ангийн дотоод журамд эмэгтэй хоригдлын эрхийг бүрэн хангаж чадахгүй байгаа талаар авч үзье.

Хорих ангийн дотоод журам нь хорих ангийн өдөр тутмын үйл ажиллагааны цагийн хуваарьт үйл ажиллагааны зохицуулалтын үндсэн эрх зүйн зохицуулалт юм. Харин эмэгтэй хорих ангид өдөр тутмын үйл ажиллагаа хоригдлыг нийгэмшүүлэх ажил явагдахад тулгарч буй асуудлын талаар 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн нийгмийн ажилтантай фокус ярилцлагын хүрээнд эмэгтэй хоригдлын хорих ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцэв.

Хорих ял эдэлж байх хугацаандаа эмэгтэй хоригдлын дийлэнх нь өдөр тутмын үйл ажиллагааны цагийн хуваарийг мөрддөг ч гэлээ нийгэмших гэхээсээ илүү үйлдвэрлэлийн ажил хийж сахилгын зөрчил гаргалгүй шагналын хоног их авч хурдан суллагдах хүсэл эрмэлзэлтэй байдаг гэнэ. Ийнхүү амьдарч байх үедээ хорих байрны орчин нөхцөлд дасан зохицох шаардлагатай. НҮБ-ын Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэмд Хоригдлын ашиглаж байгаа бүх өрөө тасалгаа, түүний дотор унтлагын өрөө нь ариун цэврийн бүх шаардлага хангасан байх ёстой бөгөөд тэгэхдээ цаг уурын нөхцөлд цаашаа эдгээр өрөөний хэмжээ, ноогдох талбай, гэрэлтүүлэг, халаалт, агааржуулалтыг онцгой анхаарвал

[236] Алтан-Очир.М. Хорих ял эдлүүлэх дэглэм.УБ., 2020 он. 78 дахь тал

[237] Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл. Эрүүгийн эрх зүй, эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. УБ., 2012 он. 11 дэх тал

зохино.[238] гэж заасан бөгөөд хоол унд, эмнэлгийн үйлчилгээ, сахилга шийтгэл гэх мэт бүхий л харилцааг тусгасан.

Тийм ч учир энэхүү олон улсын хэм хэмжээг хорих ял эдлүүлэх ажиллагаанд хэрэглэгдэх эрх зүйн зохицуулалтдаа тусгасан байдаг. Гэвч хүйсээр ялгаж зааглалгүйгээр нэг хууль дүрмээр өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Зөвхөн эмэгтэй хүний хүйсийн онцлогоос шалтгаалан үүсдэг олон төрлийн өвчин байдаг. Тухайлбал эм бэлгэсийн өвчин, судлын өвчин, эмэгтэйн бэтэг, эгэл өвчин гэх мэт нарийн мэргэжлийн эмчилгээ шаардлагатай 40 гаруй өвчин байдаг.

Энэхүү өвчний үүсэх гол шалтгаанууд нь өтгөн шингэнээ хорьж барих, сарын тэмдэг ирэх үеийн арчилгаа эмчилгээ, төрөхийн өмнөх болон төрсний дараах үеийн ариун цэвэр, сэтгэл санаа тайван бус байх, хүйтэн тохьгүй орчинд байх юм.

Иймээс эмэгтэй хорих ангийн орчин нөхцөлийг эмэгтэй хүний онцлогт тохируулан өөрчлөх шаардлага үүсэж буй нь харагдаж байна.

3. Хорих ял эдлүүлэх байршлын хувьд:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хорих ял шийтгүүлсэн 18 насанд хүрсэн эмэгтэй хоригдлын ялыг эмэгтэйчүүдийн нээлттэй, хаалттай хорих ангид эдлүүлнэ[239] гэж зааснаар эрэгтэй эмэгтэй хорих анги тусдаа байрладаг. Монгол улсын хэмжээнд эмэгтэй хорих анги ганц байдаг нь 407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 21-р хорооны Ганц худгийн аманд байрладаг[240]. Хорих ял эдэлж буй нийт хоригдлуудын хувьд эмэгтэй хоригдол цөөн хувийг эзэлдэг ч зөвхөн эмэгтэй хоригдлын талаар авч үзвэл ихэнх эмэгтэй хоригдлууд ар гэрээсээ холдоно гэсэн үг ялангуяа баруун аймгаас хоригдсон эмэгтэй хоригдлуудад илүү хохирол үүсдэг.

Жишээлбэл: Гэр бүл нь хол байдаг хүүхэдтэй хоригдлын хувьд эргэлт, уулзалт тэр бүр хуульд зааснаар тогтмол авч чадахгүй холоос ирж түр хугацаанд уулзахад тодорхой хаалттай цонхны наана цаанаас уулзуулдаг. Гэтэл эрэгтэй хоригдлын хувьд ар гэртэйгээ ойр хорих ангид хуваарилагдаж, гэр бүл, хамт олонтойгоо уулзах боломж харьцангуй нээлттэй байна.

Эмэгтэй хүн гэлтгүй эрэгтэй хүн ч удаан уулзаагүй үр хүүхдээ үнсэж тэврэхийн халуун дулааныг мэдрэхийг хүснэ. Тэгэхлээр түр уулзалтын байраас эхлээд эмэгтэй хорих ангийн орчин нөхцөлийг эмэгтэй хүний бие болон сэтгэл санааны шинжид тохируулан Олон улсын хэмжээний наад захын жишигт нийцэх

[238] Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл Уб., 2012 он
[239] https://legalinfo.mn
[240] https://cd.gov.mn

хорих анги болгон тохижуулж эрэгтэй хорих ангийн өдөр тутмын цагийн хуваарьт үйл ажиллагаанаас салгаж үзэх нь зүйтэй.

Эмэгтэй хоригдлуудад зориулсан ганц байгаа хорих ангийн байршлыг өргөтгөж олон салбар анги болгох боломжгүй учраас Жишиг хорих анги болгож хоригдлын эрх зүйн байдлыг дээдэлдэг, гэр бүл, төрөл, садантай харилцах харилцааг хүндэтгэдэг болж болно.

4. Хүүхэдтэй эмэгтэй хоригдлын хорих ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтад анхаарах асуудал байна.

Эмэгтэй хүний амьдралын нэгээхэн үнэт зүйл бол эх хүн болох ээж болох билээ. Тиймдээ ч ямар ч цаг үед үр хүүхдээ санаа тавьж, эх үрийн хүйн холбоотой амьдардаг. Гэтэл хүүхэдтэй эмэгтэй хүүхэдгүй эмэгтэй хүн хоёр хорих ялаар шийтгэгдвэл сэтгэл санааны хувьд хэрхэн ялгаатайгаар хүлээж авах бол. Хорих ялаар шийтгэгдэх тэр үед хүүхэдтэй эмэгтэй хүн тэр дундаа олон хүүхэдтэй эмэгтэй хүн хүүхдүүд минь надгүй яаж амьдрах бол, хэн өсгөж хэн халамжлах бол яг над шиг хайрлах хүн байхгүй учраас би яах вэ? гэх бодолд дарагдаж гүн шанална. Хорих ял эдэлж байх хугацаандаа надад гэр бүлтэйгээ уулзах, хамт байх боломж бий болов уу гэх эрэл хайгуулыг эрэлхийлсээр байдаг.

Өнөөгийн байдлаар 407 дугаар нээлттэй хорих ангид 253 эмэгтэй хоригдол ял эдэлж байгаагаас 5 эх 6 нярай байна. Мөн 198 хоригдол нь хүүхэдтэй ээжүүд байна.[241] Энэхүү ээж болсон хоригдлууд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар Ял эдэлж байх хугацаандаа хүүхэд төрүүлсэн хоригдлыг хүүхдийг нь хоёр нас хүртэл хамт байлгаж болно гэх заалтын дагуу 2 жил хамт байж болно. Гэтэл эрдэмтдийн судалгаанаас үзэхэд Хүүхдийн 0-3 нас бол хамгийн чухал нас энэ үедээ эхтэйгээ хамт байж хайрлах мэдрэмж авч өссөн бол зан байдал нь эергээр төлөвшдөг тиймээс ээжтэйгээ хамгийн багадаа 3 нас хүртлээ хамт байх хэрэгтэй гэж үздэг.[242] Зарим гадаад орнуудын дээрх асуудал дахь хууль зүйн үндэслэлийг харьцуулан судлахад хамгийн багадаа 4 нас хүртэл эмэгтэй хоригдол нь хүүхэдтэйгээ хамт байж болох зохицуулалтыг хуульдаа тусгажээ.[243]

Хүснэгт 1. Харьцуулалт

МОНГОЛ УЛС	АВСТРАЛИ УЛС	КАНАД УЛС
ШШГТ Хууль Хорих газраа амаржсан зарим эмэгтэй 0-1 хүртэлх насны хүүхэдтэйгээ хамт байж болно. 2002 он Ял эдэлж байх хугацаандаа хүүхэд төрүүлсэн	Эмэгтэй хоригдол 4 хүртэлх насны хүүхэдтэйгээ хамт хорих газраа байж болно. 2006 он Ванкувер	Эмэгтэй хоригдол 5 хүртэлх насны хүүхэдтэйгээ хамт хорих газраа байж болно. 2000 он Сидней

[241] График 2-г харна уу. Нийт эмэгтэй хоригдлын хүүхэдтэй эмэгтэй хоригдлын эзлэх хувь
[242] Time.mn
[243] Хүснэгт 1-г харна уу.

хоригдлыг хүүхдийг нь хоёр нас хүртэл хамт байлгаж болно. 2017 он		

Хоригдол эхчүүдэд хүүхдээ өөртэйгөө байлгахыг зөвшөөрдөг бол тэдгээр хүүхдийг эхээс тусдаа байх үед нь асрах мэргэжлийн ясли байгуулах хэрэгтэй[244] ч гэж үздэг.

Эмэгтэй хүн гэр бүл амьдралаа авч явдаг учраас хорих ял эдлэх үед гэр бүл ялангуяа үр хүүхдүүдийг нь асран хамгаалах хүн үгүйгээс болж асуудал их тулгарч сэтгэл санааны хувьд эмгэгтэй байдаг. Сэтгэл санаа тавгүйтүүлэх гол шалтгаан үүсгэж буй зүйлсийн нэг нь хүүхдээ санаа зовох асуудал юм. Учир нь эмэгтэй хүнийг хорих ял авснаас хойш нөхөр нь салах, төрөл садан нь нүүрээ буруулснаас болж дийлэнх тохиолдолд үр хүүхдийг нь хайрлаж хамгаалах хүн үгүй болдог.

Түүнээс болж хүүхдийн эрхийг хамгаалах 108 утсанд эмэгтэй хоригдлын хүүхдийн дуудлага ирж асрамжийн төвд байлгах саналууд ихээхэн гардаг. Тэр бүр хүүхэдтэй эмэгтэй хоригдол ихэнхдээ санаа зовниж утсаар ярих л эрхтэй байдаг Ийм нөхцөл байдал үүссэн үед эмэгтэйчүүд хорих ял эдэлж байгаа нь нэг талаас гэмт явдлын нийгмийн хор аюулыг ойлгох шаардагтайг харуулж байгаа ч нөгөө талаас үр хүүхэд өнчрөх, гэр бүл салж сарних, бүсгүй хүний эрхэм үүргээ биелүүлж чадахгүйд хүрэх зэрэг олон сөрөг үр дагавар буй болгож буйг харуулж байна.

ДҮГНЭЛТ

Хүний эрхийн ойлголт нь эрх чөлөө, нэр төр, адил тэгш байх шударга байх зарчмын үндэс суурь бөгөөд хүн болж төрсөн хүн бүрд угаас заяасан ёс суртахууны салшгүй эрх юм. Харин хорих ял эдлүүлэх ажиллагааны үед гэмт хэрэг үйлдсэн хоригдлын тодорхой эрхийг хууль, журмын хүрээнд хязгаарладаг нь хүний эрхийг хангах, хүний эрхэнд халдаж болзошгүй чиг хандлагыг үүсгэх аюултай. Тиймээс хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад хоригдолтой харьцахдаа хүнийх нь хувьд мэдрэмжтэй хандах нь чухал.

Хорих ял эдлүүлэх ажиллагааны зорилго нь гэмт этгээдийг залхаан цээрлүүлэх бус засан хүмүүжүүлэх дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршдог учраас гэмт хэрэг үйлдсэн л бол эмэгтэйчүүдэд ч хорих ял оногдуулж үйлдсэн гэм буруугийн хор уршгийг ойлгуулах үндсэн дээр тулгуурлан ял эдлүүлэх нь зайлшгүй.

Эмэгтэй хоригдлын хувьд сэтгэл зүй, бие бялдрын хувьд эрэгтэй хоригдлоос ялгаатай шинжүүд харьцангуй их байна. Мөн эрүүл мэндийн байдалд онцгойлон анхаарал хандуулах нь ихээхэн чухал. Тиймээс НҮБ-с тавьж буй олон улсын наад захын шаардлагат нийцүүлэн үйл ажиллагаа явуулах ман эмэгтэй

[244] Мөн тэнд 65 дах тал

болон эрэгтэй хоригдолд хорих ял эдлүүлэх ажиллагаанд хууль журмыг ялгамжтайгаар зохицуулах шаардлагатай байна.

Эмэгтэй хүнд хорих ял эдлүүлэх нь хувь хүний эрх төдийгүй гэр бүлийнх нь эрх ашигт хязгаарлалт тавьж байна. Олон улсын хэмжээнд хорих байгууллага дах хүний эрхийн асуудлыг онцгойлон авч үзэж онцгой харьцаа шаардсан эрх бүхий хоригдлуудаас онцгой ангилалд эмэгтэй хүнийг оролцуулж эмэгтэй хүнд хорих ял эдлүүлэх нь хүндрэлтэй нарийн мэдрэмж шаардсан ажиллагаа юм гэж үздэг ч үнэндээ нарийн ухаан зарцуулж, сэтгэлийн гүн арга ухааныг ойлгон хүмүүжүүлбэл эмэгтэй хоригдол засрах боломжтой.

Эмэгтэй хоригдлын ар гэр, үр хүүхдүүдийг нь тухайн хоригдлоос хөндийрч холдуулахгүйн тулд эмэгтэй хоригдлын түр хугацааны уулзалт, илгээмж авах утсаар ярих боломжид хязгаарлалт тогтоосон гэх эмэгтэй хоригдлын эрх зүйн байдлыг эрэгтэй хоригдлынхоос дордуулсан зохицуулалтыг өөрчилж шинэчлэх шаардлага байна гэж үзлээ. Энэ нь эмэгтэй хоригдлууд суллагдсаныхаа дараа дахин гэмт хэрэг үйлдэхгүй байхад нөлөөлөх томоохон хүчин зүйл болно.

САНАЛ

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар эмэгтэй, эрэгтэй хоригдлын нээлттэй хорих ангийн зэрэглэлийг ялгаатай зохицуулсныг өөрчилж, нийтлэг байдлаар зохицуулах эсвэл, эрэгтэйчүүдийн нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлтэй, эмэгтэйчүүдийн нээлттэй хорих ангийн нөхцөлийг ижил байдлаар тодорхойлох

2. Хорих ангийн дотоод журмаар эрэгтэй болон эмэгтэйчүүдийн хорих ангийн нөхцөлийг нэгэн ижил тогтоож тэнд мөрдөгдөх, арга журам, дэгийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх нь эмэгтэй, эрэгтэй хоригдлуудын биологийн онцлог, ялгаатай шинжид үл тохирч байгаа тул хорих ангийн дотоод журам дахь зохицуулалтыг харьцангуй ялгамжтай байдлаар тогтоох

3. Сэтгэлзүй, эрүүл мэнд, бие бялдрын хувьд онцлогтой эмэгтэй хоригдлуудыг нийгмээс тусгаарлан хорих ял эдлүүлэх ажиллагаа явуулдаг Улсын хэмжээний ганц хорих анги болох 407 дугаар нээлттэй, хаалттай хорих Монгол улсын жишиг хорих анги болгон тохижуулах талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон Засгийн газар хамтран ажиллах.

4. Хоригдолд олгодог чөлөөний зохицуулалтыг хүүхэдтэй эмэгтэй хоригдлын хувьд харьцангуй ялгамжтай байдлаар тодорхойлох, хоригдолд олгох урамшууллын механизмыг эмэгтэй хоригдлын хувьд хугацаанаас өмнө суллагдах нь эерэг нөлөө үзүүлэхүйц байдлаар тодорхойлох

5. Хүүхдийн асрамжийн газруудыг эмэгтэйчүүдийн хорих ангитай хамтран ажиллах санамж бичиг байгуулах, тус санамж бичгийн хүрээнд хүүхэд нь өсдөг

асрамжийн газрууд хорих ял эдэлж байгаа ээжүүдтэй нь харилцах харилцааг илүү өргөсгөн зохицуулалт тусгах

График 1. Нийт хоригдлын дотор эмэгтэй хоригдлын эзлэх хувийн жин



График 2. Нийт эмэгтэй хоригдлын хүүхэдтэй эмэгтэй хоригдлын эзлэх хувь



ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 1992 он. №01
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., 2017 он
3. Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2002 он. № 05
4. Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2016 он. №07
5.Хорих ангийн дотоод журам. УБ., 2014 он.
6. Хүний эрхийн түгээмэл тунхаглал. УБ., 1948 он.
7. Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм. УБ.,
8. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл. УБ., 2010 он

9. Совд.Г. БНМАУ-ын Эрүүгийн эрхийн курс.УБ., 1973 он
10. Р. Оюунбадам Эмэгтэйчүүд ба хорих ял. УБ., 2021 он
11. Алтан-Очир.М. Хорих ял эдлүүлэх дэглэм.УБ., 2020 он.
12.Хүний эрхийн түгээмэл тунхаглал. Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхэтгэл. Уб., 1998 он.
13.Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл. Эрүүгийн эрх зүй, эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. УБ., 2012 он.
14. Нарангэрэл.С. Эрх зүйн толь бичиг. УБ., 2011 он
15. Эрдэнэбаяр.Л. Сэтгэц судлал. УБ., 2012 он
16. Нармандах.Б. Хүний эрх. УБ., 2009 он
17. https://legalinfo.mn
18. https://cd.gov.mn
19. Time.mn
20. Ikon.mn

ХОРИГДОЛД ҮЗҮҮЛЭХ СЭТГЭЛ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ

PSYCHOLOGICAL SERVICES FOR PRISONERS



О.Баяржаргал
Дотоод хэргийн их сургуулийн
Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал төвийн
эрдэм шинжилгээний ахлах ажилтан-багш, хошууч

Товч утга: Хорих ангид хэрэгжүүлэх сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөр нь голдуу бүлгийн зохион байгуулалтаар төлөвлөгдсөн. Бүлгийн зөвлөгөө нь тодорхой нөхцөлүүдэд маш үр дүнтэй байдаг. Энэ хэсэгт бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөөнд анхаарах зүйлс болон баримтлах зарчим, хэрхэн хэрэгжүүлэх арга зам зэргийн талаар товч тайлбарлах болно.

Түлхүүр үгс: сэтгэл зүйн зөвлөгөө, зан үйл, хөтөлбөр, үйлчлүүлэгч

Abstract: As mentioned above, psychological service programs implemented in prisons are mainly designed in group settings. Group counseling is very effective under certion, we will briefly explain the principles, principles, and methods of group counseling.

Keywords: Psychological counseling, behavior, programs, clients

СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛБЭРҮҮД

Сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөрт хамрагдаж буй хүмүүсийг бүлгийн, ганцаарчилсан, хосолмол хэлбэрээр зохион байгуулж, үйлчилгээг хүргэж болно. Хорих ангийн орчин нөхцөл, хөтөлбөрт хамрагдах хүмүүсийн тоо, мэргэжилтнүүдийн хүрэлцээ зэргээс шалтгаалан ихэнх хөтөлбөрүүд бүлгийн болон хосолмол хэлбэрийн зохион байгуулалтаар хэрэгжихээр төлөвлөгдсөн байдаг. Сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд танд тус мэдээлэл хэрэг болно гэдэгт найдаж байна.

Бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөө

Дээр өгүүлсэнчлэн хорих ангид хэрэгжүүлэх сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөр нь голдуу бүлгийн зохион байгуулалтаар төлөвлөгдсөн. Бүлгийн зөвлөгөө нь тодорхой нөхцөлүүдэд маш үр дүнтэй байдаг. Энэ хэсэгт бүлгийн

сэтгэл зүйн зөвлөгөөнд анхаарах зүйлс болон баримтлах зарчим, хэрхэн хэрэгжүүлэх арга зам зэргийн талаар товч тайлбарлах болно.

Бүлгийн зөвлөгөөнд баримтлах зарчим:

- Итгэл найдвар бий болгох – эмчилгээ заслын янз бүрийн шатанд байгаа хүмүүс бүлэгт хамрагдсан байх тул аливаа зүйлийг даван туулж байгаа бусдыг харах нь тэдэнд итгэл найдвар өгнө.
- Харилцан мэдээллээ хуваалцах – мэдээллээ хуваалцах замаар бүлгийн гишүүд бие биедээ туслах боломжтой. Бүлгийн гишүүд өөрсдийн давуу талаа бусадтай хуваалцаж, бусад гишүүддээ өөртөө итгэлтэй болоход нь тусална.
- Нийгэмших арга замыг хөгжүүлэх – бүлэг нь шинэ зан үйлийг турших орчин болдог. Энэ нь аюулгүй, дэмжих орчин бөгөөд бүлгийн гишүүд алдаа гаргах вий гэхээс айж эмээлгүйгээр туршилт хийх боломжтой байх болно.
- Зан үйлийн үлгэр дуурайл үзүүлэх – бүлгийн гишүүн хувь хүн бусдадаа үлгэр дуурайлал болох ба сэтгэл зүйчийн зан үйлийг ажиглаж, түүнээс суралцана.
- Харилцан суралцах – бүлгийн бусад гишүүдтэйгээ харилцаж, тэднээс болон сэтгэл зүйчээс санал зөвлөмж сонсож, хувь хүн бүр өөрийн талаарх ойлголтоо нэмэгдүүлнэ.
- Бүлгийн гишүүдийн нэгдэл нягтрал – нэг ижил зорилгын дор бүлэг нэгдмэл болсон байх бөгөөд бүлэгт харьяалагдаж, хүлээн зөвшөөрөгдөж буй мэдрэмж гишүүдэд нэмэгдэнэ.
- Хариу үйлдэл үзүүлэх – бүлгийн гишүүдтэй өөрийн мэдрэмж, туршлагаа хуваалцах нь стресс бухимдал, өөрийн бууруутай байдал, зовлон шаналлаас ангижрахад тусална.

Бүлгийн зөвлөгөө засал хэрхэн явагдах вэ?

Бүлэгт хамгийн багадаа 3 – 4 хүн, дээд тал нь 15 хүртэлх хүмүүс хамрагдаж болно. Гэхдээ бүлгийн зөвлөгөө засалд ерөнхийдөө 7 – 12 хүнийг хамруулах нь нийтлэг тохиолддог. Хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүрээнд хэрэгжүүлэх сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөр тус бүр өөр өөрийн онцлогоос хамаарч нэг бүлэгт хамруулах хүний тоог харилцан адилгүй тодорхойлсон байдаг. Тиймээс сэтгэл зүйч та бүхэн хөтөлбөр болон өөрийн ангийн онцлог, нөхцөл байдлаас шалтгаалан тухайн хөтөлбөр тус бүрийн хувьд нэг бүлэгт хамрагдвал зохих гишүүдийн тоог бидний санал болгосныг харгалзан өөрсдөө шийдвэрлэнэ. Хэрвээ нэг хорих анги дээр сэтгэл зүйн үйлчилгээний бүх хөтөлбөрийг нэгэн зэрэг хамруулж байгаа тухайн хөтөлбөр тус бүрийн бүлэгт хамрагдах гишүүдийн тоо заавал ижил байх шаардлагагүй гэдгийг санах хэрэгтэй.

Бүлэг нэг долоо хоногт 1 – 2 удаа, 1 – 2 цагаар уулзана. Зарим эрдэмтдийн үзэж байгаагаар бүлгийн зөвлөгөө заслын уулзалтын тоо дунджаар 6 байх боловч

нэг жилийн туршид үргэлжилдэг сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөрүүд нэлээд нийтлэг байдаг. Харин хорих байгууллагад хэрэгжүүлэх сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөрүүд нь бүлгийн зөвлөгөөний 6 – 12 уулзалтуудыг багтаасан байдаг.

Бүлгийн зөвлөгөөний уулзалт нь мөн нээлттэй болон хаалттай гэсэн хэлбэртэй байна. Бүлгийн зөвлөгөөний нээлттэй уулзалтад шинэ гишүүн хэзээ ч орж ирж болно. Харин хаалттай уулзалтын хувьд бүлгийн үндсэн гишүүд л зөвхөн хамрагдах боломжтой. Хорих ангид хэрэгжүүлэх сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөр нь ерөнхийдөө хаалттай бүлгийн хэлбэрээр зохион байгуулагдах нь хөтөлбөрийн зорилгыг хангахад тустай байж болох юм.

Ихэнх тохиолдолд бүлгийн гишүүд ямар нэгэн танхимд уулзана. Хорих ангийн хувьд сэтгэл зүйчийн өрөөнд уулзаж болох боловч сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөр тус бүрийн онцлогоос хамаарч бүлгийн гишүүдийн тоо өөр өөр байж болзошгүй. Тиймээс хэрвээ нэлээд олон буюу 12 -15 орчим гишүүнтэй бүлэг бүрдүүлсэн бол томоохон өрөө тасалгаа шаардлагатай гэсэн үг. Бүлгийн гишүүд нь бие биеэ чөлөөтэй харж байхаар буюу тойрог хэлбэрээр суухаар сандал бэлтгэсэн байна. Олон улсын туршлагаас үзэхэд хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хувьд зөвлөгөөний өрөөний сандлыг шаланд бэхэлж, хөдөлгөөнгүй байрлуулсан байдаг.

Бүлгийн хамгийн эхний уулзалтаар гишүүд өөрсдийгөө танилцуулж, тус бүлэгт ямар учраас орох болсон тухай өөрсдийн санаа бодлоо бусадтайгаа хуваалцана. Харин дараа дараагийн уулзалтууд нь өмнөх уулзалтаас хойш өөрсдөд нь гарсан ахиц өөрчлөлт, туршлагын талаар гишүүд үзэл бодлоо хуваалцах байдлаар эхэлж болно. Мөн уулзалт болон уулзалтын явцад хэрэгжүүлж буй үйл ажиллагаа тус бүрийг дүгнэж байх нь маш чухал болохыг анхааралаарай.

ГАНЦААРЧИЛСАН СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ

Ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө гэдэг нь тодорхой зорилго чиглэлийн дагуу буюу хувь хүн өөрийн зан үйлээ өөрчлөх, амьдралын чанараа дээшлүүлэхийн тулд сэтгэл зүйчтэй хамтран ажиллах үйл явц юм. Бидний боловсруулсан сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөрийг ганцаарчилсан хэлбэрээр зохион байгуулж болох хэдий ч энэ нь цаг хугацаа, хөрөнгө хүч их шаардана. Тиймээс хөтөлбөрийн тодорхой хэсэгт шаардлагатай бол ганцаарчилсан байдлаар сэтгэл зүйн зөвлөгөөг ашиглана.

Ганцаарчилсан зөвлөгөөний нэг удаагийн уулзалтын үргэлжлэх хугацаа ихэвчлэн 45-60 минут байдаг. Нийт уулзалтын тоо нь тухайн хүний хэрэгцээ, зөвлөгөө заслын зорилго, ахиц өөрчлөлт зэргээс хамаарна. Ганцаарчилсан зөвлөгөөг хугацааны хувьд дараах байдлаар ангилж болно. Үүнд:

- Богино хугацааны (нийт уулзалтын тоо 4-6 удаа)
- Дунд зэрэг хугацааны (6 сар хүртэл хугацаанд үргэлжлэх)

- Урт хугацааны (6 сар ба түүнээс дээш буюу хэдэн жилээр үргэлжилж болно)

Уулзалтын давтамжийн хувьд долоо хоногт хэд хэдэн удаа, долоо хоногт 1 удаа, 2 долоо хоногт 1 удаа, эсвэл шаардлагатай тохиолдолд л гэсэн хувилбарууд байж болно.

Ганцаарчилсан зөвлөгөөний эхний уулзалтаар сэтгэл зүйч тухайн хувь хүнтэй харилцаа холбоо тогтоон, хэрэгцээг үнэлж, түүнтэй хамтран ажиллах зөвлөгөө заслын зорилгоо тодорхойлно. Тухайн хүнтэй хүлээн зөвшөөрсөн буюу шүүж буруутгахгүйгээр харилцах хэрэгтэй бөгөөд өөрийн мэдрэмж, айдас, түгшүүр, асуудал бүхий зан үйл, бодол санааныхаа талаар нээлттэй чөлөөтэй ярих боломжийг бүрдүүлэх нь чухал. Сэтгэл зүйч илүүтэй сонсож, ярьсан зүйл дээр нь тулгуурлан санал зөвлөмж, дүгнэлт хэлнэ. Тухайн хувь хүнийг өөрийн дотоод руу гүн нэвтэрч, өөрийн санаа бодол, мэдрэмж, зан үйл зэргийг зөвөөр ойлгож, ухамсарлах, улмаар өөрийгөө хүлээн зөвшөөрөх, шаардлагатай буюу хүсэж буй өөрчлөлт хийх арга замаа тодорхойлоход нь сэтгэл зүйч чиглүүлж өгнө.

ХОСОЛМОЛ СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ

Хорих ангид хэрэгжүүлэх сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөрийг хосолмол хэлбэрээр зохион байгуулж болно. Үйлчлүүлэгчийн болон хөтөлбөрийн өвөрмөц онцлог байдлаас шалтгаалан шаардлагатай тохиолдолд хосолмол байдлаар сэтгэл зүйн зөвлөгөөг хүргэнэ. Тухайлбал, үйлчлүүлэгч бүлгийн бусад гишүүдийн дунд нээлттэй байж чадахгүй, эсвэл өөрийнхөө бодол санаа, мэдрэмжээ бусдад хуваалцах нь түүнд эргээд хүндрэлтэй байдлыг бий болгох зэрэг нөхцөл үүсэж болзошгүй учраас зарим тохиолдолд ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөөг хослуулан хэрэглэх шаардлагатай болно.

Жишээ нь “Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлийг өөрчлөх” сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөрийн хувьд бусад хөтөлбөрүүдээс илүү өвөрмөц учраас хосолмол хэлбэрээр зохион байгуулах нь зорилгодоо хүрэхэд үр дүнтэй байх болно. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөөг хослуулан хэрэглэхдээ бүлгийн зөвлөгөөний явцад хүмүүсийн дунд нийтлэг ярьж болох зүйлс дээр түлхүү анхаарч, харин хувь хүнтэй холбоотой асуудлыг ганцаарчилсан уулзалтын үеэр ярилцах нь илүү тохиромжтой. Хосолмол хэлбэрийн зөвлөгөөний үед гол анхаарах зүйл бол ёс зүйн асуудал юм.

Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлийг өөрчлөх хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг тооцохын тулд хөтөлбөр анх тавьсан зорилгодоо хүрсэн эсэхийг үнэлэхийн зэрэгцээ хөтөлбөрийн эхлэл үед тухайн үеийн сэтгэл зүй – бэлгийн зан үйл болон нөхцөл байдлыг үнэлж, тодорхойлсон байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад бэлгийн хүчирхийлэл үйлдэгчид үзүүлэх үйлчилгээний хэрэгцээ болон үйлчилгээ үзүүлснээр гарч буй ахиц өөрчлөлт, эрсдэлийг 16 асуулт бүхий сорил (SOTIPS – Sex Offender Treatment Intervention and Progress Scale)

ашиглан үнэлнэ. Мөн бэлгийн хүчирхийлэл үйлдсэн үйлчлүүлэгчийн давтан гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг үнэлэхэд VASOR – 2 үнэлгээний аргыг ашиглана.

Хувь хүний зан үйл, хандлагад гарч буй ахиц өөрчлөлтийг 6 сар тутамд SOTIPS-ийг ашиглан үнэлж болно. Үнэлгээг хийхдээ аль болох олон талаас нь бодож тунгаах хэрэгтэй. Тухайлбал, зан үйлийн ажиглалт, уулзалтын тэмдэглэл, сэтгэл зүйн тест, тухайн хүнтэй харилцдаг бусад хүмүүсээс авсан мэдээлэл (эмч, нийгмийн ажилтан, харуул хамгаалалтын ажилтан, үйлчилгээний бусад ажилтнууд гэх мэт) болон хувь хүнтэй хийсэн ярилцлага зэрэг зүйлсийг бүхэлд нь тунгаан дүгнэлт хийнэ. Үнэлгээ хийх “Ярилцлагын жишээ асуултууд”-ыг тодорхой чиглэл тус бүрээр өгөх бөгөөд түүний дагуу тухайн хувь хүний талаарх цуглуулсан бүхий л мэдээллийг ашиглан, оноо өгч, үнэлнэ.

Хөтөлбөрийн төгсгөл хэсэгт зан үйлд гарсан өөрчлөлтөд үйлчлүүлэгч өөрийн үнэлгээ хийхийн зэрэгцээ хөтөлбөр эхлэх үеийн сэтгэл зүй – бэлгийн зан үйл, нөхцөл байдлын үнэлгээтэй харьцуулан дүгнэлт гаргана.

Хөтөлбөрт хамрагдах одоогийн нөхцөл байдал болон ахиц өөрчлөлтийг хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлэхдээ “Сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөрт хамрагдаж буй үйлчлүүлэгчийн нөхцөл байдал ба ахиц өөрчлөлтийн үнэлгээ”-г ашиглаж болно. Энэхүү үнэлгээний аргыг бэлгийн хүчирхийлэл үйлдэх зан үйлийг өөрчлөх хөтөлбөрийн хүрээнд болон бусад бүх төрлийн гэмт хэрэг үйлдсэн үйлчлүүлэгчид ашиглахад тохиромжтой хэсгийг салган авч хэрэглэх боломжтой. Тухайлбал, тус үнэлгээний аргын хувилбараас дараах хэсгүүдийг гэмт хэргийн төрөл хэлбэрээс үл харгалзан бүхий л үйлчлүүлэгчийн одоогийн нөхцөл байдал болон хөтөлбөрийн явц, төгсгөлд гарсан ахиц, өөрчлөлтийг үнэлж болно. Үүнд:

- Гэмт хэрэг үйлдэх болох дүрэм журам зөрчих зан үйл
- Гэмт хэрэг үйлдэх болон дүрэм журам зөрчих хандлага
- Өөрчлөлтийн үе шат
- Хөтөлбөрийн тохиромжтой нийцтэй байдал
- Сэтгэлийн хөдөлгөөнөө зохицуулах
- Асуудлыг шийдвэрлэх
- Огцом, бодлогогүй байдал
- Хөдөлмөр эрхлэлт
- Орон байр (тогтвор суурьшил)
- Нийгмийн нөлөөлөл

Гэмт хэрэг үйлдэх болох дүрэм журам зөрчих зан үйлийг үнэлж, тухайн хүний гэмт хэрэг үйлдэх, дүрэм зөрчих зан үйлийн түвшнийг тодорхойлно. Гэмт хэрэг үйлдэх болон дүрэм журам зөрчих хандлага гэсэн үзүүлэлт нь гэмт хэрэг үйлдэх болон дүрэм журам зөрчихийг дэмжих, зөвтгөх бодол, хандлагаа тухайн хүн ямар түвшинд тодорхойлж, өөрийгөө засаж залруулах талаар ямар байдалтай байгааг илэрхийлнэ.

Өөрчлөлтийн үе шат гэсэн үзүүлэлт нь тухайн хувь өөрийн асуудал бүхий буюу өөрчлөх шаардлагатай зан үйлийг хэр зэрэг ухамсарлаж, түүнийг өөрчлөх эсэх талаар ямар бодол санаатай байгааг илэрхийлнэ. “Хөтөлбөрийн тохиромжтой нийцтэй байдал” үзүүлэлт нь тухайн хүн хөтөлбөрийн үйл ажиллагаанд хэр зэрэг орж чадаж байгаа, мөн хөтөлбөрөөс хүсэн хүлээж буй зүйлд нийцэж байгаа эсэхийг үнэлнэ.

“Сэтгэлийн хөдөлгөөнөө зохицуулах” гэсэн үзүүлэлт нь “хурц” сөрөг сэтгэлийн хөдөлгөөнийг хэр зэрэг зохицуулж буй түвшнийг илэрхийлнэ. “Асуудлыг шийдвэрлэх” гэсэн үзүүлэлт нь тухайн хувь өөрийн амьдралд тохиолдох асуудлыг хэр зэрэг тодорхойлж, шийдвэрлэж байгааг илэрхийлнэ. Амьдралд тохиолдох асуудалд дараах зүйлсийг хамруулан авч үзнэ. Үүнд: амьдрах орон байр олох, цаг хугацааг хэрхэн ашиглах, ажил олох, гэр бүлийн нэгдэл нягтралыг бий болгох, шинэ холбоо харилцаа үүсгэх, гэр бүлийн яаралтай, томоохон асуудлыг шийдэх, гэр бүлийн хэн нэгэн гишүүн өвдвөл хурдан ямар нэгэн арга хэмжээ авах, олон нийтийн дэмжлэг бий болгох, хөрш, хамтран ажиллагч нартайгаа хэрхэн харилцах, удирдлага болон байгууллагын дүрэм журамтай холбоотой асуудлыг зөв зохистой зохицуулах зэрэг зүйлс орно. “Огцом, бодлогогүй байдал” гэсэн үзүүлэлт нь тухайн хүний зан үйл хэр зэрэг бодлогогүй, огцом шинжтэй болохыг илэрхийлнэ.

“Хөдөлмөр эрхлэлт” гэсэн үзүүлэлт нь тухайн хувь хүн хэр зэрэг тогтвортой, сэтгэл хангалуун ажил эрхэлдэг болохыг илэрхийлнэ. “Орон байр” гэсэн үзүүлэлт нь тухайн хувь хүний амьдардаг орон байрандаа хэр зэрэг тогтвор суурьшилтай болон түүндээ сэтгэл ханамжтай эсэхийг илэрхийлнэ. “Нийгмийн нөлөөлөл” гэсэн хэсэг нь тухайн хувь хүний амьдралд нөлөөлж буй эерэг, сөрөг нийгмийн нөлөөллийг үнэлнэ. Нийгмийн нөлөөлөлд найз нөхөд, гэр бүл орно.

Тухайн хүнд үйлчилгээ үзүүлэхийн тулд цалин авч ажиллаж байгаа хүмүүсийг үүнд хамруулахгүй. Хэрвээ тус үйлчлүүлэгч хорих ангид байгаа бол түүний холбоо харилцаа тогтоосон бусад хоригдлын нөлөөллийг тооцох хэрэгтэй. Дээрх 10 үзүүлэлтээр хөтөлбөрт хамрагдаж буй үйлчлүүлэгчийг үнэлж, “Сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөрт хамрагдаж буй үйлчлүүлэгчийн нөхцөл байдал ба ахиц өөрчлөлтийн үнэлгээний хуудас” гэсэн маягтад оноог тавина. Эдгээр үзүүлэлт тус бүрийг хөтөлбөрийн эхэнд, дунд, төгсгөл хэсэгт үнэлж, харьцуулах замаар тухайн хүнд гарсан ахиц, өөрчлөлтийг тодорхойлно. Мөн үргэлжлүүлэн ямар хөтөлбөрт хамруулахыг шийдэхэд энэхүү үнэлгээний үр дүнг ашиглаж болно.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

- Ч.Байгалмаа ба бусад. “Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлийг өөрчлөх нь” сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөр.

- Л.Эрдэнэбаяр “Монгол хүний архинд донтох зуршлыг арилгах загвар”, 2010 он
- Ч.Байгалмаа. М.Бямбабат. Зан үйлийг өөрчлөх шатчилсан аргаар зөвлөгөө өгөх нь
- http://psychology.about.com/od/psychotherapy/f/group-therapy.htm
- http://www.goodtherapy.org/individual-therapy.html#
- http://www.mdguidelines.com/psychotherapy-individual

СОГТУУРАХ, МАНСУУРАХ ДОНТОХ ӨВЧТЭЙ ХҮНД ӨГӨХ СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨНД АНХААРАХ АСУУДАЛ

PROBLEMS TO BE CONSIDERED IN PSYCHOLOGICAL COUNSELING FOR PEOPLE WITH DRUG AND DRUG ADDICTION DISEASE



Г.Батжаргал
Дотоод хэргийн их сургуулийн
Сургалт, судалгааны 403 дугаар анги-
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн ахлах багш, хошууч

Хураангуй: Хүн ямар нэг зүйлийг хэрэглэх, улмаар түүнээсээ хамааралт болох, өөрөөр хэлбэл донтох, донтох өвчтэй болох эсэх нь өнгөн талаасаа харахад тухай хүний эрх, эрх чөлөөний асуудал, төрөөс зохицуулалт хийх шаардлагагүй, төрд тийм эрх байхгүй асуудал мэт боловч бодит байдалдаа тухайн донтогч нь донтсон үедээ бусад дагалдах эрсдэлт зан үйлийг үйлдэж байдаг, улмаар нийгэмд болон өөртөө олон сөрөг үр дагавар учруулдаг нь анхаарах ёстой асуудал юм.

Тухайлбал: Тухайн нэг этгээд мансуурсан, согтуурсан үедээ гэмт хэрэг үйлдэх, өртөх нь ихэсдэг, мөн ХДХВ/ДОХ зэрэг өвчний тархалтын голлох шалтгаан нь донтсон үедээ бэлгийн харьцаанд орох, зүү тариур хэрэглэсэнтэй холбоотой байдаг, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгаагаар согтууруулах ундаанд донтогч нь тухайн бодисоос шалтгаалсан 60 гаруй суурь өвчинтэй болдог байна. Мөн гэр бүлийн тогтвортой байдал, хүүхдийн эрх ашиг, цаашилбал нийгмийн тогтвортой байдалд ч сөргөөр нөлөөлдөг. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид ч ямар нэг бодисоос хамаарсан донтох өвчинтэй байх нь өндөр үзүүлэлттэй байна.

Тоон үзүүлэлтийн хувьд 3 сая орчим хүн амтай Монгол Улсад зөвхөн Согтуурах, мансуурах донтой этгээдийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар гэхэд жилд дунджаар 700-750 хүртэл согтууруулах ундаанаас хамааралт донтох өвчтэй хүмүүс эмчлүүлдэг, тус төвд эмчлүүлээгүй буюу бүртгэгдээгүй согтууруулах ундаа болон бусад зүйлсээс хамаарах донтогчдыг оруулбал энэ тоо эрс нэмэгдэх нь гарцаагүй.

Abstract: Whether or not a person uses something and then becomes dependent on it, in other words, becomes addicted or has an addiction disease, on the surface, it seems like a matter of human rights and freedom, and the government does not need to regulate it, and the government does not have such a right, but in reality, when the addict

is addicted It is a matter that should be considered that they perform other accompanying risky behaviors and thus have many negative consequences for society and themselves.

For example: When a person is intoxicated or drunk, he commits a crime or is exposed to it, and the main reason for the spread of diseases such as HIV/AIDS is related to having sex while addicted and using needles. More than 60 basic diseases are caused due to it. It also negatively affects family stability, children's interests, and even social stability. Domestic abusers also have a high prevalence of substance abuse.

In terms of numbers, in Mongolia, which has a population of about 3 million people, only the centers for forced treatment and forced labor for people addicted to alcohol and drugs treat an average of 700-750 people with alcohol-related diseases per year. if included, this number will definitely increase dramatically.

Түлхүүр үг: Донтогч, архи, мансууруулах бодис, сэтгэл зүйн зөвлөгөө, зөвлөгч

Key words: Addiction, alcohol, drug, psychological counseling and counseling

УДИРТГАЛ

Согтуурах, мансуурах, архинд донтох өвчин орчин үеийн нийгмийн тулгамдсан асуудлуудын нэг бөгөөд нөгөө талаасаа анагаах ухааны хүндрэлтэй асуудал юм. Сэтгэл зүй ба сэтгэл заслын тусламж үзүүлэхэд шийдвэрлэхэд төвөгтэй асуудлуудын нэг юм.

Донтох явдлыг янз бүрээр тодорхойлсон байдаг. Нэг хэсэг нь архинд донтохыг оношилж болно гэж үздэг. Нөгөө хэсэг нь архинд нь донтох өвчин сэтгэцийн болон бие махбодын хамааралтай үүсдэг бие хүний хямрал гэж үздэг. Гурав дахь хэсэг нь архинд донтох гэдэг нь архийг хэрэглэснээр найз нөхөд, гэр бүлийнхэн, төрөл төрөгсөд, хамт ажиллагсадтайгаа харилцах харилцаандаа асуудал үүсгэдэг сөрөг үйлдэл бөгөөд тэд архиа уухаа больж чаддаггүй гэж тодорхойлсон байдаг. Сүүлийн тохиолдолд хэрэглэж байгаа архины хэмжээ чухал биш.

Харин согтуурах, мансуурах, архинд донтох шалтгааныг олон янзаар тайлбарладаг боловч эцсийн тодорхойлолт байдаггүй. Шалтгааныг нийгмийн, биологийн, сэтгэл зүйн гэж ангилдаг. Хувь хүний бие махбодын онцлог нь биологийн шалтгаан болдог. Нэг хэсэг хүмүүс архинд хэт мэдрэмтгий байдаг бол нөгөө хэсэг нь спиртийн ундааг их хэрэглэх чадвартай байдаг бөгөөд үүнээс үүдээд архичин болдог.

Согтуурах, мансуурах, архинд донтсон хүний хүүхэд архинд донтох өвчнөөр өвчилдөг гэсэн баримт их байдаг. Энэ нь удамшлын хүчин зүйл хэр чухал болохыг харуулж байна. Биологийн шалтгаантайгаар архинд донтсон хүмүүсийн хувьд эмийн эмчилгээний аргаар эмчлэхийг илүүд үздэг, гэхдээ төдийлөн үр дүнтэй биш байдаг.

ҮНДСЭН ХЭСЭГ

Согтуурах, мансуурах, архинд донтох сэтгэл зүйн шалтгаан нь тухайн хүн өөрийн асуудлаа архиар шийддэгт оршино. Хэдийгээр спиртийн ундаа сэтгэлийн хөдөлгөөний ачааллыг багасгахад тусалж байгаа мэт боловч архи хэрэглэх нь түүний хувьд стресс тайлах дадсан арга болдог. Хүссэн үр дүндээ хүрэхийн тулд архиа аажмаар илүү их хэмжээгээр хэрэглэдэг. Архи, мансууруулах бодисын хэмжээ ихсэх, хэрэглэх давтамж ойртох зэрэг нь дараах өөрчлөлтөд хүргэдэг. Үүнд сэтгэхүй хязгаарлагдмал болдог, бие махбодын хариу үйлдэл удааширдаг, хүмүүстэй харилцах харьцаа эвдэрдэг.

Эндээс үүсэж байгаа асуудлууд илүү хүнд, төвөгтэй болдог. Архи, мансууруулах бодист донтогч хүмүүсийн судалгаанаас үзвэл тэдний ихэнх нь идэвхгүй, бусдаас хамааралтай, сэтгэлийн хөдөлгөөн тогтворгүй болдог. Энгийн нөхцөлд хүндрэлтэй байдаг мэдрэмжээ архи уусныхаа дараа илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл архи ууснаар уурлаж хилэгнэх, бэлгийн харилцааны хэрэгцээгээ хангаж чаддаг. Нөгөө талаар их уусны дараа гэм буруутайн мэдрэмж, гэмшил төрдөг. Үүнээсээ салахын тулд мөн л дахиад архидаж, мансуурдаг.

Архи, мансууруулах бодист донтсон хүнд тусламж үзүүлэх аргыг сонгох сонголт нь зөвлөгчийн донтох асуудлын талаарх мэдлэг, архи, мансуурах бодист донтсон хүний архидалтын талаарх үзэл бодлоос ихээхэн шалтгаалдаг. [245]

Жишээ нь: Зөвлөгчийн эцэг эхийн хэн нэг нь архи, мансууруулах бодист донтдог байсантай холбоотой сөрөг сэтгэлийн хөдөлгөөн эсвэл өөрөө архийг хэт их хэрэглэдэг байх нь түүний байр суурьт нөлөө үзүүлдэг. Зөвлөгч архи, мансууруулах бодист донтсон хүнийг хүн гэж үзэхгүй, ойлгохыг хүсдэггүй бол үр дүнтэй зөвлөгөө өгч чадахгүй. Ийм тохиолдолд зөвлөгөө өгөхөөс татгалзах нь зүйтэй.

Хүмүүс сэтгэл гутралаа засах гэж архи, мансууруулах бодис хэрэглэдэг. Эхлээд сайхан байна дараа нь бүр байснаасаа ч дорддог. архи, мансууруулах бодист хэрэглэхээс татгалзах хөтөлбөрт хамрагдсанаар хүн архи, мансууруулах бодисоос гарч болно. Харин сэтгэл гутралыг эмчлэхгүйгээр архинаас гаргаж чадахгүй. Өөрөөр хэлбэл сэтгэл гутралтай тохиолдолд архинд орох нь илүү байдаг. АНУ-д явуулсан судалгаагаар архи, мансууруулах бодист донтсон хүний өвөө, аав нь бас архинд донтсон байх явдал их болохыг илрүүлсэн. [246]

Мичиганы архидалтыг хэмжих тестийг зөвлөгөөнд өргөн ашигладаг.

1. Та өөрийгөө архи, мансууруулах бодисыг тааруулдаг гэж боддог уу?
2. Таны найз нөхөд, хамаатан таныг хэвийн уудаг гэж үздэг уу?
3. Та АА-ын цуглаанд явж үзсэн үү?

[245] Л.Эрдэнэбаяр "Аддиктологийн тулгамдсан асуудал"
[246] Н.Ариунтуяа, Х.Гэрэлсүрэн “Сэтгэл зүйн зөвлөгөөний үндэс” 2007 он

4. Архи, мансууруулах бодис хэрэглэснээс болоод найз залуу, бүсгүй, эхнэр, нөхрөөсөө салж байсан удаа бий юу?
5. Архи, мансууруулах бодис хэрэглэснээс болоод таны ажил төрөл муудсан тохиолдол бий юу?
6. Архи, мансууруулах бодис хэрэглэснээс болоод гэр бүлийнхээ юм уу ажлынхаа өмнө хүлээсэн хариуцлагыг хайхрахгүй байсан удаа бий юу?
7. Архи уугаад тасарч байсан удаа бий юу?
8. Их ууж, хэрэглэсний дараа хий юм харсан, сонссон удаа бий юу?
9. Архи, мансууруулах бодис хэрэглэснээс болж эмнэлэгт очиж байсан удаа бий юу?
10. Архи, мансууруулах бодис хэрэглэснээс болж хууль зөрчиж байсан уу?

Энэхүү тестэд тийм гэсэн хариултыг хэр их сонгохын хэрээр архи, мансуурах бодист донтох байдал төдий чинээ их байна гэж үзнэ.

Амжилттай зөвлөгөө өгөхийн тулд архи, мансууруулах бодист донтсон хүний эвдэрсэн зан байдлын дундаас хүнийг нь олж харах хэрэгтэй. Зөвлөгч өөрийн донтох байдалд хандах хандлагын эх үүсвэрээ сайтар ухамсарлах хэрэгтэй.

Зөвлөгчийн ажлын стратеги тактик нь олон талаараа архи, мансууруулах бодист донтох шалтгааныг хэр зэрэг ойлгож байгаагаас шалтгаалдаг. Бёрд ийм нөхцөл байдлын хэд хэдэн хувилбарыг тодорхойлж өгчээ.

Зарим нэг зөвлөгчид архи, мансууруулах бодист донтох гэдэг бол хор хөнөөлтэй дадал зуршил, сул зан чанарын илрэл гэж үздэг. Архи ууж байна гэдэгт чухал шалтгаан байхгүй. Хэн нэгэн таалагддаг учраас, зориг хүрэхгүй байгаа учраас, хэн нэгэн уурлуулж бухимдуулсан учраас, найз нөхдийн нөлөөг эсэргүүцэх боломжгүй учраас эсвэл зүгээр л ийм болчихсон гэх мэтээр ярьдаг. Ийм хандлагын үед зөвлөгч үйлчлүүлэгчид архи, мансууруулах бодист донтогчдын талаар болон өөрийнхөө талаар юу бодож байгаагаа ярихыг хүсэж үйлчлүүлэгч юу хийх ёстойг тайлбарладаг.

Үүнд: мэдээж уухаа болих, гэр бүлтэйгээ их цагийг өнгөрүүлэх, ажилдаа анхаарлаа хандуулах, өөрийн хоббиг олохыг зөвлөдөг. Ийм заавар сайн үр дүнд хүргэдэг боловч архи, мансууруулах бодист донтогчийн хувьд тодорхой хэсэг хугацаанд уухгүй байх нь хүнд асуудал биш гэдгийг сайтар ойлгох хэрэгтэй. Тэдэнд хэдэн арав, зуун удаа уухаа болих шалтгаан байдгийг ойлгох хэрэгтэй. Ихэнх тохиолдолд зөвлөгчийн хүмүүжүүлэх гэсэн оролдлого болон уухаа болих үе хоёр давхцаж байдаг. Хэрвээ үйлчлүүлэгч гэмших мэдрэмжтэй байгаа бол тодорхой хэмжээгээр багасдаг. Архинд донтогчтой харилцаж байхдаа сургах, ёс суртахуун номлох нь цаг дэмий үрсэн хэрэг биш хэдий ч тодорхой хугацаа өнгөрсний дараа дахин архи, мансууруулах бодист ууж, хэрэглэдгийг мартаж болохгүй.

Архи, мансууруулах бодист хэт донтож байгаа шалтгааныг авч үзэхдээ зөвхөн амьдралын хүнд нөхцөл байдлыг авч үзээд бодит хүчин зүйл болох дотоод зөрчил, өөрөөсөө айх айдсыг анхаарахгүй орхигдуулах тал байдаг. Үйлчлүүлэгчийн дотоод нөхцөл байдлыг ойлгохгүйгээр түүнтэй харилцах нь гэм буруутайн мэдрэмж, түгшүүрийг нэмэгдүүлж үүгээрээ архидах дахин нэг шинэ нөхцөлийг бий болгодог.

Юуны түрүүнд зөвлөгч нь зарим нэг архи, мансууруулах бодист донтогчид туслах боломжгүй гэдгээ ойлгох хэрэгтэй. Архи, мансууруулах бодист донтогчдын ихэнх нь шүүмжлэлийг мэдрэмтгий хүлээж авдаг, өөрийгөө хамгаалах, нуугдаж үлдэх чадвартай байдаг. Архинд донтогч ч гэсэн тодорхой хэмжээгээр хүндэтгэл хүлээх эрхтэй байдаг бөгөөд зөвлөгөөний үед өөрөө өөрийгөө ойлгоход нь туслах хэрэгтэй.

Ихэнх донтогчид өөрийгөө хамгийн доод түвшинд үнэлдэг, өөрийгөө гутаан доромжилсон мэдрэмжтэй байдаг. Ер нь үргэлж архидаж байгаа нь өөрийгөө үзэн ядах, өөрийгөө устгах эрмэлзлийг илэрхийлж байдаг. Зөвлөгч нь архи, мансууруулах бодист донтогчийн бэлгийн амьдралд анхаарлаа хандуулах хэрэгтэй. Хүн өөрийн бэлгийн амьдралдаа айдастай байдаг. Ихэнх цаг хугацаагаа өөрийн хүйсийн хүмүүсийн хүрээнд өнгөрүүлдэг бөгөөд гар хангалга, гомосексуаль хөөрлөөс шалтгаалж айдас үүсдэг. Өөрийн дотоод ертөнцөө нээх нь тэдний хувьд хүнд бөгөөд маш их эрсдэлтэй байдаг.

Хөндлөнгийн хүнд бэлгийн амьдралын нууц, айдсаа илэрхийлж байгаа нь түүнийг сэтгэл санаагаар унахад хүргэдэг. Тиймээс архи, мансууруулах бодист донтох нь улам ихэсдэг. Ямар ч тохиолдолд донтогч нь зөвлөгчийн гадаад хандлагыг хүлээж авдаг бөгөөд нэлээд хурцадмал асуудлыг ярилцахаас татгалзаж, түүний дотоод ертөнцөд нэвтрэхийг зөвшөөрдөггүй.

Бёрдийн үзэж байгаагаар архи, мансууруулах бодист донтогчтой ажиллаж байгаа зөвлөгч 2 чухал зүйлийг санаж байх хэрэгтэй.

1. Мэргэжлийн бахархал, ур чадвартаа бүү бардамна.
2. Архи, мансууруулах бодист донтогчийн юу хийж чаддаг, чадвар боломжийг олж хар.

Архи, мансууруулах бодист донтогч зөвлөгчийг хэр эсэргүүцэж байгааг сайтар ойлгох хэрэгтэй. Зөвлөгчийг эсэргүүцсэнээрээ өөрөө өөрийгөө ойлгохоос зайлсхийж чаддаг. Энэ нь архидалтын үндсэн шалтгаан биш боловч гаргаж тавих нь чухал. Өөрийгөө өөрчлөхөө ухамсарлаагүй тохиолдолд үйлчлүүлэгч архи, мансууруулах бодист хэт дурлаад байгаагаа ойлгодоггүй. Гэхдээ үүнийг яаж ярих вэ гэдэг нь чухал байдаг. [247]

[247] Н.Ариунтуяа, Х.Гэрэлсүрэн “Сэтгэл зүйн зөвлөгөөний үндэс” 2007 он

Архи, мансууруулах бодист донтогч өөрөө ч гэсэн гэр бүл, ойр дотнынхныхоо амьдралыг сүйтгэж байна гэдгээ мэдэж байдаг. Зөвлөгч нь үйлчлүүлэгчийн одоогийн үйлдлийн утга санааг тайлбарлах ёстой төдийгүй зөвлөгөөний дараа түүний зан байдал ямар байх, бүх зүйл яаж дуусах талаар урьдчилан хэлж тайлбарлах ёстой. Үйлчлүүлэгчийн амьдралын бодит байдал дээр үндэслэн урьдчилан харж тодорхойлон хэлэх нь үйлчлүүлэгч өөрийн өнгөрсөн амьдралаа хэн нэгэнд буруу өгөлгүйгээр, тайван бодох боломж олгодог. Энэ нь ёс суртахуун номлох тактик ашигласнаас илүү үр дүнтэй байдаг. Архи, мансууруулах бодист донтогчтой ажиллахдаа зөвлөгч дараах зарчмуудыг дагаж мөрдөх ёстой.

Зөвлөгч үйлчлүүлэгчийг архи уугаагүй байхад зөвлөгөө өгөх

Архи, мансууруулах бодист донтогч үйлчлүүлэгчтэй харилцах харилцаа нь эсрэг тэсрэг шинжтэй байх ёстой. Үйлчлүүлэгчийн зөвлөгчид хандах хорон, зальжин харилцаа өөрчлөгдөж байдаг. Зөвлөгч нь үйлчлүүлэгчийн архи, мансууруулах бодисоос хамааралтай байдлыг өөрөөсөө хамааралтай болгоход чиглүүлнэ. Учир нь үйлчлүүлэгч архидалтаа хянадаг шигээ амьдралаа хянаж чаддаггүй.

Зөвлөгч үйлчлүүлэгчтэй харилцах харилцаан дахь хариу үйлдлээ сонгож авах хэрэгтэй. Ихэнх тохиолдолд архи, мансууруулах бодист донтогчтой ажиллаж байх явцдаа хүч чадал хүрэхгүй, найдваргүй гэсэн мэдрэмж төрж байдаг. Зөвлөгч нь донтогчийг зогсоох чадваргүй, хүчгүй гэдгээ ойлгох хэрэгтэй. Зөвхөн донтсон хүн эрүүл болохыг эрмэлзэхэд тусалж чадна. Гэхдээ уухаа болихыг албадах боломжгүй. Үйлчлүүлэгч зөвхөн өөрийнхөө хүчээр л архи, мансууруулах бодист донтохоос бүрэн салж чадна. Бодит нөхцөл байдлыг ойлгосноор зөвлөгч нь нөхцөл байдал болон үйлчлүүлэгчийн хоорондох тодорхой хязгаарыг тогтоох ёстой. Нөхцөл байдал таагүй байвал зөвлөгөө өгөхийг зогсоож болох бөгөөд гэхдээ хэзээд түүнийг хүлээж авахад бэлэн байх ёстой.[248]

АА буюу 12 алхамтай хөтөлбөр архинд донтогчид туслахад хамгийн үр дүнтэй арга юм. Бёрд үзэхдээ АА нь архинд донтогчийн гол асуудал болох өөрөөсөө айх айдсыг хөндөж чаддаг гэж үзсэн. Ихэнх тохиолдолд архинд донтогч өөртөө туслах гэсэн үед "Та надад тусалж чадахгүй. Би өдөр бүр уудаг, ажилгүй болсон, эхнэр хүүхдээсээ салсан" гэж хариулдаг. Үүгээрээ тэр өөрийнхөө уналт, зан байдлын хувьд эвдэрсэн, хэн ч байсан түүнд туслах чадваргүй гэдгийг хэлэхийг оролддог. АА-ынхан шинээр ирж байгаа архинд донтогчдын зан байдалд айгаад байх зүйл байхгүй, хувь заяа ийм байсан, чи бид нарын дунд ороод засрах болно гэж хэлдэггүй.

Харин энэ залуу 14 жил архи ууж байна, 3 удаа шоронд суусан, 12 ажил сольсон, эхнэр нь түүнийг хаяагүй боловч амиа хорлосон" гэдэг. Энэ үед архинд донтогчийн хувьд бодит байдлын мэдрэмж эргэж ирдэг. Би эдгэршгүй болчихсон

[248] С.Бямбасүрэн "Сэтгэцийн эмгэг судлал" (2007)

юм байна гэдгээ ухамсарлах үед өөрийгөө өөрчлөх, засах хүсэл эрмэлзэл төрдөг. АА нь өөрийн тусламжийг очиж өгдөггүй, архинд донтогч өөрөө очих ёстой. Унаж байгаа гэдгээ ойлгох ёстой, хүн бүрийн асуудал өөр өөр. Асуудал өөрт чинь байна, хөндлөнгийн хэн нэгнээс хамаарахгүй өөрөө архичин болж байгааг мэдрүүлж өгдөг. Хэр зэрэг архинд орсноос үл хамааражаад тусалж чаддаг.

АА хөтөлбөрийн өөр нэг чухал хэсэг нь бурханд итгэх итгэлийг төрүүлдэг. Энэ нь хамгийн гүн гүнзгий түгшүүрээс зайлсхийхэд тусалдаг. АА хөтөлбөр нь тухайн архинд донтогчийн өмнөх амьдралын утга учиргүй мэт санагдаж байсан бие хүмүүсийн харилцааг өөрчилж чаддаг. Хөтөлбөрт хамрагдаж байгаа хүмүүсийг яагаад архи хэрэглэхээ больсныг тайлбарлахад хүндрэлтэй байдаг. Ер нь өөртэйгөө адилхан асуудалтай хүмүүсийн дунд өөрийгөө харах, өөрийгөө илүү гүнзгий харахад хялбар байдаг. Шинээр, ирж байгаа хүмүүсийн ярианаас өөрийнхөө өнгөрсөн амьдралыг олж хараад буцаж архинд орохгүй гэсэн хүч авдаг.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Архи, мансууруулах бодист донтох нь гол амьдралын нөхцөл байдлаас хамаарч байгаа гэдгийг ойлгохоос гадна үйлчлүүлэгчийн юунаас зугтаагаад байгаа, асуудал, хүндрэл рүү анхаарлаа чиглүүлнэ. Ихэнх тохиолдолд донтогчид нь өөрийн хүндрэлийн талаар дуртайяа ярьдаг. Хүнд амьдрал, гэр оронгүй байсан бага нас, азгүй гэрлэлт, ажил дээр үүссэн асуудал гэх мэт.

Энэ нь зөвлөгчид бодитой туслах хүсэл, өрөвдөх сэтгэлийг бий болгодог. Мөнгө өгөх, ямар нэг зүйл худалдаж авч өгөх, орон байр олж өгөх гэх мэт. Зөвлөгчийн энэ үйлдэл тодорхой үр дүнтэй мэт харагдах боловч удаан үргэлжилдэггүй.

Зөвлөгч үйлчлүүлэгчид эелдэг хандах ёстой боловч хэт уян зөөлөн байх шаардлагагүй. Учир нь зөвлөгч маш амархан, манипулятив харилцааны хохирогч болж магадгүй. Учир нь архи, мансууруулах бодист донтогчид зөвлөгчийн анхаарлыг өөртөө татах, өөрийгөө өрөвдүүлэх чадвартай байдаг учраас үүнийг хэрэглээд байдаг.

“АА” хөтөлбөрийн сэтгэл заслын хамгийн чухал хүчин зүйл нь шинээр ирсэн хүнийг өөрийнхөө тухай хамгийн муу талаа ярихыг шаарддаг. Энэ байдал нь түүнд гэмших мэдрэмжийг үүсгээд олон жилээр өөрт хуримтлагдсан асуудлаа ярьдаг. Өөрийнхөө талаар бодохоос ч айдаг байсан зүйлээ ярихыг шаарддаг. Хамгийн гол нь хэн ч хэн нэгнээс илүү болохыг эрмэлздэггүйд оршино. Хүмүүс өөртэй нь адилхан гэдэг итгэлийг төрүүлэх нь чухал байдаг.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Д.Мөнхцэцэг “Донтолт ба сэтгэл зүйн зөвлөгөө” (2018)
2. С.Бямбасүрэн "Сэтгэцийн эмгэг судлал" (2007)

3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль;

4. Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хууль;

5. "Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг албадан эмчлэх журам" (2005 оны ЭМСайд, УЕПрокурорын хамтарсан 152/188 тушаал);

6. "Архины шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийн оношилгоо, эмчилгээ" MNS 5396-1:2004 стандарт;

7. Н.Ариунтуяа, Х.Гэрэлсүрэн “Сэтгэл зүйн зөвлөгөөний үндэс” 2007 он

8. Мансууруулах эмийн тухай 1961 оны НҮБ-ын конвенц

9. Сэтгэцэд нөлөөт бодисын тухай 1971 оны конвенц;

10. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг тэмцэх тухай 1988 оны НҮБ-ын конвенц

СУЛЛАГДАХ ХУГАЦАА ДӨХСӨН ХОРИГДОЛД ҮЗҮҮЛЭХ НИЙГЭМШҮҮЛЭХ АЖЛЫН АЧ ХОЛБОГДОЛ

SHOW INMATES APPROACHING RELEASE DEADLINE THE IMPORTANCE OF COMMUNITY WORK



Ц.Ганзориг
Дотоод хэргийн их сургуулийн
Сургалт, Судалгааны 403 дугаар анги-
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
магистрант, 439 дүгээр хаалттай хорих ангийн
төлөөлөгч, ахлах дэслэгч

Товч агуулга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд “Хорих ял эдэлж байгаа ялтанг хоригдол гэнэ”[249] хэмээн заасан байдаг. Хорих ял эдэлж буй хоригдол нь тодорхой хугацаанд нийгмээс тусгаарлагддаг ба хорих ялаа эдлээд суллагдах үед нийгмийн харилцаанд оролцохдоо их бага хэмжээгээр ямар нэгэн аливаа асуудалтай тулгарч байдаг.

Тэрхүү нийгмийн харилцаанд оролцоход тулгарч буй хүндрэл бэрхшээлийг даван туулах, ажил хөдөлмөр эрхэлж амьдрах цаашлаад гэр бүлээ тэжээн тэтгэх, дахин гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх үүднээс тухайн хоригдлыг суллагдах хугацаа дуусахаас тодорхой хугацааны өмнө нийгмийн амьдралд бэлтгэх зорилгоор суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажлыг тодорхой нарийвчлалтайгаар үр дүнтэй зохион явуулах нь чухал билээ.

Overview: The Law on Execution of Court Decisions states that "Prisoner is a convict who is serving a prison sentence. A prisoner serving a prison sentence is isolated from society for a certain period of time, and when he is released after serving his prison sentence, he faces more or less problems in participating in social relations.

In order to overcome the difficulties faced in participating in social relations, to continue to work and live, to support the family, and to prevent recidivism, to organize pre-release socialization work with a certain precision in order to prepare the prisoner for a certain period of time before the end of the release period. is important.

Түлхүүр үгс: Нийгмийн ажилтан, хоригдол, нийгэмшүүлэх ажил, суллагдах хугацаа, нийгмийн амьдрал.

Key words: social worker, prisoner, social work, time of release and social life.

[249] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2017)

ОРШИЛ

Хүн бол нийгмийн амьтан бөгөөд нийгмийг бүтээгч эх юм. Хүн байгаа газарт нийгэм оршин тогтнож байдаг. Нийгмийг бүтээгч хүн нь ямар нэгэн байдлаар гэр бүлд харьяалагдаж, гишүүн нь болж амьдардаг. Энэ нь чухамдаа Л.Берталанфийн “системийн онол” үзэл баримтлалаар маш тодорхой тайлбарлагдана. Нөгөө талаас хорих анги бол нэг төрлийн нийгэм, нийгмийн нэг хэлбэр бөгөөд хоригдлын ял эдэлж буй орчин нөхцөл, тэнд амьдарч буй бусад хоригдлууд, алба хаагчид, хамаарал бүхий этгээд ч тэрхүү нийгэмд харьяалагдаж, тэрхүү нийгэм гэх “систем”-ийн нэг хэсэгт тооцогдоно. Өрөөсгөлөөр ойлгоход бас нэгэн гэр бүл ч гэж нэрлэгдэх боломжтой.

Тиймээс л хоригдлыг суллагдах хугацаа дуусах үед нь нийгэмшүүлэх ажлыг сайтар ойлгож ухаарах нь маш чухал. Хоригдолд мэргэжил, боловсрол эзэмшүүлж, эерэг зан үйл төлөвшүүлэх системчилсэн сургалтад хамруулан, гэмт санаа бодлоос нь татгалзуулах төрөл бүрийн нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь нийгэмшүүлэх ажлын салшгүй чухал ойлголтууд мөн юм. Хорих ял эдэлж байх бүхий л хугацаанд дээрх сургалт, хүмүүжлийн ажлуудыг зохион байгуулж байдаг. Тиймээс суллагдах хугацаа дөхсөн хоригдлыг арай өөр аргаар нийгмийн амьдралд гарахад нь хөл алдахгүй байдлаар ажил хийх боломжоор хангах, ажил хөдөлмөр хийх чадвартай болгох, хамгийн наад захын ухаалаг гар утас барих, цахим төлбөр тооцоолууруудад чадавхжуулах наад захын шаардлага тулгарч байгаа юм.

Судалгааны зорилго:

Суллагдаж буй хоригдлын нийгмийн харилцаанд учрах саад бэрхшээлийг бууруулах, даван туулах чадварыг нэмэгдүүлэх, дахин гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх, хорих ангийн нийгэмшүүлэх байрны зохион байгуулалт, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход оршино.

Зорилт:

-Хоригдлыг суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажлын ойлголт, түүхэн уламжлалыг авч үзэх,

-Хоригдлыг суллагдахын өмнөх сургалтын төрөл, хэлбэрийг боловсронгуй болгох,

-Суллагдахын өмнөх эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, практик ажиллагаанд тулгамдаж буй асуудлуудыг нээн илрүүлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох хүрээнд өөрийн дүгнэлт, саналыг гаргах.

ҮНДСЭН ХЭСЭГ:

Судалгааны ажлын үндсэн агуулгын хүрээнд:

1. Суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажлын ойлголт;
2. ШШГТ хууль, Хорих ангийн дотоод журамд зааснаар суллагдаж буй хоригдлын эрх зүйн боломжийн талаар;
3. Гэр бүлийн харилцаа хоригдлын нийгэмших үйл явцад хэрхэн нөлөөлдөг талаар тус тус тусгаж өгсөн.

Энэхүү судалгааны арга зүй нь:

- Сэдэвтэй холбоотой хууль, эрх зүйн болон онолын баримт бичгүүдийг судлах;
- Хоригдолтой хийсэн уулзалт, ярилцлага /ганцааарчилсан болон бүлгийн/-ийн тэмдэглэл, бодит кейс, баримтад тулгуурлах;
- Хоригдлыг нийгэмшүүлэх ажилтай холбоотой бусад улс орны туршлагыг судлах.

Судалгааны ач холбогдол:

Хоригдлыг суллагдах хугацаа дуусах үед нь тодорхой төлөвлөгөөний дагуу сургалтыг зохион байгуулснаар тэднийг нийгмийн амьдралд дахин гэмт хэрэгт холбогдохгүй амьдрахад нь туслах, өөрийн гэсэн ур чадвартай, мэргэжилтэй болж ажил хөдөлмөр эрхлэх цаашлаад гэр бүлээ тэжээн тэтгэх, нийгмийн хөгжил, цахим хөгжилд хөл алдахгүй зэрэгцэн алхах боломжийг хоригдолд олгох зэрэг гол ач холбогдолд тулгуурлан нийгэмшүүлэх ажлын бодит үр дүнд хүрээсэй гэсэн итгэл найдварыг тээж энэхүү илтгэлийг бичлээ.

1. Суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажлын ойлголт:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2018 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/127 дугаар тушаалаар “Нийгмийн ажлын аргачилсан заавар”-ыг баталсан. Тухайн зааварт “**хорих байгууллагын нийгэмшүүлэх ажил”** гэж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 219 дүгээр зүйл 219.1 дэх хэсэгт зааснаар хоригдол нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход нь дэмжлэг үзүүлэх, чадваржуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг[250] хэлнэ гэж заасан нь хоригдол нийгмийн харилцаанд оролцох, ахин гэмт хэрэгт холбогдохгүй байхад нь чиглэсэн нийгэмшүүлэх ажлыг түлхүү авч хэрэгжүүлэх шаардлагатай гэдэг нь энэхүү тодорхойлолтоос харагдаж байна.

Тэгвэл хоригдлыг суллагдахын өмнө нийгмийн харилцаанд гарахад нь ямар ажил арга хэмжээг хэрэгжүүлэх тухай тодорхой эрх зүйн болон хууль, журмаар зохицуулж өгсөн оновчтой дүрэм, заавар дутмаг байна.

Нийгмийн ажлын аргачилсан зааврын 3.4 дэх хэсэгт хоригдлыг суллагдахын өмнө авч хэрэгжүүлэх арга хэмжээнд дараах ажил арга хэмжээнүүдийг тусгасан байна. Үүнд:

1.Ялын хугацаа дуусаж, хорих ялаас хугацаанаас өмнө суллагдах хоригдлыг нийгмийн амьдралд гарахад нь бэлтгэх зорилгоор 3 сарын өмнө сургалтад хамруулах гэж зааж өгсөн байна. Тухайн асуудал дээр ихэнх хорих анги тухайн хоригдлыг суллагдахаас 3 сарын өмнө сургалтад хамруулж чадахгүй байгаа байдал ажиглагдаж байгаа ба тухайн 3 сарын хугацаанд ямар чиглэлээр, юуны тухай сургалтыг зохион байгуулах нь тодорхойгүй байгаа ба тухайн

[250] Нийгмийн ажлын аргачилсан заавар (2018)

сургалтын төлөвлөгөө болон орчин зохион байгуулалтын талаар тодорхой тусгаж өгөх унь нэн шаардлагатай болоод байгаа юм.

2.Нийгмийн амьдрал болон цаг үеийн мэдээллийг гарын авлага, тусгайлан бэлтгэгдсэн нэвтрүүлэг бусад хэлбэрээр танилцуулах гэж заасан ба тухайн мэдээ мэдээллийг нийгмийн ажилтан нар цаг тухай бүр нь өгч ажиллаж байгаа ба суллагдах хоригдлыг зарим хорих анги нь 1-3 сарын хугацаатайгаар тусгайлан бэлтгэсэн нийгэмшүүлэх байранд байрлуулан сургалт сурталчилгааг зохион байгуулж байгаа ба тухайн нийгэмшүүлэх байрны талаар хууль эрх зүйн зохицуулалт хараахан гараагүй байгаа нь нийтээр нэвтрүүлэх хүлээн зөвшөөрөхөд хүндрэл тулгарч байгаа юм.

3.Мэргэжлийн болон бусад сургалтад хамрагдсан бичиг баримтыг бүрдүүлэх гэж заасан ба тухайн хоригдлын өмнө авсан мэргэжлийн гэрчилгээг бүртгэх эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр үйлдвэрлэлийн дадлага, практик дадлага хийлгэж ажлын байранд гараад гологдохооргүй чадвартай болгоход нь түлхүү анхаарах.

4.Хоригдлын гэр бүлд чиглэсэн зөвлөгөө өгөх гэж заасан байгаа ба зөвлөгөөг ямар хэлбэрээр явуулах тодорхой төлөвлөгөөний дагуу гэр бүлийн судалгаа хийж уулзах гэх мэт ажлуудыг нарийвчлан хийх нь нэн чухал болоод байна.

Хорих байгууллагын нийгмийн ажилтан нар нь тухайн нийгмийн ажилтны аргачилсан зааварт заагдсан ажлуудыг хоригдлуудад хэрхэн хэрэгжүүлэх талаар мэдлэг дутмаг байгаа бөгөөд зөвхөн тухайн зааврыг барин суллагдах хоригдлыг нийгэмшүүлнэ гэдэг нь өөрөө өрөөсгөл ойлголт юм. Тиймээс тухайн хоригдол нь нийгэмд гараад хувь хүн болохын нийгмийн нэг эд эс болохын хувьд төрөл бүрээр нийгмийн амьдралд дасан зохицуулж амьдрах чадварыг нэмэгдүүлэх нь чухал юм.

Зарим хоригдлууд нийгэмд гараад хүлээн авах орчин байхгүй, ар гэр, гэр бүлийн хүмүүсийн тавих хараа хяналтгүй байдлаас үүдэн буцаад гэмт хэрэгт холбогдох байдал багагүй гардаг тиймээс тэдний ар гэр, гэр бүл рүү чиглэж ажиллаж өгөх нь бас нэг анхаарах асуудал юм. Гэр бүлийн талаар 3 дугаар бүлэгт тодорхой тусгаж өглөө.

Нийгмийн хөгжил цаг үеэ дагаад улам боловсронгуй болж, хөгжин дэвшиж байна. Энэ үед 1990 оноос хойш гэмт хэрэг үйлдсэн, хорих ангиар удаан жил явсан, 20 жилийн ял эдлээд гарч байгаа хоригдлуудын хувьд ухаалаг гар утас ашиглах, цахим орчинд нэвтрэх, интернэтээс мэдээлэл хайх, төлбөр тооцоо хийх, автобус унаанд суух, очих газраа заах, саадгүй хүрэх гээд наад захын бидний амьдралд байдаг энгийн зүйлсийг хийж чадахгүй түүндээ ичиж зовсондоо нийгэмд амьдрах итгэл нь алдуурдаг. Үүнээс шалтгаалан гэмт хэрэг, зөрчилд дахин холбогдох явдал ч гардаг юм.

2.ШШГТ хууль, хорих ангийн дотоод журамд зааснаар суллагдаж буй хоригдлын нийгэмшүүлэх ажил, эрх зүйн боломжийн талаар:

Хоригдлыг нийгэмшүүлэх ажлын талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд дараах байдлаар тусгасан. Үүнд:

218 дугаар зүйл. Нийгэмшүүлэх ажил

“Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын хүрээнд хоригдол хорих ангид ял эдлэх бүхий л хугацааг хамарсан, хоригдолд нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхижуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ.”

“Хорих анги нь нийгэмшүүлэх ажлын мэргэшсэн нэгжтэй байх бөгөөд хоригдлыг хорих ангид хүлээн авмагц нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, түүнд үндэслэн нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө боловсруулж ажиллана.”

219 дүгээр зүйл. Нийгэмшүүлэх ажлын хэлбэр, зохион байгуулалт

“Хоригдлыг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон хүсэл, сонирхолд нь үндэслэн эрэг зан үйлд төлөвшүүлэх бусад хэлбэрээр нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулна.”

“Нийгэмшүүлэх ажилд хорих ангийн алба хаагчаас гадна бусад байгууллага, иргэнийг оролцуулж болно.”

“Нийгэмшүүлэх ажлыг хоригдлын үйлдсэн гэмт хэргийн болон түүний хувийн байдал, нас, хүйс, ял эдлүүлэх нөхцөлийг харгалзан ганцаарчилсан, бүлгийн, эсхүл нийтэд чиглэсэн хэлбэрээр тусгай хөтөлбөр боловсруулж үе шаттай, ялгамжтай зохион байгуулна. Нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулахад хорих анги, алба хаагч, бусад байгууллага, албан тушаалтнаас хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд туслалцаа авч болно.”

“Хоригдлыг нийгэмшүүлэх ажлыг ял эдлүүлэх ажиллагааг хөдөлмөр, сургалттай хослуулах, хоригдлын бүтээлч ажиллагаа, ур ашигтай санаачилгыг дэмжих, ёс зүй, сэтгэл зүйн нөлөөллийг хорих ангийн дэглэм, зэрэглэлийн онцлогийг харгалзан зохион байгуулна.”

Хуулийн эдгээр зүйл заалтаас харахад хоригдлыг нийгэмшүүлэх ажилд алба хаагч, бусад байгууллага, иргэнийг татан оролцуулж болох тухай заасан боловч нийгэмд гараад дахин гэмт хэрэг үйлдэх, архи согтууруулах ундаа хэрэглэж гудамжинд гарах байдал нь нийгэмшүүлэх ажлын судалгаа шинжилгээг сайтар хийж, ач холбогдлыг нь таниулан ойлгуулах ажил дутмаг байгаагийн нэг илрэл юм. Харин “хоригдол хорих ангид ял эдлэх бүхий л хугацааг хамарсан” хэмээн заасан явдал нь хоригдол ял эдэлж эхлэхээс авхуулаад л түүнийг суллагдан гарахад нь бэлтгэх шаардлагатайг харуулж байна.

Мөн хоригдлыг нийгэмшүүлэх ажлын нэг үндсэн чиглэл нь суллагдах хугацаа дуусаж байгаа хоригдолд архи согтууруулах ундаа, хорт зуршлаас хол

байлгах сургалтыг тогтмол зохион байгуулж тэдний сэтгэл зүйн байдалд нөлөөлөх явдал бас шаардлагатай байгаа юм.

Хорих ангийн дотоод журмын 11 дүгээр зүйл нийгэмшүүлэх ажлын талаар тусгасан ба 11 дүгээр зүйлийн 2 дэх хэсэгт "Хоригдлын дунд явуулах нийгэмшүүлэх ажилд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар баталсан "Нийгмийн ажлын аргачилсан заавар"-ыг мөрдөнө"[251] гэж заасан байна. Энэ нь хоригдлыг нийгэмшүүлэх ажил нь тухайн зааврын хүрээнд явагдана гэсэн үг ба тухайн зааварт заасны дагуу хоригдлыг суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажлыг хэрэгжүүлнэ гэдэг нь өрөөсгөл, дутмаг ойлголт юм.

Тиймээс хоригдлын нийгэмшүүлэх ажил, тур дундаа суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажлыг илүү боловсронгуй болгох нэн шаардлагатай байгаа нь харагдаж байна.

3. Гэр бүлийн харилцаа хоригдлын нийгэмших үйл явцад хэрхэн нөлөөлдөг талаар:

Гэрлэлт болон үрчлэлтэд суурилсан, хүмүүсийн харилцааг гэр бүл гэнэ. Гэр бүл нь нийгмийн бичил хэлбэр мөн. Гэр бүлийн зохион байгуулалт буюу гэр бүлийн тогтолцоог чулуун зэвсгийн үеэс үүсэлтэй гэж үздэг бөгөөд үүнээс өмнө гэр бүл болох явдал замбараагүй байснаас цус ойртолт элбэг байжээ.[252]

Эдгээрээс үзэхэд гэр бүл хэмээх ойлголт нь хоёроос дээш хүний бүрэлдэхүүнтэй, хоорондын хамааралт харилцаа бүхий нийгмийн бичил бүлгийн шинжийг агуулсан байна.

Монгол улсын Гэр бүлийн тухай хуульд "гэр бүл гэж гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг" ойлгох талаар, "Гэр бүл нь нийгмийн үндсэн нэгж мөн" хэмээн тус тус тунхагласан.[253]

Манай улсад гэр бүлийн систем хамгийн сонгодог утгаар хөгжсөн гэж үзэж болно. Учир юу гэвэл Монгол хүн гэр бүлсэг /гэрсэг/ шинж чанартай төдийгүй хамаатан садан, цусан төрлийн харилцаа холбоо болон нэг хонхор, дов жалганы үзэл /ярианы хэллэг/-ийг эрхэмлэдэг. Мөн өргөжсөн гэр бүлийн шинжийг хамгийн сонгодог утгаар нь хөгжүүлсэн. Өөрөөр хэлбэл нэг гэр бүлд эцэг эх, хүүхдүүд, тэдний ач зээ, эсвэл өвөө эмээ нь нэг дор, нэг ам бүл болж амьдрах тохиолдол түгээмэл байдаг. Тиймээс Монгол хүнийг нийгэмшүүлэх, гэмт санаа бодлоос нь татгалзуулахын тулд "гэр бүл" хэмээх тэрхүү "үнэт зүйл"-д нь тулгуурлан, тэдний дэмжлэг туслалцааг авч хамтран ажиллах нь нэн чухал.

Тэгвэл систем гэж юу вэ? Систем гэдэг нь нэгтгэх, нэг дор байрлуулах, хамтад нь авч үзэх, өөр хоорондоо уялдаа холбоо бүхий нэгж хэсгүүдийн нийлбэр цогц гэсэн утга бүхий "systema" гэсэн грек үгнээс гаралтай. Энэ үгийг тайлбар толь

[251] Хорих ангийн дотоод журам (2018)
[252] www.Wikipedia.org.
[253] Гэр бүлийн тухай хууль (1999)

бичгүүдэд дараах байдлаар тайлбарласан байдаг. “Систем нь өөр хоорондоо харилцан холбоотой буюу харилцан хамааралтай нэгжүүдийн цуглуулга. Харин дэд систем гэдэг нь ямар нэгэн системийн хэсэг болж буй систем юм” хэмээн тодорхойлсон байдаг “Нэгэн цогц байдлаар ажиллах зүйлс буюу хэсгүүдийн бүлэг” хэмээн тодорхойлжээ. Системүүдийг байгалийн болон хүний гараар бүтээгдсэн (загварчлагдсан) хэмээн хуваан үздэг. Хүний гараар бүтээгдсэн системүүд гол төлөв тодорхой зорилго, багц зорилтуудтай байдаг бол байгалийн системүүд тодорхой зорилгогүй хэр нь харьцангуй тогтвортой, уян хатан бөгөөд үр ашигтай байдаг. Байгалийн төрөл бүрийн системүүд байдаг.

Систем гэсэн ойлголтыг хамгийн энгийнээр “Систем нь өөр хоорондоо харилцан холбоотой хэсгүүдийн олонлог” хэмээн тодорхойлсон байдаг. Систем бүр бие биеэсээ хамаарсан, уялдаа холбоотой элементүүдээс (дэд системүүдээс) тогтож, өөрийг нь хүрээлэн буй орчноос өгөгдөл мэдээлэл хүлээн авч, өөрийн төлөв байдлыг илэрхийлдэг. Системийг хүрээлж буй орчныг системийн орчин гэнэ. Аливаа систем нь орчинтойгоо байнга харилцан үйлчлэлцэж байдаг төдийгүй үйлчлэх орчноосоо хамааран байнга хувьсан өөрчлөгдөж байдаг. Систем нь том системийн бүрэлдэхүүн хэсэг байхаас гадна өөртөө дэд хэсгүүд буюу дэд системүүдийг агуулж болно.[254]

Судалгаанаас үзэхэд давтан гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын 70% нь ямар нэгэн байдлаар гэр бүлийн харилцаа холбоо сул, гэр бүлийн гишүүдтэйгээ таарамжгүй харилцаатай эсвэл огт гэр бүлийн харилцаагүй байдаг байна. Тэднийг олон удаа, дахин давтан гэмт хэрэг үйлдэх тусам нь гэр бүлийн гишүүд нь харилцаагаа хөндийрүүлж, таарамжгүй харьцаатай болж, улмаар харилцаагаа таслах хүртэл сөрөг үр дагаварт хүрдэг. Гэр бүлийн дэмжлэг туслалцаагүй хоригдол сэтгэл санааны хувьд тогтворгүй болж энэ байдал нь даамжирсаар дахин давтан гэмт хэрэг үйлдэх, ял эдлэх хугацаандаа зөрчилд холбогдох шалтгаан болно.

Харин эсрэгээрээ гэр бүлтэйгээ харилцаа сайтай, тогтмол уулзалт хийж илгээмж авч утсаар харилцдаг хоригдлуудын хувьд ял эдлэх хугацаандаа аль болох ажил хөдөлмөр, сургалт, нийгэмшүүлэх ажилд идэвхтэй оролцон шагналын хоногоор урамшуулагдаж богино хугацаанд гэр бүлдээ очихыг эрмэлзэнэ. Гэр бүл нь амьдралын боломж тааруухан, санхүүгийн дэмжлэг туслалцаа бага байлаа ч өөрөө цалинтай хөдөлмөр эрхэлж ахуйн хэрэгцээний зүйлсээ худалдан авах санхүүгийн эх үүсвэртэй байж “амиа борлуулах”-ыг л хичээдэг.

Улмаар зарим нь цалингаасаа хохирол төлбөрөө бүрэн барагдуулж, улмаар гэр бүлийн гишүүддээ холбогдох журмын хүрээнд мөнгө шилжүүлж амьдрал ахуйд нь дэмжлэг болох ч тохиолдол элбэг байдаг.

Зарим хоригдлуудын хувьд гэр бүлийн гишүүд нь /эцэг, эх, ах, эгч, дүү, төрөл садан/ хорих ял эдэлж байгаа /хамт эсвэл өөр хорих ангид/ тохиолдол бий. Харин тэдгээр хоригдлуудын гэр бүлийн харилцаа нь зарим тохиолдолд тэдний

[254] Амарбаясгалан, Р. Оношл. -Уб., 2006. 17 дахь тал.

нийгэмшил, төлөвшилд сөргөөр нөлөөлөх хандлага ажиглагддаг. Тэд буруу, сөрөг зүйл дээр санаа нэгдэж, гэр бүлийн итгэлцэл, харилцаа холбоогоо сөргөөр ашиглан нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй төдийгүй заримдаа тийм бодит кейс ч тохиолддог.

Кейс-1.

Хоригдол Л.М нь 3 удаагийн ял шийтгэлтэй бөгөөд хамгийн сүүлд 2009 онд танхайн гэмт хэрэгт шийтгэгдэн ял эдэлж байгаад 2017 онд тус ангиас суллагдсан. Тэрээр багаасаа өнчин өссөн, эцэг, эхээ мэдэхгүй бөгөөд асрамжийн газраар хүмүүжиж ирсэн. Удаа дараа танхайн гэмт хэрэгт шийтгэгдэж байсан тул Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдож Хорих 439 дүгээр "Онцгой" дэглэмтэй хорих ангид ял эдэлж байсан. Түүнийг хариуцсан нийгмийн ажилтан түүний амьдарч байсан асрамжийн төвтэй холбогдож, хамаатан садныг нь судлан, олж харилцаа холбоо тогтоосны үндсэн дээр ойрын хамаатныг нь эргэлт уулзалтаар уулзуулж, "гэр бүл зохиож сайхан амьдрах" тухай ярилцсан байна. Улмаар түүнийг багын найзтай нь уулзуулан, зуучилж гэрлэлтийг нь батлуулан "гэр бүл"-тэй болгосон бөгөөд тэрээр хугацааны өмнө суллагдаж одоогоор тогтсон ажилтай, эхнэр 2 хүүхдийн хамт сайн сайхан амьдарч байгаа билээ.

Дээрх тохиолдлоос үзэхэд хоригдлын ухамсарт "гэр бүл" хэмээх үнэ цэнтэй ойлголтыг төлөвшүүлж, хүний ёсонд гэр бүлийн харилцаа хамгийн чухал болохыг ойлгуулан ухамсарлуулж чадвал тэр л жинхэнэ сайн нийгэмшил болдог нь харагдаж байна. Хүн нэгэнт л гэр бүлийн гишүүн болж нийгмийн харилцаанд оролцож амьдрах жамтай "Нийгмийн амьтан" тул гагцхүү тэр л ёсонд нь тулгуурлан нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулах нь хамгийн үр дүнтэй арга юм.

ДҮГНЭЛТ

Хорих ангид хоригдлыг нийгэмшүүлэх ажлыг нийгэм, сэтгэл зүйн алба тодорхой хууль, журам, зааврын хүрээнд хэрэгжүүлдэг. Харин тухайн эрх зүйн зохицуулалт нь нийгмийн хөгжил, нийгмийн амьдралтай уялдан боловсронгуй илүү нарийн байх шаардлага өнөө үед тулгарч байна. Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар нь хоригдлыг нийгэмшүүлэхдээ ШШГТ хууль болон Хорих ангийн дотоод журам, нийгмийн ажилтны аргачилсан зааврыг мөрдлөг болгон үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг. Дээр дурдгаснаар нийгмийн ажлын аргачилсан зааварт заагдсан заалтуудаар хоригдлын суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулна гэдэг нь өөрөө өрөөсгөл ойлголт болж байна.

Тиймээс эрх зүйн зохицуулалтын хувьд нарийвчлан судалж боловсронгуй болгох шаардлага нэн түрүүнд тулгарч байгаа юм. Боловсронгуй болгоно гэхээрээ огт хамаагүй зүйлүүдийг тусгана гэдэг ч бас өрөөсгөл тиймээс нийгмийн амьдралд хэрхэн бэлтгэхтэй холбогдуулна сайн судалгаа хийх явдал юм.

Өмнө дурдсанаар Ялын хугацаа дуусаж, хорих ялаас хугацаанаас өмнө суллагдах хоригдлыг нийгмийн амьдралд гарахад нь бэлтгэх зорилгоор 3 сарын өмнө сургалтад хамруулах гэж зааж өгсөн байна. Тухайн асуудал дээр ихэнх хорих анги тухайн хоригдлыг суллагдахаас 3 сарын өмнө сургалтад хамруулж чадахгүй

байгаа байдал ажиглагдаж байгаа ба тухайн 3 сарын хугацаанд ямар чиглэлээр, юуны тухай сургалтыг зохион байгуулах нь тодорхойгүй байгаа ба тухайн сургалтын төлөвлөгөө болон орчин зохион байгуулалтын талаар тодорхой тусгаж өгөх нь нэн шаардлагатай болоод байгаа юм. Нийгмийн амьдрал болон цаг үеийн мэдээллийг гарын авлага, тусгайлан бэлтгэгдсэн нэвтрүүлэг бусад хэлбэрээр танилцуулах гэж заасан ба тухайн мэдээ мэдээллийг нийгмийн ажилтан нар цаг тухай бүр нь өгч ажиллаж байгаа ба суллагдах хоригдлыг зарим хорих анги нь 1-3 сарын хугацаатайгаар тусгайлан бэлтгэсэн нийгэмшүүлэх байранд байрлуулан сургалт сурталчилгааг зохион байгуулж байгаа ба тухайн нийгэмшүүлэх байрны талаар хууль эрх зүйн зохицуулалт хараахан гараагүй байгаа нь нийтээр нэвтрүүлэх хүлээн зөвшөөрөхөд хүндрэл тулгарч байгаа юм. Мэргэжлийн болон бусад сургалтад хамрагдсан бичиг баримтыг бүрдүүлэх гэж заасан ба тухайн хоригдлын өмнө авсан мэргэжлийн гэрчилгээг бүртгэх эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр үйлдвэрлэлийн дадлага, практик дадлага хийлгэж ажлын байранд гараад гологдохооргүй чадвартай болгоход нь түлхүү анхаарах. Хоригдлын гэр бүлд чиглэсэн зөвлөгөө өгөх гэж заасан байгаа ба зөвлөгөөг ямар хэлбэрээр явуулах тодорхой төлөвлөгөөний дагуу гэр бүлийн судалгаа хийж уулзах гэх мэт ажлуудыг нарийвчлан хийх нь нэн чухал болоод байна.

Хоригдлыг нийгмийн харилцаанд гарч хувь хүн болж нийгмийн нэг эд эс болоход суллагдах үеийн нийгэмшүүлэх ажил маш чухал гагцхүү тухайн үеэс хоригдол нийгэмд гараад дахин гэмт хэрэг үйлдэж давтан гэмт хэрэгтэн болох уу? эсвэл нийгмийн хог шаар болж гудамжны архичин болох уу? эсвэл засрал хүмүүжлээ олоод амьдралын сайхныг ойлгоод гэр бүлтэй, ажил төрөлтэй сайхан амьдрах уу? гэдэг сонголтыг хийх ухааныг хайрлах хүмүүс бол хорих ангийн алба хаагчид, нийгмийн ажилтнууд юм тиймээс тухайн үед, ямар аргаар нийгэмшүүлэх нь чухал хамгийн гол нь суллагдаад гарч буй хүн нийгмийн хөгжлөөс хоцрохооргүй ур чадвартай болж гарах нь чухал юм.

САНАЛ:

- Нийгэмшүүлэх ажлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.
- Нийгмийн ажлын аргачилсан зааварт заасан суллагдах хугацаа дөхсөн хоригдлын нийгэмшүүлэх ажлын хөтөлбөрийг илүү нарийвчлан боловсронгуй болгох.
- Хоригдлын нийгмийн амьдралд гарахад нь тодорхой мэргэжил эзэмшүүлэх, үйлдвэрлэлийн дадлага зохион байгуулах, ажлын байраар хангах арга хэмжээг системтэйгээр авч хэрэгжүүлэх.
- Хугацаа дөхсөн хоригдлыг нийгэмшүүлэх байранд байршуулах, нийгэмшүүлэх байрны эрх зүйн зохицуулалт, бүтэц, харуул хамгаалалтын аюулгүй байдлыг боловсронгуй болгох.
- Хоригдол суллагдаад гарах үед гэр бүлийн хүлээн авах орчин, тэдний уур амьсгалыг судлах.

- Нийгмийн ажилтан нарын мэдлэг, боловсрол, ур чадварыг нэмэгдүүлэх.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль, эрх зүйн баримт бичиг:

1. Эрүүгийн хууль (2015)
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2017)
3. Гэр бүлийн тухай хууль (1999)
4. Нийгмийн ажлын аргачилсан заавар. (ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/129 дугаар тушаал)
5. Хорих ангийн дотоод журам. (ХЗДХСайдын 2017 оны 07 дугаар сарын 04-ний А/183 дугаар тушаал)

Ном, хэвлэл:

1. Каритас Чех ОУБ. Хорих байгууллага дахь нийгмийн ажил.-Уб., 2015.
2. Амарбаясгалан, Р. Оношилгоо. -Уб., 2006. -200х

Цахим хаяг:

1. Гэр бүлийн тухай ойлголт (2023) www.Wikipedia.org. Татаж үзсэн: 07.02.2024.
2. Гэр бүлийн тухай хууль (1999). www.legalinfo.mn. Татаж үзсэн: 26.02.2024.

УЛСЫН ХИЛИЙН НУТАГ ДЭВСГЭРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ
SECURITY OF NATIONAL BORDER TERRITORIES



Ч.Чулуунхүү
Хилийн албаны сургуулийн Хилийн албаны тэнхимийн дэд профессор, дэд хурандаа

Хураангуй: Улсын хилийн нутаг дэвсгэрийн аюулгүй байдал, учирч болзошгүй аюул занал.

Түлхүүр үг: Хилийн аюулгүй байдал.

Summary: Security and possible threats in the territory of the state border.

Keywords: Border security.

ОРШИЛ

Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна”[255] гэж Үндсэн хуульд зааснаар хөрш зэргэлдээх улсуудтайгаа сайн хөршийн найрсаг харилцаа тогтоож, дэлхийн улсуудтай олон улсын эрх тэгш, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримтлан нээлттэй харилцах гадаад бодлого баримталж байна.

Нийгэм эдийн засгийн хямрал нүүрлэж, байгаль экологийн тэнцвэрт байдал алдагдаж байгаагаас хүн амын амьдрал ахуйд нөлөөлж хөдөө орон нутгийн хүн амын ихэнх нь төврүүгээ нүүдэллэж, олонх нь нийслэлд амьдрах болсноор хилийн дагуу асар уудам газар нутаг эзэнгүйрч байна.

Олон улсын хэмжээнд хилийн аюулгүй байдлыг хилийн орон зай (хил, хилийн зурвас, бүс, хил орчмын нутаг дэвсгэр)-д төр, нийгэм, иргэдийн язгуур ашиг сонирхол баталгаатай хамгаалагдсан байхыг хэлдэг бөгөөд хилийн аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болдог.

Аливаа улсын хил нь нийгэм, улс төрийн ээдрээтэй асуудлын нэг бөгөөд түүнийг хөрш зэргэлдээ орших улсуудын төрийн эрх барих дээд байгууллага хооронд хамтран шийдвэрлэж, хоёр улсын болон олон улсын эрх зүйн баримтаар баталгаажуулдаг онцлогтой.

[255] Монгол Улсын үндсэн хууль 4.1

Манай улс XX зууны сүүлийн хагаст хөрш орнуудтай улсын хилийн асуудлыг бүрэн шийдвэрлэж, баталгаажилтыг нь хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн үндэс бүрдсэн.

Уг эрх зүйн актын хэрэгжилтийг хангах ажиллагааг боловсронгуй болгох, хилийн аюулгүй байдалд анхаарал хандуулах нь хил хамгаалах байгууллага, хилчдийн үүрэг юм.

ҮНДСЭН ХЭСЭГ

Нэг: хилийн аюулгүй байдлын тухай ойлголт, онол арга зүйн үндэс

Нийгэм, хүн төрөлхтөн хөгжих тусам хувь хүн, нийгэм, иргэншлийн аюулгүй байдал анхаарал татан, XX дугаар зууны сүүлчээс энэхүү асуудал дэлхий нийтийн шинжтэй болсон.

Хүн түүний хүрээлэн буй орчны аюулгүй байдлын тухай шинжлэх ухааныг буй болгох хэрэгцээ гарч уг шинжлэх ухааны онолын үзэл баримтлалыг шинжлэх ухааны үүднээс гүнзгий судлах шаардлага тавигдаж байна.

Хилийн аюулгүй байдлыг хангах нь учирч болзошгүй аюул, заналыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, няцаах, устгах талаар хувь хүн, нийгэм, улс орон, дэлхийн хамтын нийгэмлэгийн үйл ажиллагаанд тулгуурлан шинжлэх ухааны олон салбарыг хамарсан асуудал болж буй учир өвөрмөц судлагдахуунтай шинжлэх ухаан гэж үзэж болно.

Аюулгүй байдлыг сахих үйл ажиллагаа нь нийгэмд зэвсэгт хүчин, хилийн цэрэг, дотоодын цэрэг, цагдаа, хамгаалалтын болон онцгой байдлын албаны зэрэг хүчний байгууллагуудыг буй болгон, улмаар дэлхий нийтийн хүн амын аюулгүй байдлыг хангах үүрэгтэй НҮБ-ыг байгуулахад хүргэсэн байна.

“Аюулгүй байдал" гэдэг ерөнхий ойлголтыг янз бүрээр тайлбарлаж болно. Энэ ойлголт тодорхой тохиолдолд субъектийн аюулгүй байдлын өвөрмөц онцлогийг илэрхийлэхийн зэрэгцээ, олон салбарт хэрэглэж болох нийтлэг утга агуулагдаж байдаг. Аюулгүй байдлын талаарх энэхүү ойлголтыг В.Далийн тайлбар тольд: "Аюулгүй байдал гэдэг бол аюулгүй, бүрэн бүтэн байх, найдвартай, итгэлтэй байх"[256] гэсэн бол, Я.Цэвэлийн тайлбар тольд: “аймаар юмгүй, айх болгоомжлох шаардлагагүй”[257] гэж тайлбарлажээ.

Бодит амьдрал дээр янз бүрийн аюул урьд нь байсан, одоо ч байгаа, цаашид ч байсаар байх нь тодорхой юм. Ийм учраас аюулгүй байдлын өнөөгийн агуулгыг “Аюулаас бодитойгоор хамгаалагдсан байдал, түүнийг найдвартай сөрөн зогсох чадвар гэж тодорхойлсон байна.

Тиймээс аюулгүй байдлыг төрөл, хамрах хүрээ, аюулын эх үүсвэр, тэдгээрийн шинж байдал, бүрдэл зэргийг үндэслэн ангилах нь илүү үр дүнтэй юм.улс орны эдийн засаг, гадаад, дотоод улс төрийн бодлого, зэвсэгт хүчин,

[256] В.Далийн тайлбар толь 2.44
[257] Я.Цэвэлийн тайлбар толь 3.60

хилийн болон бусад салбаруудад учирч болзошгүй аюулыг уг үзүүлэлтээр нь ангилж болно.

Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлж, үйл ажиллагааных нь чиглэлийг тодорхойлоход аюулын иймэрхүү ангилал ихээхэн үр дүнтэй гэж үзэж байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын бүтэц дэх аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсгүүд, тэр дундаа хилийн аюулгүй байдлыг хэрхэн ойлгож байгааг судалсан судалгаа, зарим судлаачид хилийн аюулгүй байдлыг цэргийн аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэгт авч үздэг. Тэгвэл зарим нь эсрэгээр хилийн аюулгүй байдал бол үндэсний аюулгүй байдлын үндсэн бүрэлдэхүүн хэсэг буюу бие даасан төрөл гэж баталж байгаа.

Үндэсний аюулгүй байдлын бүтцэд хилийн аюулгүй байдлыг ялган зааглах үндэслэл нь үндэсний ашиг сонирхол, түүнд учрах аюул заналыг төвлөрүүлсэн нийгмийн харилцааны тодорхой орчин хамаарч байгаа болохоор хилийн аюулгүй байдлыг үндэсний аюулгүй байдлын “бие даасан төрөл” гэж онцлох нь зүйтэй.

“Улсын хилийн халдашгүй дархан байдал нь хилийн шугам хууль бусаар өөрчлөгдөөгүй, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр зөрчигдөхгүй байх явдлаар хангагдана.”[258],

Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогод: “Хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, язгуур ашиг сонирхол, тухайн нутаг дэвсгэрт хангагдсан байдлаар тодорхойлогдоно” [259] гэж заажээ.

“Хилийн аюулгүй байдал нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн эрх бүхий байгууллагуудаас нэгдмэл бодлого, харилцан уялдаатай явуулах улс төр, эрх зүй, дипломат, эдийн засаг, байгаль орчин, тагнуул, улсын хил хамгаалалтын цогц үйл ажиллагаагаар хангагдана.”[260] гэж Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад хуульчилсан байна.

Өөрөөр хэлбэл хилийн аюулгүй байдлыг хангах гэдэг нь хилийн аюулгүй байдлыг хангах орчны харилцааг зохицуулах үзэл баримтлалын үндэслэлүүд, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актууд, хуулийн дагуу хилийн аюулгүй байдлыг хангахад оролцож байгаа харилцан хамаарал бүхий төрийн захиргааны болон олон нийтийн байгууллага, иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгод нийцсэн үйл ажиллагааны нэгдэл, үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг юм.

Хилийн аюулгүй байдал гэдэг нь “Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэр (хилийн орон зай)-д үндэсний аюулгүй байдал найдвартай хангагдах явдал” гэж

[258] Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого Нэг.нийтлэг үндэслэл 7.
[259] Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого Нэг.нийтлэг үндэслэл 8.
[260] Монгол Улсын хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 4 дүгээр зүйл 5.3

зарим эрдэмтэд үздэг. Үүнийг судлаач хүний хувьд зөв тодорхойлолт гэж ойлгодог.

Хил хамгаалах байгууллага, хилчдийн үндсэн үүрэг нь улсын хилийн баталгаажилт, хамгаалалтын найдвартай байдлыг хангаж, улсын хилийг зөрчилгүй байлгах, гарсан зөрчлийг таслан зогсоох, үндэсний аюулгүй байдлыг ямар ч нөхцөлд хангах явдал юм.

Хоёр: хилийн аюулгүй байдалд учирч болзошгүй аюул занал

Даяаршиж буй өнөөгийн нөхцөлд дэлхий нийтийн хөгжлийн хандлага, хөрш орнуудын нийгэм, улс төрийн байдал, манай орны гадаад, дотоод бодлого нь улсын хилийн аюулгүй байдал, хил хамгаалалтад шинжлэх ухааны үүднээс хандахыг анхааруулж байна.

Орчин үед дэлхийд гарч буй томоохон өөрчлөлтүүд, хил дамнасан гэмт хэрэг, нийгэм эдийн засгийн хямрал, янз бүрийн өвчлөл зэргээс үүдэн гарч буй сөрөг үзэгдлүүд нь улсын хил, түүний орчинд илэрч хилийн аюулгүй байдал цаашилбал Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд бодитоор нөлөөлөх болсон.

Хилийн аюулгүй байдалд дараах хүчин зүйлүүд нөлөөлж байна. Үүнд:

а. Хил зөрчигчид (хууль бус цагаачид, хил дамнан хулгай, наймаа хийгчид, гэмт хэрэгтнүүд);

б. Хориотой бараа (хар тамхи, зэвсэг сум галт хэрэгсэл, мансууруулах бодис, чанаргүй хүнсний бүтээгдэхүүн);

в. Эрүүл ахуйн халдвар (халдварт өвчин тээгч зорчигчид, муудсан, хордсон хүнсний бүтээгдэхүүн, өвчилсөн гэрийн тэжээвэр амьтад, ан амьтад);

г. Зэвсэгт халдлага (алан хядагчид, зэвсэгт босогчид, зэвсэглэсэн хулгайч дээрэмчид, цэргийн хүчин зэрэг болно).

Улсын хил зөрчих, хүний болон зэвсгийн наймаа, алан хядах ажиллагаа, мансууруулах бодисын худалдаа, зохион байгуулалттай гэмт хэрэг хүрээгээ тэлж байгаа нь түүнтэй тэмцэх хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг шинэлэг арга хэлбэрээр өөрчлөн сайжруулахыг шаардаж байна.

Хилийн аюулгүй байдлыг хангах гол зорилго нь хилийн орчинд Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг гадаад, дотоодын аюул заналаас хамгаалах, төр, нийгэм, иргэний аюулгүй байдлыг хангахдаа юуны өмнө хилийн талаар байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр, эрх зүйн хэм хэмжээг сахих, зэргэлдээ улстай хамтын ажиллагааг хөгжүүлэх бүх талын бололцоо олгоход оршино.

Улс үндэстний аюулгүй байдал алдагдах явдал юун түрүүнд улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрээс эхлэх магадлал өндөр байдаг болохоор хилийн аюулгүй байдлыг хангах асуудлыг тэргүүн ээлжид шийдвэрлэх нь маш чухал юм.

Орчин үед Монгол Улсын хилийн аюулгүй байдалд учруулж болзошгүй ноцтой аюул заналууд:

-Хөрш зэргэлдээ улсуудын хилийн орчинд цэргийн бүлэглэлүүдийн хүн, хүчний тоо нэмэгдэх;

-Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт гадаадын тусгай албадын тагнуул хорлон сүйтгэх үйл ажиллагааны хүрээ өргөжих;

-Хөрш зэргэлдээ улсуудын хилийн орчинд улс төр, үндэстэн хоорондын, шашны болон бусад сөргөлдөөн үүсэх;

-Хөрш зэргэлдээ улсуудтай найрамдалт харилцаа холбоо сулрах, хилийн болон бусад асуудлаар үл ойлголцох асуудал үүсэх;

-Гэмт хэргийн бүлэглэлийн хууль бус наймаа болон хууль бус үйлдэл, ялангуяа хар тамхины наймаа идэвхжих гэх мэт олон аюул занал бий болж болзошгүй байна.

Хилийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн хоёр үндсэн зорилтуудыг шийдвэрлэх шаардлагатай ба энэ нь нэгдүгээрт; хилийн аюулгүй байдалд учирч болзошгүй аюул, занал буй болохоос урьдчилан сэргийлэх, хоёрдугаарт; тэдэнд тохирсон сөрөг арга хэмжээг авч хэрэгжүүлэх явдал юм.

Энэхүү зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд:

-Улс орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн аюулгүй байдлыг хангах бүх нөхцөлийг бүрдүүлэх;

-Улсын хилийн талаарх олон улсын эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох;

-Улсын хил дээр болон хил орчмын нутаг дэвсгэрт цэргийн аюул, зэвсэгт болон зэвсэггүй мөргөлдөөн гарахаас урьдчилан сэргийлэх талаар улс хоорондын хэлэлцээр байгуулах;

-Өөрийн орны нутаг дэвсгэрт бусад улс орны зүгээс хүчээр шилжин суурьших, эдийн засгийн түрэмгийллийн эсрэг чиглэсэн арга хэмжээ авах;

-Улсын үндэсний эрх ашгийн үүднээс хилийн орон зайд цэрэг улс төрийн бүлэглэл болон бусад улсын зүгээс тусгаарлагдмал байдалд орох аюулыг арилгах;

-Ямар ч хэлбэрийн гэмт хэргийн үйлдлийг (санаатайгаар улсын хил зөрчих, хууль бусаар буу зэвсэг, мансууруулах бодис, эд зүйлс нэвтрүүлэх, хил дамнасан гэмт бүлэг орж ирэх г.м) таслан зогсоох чадвартай байхын тулд улсын хил хамгаалалтыг бэхжүүлэх;

-Улсын тусгаар тогтнол, түүний материалын болон оюуны баялгийн эсрэг гарч болзошгүй ямарваа үйлдлийг таслан зогсоох;

-Улсын хилийн хамгаалалт эрхэлсэн байгууллагуудыг бэхжүүлэх, хил, хязгаар нутгийн хамгаалалтыг сайжруулах;

-Улсын хил хамгаалах үүрэг бүхий субъектүүдийн нэгдмэл ажиллагааг хангах;

-Хамгаалалт эрхлэх бүх субъектийн алба, байлдааны болон бусад боломжийг дээшлүүлэх, бэлэн байдлыг өндөржүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

ДҮГНЭЛТ:

Монгол Улсын үндэсний аюулгүй байдал /хилийн аюулгүй байдал/-ыг хангах талаар хил хамгаалах байгууллагаас хэрэгжүүлж буй хил хамгаалалтын онцлог, хэтийн төлөв, чиг хандлагатай уялдуулан “шинжлэх ухааны”-аар дээрх асуудлыг гүнзгийрүүлэн судалж, мөн чанарыг тодорхойлох нь нэн шаардлагатай асуудлын нэг болж байна.

Хилийн аюулгүй байдлын талаарх эрх зүйн орчин боловсронгуй болсноор улсын хилийн баталгаажилт бүрэн хангагдан, хил орчмын нутаг дэвсгэрт улсын гадаад, дотоод бодлого зөв хэрэгжиж, улсын хил түүнтэй холбоотой асуудал шийдвэрлэгдэх боломж бүрдэж, зэргэлдээ улсын холбогдох байгууллагуудтай тогтоосон харилцаа хамтын ажиллагаа бэхжин, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн төрийн захиргааны төв болон харилцан ажиллагаатай байгууллагуудын үүрэг уялдаатай нэмэгдэх юм.

Улсын хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь бүхэлдээ үндэсний аюулгүй байдлыг улсын хил болон хил орчмын нутаг дэвсгэрт хангах ажиллагаа байх тул улс орныг батлан хамгаалах арга хэмжээний нэг хэсэг болж байна.

Хилийн аюулгүй байдлыг хангах гол зорилго нь хилийн орчинд Монгол улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалах гадаад, дотоодын аюул, заналаас төр, нийгэм, иргэний аюулгүй байдлыг хангах, хилийн талаар байгуулсан улсын болон олон улсын гэрээ хэлэлцээр, эрх зүйн хэм хэмжээг сахих, зэргэлдээ улстай хамтын ажиллагааг хөгжүүлэх, учирч болзошгүй аюул заналаас урьдчилан сэргийлэх, арилгах тогтолцоо бүрдүүлэхэд оршиж байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Үндсэн хууль УБ., 1992 он
2. Монгол Улсын Хилийн тухай хууль УБ., 2016 он
3. Төрөөс хилийн тухай баримтлах бодлого
4. Монгол улсын Аюулгүй байдлын үзэл баримтлал /Монгол улсын Их хурлын 1994 оны 56-р тогтоол/
5. Монгол улсын хууль Үндэсний аюулгүй байдлын тухай УБ., 2001 он
6. Д.Дашдаваа. Хилийн аюулгүй байдлын тогтолцоо бүрдүүлэх асуудалд. Хил судлал сэтгүүл. 2009.№3.4 х.12
7. “Хил судлал” сэтгүүл
8. Орон нутгийн хил хамгаалалт
9. Улсын хил хамгаалалтад тулгамдаж буй зарим асуудлууд эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл 2013 он
10. Хилийн аюулгүй байдлын онол ба практикт тулгамдсан асуудлууд-2017 сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл.
11. Улсын хил хамгаалалтад тулгамдаж буй асуудал сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл 2022 он
12. Улсын хил хамгаалалтад тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл 2023 он

ШИНЖЛЭН МАГАДЛАХ УХААН

ӨСВӨР НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН АМИА ХОРЛОХ ЭРСДЭЛ ТҮҮНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС

FACTORS AFFECTING TEENAGERS' SUICIDE RISK



Ц.Нандинцэцэг
Дотоод хэргийн их сургуулийн
Шинжлэн магадлахуйн институтийн
Байгалийн ухаан, техник зүйн шинжилгээний
тэнхимийн багш, цагдаагийн ахмад

Товч хураангуй. Энэхүү судалгааг Улаанбаатар хотын хэмжээнд 13-18 насны 200 сурагчдын дунд явуулсан. Амиа хорлох оролдлогын хамаарлыг үнэлэхийн тулд нэг хувьсагч ба олон хувьсагчтай дүн шинжилгээ мөн хамаарлын шинжилгээ хийсэн. Судалгаанд хамрагдсан нийт өсвөр насныхны 32.1% нь амиа хорлохыг завдсан бөгөөд үүний 72.6 хувь нь эмэгтэйчүүд байсан байна. Гурван сурагч тутмын нэг нь амиа хорлох оролдлого хийж байжээ. Амиа хорлох оролдлогын нийт түүвэрт олон хувьсагчтай дүн шинжилгээ хийхдээ ойр дотны найз нөхөдгүй байх, сэтгэлийн түгшүүр, гэмтэл бэртэл, хүчирхийлэл, тамхи татах, архи уух, бэлгийн харьцаанд орох зэрэгт ихээхэн хамааралтай болохыг харуулсан. Амиа хорлохыг завдсан эрэгтэйчүүд ойр дотны найз нөхөдтэй байх магадлал багатай бөгөөд гэмтэж бэртэх, бие махбодын халдлагад өртөх, дээрэлхэх, тамхи татах, архи уух, бэлгийн харьцаанд орох магадлал өндөр байжээ. Сэтгэцийн хямрал, хүчирхийлэл, эрсдэлтэй зан үйл зэрэг хэд хэдэн хүчин зүйл амиа хорлох оролдлоготой холбоотой болохыг тогтоожээ. Эдгээр нь өсвөр насныхны дунд амиа хорлох зан үйлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохиох шаардлагатай байгааг харуулж байна.

Түлхүүр үг: Өсвөр нас, Сэтгэлийн түгшүүр, Архи тамхины хэрэглээ

ӨГҮҮЛЛЭГИЙН ОРШИЛ

Амиа хорлолт гэдэг нь хэн нэгэн санаатайгаар өөрийн амийг таслах төрх үйл юм. Амиа егүүтгэх болон амиа егүүтгэхээр оролдох нь манай улсын хувьд төдийгүй дэлхийн олон оронд нийгэм эдийн засгийн болон сэтгэц-нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг болоод байгаа билээ. Амиа егүүтгэх Амиа егүүтгэж нас барах, амиа егүүтгэх оролдлого хийх тохиолдол нь анагаах ухаан, философи, нийгэм судлал, нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг

билээ.[261] Хэвлэл мэдээллээс үзвэл хүн амын дундах дээрх үйлдлүүд нь өсөн нэмэгдэх хандлагатай байна. Тэр дундаа өсвөр насны хүүхдүүдийн дунд амиа хорлох эрсдэл нь нэмэгдсээр байгааг олон судалгаанаас харж болох юм. Эмэгтэйчүүдийн дэд бүлгийн хувьд сэтгэлийн түгшүүр, гэмтэл, хүчирхийлэл, тамхи татах, архи уух зэрэг нь амиа хорлох оролдлогыг мэдээлэх магадлалыг ихээхэн нэмэгдүүлдэг.

ҮНДСЭН ХЭСЭГ

Амиа хорлох нь үндсэн хэд хэдэн шалтгаантай байдаг хэдий ч хүмүүсийн дунд нийтлэг тохиолддог шалтгаануудыг дурдлаа. Дахин хэн нэгэн хүн хайртай нэгнээ амиа хорлолтоос болж алдахгүй байхын төлөө яагаад амиа хорлолт бий болдог талаар мөн урьдчилан сэргийлэхийн тулд шинж тэмдгүүдийг дурдан оруулсан байв. [262]

Амиа хорлолтын үндсэн шалтгаан:

1. Depression - Сэтгэл гутрал
2. Psychosis - Сэтгэцийн өөрчлөлт
3. Drug addiction – Донтолд /архи, мансууруулах бодисоор дамжин тархи болон зан үйлд нөлөөллөсөн байдал/
4. Bipolar disorder - Хоёр туйлт эмгэг / Тархи хэт ихээр идэвхжин хөөрлийн байдалд орох эсвэл нөгөө талаараа идэвхи эрс муудаж сэтгэл гутралын байдалд орох. Manic-depressive illness/
5. PTSD - Сэтгэл зүйн гэмтэл, цочролын түүх /осол аваар, гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, үхэл хагацал, дайн, байгалийн гамшиг, авто осол гэх мэт/

Амиа хорлох нийтлэг шалтгаан:

- Удаан хугацаанд үргэлжилсэн бие махбодын болон сэтгэл зүйн хүчирхийлэл
- Удаан хугацаанд үргэлжилсэн ичгүүр, цахим орчин болон нийгмээс ирж буй дарамт
- Нэн чухал ач холбогдолтой хүнээ алдах эсвэл салах

Санхүүгийн асуудал

- Ноцтой хүнд өвчин, архаг өвчнөөс залхах, бууж өгөх
- Хуулийн асуудал /гэмт хэргийн буруутан болох/
- Ялгаварлан гадуурхагдах /шашин шүтлэг, арьс өнгө, бэлгийн чиг хандлага, нийгмийн гарал гэх мэт/

[261] https://mn.wikipedia.org/wiki/%D0%90%D0%BC%D0%B8%D0%B0_%D0%B5%D0%B3%D2%AF%D2%AF%D1%82%D0%B3%D1%8D%D1%85

[262] https://www.caak.mn/post/view/222753

Амиа хорлох талаар бодож буй хүнээс илрэх магадлал бүхий зан үйл:

- Зан араншин огцом хурдан өөрчлөгддөг болох
- Үхлийн талаар их ярьдаг болох эсвэл үхэхийг хүсэж буйгаа хэлэх
- Ганцаардсан, орхигдсон, үл хүндлэгдсэн, хэн ч түүнд тусалж чадахгүй талаар ярих
- Болчимгүй үйлдэл ихсэх
- Зөрчил маргааны дараа онцгой дуугүй, нам гүм болох
- Их хэмжээний эм хадгалах
- Энгийнээс их эсвэл бага унтах
- Захиж үлдээж буй мэт ярих
- Онцгой их түгшүүр, сандралтай болох

1. СУДАЛГААНЫ НАЙДВАРТАЙ ИТГЭМЖТЭЙ БАЙДАЛ.

Найдвартай байдлын шинжилгээ

Reliability Statistics	
Кронба альфа	Нийт
.822	26

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Судалгааны итгэлтэй байдлыг найдвартай байдлын шинжилгээ хийн шалгахад түүний үндсэн утга болох кронба альфа утга нь 0.822 байгаа нь 0.9>a≥0.8 буюу **“сайн”** хэмээн үнэлэгдлээ. Тиймээс энэхүү судалгаа нь итгэж болохуйц судалгаа юм.

Хүчин зүйлийн шинжилгээ

KMO and Bartlett's Test		
К.М.О үндсэнутга		.752
Bartlett's Test of Sphericity	Chi square	353.908
	Df	102
	Sig	.000

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Хүчин зүйлийн шинжилгээний КМО хүснэгтээс үзэхэд түүний үндсэн утга 0.752 байгаа нь түүврийн хувьд 105 хүн байгаа нь итгэмжтэй бөгөөд хангалттай

хүрэлцэхүйц байгааг илтгэж байгаа юм. /Sig 0.000/ байгаа нь статистик ач холбогдолтой бөгөөд статистикийн хувьд алдаа багатай байна хэмээн үнэллээ.

Судалгааны бүтэц





Судалгаанд хамрагдсан нийт 200 сурагчдаас эрэгтэй 100, эмэгтэй 100 сурагч тус тус хамрагдсан. Энэ үзүүлэлт нь судалгаанд хүйсийн хувьд тэнцүү болохыг харуулж байна.Нийт өсвөр насны 200 сурагч хамрагдсанаас 11-13 насны 54 сурагч буюу 28%, 14-15 насны 57 сурагч буюу 30%, 16-17 насны 51 сурагч 26%, 18 насны 46 сурагч буюу 16% тус тус хамрагдсан.

Корреляци шинжилгээ

Correlations

	Найз нөхөдгүй байх	Сэтгэлийн түгшүүр	Архи тамхи хэрэглэж байсан уу	Бэлгийн харьцаанд орж байсан эсэх	Бага насанд бэртэл гэмтэл авч байсан эсэх
Найз нөхөдгүй байх	1	.703**	-0,004	.389**	0,037
		0	0,953	0	0,582
Сэтгэлийн түгшүүр		1	-0,011	0.0234	0,114
			0,87	0.533	0,092
Архи тамхи хэрэглэж байсан эсэх			1	.369**	0,079
				0	0,243
Бэлгийн харьцаанд орж байсан эсэх				1	0,004
					0,957
Бага насанд бэртэл гэмтэл авч байсан эсэх					1

****. Correlation is significant at the 0.01 level (2-tailed).**

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Корреляци шинжилгээнээс үзэхэд найз нөхөдгүй байх, сэтгэлийн түгшүүр, бэлгийн харьцаанд орж байсан эсэх, архи тамхи хэрэглэж байсан эсэх зэрэг нь эерэг бөгөөд хүчтэй хамааралтай байна.

Дискриптив статистик			**Дунджийн ялгаа**		
	N	Mean	SD	F утга	P утга
Хийж буй зүйлдээ сэтгэл хангалуун бус эсвэл идэвх сонирхол буурдаг уу	200	2,93	0,586	0,288	0,021
Мэдрэмж бууран сэтгэл санаагаар унах тохиолдол байдаг уу	200	3,13	0,565	0,485	0,487
Орой унтахад төвөгтэй санагддаг уу	200	3,21	0,596	1,135	0,288
Хоолны дуршил буурах эсвэл хэт идэх үе байдаг уу	200	3,25	0,601	1,05	0,307
Ядрах эсвэл эрч хүчээ алдсан мэт сэтгэгдэл төрдөг үү	200	3,26	0,604	1,888	0,171
Өөрийгөө муугаар бодож бүтэлгүй мэт санагдаж, өөртөө болон гэр бүлдээ сэтгэл гонсойдог уу	200	3,29	0,577	2,316	0,129
Өөрийгөө гэмтээх эсвэл ингэж амьдрахаас үхсэн нь дээр хэмээн бодол орж ирж байсан уу	200	3,28	0,589	0,252	0,005
Бусад хүмүүс таныг удаан хөдөлж, удаан ярьж байна гэж хэлэх эсвэл ердийнхөөс илүү тайван бус байна гэж хэлж байсан уу	200	3,2	0,565	0,535	0
Valid N (listwise)	**3.21**			**P>0.05**	

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Тойм статистик шинжилгээнээс дундаж оноо хамгийн өндөртэй байгаа нь ядрах эсвэл эрч хүчээ алдсан мэт сэтгэгдэл төрдөг үү? Өөрийгөө муугаар бодож бүтэлгүй мэт санагдаж, өөртөө болон гэр бүлдээ сэтгэл гонсойдог уу хэмээх нь 3.26-с дээш байгаа нь хамгийн өндөр хувьтай байлаа. Үүнээс үзэхэд өсвөр үеийнхний дотор амиа хорлох эрсдэл байдаг хэмээн харагдаж байна.

Та хэдэн удаа амиа хорлох оролдлого хийж байсан бэ хэмээх асуултаар ярилцлага хийж үзэхэд дараах байдалтай хариулжээ.

Кейс 1

“Б” нь өөр сургуулиас шилжиж ирсэн бөгөөд гэрийнхэнтэйгээ байнга зөрчилддөг. Гэр бүлийнхэн нь түүний бодлыг сонсолгүй мэргэжлээр сургасан учир дургүй хичээлдээ явдаг байв. Эцэст энэ залууд Амьдрал утга учиргүй санагдаж амиа хорлох тухай бодож эхлэх. Тэрээр 3 удаа амиа хорлосон бөгөөд бүх оролдлого нь бүтэлгүйтэж байсан. Тэрээр одоог хүртэл түүнд бүх зүйл утгагүй санагддаг

Энэхүү кейсээс үзэхэд гурван удаа амиа хорлох оролдлого хийсэн байгаа нь харагдаж байна. Гэр бүл нь аливаа асуудлыг нээлттэй тодорхой илэрхийлж ойлголцдог, гэр бүлийнхээ өмнө хүлээх хариуцлагаа хамтдаа үүрэлцдэг, бие биеэ хайрлан, дэмждэг, хүлээн зөвшөөрч, урамшуулдаг гишүүдээс эрүүл гэр бүл бүрдэнэ. Үүнээс үзэхэд оюутнуудын шаналах сэтгэл өндөр байгаа нь тэдний гэр бүлийн орчин болон хүмүүжилтэй давхар холбоотой болохыг харуулж байна.

ДҮГНЭЛТ

Судалгаанд хамрагдсан нийт өсвөр насныхны 32.1% нь амиа хорлохыг завдсан бөгөөд үүний 72.6 хувь нь эмэгтэйчүүд байсан байна. Гурван сурагч тутмын нэг нь амиа хорлох оролдлого хийж байжээ. Амиа хорлох оролдлогын нийт түүвэрт олон хувьсагчтай дүн шинжилгээ хийхдээ ойр дотны найз нөхөдгүй байх, сэтгэлийн түгшүүр, гэмтэл бэртэл, хүчирхийлэл, тамхи татах, архи уух, бэлгийн харьцаанд орох зэрэгт ихээхэн хамааралтай болохыг харуулсан. Амиа хорлохыг завдсан эрэгтэйчүүд ойр дотны найз нөхөдтэй байх магадлал багатай бөгөөд гэмтэж бэртэх, бие махбодын халдлагад өртөх, дээрэлхэх, тамхи татах, архи уух, бэлгийн харьцаанд орох магадлал өндөр байжээ. Сэтгэцийн хямрал, хүчирхийлэл, эрсдэлтэй зан үйл зэрэг хэд хэдэн хүчин зүйл амиа хорлох оролдлоготой холбоотой болохыг тогтоожээ. Эдгээр нь өсвөр насныхны дунд амиа хорлох зан үйлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохиох шаардлагатай байгааг харуулж байна.

КОМАНД ШТАБЫН СУРГУУЛИЙН ОНОЛ, АРГА ЗҮЙ

COMMAND HEADQUARTERS SCHOOL THEORY AND METHODOLOGY



Я.Ариунболд
Дотоод хэргийн их сургуулийн
Удирдлагын академийн
Хилийн албаны удирдлага, стратегийн профессорын
багийн профессор, хурандаа

Товч агуулга: Команд штабын сургууль /КШС/-ийн онолын үндэс, КШС-ийн тодорхойлолт, онол, арга зүйн ялгааг эх сурвалжуудаас судлан судлаачийн зүгээс санал дэвшүүлсэн.

Abstract: The theoretical basis of the Command and Staff School /CSS/, definitions of CSS, theory, and methodological differences from the sources were proposed by the researcher.

Түлхүүр үгс: Команд штабын сургууль /КШС/, цэргийн сургалт, удирдах бүрэлдэхүүний сургалт

Key words: Command and Staff School, military training, management training

ОРШИЛ

Монгол Улсын төрийн цэргийн байгууллын удирдлага нь улс төрийн дээд, төрийн захиргааны, цэргийн мэргэжлийн дээд удирдлагаас бүрдэнэ хэмээн батлан хамгаалах тухай хуульд тодорхойлсон бөгөөд цэргийн мэргэжлийн удирдлагын байгууллага болох штабын сургалт бэлтгэлийн дээд хэлбэр болсон Команд штабын сургуулийн онол, арга зүйн талаар онолын судалгаа хийж өөрийн санал дүгнэлтийг дэвшүүллээ.

НЭГ: КОМАНД ШТАБЫН СУРГУУЛИЙН ОНОЛ

Команд штабын сургууль (КШС)-ийг зэвсэгт хүчин, хилийн цэрэг, цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэг бүхий байгууллагууд зохион байгуулан явуулдаг хэдий ч тодорхойлолтын хувьд нэгдсэн ойлголтод хүрч томьёологдоогүй өөрсдийн нэр томьёоны тайлбар толь, тушаал журам, зааварт тусгасан байдаг. Тухайлбал: 2003

оны “Монгол Улсын хилчний тайлбар толь”[263], 2010 оны “Хилийн нэр томьёоны тайлбар толь”[264], 2014 оны “Цэргийн нэр томьёоны тайлбар толь”[265], 2017 оны “Хилийн албанд ашиглагдах зарим нэр томьёоны тайлбар толь”[266], Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны 12 сарын 20-ны өдрийн А/323 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, дадлага зохион байгуулах заавар”[267], Дотоод хэргийн их сургуулийн захирлын 2022 оны 11 сарын 30-ны А/658 дугаар тушаалаар батлагдсан “Багшийн багц цагаар үнэлэх журам”[268] -уудад тус тус тодорхойлсон байдаг.

КШС-ийн онолын үндэс нь цэргийн сургалтад тулгуурлагдана. Цэргийн сургалт нь алба хаагч нэг бүрийг гүйцэтгэх үүрэгт нь сургах[269] тогтолцоот шинж чанартай зорилго, агуулга, арга, хэлбэр, технологитой төлөвлөгөөт үйл ажиллагаа[270]. Цэргийн сургалтын тогтолцоо нь албан ба албан бус сургалтын нэгдэл байх ба мэргэжил эзэмшүүлэх, мэргэшүүлэх, жигдрэлтийг хангах, хөгжүүлэх гэсэн төрлүүдтэй, бүтцээр нь хүн нэг бүрийн бэлтгэл, анги салбарын бэлтгэл, штабын бэлтгэл, үечлэлээр нь нэгдүгээр үеийн буюу өвлийн, хоёрдугаар үеийн буюу зуны, хамрах хүрээгээр нь офицер, ахлагч, гэрээт болон хугацаат цэргийн албан хаагч, энгийн ажилчдын, зориулалтаар нь албаны бэлтгэл, тусгай үүргийн бэлтгэл[271] гэж ангилагдана.

Цэргийн сургалт нь боловсрол олгох сургалтаас цэргийн мэргэжил эзэмшүүлэх, мэргэшүүлэх, ур чадвар олгох, дадлагажуулах, жигдрэлтийг хангах зорилгоор тактикийн бэлтгэл сургалтын төвшнийг илэрхийлдэг тоон болон чанарын үзүүлэлт, нормативыг өөртөө багтаасан 25 хувь нь онолын 75 хувь нь практик үйл ажиллагаа байдаг онцлогтой[272].

Цэргийн сургалтын хэлбэрүүдийг цэргийн сургалтын бүтцэд хүн нэг бүрийн бэлтгэл, салбарын бэлтгэл, штабын бэлтгэл гэж төрөлжүүлэн, хүн нэг

---

[263] Сүндэв, П. (2003). “Команд штабын сургууль”-ийн тайлбар. Монгол Улсын хилчний тайлбар толь, (198), Улаанбаатар хот

[264] Ганболд,М. (2010) . “Команд штабын сургууль”-ийн тайлбар. Хилийн нэр томъёоны тайлбар толь, (122), Улаанбаатар хот

[265] Паламдорж,Ш., Дашзэвэг,Ц. (2014) . “Команд штабын сургууль”-ийн тайлбар. Цэргийн нэр томьёоны тайлбар толь, (180), Улаанбаатар хот

[266] Жавхланцогт, В., Муратхан, А., (2017) . “Команд штабын сургууль”-ийн тайлбар. Хилийн албанд ашиглагдах зарим нэр томьёоны тайлбар толь, (75), Улаанбаатар хот

[267]. Гамшигаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, дадлага зохион байгуулах заавар, 2017, А/323 дугаар тушаал

[268] Багшийн багц цагаар үнэлэх журам, 2022, А/658 дугаар тушаал

[269].Сүхбат,Р. (2016), Цэргийн сургалтын тогтолцоо. Зэвсэгт хүчний сургалтын тоголцоонд хийсэн шинжилгээ.УБ. БХИС. Эрдэм шинжилгээний хуралын эмхтгэл, х 13

[270] Мягмаржав,Г. Цэргийн сурган хүмүүжүүлэх ухааны үндэс (1998). УБ. (х.27).

[271] Бадамбазар, Ж., Соронзонболд, Т. (2016), Офицерын бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн тогтолцоо түүнийг боловсронгуй болгох нь. Зэвсэгт хүчний сургалтын тогтолцоонд хийсэн шинжилгээ. Улаанбаатар. БХИС. Эрдэм шинжилгээний хуралын эмхтгэл, х 33

[272] ХХБ, “Сургалт бэлтгэл - 2012” хөтөлбөр (2009), УБ.

бүрийн бэлтгэлд: Лекц, семинар, бие даалт, бүлгийн дасгал, шуурхай дадлага, салбарын бэлтгэлд: Тактик жагсаалын хичээл, тактикийн хичээл, сурган зааварлах хичээл, тактикийн хээрийн сургууль, байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургууль, штабын бэлтгэлд: Штабын хэсэгчилсэн дадлага, штабын нэгдсэн дадлага, КШС, цэргийн тоглоом гэсэн хэлбэрүүд хамаарна[273] хэмээн тодорхой эх сурвалжууд, тусгасан байна.

КШС-ийн зорилго нь суралцагч штабуудын үүрэг гүйцэтгэх бэлтгэлийн түвшнийг "сайжруулах", "нэмэгдүүлэх", "төгөлдөржүүлэх", "жигдрүүлэх", "дадлагажуулах", "өндөржүүлэх", "эзэмшүүлэх", "шалгах", "судлах" гэсэн санааг тусгасан, сургуульд оролцож байгаа анги, салбар тус бүрд тохирсон байх ба зориулалтаар нь төлөвлөгөөт, шалгалтын, үзүүлэх, туршилт шинжилгээний гэж ангилж, оролцож байгаа штабын бүрэлдэхүүнээс хамаарч нэг болон хоёр шатны[274], сургуулийн сэдэв, боловсруулах асуудлаас хамааран сургуулийн түвшин, үе шатууд болон нэг болон хоёр талын сургууль[275] болох нь тодорхойлогдоно [276].

ХОЁР: КОМАНД ШТАБЫН СУРГУУЛИЙГ ЯВУУЛАХ АРГА ЗҮЙ

КШС нь сургагч буюу удирдлагын бүлэг, суралцагч буюу сургуульд оролцож буй суралцагч штабын үйл ажиллагааны нэгдэл байх бөгөөд сургуулийг зохион байгуулах арга зүй нь сургуулийн бэлтгэл хангах, сургуулийг удирдан явуулах, дүн гаргах ажиллагаа байна.

КШС-ийн бэлтгэл хангах, удирдан явуулах, дүн гаргах ажлыг хариуцах удирдлагын бүлэг томилогдож[277], сургуулийг байнгийн байрлал болон газар орон дээр байр зүйн зураг, план зураг, бүдүүвч төвлөгөөг ашиглан зохион байгуулна[278].

Удирдлагын бүлэгт сургуулийн удирдагч, орлогч, туслах, удирдлагын штаб, чиглүүлэгч, дундын хянагчид багтана[279].

КШС-ийг бэлтгэх ажилд дараах асуудлууд орно. Үүнд:

1. Сургуулийн анхны өгөгдөхүүнийг тодорхойлох, тодотгох;
2. Сургуулийн удирдлагын баримт бичиг боловсруулах;
3. Сургуулийг удирдах офицерууд, төрөл мэргэжлийн цэргийн дарга нарыг бэлтгэх;

---

[273] ЗХЖШ.(2016). Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийн ерөнхий журамын 1.8-р заалт

[274] Ганболд.Ц., Баатар.Д.(2013). Штабын сургалт бэлтгэл УБ., х12.

[275] Гомбогарав.Д. (2001).Нэгтгэл ангиудад байлдааны бэлтгэл сургалтыг зохион байгуулж явуулахад захирагч, штабын ажил.Фонын лекц.ҮБХИС. УБ. 57-р тал

[276] Жаргалан.П. (2007). КШС-ийг төлөвлөн зохион байгуулж явуулах штабын ажил. Фондын лекц. УБ.

[277] Жаргалан.П. (2007). КШС-ийг төлөвлөн зохион байгуулж явуулах штабын ажил. Фондын лекц. УБ.

[278] Лхагважав.Д., Бямбацогт.Б.(1974). Офицер, захирагч, штабууд, нэгтгэл ангид тактикийн бэлтгэл заах арга зүй. УБ.,х 139.

[279] Ганболд.Ц., Баатар.Д.(2013). Штабын сургалт бэлтгэл УБ., х15.

5. Сургуульд оролцох анги, салбар, захирагч, штабыг бэлтгэх;

4. Сургууль явуулах байр /газар орон/-ыг бэлтгэх;

6. Сургуульд шаардагдах бүх талын хангалтыг зохион байгуулах асуудлууд багтана[280].

Сургуулийн анхны өгөгдөхүүн тодорхойлогдсоноор сургуулийн удирдлагын үндсэн баримт бичиг болох сургуулийн бодлого төлөвлөгөөг зурмал болон бичмэл байдлаар боловсруулж, зохион байгуулалтын, сургалт арга зүйн, оперативын, лавлагаа тайлан мэдээллийн зэрэг удирдлагын баримт бичгүүд боловсруулагдана.

Бэлтгэл ажил хангагдсанаар оператив удирдамж, тактикийн даалгавар, АББ-ын дохио өгч хийсвэр цаг зарлаж сургуулийг эхлүүлнэ[281].

Сургуулийг тасралтгүй, ойлгомжтой явуулахын тулд сургуулийн удирдлагын штабаас суралцагч нараас мэдээ ирүүлэх журам, цагийг тогтоож мөн суралцагчдад зайлшгүй шаардлагатай нэмэгдэл мэдээллийг дундын хянагч, чиглүүлэгч нараар дамжуулан цаг хугацаанд нь хүргэж[282] сургуулийг шатлан хөгжүүлэх байдлаар удирдан явуулна.

КШС-ийн дүн гаргах ажиллагаа нь сургуулийг удирдан явуулах ажлын нэг хэсэг байх бөгөөд удирдлагын бүлгээс сургуулийн үе, шат бүрд суралцагч захирагч, штабын албан тушаалтан нэг бүрийн хийж гүйцэтгэсэн ажлын явц байдалтай танилцах явцын буюу хэсэгчилсэн сургуулийн төгсгөлд сургуульд оролцсон бүрэлдэхүүн нэг бүрийн болон штабуудыг дүгнэх нэгдсэн арга хэмжээнээс бүрдэнэ[283].

Суралцагч захирагч, штабын ажлыг үнэлэхдээ онолын мэдлэг, цагийн байдлыг үнэлж, шийдвэр гарган салбар нэгжүүддээ цаг тухайд нь үүрэг хүргэж, тасралтгүй, удирдах чадварыг эзэмшсэн байдал, төрөл мэргэжлийн албадын дарга нарын гар нийлэмжтэй ажиллагаа, боловсруулж буй баримт бичиг цаг үеэ олсон, цагийн байдлыг бүрэн тусгасан, штабын соёл, бүх төрлийн хангалт, харилцан ажиллагааг хэрхэн зохион байгуулж байгаад үнэлэлт өгнө[284].

Сургуулийн явцад ахлах дундын хянагч, дундын хянагч нараас дүнгийн хүснэгт, тэмдэглэл, саналыг авч нэгтгэн удирдлагын штабт тогтоосон цагт танилцуулна.

---

[280] ЗХЖШ.(2016). Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийн ерөнхий журам

[281] Ганболд.Ц., Баатар.Д.(2013). Штабын сургалт бэлтгэл УБ., х16

[282] Лхагважав.Д., Бямбацогт.Б.(1974). Офицер, захирагч, штабууд, нэгтгэл ангид тактикийн бэлтгэл заах арга зүй. УБ.,х 140.

[283] Лхагважав.Д., Бямбацогт.Б.(1974). Офицер, захирагч, штабууд, нэгтгэл ангид тактикийн бэлтгэл заах арга зүй. УБ.,х 141.

[284] Жаргалан.П. (2007). КШС-ийг төлөвлөн зохион байгуулж явуулах штабын ажил. Фондын лекц. УБ.

Сургуулийн удирдагч, удирдлагын штаб, суралцагч захирагч штабын шийдвэрийг зурмал, бичмэл, бүдүүвч, график, фото, дүрс бичлэг зэрэг нотлох баримтуудад тулгуурлан хийх илтгэлийг сонсож, сургуулийн бодлого төлөвлөгөөтэй харьцуулан үнэлж дүн гаргана[285].

Суралцагч захирагч штаб гаргасан шийдвэр, боловсруулсан баримт бичгүүдээ, сургуулийн бодлого төлөвлөгөөтэй харьцуулан өөрсдийнхөө алдаа, дутагдалд дүн шинжилгээ хийх боломжийг удирдлагын бүлгээс олгоно.

Дүн гаргах ажиллагаа нь сургууль явуулах шийдвэр гарсан цагаас хойш зэрэгцээ явагдаж сургуулийн бэлтгэл хангасан байдал, сургуулийн хэсэгчилсэн болон нэгдсэн дүнг хүн нэг бүр дээр болон суралцагч штаб бүрээр гаргана[286].

Суралцагч штабын хэсэгчилсэн болон нэгдсэн дүнг гаргах ажлын үндсийг захирагчийн шийдвэр, түүний биелэлтийг задлан шинжлэх ажиллагаа бүрдүүлнэ.

Удирдлагын бүлгээс нэгдсэн дүн гаргахдаа суралцагч штабын дутагдлыг тоочилгүй тухайн цагийн байдалд ямар шийдвэр гарган яаж ажиллавал ашигтай байсныг хууль, эрх зүй, төрөөс баримтлах бодлого, дүрэм, журам, заавар, норматив, онолын үндэслэлээр нотолж, тайлбарлаж өгнө[287].

Хэсэгчилсэн дүнгийн нэгтгэл нь тухайн суралцагч штабын нэгдсэн дүн байх бөгөөд КШС-ийн нэгдсэн дүнг удирдлагын штабын дарга, сургуулийн сэдэв, боловсруулах асуудлууд, анхны цагийн байдал, сургуулийн бэлтгэл хангагдсан байдал сургуулийн явц дахь удирдлагын штаб, суралцагч штабуудын хийж гүйцэтгэсэн ажлын талаар дүгнэсэн нэгдсэн илтгэлийг танилцуулна. Сургуулийн удирдагч штабын даргын илтгэлтэй танилцаж, сургуулийн зорилго, үр дүнг товч дурдаад, сургуулийн удирдлагын штаб, суралцагч штабуудын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, жигдрэлт зэрэгт ерөнхий үнэлэлт өгч, цаашид анхаарах асуудал, илэрсэн дутагдлыг арилгахад ямар арга хэмжээг хэдий хугацаанд авч хэрэгжүүлэхийг заан дээд шатны ахлах даргад танилцуулах илтгэлийн төсөл, сургуулийн холбогдох материал, нэгдсэн дүнгийн нотломж зэргийг бэлэн болгох хугацааг зарлаж, сургуулийн хаалтын ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаар зааварчилгаа өгнө. Сургуулийн нэгдсэн дүн гарснаар сургуульд оролцсон бүрэлдэхүүн сургуулийн төгсгөлийн үеийн холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэн заасан цагт хаалтын ажиллагаанд тусгай хөтөлбөрийн дагуу оролцоно[288].

[285] Лхагважав.Д., Бямбацогт.Б.(1974). Офицер, захирагч, штабууд, нэгтгэл ангид тактикийн бэлтгэл заах арга зүй. УБ.,х 142.
[286] Ганболд.Ц., Баатар.Д.(2013). Штабын сургалт бэлтгэл УБ., х18.
[287] Лхагважав.Д., Бямбацогт.Б.(1974). Офицер, захирагч, штабууд, нэгтгэл ангид тактикийн бэлтгэл заах арга зүй. УБ.,х 142.
[288] Лхагважав.Д., Бямбацогт.Б.(1974). Офицер, захирагч, штабууд, нэгтгэл ангид тактикийн бэлтгэл заах арга зүй. УБ.,х 142.

Сургуулийн удирдагчийн ахлах даргад илтгэх сургуулийн дүнгийн илтгэлд сургуулийн зорилгын биелэлтийн байдал, зарцуулсан материал, хэрэгслийн хэмжээ, КШС-д оролцсон анги, байгууллагын захирагч, штабын сургуулийн бэлтгэл болон явцад илэрсэн гол дутагдал, ажиглагдсан тэргүүн туршлага, тэдгээрт өгсөн үнэлэлт, дүгнэлт, цаашид авах шаардлагатай арга хэмжээний талаарх санал зэргийг тусгана.

ГУРАВ: САНАЛ ДҮГНЭЛТ

Команд штабын сургууль (КШС)-ийг зэвсэгт хүчин, хилийн цэрэг, цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэг бүхий байгууллагууд зохион байгуулан явуулдаг хэдий ч онол арга зүйн талаар тусгасан ном, эх сурвалж хомс нэр томьёо тодорхойлолтын хувьд байгууллагууд өөр өөрсдийн нэр томьёоны тайлбар толь, тушаал журам, зааварт тусган ашиглаж байгаа зэргээс судлаачийн зүгээс дараах санал дүгнэлтийг дэвшүүлж байна. Үүнд:

1. КШС нь захирагч, штаб удирдах бүрэлдэхүүнийг гүйцэтгэх үүрэгт нь дадлагажуулах, үүссэн цагийн байдалд шийдвэр гаргах чадвар олгох, үйл ажиллагааг нь жигдрүүлэх, үүрэг гүйцэтгэх чадавхыг нь нэмэгдүүлэх зорилгоор байр зүйн зураг ашиглан танхимд болон газар орон дээр явагдах цэргийн сургалтын хэлбэрийг хэмээн тодорхойлж болох юм.

2. КШС-ийн онол нь цэргийн сургалтын онолд тулгуурлагдаж арга зүй нь КШС-ийг бэлтгэх, явуулах, дүн гаргах гэсэн хэсгээс бүрдэж, сургагч буюу удирдлагын бүлэг, суралцагч захирагч, штабын үйл ажиллагааны нэгдлийн цогц хэмээн дүгнэж болохоор байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль, 2016, 9.1

2. ХХБ. “Сургалт бэлтгэл - 2012” хөтөлбөр .(2009). УБ.

3. ЗХЖШ. “Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийн ерөнхий журам”.(2016). УБ.

4. Багшийн багц цагаар үнэлэх журам, 2022, А/658 дугаар тушаал

5. Гамшигаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, дадлага зохион байгуулах заавар, 2017, А/323 дугаар тушаал

6. Сүндэв, П. (2003). “Команд штабын сургууль”-ийн тайлбар. Монгол Улсын хилчний тайлбар толь, (198), Улаанбаатар хот

7. Ганболд,М. (2010) . “Команд штабын сургууль”-ийн тайлбар. Хилийн нэр томъёоны тайлбар толь, (122), Улаанбаатар хот

8. Паламдорж,Ш., Дашзэвэг,Ц. (2014) . “Команд штабын сургууль”-ийн тайлбар. Цэргийн нэр томьёоны тайлбар толь, (180), Улаанбаатар хот

9. Жавхланцогт, В., Муратхан, А., (2017) . “Команд штабын сургууль”-ийн тайлбар. Хилийн албанд ашиглагдах зарим нэр томьёоны тайлбар толь, (75), Улаанбаатар хот

10. Лхагважав.Д., Бямбацогт.Б.(1974). Офицер, захирагч, штабууд, нэгтгэл ангид тактикийн бэлтгэл заах арга зүй. УБ.,139-р тал

11. Ганболд.Ц., Баатар.Д.(2013). Штабын сургалт бэлтгэл УБ., 12-р тал

12. Мягмаржав,Г. Цэргийн сурган хүмүүжүүлэх ухааны үндэс (1998). УБ. (х.27).

13. Сүхбат,Р. (2016), Цэргийн сургалтын тогтолцоо. Зэвсэгт хүчний сургалтын тоголцоонд хийсэн шинжилгээ.УБ. БХИС. Эрдэм шинжилгээний хуралын эмхтгэл, х 13

14. Бадамбазар, Ж., Соронзонболд, Т. (2016), Офицерын бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн тогтолцоо түүнийг боловсронгуй болгох нь. Зэвсэгт хүчний сургалтын тогтолцоонд хийсэн шинжилгээ. УБ. БХИС. Эрдэм шинжилгээний хуралын эмхтгэл, х 33

15. Гомбогарав.Д. (2001).Нэгтгэл ангиудад байлдааны бэлтгэл сургалтыг зохион байгуулж явуулахад захирагч, штабын ажил.Фонын лекц.ҮБХИС. УБ. х 57

16. Жаргалан.П. (2007). КШС-ийг төлөвлөн зохион байгуулж явуулах штабын ажил. Фондын лекц. УБ. х3

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ҮНЭТ ЗҮЙЛ, ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

ORGANIZATION OF EXECUTION OF COURT DECISIONS VALUES AND DEVELOPMENT ATTITUDES



О.Эрдэнэсайхан
Дотоод хэргийн их сургуулийн
Удирдлагын академийн 8023 дугаар дамжааны
суралцагч, магистрант, хошууч

Товч агуулга: Энэ хүү илтгэлдээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үнэт зүйл, залуу алба хаагчдын албандаа итгэх итгэлийг тодорхойлох зорилгоор шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үнэт зүйлд баримжаалсан жишээн дээр шинжилгээ, дүгнэлт хийх замаар харуулахыг зорьсон болно.

Summary: In this report, the aim of this report is to show the values of the Judiciary and the confidence of young officers in their service through analysis and conclusions based on examples based on the values of the Judiciary.

Түлхүүр үг: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, үнэт зүйл, хүний нөөц, сургалт

Key words: General Executive Agency of Court decision, value, human resources, training

ОРШИЛ

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, хуульд зааснаар бусад байгууллага, албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шийдвэрийг гүйцэтгэдэг өвөрмөц харилцаатай төрийн тусгай институтийн хувьд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хуульд зааснаар хязгаарлах явцад энэрэнгүй, шуурхай байх зарчмыг баримтлан ажиллах үүрэгтэйг хуульчилж өгсөн.

Энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд тус байгууллага нь төрөл мэргэжлийн албадын алба хаагчдыг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх

бодлогоор дамжуулан хүний нөөцийг бүрдүүлэх нь төрийн үйл ажиллагааг тасралтгүй, хүртээмжтэй явуулах амин сүнс нь байх учиртай.

Тэгвэл энэхүү хүний нөөцийн бодлого гэдэг нь алба хаагчийн чадавхыг хангах, хадгалах, бэхжүүлэх, хөгжүүлэх болон хувьсан өөрчлөгдөж буй нийгмийн өөрчлөлтөд хариу өгөх чадвартай, мэргэшсэн өндөр бүтээмж бүхий нягт хамт олныг бий болгохын тулд чиглэгдсэн зорилго, зорилтыг боловсруулахад баримтлах зарчим, хэрэгжүүлэх арга, хэлбэр хийгээд зохион байгуулалтын механизмын нийлбэр цогц гэж ойлгодог байна[289].

Ийнхүү Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын өмнө тавигдаж буй чухал зорилгын нэг нь хүний нөөцийг оновчтой бүрэн ашиглах явдал бөгөөд энэхүү зорилгодоо хүрэхийн тулд алдаа, оноо, ололт амжилт, түүхийн сургамж дээр тулгуурлан боловсруулсан хүний нөөцийн менежментийн бодлоготой байхыг эрдэмтэн судлаачид зөвлөдөг байна. Өөрөөр хэлбэл хүний нөөцийн бодлогоор дамжуулан алба хаагч бүрд байгууллагын удирдлагын философи, үнэт зүйлийг ойлгуулахад хялбар болдог гэсэн үг юм.

ҮНДСЭН ХЭСЭГ

Нэг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын үнэт зүйлийн талаарх ойлголт:

Үнэт зүйл гэдэг нь хүний сайн, муу, сайхан муухайн үнэлэмж бөгөөд хүмүүсийн янз бүрийн итгэл үнэмшил дээр тулгуурлан тухайн хүний хувьд үнэлэх боломжгүй итгэл, бодол санааны тогтолцоог бий болгодог гэж үздэг.

Харин байгууллагын хувьд түүхэн хөгжлийн явцад алба хаагч үнэт зүйл, үзэл баримтлал, уур амьсгал, зан үйлийн тогтсон хэв маягийг бий болгодог байна.

Аливаа байгууллага үнэт зүйлээ тодорхойлохдоо дараах үзэл баримтлалыг тусгасан байвал зохино[290] гэж эрдэмтэд үздэг байна. Үүнд:

- тэгш байдал: ялгаварлалгүй хандлагад дасан зохицсоноор алба хаагч шударга ба үнэн, зөв байдаг гэсэн ойлголт бөгөөд удирдлага шударга бус шийдвэр гаргахаас хамгаалах, ажил эрхлэлтийн хувьд эрх тэгш боломжийг хангах, цалин хөлсний ялгаваргүй систем үйлчлэх зэргийг багтааж ойлгодог;

- хүндэтгэл эсхүл анхаарал халамж нь алба хаагчийн ирээдүй, аюулгүй байдал эсвэл өөрийн хүндэтгэлийг хөндсөн шийдвэр гаргах үедээ хувь хүний байдал, нөхцөлийг хангаж үздэг;

[289] Кибанов, А.Я. Основы управления персоналом. Инфра., 2005. Стр 91-96.
[290] M.Armstrong. A. Handbook of HRM Practic.9 th ed., 2003 p. 131-132.

- зохион байгуулалттай сурч, хөгжих боломж гэдэг нь шаардагдаж буй дэмжлэг, үйл ажиллагааг хангах замаар бүх алба хаагчийг сурч, хөгжих боломжоор хангана гэдэгт итгэх итгэл;

- хүмүүст тулгуурласан гүйцэтгэл: гүйцэтгэлийн соёлыг хөгжүүлэх, тасралтгүй сайжруулалтад хүргэхэд ач холбогдолтой бөгөөд хоёр талын хүлээлтийг тодорхойлох, тохиролцох замаар удирдлагад хэрэгтэй ажилтны ажлыг гүйцэтгэлийн талаар шударга эргэх холбоог хангахад чиглэгддэг;

- ажиллах нөхцөл нь аль болох амьдралд нийцсэн тав тухтай ажлын орчныг бүрдүүлэх, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад чиглэгддэг[291].

Ийнхүү дээр дурдсан үнэт зүйлс нь байгууллагын бодлогод тусгагддаг боловч зарим байгууллагын хувьд үйл ажиллагааны чиглэлдээ тулгуурлан өргөжүүлэх, эсвэл хүний нөөцийн ямар асуудлыг тэргүүн зэрэгт тавьж байгаагаас хамааран өөр өөр байдлаар тодорхойлж болдог байна[292].

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 100 алба хаагчаас байгууллагын үнэт зүйлийн ойлголтын талаарх судалгаа авахад судалгаанд оролцогчдын 60.1 хувь нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад үнэт зүйл байдаг эсэхийг мэдэхгүй, 4.2 хувь нь үнэт зүйл байхгүй, 35.7 хувь нь байгууллага үнэт зүйлээ тодорхойлоогүй гэсэн судалгааны үр дүн үзүүлсэн байна.

Зураг 1. Байгууллагын үнэт зүйлийн ойлголтын талаар судалгаанд хамрагдсан алба хаагчдын боловсролын байдалтай харьцуулсан үзүүлэлт:



Судалгааны хариултыг боловсролын байдалтай харьцуулан задлан үзвэл дээд боловсролтой алба хаагчийн 56.1 хувь, тусгай дунд боловсролтой алба хаагчийн 71.4 хувь, бүрэн дунд боловсролтой алба хаагчийн 70 хувь нь үнэт зүйлийг мэдэхгүй гэсэн хариулт өгсөн.

[291] Алтангэрэл, Б., Баярбаатар, П. нар. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бодлого. Суурь судалгаа. -Уб., 2023. 85 дахь тал
[292] Цэнд, Н. Батхүрэл, Г. нар. Менежмент. -Уб., 2013. 29 дэх тал.

Харин дээд боловсролтой алба хаагчийн 38.3 хувь, тусгай дунд боловсролтой алба хаагчийн 14.2 хувь, бүрэн дунд боловсролтой алба хаагчийн 25 хувь нь үнэт зүйлийг тодорхойлоогүй буюу үнэт зүйл байхгүй гэсэн хариултаас харахад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь алба хаагчийн нийтлэг болон туршлагын нэгдэл болсон үнэт зүйл болон итгэл найдварын илэрхийллийг тодорхойлоогүй гэж ойлгож болохоор байна.

Зураг 2. Байгууллагын үнэт зүйлийн ойлголтын талаар судалгаанд хамрагдсан алба хаагчдын боловсролын байдалтай харьцуулсан үзүүлэлт:



Түүнчлэн судалгаанд оролцогчдын 45.6 хувь нь байгууллагын үйл ажиллагаанд чиглэсэн буюу шүүхийн шийдвэрийг бүрэн биелүүлж буй үйл ажиллагаа, 24.1 хувь нь байгууллагын өндөр мэдлэг, ур чадвар, зөв хандлагатай алба хаагч нь өөрөө шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үнэт зүйл, 16.2 хувь нь байгууллагын үйлчилгээ үзүүлсэн хүнд чиглэсэн буюу гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг нийгэмшүүлж байгаа нь, 20.1 хувь нь байгууллагын үйлчилгээний үр дүн буюу хүний эрх, эрх чөлөөг хангаж зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээж буй нь үнэт зүйл гэж хариулсан байна.

Тэгвэл энэхүү судалгааны үр дүнгээс харахад тус байгууллага эрхэм зорилгынхоо хүрээнд алсын хараандаа хүрэхийн тулд зайлшгүйгээр баримтлах шаардлагатай зарчмууд буюу үнэт зүйлсийг тодорхойлох хэрэгцээ байна хэмээн үзэж байна.

Өөрөөр хэлбэл бид төрийн хуулиар хүлээлгэсэн чиг үүрэг, хамт олноороо тодорхойлсон зорилгодоо хүрэхийн тулд байгууллага нарийвчлан томьёолсон стратегиудаа бодит амьдрал дээр хэрэгжүүлэх арга хэрэгслүүдийн нэг нь үнэт зүйлсийг тодорхойлох явдал[293] гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Учир нь аливаа стратеги төлөвлөгөөг гардан хэрэгжүүлэгчид болох Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргаас эхлүүлээд хорих ангийн харуул хамгаалалтын ажилтан хүртэл бүх түвшний алба хаагч бүр Шүүхийн

[293] Үүрийнтуяа, О. Байгууллагын соёлыг удирдлагын удирдах маягтай харьцуулсан судалгаа. - Уб., 2020. 7 дахь тал.

шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрхэм зорилго, алсын харааг бүрэн дүүрэн ухамсарлан ойлгож, үнэт зүйлсээ өдөр тутмын үйл ажиллагаандаа бие бүрэлдэхүүнээрээ баримталж хэмээн байгууллагын үнэт зүйлс нь гоёмсгоор хэлэгдсэн уриа, хананд өлгөсөн бичиг биш харин алба хаагч бүрийн сайн дурааараа даган мөрддөг хэвшил болох учиртай гэж судлаачийн зүгээс үзэж байна

Тэгвэл тус байгууллагатай ижил төстэй чиг үүргийг гүйцэтгэдэг төрийн байгууллагуудын хувьд байгууллагын үнэт зүйлээ тодорхойлсон байдлыг судлан үзэхэд дараах байдлаар илэрхийлжээ.

- **Цагдаагийн ерөнхий газар үнэт зүйлээ** "Эх орон, ард иргэддээ өргөсөн тангараг[294]"

- **Дотоод хэргийн их сургууль үнэт зүйлээ** "Дуурьсах суу алдар, хандах нэгэн зүг, итгэх эрхэм чанар, сахих журамт ёс[295]"

- **Татварын ерөнхий газар үнэт зүйлээ** Шударга байдал: Нэг нөхцөл байдалд байгаа хүн бүртэй адилхан харьцах, Хариуцлага: Байгууллага, ажилтнуудын бүтээмж, авхаалж самбааг нэмэгдүүлэх, Зөв хандлага: Сайн дурын шаардлагыг дээд зэргээр нэмэгдүүлэх, Мэргэжлийн ур чадвар: Ажилтны ур чадвар, эзэмшил, сэтгэл ханамжийн өндөр түвшинд хүрэх, Бие даасан байдал: Ямар ч нөхцөлд маш сайн үйлчилгээ үзүүлэх,зөв зүйлийг хийх, Шинэ санаачилга: Ажлаа илүү сайн хийх шинэ арга замыг тасралтгүй эрэлхийлж хэрэгжүүлэх, Хамтын ажиллагаа: Үр дүнд хүрэхийн тулд харилцан итгэлцэл, хүндэтгэлтэйгээр бие биетэйгээ хамтран ажиллах[296] гэжээ.

- **Нийгмийн даатгалын ерөнхий газар үнэт зүйлээ** Нийгмийн даатгалын байгууллагын бэлгэдэл **ШҮХЭР** бөгөөд энэхүү үгийг бүтээгч үсэг бүхэнд ажилтан бидний ирээдүйн зорилго чиглэл, эрхэмлэх үнэ цэнийг тодорхойлсон. **Ш- шилдэг мэргэшсэн, Ү–** үнэнч, ёс зүйтэй, **Х**-хамтын ажиллагаа, түншлэлийг дэмжигч, **Э**-еелдэг, тусч, **Р**-эрч хүчтэй, бүтээлч санаачилгатай[297] гэж тодорхойлжээ.

Харин хувийн хэвшлийн байгууллагуудын хувьд дараах байдлаар үнэт зүйлээ тодорхойлсон байна.

- **Оюу толгой компани үнэт зүйлээ** "Анхаарал халамжтай: хамт олны эрүүл саруул, аюулгүй байдалд анхаарч бие биеэ хүндэтгэсэн илтгэлцэлд суурилсан харилцааг бэхжүүлэх, хамт олон хүрээлэн буй орчны сайн сайхан байдалд хувь нэмрээ оруулах боломжийг цаг ямагт эрэлхийлэх, Зоримог шийдэмгий: бурууд нүд хурц, ёс зүйтэй байж шаардлагатай үед шийдэмгий алхам хийж чаддаг, саад бэрхшээлийг хамтдаа даван туулж, нэгдмэл зорилгоо

[294] www.police.gov.mn
[295] www.uia.gov.mn
[296] www.mta.mn
[297] www.ndaatgal.mn

биелүүлэхийн төлөө тууштай зүтгэнэ, Сониуч соргог: шинэлэг санааг хөхиүлэн дэмжиж, сониуч соргог байж, хамтын хүчээр илүү ихийг бүтээхийн төлөө эрмэлзэнэ.

- **Эрдэнэс таван толгой компани үнэт зүйлээ** “Чадварлаг, мэргэшсэн, эвсэг хамт олон, харилцан итгэлцэл” гэж тодорхойлоод ажилчдын ур чадвар, мэргэшил туршлага, ажлын үр дүнг харгалзсан хариуцлага, урамшууллын бодлого, хөдөлмөр эрхлэлтийн тэгш нөхцөл боломжоор хангаж, чадварлаг, мэргэшсэн боловсон хүчнээр хамт олныг бүрдүүлнэ. Хүндэтгэл, итгэл, шударга, ил тод, хариуцлага, сахилга баттай байдлыг эрхэмлэсэн багаар ажиллах чадвартай, эвсэг хамт олон нь өндөр үр дүн, амжилтын нийлмэл хүч байна гэж тус тус тодорхойлсон байна.

Хоёр. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн хөгжлийн чиг хандлага:

Ирээдүй бол өнгөрсөн болон одоо үеэс эхлэлтэй гэдэгчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийг бодлогыг хөгжүүлэхийн тулд өнөөдрийн ажиллах хүчний дийлэнхийг бүрдүүлж буй ирээдүй болсон шинэ үеийн залуучуудын онцлог, сэтгэл зүй, хандлагад тохирсон удирдлагын арга барил, менежментийг байгууллагын үнэт зүйл дээр тулгуурлан тодорхойлох нь хүний нөөцийн тогтвортой хөгжлийн оновчтой бодлого байх учиртай.

Үүний эхлэл нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хүний нөөцийг бүрдүүлэх буюу байгууллагын үнэт зүйл болсон алба хаагчийн сонгон шалгаруулж авахаас эхлэх бөгөөд тэдний талаар тал бүрээс нь судлахдаа нийгмийн үе, хүн амын үе хооронд ялгаатай байдлыг судалж нас, цаг хугацаа, бүлэг гэсэн гурван хэмжигдэхүүнийг авч үзэх нь нэн шаардлагатай[298] юм.

Тухайлбал, шинэ буюу Z үеийнхэн 1995-2005 онд хамаарах энэ үеийнхэн дэлхийн хүн амын 3/1 хувийг эзлэх бөгөөд хурдан хөгжих чадвартай, харилцаа холбооны хэрэглээнд маш их холбогдсон, харьцангуй бие даасан шинжтэй, хурдан шуурхай мэдээлэл, үйлчилгээнд дуртай, нээлттэй, өндөр хурдны интернэт орчин болон сошиал орчны хэрэглээнээс үүдэн нийгмийн оролцоо багатай гэж тодорхойлдог байна.

Өндөр хөгжилтэй зарим орны ажил олгогчид болон хүний нөөцийн мэргэжилтний ажиглаж буйгаар “Z” үеийнхний залуучууд хөдөлмөрийн зах зээл дээр багагүй тоогоор ажиллах болсонтой холбоотойгоор энэ үед багтах ажилтны онцлог зан төлөвийн талаар илүүтэй судлах шаардлага үүсээд байгааг дээр дурдсан билээ.

Тэгвэл энэхүү залуу алба хаагчдын хувьд эцэг, эх нь илүү бие даасан, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлдэг, нээлттэй харилцааны хэлбэртэйгээр

[298] Цэцэгмаа, Ц. Хүний нөөцийн менежмент. -Уб., 2014. 58 дахь тал

хүмүүжүүлсэнтэй холбоотой. Мөн “Z” үеийнхэн хоорондоо дижитал хэрэгслээр байнгын холбоотой байх, ажил болон амьдралаа уян хатнаар зохицуулах хүлээлттэй, нэг ажлаас нөгөө ажилд шилжих сонирхолтой бөгөөд ажлын байранд тогтсон хуучин хэв маягийг хүлцэн тэвчдэггүй, харин удирдлагыг янз бүрийн сорилтоор турших зэрэг хандлагатай байдаг гэж хүний нөөцийн мэргэжилтнүүд нийтлэг байдлаар дүгнэдэг байна.

Харин байгууллагын өмнө тулгарч буй асуудал бол байгууллагын үнэт зүйлийг төлөвшүүлэх, шинэ үеийнхнийг тогтвортой ажиллуулах, алба хаагч байгууллагын удирдлага хоорондоо ойлголцохын тулд аль аль нь уян хатан байж, бие биедээ тохируулан өөрчлөгдөх шаардлагатай гэж үздэг. Мөн алба хаагчийн санал хүсэлтийг тогтмол хүлээн авах тал дээр анхаарлаа хандуулж, хамгийн шинэ ажилтнаасаа ч санал хүсэлтийг нь сонсдог байвал тэр байгууллагын удирдлага шинэ үеийнхний хувьд хамгийн амжилттай байх болно хэмээн хүний нөөцийн менежментийн ном зохиолуудад тэмдэглэсэн байдаг.

Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бодлого боловсруулалт, үйл ажиллагааны хэрэгжилтэд байгууллагын үнэт зүйлийн талаар ойлголтыг тусгаж, хэрэгжүүлэх нь залуу алба хаагчдыг тогтвор суурьшилтайгаар ажиллуулж тэдний нөөц боломж, хувийн чадварыг ашиглахад тустай төдийгүй байгууллагын хөгжлийн гарц байх болно хэмээн судлаачийн зүгээс үзсэн.

Өөрөөр хэлбэл хүний нөөцийн менежмент нь уламжлалт боловсон хүчний менежментээс ялгагдах гол онцлог, чиглэл нь байгууллагын хөгжлийн ерөнхий стратегитай нийцэх нийцэл, нэгдмэл чанар, байгууллагын соёлыг хөгжингүй, хүнлэг ёсны үнэт зүйлстэй хослуулан удирдах чиглэлээр илэрдэг гэж тодорхойлсон байдагтай холбоотой юм.

ДҮГНЭЛТ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага үнэт зүйлээ тодорхойлоогүй байгаад анхаарлаа хандуулж, алба хаагчдын нийгэмд хүлээх үүрэг, хариуцлага, албандаа хандах хандлагыг өөрчлөх, урам зоригийг сэргээсэн хүн төвтэй тодорхойлолтыг бий болгох хэрэгцээ, шаардлага маш их гэж дүгнэлээ.

“Алсын хараа-2050” хөгжлийн баримт бичиг, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтыг нийгэм, хүний хөгжлийг даган шинэчлэх шаардлага байна гэж үзлээ.

Хүний нөөцийн менежментийн арга ухаанд тус байгууллагын удирдах ажилтан, хүний нөөцийн алба хаагчдыг суралцуулах, улмаар хүний нөөцийн бүхий л үйл ажиллагаанд шинжлэх ухааны аргыг ашигладаг тогтолцоонд шилжих шаардлагатай гэж тус тус дүгнэж байна.

САНАЛ:

1. Албаны сургалт, байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах үйл ажиллагааны чанар, хүртээмжийг дээшлүүлэх хүрээнд алба хаагчийн албандаа хандах хандлагыг дээшлүүлэх хувь хүний хөгжилд чиглүүлэн, алба хаагч төвтэй практик үйл ажиллагааг нэвтрүүлэх;

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын олон талт үйл ажиллагаа нь гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэхэд чиглэгдэж байгаа нь тус байгууллагын алба хаагчдад олон талт мэдлэг шаардлагатай байгааг онцгойлон анхаарч, хүний нөөцийг сонгон шалгаруулах, мэргэшүүлэн сургах, тогтвортой ажиллахад анхаарсан хүний нөөцийн урт хугацааны хөтөлбөр хэрэгжүүлэх;

3. Хүний нөөцийн удирдлагыг шинжлэх ухаанчаар хөгжүүлэх, алба хаагчийн сэтгэл зүйн тогтвортой үйл ажиллагааг хангахын тулд сэтгэл зүйчийг томилон ажиллуулах, бусад мэргэжлийн байгууллагын туслалцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь“Гэмт хэрэггүй нийгмийн төлөө” гэх уриа үгтэй болох.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/.2017-12-07

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /шинэчилсэн найруулга/.2017-06-09

3. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай.1994-06-13

Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн алба хаах хугацааг сунгах журам. 2018-02-15

2. Гадаадын их, дээд сургуульд хууль сахиулах байгууллагын алба хаагчийг сонгон шалгаруулах, суралцуулах журам. 2017-02-24

3. Хууль зүй, дотоод хэргийн сайдын шагналын журам. 2017-04-13

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн тангараг өргөх ёслолын журам. 2017-07-21

5. Шийдвэр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журам. 2017-08-31

6. Жишиг норматив шинэчлэн батлах тухай. 2017-09-29

7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж буй цэргийн жинхэнэ алба хаагаагүй цэргийн насны алба хаагчдад цэргийн бэлтгэл эзэмшүүлэх хөтөлбөр батлах тухай. 2017-10-20

8. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн алба хаах хугацааг сунгах журам. 2018-02-15

9. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны сахилга, ёс зүйн дүрэм /Шинэчилсэн/. 2018-9-27

10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэх, бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэн томилох журам. 2018-10-10
11. Я.Адьяа “Менежментийн ухаан” УБ.,2002 он
12. Г.Дагважамц “Менежмент”УБ., 2004 он
13. Х.Лутчимэг “Удирдахуйн ухаан”УБ.,2015 он
14. Н.Отгонбаяр “Менежмент ”УБ., 2007 он
15. Д.Наранцэцэг “Хүний нөөцийн менежмент” УБ., 2012 он
16. Ц. Цэцэгмаа. Хүний нөөцийн менежмент. - УБ., 2014 он
17. Н. Цэнд, Г.Батхүрэл. Менежмент. УБ. 2013 он
18. А.Я. Кибанов, Основы управления персоналом. 2005 он
19. M.Armstrong. A. Handbook of HRM Practic8 9 th ed., 2003 он
20. www.legalinfo.mn
21. www.cd.gov.mn
22. www.police.gov.mn
23. www.nema.gov.mn
24. www.border.gov.mn
25. www.mojha.gov.mn

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧИЙН АНГЛИ ХЭЛНИЙ БОЛОВСРОЛЫН НЭМЭГДҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

NEEDS AND REQUIREMENTS OF ENHANCEMENT OF ENGLISH LANGUAGE EDUCATION FOR OFFICERS OF COURT DECISION ENFORCEMENT ORGANIZATIONS



Э.Цэрэнханд
Дотоод хэргийн их сургуулийн
Сургалт, судалгааны 403 дугаар анги-
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш,
Хууль зүйн магистр, хошууч

Хураангуй: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн боловсролын чиг хандлагыг судлан тодорхойлж, түүнд англи хэлний боловсролын эзлэх хувийг тогтоон, цаашид англи хэлийг алба хаагчдад эзэмшүүлэх хэрэгцээ шаардлагад дүн шинжилгээ хийж, алба хаагчийн англи хэлний боловсролын өнөөгийн байдал, анхаарах асуудлыг илрүүлнэ.

Summary: Studying and determining the education trends of court enforcement officers, determining the share of English language education in it, analyzing the need for future English language acquisition by officers, and identifying the current state of English language education for officers and issues to be considered.

Түлхүүр үгс: Англи хэл, хууль сахиулагч, албан хаагч, боловсрол, нийгэм, хэрэгцээ, хүний эрх, ашиг сонирхол.

Key words: English, law enforcement, officials, education, society, needs, human rights, interests.

Удиртгал

Дэлхий нийтийн хөгжлийг дагаад нийгмийн харилцаа, технологийн хэрэглээ, боловсрол, сургалт, хөдөлмөрийн салбарт заавал эзэмшсэн байх ур чадварын нэг нь англи хэл болоод байна. Дэлхийд өрсөлдөхүйц мэдлэг, чадвартай иргэнийг бүтээхэд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөгжиж,

дэвших чадамж бүхий сургалтын арга зүй бидэнд хэрэгтэй бөгөөд энэ нь англи хэлний суралцахуйг бүх түвшинд дэмжих тогтолцоог хөгжүүлэх, үндэсний чадавхыг бэхжүүлэх явдал юм.

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого" болон "Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030)"-д хүүхэд, залуучуудад олон улсад мэдлэг, ур чадвараараа өрсөлдөх, ерөнхий боловсролын сургуульд олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх, их, дээд сургуулийн олон улсын эрэмбийг ахиулах боломжийг олгох зорилтуудыг дэвшүүлсэн бөгөөд энэ зорилтуудын хэрэгжилтийг хангахад англи хэлний боловсрол чухал тулгуур байх юм[299].

Энэхүү бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, дэвшүүлсэн зорилтууддаа амжилттай хүрэхэд төрийн байгууллага, түүний албан хаагчдын оролцоо, үүрэг өндрөөр тодорхойлогдсон. Тус бодлогод "үндэс язгуур, төрт ёс, өв соёлоо дээдэлж, үндэсний нэгдмэл үнэт зүйлээ эрхэмлэж, хүн төрөлхтний дэвшилтэт ололтыг дэмжиж, хөрст дэлхий, унаган байгалиа хайрлан хамгаалж, амар тайван, хүмүүнлэг нийгмийг цогцлоож, ардчилал, шударга ёсны засаглалыг бэхжүүлж, өөрийгөө тэтгэсэн эдийн засаг нь өрх, иргэн бүрд тэгш, хүртээмжтэй хүрсэн, эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, эх оронч, хөрвөх чадвартай, оюунлаг,бүтээлч иргэнтэй улс болж хөгжинө[300]" гэж тодорхойлсон бөгөөд эрдэм боловсролтой иргэн тухайн улсын тогтвортой хөгжлийн гол үндэс суурь нь болж байна.

Тэгвэл боловсролтой иргэн гэж хэнийг хэлэх вэ?

Боловсрол гэдэг үгийг "Хувь хүний эзэмшсэн тогтолцоот мэдлэг, чадвар; мэргэжил мэдлэг эзэмшсэн нь"[301], "Хүн суурь хэрэгцээгээ хангахад шаардлагатай мэдлэгийг бүтээх чадвар"[302], "Боловсрол-мэдлэг, чадвар, үнэт зүйл, итгэл үнэмшил, дадал дүй олж авах, дамжуулах үйл явц гэж түгээмлээр тодорхойлдог. Тодруулбал, боловсрол-хойч үедээ дамжуулах бүхнээ зааж сургах, нөгөө талаас амьдрах эрхээ чанаржуулах, бэхжүүлэхийн төлөө өөрөө суралцах үйл явц аж"[303], "the process of teaching

[299] Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээ (2022-2025). Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 372 дугаар тогтоол.
[300] "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого. Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоол.
[301] Монгол хэлний их тайлбар толь. http://mongoltoli.mn/
[302] "Монгол улсын боловсролын тогтолцооны суурь хэв шинжүүдийг тодорхойлж, жишиг загвараар дүрслэх нь" судалгааны ажлын тайлан
[303] Лүндэндорж. МУ-ын үндсэн хууль, шинжлэх ухааны тайлбар. УБ., 2023.

or learning, especially in a school or college, or the knowledge that you get from this"[304] хэмээн олон эх сурвалжуудад тодорхойлсон байна.

Үүнээс үзвэл боловсрол бол тухайн хүний хөгжих боломжийг тодорхойлсон ойлголт болох нь харагдаж байгаа бөгөөд хүн хөгжихийн тулд олон эх сурвалж бүхий мэдээллийг цуглуулж боловсруулах чадвартай байх хэрэгтэй. Харин үүний тулд монгол хэлээс гадна гадаад эх сурвалж бүхий мэдээллийг цуглуулах боловсруулах нь чухал чадварт тооцогдож байна.

Хөгжих эрх нь хүний бүх эрх, эрх чөлөөг бүрэн хэрэгжүүлэхүйц эдийн засаг, нийгэм, соёл, улс төрийн хөгжилд хүн нэг бүр оролцож, хувь нэмэр оруулж, үр шимийг хүртэх үйл явцаас үүдэлтэй хүний салшгүй эрх юм. (НҮБ-ын Хөгжих эрхийн тунхаглал 1986 он)

Тэгвэл хүний хөгжих хэрэгцээг хангах, хүн бүрийн оролцоог хангах хүний эрх, эрх чөлөө, арчилал, шударга ёсыг бодит болгон бэхжүүлэгч нь боловсрол болох дамжиггүй.

Иймд орчин үеийн боловсролын гол түлхүүр болсон гадаад хэлний мэдлэг, түүний хэрэгцээ, шаардлагын тухай судлан авч үзье.

Үндсэн хэсэг

Төрийн албан хаагч олон эх сурвалж бүхий мэдээллийг боловсруулах чадвартай, дэлхийн жишигт хүрсэн ур чадвартай байхын тулд гадаад хэлний мэдлэг зайлшгүй эзэмших ёстой мэдлэг, чадваруудын нэг болоод байна

Нийгмийн хэрэгцээ шаардлагын үүднээс авч үзвэл улс орны хөгжлийн стратегийг хэрэгжүүлэхүйц мэдлэг, чадвартай, нийгэм, иргэдийн хүлээлт, итгэл найдварыг хүлээсэн төрийн албан хаагч тэрхүү зорилтыг хэрэгжүүлэх, бодит болгоход чухал нөлөө үзүүлэх нь дамжиггүй.

Хүний хөгжлийн индекс (ХХИ) нь хүний хөгжлийн түвшинг илэрхийлэгч, хүний хөгжлийн урт хугацааны төлөв байдлын ерөнхий дүр зургийг харуулах, хүний хөгжлийг хэмжих нийлмэл үзүүлэлт юм[305].

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс /НҮБХХ/ хүний хөгжлийн индексийн шинэ тайланг 2024 оны гуравдугаар сарын 15 өдөр

[304] https://dictionary.cambridge.org/dictionary/english/
[305] Үндэсний статистикийн хороо. Хүний хөгжлийн индексийг тооцох аргачлал. УБ хот. 2014 он.

танилцууллаа. Уг индексийг нэг хүнд ногдох орлого, боловсрол, дундаж наслалт зэрэгт үндэслэн тооцоолдог.

Дэлхийн 193 улс орон, нутаг дэвсгэрээс Швейцар улс хүний хөгжлийн индексээр дахин тэргүүлсэн бол Норвеги, Исланд, Хонконг, Дани, Швед удаалсан байна. Түүнчлэн Өмнөд Солонгос 19, АНУ 20, Япон 24, Орос 56, Хятад 75 дугаар байрт тус тус бичигджээ. Монгол Улс 96 дугаарт жагссан байна.

Дэлхийн хүний хөгжлийн индекс түүхэн дээд үзүүлэлтэд хүрч байгаа хэдий ч коронавирусний цар тахлын үеэс хойш хөгжингүй болон хөгжиж буй орнуудын ялгаа улам бүр нэмэгдсээр байгааг тайланд онцолжээ[306].

График 1. Хүний хөгжлийн бүрэлдэхүүн индекс[307]



Дээрх хүний хөгжлийн бүрэлдэхүүн индексүүдийн үзүүлэлтээс харвал манай улсын хувьд сүүлийн жилүүдэд боловсролын индексийн үзүүлэх нөлөө хүний хөгжилд ихээхэн нөлөөлөх болсон нь харагдаж байна. Харин Хүний хөгжлийн үзүүлэлтийн томоохон нэг шалгуур нь “боловсрол” болж байна.

Үүнтэй уялдан Монгол Улсын засгийн газраас хэрэгжүүлж байгаа хөтөлбөрт бүх нийтийн англи хэлний боловсролын тогтолцоог хөгжүүлэх,

[306] https://montsame.mn/jp/read/339677
[307] Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. https://www.1212.mn/

үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 2022-2023 онд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр заажээ. Үүнд:

- дээд боловсролын сургалтын байгууллагын англи хэлний багш нарыг чадавхжуулах;

- их, дээд сургуульд англи хэлний багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудыг чадавхжуулах, англи хэлний олон улсын шалгалтын оноотой төгсгөдөг болгох;

- оюутан, суралцагч, багш нарын дунд сургалтаас гадуурх англи хэлний төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах;

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэгтэй төгсөгчдөд гадаадын шилдэг их, дээд сургуульд суралцах англи хэлний бэлтгэл сургалтад дэмжлэг үзүүлэх; хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллагууд ажилтан, албан хаагчийн англи хэлийг бие дааж, ажлын байрандаа сурч боловсрох, тэдний англи хэлний насан туршийн суралцахуйг дэмжих; иргэд өөрийн хэрэгцээнд нийцсэн англи хэлний мэдлэг, чадвар эзэмших, түвшин ахиулах боломжийг бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааг тусгаж өгсөн. Эдгээр ажил, арга хэмжээнээс гадаад хэл тэр дундаа англи хэлний боловсролыг дэмжих бодлогын хүрээнд манай улс томоохон бөгөөд бодитой арга хэмжээг авч хэрэгжүүлэх болсон нь харагдаж байна.

Тэгвэл төрийн байгууллага, түүний үйл ажиллагааг дэмжих, гүйцэтгэлийн хангаж, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх чиг үүрэг бүхий бүх шатны төрийн албан хаагчийн хувьд дээрх арга хэмжээ нэн тэргүүний хэрэгжүүлэх, ард иргэдийг түүчээлэн манлайлах зорилт болоод байна.

Энэхүү бодлого, арга хэмжээ хэрэгжсэнээр хүрэх үр дүнгүүдийг Монгол Улсын засгийн газраас тодорхойлсон байна.

“Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээ[308] /2022-2025/”-г засгийн газраас хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрсэн байхыг тооцоолж байна. Үүнд:

1. Англи хэлний боловсролын судалгаа, сургалтын мэргэжлийн институц бий болж, бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих хүний болон материаллаг нөөц, сургалтын тогтолцоо бий болсон байна;

[308] Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээ Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 372 дугаар тогтоол

2. Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, багш, англи хэлтэй иргэдийн оролцоог хангасан бүх нийтийн англи хэлний боловсролын эко систем бүрдсэн байна;

3. Ерөнхий боловсрол, дээд боловсролын 50-аас доошгүй сургууль математик, байгалийн ухааны хичээлийг англи хэлээр зохион байгуулсан байна;

4. Еөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчдийн ТОЕФЛ Жуниор (TOEFL Junior) болон Duolingo платформ дээр англи хэлний шалгалтын төлбөрийн 50 хувийг төрөөс дэмжлэг үзүүлж, жил бүр ерөнхий боловсролын 12 дугаар ангийн 1800-аас доошгүй суралцагч шалгалт өгч, оноогоо баталгаажуулсан байна;

5. Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг авсан 504 суралцагчийн тодорхой хэсэг англи хэлний шалгалт өгч гадаадын их, дээд сургуульд суралцах англи хэлний болзол хангасан байна;

6. Багшийн мэргэжил дээшлүүлэх цахим картаа ашиглан 1000 багш англи хэлний сургалтад хамрагдаж, англи хэлний олон улсын шалгалт өгч оноогоо баталгаажуулсан байна;

7. Их, дээд сургуулийн 100-аас доошгүй багш англи хэлээр эрдэм шинжилгээ, судалгааны өгүүлэл нийтлүүлсэн байна;

8. Бүх нийтийн англи хэлний сургалт тогтмол зохион байгуулагдаж, үр дүнг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн байна.

Эдгээр үр дүнгүүд нь англи хэлний боловсрол түүний хэрэгцээ шаардлагыг тод бөгөөд томруунаар харуулсан хэрэг болж байна.

Нэг талаас төрөөс аль нэгийг хэлийг сурах, эзэмших шаардлагыг тавьж байгаа нь дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, олон улсын харилцаанд эзлэх байр суурь зэргийг харгалзан үзсэнээр англи хэлийг суралцах үйл хэргийг бүх нийтээр дэмжиж байгааг илэрхийлж байна. Өнөөдрийн байдлаар дэлхийн хүн ам /албан бус тоогоор/ 7000 гаруй хэлийг хэрэглэдэг гэсэн судалгаа бий. Гэвч дэлхий нийтийн глобачлалтай холбоотойгоор олон улсын хүмүүс хоорондоо харилцахад хэрэглэгдэх олон улсын хэл байх зайлшгүй шаардлага бий болно. Энэхүү шаардлагын хүрээнд англи хэлний хэрэглээ өдрөөс өдөрт өсөн нэмэгдсээр дэлхийн улс орнуудын дипломат болон бусад харилцаанд өргөн хэрэглэгддэг гэдгээрээ хэл шинжлэлийн ухаанд томоохон байр суурь эзлэх болсон.

Дэлхийд өрсөлдөхүйц мэдлэг, чадвартай иргэн, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын байгууллагыг хөгжүүлэхэд англи хэлний суралцахуйг бүх түвшинд дэмжих тогтолцоог хөгжүүлэх, үндэсний чадавхыг бэхжүүлэх шаардлага үүсээд байна.

График 2. Дэлхийн хүмүүсийн хамгийн их ярьдаг хэл[309]



Энэхүү үзүүлэлт нь дэлхийн нийт хүн амын 18,7 хувь нь англи хэлээр ярьж байгааг харуулж байна. Иймд манай улс алсын хараа, хөгжлийн бодлогоо үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд англи хэлний мэдлэгтэй алба хаагчдаар хүрээгээ тэлэх нь хөгжлийн хурдыг нэмэгдүүлэх нэг үзүүлэлт болох юм.

Швейцарьт төвтэй EF боловсролын байгууллага жил бүр үндэсний хэлээсээ гадна англи хэл эзэмшсэн дэлхийн орнуудын англи хэлний боловсролын түвшинг үнэлж "EF English Proficiency Index" жагсаалтыг гаргадаг. Жагсаалтыг гаргахдаа нийт 2.2 сая гаруй насанд хүрэгчдээс англи хэлний сорил авч үнэлсэн байна.

Тус үзүүлэлтэд энэ жил Монгол улс дэлхийн 113 орноос 73 дугаар байрт жагсаж байна. Энэхүү үзүүлэлт нь жуулчидтай харилцах энгийн

[309] https://www.statista.com/

ярианы чадвар болон найз нөхөдтэйгээ бага зэрэг яриа өрнүүлэх, энгийн имэйл буюу цахим шууданг уншиж ойлгох хэмжээний англи хэлний мэдлэгтэй гэж үнэлэгдсэн байна.

График 3. Англи хэл эзэмшсэн улс, бүс нутгийн зэрэглэл



Иймд Англи хэл дэлхий нийтээр харилцах хэл болон тархаж байгаа учраас оюутнууд шинжлэх ухааны англи хэл сайн сурах, ажил мэргэжлийн шаардлагын дагуу тухайн хэлээр харилцах чадвараа улам хөгжүүлэх хэрэгтэй байдаг. Англи хэлийг олон улсын харилцааны хэрэглүүрийн хувьд шинжлэх ухаан, технологи, эдийн засаг, бизнесийн салбарт өргөн хэрэглэж байгаа тул дэлхийн хүн амын хөгжилтэй эн зэрэгцэх ур чадвартай байх үүднээс англи хэлийг сурах зайлшгүй шаардлага улам нэмэгдсээр байна.

Тодорхой жишээ дурдвал Монгол Улсын гадаад худалдааны эргэлт 2021 оны 12 сарын байдлаар 15,5 тэрбум америк доллар, 2022 оны 12 дугаар сарын байдлаар 20,5 тэрбум америк доллар, 2023 оны 12 сарын байдлаар 23,7 америк доллар болон өсч байгаа нь гадаад худалдаа гадаад харилцааны салбар дахь монголчуудын харилцаа асар их нэмэгдэж байгааг харуулж байна.[310]

[310] Үндэсний статситикийн хороо. http://1212.mn/

Тэгвэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь бүх шатны шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх чиг үүрэг бүхий төрийн тусгай алба юм. Эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг албадан биелүүлдэг байгууллага бөгөөд олон төрлийн мэргэжил, боловсрол, нийгмийн байр суурь бүхий хүмүүстэй өдөр тутам харилцдаг. Иймд алба хаагчид гадаад хэлний мэдлэг нь шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд, шүүхийн шийдвэрт заагдсан этгээдүүд болон тэдгээртэй холбоотой хуулийн этгээдтэй цаг алдалгүй харилцах, мэдээлэл солилцох, ойлголцох шаардлагыг үүсгэдэг.

2022 онд хийгдсэн судалгаагаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь нийт 3800 орчим алба хаагчтай бөгөөд тэдгээрээс англи хэлний анхан шатны мэдлэгтэй 551, дунд шатны мэдлэгтэй 135, ахисан шатны мэдлэгтэй 24 алба хаагч байна.[311] Уг тоо нь нийт алба хаагчдын 18,6 хувь нь англи хэлний тодорхой мэдлэгтэй байгаа нь харагдаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн англи хэлний мэдлэг, боловсролын байдлыг тодорхойлоход Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн төгсөгчдийн мэдлэг, чадварын талаар ажил олгогч буюу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдах ажилтнуудаас авсан сэтгэл ханамжийн судалгааг сонгон судласан юм. Энэ судалгаа нь нэг талаас төгсөгчдийн мэдлэг, ур чадварыг тодорхойлж сайжруулахад ач холбогдолтой ч гэсэн нөгөө талаас хамгийн гол ач холбогдол нь байгууллагын хэмжээнд удирдах ажилтны хандлага ямар байгааг тодорхойлох боломжтой байж болох юм.

2020 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдах ажилтнаас авсан сэтгэл ханамжийн судалгаанд төгсөгчдийн цэрэгч, жагсаалч байдал, үнэнч шударга, хууль хэрэглэх чадвар, ёс зүйн төлөвшил, харилцааны ур чадвар, багаар ажиллах чадварууд сайн гэж дүгнэсэн бол ажлын ачаалал даах чадвар, баримт бичиг боловсруулах, шинэ санаа гаргах, сэтгэл зүйн чадвар, аюулгүй ажиллагааг хангах бэлтгэл ур чадвар, галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч, тусгай мэх хэрэглэх чадвар, англи хэлний мэдлэг тааруу байна гэж дүгнэсэн[312].

[311] Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтсийн 2023 оны тайлан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар.

[312] “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл-эрх зүй” хөтөлбөрөөр төгсөгчдийн мэдлэг, ур чадварын талаарх ажил олгогчдоос авсан сэтгэл ханамжийн судалгаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургууль. УБ., 2020. 3 дахь тал

Гэтэл улс орны гадаад харилцаа хурдацтай хөгжиж байгаа энэ цаг үед алба хаагчдын англи хэлний боловсролын түвшин хангалтгүй байгаа нь анхаарал татсан асуудал болж байна.

Хэдийгээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь Монгол Улсын төрийн албан ёсны хэлээр явагдах ёстой хэдий ч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөгжил, гадаад хамтын ажиллагаа, гадаад оронд туршлага судлах, албан хаагчдын мэргэжлийн сургалтыг зохион байгуулах олон талт хамтын ажиллагаанд албан хаагчийн хэлний мэдлэг зайлшгүй шаардагддаг.

Дэлхий нийтэд эрүүгийн болон иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүний эрхийн хандлагад нийцүүлэх, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний заалтуудыг мөрдүүлэх хүрээнд гадаад орны ижил чиг үүргийн байгууллагуудтай хамтран ажиллах, туршлага солилцох арга хэмжээг авч хэрэгжүүлэх болсон. Үүний нэг томоохон жишээ бол 2019 онд анх удаа “Ази номхон далайн орнуудын хорих байгууллагуудын удирдах ажилтны 39 дэх удаагийн бага хурал”-ыг манай улсад зохион байгуулсан явдал юм.

Эдгээрт суурилан албан хаагчдын хэлний боловсролыг дэмжих, цаашлаад байгууллагын хөгжил, дэлхийн нийтийн жишигт нийцсэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хөгжүүлэх хүрээнд ШШГЕГ-ийн даргын тушаалаар 2020 онд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгуулагын алба хаагчдын англи хэлний мэдлэгийн түвшинг дээшлүүлэх”[313] дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдаг.

Хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн англи хэлтэй алба хаагчийн нөөц бүрдүүлэх зорилгоор анги, байгууллага, салбар нэгжээс англи хэлний дунд түвшний мэдлэгтэй 16 алба хаагчийг сонгон шалгаруулж, байгууллагын зардлаар “English one” сургалтын төвд тусгай хөтөлбөрийн дагуу 80 цагийн хичээл сургалтад хамруулан, сургагч-багшаар бэлтгэсэн. Сургалтад хамрагдсан алба хаагчид өөрийн анги, нэгж дээр англи хэлний анхан шатны сургалт зохион байгуулах, хичээлийн гарын авлага, материал боловсруулах ажлыг зохион байгуулжээ.

[313] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгуулагын алба хаагчдын англи хэлний мэдлэгийн түвшинг дээшлүүлэх “Гадаад хэл-Мэдлэгийн түлхүүр” дунд хугацааны хөтөлбөр 2020-2023. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны А/42 дугаар тушаал

Сургагч багш нарт суурилан ШШГЕГ-ын харьяа хорих анги, салбар нэгж, газар, хэлтэсүүд нь дотооддоо англи хэлний сургалтын төлөвлөгөө боловсруулан долоо хоногт 8 цагийн сургалтыг зохион байгуулсан байна.

Мөн нийслэл, орон нутаг дахь гадаад хэлний сургалтын байгууллага, Ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, төрийн бус байгууллагын багш нартай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллажээ.

Цаашид англи хэлний ахисан шатны мэдлэг олгох сургалтад анги байгууллага, салбар нэгж тус бүрээс 1 алба хаагчийг сонгон шалгаруулж, суралцуулахаар төлөвлөн ажиллаж байгаа юм. Энэ нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд англи хэлний ахисан шатны мэдлэг бүхий алба хаагч 55 аар нэмэгдэх боломжийг үүсгэж байна.

Үүнээс гадна "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн шинэтгэлийн дунд хугацааны хөтөлбөр"[314]-ийн дөрөвдүгээр зүйлийн 4.1-т "гадаадын зарим улсуудын ижил чиг үүргийн байгууллагуудын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг өөрийн орны хууль тогтоомжтой харьцуулах судлах" гэсэн заалтыг оруулсан байна. Гадаад улсын эрх зүйн актыг судлахад алба хаагчдаас гадаад хэл, англи хэлний мэдлэг зайлшгүй шаардагдах нь дамжиггүй. Энэ бол байгууллагын хөгжлийн цаашдын хандлага англи хэлний мэдлэгтэй салшгүй холбогдож байгааг харуулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дээрх өөрчлөлт, нийгмийн хэрэгцээ, шаардлагын хүрээнд тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа юм.

"Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бодлогын хөгжлийг бэхжүүлэх дунд хугацааны хөтөлбөр 2020-2024[315]"-т "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бодлогын хөгжлийг бэхжүүлэх, хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, судлах, сонгож бэлтгэх, оновчтой байршуулах, тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулах, төлөвшүүлэх, хөгжүүлэх арга замыг боловсруулах цогц

[314] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн шинэтгэлийн дунд хугацааны хөтөлбөр. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөний газрын даргын 2021 оны А/44 дүгээр тушаал

[315] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бодлогын хөгжлийг бэхжүүлэх дунд хугацааны хөтөлбөр 2020-2024. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны А/91 дүгээр тушаал

харилцааг бий болгоход энэхүү хөтөлбөрийн зорилго оршино” гэж тодорхойлсон алба хаагчийн хөгжлийг мөн онцолсон хэрэг мөн.

Тус хөтөлбөрт:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцтэй холбоотой эрх зүйн орчинг нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгох;

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр гадаад, дотоодын сургалт судалгааны байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн, алба хаагчийн мэргэжлийн манлайлал, ур чадвар, хандлагыг хөгжүүлэх зэрэг зорилтуудыг тусгасан байна.

Үр дүнд нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас албан хаагч нийгмийн, олон улсын чиг хандлага, шаардлагад нийцсэн албан хаагч болон хөгжих төдийгүй иргэний эрх, ашиг сонирхолыг хэзээ ч, хаана ч хамгаалах чадвар бүхий, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн орчин үеийн шилдэг боловсон хүчин болон бэлтгэгдэх боломжтой болно.

Энэ тэмүүлэл, зорилготой уялдан Дотоод хэргийн их сургуулийн эрхэм зорилго “Орчин үеийн их сургуулийн жишиг, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн сургалтын хөтөлбөр, багшийн заах арга зүйг сайжруулах замаар сургалтын чанар, үр дүнг дээшлүүлж, захиалагчийн хэрэгцээ, шаардлагыг хангасан цогц чадамж бүхий мэргэжилтэн бэлтгэнэ”[316] гэж тодорхойлсон нь тохиолдын хэрэг биш.

Тус сургуулийн хэрэгжүүлж буй Эрх зүй, Нийгмийн ажил, Аюулгүй байдал судлал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэл бакалаврын хөтөлбөрт тусгагдсанаар Англи хэлний хичээлийг ерөнхий суурь хичээлээр 3 кр цаг буюу 144 цагийн багтаамжтайгаар 1, 2 дугаар дамжаанд нийт 6 кр буюу 288 цагийн багтаамжтайгаар үзэж, судлаж байна.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны сургуулийн үндсэн зорилт нь “Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, хорих болон хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх мэргэжлийн үйл ажиллагааг бие даан болон багаар хэрэгжүүлэхэд шаардлагатай цогц чадамжтай, хүний эрх, хууль, шударга ёсыг дээдэлдэг, эх оронч сэтгэлгээтэй, харилцааны ур чадвартай, албаны ёс зүй, бие бялдар, сэтгэл зүйн бүрэн төлөвшилтэй, мэдлэг, ур чадвараа тасралтгүй дээшлүүлэх хүсэл эрмэлзэлтэй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэрэгцээ,

[316] https://www.uia.gov.mn/listener/9

шаардлагыг хангасан мэргэшсэн албан хаагчийг бэлтгэх юм. Тэгэхээр энэ нь тус сургуулийн зорилт нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын зорилт, тэмүүлэлтэй уялдах нь зүйн хэрэг.

Иймд улс орон, төр засаг, байгууллага, иргэдийн хүлээлт шаардлагад нийцсэн англи хэлний боловсрол бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургууль, багш судлаачдын анхаарах сэдэв мөн болоод байна. Суралцагчдын мэргэжлийн мэдлэг, чадварыг олгох хичээл сургалтаас гадна Англи хэлний мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байгааг нь дурдах нь зүйтэй.

Дүгнэлт

Илтгэлийн хүрээнд дараах дүгнэлтийг хийж байна.

1. Алба хаагчийн хөгжил нь гадаад хэлний мэдлэгээр тодорхойлогддог болоод байна. Хөгжлийг биет зүйлс, техник, технологийн дэвшил төдийхнөөр тодорхойлж болохгүй бөгөөд хүний мэдлэг, боловсролд оршдог.

2. Хууль сахиулах салбарын алба хаагч нь нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ, нийгмийн гишүүдийг манлайлж, боловсрол, мэдлэг, соёлыг түүчээлэн дэлгэрүүлэгч байх ёстой.

3. Англи хэлний боловсрол бол хүний хөгжлийн томоохон шалгуур үзүүлэлт бөгөөд нийгмийн амьдралын бүхий л хүрээний өөрчлөлт, шинэчлэлтийн хурдасгуур болж байдаг зүй тогтолтой тул шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөгжил тус байгууллагын алба хаагчийн боловсрол, гадаад хэлний мэдлэгээр тодорхойлогдоно.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бодлого, стратеги нь алба хаагчийн хөгжил, гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх бодлогыг оновчтой тодорхойлж бие даан хөгжих чадвартай алба хаагчаар эгнээгээ бэхжүүлэхээр заасан нь алба хаагчийн боловсролын шинэ чиглэлийг дэмжих агуулгыг илэрхийлсэн байна.

5. Улс орон, төр засаг, байгууллага, иргэдийн хүлээлт шаардлагад нийцсэн англи хэлний боловсрол бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургууль, багш судлаачдын анхаарах сэдэв мөн болоод байна.

Санал

Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн англи хэлний мэдлэгийн түвшинг дээшлүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь илүү үр дүнд хүргэнэ гэж үзэж байна.

- Алба хаагчийн англи хэлний мэдлэгийг түвшинг нэмэгдүүлэх урт хугацааны хөтөлбөрийг зохион байгуулах,

- Гадаад улсад очиж суралцах боломжийг нэмэгдүүлэж урт богино хугацааны сургалтад суралцуулах, суралцах зардлыг шийдвэрлэх, дэмжлэг үзүүлэх,

- Ажлын ачааллыг тэнцвэржүүлж, англи хэл сурах, сургалтад хамрагдах боломжийг нэмэгдүүлж, сургалтад хамрагдах хугацааг төрийн албаны тасралтгүй байх зарчимтай уялдуулах,

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын захиалгаар тус байгууллагын мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн багш, албан хаагч, сонсогч, суралцагчдын англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх, гадаад болон дотоод урт, богино хугацааны сургалтад хамруулахад ШШГБ хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлэх зэрэг болно.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж:

Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 1992 он. №01

Төрийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2018 он №05

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2017 он. №41

“Алсын хараа-2050” монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого. Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоол.

“Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээ (2022-2025)”. Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 372 дугаар тогтоол.

Үндэсний статистикийн хороо. Хүний хөгжлийн индексийг тооцох аргачлал. УБ хот. 2014 он.

Нэг сэдэвт бүтээл

Лүндэндорж. МУ-ын үндсэн хууль, шинжлэх ухааны тайлбар. УБ., 2023.

Хөтөлбөр, төлөвлөгөө

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгуулагын алба хаагчдын англи хэлний мэдлэгийн түвшинг дээшлүүлэх “Гадаад хэл-Мэдлэгийн түлхүүр” дунд хугацааны хөтөлбөр 2020-2023. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны А/42 дугаар тушаал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн шинэтгэлийн дунд хугацааны хөтөлбөр. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөний газрын даргын 2021 оны А/44 дүгээр тушаал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бодлогын хөгжлийг бэхжүүлэх дунд хугацааны хөтөлбөр 2020-2024. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны А/91 дүгээр тушаал

Тайлан, мэдээ

Үндэсний статистикийн хороо. Хүний хөгжлийн индексийг тооцох аргачлал. УБ хот. 2014 он.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэл-эрх зүй” хөтөлбөрөөр төгсөгчдийн мэдлэг, ур чадварын талаарх ажил олгогчдоос авсан сэтгэл ханамжийн судалгаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургууль. УБ., 2020 он

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэл-эрх зүй” хөтөлбөрөөр төгсөгчдийн мэдлэг, ур чадварын талаарх ажил олгогчдоос авсан сэтгэл ханамжийн судалгаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургууль. УБ., 2020

Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтсийн 2023 оны тайлан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. УБ., 2024 он.

“Монгол улсын боловсролын тогтолцооны суурь хэв шинжүүдтийг тодорхойлж, жишиг загвараар дүрслэх нь" судалгааны ажлын тайлан., УБ., 2023 он

Цахим эх сурвалж

Монгол хэлний их тайлбар толь. http://mongoltoli.mn/

https://dictionary.cambridge.org/dictionary/english/

Статсистикийн мэдээллийн нэгсэн сан. https://www.1212.mn/

https://www.statista.com/

https://www.uia.gov.mn/listener/9

https://montsame.mn/jp/read/339677

СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СЭТГЭЛ ЗҮЙ

THE PSYCHOLOGY OF EDUCATIONAL ACTIVITIES



Б.Дэнсмаа
Дотоод хэргийн их сургуулийн
Сургалт, судалгааны 403 дугаар анги-
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, дэслэгч

Түлхүүр үг: Суралцагчдын сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэх сэтгэл зүйн онолын талаар судлан цаашид багшлах үйл ажиллагаандаа удиртгал болгох онолыг сонгон судалж чиг зорилгоо тодорхойлох.

Товч утга: Боловсролын сэтгэл судлалыг нь мэдлэг, чадвар, туршлага эзэмшүүлэх талаас нь сургалтын, төлөвшил хандлагын талаас нь хүмүүжлийн, үйл ажиллагааны онцлог талаас нь багшлах хөдөлмөрийн сэтгэл зүй гэж ангилдаг. Харин хэрэглэгдэх хүрээгээр нь сургуулийн өмнөх насны, сургуулийн насны, мэргэжлийн боловсролын, дээд сургуулийн гэх салбаруудад хуваадаг. Орчин үед боловсролын сэтгэл зүйн нэг чухал салбар нь мэргэжлийн боловсролын сэтгэл судлал болоод байна. Энэ нь мэргэжил олгох сургалтын үйл явцын сэтгэл зүйн үндсийг судалдаг. Суралцагчдын сэтгэл зүйн тодорхой өөрчлөлтүүд дээр сургалтын үйл ажиллагааны үр дүн оношлогдоно. Сэтгэл судлалын судалгааны арга зүй нь сургах зүйн судалгааны зорилтуудыг шийдвэрлэх үндэс болж байдаг. Сэтгэл судлал нь сургалт, бие хүний төлөвшлийн мөн чанар, зүй тогтлыг судалдаг суурь ухаан юм. Харин боловсролын сэтгэл судлал нь бие хүнийг сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд сэтгэл судлалын ухааныг үр дүнтэйгээр хэрэглэх зорилго бүхий хавсарга ухаан болно. Боловсролын сэтгэл судлалд анхаарал татсан өөр нэг чухал асуудал бол сургалт ба хөгжлийн хоорондын харьцаа юм.

Summary: Educational psychology is classified as learning from the aspect of acquiring knowledge, skills, and experience, educational psychology from the aspect of maturity, and teaching psychology from the specific aspect of activity. According to the field of application, it is divided into preschool, school age, professional education, and higher education sectors. Nowadays, one of the important branches of educational psychology is the psychology of professional education. It examines the psychological basis of the vocational training process. The results of educational activities are diagnosed based on specific psychological changes of students. The methodology of psychological research

is the basis for solving the objectives of pedagogical research. Psychology is a basic science that studies the nature and patterns of learning and human development. But educational psychology is an applied science with the goal of effectively applying psychology to the educational activities of individuals. Another important issue in educational psychology is the relationship between learning and development. A person is constantly learning, but may not always see significant progress. In this case, the subject of the educational process will be the development of personality, intelligence, and talent. According to this, the goal of educational psychology is not only to determine the psychological basis of educational organization, but also to determine the psychological basis of goal-oriented development of a person. Educational psychology should not be considered as a passive combined branch of knowledge that introduces the already achieved achievements of psychological science into educational practice, but rather as a major independent branch of knowledge with its own unique methods and research infrastructures. Learning theory develops the laws that govern the development of the individual during the learning process.

Key words: To study the psychology of students and the theory of educational psychology, to select the theory that will serve as an introduction to further teaching, and to clarify the purpose

Хүн тасралтгүй сураад байдаг боловч тэр болгон мэдэгдэхүйц хөгжил харагдахгүй байх нь бий. Энэ тохиолдолд сурган хүмүүжүүлэх үйл явцын судлагдахуун нь бие хүн, оюун ухааны хөгжил, авьяас чадвар болно. Үүнээс үзэхэд боловсролын сэтгэл судлалын зорилт нь сургалтын зохион байгуулалтын сэтгэл зүйн үндэс төдийгүй хүнийг зорилго чиглэлтэйгээр хөгжүүлэхийн сэтгэл зүйн үндсийг тодорхойлох явдал юм. Боловсролын сэтгэл судлал нь зөвхөн сэтгэл судлалын шинжлэх ухааны нэгэнт хүрсэн ололт амжилтыг сургалтын практикт нэвтрүүлдэг идэвхгүй хавсарсан салбар ухаан гэж үзэж болохгүй бөгөөд харин ч өөрийн өвөрмөц арга, судлагдахуун дэд бүтцүүдтэй биеэ даасан томоохон салбар ухаан юм. Сургалтын онол нь сургалтын явцад бие хүний хөгжлийг удирдах хуулийг боловсруулдаг

ҮНДСЭН ХЭСЭГ

“Сурахуй” нь тодорхой мэдлэг, чадвар туршлага эзэмших зорилго бүхий ухамсарт үйлдлээр удирдагдаж буй хүний өвөрмөц үйл ажиллагаа юм. Энэ нь хүнээс өөрийн үйлдлээ ухамсартайгаар зохицуулах чадварыг шаарддаг. Мөн танин мэдэхүйн процесс (ой, төсөөлөл, зохион бодохуй, сэтгэхүйн уян хатан чанар), зоригийн чанаруудыг (анхаарал, мэдрэмжээ удирдах гэх мэт) шаарддаг.[317]

[317] Жавзан.Б, Энхбаяр.Б., Боловсролын сэтгэл судлал, “Ган принт” ХХК, 2009, хуудас 50

Суралцахуйг учрыг нь бүрэн тайлаагүй, үл мэдэх хар хайрцагтай зүйрлэж болох бөгөөд хайрцаг дотор чухам юу болдгийг суралцахуйн талаарх онол сургаалууд өөр өөрийнхөөрөө тайлбарладаг.

Сурах үйл ажиллагааны онолыг үндэслэгч нь Л.С. Выготский онол:

Сурах үйл ажиллагааг тэрээр **аливаа хүн төрөлхтний хуримтлуулсан түүхэн соёлыг эзэмших замаар сэтгэцийн шинэ хөгжлийн түвшнийг бий болгох өвөрмөц үйл ажиллагаа гэж үзсэн**. Иймд хөгжлийн эх үндэс хүүхдэд өөрт нь биш, харин мэдлэг олж авах арга замуудыг эзэмшихэд чиглэгдсэн тэдний сурах үйл ажиллагаанд оршино гэж үзжээ. Энэ онолын үндсэн ойлголтууд нь:

- Сургалт бол түүний аргуудын зохион байгуулалтын тогтолцоо. Энэ үйл ажиллагааны зорилго нь хувь хүний сэтгэцийг зорилго чиглэлтэйгээр хөгжүүлэх явдал юм.
- Сурах үйл ажиллагаа нь тодорхой мэдлэг, чадвар, туршлага эзэмших зорилго бүхий субъектийн өвөрмөц танин мэдэхүйн үйл ажил лагаа болно.
- Эзэмшихүй нь сурах үйл ажиллагааны хамгийн гол хэсэг бөгөөд хувь хүн дээр нийгмийн туршлага чадвар, хандлага болон төлөвших үйл явц юм.

Сургалтын хамгийн чухал зүйл нь **хэрэгцээ сэдэлжилтийн** тал байдаг. Танин мэдэхүйн хэрэгцээ нь нэг талаас сурахуйн урьдчилсан нөхцөл, нөгөө талаас **сэдэл** төлөвшсөний үр дүн мөн. Иймд сурах үйл ажиллагааг танин мэдэхүйн сэдэлжилт төлөвших үйл явц ч гэж үзэж болно. Сургах үйл явцын нөхцөл нь бие хүний хэрэгцээ, сонирхлыг хүрээ, түүний бүтцийг өөрчилж маш зөв зүйтэйгээр зохион байгуулсан цагт жинхэнэ ёсоороо хөгжинө.

Хоёр дахь тал нь сурах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсгүүд. Аливаа үйл ажиллагаа нь өөрийн гэсэн судлагдахуунтай байна. Сурах үйл ажиллагааны судлагдахуун нь янз бүрийн шинжлэх ухааны мэдлэг, туршлагын цогц юм. Сурах явцад энэ үйл ажиллагааны субъект болсон суралцагч бие хүний хувьд өөрчлөгддөг.

Сурах үйл ажиллагааны явцад хүн зөвхөн мэдлэг, чадвар, туршлагыг эзэмшээд зогсохгүй сурах чадварыг өөртөө төлөвшүүлдэг. Сурахуй нь хүний танин мэдэхүйн хэрэгцээг хангаж байдаг. Хэрвээ суралцагчид танин мэдэхүйн хэрэгцээ байхгүй л бол тэрээр хэзээ ч сурахгүй, түүнд танин мэдэхүйн шинэ хэрэгцээ бий болохгүй. Иймд сурахуй нь хэзээ ч үйл ажиллагаа байж чаддаггүй, хэзээ ч суралцагчийн хэрэгцээг хангаж чаддаггүй. Зөвхөн завсрын зорилтуудыг л агуулдаг. Хамгийн гол нь суралцагч сурах үйл ажиллагаанаас баяр баясгалан олж авч чаддаг байх нь чухал. Сурахуйн хамгийн гол зорилго нь нийгмийн туршлагыг эзэмших явдал юм.

Хөдөлмөрийн үйл ажиллагаа нь нийгэмд ач холбогдолтой, хүмүүст шаардлагатай ямар нэгэн бүтээгдэхүүнийг бий болгоход чиглэгддэг. Сурах үйл

ажиллагааны бүтээгдэхүүн нь хүний өөрийнх нь өөрчлөлт юм. Хүн шинэ мэдлэг эзэмшсэнээр өөрийгөө өөрчилдөг. Үйл ажиллагааны бүтээгдэхүүн нь шинэ танин мэдэхүйн боломж, шинэ практик үйлдлүүд юм.

Сурах үйл ажиллагаа нь суралцагчийг бие хүний хувьд хөгжүүлэх, төлөвшүүлэх, нийгмийн эерэг туршлагуудыг эзэмшүүлэх, танин мэдэхүй ба онол практикийн үйл ажиллагааг хөгжүүлэхэд чиглэгдэнэ.

Сурахуй нь танин мэдэхүйн хэрэгцээг хангахад чиглэгддэг. Танин мэдэхүйн үйл ажиллагаа нь сурахуйгаас гадна судалгаа шинжилгээний ажлаар хангагдаж болно. Сурахуй нь танин мэдэхүйн хэрэгцээг хангахад чиглэгдсэн үйл ажиллагааны нэг төрөл юм. Судалгаа шинжилгээний ажил нь зөвхөн танин мэдэхүйн хэрэгцээг хангахад чиглэгдэхгүй, мөн нийгэмд урьд илрээгүй шинэ танин мэдэхүйг бий болгодог. Сурах үйл ажиллагаа нь хийсвэрээс тодорхой руу, ерөнхийгөөс хийсвэрлэл рүү чиглэдэг.

Багш сургалтыг амжилттай явуулахын тулд суралцагчийнхаа онцлогийг сайтар мэдэж байх ёстой. Ялангуяа, мэдээллийг хүртэх, тогтоох, сэргээн санах, зорилтыг шийдвэрлэх, мэдрэхүйн онцлогийг сайн мэдэж байх нь чухал. Оюун ухааны аливаа үйл ажиллагаанд зайлшгүй мэдрэхүйн эрхтний оролцоо байдаг. Суралцагч лекц унших эсвэл сонсох, лабораторийн хичээлийн үед ажиглалт хийх зэрэг нь юуны өмнө сэрэл, хүртэхүйн үйл ажиллагааг шаарддаг бөгөөд үүний үндсэн дээр тогтоох, сэргээн санах, зүй тогтлыг нь олох, ухаарах, бүтээлч үйл ажиллагаа хийгдэнэ.

Амжилттай сургалтын сэтгэл зүйн томьёоллыг дараах байдлаар томьёолж болно. **С + 4Х + Т.М** гэдэг нь сэдэлжилт буюу өдүүлбэр, 4Х нь дөрвөн бүрэлдэхүүнтэй.

Үүнд: 1Х мэдээллийг хайх арга,

2х мэдээллийг ойлгох,

3Х мэдээллийг тогтоох,

4Х мэдээллийг хэрэглэх,

Т.М - тогтолцоот мэдлэг. Сэдэл нь суралцагчийг сургалтын зорилгод

хөдөлгөгч тэдний дотоод хүч юм. Сэдэлжилт нь гадаад ертөнцийн юмс үзэгдэл, төсөөлөл, үзэл баримтлал, мэдрэмж, үг яриа байж болно. Сэдэлжилтийн тухай ойлголт нь дотроо сэдэл, хэрэгцээ, сонирхол, эрмэлзэл, зорилго, дур хүсэл гэх мэт хүний үйл ажиллагааг нөхцөлдүүлэгч хүчин зүйлсийг агуулдаг. Сэдэлжилт нь 4 бүрэлдэхүүнийг агуулна. Үүнд:

- өөрийн үйл ажиллагаанаас ханамж авах
- бие хүний хувьд үйл ажиллагааны үр дүн нь ач холбогдолтой байх.
- үйл ажиллагааны төлөөх шагнал урамшуулал
- бие хүнд хүчээр тулган хүлээлгэлт

Сэдлүүд нь гадаад ба дотоод шинжтэй байж болно. Гадаад сэдэлд шагнал, шийтгэл, шаардлага, заналхийлэл, материаллаг үр ашиг, бүлгийн дарамт, ирээдүйд

хүрч болох баялаг гэх мэт байна. Энэ тохиолдолд мэдлэг ба чадвар нь өөр бусад зорилгоо биелүүлэх хэрэгсэл болдог байна.

Сурахуй нь ямагт хүчилсэн шинжтэй байдаг. Дотоод сэдэл нь хүний сурах дотоод хүсэл эрмэлзэлтэй холбоотой байдаг. Танин мэдэх сонирхол нь гурван үе шатаар явагддаг.

1. нөхцөл байдлыг танин мэдэх сонирхол (энэ нь тодорхой бус, шинэ нөхцөл байдалд үүсдэг).

2. үйл ажиллагааны тодорхой бодит агуулгыг тогтвортойгоор сонирхох

3. танин мэдэхүйн сонирхол нь бие хүний ерөнхий чиглэл болох, түүний амьдралын зорилго, төлөвлөгөөтэй холбогдох. Танин мэдэхүйн үйл ажиллагааг идэвхжүүлэх хамгийн үр нөлөөтэй арга бол суралцагчдыг идэвхжүүлсэн идэвхтэй сургалт.

Танин мэдэхүйн сэдэлжилт нь асуудал бүхий нөхцөлд үүсдэг. Танин мэдэхүйн сэдэлжилт үүсэж бий болох, цаашаа хөгжих нь багш суралцагч, суралцагч хоорондын харилцан үйлчлэлийн үр дүн байдаг. Оюутны танин мэдэхүйн сэдэлжилтийн хөгжил нь ихэнхдээ багшийн сурган хүмүүжүүлэх ур ухаан, суралцагчийн үйл ажиллагааг зохион байгуулах чадвар, тэднийг танин мэдэхүйн үйл ажиллагаанд өдөөх чадвар зэргээс хамаардаг.

Сэдэлжилтийн талаарх зөв ойлголт нь багшийн бүтээлч үйл ажиллагааны үндэс юм. Туршлагатай багш суралцагчийн танин мэдэхүйн сэдэлжилтийг зорилго чиглэлтэйгээр хөгжүүлж чаддаг. Тэдэнд өвөрмөц сэдэлжилтийг бий болгохдоо өвөрмөц оюуны зорилтыг шийдвэрлүүлэх. гэхдээ мэдлэгийг бэлнээр өгөхгүй байх, энгийн хялбар мэдээлэл өгөхгүй байх, эсвэл тушаан зандрахаас зайлсхийх нь зүйтэй.

Мэдээллийг хүлээж авах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд суралцагчийн мэдрэхүйн эрхтний онцлогийг мэдэж байх нь чухал. Тухайлбал, хараан, сонсголын мэдрэмж гэх мэт. Харааны сэрлийн тусламжтайгаар хүн мэдээллийн ихэнхийг авдаг. Энэ нь харааны сэрлийг бий болгоно. Харааны сэрлийн эрхтэн нь харааны анализатор юм. Судалгаанаас харахад, хүний гэрлийг болон юмсын зааг ялгааг харах чадвар нь үзүүлж буй юмсын фоноос (дэвсгэр болж буй юмс) их шалтгаалдаг.

Америкийн сэтгэл судлаачид хүн самбарын баруун дээд өнцөгт бичигдсэн мэдээллийг илүү сайн тогтоодог болохыг тогтоосон байна. Үүний 33 хувь нь бидний анхааралд оршдог. Харин зүүн дээд буланд бичигдсэн зүйлс нь 28%, баруун доод буланд 23%, зүүн доод буланд 16% тай тогтоогддог байна.



Уншиж буй мэдээллийг хүртэх (ойлгох) нь текстийн (мэдээллийн) хялбар байдал, хуудсан дээрх байрлал, хэлбэр, өнгө (жишээ нь, текст, хүснэгтэн дэх

баганын өргөн нарийн, текстийн том жижиг, төлөвлөгөөтэй эсэх, цаасны өнгө, хэвлэсэн байдал, өнгөний фон гэх мэт) зэргээс шалтгаална.

Цагаан фон дээр хар шрифтээр бичсэн текст уншигдах нь илүү хялбар байна, харин цагаан фон дээр шараар бичвэл төвөгтэй байна. Ер нь ямар ч өнгийн дэвсгэр дээр хар шрифт зохимжтой байдаг.

Өнгө хүний сэтгэцэд болон мэдээллийг хүлээж авахад их нөлөөтэй. Мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар, бие биетэйгээ зохицдог өнгөний гурван хослол байдаг. Үүнд: улаан ногоон, шар хүрэн, цэнхэр - улбар шар. Улаан үсгээр ногоон дэвсгэр дээр, харин ногооноор улаан дэвсгэр дээр бичих нь зохимжтой байна. Ногоон болон хөх өнгө нь сангвиник болон холерик хэв маягийн хүмүүсийг тайвшруулдаг бол флегматикуудыг улам нойрмог идэвхгүй байдалд оруулдаг, меланхоликуудыг улам зожиг байдалд хүргэдэг байна. Улаан өнгө нь мэдрэлийн системийг цочроох үйлчилгээтэй.

Судалгаанаас харахад, хүн мэдээллийн 15%-ийг бичгийн хэлбэрээр, 25%-ийг харааныхаа тусламжтайгаар тогтоодог байна. Хэрвээ мэдээллийг дамжуулахад энэ хоёр арга хоёулаа нэгэн зэрэг хэрэглэгдэж байгаа бол хүн мэдээллийн 65 хүртэл хувийг хүртэж чадна. Иймд сургалтад телевизор, компьютер зэргийг ашиглах нь тохиромжтой.

Сэтгэл зүйч Б.Г.Ананьев онол:

Харааны хүртэхүй нь гурван түвшинд явагд- даг гэж үзсэн.

1. сэрэл

2. хүртэхүй

3.төсөөлөл. Харин сонсголын систем нь нэг түвшинд явагдана. Зөвхөн төсөөллийн түвшинд. Иймд мэдээллийг унших нь сонсохоос илүү ач холбогдолтой байдаг байна. Сонсож буй мэдээллийн 20% нь тогтоогддоггүй.

Мэдээллийг хүртэхэд сэтгэхүйн хэв маяг маш чухал. Нейропсихологичдын судалгаанаас харахад, хүмүүсийн 48%-нь мэдээллийг логик сэтгэхүйн аргаар, 52%-нь дүрслэх сэтгэхүйн аргаар хүлээж авдаг байна. Ихэнх сэтгэл зүйчдийн үзэж байгаагаар, хүн ямар нэгэн мэдээллийг ойн тойндоо хадгалах нь хүртэгдэж байгаа ертөнц, сэтгэхүйн хэв маягтай нь салшгүй холбоотой.

Логик сэтгэхүйтэй хүмүүсийг үндсэн 2 категорид хувааж болно.

1. онолын сэтгэхүйтэй.

2. эмпирик сэтгэхүйтэй.

Онолын сэтгэхүйтэй хүн юмсыг тогтоохдоо дотоод зүй тогтол мөн чанараар нь тогтоодог бол практик (эмпирик) сэтгэхүйтэй хүн бодитоор нь тодорхой баримтыг тогтоодог байна. Судлаачид материалыг хэдэн өдөр, хэдэн долоо хоног, 20 сарын дараа асуухад онолын сэтгэхүйтэй хүмүүс хийсвэр материалыг 20 сарын дараа ч сайн санаж байсан байна.

Практик сэтгэхүйтэй хүмүүс тодорхой баримт, тодорхойлолтуудыг санаж байв. Ийм хүмүүс онолын сэтгэхүйтэй хүмүүсийг бодвол текстийг нь ерөнхийд нь их бага ямар нэг хэмжээгээр санаж байжээ. Сэтгэл зүйчид суралцагчдын онолын сэтгэхүйг хөгжүүлэхэд анхаарах хэрэгтэй гэж онцлон үздэг.

Суралцагч мэдээллийг ойлгох нь багш мэдээллийг хэрхэн дэс дараалал зохион байгуулалттай өгч байгаагаас их шалтгаалдаг. Мөн багш тохирсон жишээ авах, түүнийгээ онолтой холбож өгөх нь хамгийн чухал.

Ухамсарлаж мэдэхгүйгээр ойлголт явагдахгүй. Аливаа сурахуйн хамгийн чухал бүрэлдэхүүн нь цээжлэлт байдаг. Суралцагч сургалтын материалыг эзэмшихэд чиглэгдсэн үйлдлийн цогцыг цээжлэлт гэнэ. Цээжлэх анхны нөхцөл бол зайлшгүй таньж мэдэх ёстой гэдгийг ухамсарлах явдал юм. Бие хүний шилэн сонголтод установка маш чухал байдаг.

Сурахуйн үр дүн нь зөвхөн эдгээр субьектив хүчин зүйлээс хамаарахгүй (судлагдахуунд хандаж буй субъектийн хандлага) мөн объектив хүчин зүйл буюу тухайн судалж буй материалын шинжээс их хамаардаг.

- *Сургалтын материалын агуулга* - Цээжилж буй зүйл нь баримт мэдээ, ойлголт, чадвар эсвэл туршлага байж болно. Цээжлэх гэж буй материал ямар хэв маягийнх байна вэ? ямар түвшинд цээжлэх ёстой вэ? гэдгээс сургалтын арга шалтгаална.
- *Сургалтын материалын хэлбэр* - Материал нь бодит зүйлс, үйл ажиллагааны тодорхой төрлөөр гүйцэтгэгдэх ахуй амьдралын шинжтэй байж болно, нөгөөтэйгүүр сургалтын даалгавар байж болно. Иймд сургалтын материалын хэлбэр нь бодит, загварчилсан, хэл ярианы, тэмдгийн (символ) хэлбэртэй байж болно.
- *Сургалтын материалын төвөгтэй байдал* - Энэ нь цээжлэлтийн үр дүн, хурдан, зөв байдалд их нөлөөтэй. Төвөгтэй шинэ материалыг цээжлэх нь суралцагчийн туршлага, мэдлэг, чадвараас их шалтгаалдаг. Суралцагч хэдийчинээ их туршлага, мэдлэг, чадвартай байна тэр хэмжээгээр цээжлэлт хялбар, үнэн зөв, хурдан явагдана.
- *Сургалтын материалын ач холбогдол* - Тодорхой мэдээ эсвэл үйлдэл нь суралцагчийн хувьд эсвэл дараагийн материалыг эзэмшихэд чухал байж болно. Энэ тохиолдолд цээжлэлт хурдан яваг- дана. Мөн бие хүний тодорхой зан төлөвийн шинж төлөвшихөд чухал байж болно. Материал нь танин мэдэхүйн, практик, ёс суртахууны, урлаг уран сайхны, нийгмийн, хүмүүжлийн ач холбогдол өндөртэй байна.
- *Ухаарагдсан байдал* - Ажиглалт туршилтаас харахад ухаарагдсан материал цээжлэгдэх нь илүү хурдан байдаг байна. Нөгөөтэйгүүр алдаа багатай, удаан хугацаанд, бүрэн хадгалагддаг байна.

Аливаа материалыг цээжлэхдээ түүнийг бүтцэд нь авч үзэх, логик холбоог нь гаргах нь чухал байдаг. Сургалтын материалын сэтгэл хөдлөлийн онцлог цээжлэхэд гол хүчин зүйл болдог. Материал нь хүний сэтгэлийг татсан, тодорхой сэтгэл мэдрэмжийг агуулсан байвал тогтоогдохдоо хурдан.

2. СУРГАЛТЫН СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ СЭТГЭЛ ЗҮЙН ҮНДЭС

Сургалтын сэтгэл зүй нь сургалтын явцад дахь суралцагчдын сэтгэцийн үйл ажиллагааг судалдаг. Иймээс сургалтын ерөнхий ба тусгай сэтгэл зүй гэж

ангилах нь бий. Сургалтын ерөнхий сэтгэл зүй нь сургалтын ерөнхий онол арга зүйтэй, сургалтын тусгай сэтгэл зүй нь аль нэг хичээлийн заах арга зүйтэй холбоотой гэж хандах тал байдаг. Ер нь сургалтын сэтгэл зүйн нэг гол асуудал нь сургалт ба хүүхдийн хөгжлийн хамаарал байдаг. Судлаачид хүүхдийн хөгжил сургалтаас хамаарна, хамаарахгүй, сургалт хүүхдийн хөгжлийн араас явна, сургалт хүүхдийн хөгжлийг араасаа дагуулна гэх зэргээр хандаж ирсэн.[318]

Сэтгэл судлалын нэг салбар болох сурган хүмүүжүүлэх сэтгэл судлал нь хүний сурах, хөгжих, төлөвших үйл ажиллагаатай холбоотой илрэх сэтгэцийн өөрчлөлт хөгжлийн асуудлыг судлан тодорхойлно. Сурган хүмүүжүүлэх сэтгэл судлал нь тодорхой үйл ажиллагаа, хөгжил, харилцааг авч үзэхдээ боловсролын салбарын хүрээнд судалдаг.

Сургалт нь зорилго, чиглэл, зохион байгуулалттай боловсрол эзэмших, эзэмшүүлэх багш, суралцагчдын хамтын ажиллагаа. Хүмүүжил нь бие хүний хөгжил, төлөвшилд зорилго, чиглэл, зохион байгуулалттай нөлөөлөх үйл явц. Өөрөө хүмүүжих гэдэг нь хүн ухамсар, төлөвлөгөөтэйгөөр санаа бодлоо төгөлдөржүүлэх, сул талаа багасгаж арилгах явдал. Өөрөө боловсролоо дээшлүүлэх гэдэг нь хүн ухамсар, төлөвлөгөөтэйгөөр мэдлэг, чадвараа чанарын дээд түвшинд гаргахыг хэлнэ.

Суралцагчдын хөгжил нь бие хүн ба үйл ажиллагааны субъект болохын хувьд:

1) оюун ухаан,

2) сэтгэл хөдлөлийн хүрээ,

3) аливаа түгшүүр бүхий нөхцөл байдалд тогтвортой байх,

4) өөртөө итгэх итгэл, өөрийгөө хүндлэх хүндлэл,

5) ертөнцийн юмс үзэгдэл болон бусдын гаргаж буй шийдвэрт хүндэтгэлтэй, эергээр хандах хандлага,

6) бие даасан байдал,

7) өөрийгөө идэвхжүүлэх, хөгжүүлэх чиглэлүүдээр явагдах ёстой. Сурах сэдлийн хөгжил нь өөрийн хөгжлийн сэдлийн хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг болно.

Сурах чадвар нь шинэ мэдлэг, шинэ үйлийн системийг эзэмшихэд чиглэгдсэн танин мэдэхүйн янз бүрийн төрлүүдээс бүрддэг. Эдгээр нь танин мэдэхүйн хэрэгсэл болно.

Сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны агуулга ба сэтгэл зүй нь нийгмийн хүчин зүйлүүдээс шалтгаална, өөрөөр хэлбэл, нийгэм дэх байр суурь, багшид тавигдах нийгмийн шаардлага, нийгэм сэтгэл зүйн нөлөөллүүд, бие хүний хувьд түүний үйл ажиллагаанаас болон багшаас хүлээх нийгмийн хүлээлтүүд, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны хүрээнд илрэх тогтсон хандлагууд зэрэг нь тухайн

[318] Даваа.Ж, Сурган хүмүүжүүлэх зүй, “Соёмбо принтинг” ХХК, 2014, хуудас 145

үеийн нийгмийн байдлаас шууд шалтгаална.

Сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны сэтгэл зүйн бүрэлдэхүүн талуудыг авч үзвэл:

Бүтээх тал. Багшийн ажлын ихэнх нь хичээлийн зохион байгуулалт, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, хичээлийн хэрэглэгдэхүүний бэлтгэл, сургалтын төлөвлөгөөнд нийцсэн сурах бичиг боловсруулах зэрэгт зарцуулагдана. Энэ бүх ажил нь хичээлийн төлөвлөлт, бичиг баримтад туссан байдаг. Сургалтыг идэвхжүүлэх эрчимжүүлэх арга замыг эрж хайх асуудал нь мөн энэ хэсэгт хамаарагдана.

Зохион байгуулалтын тал. Сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны нэг чухал хэсэг бол зохион байгуулалтын үйл ажиллагаа байдаг ба бүтээх бүрэлдэхүүн хэсэгтэйгээ нэгдэн нэг санааг агуулж байдаг. Хичээлийн туршид багшийн төлөвлөсөн төлөвлөлт нь тухайн хичээлийг бүхэлд нь зохион байгуулах чадвар, зохион байгуулалт хүмүүжлийн үйл явцтай уялдах ёстой. Зөвхөн энэ тохиолдолд л сурагчид мэдлэгээр цэнэглэгдэнэ. Зохион байгуулалтын бүрэлдэхүүн нь гурван чиглэлтэй байдаг: хувийн зохион байгуулалт, хичээл дээрх өөрийн зан үйлд тулгуурласан зохион байгуулалт, хүүхдийн үйл ажиллагааны зохион байгуулалт. Багш нь сурагчийн танин мэдэхүйн хүрээг байнга идэвхжүүлж байдаг, хэрвээ багш зөвхөн үйл ажиллагааны зохион байгуулах нэг хэсэгт анхаарал хандуулан жишээ нь: өөрөө зохиосон зохион байгуулалт нь сайн, сургалтын материалыг чадварлаг сонгосон, үгэн харилцаа ба хичээлийн хэрэглэгдэхүүний сонголт сайн, гэвч хүүхдүүдийг идэвхтэй оюуны үйлд сэдэлжүүлээгүй тохиолдолд хичээл нь зөвхөн сэргээх шинжтэй болж хувирах ба хүүхэд мэдлэг гүйцэт авах боломжгүй байна. Энэ нь хичээлийг зохион байгуулах бусад бүрэлдэхүүнд хамаардаг.

Харилцааны тал. Энэ хэсэг нь багш нараас суралцагчид, эцэг эхчүүд, сургуулийн захиргаатай харилцах харилцааг дэмжих үйлийг өөртөө багтаадаг. Тодруулбал багшаас сурагчид хандах хандлага нь бүтээх ба зохион байгуулалтын үйл ажиллагааны сургалтын явц дах сэтгэл хөдлөлийн эерэг байдлыг хангадаг. Багшаас сурагчид хандах сэтгэл хөдлөлийн дараах хэв маягууд байдаг: **эерэг сэтгэл хөдлөл-идэвхтэй, эерэг сэтгэл хөдлөл-идэвхгүй, сөрөг сэтгэл хөдлөл-идэвхтэй, сөрөг сэтгэл хөдлөл-идэвхгүй, тэнцвэргүй.** Бүлэг дэх хүүхдүүдийн харьцаа хандлага нь ихэнх тохиолдолд багшийн зан үйлээс үүдэлтэй сэтгэл хөдлөлийн аль хэв маягт байгаагаас шалтгаалдаг байна. Хэрвээ багшийн хувьд сэтгэл хөдлөл нь тогтворгүй харагдсан, сурагчид сөрөг хандлагатай байвал багш уян хатан байна. Бүлэг хамт олон бухимдалтай, бие биедээ хандах хандлага нь жигд эерэг биш байхад хүүхдийг үндэслэлгүй магтах зэрэг харилцаа нь оновчгүй юм. Сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны харилцааны тал нь сурган хүмүүжүүлэх үйлийн явцад илрэн гарч байдаг. Хувь хүний зүгээс илрэх өөрийн хандлага нь харилцаанд хүний үйл ажиллагааны нэг талын субъект болохынхоо хувьд тухайн ажлын амжилтад чухал нөлөөтэй. Багш сурагчийн онцлогийг олж хардаг байх, саад болох эсвэл туслах хэлбэрээр хариу үйлдэл үзүүлэх.

А.И.Щербаков дээрх ангиллаас гадна сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны сэтгэл зүйн хүчин зүйлүүдийг тодорхойлсон байдаг. [319]

Сургалтын сэтгэл зүйн өөр нэг асуудал нь сургалт зохион байгуулахдаа сурагчдын нас, сэтгэл зүйн онцлогийг харгалзах, ажил хэрэгч нөхөрсөг уур амьсгал бүрдүүлэх, багш өөрөө сэтгэл зүйн хувьд тайван тогтвортой бүтээлч, эрч хүчтэй, өөдрөг үзэл хандлагатай, хүмүүнлэг байх харилцаа юм.

3. СУДАЛГАА

Судалгаанд Дотоод хэргийн их сургуулийн Сургалт, судалгааны 403 дугаар анги- Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн 1-ээс 3 дугаар дамжааны 51 суралцагч хамрагдав.

Дамжаа	Хамрагдсан тоо	Хувь
512	12	23.5
522	20	39.2
532	19	37.3
Нийт	51	100

Судалгааны асуулт нь дээр 3 дамжааны суралцагч анги дотроо хэрхэн сэтгэл ханамжтай байдаг талаар 10 асуулттай судалгаа хийсэн.





[319] Багшийн сурган хүмүүжүүлэх харилцааны сэтгэл зүй | Володягийн Оюумаа (legaldata.mn)

Судалгааг SPSS программ дээр нэгтгэсэн.Судалгаанаас дүгнэхэд 1 дүгээр дамжааны суралцагч нар хамт олон, хоорондын харилцаан ойлголцол муу байна. 2 дугаар дамжааныхан нөхөрлөн нийтэж, бие биеэ ойлгох сэтгэлтэй болж чадаж байна.

ДҮГНЭЛТ

Сургалтын сэтгэл зүйн үүргийг тодорхойлохдоо онолын чиг хандлага, системчилсэн хяналтыг судлан үзэхийн зэрэгцээ Их сургуулийн сургалтын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа баримт бичиг, сургалтыг зохион байгуулах, удирдан чиглүүлэх чиг үүрэг бүхий алба хаагч болох багшийн ажлын байрны тодорхойлолтод тулгуурлан эрх зүйн баримт бичгийн хүрээнд сургалтын судлан үзсэнийг дурдах нь зүйтэй.

Боловсрол нь бие хүний амьдрах чадавхыг нөхцөлдүүлэгч гол хүчин зүйл гэдгээрээ дэлхийн хүн төрөлхтний нэгдмэл үнэт зүйл юм. Энэ нь угтаа хүн амьдралдаа зөв үйлдэл хийхийн үндэс суурь байдаг. Чанартай боловсролын үндэс нь сэтгэл зүйн шинжлэх ухааны үндсэн ойлголт, онолууд бөгөөд боловсролын менежментийн нэг чиглэл нь бие хүн мэдлэг, чадвар, туршлага эзэмшихүйн сэтгэл зүйн мөн чанарыг удирдан залах явдал юм.

Хүн өөрийнхөө бүтээлч үйл ажиллагаагаар хөдөлмөрлөн сурч мэдлэгээ өөрөө бүтээдэг гэдэгтэй судлаач миний бие санал нэгдэж байгаа тул багш мэргэжлээр ажиллахдаа дараах зарчмуудыг удирдлага болгохоор сонголоо. Үүнд:

Суралцагчийн сурах сэдэлд нөлөөлж, сэтгэн бодох чадвар, байгалийн сониуч занг нь идэвхжүүлэх;

Суралцагчдын соёл болон нийгмийн орчны ялгааг тооцож сурах үйлийг илүү үр дүнтэй зохион байгуулах;

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Жавзан,Б., Энхбаяр,Б., (2009) Боловсролын сэтгэл судлал. Улаанбаатар:Ган принт.
2. Мягмар,О., Оюунгэрэл,С., Дэлгэрмаа,Д., Тунгалаг,О., (2023) Боловсролын сэтгэл судлал. Улаанбаатар: “Арвайбархан”ХХК.
3. Даваа,Ж., (2014) Сурган хүмүүжүүлэх зүй. Улаанбаатар: “Соёмбо принтинг”ХХК.

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СЭТГЭЛ ЗҮЙН АСУУДАЛ

PROFESSIONAL EDUCATION OF MILITARY OFFICERS, PSYCHOLOGICAL PROBLEMS



Я.Ариунболд:
Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Хилийн албаны удирдлага, стратегийн профессорын багийн профессор, хурандаа

Товч агуулга: Эх орон, үндэс угсаагаа тэргүүн зэрэгт тавьж, түүнийг хайрлах, хамгаалах ухамсар санаачилгатай монгол хүнийг үе шаттайгаар төлөвшүүлэн бэлтгэх нь төрөөс боловсролоор дамжуулан ард иргэдээ соён гэгээрүүлэх үйл явц хэмээн ойлгож, энэхүү үйл хэргийг "Батлан хамгаалах боловсрол" гэсэн нэгдмэл тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлэх боломжтой гэж үзэн батлан хамгаалах боловсролын сургах зүй болон сэтгэл зүйн үндсийг сурган хүмүүжүүлэх ухаан, цэргийн удирдахуйн ухаан, сэтгэл судлалын ухааны уулзвар зааг дээр судлан тодорхойлсныг өгүүлэлд товчлон авч үзэв.

Abstract: The state understands the process of educating the people through education to prepare Mongolians who put their motherland and ethnic group first, and who have the initiative to love and protect it, and believe that this task can be implemented through a unified system called "Defense Education". In the article, the pedagogy and psychological foundations of defense education were studied and defined at the intersection of pedagogy, military management, and psychology.

Түлхүүр үгс: Батлан хамгаалах боловсрол, цэргийн сэтгэл зүй, батлан хамгаалах нэгдмэл тогтолцоо, цэргийн анги, салбар, цэргийн сургалт.

Key words: Defense Education, Military Psychology, Defense Integrated Command, Military Units, Branches, Military Training.

ОРШИЛ

Боловсрол нь нийгмийн хөгжил, хүмүүсийн оюуны хэрэгцээтэй уялдан байнга хөгжиж байдаг нарийн нийлмэл тогтолцоо бүхий үйл явц юм. Шинэ зууны хөгжлийн хөдөлгөгч хүчин зүйл нь нийгмийн иргэн төлөвшүүлэх боловсрол, түүний агуулга болон арга зүйтэй салшгүй холбоотой. Орчин үед боловсролыг

сургуулийн хүрээнд биш жинхэнэ хүн төлөвшүүлэх нийгмийн хүрээгээр нь ойлгож түүнд шинэ байдлаар хандаж, өргөн утгатай томьёолох хэрэгцээ шаардлага бий болсон.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид болон иргэдийн боловсрол, хүмүүжил төлөвшлөөс шууд хамаарч байдаг. Өнөө үед улс орны батлан хамгаалах хүч чадавхад нөлөөлж байдаг үндсэн хүчин зүйлүүдийн нэг цэрэг, батлан хамгаалах, аюулгүй байдлын чиглэлийн боловсролыг нэгдсэн тогтолцоонд оруулан боловсронгуй болгож, түүний чанар, үр дүнг дээшлүүлэх явдал тулгамдсан зорилт болж байна.

Батлан хамгаалах боловсрол нь иргэдэд цэргийн боловсрол, эх оронч хүмүүжил олгох, аюулгүй амьдрах арга ухаанд сургах, батлан хамгаалах болон зэвсэгт хүчнийг мэргэжлийн бие бүрэлдэхүүнээр нөхөн хангах, цэргийн дайчилгааны нөөцийн бие бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх, төрийн албан хаагчдад аюулгүй байдал, цэрэг стратегийн мэдлэг, чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн олон түвшинтэй, шаталсан үйл ажиллагаа юм. Энэхүү үйл ажиллагааг “Батлан хамгаалах боловсрол" гэсэн нэгдмэл тогтолцоогоор хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж, батлан хамгаалах боловсролын сургах зүй ба сэтгэлзүйн зарим асуудлыг боловсруулсан харьцуулсан.

Батлан хамгаалах боловсролыг өргөн утгаар нь “Хүн төрөлхтний цэргийн эрдэм, амьдрах ухаан, соёлыг нэг үеэс нөгөө үед өвлүүлэн дамжуулах хэрэгсэл” гэж тодорхойлж болох юм. Батлан хамгаалах боловсролын судалгааны гол асуудал бол үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр цэргийн эрдэм, аюулгүй амьдрах арга ухаанд суралцсан монгол хүний үнэт чанар, соёлыг хөгжүүлэх чадвартай, эх орон үндэс угсаагаа эрхэмлэн дээдлэх үзэл санаа баттай тогтсон ухамсартай монгол хүнийг нийгэмд төлөвшүүлэн бэлтгэхэд чиглэгдэнэ.

НЭГ: ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙГ СУРГАХ ЗҮЙН ҮНДЭС

Үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах зорилтоо шийдвэрлэхэд монголчууд бидний оюун санааны чадавх буюу эх оронч үндэсний үзэл, ёс суртахууны чанар, үндэсний эв нэгдлийн асуудал ямар ч үед чухал ач холбогдолтой байдаг. Энэ талаар судлаач Б.Шагдар “Монголчууд нэн эрт үеэс эх орноо батлан хамгаалж, өөрийнхөө аюулгүй байдлыг хангаж ирсэн түүхэн уламжлалтай ард түмэн билээ. Энэ нь тоогоор хэдий цөөн ч гайхалтай өндөр хөгжсөн цэргийн урлаг, стратеги-тактикийн цагийн байдлыг зөв үнэлэн тогтоох чадвар, улс орон, газар нутгийнхаа талаарх гүн гүнзгий мэдлэгтэй нь зайлшгүй

холбоотой”[320] гэжээ. ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг “Цэрэг хүний үндсэн хөдөлмөр бол сургалт бэлтгэл бөгөөд энэхүү хөдөлмөр нь цэргийн алба хаагчийн хөгжих, мэргэших хэрэгцээг хангахад чиглэгдэх ёстой”[2] гэж Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд илгээх захидалдаа онцлон тэмдэглэсэн[321] байна.

Ийнхүү Монгол Улсын аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, орчин үеийн Зэвсэгт хүчний үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүч хэрэгсэл нь батлан хамгаалах боловсрол, түүний олон талт үйл явц гэж үзэх үндэслэлтэй. Батлан хамгаалах боловсрол судлалд бие хүнийг төлөвшүүлэх онол, арга зүйн асуудал, ерөнхий ба хичээлийн сургах зүйн асуудал чухал байр суурийг эзэлдэг. Энэ салбар ухаан нь улс орноо батлан хамгаалах чадвар бүхий монгол хүний хөгжин төлөвших зүй тогтлыг судалж, хүний төлөвшлийн тулгуур багана болсон олны ашиг тус (улс, нийгэм)-ыг эрхэмлэсэн ёс суртахуун (моральность хандлагатай)[322], амьдрах ухаан, сэтгэл зүй, бие бялдрын хүмүүжил, соёлыг эзэмшүүлэх ажлын зорилго, агуулга, арга зүйг авч үзнэ. Өөрөөр хэлбэл, батлан хамгаалах боловсролын судлах зүйлүүд нь цэргийн алба хаагчид, иргэдийг эх орноо батлан хамгаалахад бэлтгэх сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаа (суралцагчдын сэтгэл зүйд зорилго, чиглэлтэйгээр нөлөөлөх), түүний зүй тогтлууд болно.

Хүмүүжил гэдэг нь цэргийн алба хаагч болон иргэнийг төлөвшүүлэх тодорхой зорилготой үйл ажиллагаа бөгөөд хүн төрөлхтний амьдрах ухаан, урлаг соёлын нөлөөллийг өөртөө багтаасан хүний хувийн чанар бүрэлдэх үйл явц юм. Тухайлбал, хүмүүжил нь аливаа зүйлд хандах шинжлэх ухааны хандлага, ёс суртахууны эрхэм чанар, цэргийн болон мэргэжлийн өндөр түвшин, бие бялдрын хөгжлийг төлөвшүүлэх зорилгоор цэрэг дайчид, иргэдийн ухамсар, сэтгэл санаанд сурган сэтгэл зүйн үүднээс нөлөөлөх үйл явц юм.

Залуучуудад цэрэг, эх оронч хүмүүжил олгох, эх орноо батлан хамгаалах үйл хэрэгт иргэн бүрийн оролцоог хангахын тулд ард түмэн үр хүүхдээ хүмүүжүүлж ирсэн уламжлалт арга барилд тулгуурлана. Хүн бол бие, оюун ухааны нэгдэл учраас биеийн боловсрол, оюуны боловсрол хоёр салшгүй холбоотой, нэг нь нөгөөтэйгөө харилцан шүтэлцсэн шинжтэй боловч манай уламжлалт ухаанд биеийн боловсрол буюу бие махбодын өсөлт, чийрэгжилт, биеийн хүчийг тэргүүн зэрэгт тавьж иржээ. Хүүхдэд багаас нь практик үйл, туршлагын мэдлэг, амьдрал, хөдөлмөрийн явцад олгож, биед нь тамир тэнхээ суулгахыг "Эрүүл биед саруул ухаан оршино", "Дайнд баатар далайд усч", "Ажил хийвэл ам тосдоно", "Гарын дүйтэй болгох" гэсэн онч мэргэн үгээр илэрхийлсэн

[320] Шагдар.Б, Өөрийгөө хамгаалах эрх ашгийн үүднээс монгол орноо судлах нь. БХЭШХ-ийн ЭШ- 1 ний хуралд тавьсан илтгэл. УБ., 2014.т.

[321] Ганзориг Д. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд илгээх захидал. “Соёмбо” сонин. 2019.10.24. 2 3 No43(10668).

[322] Паламдорж Ш. Батлан хамгаалах боловсрол судлал, түүний онол арга зүйн асуудал. Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал. УБ.,2019. №27. х126.

нь биеийн тамир тэнхээ буюу бие махбодын эрүүл чийргийг эрхэмд үзсэн сэтгэлгээ юм. Биед тамир тэнхээ суухыг дагаад ухаан билэг нээгдэх бөгөөд улмаар ухаанаар өөрийгөө удирдан хөгжүүлж "Би" гэдгээ мэдэхтэйгээ болох нь монголчуудын уламжлалт хүмүүжлийн гол үзэл баримтлал байжээ.

Ерөнхий сургах зүйгээр сургалтын агуулга, арга зүй, зохион байгуулалтын хэлбэр, түүний мөн чанарыг тайлбарлана. Батлан хамгаалах боловсролын үндсэн агуулгыг үе шат бүрээр томьёолж, тэдгээрийг эзэмших түвшин түүнд тавих шаардлагыг нарийн тодорхойлж өгнө. Батлан хамгаалах боловсролын тогтолцоо, үзэл баримтлал үүсэн бий болох үндсэн нөхцөл нь боловсрол олгох сургалтын хөтөлбөрүүд, түүний агуулгаас ихээхэн хамааралтай билээ. Хүн төрөлхтөн олон зууны турш хуримтлуулсан оюуны болон материаллаг өв баялгаасаа хойч үедээ сургалтын агуулгаар дамжуулан өвлүүлэн үлдээсээр иржээ.

Аливаа сургалтын агуулгыг тодорхойлон тогтоохын тулд тухайн шинжлэх ухааны түвшин, нийгмийн хэрэгцээ шаардлага, суралцагчдын сурах чадвар, сургалт явуулах багш нараа бэлтгэсэн байдал, олон улсын жишиг болон сургалтын агуулгыг боловсронгуй болгоход баримтлах зарчмуудыг харгалзан үзэх шаардлагатай юм.

Сургалтын зарчмыг янз бүрээр авч үзэх боловч ихэвчлэн хичээл сургалтад тавигдах шаардлагуудын цогц гэж үздэг. Зарчим нь юмс үзэгдэл, ухагдахууны мөн чанарыг шинжлэх ухааны үүднээс тодорхойлон тогтоохын үндэс болдог. Шинжлэх ухааны гол зарчим бол тухайн ойлголт, ухагдахууны ерөнхий агуулгыг урьдчилан зөв харж тогтооход чиглэж байх учиртай.

Хөрш орнууд аюулгүй байдал, цэргийн мэргэжлийн боловсрол, сургалтын чанар, үр дүндээ ихээхэн анхаарах боллоо. ОХУ-ын Зэвсэгт хүчний сургалтын зарчмууд “Сайтар сургаж бэлтгэгдсэн цэргийн мэргэжилтэн нь...тавигдаж буй цаг үеийн шаардлага, хэрэгцээнд нийцсэн, ирээдүй рүү хандсан байх хэрэгтэй”[323] гэсэн үзэл санааг удирдлага болгон шинэчлэгдэж эхэлсэн.

БНХАУ-ын “Улсын батлан хамгаалах боловсролын тухай хууль”-д батлан хамгаалах боловсрол олгох зарчмын онцлогийг үе үеийн удирдагч, манлайлагчдын явуулсан батлан хамгаалах үзэл санаагаар баяжуулж, бүх нийтэд улс орноо хамгаалахын чухлыг ойлгуулж, байнга сайжруулж байх тухай зааж, улсын байгууллага, төрийн албанд ажиллах иргэнийг зөвхөн батлан хамгаалах боловсролоор дамжуулан бэлтгэдэг санаагаа улам баталгаажуулсан байна.

Батлан хамгаалах нь цэргийн шинжлэх ухаан, аюулгүй байдал судлалыг өөртөө агуулсан судлагдахуун харин боловсролын онол тэр дундаа сурган хүмүүжүүлэх ухаан нь бусад шинжлэх ухааны ойлголтуудыг багтаадаг тул батлан

[323] Путин В.В, Быть сильными: гарантий национальной безопасности для России. Российская газета. №5708 (35) 17 фев 2012г.

хамгаалах боловсрол нь нэлээд өвөрмөц байдлаар илрэх хандлагатай. Орчин үед цэргийн боловсролын сургуулийн хүрээнд биш жинхэнэ эх оронч сэтгэлгээтэй хүн төлөвшүүлэх нийгмийн хүрээгээр нь ойлгож, системчлэн шинжлэх ухааны түвшинд авч үзэх, боловсролын зүй тогтлыг тайлбарлах шинжлэх ухааны шинэ зарчим бий болгохыг шаардаж байна.

ХОЁР: ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН СЭТГЭЛ ЗҮЙ

Батлан хамгаалах боловсролын сэтгэл зүйн асуудал нь цэргийн алба хаагчид, хүүхэд залуучуудыг эх орноо батлан хамгаалахад сургаж бэлтгэх сургалт, хүмүүжлийн үйл ажиллагааны агуулга, арга хэлбэрийг тэдний нас бие, сэтгэцийн хөгжлийн түвшинд зохицуулан явуулах ажлын сэтгэл зүйн үндсийг судлахад гол анхаарлаа хандуулна.

Сэтгэл зүйн боловсрол нь байгаль дэлхий, эх орон, элгэн саднаа хайрлах, хамгаалах зэргээр оршин байгаа ахуй руу ханддаг тул залуу үеийн хүмүүжил боловсролд ач тусаа өгсөөр ирсэн. Гэтэл улам бүр хувьсан өөрчлөгдөж буй эрин үед уламжлалт ахуйгаас холдож байгаа нөхцөлд энэхүү хүмүүжил боловсролыг зайлшгүй албан ёсоор олгохоос өөр аргагүй байгаа нь нэгэнт тодорхой болжээ.

Сэтгэл зүйн асуудал батлан хамгаалах боловсролд чухал. Ирээдүйд улс орноо авч явах, эх орон, ард түмнийхээ язгуур эрх ашгийн төлөө хоёргүй сэтгэлээр хүчин зүтгэх залуу үеийн цэрэг эх оронч үзэл, сэтгэхүйг нь илүү бадрааж, зоригжуулж өгөх үүрэгтэй. Монгол хүн гэсэн бахархал, мэдрэмжийг батлан хамгаалах боловсрол олгох ёстой хэмээн үзэж байна.

Хүний сэтгэл зүйд чухал нөлөөлж байдаг маш хүчтэй зүйл бол мэдрэмж юм. Хүмүүний мөн чанар, өвөрмөц шинжийг мэдрэмжтэй холбон үздэг сэтгэл судлалыг үндэслэгчийн хувьд С.Л.Рубинштейн "Хүний мэдрэмжүүд бол байгалийн хамгийн яруу илэрхийлэл бөгөөд хүний жинхэнэ мэдрэмжээс урган гардаг сэтгэл догдлуулам тэр татах хүч чухамхүү үүнтэй л холбоотой"[324] гэжээ. "Монголын сурган хүмүүжүүлэх уламжлалын дагуу сургах ёсон нь хөвгүүдийн сэцэн мунхаг хийгээд чийрэг буурай ба хурц хийгээд мохоо хийгээд чадалтай үхээнц, жич түүний авьяасыг шинжлэн савыг үзэж сургаваас зохимуй хэмээсэн аж сэтгэлгээтэй нийцнэ"[325]. Эндээс харахад боловсролыг нийтээр хавтгайруулан нэг хэв загвараар олгох гэж зүтгэх нь нэгэнт өнгөрсөн бөгөөд хүүхэд бүрийн сэтгэл зүйн хэв шинж мэдрэмж дээр тулгуурлан хүмүүжил боловсролыг олгох, монгол хүнийг бэлтгэх шинэ загвар боловсруулах хэрэгтэй болж байна. Өөрөөр хэлбэл, мэдээлэл технологийн эрин зуунд монгол хүнийг бэлтгэх батлан хамгаалах боловсролын нээлттэй олон загварт тогтолцоо хэрэгтэй гэсэн үг.

[324] Рубинштейн.С.Л. Основы общей психологий. В двух томах. Т.2.М.,1989.стр 147.
[325] Дэмчигдорж.Ч. Эрдэнэт толь хэмээх шаштир оршвой. УБ.,1995.т.30.

Монголчууд хүний оюун ухаан, бие махбодыг сэтгэл нь удирддаг гэж үздэг бөгөөд Чингис хаан нэгэнтээ "Хүний сэтгэлийг эзэмдвээс бие хааш одох" хэмээн айлджээ. Сэтгэлийн гол цөм нь сэтгэхүй юм. Сэтгэхүй бол хүний ууараг тархины үйл ажиллагааны хамгийн дээд хөгжингүй хэлбэр мөн. Өөрөөр хэлбэл, хүн сэтгэж танин мэдсэн зүйлээ дахин тархиндаа боловсруулж, өөрөө болон бусдад итгэл үнэмшил төрүүлэхүйц мэдлэг гэгчийг үйлдвэрлэн энэхүү мэдлэг нь хүнд шингэснээр тухайн хүний үзэл санаа, итгэл үнэмшил болж тогтдог. Хүн бүрийн үзэл санаа хуримтлагдан нийгэмд тухайн ард түмний өвөрмөц сэтгэлгээний хэв маяг, онцлог бий болж энэ нь хүнд өөрийгөө нэг улс үндэстний хэсэг гэсэн мэдрэмжийг хүчтэй төрүүлдэг байна. Ийнхүү монгол хүний мэдрэмжийг чухалд авч үздэг шинж чанарыг батлан хамгаалах боловсролын сэтгэл зүйд авч үзэх боломжтой юм.

"Хүний сэтгэж танин мэдэх үйл ажиллагааны анхдагч хэлбэр буюу түгээмэл арга нь ажиглах арга бөгөөд энэ аргын сэтгэл зүйн үндэс нь ажигч гярхай чанар болно. Ажиглах чадвар нь монгол ахуй амьдрал, аж төрөх хэвшлээс үүдэлтэй ажиллах, хөдөлмөрлөх хэрэгцээнээс үүссэн сэтгэхүйн үйлийн анхдагч арга юм. Ажиглах явцад нэгийг нөгөөгөөс ялгах, тодруулах, хооронд нь жиших харьцуулах зэрэг оюуны үйлдлүүдийг хийдгээрээ онцлог ач холбогдолтой"[326]. Иймээс батлан хамгаалах боловсролын олон талт асуудлыг монгол хүнд илүүтэй хөгжсөн сэтгэхүйн энэ чадварт суурилан шийдэх нь зохистой бөгөөд бүтээлч байж болох юм. Монгол хүн ямар онцлогтойг судлан үзэж бие махбод, сэтгэл зүйн хэв шинжид ямар хүмүүжил боловсролын тогтолцоо тохирохыг үндэстэй тогтоох шаардлагатай.

Монгол хүний сэтгэхүйн онцлогийг логикийн зарим мөрдөлдсөнөөс гаргаж болох юм. Логик мөргөлдөөний хуулиуд дотроос дедукцид буюу ерөнхийгөөс тусгай руу чиглүүлж оюун дүгнэлт хийх чадвар сайн байдаг нь монгол хүний байгалийн нэгэн онцлог шинж юм. Тухайлбал, монголчууд дээрээс доош тэрлэсэн унаган бичигтэйгээс гадна жилийн дотор сар, өдрийг багтаан ерөнхийгөөс тусгай хэсэгт шилжүүлэн ярьж, бичдэг нь дээрх санааг тодотгох нэгэн баримт болж байна. Өрнөдийнхөн хэсгээс ерөнхийд чиглэсэн индукц гаргалгааг зонхилон хэрэглэдэг бөгөөд манай улсын боловсрол яг ийм зарчмаар зохиогдсон хичээлийн агуулга үзэж, сурах бичиг гарын авлага ашиглаж ирсэн байдаг.

Дээрх онцлогуудыг харгалзан батлан хамгаалах боловсролын тогтолцоогоор цэргийн алба хаагч, оюутан сонсогч, иргэдэд өгөх мэдээллийн хэмжээг нягтруулж, сургалтын агуулгыг ерөнхийлөн багцлах зүй ёсны шаардлага

[326] Баттогтох Д. Монголын уламжлалт боловсролын онол түүхийн судалгаа. Боловсрол судлалын шинжлэх ухааны докторын зэрэг горилсон диссертаци. УБ.,2019.т.64 "Аюулгуй байдал, батлан хамгаалах судлал" № 28 (38) 2019

тавигдаж болох юм. Тухайлбал, аль ч шатны батлан хамгаалах боловсролын агуулгыг хөндлөн ба босоо чиглэлээр нэгээс нөгөө нь урган гарахуйцаар учир зүйн эрэмбэд оруулж хөлгөн мэдээллийн маягаар оновчтой цомхон болгох хувилбарыг боловсруулах нь зүйтэй юм.

Ийм зарчмаар боловсруулсан дидактик нь монгол хүний сурах байгалийн онцлогт сайн тохирч улмаар сурах, сургах үйл ажиллагааг хамтын бүтээлч хөдөлмөр болгож, шинэ зууны иргэдийн зайлшгүй эзэмших чадварууд (аливаа асуудлын учрыг олдог, зөв шийдвэр гаргаж чаддаг, хамтран ажиллах чадвар, харилцааны чадвар)-ыг хялбар олгох боломжийг бүрдүүлнэ. Нөгөө талаас дур мэдэн хичээлийн тоо, цагийг нэмэгдүүлдэг үр ашиг багатай, идэвхгүй арга барилаас салж, мэдээлэл боловсруулах дэвшилтэт аргыг хэрэглэн сургалтын хөтөлбөрийн агуулгыг төгөлдөржүүлэх боломжтой.

ГУРАВ: САНАЛ ДҮГНЭЛТ

Батлан хамгаалах боловсролын сургах зүй ба сэтгэл зүйн зарим асуудлаас нийгэмд гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг тодруулан авч үзвэл:

1. Батлан хамгаалах боловсролын нийгмийн үүрэг нь Монгол Улсын иргэнийг эх орон, төр, ард түмнээ дээдлэн хүндэтгэх, газар нутаг, байгаль дэлхийгээ хайрлах, үндэс угсаа, түүх, соёл иргэншил, үнэт зүйлсээрээ бахархах эх оронч үзэл бодол, итгэл үнэмшлээр хүмүүжүүлж, улс орныхоо тусгаар тогтнолын баталгааг нэмэгдүүлж, тогтвортой хөгжлийг хангах үйл явцад чиглэгдэнэ.

2. Батлан хамгаалах боловсрол нь хүн амын доторх бүлэг нийтлэгийн нийгмийн ялгааг багасгах, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа болох, нийгмийн харилцааг боловсронгуй болгох зэрэгт шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ.

3. Монгол орны түүх, соёлын онцлог, үндэсний өв уламжлал, цэрэг эх оронч сэтгэлгээ, өнөөгийн нийгэм эдийн засгийн хөгжил, боловсролын гүйцэтгэх үүрэг зориулалтаас үзэхэд бие хүнийг нийгмийн иргэн болгон төлөвшүүлэх нарийн төвөгтэй үйл явцыг судалдаг батлан хамгаалах боловсрол нь цэргийн ухааны нэгэн хэсэг мөн болохын хувьд улс орны хөгжил, түүнтэй зэрэгцэн өөрчлөгдөн шинэчлэгдэж эхэлсэн.

4. Батлан хамгаалах, аюулгүй байдлын мэдлэг, ур чадварыг эзэмшсэнээр хувь хүний авьяас чадвар хөгжих, зан суртахуун, үзэл бодол төлөвших, нийгмийн харилцаанд оролцох, өрх гэрээ төвхнүүлэх, аюулгүй амьдрах зэрэг боломжууд нэмэгдэх болно.

5. Монгол хүний сэтгэхүйн өвөрмөц онцлогуудыг батлан хамгаалах боловсрол, сургалтын үйл ажиллагаанд туршин хэрэгжүүлэх нь залуучуудад цэрэг, эх оронч хүмүүжил олгох, эх орноо батлан хамгаалах үйл хэрэгт иргэн

бүрийн оролцоог хангах ажлын сэтгэл зүйн үндсийг бүрдүүлэхэд ач тустай гэж үзлээ.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Шагдар Б. Өөрийгөө хамгаалах эрх ашгийн үүднээс монгол орноо судлах нь. БХЭШХ-ийн ЭШ-ний хуралд тавьсан илтгэл. УБ., 2014.т.2

2. Ганзориг Д. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд илгээх захидал. "Соёмбо" сонин. 2019.10.24. № 43(10668).

3. Паламдорж Ш. Батлан хамгаалах боловсрол судлал, түүний онол арга зүйн асуудал. Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал. УБ.,2019. №27. х126.

4. Путин В.В Быть сильными: гарантии национальной безопасности для России. Российская газета. №5708 (35) 17 фев.2012г.

5. Рубинштейн.С.Л. Основы общей психологий. В двух томах. Т.2.М.,1989.стр 147.

6. Дэмчигдорж.Ч. Эрдэнэт толь хэмээх шаштир оршвой. УБ.,1995.т.30.

7. Баттогтох Д. Монголын уламжлалт боловсролын онол түүхийн судалгаа. Боловсрол судлалын шинжлэх ухааны докторын зэрэг горилсон диссертаци. УБ.,2019.т.64

ЦЭРГИЙН НИЙТЛЭГ ДҮРМИЙН ХЭРЭГЖИЛТЭД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS OF THE FACTORS AFFECTING THE APPLICATION OF COMMON MILITARY RULES



П.Лхагадорж
Дотоод хэргийн их сургуулийн
Сургалт, судалгааны 403 дугаар анги-
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
531 дүгээр дамжааны ахлах түрүүч



М.Маралмаа
Дотоод хэргийн их сургуулийн
Сургалт, судалгааны 403 дугаар анги-
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
531 дүгээр дамжааны ахлах түрүүч

Хууль сахиулах байгууллагад тухайн мэргэшлийн тусгай чиг үүрэг бүхий их сургуульд суралцаж төгссөн, цэргийн хэргийн мэдлэгтэй иргэнийг авч ажиллуулдаг. Гэвч сүүлийн үед цэрэг, цагдаагийн байгууллагуудад цэргийн цолны зохистой харьцаа алдагдаж, цэргийн зохих ёсны боловсрол эзэмшээгүй, цэргийн алба хаагаагүй, офицерын албанд элсүүлэх насны дээд хязгаар хэтэрсэн иргэд, спорт, урлагийнханд цэргийн цолыг хавтгайруулан олгож байгаа зэрэг шүүмжлэлтэй асуудлууд гарч байгаа нь цэргийн нийтлэг дүрмийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байгааг энэхүү судалгааныхаа хүрээнд тодруулахыг зорилоо.

Түлхүүр үг: Мэргэжлийн бахархал, төрийн тусгай алба, тэсвэр хатуужил, итгэл үнэмшил, мэргэжлийн үнэ цэнэ, ялгаатай байдал.

Хураангуй: Цэргийн албаны тухай хуульд “цэргийн цол” гэж цэргийн албан хаагчийн эрхэлж байгаа албан тушаалын ангилал, цэргийн боловсрол, цэргийн жинхэнэ алба хаасан хугацааг илэрхийлсэн зэрэглэлийг хэлнэ гэж заасан боловч цэргийн жинхэнэ албанд ажиллаж байгаагүй мэргэжлийн бус төрийн албан

хаагчид цол олгогдож байгаа нь цэргийн алба хаагчдын хувьд үнэт зүйл нь алдагдаж,төрийн албаны залгамж чанар, халдашгүй дархан байдлыг ганхуулах магадлалтай юм.

Цол бол шагнал биш, цол бол албан тушаал, сурч боловсорсон ажлын туршлага, эрх мэдлийг илэрхийлэгч юм. Цэргийн алба болон төрийн байгууллагад мэдлэг ур чадвараараа тэмцэн ажиллаж байгаа алба хаагчийн хичээл зүтгэл, зориг тэвчээр, эрхэмлэж явах үнэт зүйл түүнийг үнэгүйдүүлж, Цэргийн цолыг энгийн болон урлаг соёл спортын амжилт гаргасан иргэдэд шагнал мэтээр өгөх нь цэргийн алба хаагчдын хүсэл эрмэлзэл хичээл зүтгэл бахархлыг мохоодог юм.

Цэргийн албаны тухай хуулийн нэр томьёоны тайлбарт "цэргийн цол" гэж цэргийн алба хаагчийн боловсрол, цэргийн жинхэнэ алба хаасан хугацааг илэрхийлсэн зэрэглэлийг хэлнэ. Үүнээс авч үзэхэд цэргийн жинхэнэ алба хаасан хугацаанаас бусад агуулга нь Мерит зарчмын дагуу цэргийн цол олгоно.

Хууль сахиулах байгууллага гэж хууль ёс, эрх зүйн дэг журмыг хамгаалах, хүний эрх ба эрх чөлөөг хамгаалах, гэмт явдалтай тэмцэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн байгууллага. Хууль сахиулах байгууллагад дараах байгууллага хамаарагдана: шүүх, үндсэн хуулийн шүүх, прокурорын байгууллага, дотоод хэргийн асуудал эрхэлсэн байгууллага, улсын аюулгүй байдлын алба, улсын хяналт шалгалтын байгууллага, гаалийн хяналт шалгалт, хууль зүйн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллага зэрэг.

Цэргийн алба хаагч, төрийн цэргийн байгууллагын мөрдөс зүүсэн алба хаагчид хөдөлмөр, идэвх чармайлт, хөлс хүчээ үнэлүүлж цол нэмж цолоороо бахархдаг. Түүнийгээ дагаад ч цэргийн нийтлэг дүрмээ дагаж мөрддөг. Гэтэл тэрхүү цолыг хүртэх ёстой замаар нь явж аваагүй хэр нь мөрдөс зүүж байгаа зарим хүмүүсээс болж цэргийн нийтлэг дүрмийн хэрэгжилт хангагдахгүй, мөрдөгдөхгүй, үл тогтоох асуудлууд гарч байна хэмээн харж байна.

A law enforcement organization recruits a person who graduated from a university with unique functions and combat experience. However, there have recently been critical issues such as the loss of proper military rank ratios in military and police organizations, as well as the granting of military ranks to citizens who have not received proper military education, have not served in the military, have exceeded the upper age limit for enlistment in the officer's service, sports, and arts. We hope that our research will shed light on the harmful consequences.

Keywords: Professional pride, special public service, resilience, trust, professional value, difference.

Summary: According to the Law on Military Service, "military rank" relates to the rank of a military officer's post, military education, and the length of military service. Those who close risk losing value and jeopardizing the continuity and immunity of the public service.

A title is not a prize; rather, it represents position, education, professional experience, and authority. The efforts, courage, and values of servicemen who struggle with their knowledge and skills in the military and government organizations are undervalued, and awarding military rank to citizens who have achieved achievements in the arts, culture, and sports diminishes the military servicemen's aspirations, efforts, and pride.

In the context of the Law on Military Service, "military rank" refers to a military serviceman's educational rank as well as the duration of his actual military service. Based on this, material other than actual military duty shall be granted a military rank in accordance with the merit principle.

A law enforcement organization is a government body whose primary tasks include maintaining law and order, preserving human rights and freedoms, and combating crime. Law enforcement agencies include courts, constitutional courts, prosecutor's offices, internal affairs organizations, state security services, state inspection offices, customs inspections, legal organizations, and court decision enforcement organizations.

Military personnel and those wearing the state military organization's insignia take pride in their labor, efforts, and hard work, as well as their rank. Even after that, he observes the military's general guidelines. However, because some individuals do not take the route they deserve, they see that the military's common norms are not being applied, obeyed, and problems are not being resolved.

ЦЭРГИЙН ЦОЛ ОЛГОХ ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол улсын үндсэн хууль: Монгол улсын үндсэн хуулийн 30 дугаар зүйлд Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг тусгасан байдаг бөгөөд тэрхүү зүйлийн 7 дахь хэсэгт Ерөнхийлөгч нь улсын цол, цэргийн дээд цол хүртээх, одон, медалиар шагнах бүрэн эрхтэй хэмээн заасан байдаг. Энэ эрхийнхээ хүрээнд Ерөнхийлөгч цэргийн цол хүртээх эрхтэй байх нь.

Цэргийн албаны тухай хууль: Энэ хуулийн 26 дугаар бүлэгт цэргийн цол, цэргийн цол олгох албан тушаалтан, цэргийн цол хэрэглэх, цэргийн цолыг бууруулах, хураан авах сэргээх талаар хуульчилсан. Мөн энэ хуулийн 27.2-т “Цэргийн алба хаагчаас бусад албан тушаалтан хуульд өөрөөр заагаагүй бол цэргийн цол хэрэглэхийг хориглоно” хэмээн заасан байдаг байна. гэтэл энэ заалт бодит байдал дээр биеллээ олохгүй байна.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль: энэхүү хуулийн 6 дугаар зүйлд цэргийн алба хаагчийн үүргийг тусгасан бөгөөд цэргийн алба хаагч нь “Монгол Улсын хууль тогтоомж, цэргийн нийтлэг дүрмийг чанд сахин биелүүлнэ” гэж заасан.

Цэргийн цол олгох журам: Уг журмын 3 дугаар зүйлд Цэргийн алба хаагчдад цэргийн цол хүртээх, олгох талаар тусгасан бөгөөд үүнд:

- Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч цэргийн дээд цолыг хүртээх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

- Монгол Улс Цэргийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх заалтын дагуу цэргийн цолыг олгоно.

- Цол олгох албан тушаалтан цэргийн цол олгохдоо эзэмшсэн боловсрол, ажилдаа мэргэшсэн байдал, ажлын үр дүн, цэргийн алба хаагчийн ёс зүй, албан тушаалын цолны зэрэглэл, шалгуур үзүүлэлтийг үндэслэл болгоно.

- Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч өөрийн томилдог албан тушаалтанд цэргийн дээд офицерын болон дээд офицерын дараагийн цолыг өөрийн санаачлагчаар олгож болно.

- Дээд офицерын анхны цол олгох насны доод хязгаар 47 нас байна.

- Гүйцэтгэх албан тушаалын ахлагчид цэргийн цолыг ажилласан жил, мэргэжлийн түшингийн үнэлгээ, мэргэжлийн зэрэг эзэмшсэн байдлыг харгалзан олгоно.

- Ахлах дэслэгч цолыг офицерын албан тушаалд 3-аас дээш жил ажилласан тохиолдолд олгож болно.

- Дайчилгаатай сургуульд оролцсон цэргийн бэлтгэл үүрэгтэнд цэргийн цолыг оногдуулан бүртгэгдсэн албан тушаалын ангилал, цолны зэрэглэлийг үндэслэн энэ журмаар тогтоосон цэргийн цол олгох хоорондын хугацааг харгалзан олгоно.

- Дайчилгааны болон цэрэг-стратегийн сургалтад хамрагдсан цэргийн бэлтгэл үүрэгтэнд цэргийн цолыг цэргийн мэргэжил эзэмшиж, цэргийн тангараг өргөсөн нөхцөлд оногдуулан бүртгэгдсэн албан тушаалын ангилал, цолны зэрэглэлийг үндэслэн энэ журмаар тогтоосон цэргийн цол олгох хоорондын хугацааг харгалзан олгоно.

- Цэргийн жинхэнэ алба хаагаагүй иргэн цэргийн жинхэнэ албаны офицер, ахлагчийн албан тушаалд томилогдвол цэргийн бэлтгэл, сургалтад хамрагдсаны дараа офицер, ахлагчийн анхны цол олгоно.

Дээрх байдлаар тус тус тусгасан байдаг бол уг журмын 5 дугаар зүйлд “Цэргийн цол олгохоос татгалзах” үндэслэлүүдийг тусгасан бөгөөд үүнд:

- Цэргийн тангараг өргөөгүй;

- Цэргийн мэргэжил олгох, давтан бэлтгэх сургалтад хамрагдаагүй;
- Цэргийн академи, коллеж, их дээд сургуульд суралцаж байгаа;
- Чөлөөнд байгаа;
- Цэргийн цолоо хураалгасан. Эдгээр тохиолдлуудад цэргийн цол олгохоос татгалздаг байна.

Хууль, хүчний байгууллагад харьяалагддаг тамирчид манай улсад олон байдаг. Тэднийг ямар нэг амжилт гаргахад цэрэг, цагдаагийн цолоор шагнаж, зарим нь бүр генерал болох нь дөхөж байна. 2014 онд Ардын хувьсгалын 93 жилийн ойн баяр наадамд найм давж, гарьд, Ш.Жаргалсайханд цагдаагийн ахмад, 2015 онд наадамд түрүүлсэн Э.Оюунболд арсланд цагдаагийн ахмад, П.И.Чайковскийн нэрэмжит олон улсын уралдааны гоцлол дуу дуулаачдын төрөлд тэргүүн байр эзэлсэн Г.Ариунбаатарт ахмад цол, 2017 оны наадамд түрүүлсэн улсын арслан Ц.Содномдоржид улсын баярын дараа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас дэд хурандаа цол, 2018 онд О.Гүндэгмаа баатрыг дэд хурандаа цол, Х.Эрдэнэт-Од дасгалжуулагч хурандаа цол хүртсэн гэх мэт.

2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн захирамжаар Батлан Хамгаалахын Сайд Сайханбаяраар ахлуулсан ажлын хэсэг гарч Цэргийн цолыг Урлаг спортынхон, улс төрийн албан тушаалтанд олгохгүй байхаар шийдвэрлэсэн байна. Мөн цэргийн цол ч гэлтгүй цэргийн хувцас хэрэглэлийг цэргийн зориулалтаар ашиглана хэмээн шийдвэрлэсэн байна. энэ нь зөв зохицуулалт болсон боловч энэхүү захирамж гарахаас өмнөх цол авсан урлаг спортынхонд олгогдсон цол хүчингүй болчихгүй нь мэдээж. Энэхүү Монгол Улсын Ерөнхийлөгчийн захирамжаар Батлан Хамгаалахын Сайд Сайханбаяраар ахлуулсан ажлын хэсэг гарахаас өмнө 300 гаруй улс төрийн албан тушаалтан цэргийн цолоор шагнуулсан байна.

ЦЭРГИЙН НИЙТЛЭГ ДҮРМИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол улсын цэргийн нийтлэг дүрмүүд 2022 онд шинэчлэн батлагдсан. Цэргийн нийтлэг дүрмүүд нь дараах 4 хэсэг бүтэцтэй юм.

- "Цэргийн дотоод албаны дүрэм"
- "Цэргийн хүрээний ба харуулын албаны дүрэм"
- "Цэргийн жагсаалын дүрэм”
- "Цэргийн сахилгын дүрэм"

Цэргийн дотоод албаны дүрэм. Цэргийн алба хаагчийн нийтлэг эрх, үүрэг, хоорондын харилцаа, албан тушаалтны үүргийг тогтоож, ангийн дотоод

алба, түүнийг удирдах, төлөвлөх, хэрэгжүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулдаг.

Цэргийн хүрээний ба харуулын албаны дүрэм . Энэ дүрэм нь цэргийн хүрээний албыг зохион байгуулах, гүйцэтгүүлэх, хүрээний албан тушаалтан, тэдний үүргийг тодорхойлох, цэргийн нэгтгэл, анги, салбарын харуулын албыг зохион байгуулах, харуулын бие бүрэлдэхүүний эрх, үүрэг, харуул, хамгаалалтыг хүлээн авах, халалцуулах, харуулын дотоод журам, харуул шалгах, цэрэг, цэргийн ачаа тээвэрлэх үед харуулын албыг зохион байгуулах, гүйцэтгэх онцлог, харуулын байгууламж (цэг)-ийг нохойгоор хамгаалах, цэргийн цагдаа, цэргийн тээврийн хяналтын албаны үйл ажиллагааг тодорхойлдог.

Цэргийн жагсаалын дүрэм. Энэхүү дүрмээр цэргийн алба хаагч, анги, салбарын зэвсэгтэй, зэвсэггүй, явган болон машинтай үеийн жагсаалын ажиллагаа, хөдөлгөөн, жагсаалд цэргийн алба хаагч, анги, салбарын гүйцэтгэх үүргийг тодорхойлон, жагсаалын үзлэг, цэргийн ангийн Байлдааны тугийг залж гаргах, жагсаалд байрлуулах, буцааж оруулах, цэргийн ёслолын ба хүндэтгэлийн ажиллагааг явуулах дэг журмыг тогтоодог.

Цэргийн сахилгын дүрэм. Зорилго нь цэргийн сахилга, түүнийг сахин биелүүлэхэд цэргийн алба хаагчийн хүлээх үүрэг, сайшаал болон сахилгын шийтгэлийн төрөл, тэдгээрийг хэрэглэх захирагчийн эрхийг тодорхойлж, сайшаал хүртээх, сахилгын шийтгэл ногдуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршдог. Дүрмийн үйлчлэх хүрээнд цэргийн жинхэнэ албаны болон цэргийн гэрээт албаны офицер, ахлагч, түрүүч, байлдагч, цэргийн сургуулийн сонсогч, оюутан-цэрэг, давтан сургалт, цэргийн бэлтгэл албаны сургалт (дайчилгаатай сургууль, цугларалт)-д оролцож байгаа бэлтгэл үүрэгтэн хамаарна.

Цэргийн нийтлэг дүрмийг цэргийн тангараг өргөсөн, цэргийн мэргэжил олгох, давтан бэлтгэх сургалтад хамрагдаж байгаа, цэргийн цол зүүсэн алба хаагч,албан тушаалтан дагаж мөрдөнө.

Цэргийн жинхэнэ алба хаагаагүй, цэргийн сургуульд суралцаагүй хэр нь цэргийн цол зүүж буй урлаг спортын алдартнууд нь цэргийн алба хаагчийн заавал дагаж мөрдөх ёстой цэргийн нийтлэг дүрмийг дагаж мөрдөх нь асуудал юм.

Цэргийн алба хаагч нь Эх орноо хамгаалах бэлтгэл эзэмших, цэргийн хэрэгт заавал суралцах, эрх бүхий албан тушаалтны баталсан ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх, цэргийн цол, албан тушаал харгалзахгүйгээр хүндэтгэлтэй, ёс зүйтэй, соёлтой харьцах,сэтгэл зүйн болон бие бялдрын тэсвэр, хатуужилтай байх,эрхэлж байгаа албан тушаалын шалгуур үзүүлэлтийг хангасан байх,цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлийг албан үүргээ гүйцэтгэх үедээ дүрмийн дагуу цэвэр, үзэмжтэй өмсөж хэрэглэх үүрэгтэй.

Цэргийн алба хаагч нь Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Цэргийн нийтлэг дүрмүүдээр хүлээсэн

үүргээ зөрчсөн тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ. Гэх мэтчилэн мөрдсөндөө таарсан үүрэх хариуцлагаа хүлээдэг билээ.

Цэргийн хүний хувьд мөрдөс гоёсон хувцас, төрийн сүлдэт малгай зэрэг өмсгөл зүүсгэл нь эрхэм бахархал нь байдаг. Гэтэл сүүлийн үед зүгээр нэг зүүсгэл гоёл шиг үнэгүйдэж байгаа нь харамсалтай. ДҮГНЭЛТ

Цэргийн цол гэдэг цэргийн албан хаагчийн эрхэлж байгаа албан тушаалын ангилал, цэргийн боловсрол, ур чадвар, цэргийн жинхэнэ алба хаасан хугацааг илэрхийлсэн эрэмбэ зэрэглэлийг хэлдэг. Гэвч сүүлийн үед энэ зүйлс алдагдаж цэргийн жинхэнэ албанд ажиллаж байгаагүй, мэргэжлийн бус, урлаг спортын хүмүүст шагнал маягаар олгогдож байгаа нь цэргийн албанд ажиллаж байгаа алба хаагчдын хувьд эрхэмлэж дээдэлж явах үнэт зүйл нь алдагдаж мэргэжлээрээ бахархах хүсэл зоригийг нь мохоож байна. Энэ нь ч тодорхой зүйл байх мэдээж хэрэг олон жилийн хүч хөдөлмөр, хүсэл мөрөөдөл, албандаа үнэнч зүтгэж өдрийн бодол шөнийн зүүд болж зүүсэн мөрдсөөрөө бахархаж явах нь цэргийн бидний хамгийн сайхан зүйл. Хэн нэгэн дуучин, тамирчин тэмцээн уралдаанд ороод амжилт гаргасны төлөө цэргийн цолоор шагнах нь өрөөсгөл зүйл бөгөөд тэдгээр хүмүүст өөрсдийн гэгдэх МУГТ, МУСТА, МУГЖ, гэх цолуудыг нь өгөх нь нүдээ олсон шийдвэр байх. Түүнээс хэн бүхэнд цэргийн цол зүүлгэж энгийн цэргийн нь мэдэгдэхгүй хавтгайруулж болохгүй.

Цэргийн цол олгох журам, Цэргийн алба хаагчийн эрх үүргийг Монгол улсын Үндсэн хууль болон Цэргийн нийтлэг дүрэмд тусгаж өгсөн байдаг. Эндээс харвал зөвхөн цэргийн жинхэнэ алба хаагчийн хүсэл зоригийг мохоогоод ч зогсохгүй Хууль дүрэм журмыг зөрчиж байна.

Үүнээс гадна цэргийн дүрэмт хувцсыг хэн дуртай нь өмсөж үйлдвэрлэж худалдаалдаг өнөөгийн мөрдөж байгаа “Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм”-д Монгол Улсын Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг, Дотоодын цэрэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Тагнуулын байгууллагад алба хааж байгаа офицер, ахлагч, цэргийн сургуулийн сонсогч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчид Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан загварын цэргийн дүрэмт хувцсыг өмсөж, цол, ялгах тэмдгийг дүрэмд заасны дагуу хэрэглэнэ” гэж тодорхой заасан байтал цэргийн дүрэмт хувцсыг хэн дуртай нь зөвшөөрөлгүй өмсөх, үйлдвэрлэх, худалдаалах зэрэг зөрчил элбэгшиж цэргийн дүрэмт хувцасны нэр хүндийг бууруулж байна.

Цэргийн дүрэмт хувцасны хууль бус хэрэглээний талаар "Цэргийн дүрэмт хувцсыг өмсөх дүрэм"-д заасан хууль, эрх зүйн заалтуудын хэрэгжилтийг хангах нь чухал. Ингэснээр цэргийн албаны нэр хүнд өсөж, цэргийн алба хаагчдын албаа хаах итгэл үнэмшил дээшлэх юм Энэ буруу тогтолцоог хуульд заасан дүрэм журмаар зохицуулж зөв замд нь оруулснаар олон алба хаагчдын албандаа зүтгэх

зүтгэл хүсэл эрмэлзэл нэмэгдэж байдаг. Цол нэмэхээ дагаад цалин өсдөг бөгөөд энэ нь цэргийн алба хаагчийн амьдрал ахуйд ч хэрэгтэй. Өөрөөр хэлбэл спорт урлагийнханд цол хэрэггүй. Энэ нь тэдний амжилтыг битгий үнэл гэж байгаа юм биш. Хэнд цол хэрэгтэй хэнд шагнал урамшуулал хэрэгтэй вэ гэдгийг нь ялгаж салгаж өгвөл нүдээ олох юм. Энэ буруу тогтолцоог хуульд заасан дүрэм журмаар зохицуулж зөв замд нь оруулснаар олон алба хаагчдын албандаа зүтгэх зүтгэл хүсэл эрмэлзэл нэмэгдэх юм. Мөн цэргийн нийтлэг дүрмийн хэрэгжилтэд ч эерэг нөлөө үзүүлэх юм.

Ингэж ялгаж салгаснаар аль аль талдаа өөрсдийн мэргэжлийн үнэ цэнийг мэдэрч тухайн мэргэжлийг сонгосноор бусдаас ялгарах зүйлээ ойлгож бахархаж явах төдийгүй өөрсдийн болон цаашлаад улс орныхоо ирээдүй тусгаар тогтголд эергээр нөлөөлнө.САНАЛ

- 2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн захирамжаар Батлан Хамгаалахын Сайд Сайханбаяраар ахлуулсан ажлын хэсэг гарч Цэргийн цолыг Урлаг спортынхон, улс төрийн албан тушаалтанд олгохгүй байхаар шийдвэрлэсний хэрэгжилтэд хяналт тавих;

- Монгол улсын цэргийн нийтлэг дүрмийн хэрэгжилтийг хангахын тулд цэргийн цолыг нэгэнт зүүсэн хэн ч байсан дээрх дүрмийг дагаж мөрдөх эрх зүйн зохицуулалтыг бий болгох, дагаж мөрдөөгүй, зөрчсөн тохиолдолд тодорхой арга хэмжээ авдаг байх;

- Урлаг спортын гавьяа шагналаар цол авсан хүмүүст цэргийн нийтлэг дүрмийн талаар мэдлэг олгож, тодорхой шаардлага тавьдаг байх.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

- Монгол Улсын Үндсэн хууль. Уб., 1992. Төрийн мэдээлэл эмхэтгэл №1.
- Цэргийн албаны тухай хууль. Уб., 2016 . Төрийн мэдээлэл эмхэтгэл №36
- Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль. Уб., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл №36
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 41 дүгээр зарлигийн хавсралт, Цэргийн цол олгох журам.
- С.Нарангэрэл “Монголын эрх зүйн англи, орос, латин хадмал эх толь бичиг", Улаанбаатар 2015 он, дөрөв дэх хэвлэлт.

Eagle news eagle.mn 2021оны 09дүгээр сарын 14.

ТЕЛЕХЯНАЛТЫН СИСТЕМИЙН ӨНӨӨГИЙН ЧИГ ХАНДЛАГА

CURRENT TRENDS IN TELEMONITORING SYSTEMS



Х.Отгонбат
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын захиргааны удирдлагын газрын төв архивын мэргэжилтэн, дэслэгч

Хураангуй: "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт “Хорих байгууллагын аюулгүй байдлын нэгдсэн удирдлагын систем", "Хоригдлын нүүр танилт, бүртгэлийн систем", "Ухаалаг хорих байгууллага”-ыг бий болгохоор тусгагдсан нь хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаа болон бусад чиглэлийн техник хэрэгслийг орчин үеийн хэрэгцээ, шаардлагад тулгуурлан шинэчлэх, хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаанд инновацид суурилсан технологийг нэвтрүүлэх чиг хандлага нэгэнт бий болсон.

Abstract: In the long-term development policy document of Mongolia "Vision 2050", it is included to create "Integrated Security Management System of Prison Institution", "Prisoner Identification and Registration System", "Smart Prison Organization", which is the security function of the prison institution. There has already been a trend of modernizing the operation and other areas of equipment based on modern needs and requirements, and introducing innovation-based technology in the operation of ensuring the security of prison institutions.

Түлхүүр үг: Монгол Улсын Төв орон нутгийн хорих анги, байгууллага, цагдан хорих байруудад ашиглагдаж буй телехяналтын систем, хиймэл оюун ухаан

Keywords: telemonitoring system, artificial intelligence used in prisons, institutions, detention centers in central Mongolia

УДИРТГАЛ

Дэлхий дахины технологийн хөгжил, дижитал шилжилтийн энэ цаг үед орчин үеийн технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх асуудал хувийн хэвшил болон төрийн байгууллагуудын дунд маш чухлаар тавигдаж, энэ нь тухайн байгууллагын хөгжлийг тодорхойлоход томоохон шалгуур үзүүлэлт болж эхэлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын нэг бөгөөд

таслан сэргийлэх цагдан хорих арга хэмжээ авагдсан болон шүүхээр гэм буруутайд тооцогдон хорих ялаар шийтгэгдсэн этгээдийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 267 дугаар зүйлд заасны дагуу нийгмээс тусгаарлах, эрүүгийн хариуцлагын зорилгыг болон аюулгүй байдлыг хангах, хорих ангид хууль ёс, дэг журмыг сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд хорих байгууллагын харуул хамгаалалтыг хорих байгууллагад үүрэг гүйцэтгэж буй алба хаагч болон техник хэрэгслийн тусламжтайгаар зохион байгуулдаг.

Сүүлийн 3 жилийн статистик тоо, дүн мэдээллээс үзвэл нээлттэй, хаалттай дэглэмд ял эдэлж буй хоригдлын тоо жилээс жилд нэмэгдэж, нийт хорих байгууллагын хэмжээнд хорих ангийн ачаалал нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Өнөөдрийн байдлаар хорих байгууллагын хэмжээнд үүрэг гүйцэтгэж буй хамгаалалтын ажилтан, холбоочин, дүрс бичлэгийн ажилтан зэрэг хоногийн харуул хамгаалалтад шууд аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий алба хаагчид 24 цагийн хоногийн үүрэг гүйцэтгэж, 48 цаг амарч цагийн амралтын байгаа нь Хөдөлмөрийн хуульд заасан зохицуулалтыг зөрчихийн зэрэгцээ, ажлын ачааллыг эрс нэмэгдүүлэн алба хаагчийн эрүүл мэнд, аюулгүй байдалд өндөр эрсдэлийг үүсгэн, алба хаагчийн эрх зөрчигдөх, хорих анги, байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагаврыг үүсгэж байна.

Иймд дээрх нөхцөл байдлыг нэгтгэн дүгнэвэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох, байгууллагын алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, цаашлаад гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хорих анги, байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаанд ухаалаг системийг нэвтрүүлж, ашиглагдаж буй техник хэрэгслийг хөгжүүлэх замаар хуулиар хүлээсэн чиг үүргийн нэг мөр хэрэгжүүлэхэд судалгааны үндсэн дээр шинжлэн судлах зайлшгүй хэрэгцээ шаардлагатай байна.

Өнөөдрийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын чиг үүрэг болох хорих ял эдлүүлэх, тэр дундаа харуул хамгаалалтын үйл ажиллагааны орчин үеийн технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх сэдвээр тусгайлан судалсан эрдэм шинжилгээний бүтээл, судалгааны ажил ховор байна.

1931 онд хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулсан бие даасан анхны хууль батлагдаж байсан бол 1966, 1981, 1993, 1996, 2002, 2017 онуудад шинэчлэн батлагджээ.

2002 онд батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар эрх зүйн томоохон шинэчлэл хийснээр ял эдлүүлэх ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс сэргийлэх, хоригдогчийн ахуй нөхцөлийг дээшлүүлэх, иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг олон улсын жишиг хандлагад нийцүүлж, ажиллагааны үр дүнгээс хамаарч шийдвэр гүйцэтгэгчийг урамшуулах,

төвлөрүүлсэн урамшууллаас зардлаа нөхөж, өөрийгөө санхүүжүүлэх тогтолцоог бий болгож, шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар төлбөр төлөгчийн эд хөрөнгийн мэдүүлгийг үндэслэн хөрөнгө тогтоох, мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн этгээдийг өртэй этгээдийн бүртгэлд бүртгэж нийтэд зарлах, бусдад барьцаалсан эд хөрөнгөнд ажиллагаа явуулах зэргээс гадна хорих байгууллагын үйл ажиллагаанд хэт богино долгионы радио станц, телехяналтын техник хэрэгслийн нэвтрүүлэх, ашиглах эрх зүйн шинэ зохицуулалтыг хуульчилсан нь хорих байгууллагын үйл ажиллагаанд орчин үеийн технологийг харуул хамгаалалтын нэвтрүүлэх үндсэн суурь тавигдсан гэж үзэж болно.

Тус үеэс хорих ял эдэлж байгаа этгээдийн талаас шинээр гэмт хэрэг үйлдэх, оргох явдлыг таслан зогсооход чиглүүлэн хорих ангиудад дохиолол, зүйн эрх ажиллагааны зохицуулалтыг шинэчлэн, техник хэрэгсэл нэвтрүүлэх ажлыг эрчимтэй зохион байгуулжээ.

Хоригдолд тавих хяналт, харуул хамгаалалтын ажлын үр дүнд зайлшгүй нөлөөлөх зүйл бол унаа машин, шуурхай холбооны техник хэрэгсэл байдаг бөгөөд энэ чиглэлээр дэс дараатай олон арга хэмжээ авагдаж ирснийг тэмдэглэх нь зүйтэй.

Тухайлбал: Гяндан, жирийн, чанга, онцгой дэглэмийн нийт хорих ангиуд, Ганц худаг дахь цагдан хорих төвийг бүхэлд нь телекамерын хяналтад оруулж, бусад цагдан хорих байрын 60.7 хувь, баривчлах байрын 80 гаруй хувийг телекамерын хяналтад хамруулсан байна.[327]

Хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаанд тогтсон нэг технологи арга хэрэгслийг нэвтрүүлэх нь учир дутагдалтай юм. Тухайлбал, хорих ял эдлүүлэх ажиллагаа нь зөвхөн хяналт тавихаас гадна аюулгүй байдлыг хангах, хүний эрхийг хангуулах зарчимтай уялдах хамгаалалтын үйл нь зүйтэй учраас хорих байгууллагын харуул ажиллагаанд мэдээллийн технологийн системтэй салшгүй холбоотой бөгөөд үүнтэй уялдуулах нь илүү оновчтой байгааг доорх тодорхойлолтуудаас болно.[328]

Америкийн Нэгдсэн Улсын Мэдээллийн технологийн холбооноос (ITAA) "Компьютер дээр суурилсан мэдээллийн систем, программ хангамж болон техник хангамжийн дизайн, хөгжүүлэлт, хэрэгжүүлэлт, хангамж болон удирдлагыг мэдээллийн технологи" гэж тодорхойлжээ. Харолд Леавит, Томас Вислер нар "МЭӨ 3000 жилийн тэртээд Месопотами дахь Шумерчууд бичиг үсэг бий болгосноос эхлэн хүн төрөлхтөн мэдээллийг хадгалах, олборлох, ашиглах мөн мэдээлэл солилцох болсон, тус шинэ технологид одоогоор тогтсон ганц ч нэр

[327] А.Лхагва, Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал УБ, 2008, 176 дахь тал 8

[328] Б.Батчингис, Хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаанд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх нь, УБ, 2022, 9 дүгээр тал

байхгүй байна. Бид үүнийг мэдээллийн технологи гэж нэрлэх хэрэгтэй" гэж анх томьёолсон байна.

Байгууллага өмнөө тавьсан зорилгодоо нийцүүлж үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаа эсэхийг тодорхойлох, буруу үйлдлийг зогсоох, урьдчилан сэргийлэх ажиллагаа юм. Байгууллага үр ашигтай үйл ажиллагаа явуулахын тулд удирдлагын дээд, дунд, доод түвшнийг хамарсан хяналтын оновчтой системийг тогтоох нь чухал. Хорих байгууллагын харуул хамгаалалтад ашиглагдаж буй техник хэрэгслийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, түүнд нийцүүлэн баталсан журам, заавар, стандартад хамгаалалтын байгууламж, хамгаалалтын хүч хэрэгсэл, хамгаалалтын техник хэрэгсэл гэж ангилан, тэдгээрт ашиглаж буй хэрэгслийн төрөл, нэр, томьёог ийнхүү тусган тайлбарлажээ. Үүнд:

Хамгаалалтын байгууламжид: Хорих анги, цагдан хорих байр, хорих байр, хорих өрөөний хаалга, цонхны төмөр сараалжин хаалт, хэрмэн хашаа, үндсэн хашаа, хяналтын цамхаг, хөдөлгөөн хязгаарлагч /лабиринт/, Хөдөлгөөн сааруулагч, тольдуур, шалгах тавцан, галын булан, нүхэн яам.

Хамгаалалтын хүч, хэрэгсэлд: Хорих ангийн харуул хамгаалалтын болон бусад мэргэжлийн ажилтнууд, Галт зэвсэг, тусгай хэрэгсэл, Хамгаалалтын бүс, Тээврийн хэрэгсэл; Албаны нохой, Болзошгүй ажиллагааны үед ажиллах төлөвлөгөө болон хуулийн дагуу явуулж буй бусад ажиллагаа.

Хамгаалалтын техник хэрэгсэлд: Телекамер, телехяналт, цахилгаан, дохиолол бүхий сийрэгжүүлсэн хөрстэй бүс, дотоодын хориотой бүс, гэрэлтүүлэх хэрэгсэл, тэдгээрийн удирдлагын төхөөрөмж, тэжээлийн кабель, цахилгааны утас зэргээс бүрдэнэ.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд нарын 2017 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн А247, А167, 303 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив 15"-аар нээлттэй, хаалттай хорих ангиудад 20 хоригдол тутамд 1, хаалттай хорих ангийн тусгай нэгжид 5 хоригдол тутамд 1, нийслэл дэх цагдан хорих төвд 10 хоригдогч тутамд 1, орон нутаг дахь цагдан хорих байруудад 20-50 хоригдогчтой бол 2 хамгаалалтын ажилтан биечилсэн хяналт тавихаар тогтоосон хэдий ч өнөөгийн нөхцөл байдалд нийслэл, орон нутаг дахь хорих анги, баривчлах, цагдан хорих байранд хоригдож буй хүний тоог үүрэг гүйцэтгэж буй алба хаагчийн тоонд харьцуулан авч үзвэл 1 харуул хамгаалалтын ажилтан 80-100 хоригдолд хяналт тавин ажиллаж байгаа нь хэт өндөр үзүүлэлт юм. Мөн өнөөдрийн байдлаар хорих байгууллагын хэмжээнд үүрэг гүйцэтгэж буй хамгаалалтын ажилтан, холбоочин, дүрс бичлэгийн ажилтан зэрэг хоногийн харуул хамгаалалтад шууд аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий алба хаагчид 24 цагийн хоногийн үүрэг гүйцэтгэж, 48 цаг амарч байгаа нь Хөдөлмөрийн хуульд заасан ажил амралтын цагийн зохицуулалтыг зөрчихийн

зэрэгцээ, ажлын ачааллыг эрс нэмэгдүүлэн алба хаагчийн эрүүл мэнд, аюулгүй байдалд өндөр эрсдэлийг үүсгэн, алба хаагчийн эрх зөрчигдөх, хорих анги, байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагаврыг үүсгэж байна.

Хоригдлын тоо ихсэх бүрд хорих байгууллагын алба хаагчийн орон тоог нэмэх нь өрөөсгөл ойлголт бөгөөд энэхүү тулгамдаж буй сорилт бэрхшээлийн шийдвэрлэх гарц нь өнөөгийн эрүүгийн нөхцөл байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэлбэр, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн харуул хамгаалалтын үйл ажиллагаанд орчин үеийн технологийн шийдлийг нэвтрүүлэх замаар боловсронгуй болгох явдал юм.

Өнөөдрийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 243 дугаар зүйлийн 243.3, 243.2.4 дэх хэсэгт заасны дагуу хорих анги байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаанд HIK VISION маркийн тоон технологийн .... ширхэг телекамер, ... ширхэг дүрс бичлэгийн төхөөрөмж, …. орчим хяналтын дэлгэц болон бусад дагалдах тоног төхөөрөмж бүхий телехяналтын системийг ашиглаж байна.

Байгууллагын хэмжээнд “KENWOOD" маркийн хэт богино долгионы өндөр давтамжийн гар станц …. ширхэг, суурин станц … ширхэг, автомашины станц … ширхэг, нийт ….. ширхэг иж бүрдэл радио холбооны станц, төв орон нутгийн 6 байршилд дахин дамжуулах станцууд тус тус ашиглагдаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа хорих анги, байгууллага, салбар нэгжээс оргон зайлах гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллага, 401 дүгээр хаалттай хорих анги, нэгдсэн эмнэлэг, 421 дүгээр нээлттэй хорих анги, 423 дугаар нээлттэй, хаалттай хорих анги,429 дүгээр хаалттай хорих анги, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, 461 дүгээр хаалттай хорих анги зэрэг нийт 6 нэгжид гадна хамгаалалтын цахилгаан дохиоллын LANSTAR системийг нэвтрүүлэн харуул хамгаалалтын үйл ажиллагаанд ашиглаж байна. Энэ нь харуул Хамгаалалтын тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах ажлын хүрээнд сүүлийн 2 жилийн хугацаанд хорих анги, байгууллага, салбар нэгжид ашиглагдаж буй телекамерын системийг аналоги технологиос орчин үеийн тоон технологид (IP) шилжүүлэх ажлыг үе шаттайгаар шинэчлэн нийт ашиглагдаж байгаа телекамерын 93%-ийг шинэчилсэн байна.[329]

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 243, Хорих ангийн харуул хамгаалалтын журмын 3, 5, 6, 7 дугаар зүйлүүдэд хаалттай хорих ангийн гадна хамгаалалтын үйл ажиллагаа, ашиглагдах техник хэрэгслийн байгуулах эрх зүйн зохицуулалттай боловч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, хорих анги,

[329] Шүүхийн шийвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорих ял эдлүүлэх албаны 2021 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан. УБ.,

байгууллагын удирдлага тодорхой арга хэмжээ авч ажиллахгүй, санхүү, эдийн засаг, хөрөнгө мөнгөнөөс шалтгаалж гадна хамгаалалтын үйл ажиллагаа орхигдож, гадна хамгаалалтад ашиглаж байгаа техник хяналтын хэрэгсэл чанарын шаардлага хангахгүй болоод байна.

Дээрх нөхцөл байдлын улмаас хорих анги, байгууллагаас үйлдэгдэж буй орголт, гэмт хэрэг, зөрчлийн тоо буурахгүй байгаа нь өнөөгийн хорих байгууллагын практик үйл ажиллагаа, өмнөх онуудын судалгаа, тайлан, мэдээнээс тодорхой харагдаж байна.

Дээрх бүгдээс үзвэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа хорих байгууллагуудаас нэг хорих байгууллагыг сонгон туршилтын хугацаанд орчин үеийн техник, технологид суурилсан харуул хамгаалалт бүхий жишиг "Ухаалаг хорих анги" болгон өөрчлөн үр дүнг тооцож, бусад хорих байгууллагуудад үе шаттайгаар нэвтрүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авах хэрэгцээ шаардлага бий болоод байна. [330]

Хүснэгт 1. Системийн автоматжуулалт

Нэгдсэн дүрс бичлэгийн аналитикаар хамгаалалтын системийг автоматжуулах	Хэрэглэгчийн нууцлалыг хамгаалах моделууд	Дүрс бичлэг мөрдөн шалгах ажиллагааг гүйцэтгэхэд зориулсан quick search tool
Дүрс бичлэг тасралтгүй хийгдэж буй хяналт	Security Center-т биед суурилсан камеруудаас мэдээллийг шууд авах боломжтой	Программын тохируулга, ашиглалтыг хөгжүүлэхэд зориулагдсан шинэ функцууд

Энэ нь орчин үеийн компьютерын технологид суурилсан аюулгүй байдлын хяналтыг хангах ямар ч төрлийн салбар, байгууламж, тэр дундаа хууль сахиулах, ял эдлүүлэх ажиллагаанд тохирохуйц, зохицох бүрэн чадамжтай нэгдсэн хяналтын платформ юм. Үүнд:

Видео хяналтын системээс видео урсгал болон өгөгдлийг боловсруулахад зориулагдсан программ хангамжийн багц модуль

[330] Б.Батчингис, Хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаанд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх нь, УБ, 2022, 9 дүгээр тал

Зураг 1. Удирдлагын хяналтын төв



Том видео массив дахь объект, үйл явдлыг хайх хэрэгсэл хорих анги, байгууллагад гарсан гэмт хэрэг, зөрчлийг цаг алдалгүй, түргэн шуурхай тухайн үйл хөдлөлөөр хайх;

Зураг 3. Системийн хяналт.

Видео аналитик модуль: Улсын хэмжээн дэх хорих анги, байгууллага, салбар нэгжийн нийт телекамерт бичигдсэн дүрсэнд анализ хийнэ.

Нэвтрэх болон мэдээллийн аюулгүй байдлыг хязгаарлах хэрэгсэл: Хорих байгууллагын мэдээллийн санд гаднаас хандах эрхийг хязгаарлаж, эрхийн түвшнийг тогтоож, мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангана.

Мөн тус платформын программ нь хязгааргүй тооны камер, тусгай мэдрэгчтэй ажилладаг бөгөөд хорих ангиудад суурилуулах камерын тоо хязгаарлагдахгүй бөгөөд шугаман масштаб нь нэмэлт төхөөрөмж суурилуулахгүйгээр шинэ камертай холбогдох боломжийг олгож, камераас өгөгдлийг тухайн цагт боловсруулж, системийн хэрэглэгчдэд онцгой байдлын талаар мэдэгддэг давуу талтай байна. Видео анализын модулиуд нь хорих байгууллагын телехяналтын системд тулгуурлан хоригдол, хоригдогч, баривчлагдсан этгээдийн нүүр царай, хорих ангид нэвтэрч буй тээврийн хэрэгслийн улсын дугаар, таних тэмдэг, хоригдогсод олноор цугларсан газар зэргийг харуулах бөгөөд хамгаалалтын бүсэд зөвшөөрөлгүй хүн нэвтрэх, утаа илрэх, аливаа газарт хүмүүс сэжигтэй үйлдэл хийх зэрэг үйлдлүүдийг хянах боломжуудыг олгохоор байна.



Энэхүү хиймэл оюун ухаанд суурилсан дэвшилтэт технологи нь хоригдлын хувийн дугаар таних алгоритм болон видео анализыг ашиглан

теленхяналтын системд бичигдсэн томоохон өгөгдлүүд дээр бодит цаг гэмт хэрэг зөрчил, шуурхай хайлт хийх боломжийг олгодог.

Хиймэл оюун ухаан (зохиомол оюун) нь компьютерын программ хангамжаар бүтээгдсэн хүний сэтгэхүйг дуурилгасан ба бараг ижил түвшинд хүргэхийг хичээдэг технологийн төрөл ба аливаа хүний хийдэг үйл ажиллагааг хийж орлуулахад зориулагддаг болно. Мөн энэ асуудлыг судалдаг шинжлэх ухааны салбар, судалгааны чиглэл, их дээд сургуулийн хичээл, курсийг нэрлэхдээ энэ нэр томьёог ашиглана. Хиймэл оюун ухаан судлал, хиймэл оюун ухааны хичээл гэх мэт. Ихэнх хиймэл оюун судлаачид болон ном зохиолд судалгааны энэ чиглэлийг тодорхойлохдоо "ухаалаг агент бүтээх шинжлэх ухааны судалгаа" гэсэн байдаг. Энд ухаалаг агент гэж "орчноо танин мэдэж, тохирсон үйлдлийг гүйцэтгэхдээ амжилтад хүрэх магадлалаа дээд зэрэгт хүргэхийг эрмэлздэг систем"-ийг хэлжээ.[331]

Хиймэл оюун нь өөрөө өөрийгөө хөгжүүлж байдаг программ хангамжийн төгс программ юм. Бид бүхэн хиймэл оюуныг роботоор төсөөлж болно. Гэхдээ ялгаа нь өнөөгийн робот бол зөвхөн тухайн зохиогчийн бичигдсэн алгоритмын дарааллаар ажилладаг билээ. Мөн өнөөгийн компьютер тоглоомууд нь үүний тод жишээ юм. Хэрэв бид төгс хиймэл оюуныг зохион бүтээх аваас хүн төрөлхтөн өөрсдийнхөө бүтээсэн зүйлд устаж үгүй болох аюулт магадлал байгаа. Хиймэл оюунд байвал зохих чадварууд:

1. Өөрт дүн шинжилгээ хийж, хариултыг өөрийнхөөр илэрхийлдэг байх.
2. Өөрийнхөө алдааг өөрөө олж засварладаг
3. Хүний сэтгэхүйгээс илүү давсныг сэтгэх

Дээрх системийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаанд нэвтрүүлснээр улсын хэмжээний хорих байгууллагуудад ашиглагдаж буй олон төрөлт техник, технологиудыг нэгтгэн цогц системээр түргэн шуурхай, эрсдэлгүй, бүрэн удирдах боломжтой гэж судлаачид үзэж байна.

Бүгд найрамдах Хятад ард улс

Бүгд Найрамдах Хятад Ард Улс нь "Ухаалаг хорих байгууллагын бий болгох" нь дэлхийн хамгийн аюулгүй хорих анги байгуулах, менежментийн цогц чадварыг сайжруулах чиглэлийг баримталж ирсэн байна.

Тус чиглэлийн хүрээнд хууль сахиулах үйл ажиллагаанд хөдөлгөөнт терминал түгээмэл болсноор ухаалаг дагалдах хэрэгсэл, жолоочгүй хуяглан хүргэлтийн тээврийн хэрэгсэл, мэдээллийн системд анализ хийх гэх мэт ухаалаг

[331] www.wikipedia.org

программуудыг ашиглах, мэдээллийн санд задлан шинжлэх замаар хорих ангийн үйл ажиллагааг "Үйлдлийн дараах арга хэмжээ"-с "Үйлдлийг хийхээс өмнөх хяналт"-д, мэдээллийг боловсруулах системээс мэдээллийг урьдчилан таамаглах, ээлжийн ажил хүлээлцэх менежментийг ухаалаг төхөөрөмжийн менежментийн хэлбэр рүү шилжүүлэх боломжийг бүрдүүлжээ.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хорих байгууллагад "Ухаалаг хорих байгууллага" төслийн хүрээнд дараах 14 системийг нэвтрүүлсэн байна.[332] Үүнд:

Видео аналитик хяналтын систем: Видео шинжилгээний технологийг ашиглан хоригдогчдын хэвийн бус байдал, үйлдлүүдийг илрүүлэх.

Эрүүл мэндийн хяналтын систем: Цахим бугуйвч ашиглан хоригдогчдын зүрхний цохилт болон бусад бие байдлыг хянах.

Явах хөдөлгөөний хяналтын систем: Ухаалаг бугуйвч ашиглан хоригдогчдын өрөөнөөс гаднах хөдөлгөөнийг хянана.

Мансууруулах бодис мэдрэгч автомат роботын систем: Мансууруулах бодис болон бусад хориотой эд зүйл нэвтрэхээс урьдчилсан сэргийлэх зорилгоор автомат робот үзлэг шинжилгээ хийх.

Цахилгаан цоожны аюулгүй байдлын систем: Албан хаагчдын нүүр царайгаар таньж үйлдэл үзүүлэх аюулгүй байдлын төхөөрөмж.

Байршлын мэдээллийн систем: Ухаалаг бугуйвч, нүүр таних технологийг ашиглан түр саатуулах байранд хоригдож байгаа хүний тоо, түүнчлэн тэдгээрийн бодит цагийн байршлыг байгууламжийн газарзүйн мэдээлэлтэй нэгтгэх;

Харилцаа холбооны нэгдсэн систем: Хоригдогч, харилцагч хоорондын утсан холбоо харилцааны үед дуу хоолойг илрүүлж зөвшөөрөлгүй гуравдагч этгээдийн оролцоог таслан зогсоох;

Түлхүүр ба тоног төхөөрөмжийн нэвтрэх систем: Түлхүүр, тоног төхөөрөмжийн менежментийг хөнгөвчлөхийн тулд /RFID /радио давтамжийг тодорхойлох технологийг ашиглана.

Хоригдогчдын цахим шүүгээ: Ухаалаг бугуйвчийг ашиглан өөрсдийн эд зүйлс хадгалах шүүгээг түр хугацаанд эзэмших боломжтой.

Хоригдогчдын өөртөө үйлчлэх ТҮЦ машин: Ухаалаг бугуйвч болон өөрсдийн хувийн дугаартайгаа хослуулан хоол худалдаж авах, өргөдөл гаргах,

[332] Хонг Конг (БНХАУ)-ийн Хорих байгууллагын ахлах мэргэжилтэн ноён Хуй Вай Ман. Хорих ангийн үйл ажиллагаа, нийгэмшүүлэх, олон нийтэд суурилсан засан хүмүүжүүлэх ял эдэлж буй хоригдогсдод хяналт тавих зэрэг үйл ажиллагаанд орчин үеийн технологийг ашиглах нь. Ази, номхон далайн бүс нутгийн хорих байгууллагын удирдах ажилтнуудын 39 дүгээр бага хурал. УБ. 2019

хүсэлт гаргах, гэр бүлийнхэнтэйгээ харилцах зэрэг үйлчилгээг өөртөө үйлчлэх ТҮЦ машинаас авах боломжтой.

Хоригдогчдын бие даан суралцах таблет: Хоригдогчид таблетаар цахим ном унших, цахим сэтгүүл унших, хөгжим, видео үзэх гэх мэт өөртөө үйлчлэх;

Робот хяналтын систем: Хянагчийн эргүүл хийх тогтсон хугацааны хоорондох сул цагийн үед хоригдогчдыг биечлэн хянах.

Ухаалаг хяналтын систем: Wifi, Bluetooth болон GPS технологид суурилсан ухаалаг бугуйвч ашиглан хорихоос өөр төрлийн ял, батлан даалтад байгаа хоригдогчдыг хянах.

Албан хаагчдын гар төхөөрөмж: Албан хаагчдыг үүргээ гүйцэтгэх ажлыг хөнгөвчлөх, тэдний хоорондын харилцааг сайжруулах зорилгоор гар төхөөрөмжөөр буюу таблет.

Сингапур улс

Сингапур Улсын хорих байгууллагын нэвтрүүлсэн аюулгүй байдлын систем нь бүх хоригдогчдын суурь, нэгдсэн, бие даасан байрны систем юм.

Тус систем нь хоригдогчдын "Амьдрах байрны хэсэг" голчлон чиглэгдсэн бөгөөд хоригдлуудын бие махбодын болон динамик 16 аюулгүй байдлыг хангах, тэдэнд учирч болох эрсдэлийг, харилцан адилгүй хэрэгцээ шаардлагад нийцүүлэн нийгэмшүүлэх ажлыг үр дүнтэй зохион явуулах зориулалттай байгуулсан байна.

Мөн тус системийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр болох "Хянагчгүй хорих байгууллага" хөтөлбөрийг хэрэгжилтийг сайжруулахад дэвшилтэт технологийг ашигласан. Техник, технологийн дэвшлийг ашигласнаар өдөр тутмын энгийн ажлыг автоматжуулж, албан хаагчдад нарийвчилсан, боломжийг олгох бөгөөд дараагийн түвшний ажлыг гүйцэтгэх хоригдогчийг засан хүмүүжүүлж, нийгэмшүүлэх арга хэрэгслийг дижитал хэлбэрт шилжүүлэх (DIRECT), хорих байгууллагын үйл ажиллагаа, засан хүмүүжүүлэх системийн хөдөлгөөнт төхөөрөмж (M-PORTS) зэрэг хоёр төслийн нэвтрүүлжээ.[333]

Нийгэмшүүлэх арга хэрэгслийг дижитал хэлбэрт шилжүүлэх (DIRECT) систем: "DIRECT" систем нь хоригдогчдыг нийгэмшүүлэх хөтөлбөр болон бусад төрлийн үйлчилгээг авах боломж юм. Тухайлбал, цахим захидлыг аюулгүйгээр илгээх, хүлээн авах боломжтой, цахим хэлбэрийн ном унших боломжтой болсноор хорих байгууллагад захидал, номыг хууль бусаар нэвтрүүлэх явдал буурсан байна. Захидлын хуулбарууд нь байгууллагын үйл ажиллагаа, засан хүмүүжүүлэх системд автоматаар хадгалагдан үлдэх горимтой тул гар аргаар цахим хувилбарт

[333] Сингапур Улсын Хорих байгууллагын зааварлагч Сеу Мун Чунг. Орчин үеийн технологийн дэвшлийг хорих байгууллагын үйл ажиллагаа, хоригдогсдод хяналт тавих, тэднийг нийгэмшүүлэх хөтөлбөрт ашиглах нь, Ази, номхон далайн бүс нутгийн бага дүгээр хорих байгууллагын удирдах ажилтнуудын 39 хурал, УБ. 2019.

шилжүүлэх ажлыг хөнгөвчилсөн юм. Хоригдогчдыг эргэн нийгэмшүүлэх, ур чадварыг сайжруулах, боловсрол олгох зэрэг хөтөлбөрүүдийн сургалтын материалыг "DIRECT" системд хадгалснаар хоригдогчид өрөөнөөсөө бүх хөтөлбөр, сургалтыг авах боломжтой болсноор нэмэлт танхимын сургалт, зай талбайн асуудлыг шийдвэрлэх боломжийг бүрдүүлжээ.

Хорих байгууллагын үйл ажиллагаа, системийн хөдөлгөөнт төхөөрөмж (M-PORTS II) M-PORTS III систем засан хүмүүжүүлэх нь Сингапур Улсын хорих байгууллагын мэдээллийн технологийн гол системүүдийн нэг бөгөөд тус системийн тусламжтайгаар эргэн нийгэмшүүлэх болон бусад үйл ажиллагааны явцад дэмжлэг үзүүлэх зориулалттай байна. M-PORTS II нь албан үүргээ гүйцэтгэж буй офицеруудын ажлыг хөнгөвчлөх зорилгоор өөрчлөн тохируулсан PORTS II программыг агуулсан электрон гар төхөөрөмж юм.

Алба хаагч M-PORTS II-г ашиглан албан өрөөнөөс гадуур мэдээлэл олж авах боломжоор хангагдаж, өөрт шаардлагатай мэдээллийг олж авах, шинэчлэхийн тулд ширээний компьютер ашиглах шаардлагагүй болсон. Эдгээр хөдөлгөөнт төхөөрөмжүүдийн тусламжтайгаар хорих байгууллагын албан хаагчид тухайн орчин, хоригдогчийн нөхцөл байдлын талаар хамгийн сүүлийн үеийн мэдээллийг авах боломжтой. Нөхцөл байдлын талаарх ойлголтыг сайжруулснаар ослын менежментэд илүү хурдан, үр дүнтэй хариу арга хэмжээ авах боломжийг бүрдүүлжээ. Мөн хорих байгууллагын ажилтнуудад мэдээллийг дүрслэн харуулах, гар дээрээс илүү мэдээлэлтэй болж илүү оновчтой шийдвэр гаргах боломжийг бүрдүүлсэн.

ДҮГНЭЛТ

Нийгэм, эдийн засгийн харилцаа, эрүүгийн нөхцөл байдал хурдтай хувьсан өөрчлөгдөж байгаа өнөө үед хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаанд орчин үеийн технологийг шинэчлэн нэвтрүүлэх замаар ял эдлүүлэх ажиллагааг нэг мөр хэрэгжүүлэх, түүнийг боловсронгуй болгох, тулгамдаж буй асуудлыг цогц байдлаар шийдвэрлэх, хэрэгцээ шаардлага байсаар байна. Гэвч дэлхий нийтийн техник технологийн хурдацтай хөгжилд нийцүүлэн хорих ангийн харуул хамгаалалтад ашиглаж буй техник хэрэгслийг тухай бүр шинэчлэн сайжруулахад хүндрэлтэй хэдий ч тухай бүр шинэчлэн сайжруулахад хүндрэлтэй байна.

Хиймэл оюун ухааныг бид хүнээс илүү ухаантай робот, супер хүчин чадалтай компьютероор төсөөлдөг. Гэхдээ энэ нь аль хэдийн орчин үеийн технологийн ертөнцийн салшгүй нэгэн хэсэг болж, бид өөрсдөө ч мэдэлгүй өдөр тутмын амьдралдаа үүнийг ашигладаг бөгөөд энгийн нэгэн гар утас, компьютер гэх мэт бүхий л ухаалаг төхөөрөмж болон цахим сүлжээнүүд хиймэл оюун ухаан дээр суурилагдсан байдаг юм.

Иймд Манай улсын хувьд гадаад улс орнуудын туршлага, техник технологийн дэвшлийг судалж, цаашлаад хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаанд тухай бүр нэвтрүүлж, “Ухаалаг хорих байгууллага” болж хөгжих боломжтой.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. А.Лхагва, Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал УБ, 2008, 176 дахь тал 8

2. Б.Батчингис, Хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаанд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх нь, УБ, 2022, 9 дүгээр тал

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорих ял эдлүүлэх албаны 2021 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан. УБ.,

4. www.wikipedia.org

5. Хонг Конг (БНХАУ)-ийн Хорих байгууллагын ахлах мэргэжилтэн ноён Хуй Вай Ман. Хорих ангийн үйл ажиллагаа, нийгэмшүүлэх, олон нийтэд суурилсан засан хүмүүжүүлэх ял эдэлж буй хоригдогсдод хяналт тавих зэрэг үйл ажиллагаанд орчин үеийн технологийг ашиглах нь. Ази, номхон далайн бүс нутгийн хорих байгууллагын удирдах ажилтнуудын 39 дүгээр бага хурал. УБ. 2019

6. Сингапур Улсын Хорих байгууллагын зааварлагч Сеу Мун Чунг. Орчин үеийн технологийн дэвшлийг хорих байгууллагын үйл ажиллагаа, хоригдогсдод хяналт тавих, тэднийг нийгэмшүүлэх хөтөлбөрт ашиглах нь, Ази, номхон далайн бүс нутгийн бага дүгээр хорих байгууллагын удирдах ажилтнуудын 39 хурал, УБ. 2019

ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТҮҮХЭН ЭХ СУРВАЛЖ

HISTORICAL SOURCE OF SENTENCES OTHER THAN DEPORTATION



Б.Насанжаргал
Дотоод хэргийн их сургуулийн
Сургалт, судалгааны 403 дугаар анги-
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
521 дүгээр дамжааны сонсогч

Хураангуй: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь зөвхөн эрүүгийн ял эдлүүлэх тэр дундаа зөвхөн хорих ял эдлүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг байсан цаг үе өнгөрч 1955 оноос эхлэн шүүхээс гарсан бүхий л төрлийн шийдвэрийг гүйцэтгэдэг үндэсний хэмжээний томоохон агентлаг болон өргөжсөн. Гэмт хэрэгтнийг нийгмээс тусгаарлахгүйгээр засан хүмүүжүүлэх, нийгэм хамт олны дунд, гэмт хэрэгт нь тохирсон ялыг эдлүүлж, ухамсарлуулах талыг чухалчлан үзэж цээрлэлийг хорихоос өөр төрлийн ялын мөн чанараар хэрэгжүүлж, хууль тогтоомжийн хэрэгжилт олон нийтэд ил тод хяналт дор явагдах нөхцөлийг бүрдүүлж сайжруулах талаар улам бүр хууль тогтоомж шинэчлэгдэн олон улсаас туршлага судалж шинийг эрэлхийлэн хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлоон хөгжсөөр байгаа юм.

Summary: The court's decision-making body is only responsible for criminal punishment From 1955 onwards, it has grown into a large-scale agency that executes all types of court decisions. More and more laws and regulations to improve the conditions for the implementation of laws and regulations to be carried out under public supervision, with emphasis on the aspect of correcting and educating criminals without isolating them from society, serving sentences appropriate to their crimes in the community, and making people aware It is reformed and continues to develop a humane civil democratic society by studying the experiences of many countries and seeking new ones.

Түлхүүр үг: Гэмт хэрэг, ялтан, ял, торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, эрх хасах;

Key words: Crime, convict, sentence, fine, community service, restriction of travel rights, disqualification

Удиртгал:

Хорихоос өөр төрлийн буюу олон улсад “альтернатив ял” гэж нэрлэгддэг ял (alternative penalty) нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг шүүхээр тогтоосны дараа нийгмээс тусгаарлаж, тогтоосон хугацаанд хорихгүйгээр тодорхой эрхийн хязгаарлалт тогтоох хэлбэрээр хэрэгждэг[334].

Монгол улсын Шүүх засаглалын нэг томоохон хэсэг болох Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгох эрин зууны шинэ шаардлагыг эрх зүйт төрийн өнөөгийн төлөвшилтэй уялдуулан хэрэгжүүлэх зорилтыг тавих болсон[335].

Дэлхийн олон улс эрүүгийн ялын бодлого хүний эрхийг хангах, хүнлэг энэрэнгүй ёсны хандлагыг хэрэгжүүлэх, ялын чанга шийтгэлээс үндсэндээ татгалзах, гэмт этгээдэд хүмүүжил, төлөвшил олгох хүрээнд хорихоос өөр төрлийн нөлөөллийн арга хэмжээг хэрэглэх чиг хандлагатай болжээ[336].

Монгол Улсын Эрүүгийн хуульд хорихоос өөр төрлийн 4 ял байдаг ба үүнд;

- Торгох ял
- Нийтэд тустай ажил хийлгэх ял, албадан ажил хийлгэх, албадан хөдөлмөр хийлгэх, хөдөлмөр хийлгэх, үйлдвэр хийлгэх
- Зорчих эрхийг хязгаарлах ял, нутаг заах, зайлуулах
- Эрх хасах ял

Торгох ял-“торгууль” гэх үгийн эхний утга нь “ял болгож авах мөнгө, торгуулийн мөнгө, тавин төгрөгийн торгууль ногдов” гэсэн утгатай[337], хууль зүйн толь бичигт англи хэлнээ торгууль гэдгийг “fine” гэж тэмдэглэсэн байдаг[338]. Гэмт хэрэг үйлдсэн хувь хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд, шүүхээс, торгуулийн тогтоосон нэгжийн хэмжээгээр, мөнгөн төгрөг төлөх хэлбэрээр торгууль оногдуулахыг **торгох ял** гэнэ.

Нийтэд тустай ажил хийлгэх ял- Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг **нийтэд тустай ажил хийлгэх ял** гэнэ[339].

---

[334] Очгэрэл, Ц. Торгох ялын хэрэгжилт ба түүний хэрэгжилтэд анхаарах асуудал эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Уб., 2017. 411 дахь тал

[335] Дашзэвэг, Б. Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй. Уб., 2003 он. 5 дахь тал

[336]Алтангэрэл, Б. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа. Уб., 2018. 29 дахь тал

[337]Цэвэл, Я. Монгол хэлний тайлбар толь. Уб., 1966. 544 дахь тал.

[338]Нарангэрэл,С. МУ-ын Хууль зүйн нэвтэрхий толь бичиг. Уб., 2021. 396 дахь тал.

[339] Торгох ялын үндэс нь торгууль юм. Энэ торгууль нь /бусад торгуулийг бодвол/ эрүүгийн хуульд заагдсан ял болохын хувь Монгол Улсын мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр тооцогдож байгаа болно.иргэний эрх зүйн харилцаанд үүргийн гүйцэтгэлийн хангах нэг арга болох анзын нэг хэлбэр торгууль, нөгөөх нь алданги байдаг... Иргэний хууль 232 дугаар зүйлийн 232.4 ба232.5 дахь хэсэг

Эрх хасах ял- Гэмт хэрэг үйлдсэн хүний нийтийн албанд ажиллах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, эсхүл бусад тодорхой эрхийг нэг жилээс найман жил хүртэл хугацаагаар хориглохыг **эрх хасах ял** гэнэ.

Зорчих эрхийг хязгаарлах ял- Гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг нэг сараас таван жил хүртэл хугацаагаар хүлээлгэхийг **зорчих эрхийг хязгаарлах ял** гэнэ.

Хорихоос өөр төрлийн ялын төрөл ангилал түүний түүхэн тоймчлол

1926 он Манай улсны анхны эрүүгийн хууль болох БНМАУ-ын "Шүүх цаазын бичиг"-ийн "Ял ба засан сайжруулах арга хийгээд ард олныг арчлан хамгаалах аргууд нь" гэсэн 2-р бүлэгт хорихоос өөр төрлийн 4 ялыг тусгасан.

Уг Шүүх цаазын бичгийн 11 дүгээр зүйлд "торгох" ялын талаар хуульчлан тогтоожээ[340]. Үүнд: "Ял торгууль дор төгрөг ба мөнгөөр тогтооно. Хэрэв цааз хуулийн дотор ялын дээд хэмжээ 100 төгрөгөөс дээш бус болбоос ял торгохыг даган 10 төгрөгөөс дорогш /доош/ торгож үл болно. Ял тушаах хугацааг Шүүх таслах газрын тогтоол шийтгэсэн өдрөөс хойш 1 жил хүртэл сунгаж болно. Хэрэв ялыг тушаах чиггүй бөгөөс нэгэн төгрөгт нэгэн өдөр бодож түүний биеийг хорихгүйгээр үйлдвэр хийлгэнэ.

Ялаас зайлсхийвэл хувийн хөрөнгө хогшлыг албан газраас данс тэмдэг үйлдэж худалдах буюу банкны зэрэг газар хадгалуулсан мөнгө, зоос, бусдаас авах зүйл байваас тэдгээрийг битүүмжлэх зэргээр тушаалгаваас зохино[341] гэжээ.

3-р зүйлд дахь хэсэгт анх "Нийтэд тустай ажил хийлгэх" ялыг "Гяндан хорихгүйгээр албадан үйлдвэр хийлгэх" хэмээх агуулгаар зааж, "Хорихгүйгээр үйлдвэр хийлгэх ялын хугацаа 100 өдрөөс үл хэтэрнэ" гэж хуульчилжээ.

Харин "Гадаад улсын харьяат нарыг хязгаараас үлдэн гаргах" хэмээн зорчих эрхийг хязгаарлах ялыг заажээ. Энэ нь 1926 оны шүүх цаазын бичгийн 15, 1929 оны шүүх цаазын бичгийн 17 дугаар зүйлүүдийн агуулгаас тод харагдах бөгөөд "гадаад улсын иргэдийн хувьд гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд тэдгээр нь тус улсад оршин суухад сэжиг бүхий харш шалтгаантай байвал шүүх эргэж ирэхгүй байхаар хөөн гаргах ялыг нэмж тогтоож болно" гэсэн утга юм.

"Тушаалаас огцруулах буюу ямар нэгэн эрхэлж буй ажил үйлдвэрлэлийг хийхийг нь цаазлах", "Аливаа эрхүүдийг бүрэн буюу эсхүл заримыг хугацаагаар

[340] Шүүх цаазын бичиг. Уб., 1927. БНМАУ-ын Засгийн газрын албаны сэтгүүл. №23.
[341] Адъяабазар, Д. Монгол Улсын 1921 оноос хойших Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт /1 дэвтэр/. Уб., 1998. 9,10 дахь тал.

буюу үүрд эвдэх” хэмээн зааж байжээ[342]. Гэмт явдлыг үйлдэгчдийн уг ялын дээр шүүх таслах газруудаас зүй зохисыг үзэж ялт хүний аливаа эрхүүдийг бүрэн буюу заримыг хугацаагаар буюу эсвэл үүрд эвдэх /хасах/ зэргээр нэмэгдүүлэн яллуулж болно гэжээ.

1929 он БНМАУ-ын “Шүүх цаазын бичиг”-д өмнөх оноос ялгарах онцлог нь торгуулийг төгрөгөөр тогтоож улсын ба орон нутгийн сан дор хурааж гэм хор, хохирлыг арилгуулахаар зааснаас өөрөөр зарчмын шинжтэй өөрчлөлт хийгээгүй байна.

"Гадаад улсын харьяат нарыг хязгаараас үлдэн гаргах" хэмээх утга санаагаар маш Хязгаарлагдмал агуулгаар зорчих эрхийг хязгаарлах ялыг тухай тус тус зааснаас[343] өөр томоохон хэмжээний шинэ зүйл заалт нэмэгдээгүй.

“Тушаалаас огцруулах ба ямар нэгэн эрхэлж буй аж үйлдвэрээ хийхийг нь цаазлах, 12-т "Зарим нэг эрхийг хугацаагаар эвдэх" гэсэн зүйлүүдэд зарим нэг агуулгаар эрх хасах ялын талаар хуульчилсан байна. Зарим нэг эрхийг хугацаагаар эвдэх гэсэн нь

- Сонгох сонгогдох
- Аливаа сонгуулийн тушаалыг явуулах эрх
- Ардын шүүн таслах газрын ардын төлөөлөгчийн алба явуулах эрх
- Уг газраас бус газраас шилжин явах эрх эдгээр эрхүүдийг эвдэх явдлыг 1-5 жилийн хугацаатай эдлүүлж байжээ.

1934 он БНМАУ-ын Шүүх цаазын бичиг 4 дүгээр бүлгийн "Шийтгэх ялууд нь" гэсэн 14 дүгээр зүйлийн 9-д "Мөнгөөр торгох" хэмээн зааж, уг шүүх цаазын бичгийн 28 дугаар зүйлд торгох ялын талаар хуульчлан тогтоосон байна.

Үүнд; Энэхүү шүүх цаазын бичгийн тусгай зүйлүүдэд заасан хэмжээний дотор шүүх таслах газраас мөнгөөр хэмжээ тогтоон шийтгэхийг торгууль гэгдэнэ. Торгууль ногдуулан шийтгэхэд уул шийтгэгдсэн этгээд нь ямар байдлаар амьдран суудаг ба хөрөнгө чинээний байдлыг харгалзан тогтоон ногдуулах бөгөөд хураасан торгуулийг улсын санд оруулна. Хэрэв ногдсон торгуулийг эс төлбөл шүүх таслах газраас хорихгүйгээр албадан ажил хийлгэхээр сольж тогтоогоод 50 төгрөг бүрийн төлөө 1 сар албадан ажил хийлгэх болгон гүйцэтгэж болно. Торгохын оронд хорьж, мөн хорихын оронд торгож болохгүй. Хөрөнгө хураахад оролцохгүй юмнуудыг мөн торгууль болгон хурааж болохгүй. Мөн биеийн хүчин

[342] ХЗҮХ. Дурдсан бүтээл /1911-2009/. УБ., 2011. 282 дахь тал
[343] Адьяабазар, Д. Дурдсан бүтээл. Уб., 1998.9. 10. 38. 40 дахь тал

үнэлэн амьдрах хүмүүст торгууль ногдуулахдаа 2 сарын хөлсний хэмжээнээс хэтрүүлэн тогтоож болохгүй[344] гэсэн томоохон зохицуулалт нэмэгдсэн байна.

Дээрх бүлгийн 14 дүгээр зүйлийн 3-т "Хорихгүйгээр албадан ажил хийлгэх" ялын тухай зааж, 21 дүгээр зүйлд "... албадан ажил хийлгэх нь уул ял шийтгэгдэгсдийг ажил үйлдвэрээр засан сайжруулах ба сахилга журамтай болгохын тулд хэрэглэнэ. Хорихгүйгээр албадан ажил хийлгэх явдлыг 7 хоногоос 6 сар хүртэл хугацаагаар тогтооно. Түүнчлэн Үндэсний улаан цэргийн жинхэнэ албанаа бүхий цэргийн хүмүүсийг хорихгүйгээр албадан ажил хийлгэж үл болно" гэж тусгажээ[345].

"Улсын хязгаараас хугацаагаар ба үүрд үлдэн гаргах, үүнийг гадаадын харьяатанд хэрэглэнэ" гэж өмнөх оны бүлгийн нэрийг өөрчлөхийн сацуу "Аливаа нэгэн орон нутгаас шилжүүлэн зайлуулах бөгөөд үүнд аль нэг орон нутагт оршин суухыг цаазлах ба үл цаазлах 2 янз байна" гэсэн зохицуулалт хийсэн байна. Энэ хуулийн онцлог нь нэгж нутгаас нүүх, нутагт шилжүүлэн суулгах зэрэг нэмэгдэл ял тогтоож болно.

"Улс төрийн эрхийг эвдэх ба хувийн зарим эрхийг эвдэх", "Албан тушаалаас буюу эрхэлж буй ажлаас халах цааш мөнхүү эрхлэн буй ажлыг уламжлан хийхийг цаазлах ба цаазлахгүйгээр халах" хэмээн зааж, Шүүх цаазын бичгийн 22, 23 дугаар зүйлд дараах агуулга бүхий байдлаар эрх хасах ялын талаар хуульчилсан байна. Улс төрийн эрхийг эвдэх ба хувийн эрхийг эвдэх ялыг 1-5 жил хүртэл тогтооно. Үүнд:

1. Сонгох ба сонгогдох эрхийг хасах,

2. Олон нийтийн байгууллагад сонгуулийн тушаалд орох эрхийг хасах,

3. Улсын аливаа нэгэн албан тушаалыг эрхлэн явуулах эрхийг хасах,

4. Хүнд нэр нэрлэх ба аливаа гавьяаны тэмдэг зүүх эрхийг хасах,

5. Эцэг, эх бологсдын эрхийг хасах. Эдгээр дурдсан эрхүүдийг уул ял шийтгэгдсэнд цөмийг буюу зарим нэгнийг эвдэн тогтоож болох боловч 1 жилээс дорогш хугацаагаар хорих ял шийтгэгсдэд эрхийг эвдэж үл болно. Шүүх таслах газраас ял шийтгэгдэгсдийн гавьяаны одон тэмдгийг хураах ёстой гэж үзэх энэ тухай Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн газар мэдүүлж байцаан тогтоолговол зохино. Эцэг эхийн эрхийг хасах явдлыг ял шийтгэгдэгсдээс уул эрхээн хортойгоор хэрэглэсэн нь илэрсэн аваас сая гүйцэтгэж болно.

Уул эрхэлсэн ажлаа явуулахыг цаазлах буюу аливаа нэгэн нутгаас шилжүүлэн зайлуулах явдлыг тогтоохдоо шийтгэгдэгсэд нь уул газраа хэвээр

[344] Хууль зүйн үндэсний хүрээлэн. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал /1911-2009/. Уб., 2011. 350-351 дахь тал
[345] ХЗҮХ. Дурдсан бүтээл /1911-2009/. УБ., 1949. 58 дахь тал

үлдвээс олон нийтэд аюултай хэмээн шүүх таслах газраас үзвэл сая хэрэглэж болох бөгөөд энэхүү Шүүх цаазын бичгийн тусгай ангийн гагц зүйлүүдэд заасан гэмт хэрэг үйлдэгсдийг эрүүгийн хариуцлагад татан шийтгэхдээ уул ялыг хэрэглэж болох ба хугацааг 1-3 жилээр тогтоож болно.

Үүнээс үзэхэд ялтанд хариуцлага хүлээлгэхдээ шүүхээс гарсан үндэслэл журмын дагуу хариуцлага оногдуулж гэм бурууд нь тохирсон шийтгэл хүлээлгэж, шударга шүүхийг явуулж, Үндсэн хуулийн зарчмын хүрээнд үйл ажиллагаа явуулахыг эрмэлздэг байсан нь харагдаж байна.

1942 оны БНМАУ-ын "Эрүүгийн хууль"-ийн "Гэмт хэрэг үйлдэгчдэд Эрүүгийн хуулийн ёсоор оногдуулах ялын тухай" гэсэн 4 дүгээр бүлгийн "Шүүх таслахын засан сайжруулах чанар бүхий арга хэмжээнүүд" гэх зүйлийн 8 дугаарт торгох ялыг "Мөнгөн торгууль" хэмээн нэрлэж заасан байна[346]

Шүүх таслах газраас мөнгө торгож шийтгэх этгээдийн хөрөнгө чинээний байдлыг харгалзан тогтоовол зохино. Хэрэв оногдсон торгуулийг эс төлбөл шүүх таслах газраас хорихгүйгээр засан сайжруулах хөдөлмөр хийлгэх шийтгэврээр сольж болох бөгөөд үүнд торгуулийн 120 төгрөгт 1 сарын хугацааны засан хөдөлмөр хийлгэхээр бодвол зохино. Хөрөнгө хураах дэлж амьдрах хүмүүст торгуулийг оногдуулахдаа түүний 2 сарын цалингийн хэмжээнээс хэтрүүлэн тогтоож үл болно" гэжээ. Энэ хуулийн заалтын өөр нэгэн өөрчлөлт нь өмнөх хуульд 50 төгрөгт 1 сар хөдөлмөр хийлгэдэг байсан бол шинэ зохицуулалтад 120 төгрөг болж өөрчлөгдсөн мөн хөрөнгө чинээнээс харгалзан торгох шийтгэлийг тогтоох заалт нь хүнлэг энэрэнгүй ёсны зарчмыг харуулж байгаа юм.

19 дүгээр зүйлийн 2-т ... Хорихгүйгээр засан хүмүүжүүлэх хөдөлмөр хийлгэх" хэмээх утгаар нийтэд тустай ажил хийлгэх ялын талаар дурдаж, тус хуулийн 30 дугаар зүйлд хуульчлан заасан байна.

Үүнд "Хорихгүйгээр засан хүмүүжүүлэх хөдөлмөр хийлгэх ялыг 14 хоногоос 1 жил хүртэл хугацаагаар тогтоож, уг ажиллаж байсан газар дээр нь ажиллуулах ба цалингийн 10-25 хувийг суутган улсын орлого болгож байвал зохино. Ажилгүй байсан хүмүүсийг засан хүмүүжүүлэх газар шилжүүлнэ. Тайлбарлах нь: Ардын хувьсгалт цэргийн хугацаагүй албыг хааж байгаа дунд, ахлах, дээд ба бага дарга нар, мөн түүнчлэн ардын хувьсгалт цэргийн хугацаа бүхий албыг хааж байгаа бага дарга, цэргүүдэд хорихгүйгээр засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн ажлыг үл оногдуулна. Үүнд: Ийнхүү засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн оронд дээр дурдсан цэргийн албан хаагчдад ардын хувьсгалт цэргийн сахилга журмын дүрэм ёсоор 2 сар хүртэл хорьж шийтгэвэл зохино[347].

[346] БНМАУ-ын Эрүүгийн хууль. Уб., 1949. Шүүх яамны хэвлэл. 58 дахь тал
[347] БНМАУ-ын Эрүүгийн хууль Уб., 1949. 58 дахь тал. Шүүх яамны хэвлэл. 58 дахь тал

“Гадаадын харьяат нарт болбол БНМАУ-ын хилээс үлдэн хөөх”, “Аль нэгэн аймаг нутагт суухыг цаазалж тусгай заасан нутагт шилжүүлэн суулгах буюу эсвэл тийнхүү тусгай газрыг заахгүйгээр ямар нэгэн нутгаас зайлуулах"[348] гэсэн шинэ нэр томьёогоор зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжүүлж байсан байна.

19 дүгээр зүйлийн 3-т "Улс төрийн ба иргэний зарим эрхүүдийг хасах", "Аль нэг тушаалыг эрхлэхийг цаазлах буюу эсвэл цаазлахгүйгээр тушаалаас огцруулах" хэмээн тусгаж, Эрүүгийн хуулийн агуулгад дараах байдлаар эрх хасах ялын талаар хуульчлан заажээ.

- Улс төрийн ба ард иргэний зарим эрхийг хасаж болох. Үүнд:

  1. Сонгох ба сонгогдох эрх,

  2. Улсын ямар нэгэн тушаал үүргийг гүйцэтгэх эрх,

  3. Хүндэт цол эдлэх эрх,

  4. Эцэг, эх болох эрх,

  5. Нийгмийн аюулаас хамгаалах эрх, ба улсаас эрхлэн хангах журмаар өгч байгаа тэтгэвэр авах эрх. Гэмт этгээдийн эрхийг өмнө дурдсан зүйлүүдээр бүрэн буюу заримыг хасаж болно.

- Эрхэлсэн албан тушаалаас халж зайлуулах буюу эрхэлсэн ажлыг хориглох явдалд холбогдсон этгээдийн хэргийг таслан шийтгэхэд түүний эрхэлж бүхий албан тушаал буюу эрхэлсэн ажилд хэвээр үлдээхэд нийтэд аюултай гэж шүүх таслах газраас үзвэл тийнхүү эрхийг хасаж болох бөгөөд хугацаа нь 1-5 жил хүртэл болно.

1961 оны БНМАУ-ын Эрүүгийн хуульд "Торгох", үндсэн ялаас гадна "торгох ялыг нэмэгдэл ялын чанартай хэрэглэж болно" гэж заасан нь торгох ялыг өмнөх оноос онцлох онцлогтой болж байгаа юм.

Торгуулийн хэмжээг гэмт этгээдийн хөрөнгийн байдал, хэргийн хүнд хөнгөнийг харгалзан тогтооно. Торгууль төлөх хугацааг шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 2 сараас дээшгүйгээр тогтооно. Тогтоосон хугацаанд торгуулийг төлөхгүй бол шүүх торгуулийн 75 төгрөг бүрийг 1 сарын засан хүмүүжүүлэх ажилтай тэнцүүлэн бодож, уг торгох ялыг засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялаар сольж болох боловч 1 жил 6 сараас хэтрүүлж болохгүй. Торгуулийг хорих ялаар сольж болох буюу хорих ялыг торгуулиар сольж болохгүй" гэжээ[349]

"Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх" хэмээх агуулгаар нийтэд тустай ажил хийлгэх ялыг томьёолсон байна.

[348] БНМАУ-ын Эрүүгийн хууль. Уб., 1949. 58 дахь тал. Шүүх яамны хэвлэл. 58 дахь тал
[349] ХЗҮХ. Дурдсан бүтээл /1911-2009/. Уб., 2011. 422-424 дахь тал

Тус Эрүүгийн хуульд "засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг 1 сараас доошгүй, 1.6 жилээс дээшгүй хугацаагаар тогтоож, шийтгэгчийн ажиллаж байсан газар буюу оршин суугаа газарт нь ойролцоо өөр газар ажиллуулж, цалин хөлсний 10-25 хүртэл хувийг шүүхийн тогтоолд зааснаар суутган авч улсын санд нийлүүлнэ. Хөдөлмөрийн чадваргүй этгээдэд оногдох засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг шүүхийн шийдвэрээр торгууль буюу олон нийтийн өмнө буруушаах ялаар солино"[350] гэж хуульчлан заажээ.

"Ял шийтгэл" гэсэн 17 дугаар зүйлийн 2-т "Нутаг зааж суулгах", мөн зүйлийн 3-т "Уг нутгаас зайлуулах" гэсэн байдлаар авч үзэж, харин гадаад улсын иргэдийг эх нутгаасаа хөөн зайлуулах ялыг халсан байна. Үүнд:

1. **Нутаг зааж суулгах.** Шийтгэгдсэн этгээдийг оршин суугаа нутгаас нь хугацаатайгаар зайлуулан тодорхой нутаг заан суулгахыг нутаг заан суулгах гэнэ. Нутаг заан суулгах ялыг Эрүүгийн хуульд тусгайлан заасан байвал үндсэн буюу нэмэгдэл ялын хувьд хэрэглэхдээ 2-5 жил хүртэл хугацаагаар тогтооно. Нутаг заан суулгагдсан этгээдийг хөдөлмөрт зохион байгуулахыг орон нутгийн АДХ-ын /Ардын депатутын хурал/ гүйцэтгэх захиргаад хариуцна. Нутаг зааж суулгах ялыг эдлэх журам, газар, нөхцөлийг БНМАУ-ын хууль тогтоомжоор тогтооно.

2. **Уг нутгаас зайлуулах**. Шийтгэгдсэн этгээдийг оршин суугаа нутгаас нь хугацаатай албадан зайлуулахыг уг нутгаас зайлуулах гэнэ. Уг нутгаас зайлуулах ялыг Эрүүгийн хуульд тусгайлан заасан байвал үндсэн буюу нэмэгдэл ялын хувьд хэрэглэхдээ 2-5 жил хүртэл хугацаагаар тогтооно. Гэмт хэрэг үйлдэх үед 18 нас хүрээгүй байсан хүмүүс, 8 нас хүрээгүй хүүхдээ асран тэжээж байдаг буюу жирэмсэн эмэгтэйчүүдэд уг нутгаас зайлуулах ялыг хэрэглэж болохгүй"[351].

1961 онд "Ямар нэгэн тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу ажил хэрэг эрхлэхийг хориглох" хэмээн зааж, дараах агуулга бүхий байдлаар эрх хасах ялын талаар хуульчлан заажээ. Үүнд:

- Ямар нэгэн тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу ажил хэрэг эрхлэхийг хориглох ялыг энэ хуулийн тусгай ангид заасан байвал үндсэн ялын хувьд оногдуулна;

- Гэмт хэргийн шинж чанар нь гэмт хэрэг үйлдэгчийн гүйцэтгэж байсан албан тушаал, эрхэлсэн ажилтай холбоотой учир уул этгээдийн ямар нэгэн тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу ажил хэрэг эрхлэх явдлыг хэвээр үргэлжлүүлэх нь тохирохгүй гэж шүүх үзвэл ямар нэгэн тодорхой албан

[350] БНМАУ-ын Эрүүгийн хууль. Уб., 1987. 20. 108 дахь тал
[351] Адьяабазар, Д. Дурдсан бүтээл. Уб., 1998. 154-156 дахь тал

тушаал гүйцэтгэх буюу ажил хэрэг эрхлэхийг хориглох ялыг нэмэгдэл ялын хувьд оногдуулна;

- Ямар нэгэн тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу ажил хэрэг эрхлэхийг хориглох ялын үндсэн ба нэмэгдэл ялын хувьд хэрэглэхдээ 1-10 жил хүртэл хугацаагаар тогтооно;
- Хэрэв энэ ялыг хорих ялд нэмэгдэл ялын хувьд оногдуулсан бол ийнхүү хасагдсан явдал нь хорих ялаа эдэлж байгаа бүх хугацаанд хамаарагдах ба үндсэн ялаа эдэлж дууссаны дараа шүүхийн тогтоолд заасан хугацаанд ял эдэлнэ.
- Ямар нэгэн тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу ажил хэрэг эрхлэхийг хориглох ялыг хорихоос өөр ялд нэмэгдэл ялын хувьд оногдуулсан бол түүний хугацааг үндсэн ялаа эдэлж эхэлсэн өдрөөс тоолно.

1986 онд БНМАУ-ын "Эрүүгийн хууль"-ийг шинэчлэн найруулж Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажлуудын талаар тусгагдсан нь 1987 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс үйлчилж эхэлсэн юм.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд торгох ялыг үндсэн болон нэмэгдэл ялын чанартай хэрэглэнэ

"Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх" ялыг, үндсэн ялын чанартай хэрэглэнэ

"Уг нутгаас зайлуулах" ялыг, мөн зүйлийн 2 дахь хэсэгт 6/ "нутаг заах"/., үндсэн болон нэмэгдэл ялын чанартай хэрэглэнэ" гэж тус тус зааж хэрэглэж эхэлсэн байна. "Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах "цэргийн болон тусгай алдар цолыг хасах ялуудыг багтаасан" байна. Жишээ нь: Цэргийн болон бусад цол, түүнчлэн одон, медаль, хүндэт алдар цолыг хасах ял.

1. Цэргийн болон бусад тусгай цолтой этгээд хүнд гэмт хэрэгт шийтгүүлбэл түүний цолыг шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор хасаж болно.

2. БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдээс шагнасан одон медаль, хүндэт алдар цолтой болон БНМАУ-ын Засгийн газрын Хүндэт жуух бичгээр шагнагдсан хүмүүс, түүнчлэн БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчид, Сайд нарын Зөвлөлөөс олгосон цэргийн болон бусад тусгай цолтой хүмүүс гэмт хэрэгт шийтгүүлбэл тэдний одон, медаль, хүндэт алдар цол, хүндэт жуух бичиг, цэргийн болон бусад тусгай цолыг хасуулах асуудлыг шагнасан буюу олгосон байгууллагад тавих нь зохистой эсэхийг шүүх таслан шийдвэрлэх тогтоол гаргахдаа шийдвэрлэнэ" гэсэн хуулийн зохицуулалтыг хэрэглэж байжээ.

2002 оны "Эрүүгийн хууль"- Ерөнхий ангийн "Ялын төрөл"-д "торгох ялыг үндсэн ялын чанартай хэрэглэнэ" Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд шүүхээс мөнгөн төлөөс оногдуулахыг торгох ял гэнэ. Торгох ялын

хэмжээг гэмт хэрэг үйлдэх үед мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид заасан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тогтооно.

Торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл уг ялын хэмжээнээс хамааруулан шүүх торгох ялыг гурван жил хүртэл хугацаагаар хорих ялаар сольж болно.Албадан ажил хийлгэх, баривчлах, хорих ялыг торгох ялаар солихыг хориглоно" [352].

"Ялын төрөл", "албадан ажил хийлгэх ялыг үндсэн ялын чанартай хэрэглэнэ"

Албадан ажил хийлгэх ял нь нэг зуугаас таван зуун цагийн хугацаатай байна. Албадан ажил нь нэг өдөрт гурван цагаас доошгүй хугацаагаар үргэлжилнэ. Албадан ажил хийлгэх ял эдлэхээс санаатайгаар зайлсхийсэн ялтны эдлээгүй үлдсэн ялын найман цагийн ажлыг нэг хоног баривчлах ялаар тооцож солино. Хөдөлмөрийн чадваргүй этгээд, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэг, түүнчлэн тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй, цэргийн жинхэнэ хугацаат алба хааж байгаа этгээдэд албадан ажил хийлгэх ял оногдуулахгүй".

2002 оны Эрүүгийн хуулийн 46 дугаар зүйлээр ялын 7 бие даасан төрлийг шинэ агуулга, хэлбэрээр тогтоосон байх бөгөөд энэ үндсэн дээр "нутаг заах", "уг нутгаас зайлуулах" гэх зэрэг ялын төрлийг дахин сэргээгээгүй учир хүчингүй болгосон /устгасан/ байна[353].

2015 оны Эрүүгийн хуульд хорихоос өөр төрлийн ялын шинэ нэмэлт зохицуулалт хийгдсэн ба энэ нь:

Торгох ялын хэмжээ нь нэг зуун нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна. Энэ хуульд заасан нэг нэгж нь хоёр мянган төгрөгтэй тэнцүү байна. Шүүх ялтны хөрөнгө, цалин хөлс, бусад орлого олох боломжийг харгалзан торгох ялыг гурван жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоож болно. Ялтан торгох ялыг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол шүүх биелэгдээгүй торгох ялын арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг нэг хоногоор тооцож хорих ялаар солино. Нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих ялыг торгох ялаар солихгүй" гэж шинэчлэн найруулсан байна.

"Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг үндсэн болон нэмэгдэл ялын чанартай хэрэглэнэ"

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн төрийн албан тушаал эрхлэх, тодорхой мэргэжлийн болон бусад үйл ажиллагаа явуулах эрхийг энэ хуулийн тусгай ангид

[352] Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл. Уб., 2002.№5
[353] Төрийн мэдээлэл /сэтгүүл/. Уб., 2002. №5

заасан тохиолдолд нэгээс таван жил хүртэл хугацаагаар хязгаарлахыг тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял гэнэ.

Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг баривчлах, хорих ялд нэмэгдэл ялын чанартай оногдуулсан бол хугацааг нь үндсэн ялыг эдэлж дууссан үеэс эхлэн тоолох ба хорих ялыг тэнссэн бол хугацааг нь шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн тоолно[354].

“Нийгэмд тустай ажил хийлгэх ялыг үндсэн ял" нэмэлт зохицуулалт

Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан торгох ял дээр нэмж, эсхүл дангаар нь нийтэд тустай ялыг оногдуулж болно. Нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт дөрвөөс дээшгүй цагаар, нийт нэг зуун хориос дөрвөн зуун наян цагаар тогтооно. Ялтан нийтэд тустай ажил хийлгэх ялыг биелүүлээгүй бол нийтэд тустай ажил хийлгэх ялыг ялын найман цагийн ажлыг нэг хоногоор тооцож хорих ялаар солино. Нийтэд тустай ажил хийлгэх ялын хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, жирэмсэн эмэгтэй, 55-с дээш насны эмэгтэй, 60-с дээш насны эмэгтэй хүнд оногдуулахгүй гэж шинэчлэн найруулсан байна.

"Зорчих эрхийг хязгаарлах ялыг үндсэн ялаар хэрэглэнэ"

Шүүх тухайн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан ялтныг бусдад аюул учруулах эрсдэлтэй гэж үзвэл тодорхой хүнтэй, бусадтай харилцахыг хориглож болно. Ялтан зорчих эрхийг хязгаарлах ялыг биелүүлээгүй бол ялтны зорчих эрхийг хязгаарлах ялын эдлээгүй үлдсэн хугацааны нэг хоногийг хорих ялын нэг хоногоор тооцож хорих ялаар солино" гэж өөрчлөн найруулжээ.

"Эрх хасах ялыг нэмэгдэл ялаар хэрэглэнэ"

Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан оногдуулсан үндсэн ял дээр нэмж эрх хасах ялыг оногдуулж болно. Шүүх эрх хасах ялыг хорих ял дээр нэмж оногдуулсан бол уг ялыг эдэлж дууссаны дараа, эсхүл торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ял дээр нэмж оногдуулсан бол ял оногдуулсан үеэс, эсхүл хорих ял оногдуулахгүйгээр үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан бол албадлагын арга хэмжээ авсан үеэс хугацааг тоолно" гэж шинэчлэн найруулсан байна[355].

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны тухай анхны төрөлжсөн хуулийн талаар авч үзвэл:

[354] Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл / сэтгүүл/. Уб., 2002. №5
[355] Төрийн мэдээлэл. 2016.02.19. №7/916/. 281 дахь тал

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх тухай хууль албан ёсоор батлан гарахаас өмнө БНМАУ-ын АИХ-ын Тэргүүчдээс 1987.11.23-нд батлан гаргасан “БНМАУ-д Хорихоос өөр төрлийн зарим ял эдлүүлэх журам, нөхцөлийн тухай дүрэм” үйлчилж байсан. Шинэ хууль гарах болсон шалтгааныг дээрх дүрмийг хууль болон хэрэгжүүлэх шаардлага тавигдсан, мөн гэм буруутай нь тогтоогдсон хүмүүст оногдуулах эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хуульчлах хэрэгцээтэй болсон байдалтай холбон үзэж хэрэгтэй юм.

Монгол Улсын Их Хурлаас 1995.12.11-ны өдөр “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх тухай” хуулийг батлан гаргав[356]. Тус хуулийн зорилт нь “Монгол Улсын нутаг дэвсгэр дээр торгох, тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах, эд хөрөнгө хураах, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг эдлүүлэх, цаазаар авах ялыг гүйцэтгэх тэнсэгдсэн болон шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан ялтныг хянан харгалзах, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж тодорхойлжээ.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаандаа хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэхэд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хуульд заанаар хязгаарлах, шүүхийн шийдвэр заавал биелэх ялтан зөвхөн өөрөө хариуцлага хүлээх зарчмыг баримталдаг байжээ.

ДҮГНЭЛТ

Хорихоос өөр төрлийн ял нь гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх түүнчлэн үйлдсэн гэмт хэргийг нь засаж залруулах боломжийг илүү олгодог бөгөөд ялын уламжлалт онолын хандлага буюу зөвхөн цээрлэл үзүүлэх явдлыг шүүмжилсэн, нийгэм-хамт олны дунд ил, тод нээлттэй байх, тэдний оролцоо, дэмжлэг, тусламжид тулгуурласан хэлбэртэй байхын зэрэгцээ эдийн засаг, нийгмийн үр өгөөж болон хүмүүжил нөлөөтэй ял эдлүүлэх тогтолцооны шинэ хэлбэр юм.

Гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхийн тулд юуны өмнө шийтгэлийн хэлбэрийг боловсронгуй болгох шаардлагатай. Учир нь өнөөг хүртэл гэмт хэрэг үйлдсэн хүнийг залхаан цээрлүүлэх, тарчлаан зовоох арга барил шүүх болон хуль сахиулах практикт байсаар байгаа юм.

Иймд олон нийтийн зүгээс эрүүгийн ял шийтгэлийн бодлогыг илүү хүнлэг, энэрэнгүй, хүний эрх, эрх чөлөөг хүндэлсэн ардчилсан хэлбэрт шилжүүлэх арга замыг эрэлхийлж эхэлсэн. Эдгээр аргын нэг нь “нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял шийтгэл” буюу “хорихоос өөр төрлийн ял юм”.

[356] Энэ хууль. “Ардын эрх сонины. 1995.12-р сарын дугаарт нийтлэгдсэн.”

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. А. Лхагва “Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын эх сурвалж” УБ хот 2014 он;
2. Э. Батбаяр, Б. Ганболд “Хорихоос өөр төрлийн ял” УБ хот 2023 он;
3. Б. Дашзэвэг “Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй” УБ хот 2003 он;
4. Тэргүүн боть “Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал (1911-2019)” УБ хот 2011 он;

ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ, ХАМГААЛАХ ТӨРИЙН ҮҮРЭГ

STATE'S ROLE IN ENSURING AND PROTECTING HUMAN RIGHTS



А.Мягмарнаран
Дотоод хэргийн их сургуулийн
Сургалт, судалгааны 403 дугаар анги-
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
511 дүгээр дамжааны дэд түрүүч

Товч агуулга: Венийн тунхаглалд заасан хүний эрхийн талаар үүрэг хариуцлага хүлээх зарчмын дагуу төр нь иргэнийхээ эрх, эрх чөлөөг хангаж, зөрчигдөхөөс хамгаалах, зөрчигдсөн тохиолдолд сэргээн эдлүүлэх үүргийг хүлээдэг. Монгол Улс Үндсэн хуулиараа хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулж, түүнийг хэрэгжүүлэх эдийн засаг, нийгэм, хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийг төрд даалгасан ба төр хүний эрхийг хэрхэн хангаж, хамгаалж байгаа тухай тодорхойлохыг зорилоо.

Abstract: According to the principles of human rights responsibility stated in the Vienna Declaration, the state is responsible for ensuring the rights and freedoms of its citizens, protecting them from violations, and restoring them in case of violations. The Constitution of Mongolia assigns the government the responsibility of ensuring human rights and freedoms and providing economic, social, and legal guarantees for their implementation, and defines how the government will ensure and protect human rights.

Түлхүүр үг: Үндсэн хууль, эрхийн зөрчил, эрх чөлөө, үүрэг хариуцлага, төрийн байгууллагууд, төрийн механизм

Keyword: Constitution, violation of rights, freedom, responsibilities, state institution, state mechanisms

ОРШИЛ

Орчин үеийн нийгмийг эрх чөлөө, тэгш байдал, шударга ёсны зарчимд үндэслэсэн хүний эрхгүйгээр төсөөлөх боломжгүй бөгөөд энэ нь хүн төрөлхтний түүхэн урт хугацааны төлөвшлийн явцад харилцан адилгүй хэмжээнд үнэлэгдэж иржээ. Хүй нэгдлийн үед хүн бүр өөрийн аюулгүй байдлыг хангах нөхцөлд амьдрал маш ахар, эрсдэлтэй байсан. Удалгүй ураг төрлөөрөө нэгдэн, овог аймгууд нэгдэн орших болсон билээ. Үүний тулд хүн бүр зэвсэг барьж явахаа болин, хөдөлмөрийн хуваарьт шилжсэнээр хувийн аж ахуйгаа эрхлэх үед аюулгүй байдлыг хангах, хүч хэрэглэх боломжтой этгээдийг сонгосноор төр үүслийг

тайлбарлаж болно[357]. Өнөө цагийн төрийн үүрэг нь хүний эрх, эрх чөлөөтэй салшгүй холбоотой ба төр энэхүү үүргээ хэрхэн гүйцэтгэж байгаа тухай судалсан болно.

ҮНДСЭН ХЭСЭГ

Дэлхийн хүний эрхийн бага хурлаар 1993 онд баталсан Венийн тунхаглалд "Хүний эрх бол бүх хүнд заяасан төрөлх эрх бөгөөд хүний эрхийг хамгаалах нь төр засгийн байгууллагуудын анхдагч үүрэг юм[358]" хэмээсэн байдаг. Хүний эрх нь бүх хүний нэр төр, алдар хүндтэй хамт угаас заяагдсан төрөлх чанартай агаад нас, хүйс, арьсны өнгө, хэл, үндэс угсаа, язгуур, шашин, улс төрийн үзэл бодол үл харгалзан эрхээ бүгд тэгш эдлэх үндсэн зарчимд тулгуурладаг.

Монгол Улсын Үндсэн хууль[359]-ийн Арванесдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэж заасан билээ. Эндээс үзвэл хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах нь төр засгийн сайн сануны үйлс бус, харин Үндсэн хуулиар төр засагт ард түмнээс ногдуулсан үүрэг юм.

"Хүний эрхийг зөрчих явдал улс орны хуулийн эрх мэдлээс гадуур сансар огторгуйд бус, харин улс орны дотоодод, голчлон төр засаг, иргэдийн хооронд үүсдэг" гэж Ж.Штайнер[360] хэлсэн байдаг. Хүний эрхийг хангах төрийн үүрэг нь дан ганц тухайн улс хүний эрх, эрх чөлөөг Үндсэн хууль болон бусад хуульдаа зааж өгөх, түүнчлэн хүний эрхийн асуудлаарх олон улсын гэрээнд элсэн орох явдлаар хязгаарлагддаггүй. Харин тухайн улсад хүний эрх, эрх чөлөө нь үндэсний болон олон улсын эрх зүйгээр хамгаалагдсан эсэх, гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд хүний эрх, эрх чөлөөг зөрчих, хязгаарлах эрсдэл гарахаас сэрэмжлэх чадавхтай эсэх, зөрчигдсөн тохиолдолд сэргээх шударга шүүхийн тогтолцоо ажиллаж чадаж байгаа эсэхээс хамааран хүний эрх, эрх чөлөө хангагдах шалгуур болдог.

Хүний эрхийн олон улсын суурь баримт бичиг болох Хүний эрхийн Биллд тусгагдсан, үндсэн эрхүүдийг манай улсын Үндсэн хуульд бүрэн хэмжээгээр тусгаж чадсан гэж судлаачид үздэг байна. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ. Үндсэн хууль, олон улсын гэрээнд хүн бүрийн эдлэх ёстой эрхүүдийг баталгаажуулж, төрийн хүлээх үүргийг зааж өгсөн байдаг.

---

[357] Нармандах, Б. Хүний эрх. Уб., 2010.
[358] Дэлхийн хүний эрхийн Дэлхийн бага хурлаар баталсан Венийн тунхаглал. 1993.
[359] Монгол Улсын Үндсэн хууль. Уб., 1992. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №1
[360] Харвардын их сургуулийн профессор, хүний эрхийг хамгаалах чиглэлээр идэвхийлэн судлаач багш

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар зүйлийн 1-т "Энэхүү Пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон харьяалалдаа байгаа бүх хүний энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй[361]" гэж заасан.

Харин сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалуулах, нийгмийн хамгаалал хүртэх эрх зэрэг эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хэрэгжүүлэх нь төрийн үйл ажиллагаа, эдийн засаг, нийгмийн хөгжил, бусад нөөц бололцооноос шууд хамаардаг. Профессор П.Оюунчимэг "Хүний эрхэд суурилсан хандлага" бүтээлдээ дээрх баримт бичигт заасан үүргийг дараах байдлаар тайлбарласан байдаг. Үүнд:

1. "Дэвшилттэйгээр хангах" гэдэгт эдийн засаг, нийгэм, соёлын бүхий л эрхийг богино хугацаанд бүрэн хэрэгжүүлэх боломжгүй болохыг хүлээн зөвшөөрч, эрхүүдийг хүндэтгэн хангах арга хэмжээг нэн даруй авч аажим аажмаар хангахыг ойлгоно

2. "Бүх боломжийнхоо хэрээр" гэдэгт улсуудын эдийн засаг, санхүүгийн бололцоо, бусад нөөц харилцан адилгүй тул тодорхой цаг хугацааны дараа эрхүүдийг бүрэн дүүрэн хэрэгжүүлж болно. Гэхдээ үүнийг төрөөрөө хангалттай нөөц бололцоотой болох хүртлээ эрхүүдийг хамгаалахгүй гэж буруугаар тайлбарлаж болохгүй. Харин өөрийн чадах хэрээр эрхүүдийг эдлэх явдлыг сайжруулахаар бүхий л талаар хичээх ёстой.

3. "Зохистой арга хэмжээг авах" гэдэгт оролцогч улсууд энэ Пактад нэгдэн орсны дараа богино хугацаанд авч хэрэгжүүлэх зорилгод чиглэсэн дэвшилттэй алхам хийнэ гэсэн үг. Эрх бүртэй холбоотой нөхцөлийг харгалзан тэдгээрт тохирсон зохистой арга хэмжээг өөрсдөө шийдвэрлэн авч хэрэгжүүлэх ёстой[362].

Төр нь дотооддоо хүний эрхийг хангахдаа өөрийн тогтолцоог сайтар ажиллуулах үүрэг хүлээдэг. Эдгээр тогтолцоог нийтэд нь хүний эрхийг хамгаалах төрийн механизм хэмээн нэрийдэж байна. Төрийн механизм нь нутгийн захиргааны болон орон нутгийн өөрөө удирдах ёсны болон иргэний нийгмийн байгууллагуудын тогтолцоотой нэгдэн хүний эрхийг хамгаалах үндэсний механизмыг бүрдүүлдэг.

Аливаа төрийн үүрэг нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, хангах явдал юм. Төрийн үүрэг нь хүний эрх, эрх чөлөөтэй салшгүй холбоотой бөгөөд нэгэнт хүнээс салгаж болшгүй ойлголт тул хүний эрхийг огт үгүйсгэлгүй, зөвхөн тусгайлан заасан нөхцөлд хязгаарлах боломжийг орчин үеийн төрд

[361] Хүний эрх, олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхэтгэл. Уб., 1993.
[362] Оюунчимэг, П. Хүний эрхэд суурилсан хандлага гарын авлага. Уб., 2015. 27, 28 дахь тал

олгожээ. Иймд төр нь эн тэргүүнд өөрийн улсын нутаг дэвсгэр дээрх хүмүүсийн эрхийг хангах, хамгаалах үүргийг хүлээнэ.

Хангах гэдэг нь: Үндэсний эрүүл мэндийн бодлогыг хүлээн зөвшөөрөх, төсвөөс хангалттай хувийг эрүүл мэндийн салбарт зарцуулах, шаардлагатай үйлчилгээгээр хангах буюу хувь хүн шаардлага хангасан, хангалттай үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй. Үүнд эрүүл мэндийн асрамж, сувилгааны үйлчилгээ, ундны цэвэр ус зэрэг орно. Ялангуяа хялбаршуулах (үйлчилгээний хүртээмжийг амар хялбар болгох), хөхиүлэн дэмжих (мэдээлэх), хэрэгжүүлэх (эмзэг бүлгийг нэн тэргүүнд анхаарч, тэгш байдлыг бүрдүүлэхэд чиглэх) арга хэмжээг авна.

Эрдэмтэн Н.Цогт "Хүний эрхийн зөрчил" гэдэг нь өөрийн иргэдийн өмнө төдийгүй дэлхий нийтийн өмнө хүний эрхийг ямар нэгэн ялгаваргүйгээр тэгш эдлүүлэх үүрэг хүлээсэн улс орон буюу бусад этгээд үүргээ үл биелүүлэх явдлыг хэлнэ[363] гэж үзжээ.

- хүний эрхийн зөрчлийн холбогдогчдыг дараах байдлаар томьёолдог байна. үүнд: зөрчилд өртөж хохирсон хүмүүс \хохирогч\
- тэдний гэр бүлийнхэн, хууль ёсны төлөөлөх этгээд \төлөөлөгч\
- уг асуудлаар ажиллаж байгаа бусад идэвхтэн \сонирхогчид\
- уг зөрчилд сэрдэгдэж буй хүмүүс, байгууллагууд \буруутан\
- тухайн зөрчлийн талаар шууд мэдэх буюу тодорхой мэдээлэл, эрх мэдэлтэй онцолж авч үзэх хариуцлагатай хүмүүс \эх сурвалж\

Дээрх байдлаар хүний эрхийн зөрчлийн холбогдогчдыг тогтоож болох боловч хүний эрхийг зөрчсөн зөрчигч нь төрийн байгууллага, албан тушаалтан байдаг. Яагаад энэ талаар онцлон дурдаж байна гэвэл хүний эрхийг хангах, хамгаалах үүргийг иргэн биш төр засаг хүлээдэг. Тиймээс хүний эрхийн түгээмэл зөрчлүүд олноор гарч байгаа явдал бол төр үүргээ биелүүлэхгүй байгаатай шууд холбоотой асуудал юм[364].

“Хүний эрхийн зөрчил” гэж Үндсэн хууль болон бүс нутгийн, олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцоор баталгаажуулсан хүний эрхийг төр, засгийн байгууллагууд зөрчсөн, төрөөс хамааралтай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас тэдгээр эрх зүйн хэм хэмжээнээс урган гарах хууль зүйн үүрэг биелэгдээгүй байхыг хэлнэ. Хууль тогтоомж, бодлого хөтөлбөр, бодит байдал хүний эрхийн талаар төрийн хүлээсэн үүрэгт нийцээгүй, шууд зөрчилдсөн буюу үүргээ биелүүлэхэд шаардагдахуйц арга хэмжээ авч, үр дүнд хүрээгүй тохиолдолд хүний эрхийн зөрчил үүснэ. Түүнчлэн, төр өөрөө хүний эрхийн хамгаалалтыг үгүй болгох,

[363] Цогт, Н. Хүний эрхийг хамгаалах үндэсний болон олон улсын механизм сэдэвт өгүүлэл. Хүний эрх сэтгүүл. Уб., 2003. № 2
[364] Нармандах, Б. Хүний эрх. Уб., 2010. 109-110 дахь тал

түүнээс татгалзах нь хүний эрхийг зөрчсөн хэрэг юм гэж доктор, профессор Б.Нармандах үзжээ.

Төр хүний эрхийн хамгаалалтыг сулруулах, түүнээс татгалзах нь хүний эрхийн ноцтой зөрчилд тооцогддог. Хүний эрхийн зөрчил нь Монгол Улсын Үндсэн хууль, нэгдэн орсон олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрхийн хэрэгжилтээр тодорхойлогдох боловч эрүү, иргэн, захиргааны эрх зүй гэх мэт салбар эрх зүйгээр зохицуулах харилцаанаас үүдэн гарсан зөрчил нь хүний эрхийн зөрчилд хамаарахгүй.

Хүний эрх зөрчигдвөл хаана хандах вэ?

Таны Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан эрх, эрх чөлөөг аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн зөрчсөн тохиолдолд тухайн байгууллагын захиргаанд хандахаас гадна холбогдох төрийн байгууллага болон шүүхэд хандана.

Төр үүргээ биелүүлж чадахгүй бол яах вэ?

Иргэд төрийн холбогдох байгууллага, удирдлагатай хариуцлага тооцохыг шаардах, зөрчигдсөн эрхээ сэргээх, учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр төрөөс шаардах эрхийг баталгаажуулсан. Холбогдох байгууллага гэдэгт тухайн албан хаагч, эсвэл байгууллагын дээд шатны удирдах эрх бүхий этгээдэд, мөн иргэний болон захиргааны хэргийн шүүхэд, Хүний эрхийн Үндэсний Комисст, Үндсэн хуулийн цэцэд хандаж өөрийн эрхээ шаардаж болно.

Ямар нөхцөлд, хэн байх, юу хийхээс үл хамааран хүүхэд өтгөс байхаас үл хамааран хувь хүн бүр эрх агуулагч юм. Үүрэг хүлээгч гэдэгт эн тэргүүнд төр, түүний байгууллагууд, төрийн албан хаагчид, бусдын өмнө үүрэг хүлээсэн хувь хүмүүс багтана[365].

Хамгаалах гэдэг нь: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа тохиолдолд хүн бүр тэгш эрхтэйгээр хүртэх боломжийг хангах, хохирохоос урьдчилан сэргийлсэн хууль бодлого хэрэгжүүлэх, хохирлыг барагдуулах шударга механизм бүрдүүлэх, бусад арга хэмжээг авах үүрэгтэй.

Хүний эрхийг хамгаалах үндэсний механизм гэдэг нь хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн болон орон нутгийн өөрөө удирдах ёсны хийгээд иргэний нийгмийн байгууллагууд, тэдгээрээс хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, арга хэрэгслүүдийн нийлбэр цогц байна. Хүний эрхийг хамгаалах үндэсний механизмд төр өөрөө онцгой байр эзэлнэ. Учир нь төр хүний эрх, эрх чөлөөний стандартыг Үндсэн хууль болон салбар хуулиудаар хуульчлан

[365] П.Оюунчимэг, Хүний эрхэд суурилсан хандлага гарын авлага. Уб., 2015. 33, 34 дахь тал

бататгаж, түүний биелэлтийг зохион байгуулах, гүйцэтгэлийг нь хянах үүргийг хүлээнэ[366].

Хүний эрхийг хамгаалах төрийн механизмд дараах байгууллагууд хамаарна. Үүнд:

- хууль тогтоох эрх мэдлийн байгууллага буюу монгол улсын их хурал;
- гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага буюу монгол улсын засгийн газар, монгол улсын яам, тусгай газар, агентлагууд, аймаг, нийслэл, сум, дүүрэг, багийн засаг захиргааны нэгж;
- шүүх эрх мэдлийн байгууллага буюу монгол улсын үндсэн хуулийн цэц, бүх шатны шүүх, бүх шатны прокурорын байгууллага зэрэг болно.

Эдгээр байгууллага дор бүрнээ хүний эрхийг хангах, хамгаалах талаар ямар үүрэг хүлээж ажиллах ёстойг авч үзье. Үүнд:

Нэг. Хүний эрхийг хангах хууль тогтоох байгууллагын үүрэг:

Улсын Их Хурал нь хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хүний эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагаа явуулдаг. Мөн олон улсын гэрээ конвенц, Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бий болгох зорилгоор шинээр хууль тогтоомж гаргах, хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой хууль тогтоомжийг олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц, Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэх, боловсронгуй болгох, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах арга хэмжээг хэрэгжүүлэх үүргийг хүлээж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулна.

Улсын Их Хурлаас 2003 онд баталсан Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр[367]-Улсын Их Хурал нь хууль тогтоомжийг судалж, хүний эрхэд харшилсан заалтаас цэвэрлэх үүрэгтэй гэж тусгасан байдаг.

Хоёр. Хүний эрхийг хангах гүйцэтгэх байгууллагын үүрэг:

Засгийн газар төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага болох хувьдаа олон улсын гэрээ, Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг хангах үүрэг хүлээдэг. Тухайлбал, төрийн захиргааны болон орон нутгийн захиргааны байгууллагаас хүний эрхтэй холбоотой хуулийн биелэлтийг хангах арга замыг тодорхойлж, уг ажлыг нэгтгэн удирдах, хуульд тусгайлан заасан тохиолдолд зарим хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс журам, дүрэм батлан гаргах, хүний эрхтэй холбоотой шинээр гарсан олон улсын гэрээнд нэгдэх, шинэ хууль гаргах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санаачилга

[366] Совд, Г. Үндсэн хууль ба хүний эрх. Уб., 1990. 198-199 дахь тал.
[367] Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр батлах тухай. 2003.

гаргах ажлыг үүнд хамааруулан ойлгож болно. Мөн хууль тогтоомжийн биелэлтийн байдалд улсын хэмжээнд, эсхүл тодорхой бүс нутаг, салбарын хэмжээнд хяналт шалгалт хийж, түүний мөрөөр тодорхой бодлого боловсруулах, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтийн талаарх илтгэлийг боловсруулж, НҮБ-ын холбогдох хороодоор хэлэлцүүлэх, хууль болон Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг тооцож, Улсын Их Хуралд тайлагнах үүрэгтэй байдаг

Гурав. Хүний эрхийг хангах шүүх эрх мэдлийн байгууллагуудын үүрэг:

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулиар байгуулагдсан, шүүх эрх мэдлийн хүрээнд хамаарах, хүний эрхийг хамгаалах төрийн томоохон механизм юм. Цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих үүргээ хэрэгжүүлэхдээ Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянаж дүгнэлт гаргах, Үндсэн хуулийн маргааныг эцэслэн шийдвэрлэх үүрэг хүлээн ажилладаг. Цэц нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, зарлиг, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, Засгийн газрын тогтоол, бусад шийдвэр, олон улсын гэрээ гэх мэт нь Үндсэн хууль зөрчсөн эсэхийг шийдвэрлэдэг. Хэдийгээр хувь хүн өөрийнх нь эрх, эрх чөлөө шууд зөрчигдсөн асуудлаар Цэцэд хандах эрхгүй хэдий ч Үндсэн хууль нь бүхэлдээ хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгод чиглэгдэн батлагдсан учир гарч буй маргааны дийлэнх нь хүний эрхтэй холбоотой байдаг.

Дөрөв. Бүх шатны шүүх:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд: “Хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдвөл шүүхэд гомдол гаргах эрхтэй” гэж заасан. Шүүх зөвхөн хүний эрх зөрчсөн тухай тодорхой маргааныг хянан эцсийн шийдвэр гаргаж, хүний зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох, хохирлыг барагдуулах үүрэгтэй бөгөөд төрийн байгууллага, албан тушаалтнаас хараат бусаар ажиллаж, зөвхөн хуульд захирагдаж шийдвэр гаргах, хууль, шүүхийн өмнө иргэн бүр эрх тэгш байх баталгааг бүрдүүлэн ажилладаг. Шүүх хараат бус зарчмаар ажиллана.

Тав. Хүний эрхийг хангахад хүний эрхийн үндэсний байгууллага:

Монгол Улсад бие даасан, хараат бусаар ажиллах чиг үүрэгтэй Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг 2000 онд баталж, Комисс 2001 онд байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна. ХЭҮК нь төр өөрөө байгуулсан боловч төрийн өөрийн үүрэг функцийг хэрэгжүүлдэггүй, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас хараат бусаар үйл ажиллагаа явуулдаг, төрийн үйл ажиллагаанд хяналт тавих замаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үүрэгтэй хүний эрхийг хамгаалах бие даасан механизм юм.

ХЭҮК-ын үйл ажиллагаа НҮБ-ын Хүний эрхийн Комиссын 1993 оны 54, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 48/134-р тогтоолоор батлагдсан баримт бичгээр

тодорхойлдог. Уг баримт бичигт дурдсанаар “хүний эрхийн үндэсний байгууллагад хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах эрх мэдэл олгосон байх, үйл ажиллагааны цар хүрээ, эрх мэдлийг нь Үндсэн хууль, эсхүл бусад хуулиар тогтоосон байх шаардлага тавьдаг[368]”.

ХЭҮК нь хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах асуудлаар төрийн аль ч байгууллагад санал, зөвлөмж илгээх, хууль тогтоомж, захиргааны практикт анализ хийх, эдгээрийг хүний эрхийн тулгуур зарчмуудтай уялдуулах талаар зөвлөмж гаргах, шаардлагатай гэж үзсэн хүний эрхийн ямар ч зөрчилтэй асуудлын талаар зөвлөмж, илтгэл хүргүүлэх, олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орохыг дэмжих, олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар НҮБ-д илгээх Засгийн газрын илтгэлд санал өгөх, зэрэгцсэн илтгэл хүргүүлэх, хүний эрхийг заах, судлах хөтөлбөрийг боловсруулахад туслалцаа үзүүлэх, хүний эрхийг сурталчлах, бүх төрлийн ялгаварлан гадуурхалттай тэмцэх зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

Орчин үеийн нийгмийг эрх чөлөө, тэгш байдал, шударга ёсны зарчимд үндэслэсэн хүний эрхгүйгээр төсөөлөх боломжгүй юм. Хүнээс түүний жам ёсны эрх болох амьд явах, халдашгүй дархан байх, эрүү шүүлтээс ангид байх, өөрийн амьдрах аргаа чөлөөтэй сонгох эрх, шүтэж бишрэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөө, хувийн амьдралын бие даасан байдал болон бусад эрхийг хэн ч хасах эрхгүй.

“Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай[369]” хуулиар аюул, эрсдэлд өртсөн, өртөж болзошгүй хүний эрх хамгаалагч, түүний хамаарал бүхий гэр бүлийн гишүүдийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан.

Уг хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг “Зөрчлийн тухай хууль[370]”-д зааж өгсөн хэр нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд тухайн зөрчлийг ямар байгууллага хариуцахыг огт зохицуулалтгүй орхижээ. Үүнээс үүдэн хэргийн харьяалал тодорхойгүй гэх үндэслэлээр асуудал эзгүйдэж, хүний эрх хамгаалагчдын зөрчигдсөн эрх үр дүнтэй сэргээгдэхгүй, зөрчигдсөн хэвээр байгаа ба хүний эрх Монгол улсад хангалттай хэрэгжиж чадахгүй байгаа[371] талаар илтгэлдээ дурдсан. Үүнээс үзэхэд хүний эрх монгол улсад хангалттай хэрэгжихгүй байгааг харуулж байна.

ДҮГНЭЛТ

Орчин үеийн нийгмийг эрх чөлөө, тэгш байдал, шударга ёсны зарчимд үндэслэсэн хүний эрхгүйгээр төсөөлөх боломжгүй юм. Хүмүүн заяаг олж төрсөн

[368] НҮБ-ын Хүний эрхийн Комиссын 1993 оны 54, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 48/134-р тогтоолоор батлагдсан.
[369] Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай. Уб., 2021.
[370] Зөрчлийн тухай хууль. Уб., 2017.
[371] Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл

хэн боловч ямар нэг ялгаваргүйгээр нийгмийн олон талт харилцаанд оролцож, эрх, эрх чөлөөгөө хэрэгжүүлдэг. Гэхдээ улс гүрнүүдийн уламжлалт ёс заншил, ухамсар сэтгэлгээ, нийгмийн баялгаас хүртэх боломж, хөгжлийн түвшингийн харилцан адилгүй байдлаас хамааралтайгаар хүн эрх, эрх чөлөөгөө эдлэх боломж тэнцвэртэй бус байна. Тиймээс хүн бүрийн эрхийг хангахын тулд төр засаг нь үйл ажиллагаа, механизмаа зөв зохистой тодорхойлох, эрх, эрх чөлөөг хуульчлан хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх боломжийг бүрдүүлдэг байх хэрэгтэй. Мөн хүний эрхийг хамгаалахад дан ганц хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх механизм байгаад зогсохгүй иргэд өөрсдөө хүний эрхийн талаар мэдлэгтэй байх нь нэн чухал.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

П.Оюунчимэг, Хүний эрхэд суурилсан хандлага гарын авлага. Уб., 2015

Хүний эрх эмхэтгэл. Уб., 2014

Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл

Г. Совд, Үндсэн хууль ба хүний эрх. Уб., 1990.

Цогт, Н. Хүний эрхийг хамгаалах үндэсний болон олон улсын механизм сэдэвт өгүүлэл. Хүний эрх сэтгүүл. Уб., 2003. № 2

Нармандах, Б. Хүний эрх. Уб., 2010.

Монгол Улсын Үндсэн хууль. Уб., 1992. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №1

4. Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхэтгэл. 1993.

ИРГЭНИЙ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН ТЭНХИМД АЖИЛЛАСАН ОН ЖИЛҮҮД

ДОКТОР (PH.D), ПРОФЕССОР Б.АЛТАНГЭРЭЛ БАГШИЙН

ДУРСАМЖ ЯРИА



Миний бие 2000 онд сургуулиа төгсөөд Зүүнхараа дахь хорих 413 дугаар ангид ахуй дэглэмийн байцаагч (өнөөгийн нийгмийн ажилтан)-аар ажиллаж байгаад 2002 оны хавар тухайн үеийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тамгын газрын дарга, хурандаа Х.Уламбаярт хот руу шилжих хүсэлтээ өгсөн билээ. Тамгын газрын дарга, хурандаа Х.Уламбаяр миний хүсэлтийг сонсоод 3 хоногийн дараа өрөөндөө дуудаад чиний төгссөн Цагдаагийн академийн Шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүйн тэнхимд багш болох уу, тэнд орон тоо байна, одоо хариугаа хэл эсхүл хорих 409 рүү томилогдоод яв, яг одоо хариугаа хэл гэхэд би сургууль руу явъя гэдэг шийдвэрийг тэрхэн агшинд тухайн өрөөнд гаргаж байсан сан. Ингээд ерөнхий газрын албан бичгийг аваад сургууль дээр иртэл захирлын зөвлөлийн хурлаар оруулж, тухайн үеийн захирал, хурандаа М.Батаев “манай сургуулийн түүхэнд 23 настай багш томилогдож байсныг би сайн мэдэхгүй юм, залуу хүн эрчтэй сайн ажиллаарай” гээд А.Лхагва багшийг энэ залууг сайн багш болгоорой гэсэн үүрэг, даалгавар өгч багш хэмээх албан тушаалд анх томилогдож байжээ.

Тухайн жил багшаар томилогдсон даруйд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Ж.Чойжанцан өрөөндөө намайг дуудаж, тухайн үеийн ерөнхий шийдвэр гүйцэтгэгч хурандаа Т.Батболдыг дуудан Шийдвэр гүйцэтгэлийн хичээл заах багш байгаа юм гэж танилцуулаад “хагас өдрөөр шийдвэр гүйцэтгэгч нартай хамт ажиллагаанд явуул” гэж үүрэг өгсөн юм. Тэгээд би өглөө 08:00-12:00 хооронд сургууль дээр хичээлээ заагаад 13:00-16.00 цагийн хооронд Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хуваарилж өгсөн хэдэн хувийн хэргээ аваад шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд явдаг байсан юм. Тухайн үед би чинь

цалингаасаа гадна Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас бага зэрэг цалин хөлс авч, тэндээ хоолоо идчихдэг байлаа. Ингээд нэлээн хугацаанд 2 газар зэрэг ажиллаж шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар дадлага эзэмшин, хичээл сургалтаа бэлдэж байсан юм. Энэ нь ч тухайн үедээ маш зөв арга зам болсон гэж боддог юм. Ер нь бол шийдвэр гүйцэтгэлийн багш хүн практиктай маш ойр байх хэрэгтэй юм билээ. Түүнээс хойш би ер нь багшлах хугацаандаа жилдээ нэг удаа бүх хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар хэлтсээрээ тойрч явж судалгаа хийдэг болсон. Ийнхүү багш болж тэнхимийн эрхлэгч, доктор, профессор, хурандаа А.Лхагва болон бусад багш нараасаа суралцан 20 гаруй жил төрөлх сургуульдаа ажиллажээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн тэнхимийн түүхийг ярихын өмнө шийдвэр гүйцэтгэгч бэлдэж ирсэн байдлыг товч дурдах нь зүйтэй байх.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийг бэлтгэх үндсэн сургалтын байгууллага нь өнөөгийн Дотоод хэргийн их сургууль бөгөөд уг сургуульд бэлдэж ирсэн уламжлал Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны Цэргийн тусгай дунд сургуулиас үүсэлтэй юм. 1975 оноос Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны Цэргийн тусгай дунд сургуульд Засан хүмүүжүүлэх албаны мэргэжлээр элсэлт авч, офицер, боловсон хүчнийг бэлтгэх анги 1978 онд анхны төгсөлтөө хийсэн нь Засан хүмүүжүүлэх байгууллагын түүхэнд анх удаа дотооддоо хуулийн мэргэжлийн боловсон хүчнээр эгнээгээ өргөтгөсөн явдал бөгөөд Цэргийн тусгай дунд сургуульд сонсогч элсүүлэн 70 гаруй хүн төгссөн байдаг.

Хууль зүйн сайдын 1996 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн “Тэнхим байгуулах тухай” 191 дүгээр тушаалаар Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Цагдаагийн дээд сургуульд 1996 оны 11 дугаар сарын 22-ний өдрөөс эхлэн “Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн тэнхим”-ийг байгуулав. Тус тушаалаар шинээр байгуулагдсан тэнхимийн орон тоог шийдвэрлэж, 1997 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс тэнхимийн багшлах бүрэлдэхүүнийг Цагдаагийн Ерөнхий Газарт шилжүүлэхийг зөвшөөрчээ. Тухайн үед тэнхимийн эрхлэгчээр (Монгол Улсын гавьяат хууль, хууль зүйн ухааны доктор, профессор, Дотоод хэргийн их сургуулийн эмерит профессор) А.Лхагва ажиллан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй, мэргэшүүлэх хичээл болох Харуул хамгаалалт, гүйцэтгэх ажлын чиглэлээр хурандаа М.Очирбат, Хоригдлын сурган

хүмүүжүүлэх чиглэлээр хурандаа Ю.Сэрсэнжав, Шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээр хурандаа Н.Баттогоо нар заан, лаборантаар Ч.Пүрэвсүрэн нар ажиллаж байлаа.

Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль батлагдсантай холбогдуулан Хорих байгууллагыг, Шийдвэр гүйцэтгэлийн газар нэгдэж, Хууль зүйн сайд, Гэгээрлийн сайдын 1998 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 188/177 дугаар хамтарсан тушаалаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч болон хуулийн дунд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх чиг үүрэгтэй Хууль зүйн дунд сургуулийг Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн дээд сургуулийн харьяаллаас гаргаж, Цагдаагийн дээд сургуулийн бүрэлдэхүүнд шилжүүлэв. Тухайн үед хурандаа П.Бадамдорж, ахмад Д.Нямсүрэн, Х.Ариунцэцэг нарын багш иргэний шийдвэр гүйцэтгэгч нарыг 2 жилийн хугацаатайгаар бэлдэж байв.

Засгийн газрын 2000 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 17 дугаар тогтоолоор Цагдаагийн академи байгуулагдан, бүтцэд “Шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүйн тэнхим”-ийг хэвээр үлдээн, сургалт, судалгааны үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн.

2003 онд Цагдаагийн академийн Шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүйн тэнхимийг “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажилтны бакалаврын сургалтын факультет” болон өргөжин, эрхлэгчээр хурандаа Г.Ганболд, ахлах багшаар А.Лхагва, Ю.Сэрсэнжав, Б.Доржбат, Ш.Дуламсүрэн, Б.Алтангэрэл, Б.Отгонбаяр нарын багштайгаар сургалтын үйл ажиллагаа явуулж ирсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 229 дүгээр тогтоолоор Дотоод хэргийн их сургууль байгуулагдсанаар өнөөг хүртэл Их сургуулийн бүрэлдэхүүн сургуулиуд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийг шаталсан сургалтаар бэлтгэж байна.

Харин Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн түүхэн тоймыг 3 үед хуваан авч үзэж болох юм. Нэгдүгээрт, 1996-2012 оны хооронд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр “Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа” гэсэн хичээл зааж байсан юм. Бусад хичээлүүд нь бүгд хорих ял эдлүүлэх ажиллагааны чиглэлийн хичээлүүд байсан юм. Энэ хичээлийг тухайн үед хурандаа Н.Баттогоо, 2002 оноос миний бие зааж эхэлсэн, хоёрдугаарт, 2012 онд тэнхим маань Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль болж Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тэнхимтэй

болж мэргэжлийн хичээлүүдийн тоог нэмэгдүүлж 5-6 төрлийн шинэ хичээлүүдийн материалыг гадаад орнуудын ижил төстэй хөтөлбөр хэрэгжүүлдэг сургуулиудын хөтөлбөрийн задаргааг харьцуулан судалж боловсруулж, тухайн үедээ анхны гарын авлага, эмхэтгэлүүдээ гаргаж авч байсан, гуравдугаарт, 2017 оноос эхлээд хошууч Б.Болор-Эрдэнэ, хошууч Ц.Баяртбаатар буюу манай төгсөгч нар эхнээсээ багшаар томилогдож ирсэн юм.

Өнөө цагт эрх зүйн хичээлүүд дээр нэмэлтээр процессын болон арга тактикийн хичээлийг нэмж хөгжүүлсэн байна.

Одоо Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургууль маань 3 бакалаврын хөтөлбөр, магистр, докторын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг болсон байна. Бидний үед мөрөөдөл байсан шийдвэр гүйцэтгэлийн цахим сантай холбогдсон зэрэг хийж бүтээсэн зүйл олон байна. Цаашдаа Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхим шийдвэр гүйцэтгэгч нарыг бэлтгэх сургалт, давтан сургалтыг хариуцан зохион байгуулах хэрэгтэй гэж боддог. Мөн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой мэдээллээр иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх соён гэгээрүүлэх ажил, гадаад харилцаагаа өргөжүүлэх, судалгаа, шинжилгээ, сургалтын ажлыг сайжруулах, шүүхийн нарийн бичиг, шүүхийн захиргааны ажилтныг бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсруулах хэрэгтэй. Цаашдаа илүү өргөн цар хүрээтэй ажлыг хийх байх гэж найдаж байна.

Миний бие шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын чиглэлээр багш, судлаачидтайгаа хамтран судалгааны төсөлт болон захиалгат суурь, хавсарга судалгааны ажил чамгүй гүйцэтгэсэн. Үүний нэг нь Их сургуулийн хэмжээнд анх удаа Шинжлэх ухаан, технологийн санхүүжилтээр “Дэлхийн зарим улс орны хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны харьцуулсан судалгаа” сэдэвт судалгааны ажлыг гүйцэтгэснээс тухайн жилд зорчих эрхийг хязгаарлах ял болон пробацын алба, үйл ажиллагааны талаар эрх зүйн зохицуулалт, бодлогын баримт бичиг нэлээдгүй гарч хэрэгжиж байна.

Төрөлх сургуулийнхаа түүхт 90 жилийн ойн баярыг нийт ахмадууд, хамтран ажиллаж байсан хамтран зүтгэгчид, төгсөгч, сонсогч, оюутнууддаа эрдэм, судлалын өндөр амжилт хүсэн ерөөе.

---o0o---

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГА АХЛАГЧ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ДУНД “АХЛАГЧИЙН АЛБА-ӨНӨӨ БА ИРЭЭДҮЙ” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдах “Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын ахлагч нарын чуулга уулзалт”-ыг угтан байгууллагын ахлагчийн албаны хөгжлийн өнөөгийн түвшин, мэргэжил, мэргэшил сургалтын тогтолцоо, албандаа хандах хандлага, ёс зүй, төлөвшил, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, нийгмийн хамгааллыг дэмжих болон бүрэлдэхүүний өмнө тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилгоор “Ахлагчийн алба-Өнөө ба ирээдүй” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг өнөөдөр /2024.02.26/ амжилттай зохион байгууллаа.



Тус эрдэм шинжилгээний хуралд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, байгууллага, салбар, нэгжийн 39 ахлагчийн 31 илтгэл ирүүлснээс илтгэлд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан 9 илтгэлийг хэлэлцүүллээ.

Эрдэм шинжилгээний хурлын шүүгчээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хяналт шалгалт, аюулгүй байдлын газрын дарга, хурандаа П.Батзориг, Хорих ял эдлүүлэх албаны дэд дарга, хурандаа Ч.Нэргүй, Шийдвэр гүйцэтгэх албаны дэд дарга бөгөөд Мэргэжлийн удирдлагын хэлтсийн дарга, доктор, хурандаа Б.Батболд, Албадлагын арга хэмжээ, хяналтын хэлтсийн дарга, хурандаа Р.Саруултамир, Соён гэгээрүүлэх, сургалт, судалгааны хэлтсийн дарга, хошууч У.Анхцэцэг, 403 дугаар анги-Шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор, дэд хурандаа Б.Галбадрах нар оролцож, шилдгүүдийг тодруулсан юм.

---o0o---

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАГЧИДТАЙ УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Дундговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар Дотоод хэргийн их сургуулийн Сургалт судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуульстай хамтран албаны болон сургуулийн онцлог, мэргэжил сонголтын талаар ойлголт өгөх, гэмт хэрэг зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл хүргэх зорилгоор аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн 220 орчим сурагчтай уулзалт зохион байгууллаа.



Энэ үеэр Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн эрхлэгч, доктор /Ph.D/, дэд хурандаа Б.Галбадрах, Аюулгүй байдлын тэнхимийн багш, ахмад И.Санчиргарав, Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, дэслэгч Б.Дэнсмаа нар Дотоод хэргийн их сургууль, Шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн хөтөлбөрийн танилцуулга, давуу тал, элсэлтийн бүртгэлд анхаарах асуудлаар мэдээлэл өгч, сурагчдын сонирхсон асуултад хариуллаа.

Мөн тус газрын алба хаагчид гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сурагчдад яриа таниулга хийж, гарын авлага, тараах материал олголоо.

---o0o---

“ТӨРИЙН ЦЭРГИЙН БОЛОН ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ЭМЭГТЭЙ АХЛАГЧ НАРЫН АНХДУГААР ЧУУЛГА УУЛЗАЛТ” БОЛЛОО

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн ивээл дор “Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын эмэгтэй ахлагч нарын анхдугаар чуулга уулзалт” өнөөдөр /2024.03.06/ Төрийн ордонд болж байна.

Энэ жилийг “Ахлагчийн жил” болгон зарлаж, алба хаагчдын албаны



эрхзүйн орчин, нийгмийн хамгааллыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, мэдлэг, ур чадвар, албандаа хандах хандлага, итгэл үнэмшлийг дээшлүүлэх зорилгын хүрээнд олон талт ажлыг төлөвлөн ажиллаж байгаагийн нэг нь энэхүү чуулган юм.

Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын 500 эмэгтэй ахлагч оролцож буй тус чуулга уулзалтаар ахлагч бүрэлдэхүүн тэр дундаа эмэгтэй ахлагч нарыг дэмжих бодлого, чиглэл, хийж хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээний талаар танилцууллаа. Уулзалтад эмэгтэй сонсогч нар оролцсон.

---o0o---

ЭРЭГТЭЙ БАГШ, АЛБАН ХААГЧДЫН ДУНД “ДАРТС-2024” ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Дотоод хэргийн их сургуулийн түүхт 90 жилийн ой, Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 103 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”-ийг угтан Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, Ахлагчийн зөвлөл хамтран их сургуулийн эрэгтэй багш, албан хаагчдын дунд “Дартс-2024” тэмцээнийг өнөөдөр (2024.03.12) ганцаарчилсан болон дан хосын төрлөөр зохион байгууллаа.



Ганцаарчилсан төрөлд 39 тамирчин, дан хосын төрөлд 11 баг өрсөлдсөнөөс ганцаарчилсан төрлөөр тэргүүн байрт Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн дамжааны захирагч-багш, хошууч З.Мягмардорж, дэд байрт Цэргийн албаны бэлэн байдлын газрын цэргийн албаны зохион байгуулалт хариуцсан офицер, хошууч Л.Зэсшагай, гутгаар байрт Захиргааны удирдлагын газрын Олон нийттэй харилцах төвийн графикч-эвлүүлэгч, дэслэгч Г.Энхсайхан тус тус шалгарлаа. Харин дан хосын төрлөөр тэргүүн байрыг Цэргийн албаны бэлэн байдлын газрын 1 дүгээр баг, дэд байрыг Хангалт үйлчилгээний газрын 1 дүгээр баг, гутгаар байрыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 1 дүгээр баг тус тус эзлэв.

---o0o---

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ ТЭНХИМИЙН “ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН АЛБАНЫ АЖИЛТАН" МЭРГЭЖЛИЙН ДАМЖААНЫ ТӨГСӨЛТ БОЛЛОО

Дотоод хэргийн их сургуулийн харьяа Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тэнхимийн “Харуул хамгаалалтын албаны ажилтан” мэргэжлийн дамжааны 79 төгсөгчид чадамжийн гэрчилгээ, энгэрийн тэмдэг гардуулах ёслолын ажиллагаа өнөөдөр (2024.03.15) Их сургуулийн Соёлын төвд боллоо.



Энэхүү үйл ажиллагаанд Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн захирал, доктор (Ph.D), профессор, цагдаагийн хурандаа Г.Ганбаатар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын Соён гэгээрүүлэх, сургалт, судалгааны тасгийн дарга, хошууч Э.Алтанцэцэг, тус сургуулийн тэнхимийн эрхлэгч, багш, албан хаагчид оролцов.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тэнхимийн “Харуул хамгаалалтын албаны ажилтан” мэргэжлийн дамжааны төгсөгчид та бүхэндээ халуун баяр хүргэж, ажлын өндөр амжилт хүсье.

---o0o---

“ENGLISH LANGUAGE IN MY CAREER AND FUTURE” СЭДЭВТ БАГШ НАРЫН АНГЛИ ХЭЛНИЙ ИЛТГЭЛИЙН УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Дотоод хэргийн их сургуулийн Багшийн хөгжлийн төвөөс Их сургуулийн түүхт 90 жилийн ойг угтан их сургуулийн профессор багш нарын англи хэлний ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “English Language in My Career and Future” сэдэвт илтгэлийн уралдааныг өнөөдөр /2024.03.15/ зохион байгууллаа.



Энэхүү уралдааныг 2 үе шаттай зохион байгуулж, хоёрдугаар шатанд шалгарсан 10 илтгэлийг хэлэлцүүлэн, ахисан дунд, дунд гэсэн 2 түвшинд байр эзлүүлсэн юм. Сургалт судалгааны 403 анги Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны сургуулийн Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, хошууч Э.Цэрэнханд оролцсон.

---o0o---

“АЛДРЫН ДУУЛАЛТАЙ БИДНИЙ СУРГУУЛЬ” КАРАОКЕ ДУУНЫ ТЭМЦЭЭН БОЛЛОО

Дотоод хэргийн их сургуулийн түүхт 90 жилийн ой, Монгол Улсад орчин цагийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 103 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”-ийг тохиолдуулан багш, албан хаагчдын дунд “Алдрын дуулалтай бидний сургууль” караоке дууны тэмцээнийг өнөөдөр (2024.03.14) зохион байгууллаа.



Багш, албан хаагчдын авьяас, чадварыг хөгжүүлэх, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, хамт олны эвсэг найрсаг харилцааг бэхжүүлэх зорилгоор зохион байгуулсан тус тэмцээнд 11 баг оролцож, дуулах авьяасаа сорин өрсөлдөв.

Баг тус бүр 8 гишүүнээс бүрдэн, гоцлол дуу, хамтлаг дуу, багийн ахлагчийн үзүүлбэр гэсэн 3 төрлөөр өрсөлдөж, нийлбэр оноогоор аваргуудаа тодруулсан юм.

Караоке дууны тэмцээний тэргүүн байрыг Онцгой байдлын сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн хамтарсан баг, дэд байрыг Төв номын сан, Биеийн тамир, албаны тусгай бэлтгэлийн институтийн хамтарсан баг, гутгаар байрыг Цагдаагийн сургууль, тусгай байрыг Ерөнхий боловсролын ахлах сургууль тус тус эзэлсэн байна.

Авьяас чадвараа сорин “Алдрын дуулалтай бидний сургууль” караоке дууны тэмцээнд амжилттай оролцсон багш, албан хаагчдадаа баяр хүргэж, ажлын өндөр амжилт хүсье.

---o0o---

ҮЕ ҮЕИЙН ТӨГСӨГЧДИЙН ДУНД ДАРТСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Дотоод хэргийн их сургуулийн түүхт 90 жилийн ойг тохиолдуулан үе үеийн төгсөгчдийн дунд дартсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгууллаа. Энэхүү тэмцээнд манай Их сургуулийн 1985-2023 оны төгсөгчдийн төлөөлөл оролцсон юм.



Тэмцээний эрэгтэй төрөлд 45 тамирчин 16 хэсэгт хуваагдан өрсөлдөж, тэргүүн байранд Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн 2013 оны төгсөгч З.Мягмардорж, дэд байранд мөн сургуулийн 2015 оны төгсөгч Н.Эрдэнэчулуун, гутгаар байранд Цагдаагийн сургуулийн 2016 оны төгсөгч Ц.Анхбаяр нар тус тус шалгарлаа.

Харин эмэгтэй төрөлд 23 тамирчин 8 хэсэгт хуваагдан өрсөлдөж, тэргүүн байранд Хилийн цэргийн дээд сургуулийн 2005 оны төгсөгч Ж.Одончимэг, дэд байранд Цагдаагийн сургуулийн 2012 оны төгсөгч С.Мөнхжин, гутгаар байранд Онцгой байдлын албаны сургуулийн 2020 оны төгсөгч Б.Батцэцэг нар бусдыгаа манлайлан амжилттай оролцлоо.

Мөн энэ үеэр нийт тамирчдын дунд 9 сумаар хамгийн өндөр оноо авах хөгжөөнт тэмцээнийг зохион байгуулж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны сургуулийн 2020 оны төгсөгч С.Эрдэнэтөгс 257 оноогоор тэргүүн байр, 9 сумаар буханд хамгийн олон онох тэмцээнд мөн сургуулийн 2013 оны төгсөгч Д.Мөнхтөр 6 оноогоор дэд байранд тус тус шалгарсан юм.

---o0o---

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ҮЕ ҮЕИЙН ТӨГСӨГЧДИЙН ВОЛЕЙБОЛЫН ТЭМЦЭЭНИЙ АВАРГУУД ТОДОРЛОО

Дотоод хэргийн их сургуулийн түүхт 90 жилийн ойг угтан үе үеийн төгсөгчдийн дунд зохион байгуулсан волейболын тэмцээний аваргууд тодорлоо. Тэмцээнд 20 багийн 160 гаруй тамирчин оролцож, хурд, хүч, авхаалж самбаагаа сорьсон юм.



2012-2017 оны төгсөгчдийн волейболын эрэгтэй төрөлд тэргүүн байрт дэд хурандаа М.Баяржаргал ахлагчтай ХЦДС-ийн 2008-2010 оны төгсөгчид, дэд байрт хошууч Б.Амар ахлагчтай ХЦДС-ийн 2011-2012 оны төгсөгчид, гутгаар байрт хошууч Ү.Батхишиг ахлагчтай ШШГАС-ийн 2012-2017 оны төгсөгчид шалгарлаа.

Харин 2018-2023 оны төгсөгчдийн төрөлд тэргүүн байрыг Б.Энхбат ахлагчтай ЭЗНУС-ийн 2018-2023 оны төгсөгчид, дэд байрыг Энхжин ахлагчтай ШШГАС-ийн 2018-2023 оны төгсөгчид, гутгаар байрыг дэслэгч Б.Бэх-Очир ахлагчтай ХАС-ийн 2022-2023 оны төгсөгчид тус тус эзлэв.

Мөн 2012-2017 оны эрэгтэй “Шилдэг тоглогч”-оор ХЦДС-ийн 2008-2010 оны төгсөгч, дэд хурандаа М.Баяржаргал, 2018-2023 оны эрэгтэй “Шилдэг тоглогч”-оор ЭЗНУС-ийн 2022 оны төгсөгч Б.Энхбат, эмэгтэй “Шилдэг тоглогч”-оор ОБС-ийн 2022 оны төгсөгч дэслэгч Х.Дуламсүрэн нар тус тус тодорчээ.

---o0o---

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН АЛБАНЫ СУРГУУЛИЙН ҮЕ ҮЕИЙН БАГА ДАРГА, ТӨГСӨГЧДИЙН ТӨЛӨӨЛӨЛ ОРОЛЦСОН УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Дотоод хэргийн их сургуулийн түүхт 90 жилийн ой 2024 онд тохиож байгаатай холбогдуулан Их сургуулийн бүрэлдэхүүн сургуулиудын үе үеийн бага дарга, төгсөгчдийн уулзалтыг үе шаттай зохион байгуулж байна.



Үүнтэй холбогдуулан Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 1985-2022 оны бага дарга, төгсөгчдийн төлөөлөл оролцсон уулзалтыг 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр Их сургуулийн хурлын танхимд зохион байгууллаа.

Уулзалтад Сургалтын бодлого төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Б.Мөнхзаяа, Сургалт, судалгааны 403 дугаар ангийн дарга бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн захирал, доктор (Ph.D), бригадын генерал Д.Дамдинцэрэн, АМСҮТ-ийн захирал, доктор(Ph.D), цагдаагийн хурандаа Г.Ганбаатар болон багш, албан хаагчдын төлөөлөл оролцсон юм.

Уулзалтын үеэр Их сургуулийн удирдлага, багш, албан хаагчдын төлөөлөл оролцож, түүхт 90 жилийн ойн хүрээнд хийж гүйцэтгэх бүтээн байгуулалтын болон соён гэгээрүүлэх ажлын талаар мэдээлэл өгч, Их сургуулийн үйл ажиллагаа, сургалтын орчинтой танилцууллаа.

---o0o---

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ АВАРГА ШАЛГАРУУЛАХ “СПОРТЫН ЗУРГААН ТӨРӨЛТ ТЭМЦЭЭН” БОЛЛОО

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бие бүрэлдэхүүний дунд нийтийн биеийн тамир, спортыг дэлгэрүүлэх, хамт олны эв нэгдлийг хангах, алба хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх замаар эрүүл мэндийг хамгаалах зорилгоор зохион байгуулж буй 2024 оны аварга шалгаруулах “Спортын зургаан төрөлт тэмцээн” өнөөдөр (2024.03.25) эхэллээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа анги, байгууллага, салбар, нэгжийн тамирчид 7 бүсэд сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, шатар, дартс, туухай өргөлтийн төрлөөр өрсөлдөж байна. Эрэгтэй “Гар бөмбөг”-ийн төрөлд 2 дугаар байр, эмэгтэй “Гар бөмбөг”-ийн төрөлд 1 дүгээр байр, эмэгтэй “Шатар”-ын төрөлд сонсогч Б.Одонтуяа, эрэгтэй “Дартс”-ын төрөлд З.Мягмардорж, эрэгтэй “Туухай өргөлт” +80 төрөлд Ц.Пүрэвням нар тус тус шагнагдан нийлбэр дүнгээрээ 3 байр эзэлсэн.



---o0o---

“АХЛАГЧ ТАНД БАЯРЛАЛАА” УРЛАГИЙН ҮЗЛЭГИЙН БҮСИЙН ШАЛГАРУУЛАЛТ ЭХЭЛЛЭЭ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх шийдвэр гүйцэтгэх байгууллагаас 2024 онд “Байгууллагын соёлыг төлөвшүүлж, ахлагчийн манлайллыг дэмжих жил” болгох зорилт дэвшүүлсэнтэй холбогдуулан алба хаагчдын урлагийн авьяас, чадварыг нээн хөгжүүлэх, хамт олны эв нэгдлийг бэхжүүлэх зорилгоор “Ахлагч Танд баярлалаа” урлагийн үзлэгийн бүсийн шалгаруулалт өнөөдөр /2024.03.23/ эхэллээ.



Тус урлагийн үзлэг хоёр үе шаттай бөгөөд эхний шатанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, байгууллага, салбар, нэгжүүдийг 7 бүсэд хуваан гоцлол дуу, гоцлол хөгжим, гоцлол бүжиг, уран уншлагын төрлөөр шилдгүүдийг тодруулна.

Улаанбаатар хотыг Банкны төлбөр барагдуулах газраас Б бүсийн Ахлагч Танд баярлалаа” урлагийн үзлэгт амжилттай оролцож гоцлол бүжгийн төрөлд дэслэгч Б.Анун тэргүүн байр эзэлсэн эцсийн шатны шалгаруулалтад өрсөлдөхөөр болсон.

---o0o-

АЛБА ХААГЧИЙГ МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТЫН НЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭХЛҮҮЛЛЭЭ

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт Хүчний Ерөнхий командлагчийн санаачилгаар төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын хэмжээнд 2024 оныг Ахлагчийн жил болгон зарласан.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас 2024 оныг “Байгууллагын соёлыг төлөвшүүлж, ахлагчийн манлайллыг дэмжих” жил болгон зарласан зорилтын хүрээнд Дотоод хэргийн их сургуультай хамтран Улаанбаатар хотын бүсийн хорих анги, байгууллага, салбар нэгжийн 58 ахлагчийг мэргэшүүлэх сургалтад /2024.03.21-03.22/ хамруулж байна..

Хичээл сургалтыг Дотоод хэргийн их сургуулийн эрдэмтэн багш нар “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Аюулгүй байдлын ойлголт”, “Хорих ял эдлүүлэх ажиллагааны олон улсын хэм хэмжээ”, “Хорих байгууллага дахь хүний эрх” сэдвийн хүрээнд тус тус явуулж байна.

---o0o---

Монголын мэтгэлцээний нэгдсэн танхимын ээлжит 3-р чуулганы №5 тоот тогтоолын хавсралт №1

ПАРЛАМЕНТЫН МЭТГЭЛЦЭЭНИЙ ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Мэтгэлцээн нь хувь хүнийг хөгжилд хөтлөгч хүчирхэг арга хэрэгсэл бөгөөд мэтгэлцээнд оролцогч нь ганцхан ялахын төлөө мэтгэлцдэггүй. Мэтгэлцэгч нь СУРАЛЦАХЫН ТУЛД МЭТГЭЛЦЭХ, ҮНЭНИЙГ БАРИМТЛАХ, БУСДЫГ ХҮНДЭТГЭХ гэсэн гурван үндсэн зарчмыг баримтлан өндөр ёс зүйтэйгээр энэхүү дүрмийн хүрээнд мэтгэлцэнэ.

1.2 Мэтгэлцээний соёл нь хэн нэгэн хувь хүн, улс төрийн нам, шашны байгууллага зэрэг аливаа байгууллага, төр түүний албан тушаалтны өмч биш бөгөөд хүн төрөлхтний нийтлэг өв соёл учраас түүнийг өмчлөх эрх хэнд ч байхгүй. Мэтгэлцээнийг түгээн дэлгэрүүлэх, хичээллэн суралцах эрх хэн бүхэнд бий.

1.3 Энэхүү дүрэм нь сонгодог парламентын мэтгэлцээний гарын авлага, үндсэн зарчмыг бичвэрийн хувьд дүрэм журмын хэлбэрт оруулсан дүрэм бөгөөд Монгол улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй бүхий л парламентын мэтгэлцээний тоглолтод баримтална.

1.4 Энэхүү дүрмийн зорилго нь парламентын мэтгэлцээнээр мэтгэлцэх үед үүсэх бүхий л харилцааг нарийвчлан зохицуулах зорилготой.

ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Энэхүү дүрэмд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1 "Монголын мэтгэлцээний нэгдсэн танхим" гэж Монголын мэтгэлцээний холбоо, нийгэмлэгүүдийг эгнээндээ нэгтгэсэн, мэтгэлцээний нэгдсэн байгууллагыг;

2.1.2 "Парламентын мэтгэлцээн" гэж тодорхой сэдэв буюу шийдэлтэй холбоо бүхий санаа бодол, төсөөллийг олох, бий болгох, шинжлэн үзэх, хамгаалах, эсрэг талын байр суурийг няцаах гэх зэрэг тодорхой бүтэц, дүрэм, хязгаартай, шийдвэр гаргах түвшний багуудын хооронд өрнөх парламент дахь засгийн газар сөрөг хүчний байр сууринаас асуудлыг авч үзэх зохиомжит үйл ажиллагааг;

2.1.3 "Мэтгэлцээний баг" гэж дүрэмд заасан шаардлагыг хангасан 2 гишүүн бүхий өөрийн гэсэн нэртэй нэгдлийг;

2.1.4 "Засгийн газар" гэж хэлэлцэж буй шийдлийн үнэн зөв болохыг шүүгч, сөрөг хүчинд өөрийн дэвшүүлсэн аргумент болон эсрэг талын үзэл баримтлалыг няцааж буй няцаалтаараа дамжуулан нотлон харуулах үүрэг бүхий багийг;

2.1.5 "Сөрөг хүчин" гэж хэлэлцэж буй шийдэл болон шийдлийг хамгаалан үзэл баримтлалаа дэвшүүлсэн засгийн газрын аргумент буруу, алдаатай болохыг шүүгч, засгийн газарт өөрийн үзэл баримтлал болон няцаалтаараа батлан харуулж, няцаалт хийж, сөргөлдөөн үүсгэх үүрэг бүхий багийг;

2.1.6 "Шийдэл" гэж засгийн газар болон сөрөг хүчин, тухайн тэмцээний үед өгөгдсөн цаг хугацаанд авч хэлэлцэн мэтгэлцэх асуудлыг;

2.1.7 "Хүрээлэл" гэж засгийн газар бүрэн эрхийнхээ хүрээнд давуу байдлаа ашиглан тогтоох хэдий ч сөрөг хүчин тус хүрээлэлд орж тоглох боломж бүхий хязгаарлалтыг;

2.1.8 "Тодорхойлолт" гэж тухайн шийдэлд дурдагдаж буй түлхүүр үгсийг хэрхэн ойлгож буйгаа тодорхойлон гаргахыг;

2.1.9 "Аргумент" гэж өөрийн багийн байр суурь үнэн зөв гэдгийг шүүгчдэд нотолж буй өгүүлбэр эсхүл үргэлжилсэн үгээр илэрхийлэгдсэн нотолгоо, дэмжлэгийн нийлбэрийг;

2.1.10 "Дэмжлэг" гэж дэвшүүлсэн нотолгоо буюу аргументаа бодит тоо баримт, жишээ, судалгаа, түүхээр баяжуулахаар хэрэглэж буй баримтыг;

2.1.11 "Тодруулгын үе" гэж эсрэг талын илтгэгчийн зөвшөөрлийг авч яриаг түр тасалж, илтгэл дундуур тодорхойгүй байгаа асуудлыг дэлгэрүүлэх, алдаатай логикийг шүүгчид харуулах зорилгоор асууж буй асуултыг;

2.1.12 "Дүрмийн үе" гэж эсрэг талын илтгэгчийн илтгэлийн үед мэтгэлцэгч мэтгэлцээний дүрмийг зөрчсөн хэмээн үзэж, шүүгчид хандан гаргаж буй эсэргүүцлийг

2.1.13 "Шүүгч" гэж Монголын мэтгэлцээний нэгдсэн танхимаас шүүгчийн эрх авсан, зэрэглэл бүхий шүүгч байна. Шүүгч шийдлийг хэлэлцсэн харилцан эсрэг байр суурь бүхий багуудыг энэхүү дүрэмд захирагдан, өөрийн дотоод итгэл үнэмшлээр шүүх бүрэн эрх бүхий парламентын мэтгэлцээний талаар онол, практикийн өндөр ур чадвар бүхий хүнийг тус тус ойлгоно.

ГУРАВ. МЭТГЭЛЦЭЭНД ОРОЛЦОХ БАГ

3.1 Парламентын мэтгэлцээнд оролцох баг нь дараах шаардлагыг хангасан байна.

3.1.1 Парламентын мэтгэлцээний үндсэн ойлголт өгөх сургалт, үйл ажиллагаанд хамрагдсан,

тус мэтгэлцээний талаар мэдлэгтэй байх; 3.1.2 Монголын мэтгэлцээний нэгдсэн танхимын харьяа клубээс зохион байгуулсан парламентын мэтгэлцээний мэтгэлцэгчийн эрх олгох сургалтад хамрагдсан байх;

3.1.3 Энэхүү дүрмийг уншиж бүрэн хүлээн зөвшөөрсөн байх; 3.1.4 Баг нь хоёр гишүүнтэй байх бөгөөд мэтгэлцээний үед гүйцэтгэх үүрэг нь тухайн мэтгэлцээнээс хамаарч солигдож болно;

3.1.5 Парламентын мэтгэлцээний тэмцээний үеэр энэхүү дүрэмд зааснаас бусад нэмэлт шаардлагуудыг Монголын мэтгэлцээний нэгдсэн танхимын зүгээс багуудад тавьж болно.

ДӨРӨВ. ШҮҮГЧ

4.1 Парламентын мэтгэлцээний талаар онол, практикийн өндөр ур чадвартай, тодорхой түвшинд амжилт үзүүлсэн, дадлага туршлага бүхий этгээд шүүгчээр ажиллана.

4.2 Шүүгч нь Монголын мэтгэлцээний нэгдсэн танхимаас зохион байгуулсан мэтгэлцээний шүүгчийн сургалтад хамрагдаж, "Мэтгэлцээний шүүгч"-ээр ажиллах гэрчилгээг авсан байх ёстой. Мэтгэлцэгч нь шүүгчээр шүүлгэхдээ тухайн шүүгчийг шүүгчийн сургалтад хамрагдсан эсэх баталгааг шаардан гаргуулах эрхтэй.

4.3 Монголын мэтгэлцээний нэгдсэн танхимын шүүгч нь мэтгэлцээний шүүгчийн ёс зүйн мэдэгдлийг[372] тухайн тэмцээн эхлэхээс өмнө бөглөж, тухайн тэмцээний ерөнхий шүүгч уг мэдэгдлийг баталгаажуулна.

4.4 Монголын мэтгэлцээний нэгдсэн танхимын шүүгч нь парламентын мэтгэлцээний шүүгчийн хуудсанд[373] тусгагдсан зохих үзүүлэлтүүдийн дагуу оноог[374] өгч, тайлбарыг бичиж, зөвхөн мэтгэлцээний шийдлийг харгалзан шүүлтийн дүрмийн дагуу,[375] мэтгэлцээний үйл явц, талуудын гаргасан нотолгоо, дэмжлэг, үндэслэл дээр тулгуурлан шийдвэрээ гаргана. Шүүгч мэтгэлцээний аль нэг тал биш, шүүн шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж буйгаа үргэлж санаж ажиллана.

4.5 Шүүгч нь мэтгэлцэж буй багуудтай ямар нэгэн байдлаар хамааралтай, тухайн мэтгэлцээнийг чин шударгаар явуулах боломжгүй гэж үзвэл өөрийн хүсэлтээр мэтгэлцээнийг шүүхээс татгалзаж болно.

---

[372] Шүүгчийн ёс зүйн мэдэгдлийг уг дүрмийн хавсралт №1

[373] Парламентын мэтгэлцээний шүүгчийн хуудсыг уг дүрмийн №2 батална.

[374] Онооны үзүүлэлт нь 1-5 оноо байна.

[375] Монголын мэтгэлцээний нэгдсэн танхимаас баталсан Шүүлтийн дүрэм нь парламентын мэтгэлцээний дүрэмтэй харилцан уялдаатай байна. Монголын мэтгэлцээний нэгдсэн танхимын шүүгч нь шийдвэр гаргахдаа парламентын мэтгэлцээний дүрэм, шүүлтийн дүрмүүдийг тус тус баримтлана.

4.6 Шүүгчийн шийдвэр тухайн мэтгэлцээний хувьд эцсийнх байх бөгөөд гомдол маргаан шийдвэрлэх дараагийн шат мэтгэлцээний хувьд байхгүй.

ТАВ. МЭТГЭЛЦЭЭНИЙ ДАРААЛАЛ

5.1 Хоорондоо мэтгэлцэх хоёр баг ширээнд сууж, шүүгч “ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨЛ”-өөс санал болгосон шийдлийг танхимд зарлана.

5.2 Шийдлийг зарласны дараа шүүгч 2 талыг оролцуулан сугалаа хийнэ. Сугалаанд ялсан баг 30 секунд зөвшилцсөний дараа засгийн газар эсхүл сөрөг хүчний байр сууриас мэтгэлцэх сонголт хийнэ.

5.3 Талууд мэтгэлцэх байр сууриа сонгосны дараа зарласан шийдлийг 15 минут бэлтгэнэ. Шүүгч, зохион байгуулагчид тэмцээний нөхцөл байдлаас хамаарч уг хугацааг ихэсгэх, багасгах эрхтэй. Хугацааг ихэсгэх, багасгах шийдвэр гаргасан тохиолдолд талууд маргах эрхгүй.

5.4 Парламентын мэтгэлцээний үндсэн илтгэл

5.4.1 Засгийн газрын ерөнхий сайдын үзэл баримтлалын илтгэл: 7 минут

5.4.2 Сөрөг хүчний удирдагчийн үзэл баримтлал, няцаалтын илтгэл: 8 минут

5.4.3 Засгийн газрын гишүүний дэмжлэгийн болон няцаалтын илтгэл: 8 минут

5.4.4 Сөрөг хүчний гишүүний дэмжлэгийн болон няцаалтын илтгэл: 8 минут

5.4.5 Сөрөг хүчний удирдагчийн дүгнэлтийн илтгэл: 4 минут 5.4.6 Засгийн газрын ерөнхий сайдын дүгнэлтийн илтгэл: 5 минут

5.5 Мэтгэлцээний тэмцээн, бэлтгэлийн үед цаг хугацаа, багуудын тооноос хамаарч уг хугацааг богиносгож болно.

5.6 Багийн гишүүн тус бүр эхний дөрвөн илтгэлийн үед өөрт оногдсон илтгэх хугацаar 30 секундээр сунгаж болох бөгөөд шүүгчид хандан "Нэмэлт 30 секундээр сунгая" гэж мэдэгдэх эсхүл дохиогоор мэдэгдэн зөвшөөрөл авна.

5.7 Багууд эхний 4 илтгэлийн өмнө бэлтгэлийн 1 минутыг авч болно.

5.8 Мэтгэлцээн бүрэн дууссаны дараа шүүгч буюу шүүгчдийн бүрэлдэхүүн шийдвэрээ танилцуулна.

ЗУРГАА. ДҮРМИЙН ҮЕ

6.1 Дүрмийн үе гэдэгт энэхүү дүрмийн 2.1.12-т заасныг ойлгох бөгөөд дүрмийн үеийг санал болгохын тулд мэтгэлцэгч "Эрхэм шүүгчээ дүрмийн үеийг санал болгож байна" хэмээн хэлнэ. Энэ үед илтгэж буй илтгэгч илтгэлээ зогсоож, шүүгч цагийг зогсооно. Шүүгч дүрмийн үеийг санал болгосон мэтгэлцэгчээс

"Дүрмийн үеийн үндэслэл"-ийг асууна. Мэтгэлцэгч энэхүү дүрмийн 6.3-т заасан 11 үндэслэлийн аль нэгэнд хамаарах дүрмийн үе авч буйгаа мөн үндэслэлээ танилцуулна. Шүүгч шаардлагатай гэж үзвэл дүрмийн үеийн үндэслэлийг сонссоны дараа илтгэж буй мэтгэлцэгчээс тайлбар авч болно.

6.2 Талуудын байр суурийг сонссоны дараа нэг шүүгч байвал дангаар бүрэлдэхүүнтэй шүүгчид байвал олонхын саналаар дүрмийн үеийг шийдвэрлэнэ.

6.3 Дүрмийн үеийг дараах үндэслэлээр авна. Үүнд:

6.3.1 Илтгэлийн цаг хэтэрсэн /Илтгэгч өөрт оногдсон илтгэлийн хугацаанаас 15 секундээр хэтрүүлбэл/

6.3.2 Тодруулгын үед асуултаа сунжруулсан Тодруулгын асуулт асууж буй баг асуултаа 15 секундээр хэтрүүлсэн бол/

6.3.3 Тодруулгын үеийг буруу цагт авсан /Мэтгэлцэгч эхний 4 илтгэлийн эхний болоод төгсгөлийн 1 минутын үед, сүүлийн 2 илтгэлийн аль ч үед тодруулга авч болохгүй бөгөөд тодруулга авахыг оролдвол/ 6.3.4 Дүгнэлтийн 2 илтгэлийн үед илтгэгч мэтгэлцээнийг илт өөрчилсөн шинэ аргумент эсхүл түүнтэй дүйцэхүйц санаа дэвшүүлсэн /Сөрөг хүчний гишүүний гаргасан шинэ аргумент санааг няцаах зорилгоор Засгийн газрын ерөнхий сайдын дүгнэлтийн илтгэлд гарсан шинэ санааг уг дүрмийн үед тооцохгүй./

6.3.5 Дүгнэлтийн илтгэлийн үед кейсийг илт өөрчлөх /Байр сууринаасаа ухрах, байр сууриа илт өөрчилсөн, мэдэгдэл, үндэслэл гаргах/

6.3.6 Дархлагдсан аргументыг няцаах

6.3.7 Туризм буюу мэдээжийн үнэний дурдалт ашиглах

6.3.8 Давталт буюу тавталоги ашиглах

6.3.9 Субъектийн дайралт хийх /Эсрэг багийн мэтгэлцэгчийг дайрч доромжилсон, хувь хүний үүднээс гоочилсон зэрэг тохиолдолд/

6.3.10 Эсрэг багийн мэтгэлцэгчийн илтгэлийн утгыг илт мушгин гуйвуулах /хэлээгүй хэлсэн болгох зэргээр гүтгэх/

6.3.11 Танхимд худал мэдээлэл тараах

6.3.12 Хүрээллийг давчуу тогтоосон тохиолдолд Хэдийгээр засгийн газар бүрэн эрхийнхээ хүрээнд хүрээлэл тогтоох хэдий ч тус хүрээлэлд сөрөг хүчинд эсрэг нотолгоо гаргах боломжтой байх ёстой. Хэрэв засгийн газрын тогтоосон хүрээлэл нь туйлын тодорхой эсхүл эсрэг нотолгоо гаргах боломжгүй бол/

6.4 Дүрмийн үеийг аль нэг багаас санал болгож, шүүгч үндэслэлийг сонсон үндэслэлтэй гэж үзвэл уг дүрмийн 6.3.12-с бусад үндэслэлээр дүрмээ зөрчсөн багт

хасах 1 оноо өгнө. Уг оноог шүүгч тус бүр өөрийн шүүгчийн онооноос хасаж тооцно.

6.5 Талууд дүрмийн алдаа гаргасан ч гэсэн эсрэг баг уг алдааг олж дүрмийн үе санал болгоогүй бол шүүгч дүрмийн алдаа гаргаагүйд тооцох ба оноо хасахгүй.

6.6 Эсрэг багийн илтгэлийг санаатайгаар үймүүлэх зорилгоор үндэслэлгүйгээр олон дахин дүрмийн үе авах нь шүүгч тухайн багийн зохион байгуулалтын онооноос хасах үндэслэл болно.

6.7 Сөрөг хүчин нь Засгийн газрын хүрээллийг хүлээн зөвшөөрсөн бол тухайн хүрээнд мэтгэлцэх бөгөөд хүрээллээс гадуур мэтгэлцээн өрнүүлэх нь талуудын шүүлтийн онооноос хасах үндэслэл болно.

ДОЛОО. ТОДРУУЛГЫН ҮЕ

7.1 Тодруулгын үе гэдэгт энэхүү дүрмийн 2.1.11-т заасныг ойлгох бөгөөд тодруулгын үеийг эсрэг багийн илтгэл танилцуулж буй илтгэгчээс нөгөө баг нь авна. Тодруулгын үе өгөх эсэхээ илтгэж буй илтгэгч шийднэ. Тодруулгын үеийн бүхий л цаг нь илтгэгчийн илтгэлийн үндсэн хугацаанаас хасагдана.

7.2 Тодруулгын үед тодруулан асуух хугацаа нь 15 секунд байх бөгөөд илтгэгчийн хариулах хугацаа нь тухайн илтгэгчээс хамаарна.

НАЙМ. ШҮҮГЧИЙН ШИЙДВЭР ГАРГАХ

8.1 Тэмцээний шүүгч, шүүх бүрэлдэхүүн парламентын мэтгэлцээний дүрэм, парламентын мэтгэлцээний шүүлтийн дүрмүүдийг үндэслэж шийдвэр гаргана.

8.2 Тэмцээний шүүх бүрэлдэхүүн уг дүрмийн хавсралт №2[376] заасан шүүгчийн хуудсыг бөглөж шүүлтээ хийнэ.

8.3 Уг хуудсанд заагдсанаас өөр үзүүлэлт, үндэслэлээр мэтгэлцээний ялалт ялагдлыг шийдвэрлэхгүй.

8.4 Шүүгч шийдвэрээ танхимд танилцуулах бөгөөд шийдвэр гаргасан үндэслэлээ талуудад талуудыг байлцуулан нэг удаа тайлбарлана. Шүүгч шийдвэрээ гаргах, танилцуулах нийт хугацаа нь 6 минутаас хэтрэхгүй.

8.5 Оноогоор илүү байсан багт хожлыг өгөх ба хоёр багийн аль нэгт ялалтыг заавал өгнө. Хоёр багийг зэрэг ялагдуулж болохгүй.

ЕС. ДҮРЭМ ХЭРЭГЖИХ, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ҮНДСЭН ЭХИЙГ ТҮГЭЭХ, ДҮРМИЙН ХҮРЭЭ ХЯЗГААР

[376] 5. Парламентын мэтгэлцээний дүрмийн хавсралт №2 баталсан шүүгчийн хуудаснаас өөр шүүгчийн хуудсаар парламентын мэтгэлцээний тэмцээн шүүхийг хориглоно

9.1 Энэхүү дүрмээр зохицуулагдаагүй харилцааг тухайн тэмцээний шүүгчдийн бүрэлдэхүүн болон зохион байгуулах баг нарийвчлан зохицуулж болно.

9.2 Энэхүү дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулахдаа Монголын мэтгэлцээний нэгдсэн танхимын удирдах зөвлөлийн саналаар Монголын мэтгэлцээний нэгдсэн танхимын чуулганы хурлаар шийдвэрлэнэ.

9.3 Уг дүрмийн үндсэн эхийг Монголын мэтгэлцээний нэгдсэн танхимын Ерөнхийлөгчид нэг хувь, салбар холбоод тус бүрд нэг хувь, мэтгэлцээний клубүүдэд тус тус хүргэнэ.

9.4 Энэхүү дүрмийг 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛЫН МЭТГЭЛЦЭЭНИЙ НЭГДСЭН ТАНХИМ

Парламентын мэтгэлцээний
дүрмийн хавсралт №2

ПАРЛАМЕНТЫН МЭТГЭЛЦЭЭНИЙ ШҮҮГЧИЙН ХУУДАС

Шийдэл_____

_____

Засгийн газар_____ Сөрөг хүчин_____

ЗГ-ЕС	ЗГ-Г	Үнэлэх үзүүлэлт	СХ-У	СХ-Г
		Нотолгоо		
		Дэмжлэг, няцаалт		
		Агуулга		
		Илтгэх чадвар		
		Зохион байгуулалт		
		Цаг ашиглалт		
		Хувийн нийт оноо		
		Дүрмийн үе		
		Багийн нийт оноо		

Ялагч тал_____ багийн нэр_____

Ялалт өгсөн үндэслэл

Засгийн газрын ерөнхий сайдын үзэл баримтлалын илтгэл	Сөрөг хүчний удирдагчын үзэл баримтлалын илтгэл
Засгийн газрын гишүүний дэмжлэг болон няцаалтын илтгэл	**Сөрөг хүчний гишүүний дэмжлэг болон няцаалтын илтгэл**
Засгийн газрын ерөнхий сайдын дүгнэлтийн илтгэл	**Сөрөг хүчний удирдагчын дүгнэлтийн илтгэл**

Шүүгч / / гарын үсэг, нэр/